



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР



ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ
ҮНЭТ ЗҮЙЛ



ХҮНИЙ
ХӨГЖИЛ



АМЬДРАЛЫН ЧАНАР БА
ДУНДАЖ ДАВХАРГА



ЭДИЙН
ЗАСАГ



САЙН
ЗАСАГЛАЛ



НОГООН
ХӨГЖИЛ



АМАР ТАЙВАН
АЮУЛГҮЙ НИЙГЭМ



БҮСЧИЛСЭН
ХӨГЖИЛ



УЛААНБААТАР БА
ДАГУУЛ ХОТ

АЛСЫН ХАРАА 2050

МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

АЛСЫН ХАРАА 2050

МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

30 ЖИЛИЙН
ДҮГНЭЭЛТ

30 ЖИЛИЙН
ЗОРИЛГО



АЛСЫН ХАРАА 2050

МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

ТӨСЛИЙН ЭХНИЙ ХУВИЛБАР

АГУУЛГА

ӨМНӨТГӨЛ	1
• “Монгол Улсын сүүлийн 30 жилийн дүгнэлт ба ирэх 30 жилийн зорилго” бүхий урт хугацааны хөгжлийн бодлого боловсруулах үндэслэл, шаардлага	1
• Монгол Улс хөгжлийн бодлого боловсруулж хэрэгжүүлж ирсэн түүхэн товчоо	6
• “Монгол Улсын хөгжлийн загвар” буюу урт хугацааны хөгжлийн бодлогын суурь үнэт зүйл	24
МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ	32
УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО	84
ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ	88
• Дэлхийн Монгол	92
• Нүүдлийн соёл иргэншилт Монгол	95
• Монгол хэл бичиг	98
• Үндэсний бахархал, эв нэгдэл	100
• Эрдэм судлал, нийгмийн соён гэгээрэл	102
ХҮНИЙ ХӨГЖИЛ	106
• Боловсрол	109
• Эрүүл мэнд	117
• Гэр бүл	123
• Шинжлэх ухаан, инноваци	125
• Хүнд ээлтэй амьдрах орчин	128
• Хөдөлмөрийн зах зээл	131
• Удмын сан	133
АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА	156
• Нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэл	160
• Орлогод нийцсэн орон байр	168
• Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес	170
• Дундаж давхаргыг дэмжсэн санхүүжилт	175
• Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг	176
• Газрын харилцаа	178

ЭДИЙН ЗАСАГ 190

- Чинээлэг Монгол 196
- Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд 206
- Ухаалаг санхүүгийн зах зээл 222
- Бүс нутгийн хамтын ажиллагаа 229
- Өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн 238
- Үндэсний баялгийн сан 240

САЙН ЗАСАГЛАЛ 246

- Ухаалаг засаглал 250
- Ухаалаг бүтэц 255
- Цахим Монгол (иргэн, төр, хувийн хэвшлийн нэгдсэн систем) 258
- Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба 265
- Хүний эрхийг дээдлэсэн нийгэм 270
- Авлигагүй засаглал 272

НОГООН ХӨГЖИЛ 278

- Эх байгаль ба анхдагч экосистем 281
- Байгалийн баялгийн үр өгөөж 286
- Үнэт баялаг ус 293
- Хүлэмжийн хийн ялгарал багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил 298

АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ 310

- Зэвсэгт хүчин 314
- Дархан хил 319
- Хүн нийгмийн амар тайван байдал 323
- Хууль сахиулах салбарын хөгжил 326
- Мэдээллийн аюулгүй байдал 330

БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ 340

- Дорнод Монголын эдийн засгийн хөгжлийн тэнхлэг, үйлдвэрлэл, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бүс 345
- Хариуцлагатай уул уурхай, өндөр технологид суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээ, палеонтологийн аялал жуулчлалын бүс 352
- Байгалийн нөөц, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бүс 360
- Өрнөд Монголын эдийн засгийн хөгжлийн тэнхлэг, Алтайн соёл, байгалийн нөөц, ногоон хөгжлийн бүс 366
- Хангайн эрчимжсэн хөдөө аж ахуй, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бүс 372
- Олон улсын шинжлэх ухаан, технологийн төв, тээврийн зангилаа, өндөр технологийн үйлдвэрлэл, үйлчилгээний бүс 379

УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ 396

- Хүн төвтэй хот 400
- Орчин төвтэй шийдэл 405
- Төлөвлөлт төвтэй хөгжил 414
- Хотын сайн засаглал 422
- Дагуул хот 428

АЛСЫН ХАРАА 2050, МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ 440

АЛСЫН ХАРАА 2050, МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД УЧИРЧ БОЛОХ ЭРСДЭЛҮҮД 476

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	БНМАУ-ын Үндсэн хууль	7	Зураг 4.15.	Санхүүгийн салбарын бүтэц	223
Зураг 2.	1924 оны Ардын Засгийн газрын 44 дүгээр тогтоол	8	Зураг 4.16.	Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ ба хөрвөх чадварын үзүүлэлт	223
Зураг 3.	Сайд нарын зөвлөлийн 21 дүгээр хурлын тэмдэглэлээс	11	Зураг 4.17.	IPO түүхэн замнал	224
Зураг 4.	Гол тулгуур гурвалжин	27	Зураг 4.18.	Улс орнуудын ЗЗҮ-г харьцуулсан үзүүлэлт (тэрбум ам.доллар)	224
Зураг 5.	Баялгийн хуваарилалтын зохистой хувилбар	28	Зураг 4.19.	Төмөр замын сүлжээний зураглал	231
Зураг 6.	Хүн амын өсөлт, өөрчлөлт, 2009-2050	55	Зураг 4.20.	БНХАУ болон ОХУ хоорондох байгалийн хийн дамжуулах хоолойн зураглал	231
Зураг 7.	Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд	56	Зураг 4.21.	Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого	232
Зураг 8.	Хөдөлмөрийн зах зээлийн зарим үзүүлэлтүүд	57	Зураг 4.22.	Монгол – Орос – Хятад улсын эдийн засгийн коридорын бүтэц зохион байгуулалтын зураглал	234
Зураг 9.	Дундаж давхаргын нийт хүн амд эзлэх хувь, 2002-2017	59	Зураг 4.23.	Инновацийн хөгжлийн зураглал	236
Зураг 2.1.	ЕБС-д нэмэх шаардлагатай суудлын тоо, 2030 он	112	Зураг 5.1.	Засгийн газрын тогтвортой байдал	252
Зураг 2.2.	Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэлтэй уялдсан мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрийн чиглэл	114	Зураг 5.2.	Иргэн, төр, хувийн хэвшлийн нэгдсэн систем дэх цахим үйлчилгээ ба мэдээллийн сан	260
Зураг 2.3.	Эрүүл мэндийн салбарын хөгжил, шинэчлэл	119	Зураг 5.3.	Цахим Монгол – цахим засаглал	262
Зураг 3.1.	Нийгмийн хамгааллын тогтолцооны шинэчлэл	162	Зураг 5.4.	Мэргэжлийн чадварлаг, цомхон төрийн алба	268
Зураг 3.2.	Амьдралын чанарын бүрдэл хэсгүүд	166	Зураг 6.1.	Ойн сан бүхий газар	282
Зураг 3.3.	Гэрээт хадгаламжийн сангийн тогтолцоо	172	Зураг 6.2.	Аялал жуулчлал, тусгай хамгаалалтын газар	283
Зураг 4.1.	Эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах үйл ажиллагааны хүрээнд хүрэх үр дүн	194	Зураг 6.3.	Экосистемийн үйлчилгээ, тусгай хамгаалалт	284
Зураг 4.2.	Эдийн засгийн өсөлтийн тооцоо	196	Зураг 6.4.	Монгол орны биологийн олон янз байдал	288
Зураг 4.3.	Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ	197	Зураг 6.5.	Монгол орны биологийн олон янз байдал (Генетик нөөцийн ашиглалтаас үүдэх үр шим)	290
Зураг 4.4.	Дундаж цалингийн төсөөлөл	197	Зураг 6.6.	2030 оны усны нөөцийн бүлэг	297
Зураг 4.5.	Ажиллах хүчний төсөөлөл, салбараар, 2018 он	198	Зураг 6.7.	Улирлын температур, хур тунадасны ирээдүйн өөрчлөлт	300
Зураг 4.6.	Ажиллах хүчний төсөөлөл, салбараар, 2025 он	199	Зураг 6.8.	Уур амьсгалын ногоон санхүүжилт	302
Зураг 4.7.	Ажиллах хүчний төсөөлөл, салбараар, 2030 он	199	Зураг 7.1.	Хааны эрэлд олон улсын сургуулилт	316
Зураг 4.8.	Ажиллах хүчний хэрэгцээ	199	Зураг 7.2.	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах тогтолцоо	335
Зураг 4.9.	Өрийн дарамтгүй төр	202	Зураг 8.1.	Монгол Улсын бүсчлэлийн шинэ схемийн төсөл (макро бүс)	343
Зураг 4.10.	Органик хүнс, эрчим хүчний тоглогч орон	208	Зураг 8.2.	Монгол Улсын бүсчлэлийн шинэ схемийн төсөл (микро бүс)	344
Зураг 4.11.	Газрын тосны боловсруулах үйлдвэр байгуулах төслийн зураглал	212	Зураг 8.3.	Дорнод Монголын эдийн засгийн хөгжлийн тэнхлэг, үйлдвэрлэл, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бүс	350
Зураг 4.12.	Дарханы арьс ширний цогцолборын зураглал	214			
Зураг 4.13.	Бүтээлч аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилтууд	216			
Зураг 4.14.	Эрчим хүчний салбар дахь томоохон төсөл, хөтөлбөрүүдийн зураглал	218			

Зураг 8.4.	Хариуцлагатай уул уурхай, өндөр технологид суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээ, палеонтологийн аялал жуулчлалын бүс	358
Зураг 8.5.	Байгалийн нөөц, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бүс	364
Зураг 8.6.	Өрнөд Монголын эдийн засгийн хөгжлийн тэнхлэг, Алтайн соёл, байгалийн нөөц, ногоон хөгжлийн бүс	370
Зураг 8.7.	Хангайн эрчимжсэн хөдөө аж ахуй, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бүс	376
Зураг 8.8.	Олон улсын шинжлэх ухаан, технологийн төв, тээврийн зангилаа, өндөр технологийн үйлдвэрлэл, үйлчилгээний бүс	384
Зураг 9.1.	Нийслэлийн зарим статистик үзүүлэлт /2019/	398
Зураг 9.2.	Хүний хөгжил	402
Зураг 9.3.	Орчин төвтэй хот	410
Зураг 9.4.	Хаягдалгүй хот	412
Зураг 9.5.	Олон төрөлт ухаалаг тээврийн сүлжээ	418
Зураг 9.6.	Улаанбаатар метрополитан	420
Зураг 9.7.	Олон төвт шийдэл	424
Зураг 9.8.	Зүүн хойд Азийн ачаа тээврийн зангилаа төв	426
Зураг 9.9.	Төрөлжсөн хөгжилтэй хотууд	432
Зураг 9.10.	Орон сууцны бодлого	434
Зураг 9.11.	Үйлдвэрлэлийн технологийн парк	436

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Хүчин төгөлдөр үйлчилж буй хөгжлийн бодлогын баримт бичгүүд	18
Хүснэгт 2.	Суурь үнэт зүйл	25
Хүснэгт 3.	Монгол Улсын хөгжлийн өнөөгийн нөхцөл байдал	32
Хүснэгт 1.1.	Үндэсний нэгдмэл үнэт зүйл зорилгын хэрэгжилтийн хяналт, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин	104
Хүснэгт 2.1.	Сургуулийн насны хүн амын тоо (мянган хүн)	111
Хүснэгт 2.2.	Цэцэрлэгт шаардлагатай багшийн урьдчилсан тооцоо, 2021-2050	115
Хүснэгт 2.3.	ЕБС-д шаардлагатай багшийн урьдчилсан тооцоо, 2025, 2030	115
Хүснэгт 2.4.	Хүний хөгжил зорилгын хэрэгжилтийн хяналт, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин	134
Хүснэгт 3.1.	Амьдралын чанар ба дундаж давхарга зорилгын хэрэгжилтийн хяналт, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин	180
Хүснэгт 4.1.	Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлснээр гарах үр дүнгийн прогноз	206
Хүснэгт 4.2.	Эдийн засаг зорилгын хэрэгжилтийн хяналт, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин	242
Хүснэгт 5.1.	Сайн засаглал зорилгын хэрэгжилтийн хяналт, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин	274
Хүснэгт 6.1.	Тусгай хамгаалалтад авах газар нутгийн хэмжээ	283
Хүснэгт 6.2.	2040 оны нийт усны хэрэгцээний тооцоолол, аймгаар	296
Хүснэгт 6.3.	Усны нөөц, үнэ цэнийг нэмэгдүүлж хамгаалах, хуримтлал бий болгох тооцоолол	297
Хүснэгт 6.4.	Ногоон хөгжил зорилгын хэрэгжилтийн хяналт, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин	304
Хүснэгт 7.1.	Амар тайван, аюулгүй нийгэм зорилгын хэрэгжилтийн хяналт, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин	336
Хүснэгт 8.1.	Дорнод Монголын эдийн засгийн хөгжлийн тэнхлэг, үйлдвэрлэл, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бүсийн эрчим хүчний төслүүд	347
Хүснэгт 8.2.	Дорнод Монголын эдийн засгийн хөгжлийн тэнхлэг, үйлдвэрлэл, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бүсийн зам, тээврийн төслүүд	348

Хүснэгт 8.3.	Хариуцлагатай уул уурхай, өндөр технологид суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээ, палеонтологийн аялал жуулчлалын бүсийн эрчим хүчний төслүүд	354
Хүснэгт 8.4.	Хариуцлагатай уул уурхай, өндөр технологид суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээ, палеонтологийн аялал жуулчлалын бүсийн авто зам, төмөр зам, тээвэр логистикийн төслүүд	354
Хүснэгт 8.5.	Байгалийн нөөц, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бүсийн эрчим хүчний төслүүд	361
Хүснэгт 8.6.	Байгалийн нөөц, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бүсийн авто зам, төмөр зам, тээвэр логистикийн төслүүд	362
Хүснэгт 8.7.	Өрнөд Монголын эдийн засгийн хөгжлийн тэнхлэг, Алтайн соёл, байгалийн нөөц, ногоон хөгжлийн бүсийн эрчим хүчний төслүүд	367
Хүснэгт 8.8.	Өрнөд Монголын эдийн засгийн хөгжлийн тэнхлэг, Алтайн соёл, байгалийн нөөц, ногоон хөгжлийн бүсийн авто зам, төмөр зам, тээвэр логистикийн төслүүд	368
Хүснэгт 8.9.	Хангайн эрчимжсэн хөдөө аж ахуй, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бүс эрчим хүчний төслүүд	374
Хүснэгт 8.10.	Хангайн эрчимжсэн хөдөө аж ахуй, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бүс авто зам, төмөр зам, тээвэр логистикийн төслүүд	375
Хүснэгт 8.11.	Олон улсын шинжлэх ухаан, технологийн төв, тээврийн зангилаа, өндөр технологийн үйлдвэрлэл, үйлчилгээний бүсийн эрчим хүчний төслүүд	380
Хүснэгт 8.12.	Олон улсын шинжлэх ухаан, технологийн төв, тээврийн зангилаа, өндөр технологийн үйлдвэрлэл, үйлчилгээний бүсийн авто зам, төмөр зам, тээвэр логистикийн төслүүд	381
Хүснэгт 8.13.	Монгол Улсын эдийн засгийн микро бүсийн төвүүд	386
Хүснэгт 8.14.	Бүсчилсэн хөгжил зорилгын хэрэгжилтийн хяналт, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин	394
Хүснэгт 9.1.	Улаанбаатар хотын сургуулийн насны хүн амын тоо (мянган хүн)	401
Хүснэгт 9.2.	Улаанбаатар ба дагуул хот зорилгын хэрэгжилтийн хяналт, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин	438
Хүснэгт 4.	Төслийн санхүүжилтийн тооцоо, зорилгоор	441
Хүснэгт 5.	Хэрэгжүүлэх төслийн жагсаалт	442

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

	Товчилсон нэр	Тайлбар
1	ААН	Аж ахуй нэгж
2	ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
3	АНЗДТГ	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар
4	АНУ	Америкийн Нэгдсэн Улс
5	АПЕК	Ази-Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны нийгэмлэг
6	АСЕАН	Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэг
7	АХБ	Азийн хөгжлийн банк
8	БЗД	Баянзүрх дүүрэг
9	БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
10	БНСУ	Бүгд Найрамдах Солонгос
11	БНТУ	Бүгд Найрамдах Турк Улс
12	БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
13	БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
14	БСМС	Боловсролын салбарын мэдээллийн систем
15	БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
16	БҮТ	Боловсролын үнэлгээний төв
17	БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
18	БЦГ	Байгалийн цогцолборт газар
19	ГХГЗЗГ	Газрын харилцаа геодези, зураг зүйн газар
20	ГХО	Гадаадын хөрөнгө оруулалт
21	ГХЯ	Гадаад хэргийн яам
22	ДБ	Дэлхийн банк
23	ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
24	ДНХ	Дезоксирибонуклейны хүчил
25	ДХБ	Дэлхийн худалдааны байгууллага
26	ДХТХ	Дунд хугацааны төсвийн хүрээ
27	ДЦС	Дулааны цахилгаан станц
28	ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
29	ЕАЭЗХ	Евразийн эдийн засгийн холбоо
30	ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
31	ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
32	ЗГ	Засгийн Газар
33	ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
34	ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
35	ЗХУ	Зөвлөлт Холбоот Улс
36	ИДС	Их, дээд сургууль
37	КАХЗГБ	Коридорын асуудал хариуцсан засгийн газрын байгууллага
38	МОУХАН	Монголын олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг
39	МСҮТ	Мэргэжлийн, сургалт, үйлдвэрлэлийн төв
40	МТ	Мэдээллийн технологи

Товчилсон нэр	Тайлбар
41 МУ	Монгол Улс
42 МУИС	Монгол Улсын их сургууль
43 МУТС	Мөнгө угаах терроризмын санхүүжилт
44 МҮХАҮТ	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
45 МХХТ	Мэдээлэл, харилцаа, холбооны технологи
46 МХХТГ	Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар
47 НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
48 НОСДБГ	Нийслэлийн Орон сууцны дэд бүтцийн газар
49 НОСК	Нийслэлийн Орон сууцны корпорац
50 НСГ	Нийслэлийн Статистикийн газар
51 НСЦ	Нарны цахилгаан станц
52 НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
53 НҮБХХ	Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
54 НШУҮИГ	Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газар
55 ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
56 ОӨГ	Оюуны өмчийн газар
57 ОСЗ	Орон сууцны зээл
58 ОСХГ	Орон сууц, хөгжлийн газар
59 ОУ	Олон улс
60 ОУВС	Олон улсын валютын сан
61 ОХУ	Оросын Холбооны Улс
62 ӨНЭЗС	Өрх, нийгэм эдийн засгийн судалгаа
63 СБД	Сүхбаатар дүүрэг
64 СХД	Сонгинохайрхан дүүрэг
65 СЦС	Салхин цахилгаан станц
66 СЯ	Сангийн яам
67 ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
68 ТОСК	Төрийн орон сууцны корпорац
69 ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
70 ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
71 ТХҮБ	Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал
72 ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
73 УАНС	Уур амьсгалын ногоон сан
74 УБ	Улаанбаатар
75 УБТЗ	Улаанбаатар төмөр зам
76 УИХ	Улсын Их Хурал
77 УТ	Улсын төсөв
78 УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
79 УЦС	Усан цахилгаан станц
80 ҮСХ	Үндэсний статистикийн хороо
81 ҮТП	Үйлдвэрлэл, технологийн парк
82 ҮХГ	Үндэсний хөгжлийн газар

Товчилсон нэр	Тайлбар
83 ФАТФ	Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага
84 ХАА	Хөдөө аж ахуй
85 ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
86 ХААҮТП	Хөдөө, аж ахуйн үйлдвэрлэл, технологийн парк
87 ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
88 ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
89 ХЗЗ	Хөрөнгийн зах зээл
90 ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
91 ХУД	Хан-Уул дүүрэг
92 ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
93 ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
94 ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
95 ЦУОШГ	Цаг уур, орчны шинжилгээний газар
96 ШХАБ	Шанхайн хамтын ажиллагааны байгууллага
97 ШШХ	Шингэн шатамхай хий
98 ЭМТ	Эрүүл мэндийн төв
99 ЭМЯ	Эрүүл мэндийн яам
100 ЭСЯ	Элчин сайдын яам
101 ЭХЯ	Эрчим хүчний яам
102 ЭШХ	Эрдэм шинжилгээний хүрээлэн
103 AI	Artificial Intelligence
104 BRT	Bus rapid transit /Тусгай замын автобус/
105 CDI	City development index
106 CERT	Computer emergency response team
107 CGE	Computable general equilibrium
108 CPG	Consumer Packaged goods
109 GGEI	Global Green Economy Index
110 IPO	Initial public offering
111 IPTV	Internet protocol television
112 ISO	International Organization for standardization
113 MICA	Mongolian International Cooperation Agency
114 MOOC	Massive open online courses
115 NDC	Nationally Determined Contribution
116 OER	Open Educational Resources
117 STEM	Science, Technology, Engineering and Mathematics

ӨМНӨТГӨЛ

“МОНГОЛ УЛСЫН СҮҮЛИЙН 30 ЖИЛИЙН ДҮГНЭЛТ БА ИРЭХ 30 ЖИЛИЙН ЗОРИЛГО” БҮХИЙ УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

Монгол Улс 1992 онд шинэ үндсэн хуулиа тунхаглаж, чөлөөт эдийн засаг бүхий ардчилсан тогтолцоонд шилжээд 30 жилийг үдэв. Өнгөрсөн 30 жилд хүний эрх, эрх чөлөө, гадаад харилцаа, чөлөөт хэвлэл, олон намын тогтолцоо бүхий парламентын засаглал, зах зээлийн чөлөөт эдийн засаг зэрэг ардчиллын олон чухал үзүүлэлтүүд Монгол хөрсөнд нутагшин хөгжсөн нь түүхэн ололт юм.

Нөгөө талдаа хүний хөгжлийн үзүүлэлтүүд ухарч, орлогын тэгш бус байдал бий болж, баян ядуугийн ялгаа гүнзгийрч, засаглалын тогтворгүй байдал үүсэж, урт хугацааны бодлого алдагдаж, авлига хээл хахууль газар авч, нийгмийн шударга ёс алдагдаж, Монгол Улсын үндэсний нэгдмэл үнэт зүйлд эрсдэл нүүрлэж байгаа нь бодит сургамж билээ.

Монгол Улс хүний хөгжлийн үзүүлэлтээр дэлхийн 177 орноос 92-р, эдийн засгийн өрсөлдөх чадварын индексээр дэлхийн 140 орноос 99-р, бизнесийн орчны индексээр дэлхийн 190 орноос 74-р, авлигын индексээр 93-р байрыг эзэлж байна. Монгол Улс хөгжлийн олон үзүүлэлтээр бүс нутгийн улс орнууд, дэлхийн дунджаас доогуур байдалтай байсаар байна.

Нийгмийн хөдөлгөгч хүч болсон **дундаж давхарга** эмзэг, нимгэн байгаа нь тэгш бус байдлыг бий болгож, ардчиллын суурь үнэт зүйлийг ганхуулж эхэлж байгаа нь зөвхөн Монголд ч биш, дэлхий дахины тулгамдаж буй асуудал юм.

Тэгш бус байдлаас улбаатай хүндрэл Монгол Улсын хувьд ч өнгөрсөн 30 жилийн үндсэн сорилт байв.

Манай улсад **ядуурлыг бууруулахад чиглэн халамжийн бодлого** хангалттай үр дүнд хүрч чадаагүйг хөгжлийн суурь үзүүлэлтүүд нотолж байна. Цаашид нийгмийн **дундаж давхаргаа дэмжих цогц бодлого** баримталж ажиллах бодит шаардлага үүсэж байна.

Монгол Улсын эдийн засгийн дундаж өсөлт 1990-2017 онд ихээхэн хэлбэлзэлтэй байсаар ирсэн бөгөөд 1995-2000 онд эдийн засгийн өсөлт 2.7 хувь байсан бол 2005-2010 онд дундаж 10.2 хувьд хүрч байлаа.

Сүүлийн 30 орчим жилийн хугацаанд дэлхийн эдийн засгийн хямралаас шалтгаалан 2009 онд эдийн засаг 1.3 хувь хүртлээ унаж байсан бол Оюу Толгойн зэсийн ордыг ашиглах ажил эхэлснээс хойш уул уурхайн салбарын

өсөлт нь эдийн засгийн өсөлтөд нөлөөлж, 2011 онд эдийн засгийн өсөлт 17.3 хувьд хүрч дэлхийд хамгийн өндөр өсөлттэй гарч байв.

Гэвч уул уурхайн түүхий эдийн үнэ буурахтай зэрэгцэн эдийн засгийн өсөлт унаж, улсын төсөв болон өрийн дарамтад засгийн газрыг оруулах нөхцөл байдал үүсгэсэн нь дэлхийн зах зээл дээрх зэс, нүүрсний үнийн хэлбэлзэл, экспортоос ихээхэн хамааралтайг илтгэсэн томоохон сургамж юм.

ДНБ-ий өсөлт 2017 онд 5.3 хувь, 2018 онд 7.2 хувь, 2019 онд хувь орчим өсөхөөр байгаа нь сүүлийн жилүүдэд эдийн засаг сэргэж буйг илтгэж байгаа бөгөөд эдийн засгийн суурь үзүүлэлтүүд сайжирч 2020 онд үргэлжлэх төлөвтэй байна. Гэхдээ цаашид эдийн засгийн өсөлт уул уурхайн салбар, гадаадын шууд хөрөнгө оруулалт, глобал нөхцөл байдлаас хамаарах магадлал хэвээр байна.

Тиймээс урт хугацааны энэхүү хөтөлбөр нь эдийн засгийн төрөлжилтийг сайжруулж, тэргүүлэх салбаруудыг бодлогоор дэмжүүлэн хөгжүүлэх, экспортын шат дараалсан өсөлтийг хангах, нэмүү өртөг шингэсэн үйлдвэржилтийн бодлого урт хугацаанд тогтвортой барих суурь зарчимд тулгуурлан боловсруулагдсан болно.

Монгол Улсын эдийн засгийн бүтцэд 1994 онд хөдөө аж ахуйн салбар 32.3 хувийг эзэлж байсан бол 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 10.8 хувь болж буурсан байхад аж үйлдвэр түүний дотор уул уурхайн салбарын хувийн жин 28.5-41.5 хувь, үйлчилгээний салбар 39.2-47.7 болж тус тус өссөн байна.

Уул уурхайн хөгжлөөс хэт хамааралтай манай улсын эдийн засгийн бүтэц нь эдийн засгийн өсөлт тогтвортой байж, нийгмийн үзүүлэлтүүдэд шилжих боломжийг хязгаарлаж иржээ. Сүүлийн 20 жилийн байдлаас харахад манай улсын эдийн засагт 3-4 жил тутамд өрнөл, уналтын мөчлөг тохиолдож байгаа нь богино хугацааны өсөлтийн нөлөө нь өрхийн амьжиргаа, нийгмийн үзүүлэлтүүдийг сайжруулах боломжийг хязгаарлаж байна. Түүнчлэн, эдийн засгийн өсөлт нь уул уурхайн зэрэг капиталын багтаамжтай цөөн салбар, компаниуд бий болж байгаа нь хүртээмжтэй өсөлт сул байх, өсөлтөөс бий болсон орлого нь импорт (машин тоног төхөөрөмж, шатахуун, эрчим хүч гэх мэт), үйлчилгээ (тээврийн, зураг төсөл, барилга байгууламж зэрэг зөвлөх үйлчилгээ), ногдол ашгийн төлбөрт эргээд гадагшаа гарахад хүргэдэг. Энэ нь нөгөө талаас гадаад худалдааны хамгаалалтын бодлого дутагдсантай холбоотой байна.

Монгол Улсын эдийн засаг өсөхийн хэрээр нэг хүнд ногдох ДНБ хэмжээ нэмэгдэж 1994 онд 174.5 мян.төг байсан бол 2018 онд 10.2 сая төгрөгт хүрч 58.3 дахин нэмэгдсэн нь Дэлхийн банкны Атласын аргаар бодсон, оны үнээр тооцоход 4009 ам дол. болж байна. Үүнийг олон улстай харьцуулан харвал, Монгол Улс нь Ази номхон далайн бүс нутгийн улс орнуудаас дунджаас доогуур орлоготой гэсэн ангилалд багтаж байгаа нь зах зээлд шилжиж эхэлсэн эхний үетэй харьцуулахад том ахиц боловч дэлхийн түвшинд эрэмбэлэхэд тийм ч өндөр түвшин биш юм

Дэлхийн зах зээл дээр зэс, нүүрсний үнэ өсөж байх үед байгалийн баялгаа экспортолж эхэлсэн нь Монгол Улсад эхний үед эерэгээр нөлөөлж байсан ч үнийн хэлбэлзэл нь яваандаа Монгол Улсын ДНБ, экспортын

орлогод нөлөөлж, эдийн засгийн тогтворгүй байдалд хүргэв. Цаашид ашигт малтмалын үнэ гадаад зах зээлийн нөхцөл байдлаас хамаарч эдийн засгийн тогтворгүй байдалд хүргэх эрсдэлийг дагуулав.

Дэлхийн төв банкууд алтны нөөцөө нэмж эхэлсний дээр хөрөнгө оруулалтын багцад алт чухал байр эзлэх болсноор алтны үнэ өсөж эхэллээ. АНУ-д Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ сүүлийн 10 жилд анх удаа бууруулж, богино хугацаатай үнэт цаасны хэлцлийн хүү нь урт хугацаатай хэлцлийн хүүнээс өндөр болж эхэлсэн нь хямралын дохиог өгөв. Харин Хятадын эдийн засгийн өсөлт удааширсны үр дүнд зарим эрдэс бүтээгдэхүүний эрэлтийг багасгаж, улмаар тэдгээрийн үнийг бууруулахад хүргэж байна. Ийм байдал нь Монгол Улсын гол экспортын эрдэс бүтээгдэхүүний үнийн төсөөллүүдэд сөрөг нөлөө үзүүлж төсвийн орлого дутагдаж, гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ буурах төлөвтэй байна. Дэлхийн эдийн засаг уналтад орох өөр нэг дохио нь Евро бүсийн хамгийн том эдийн засаг болох Германы эдийн засгийн өсөлт саарч, аж үйлдвэрийн салбарын хувийн жин буурч буй явдал юм.

Энэ удаагийн дэлхийн эдийн засгийн хүндрэл нь 2008 оны санхүүгийн хямралаас ялгаатай. Өмнөх хямрал нь эрэлтийн шалтгаанаар өдөөгдөж байсан бол энэ удаагийнх АНУ-Хятадын хоорондын худалдааны, ханшны болон технологийн дайнаас үүдэлтэй удаан хугацаанд үргэлжлэх хүчин зүйлсээс хамаарахаар байна. Өмнөх хямралын хор хөнөөлийг төсөв, мөнгөний тэлэх бодлогоор даван туулсан бол энэ удаа эдгээр мөчлөг сөрсөн эдийн засгийн бодлогуудын аль нь ч туслахгүйг зарим эдийн засагчид онцолж байна. 2019-ийн Roubini үзэж байгаагаар энэ удаагийн хямралын шалтгаан нь нэгдүгээрт, АНУ-Хятадын хоорондын худалдааны дайн болон валютын ханшны сулрал, хоёр тал бие биендээ ногдуулахаар болж байгаа импортын тарифуудыг нэмэгдүүлснээр АНУ нь Хятадыг ханшны дайн эхлүүлэгч гэж нэрлээд байна; хоёрдугаарт, технологийн салбар дахь АНУ-Хятадын хоорондын хүйтэн дайн, хиймэл оюун ухаан, роботчлол, 5G зэрэг ирээдүйн аж үйлдвэрийн салбар дахь ноёрхлын төлөөх тэмцэл ширүүслээ. Хөрөнгө оруулагчид цаашид дунд, урт хугацаандаа хүү буурна гэсэн хүлээлттэй байгаа боловч энэ нь АНУ-ын эдийн засаг суларч, Холбооны нөөцийн сангийн бодлогын хүү өмнөх 10 жилтэй адил тэг орчим байна гэсэн хүлээлтийг давхар агуулж байна. Гуравдугаарт, газрын тосны нийлүүлэлттэй холбоотой эрсдэлүүд гарч эхлэв. Худалдааны дайн нь эрчим хүчний нөөцийн эрэлтийг бууруулж, үнэ, ханш буурахад сөргөөр нөлөөлөх хэдий ч АНУ болон Ираны хоорондын зөрчилдөөн нь эсрэг нөлөө үзүүлэхээр байна. Эдгээр зөрчилдөөн нь дэлхий дээр шинэ зэвсэгт мөргөлдөөнийг өдөөж болзошгүй бөгөөд энэ тохиолдолд дэлхийн зах зээлд газрын тосны үнийг хурдацтай өсгөх бөгөөд Ойрх-Дорнодын 1973, 1979, 1990 оны хурцадмал асуудлуудтай адил шинж чанарыг агуулж, глобал хүндрэл бий болохоор байна.

Дээр дурдсан болзошгүй 3 хүчин зүйл буюу худалдааны, ханшийн дайн болон технологийн өрсөлдөөн улс орнуудад эдийн засгийн уналт, өндөр инфляцыг нэгэн зэрэг бий болгох буюу импортын хэрэглээний бүтээгдэхүүн, завсрын орцууд, технологийн бүрдлүүд болон энергийн үнийг өсгөн глобал нийлүүлэлтийн сүлжээг тасалдуулах замаар үйлдвэрлэлийг бууруулахад хүргэж болзошгүй юм. Түүнчлэн дэлхийн тавцанд улс орнууд харилцан

нэг нэгэнтэйгээ сэргэлдэх нөлөөг бий болгож, энэ нь удаан хугацаанд үргэлжлэх тохиолдолд мөнгөний болон төсвийн бодлого тэлэх нь өмнөх хямралтай адил нөлөөтэй эсэх нь эргэлзээтэй² болно.

Монгол Улсын хүн 2018 оны эцэст 3,238.5 мянга болж, хүн амын дундаж өсөлт 2010 он хүртэл 1.4 хувь байсан. Харин 2010 оноос дундаж өсөлт 2 хувьд хүрсэн бол сүүлийн 3 жилд энэ үзүүлэлт хадгалагдсан хэвээр байна. Хүн амын жилийн дундаж өсөлт 1990-2018 онд буюу 28 жилийн хугацаанд хүн амын жилийн дундаж өсөлт 1.5 хувь байна. Мөн өнгөрсөн 28 жилийн хугацаанд бүс, нутгуудын хүн амын өсөлт хэлбэлзэлтэй байсан ч Баруун болон Зүүн бүсүүдийн хувьд 2010 онд хүртэл дундаж өсөлт хасах үзүүлэлттэй байсан. Түүнчлэн Монгол Улсын 4 бүсийн хүн амын өсөлт 2000-2005 онд хасах гарсан ба харин нийслэл Улаанбаатар хотын хүн амын өсөлт энэ 28 жилийн хугацаанд хамгийн өндөр өсөлттэй буюу сүүлийн 5 жилийн хугацаанд жилийн дундаж өсөлт 5.6 хувьд хүрсэн байна. Улаанбаатар хотын эдийн засаг, хүн амын хэт төвлөрөл нь хот болон хөдөөгийн хөгжлийг ялгааг ихэсгэж нийслэлд агаар, усны бохирдол, замын түгжрэл, инженерийн дэд бүтцийн хомстол зэрэг тулгамдсан асуудлуудыг үүсгэж байна. Сүүлийн 7 жилд бусад бүсүүдтэй харьцуулахад Улаанбаатар хотын хүний хөгжлийн индекс хамгийн өндөр гарч, Монголын хүний хөгжлийн индексийн түвшингээс давсан байна. Энэ нь Улаанбаатарын бүсэд харьцангуй боловсролтой, ур чадвартай, бүтээмж өндөртэй ажиллах хүчин байдаг, чанартай, хямд эрүүл мэндийн болон соёл, урлагийн үйлчилгээ авах боломжтой учир хүн амын наслалтын түвшин өндөр, бизнес эрхлэх харьцангуй өргөн боломжтой, төлбөрийн чадвартай зах зээлд ойрхон учир 1 хүн ногдох орлогын хэмжээ илүү өндөр байдагтай холбоотой гэж үзэж байна.

Монгол Улсын хүн амын ядуурлын түвшин 2018 оны байдлаар 28.4 хувь байгаа ба засгийн газрын гадаад өр 28 тэрбум долларт хүрч, ДНБ-ий 240 хувьтай тэнцэж, зөвхөн гадаад өрийн хүүгийн төлбөрт жилд 1 их наяд төгрөг төлж, төсвийн алдагдал 2 их наяд төгрөгт хүрсэн байна. Гадаад өрийн дарамттай байдлын зэрэгцээ Монгол Улсын дотоод нийгэм, улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан “Оюу толгой” төслийн зөрчилдөөн, маргаантай байдал үргэлжилж байгаа нь гадаадын шууд хөрөнгө оруулалтын цаашдын төлөв хандлагад сөргөөр нөлөөлөх, далд уурхайг ашиглалтад оруулах хугацаа илүү сунжрахад хүргэж болзошгүй. Тус уурхай анх 2021 онд ашиглалтад орно гэж тооцож байсан бол одоо 2024 он хүртэл хойшлох нөхцөл байдал үүсэв. Энэ хугацаагаар экспортын орлого хойшилж, импорт, үйлчилгээний гадаад төлбөр тооцоо, төлбөрийн тэнцлийн дарамт нэмэгдэх болно.

Эдийн засгийн сэргэлтээс нийгмийн үзүүлэлтүүд (ядуурал, тэгш бус байдал, боловсрол, эрүүл мэнд, цэвэр ус, цэвэрлэх байгууламж, инноваци, хүмүүн капитал, дэд бүтэц гэх мэт) рүү шилжих үндсэн суваг нь улсын төсөв болж байна. Хэдийгээр энэ нь өрхийн орлогоор дамжих боломжтой хэдий ч хүн амын дийлэнх хэсэгт орлогын дорвитой өсөлт ажиглагдахгүй байгаагаас энэ суваг харьцангуй сул байна. Нөгөө талаас, эдгээр нийгмийн үйлчилгээг авагчдын дийлэнх нь хувийн секторт орж ажиллах сонирхолгүй байна. Энэ тохиолдолд улсын төсвөөс энэ зориулалтаар олгож буй санхүүжилт хангалтгүй, зорилтот бүлэгтээ хүрч чадахгүй, улсын төсвийн хөрөнгө

оруулалт үр ашигтай байж чадахгүй зэрэг олон асуудлууд урган гардаг. Эдийн засгийн хүндрэлийн жилүүдэд авч зарцуулсан улсын өрийн хүүний төлбөр, үндсэн төлбөрөө төлөхөд анхаарсаар байтал нийгмийн асуудлуудаа дорвитой шийдэж чадахгүй байх хооронд он жилүүд өнгөрсөөр ирлээ. Эдгээр дотоод, гадаад орчинд үүсээд байгаа нөхцөл байдал нь дотоод эдийн засгийн дунд хугацааны төлөв байдал нэлээд хүндэвтэр байх дохиог бидэнд өгч байна.

Сүүлийн жилүүдийн төсвийн хэт тэлэлтийн үед аж ахуйн нэгжүүд болон өрхүүдийн өрийн дарамт илт нэмэгдэв. Орон сууцны 8 хувийн зээлийн хөтөлбөр 2013 онд хэрэгжиж эхэлснээс хойш өрхүүдийн дарамт илт нэмэгдэж эхлэн өрхийн өр, ДНБ-ий харьцаа 40 хувьд дөхөж ирээд байна. Ийнхүү өртэй байдал нэмэгдэх нь өрхүүд хэрэглээгээ хумих үзэгдэл эхэндээ ажиглагдаж, эдийн засгийн уналтад хувь нэмэр оруулсан, цаашдаа ч оруулахаар байна. Эдийн засаг сэргэж эхлэх үед орон сууцны зээлийн төлбөрийн дараа үлдэх хэсэг бусад хэрэглээний өсөлтийг хангахад хүрэлцэхгүй тул өрхүүд хэрэглээний зээл илүүтэй авч эхэлснээр өрхийн өрийн дарамтыг улам нэмэгдүүлэх хандлага ажиглагдав. Энэхүү өрийн дарамт нь дараагийн эдийн засгийн хүндрэлийн үед өрхийн санхүү улам муудах, улмаар банкны салбарт зээлийн эрсдэл хүчтэй нэмэгдэх эрсдэлийг бий болгож байна. Өнөөг хүртэл банкнаас бусад санхүүгийн байгууллагуудад үүнээс сэргийлэх арга хэмжээг давхар авч хэрэгжүүлэхгүй байгаа нь хэрэглээний зээлийн хүсэлт, үүнийг дагаад холбогдох эрсдэл нь банк бус салбар руу шилжихэд хүргэж байна. Өрхүүд илүү өндөр хүүтэй зээл авч (банк бус санхүүгийн байгууллагын дундаж хүү нь банкны салбарынхнаас 2.5 дахин өндөр буюу жилийн 40 гаруй хувь байна) өрхийн өрийн дарамтыг улам нэмэгдүүлж байна.

Энэ бүхнээс үндэслэн дүгнэхэд Монгол Улсын цаашдын ирээдүйн макро эдийн засгийн бодлого нь урт хугацаанд тогтвортой, мөчлөг сөрсөн, өрийн дарамт болон зардлын өсөлтийн нарийвчлан тооцсон аргачлалаар дунд хугацаанд эдийн засгийг тогтворжуулж, улмаар урт хугацаанд тогтвортой хөгжлийг хангасан өөрөө өөрийгөө тэтгэсэн, гадаад зах зээлийн сөрөг өөрчлөлтөөс дархлагдсан байх шаардлагатай бөгөөд эдийн засгийн өсөлт хүний хөгжил, дундаж орлоготой иргэдийг тэтгэх цогц бодлого уруу илүүтэй чиглэх бодит шаардлагыг бий болгож байна.

Эл утгаар бид өнгөрсөн 30 жилийг бүхэлд нь дүгнэж, ирэх 30 жилийг урт хугацаагаар төсөөлөх урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах түүхэн шаардлага үүсэж байна.

МОНГОЛ УЛС ХӨГЖЛИЙН БОДЛОГО БОЛОВСРУУЛЖ, ХЭРЭГЖҮҮЛЖ ИРСЭН ТҮҮХЭН ТОВЧОО

Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн түүхэн үечлэлийг дараах байдлаар тоймлож болно.

1911–1920 он: ҮНДЭСНИЙ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТӨЛӨӨ ТЭМЦЛИЙН ЯЛАЛТЫН ҮЕ

“ҮНДЭСНИЙ ЭРХ ЧӨЛӨӨ, ТУСГААР ТОГТНОЛОО ОЛСОН ҮЕ”

Улс төр: Манжийн төр сулран доройтсоноор монголчууд Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэж, үндэсний ухамсар сэргэж, 1911 оны 12 сарын 29-нд “Богд Хаант Монгол Улс”-ыг байгуулан Манжаас бүрэн тусгаарлав. 1914 онд дээд, доод танхимтай Улсын хурлыг байгуулж, хурлын гишүүд нь сонгуулийн бус зарчмаар гарч ирсэн боловч иргэдийн санал авснаараа парламентын засаглалтай ижил төстэй байв. Анхны Засгийн газар таван яамтайгаар байгуулагдаж, Ерөнхий сайдаар Сайн ноён хан Т.Намнансүрэн ажиллаж байв.

Хөгжлийн бодлого: Богд Хаант Монгол Улсын эхний зорилго нь олж авсан тусгаар тогтнолоо бусад орнуудаар баталгаажуулах, шинэ тулгар төрийг бэхжүүлэх, улс орныхоо аж ахуйг хөгжүүлэхэд түлхүү анхаарч байв. Тариалангийн аж ахуйг дэмжих, атар газрыг эзэмших зорилгоор “Газрыг түрээслэх тусгай дүрэм”, “Алт мөнгөний зэрэг уурхайг нээх дүрэм” батлан, гадаад дотоодын хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллаж байв. Мөнгөн гүйлгээ эмх замбараагүй олон валютаар хийгдэж байсан бөгөөд зээл олгох, төлбөр тооцоо гүйцэтгэх үйл ажиллагааг хариуцан явуулах байгууллагыг хараахан бий болгож чадаагүй юм.

Ололт: Улс орны аж ахуйг босгоход хөрөнгийн эх үүсвэр шаардлагатай байсан бөгөөд гадаадын хөрөнгө оруулалтаар алт олборлох “Монголор” хамтарсан нийгэмлэг байгуулан олборлолт явуулж, тус нийгэмлэг улсын төсөвт нийт олборлосон алтны 16 хувьтай тэнцэх татвар төлж 2800 ажлын байр бий болгож байв. Монгол Улсын засгийн газар 1914 оны гуравдугаар сард газар тариаланг ашиглах талаар журам гаргав. Энэ ажлыг өрнүүлэхдээ эхний удаа улсаас эд материалын тусламж үзүүлж, тарьсны дараа 3 хувийнх нь 1 хувийг үр болгож, 1 хувийг улсын санд өгч, 1 хувийг нутаг хошууны иргэдийн хэрэгцээнд гэсэн хуваариар явуулав. Энэ нь газар тариалангийн талаар тодорхой бодлого баримтлан төрийн зохицуулалт хийх болсон дэвшил байлаа.

Нийгмийн салбарт түлхүү анхаарч, 1912 онд анхны бага сургуулийг Нийслэл хүрээнд байгуулж, улмаар аймаг, хошуудад нийт 60 гаруй сургууль байгуулав. 1913 оноос Сонин хэвлэл, Утасны хороо, Шинжлэх ухааны хүрээлэн байгуулсан нь харилцаа холбоо, хэвлэл мэдээлэл, шинжлэх ухааны салбарын хөгжлийн эхлэл болжээ. Манж, Хятадын худалдааны пүүсүүдийг татан буулгаж, иргэдийг өрөөс чөлөөлөн эд хөрөнгийг улсын орлого болгож байв.

Сургамж: Улс төрийн хувьд тусгаар тогтносон улсынхаа нийгмийн бүлгүүдийн хоорондын зөрчлийг зөвшилцөл болгож чадаагүй нь шарын шашны ноёд, төрийн /хар/ ноёдын хоорондын зөрчлөөс харагдаж байв. Төр нь ноёдын урвалт, шарвалт, эв нэгдэлгүй байдал, шунахай улс төрчдийн увайгүй үйлдлийг хязгаарлаж чадаагүй. Энэ нь Монгол Улсын цаашдын хөгжилд заавал анхааран авч үзэх ёстой асуудал юм. Үндэсний манлайлагчид, төр, нийгмийн зүтгэлтнүүдийнхээ амь насыг хамгаалж чадаагүй явдал тухайн үед иргэдийн итгэлийг алдахад хүргэж байв. Үндэсний аюулгүй байдлын дархлаа бүрдэж чадаагүйн улмаас тусгаар тогтнолоо алдаж байсан гашуун түүхтэй. Мөн олон дээд ноёд, лам нар албат ардаасаа татвар авахын хажуугаар, цалин пүнлүү авч байгаа нэрээр улсын санг хоосруулж байсан нь эдийн засгийн тэнцвэртэй бодлого явуулж чадаагүйтэй холбоотой. 1916 оны байдлаар Монгол Улсын төсвийн орлого нь зарлагаа нөхөж чадахгүйд хүрсэн тул жилээс жилд алдагдалд орж, Оросоос 5 сая рублийн зээл авч байв. Европ, Америкийн худалдаачид хятад худалдаачдаар дамжуулан Монголын түүхий эдийг хямд үнээр борлуулах худалдааны сүлжээ бий болов.

1921–1924 он: АРДЫН ХУВЬСГАЛЫН ҮЕ

“ҮНДЭСНИЙ ЭРХ ЧӨЛӨӨ, ТУСГААР ТОГТНОЛОО СЭРГЭЭЖ, БАТАЛГААЖУУЛСАН ҮЕ”

Улс төр: Гадаад, дотоодод үүссэн нөхцөл байдлыг зөв үнэлэн, эвлэлдэн нэгдэж, 1921 онд Ардын хувьсгал ялсан бөгөөд улмаар Богд Хаант Монгол Улсыг сэргээн байгуулав. 1924 онд “Анхны үндсэн хууль”-ийг баталж, Шашин төрийг тусгаарлан БНМАУ-ыг байгуулав.

Зураг 1. БНМАУ-ын Үндсэн хууль




Эх сурвалж: Архивын ерөнхий газар

Хөгжлийн бодлого: 1921 онд Ардын хувьсгал ялснаар Монгол ардын нам “Бид улс орноо харгис капиталын мөлжлөгийн замаар явуулахгүй, хөрөнгөтний биш хөгжлийн замаар хөгжиж, гадаад орнуудад дарлуулахгүй, тусгаар тогтнолоо хамгаална” гэж тунхаглав. 1923 онд “Эдийн засгийн үндсэн бодлого” боловсруулан баталсан бол 1924 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар Засгийн газрын дэргэд Эдийн засгийн зөвлөл байгуулав. Тус зөвлөл нь аж ахуй, санхүүгийн бодлогыг улсын хэмжээнд нэгтгэн явуулахад онцгой анхаарч, аж ахуйн үйл ажиллагааны гүйцэтгэлийг бүртгэн судлах, улс орны эдийн засгийн ойрын ирээдүйн хөгжлийн төлөвийг тодорхойлох талаар идэвхийлэн ажиллаж байв. “Эдийн засгийн үндсэн бодлого” баримт бичигт тусгаснаар Герман, Англи, Орос, Америк, Хятад гэх мэт хэмээн өрнөдийн өндөр хөгжилтэй орнуудтай харилцан хамтран ажиллах бодлого баримталж байв /МАХН-н түүхэнд холбогдох баримт бичгүүд 1920-1940 он I дэвтэр УБ 1966/.

1924 оны 12-р сард Ардын Засгийн газрын 44-р тогтоолоор Аж ахуйн яам шинээр байгуулж, Сангийн яамны Баялгийг бадруулах хэлтэс нь худалдаа, үйлдвэр, мал аж ахуй, газар тариалан, ой мод, уул уурхай зэрэг салбаруудыг хариуцах болов.

Зураг 2. 1924 оны Ардын Засгийн газрын 44 дүгээр тогтоол



Эх сурвалж: Архивын ерөнхий газар

Ололт: 1921 онд эх орноо гадаадын дарангуйллаас чөлөөлж, тусгаар тогтнолоо сэргээн зарлаж, Анхдугаар Үндсэн хуулийг батлан, Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг зарлан тунхаглав. Ард түмний хүсэл зоригт тулгуурлан төр-засгийн эрх мэдлийг хэрэгжүүлж, дотооддоо бүх хүн тэгш эрхтэй болохыг тунхаглан, язгуур угсаа болон шүүхийн харгис аргуудыг

устган хамжлагат ёсыг халав. Мөн бүх нийтээр бичигтэн болох нийт ардын боловсрол болон эрүүл мэндийг хамгаалах систем тогтоох арга хэмжээнүүдийг авч байсны үр дүнд олон арван бага сургууль, Багшийн сургууль байгуулагдсан ба хүн эмнэлэг болон мал эмнэлгүүдийг олноор байгуулжээ. Түүнээс гадна үндэсний үйлдвэрийг байгуулан өөрийн хэрэгцээг хангах зорилгоор ноос угаах, хувцас оёх, эсгий эдлэл хийх, гэр ахуйн эдлэл хийдэг жижиг артель, цехүүдийг байгуулж, үндэсний худалдааны байгууллага болох “Монгол хоршоо”-г байгуулав.

1924 оны 06 дугаар сарын 02-нд Зөвлөлт-Монголын хувь нийлүүлсэн “Худалдаа ба аж үйлдвэрийн банк (Монгол банк)” байгуулагдаж, 1925 оны 12 дугаар сарын 09-нд “Үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөг”-ийг гүйлгээнд гаргажээ. 1923 оны 3 дугаар сарын 22-нд баталсан “Монгол улсын олон засаг ба засаг бус ван гүнгүүдийн эрх хэмжээний дүрэм”-ээр олон зууны турш нийгмийн дарлагч анги байсан ихэс ноёдын засаглах эрхийг эгнэгт устгаж, хэтэрхий эрх ямба, сүр хүчийг хязгаарлав. Энэхүү дүрэм нь Монгол Улсын бүх иргэдийг хуулийн өмнө тэгш эрхтэй байх нөхцөлийг бүрдүүлэхэд чухал алхам болжээ.

Сургамж: Гадаадын хөрөнгө оруулалтыг хөөн зайлуулж, улмаар ЗХУ-аас бүхий л хүрээнд хараат байдалд оров. 1921 оны хувьсгалын зүтгэлтнүүд өөр хоорондоо маргалдан тэмцэж, нэг нэгийгээ эрсдүүлэн хэлмэгдүүлэх эхлэл тавигдав.

1925-1940 оны ҮЕИЙН ТӨРИЙН БОДЛОГО

“КАПИТАЛИСТ БУС ХӨГЖЛИЙН ЗАМ”

Улс төр: Коминтерний шахалтаар улс төрийн их хэлмэгдүүлэлт явагдаж, сүм хийдийг нураан, лам, ноёдын хөрөнгийг хурааж, хүчээр хамтрал, коммуныг байгуулав. 1939 онд Японы эзэрхэг түрэмгийлэгчийн санаархлыг тас цохин Халхын голын дайн-д ялав.

Хөгжлийн бодлого: Эдгээр жилүүдэд төрийн бодлого эдийн засгийн бүх салбарыг онцлон анхаарч, ардын хувьсгалын үзэл санааг нийгмийн бүхий л хүрээнд өргөжүүлж, улс орны эдийн засгийн тусгаар тогтнолыг бататгах зорилтыг дэвшүүлж, хөрөнгөтний биш хөгжлийн зам дээр баттай гарах бэлтгэлийг бүрэн хангахад чиглэж байв.

1928 онд МАХН-ын зүүн жигүүр хүчээр нийгэмчлэх бодлого явуулж, завхрал бий болгосны улмаас 1929-1932 онд эдийн засаг, нийгэм, улс төрийн хямрал тохиолдов.

Эдийн засгийн зөвлөл 1925-1932 он хүртэл ажилласан бөгөөд түүнийг 1932 онд татан буулгаж, 1932 оны 5 дугаар сард нийгэм, эдийн засагт үүссэн нөхцөл байдлыг арилгах зорилгоор “Шинэ эргэлтийн бодлого” боловсруулж, батлав.

1932 онд БНМАУ-ын 17 дугаар онц бага хурлаар ардын аж ахуйг хоршоолон хамтралжуулах үндсэн дээр “Эдийн засгийн зөвлөл”-ийг Сайд нарын зөвлөлийн дэргэд Улсын төлөвлөх, тэгшитгэх, Улсын тоо бүртгэлийн газар

болгон өөрчлөн байгуулав.

Ололт: Буруу бодлогын уршгаар Улс төр, нийгэм, эдийн засагт үүссэн завхралыг арилгах “Шинэ эргэлтийн бодлого” боловсруулж даван туулав.

Тархай бутархай, зөвхөн өрхийн амьжиргааг авч явсан мал аж ахуйг нэгтгэх оролдлогууд хийгдэв. 1919-1940 онуудад бодит үндэсний нийт орлого (ҮНО)-ын дундаж өсөлт 5.7 хувь байв.

Сургамж: 1930-аад оноос эхлэн ноёд, баян лам нар, баячуудын хөрөнгийг хураан, малчдыг хүчээр хамтралжуулах бодлого баримталсны хор уршгаар 1932 онд зэвсэгт бослого гарсан төдийгүй олон тооны хүн хилийн чанадад дүрвэн гарав. Коминтернийн шахалтаар зүүнтэн, баруунтанг илрүүлэн улс төрийн хэлмэгдүүлэлт явагдсан байна. Коминтерний буруу бодлогоос үүдэн эдийн засгийн хямрал болов. Их хэлмэгдүүлэлтийн үнэ цэн 30 гаруй мянган иргэний аминд хүрсэн нь хүн амын өсөлтөд сөргөөр нөлөөлж, улс орны хөгжилд ухралт болов.

1940–1966 он: СОЦИАЛИСТ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТАД ШИЛЖСЭН ҮЕ


“СОЦИАЛИСТ ХӨГЖЛИЙН ЭХЛЭЛ”

Улс төр: Дэлхийн 2-р дайнд ЗХУ-ыг бүх талаар дэмжиж, туслав. Японы түрэмгийллээс Зүүн Хойд Азийг чөлөөлөх дайнд оролцож, ялалт байгуулсан нь олон улсад тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлж, Нэгдсэн Үндэсний байгууллага (НҮБ)-ын бүрэн эрхт гишүүн болов.

Найман удаагийн **таван жилийн** төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлсэн нь нийгэм, эдийн засгийн хөгжлийн дэвшлийг бий болгож байсан бөгөөд 1950-1960 он бол БНМАУ-ын хөгжлийн оргил үе байсан төдийгүй дэлхийд хөгжлийн хурдцаар тэргүүлэх орнуудын эгнээнд орж байв.

Хөгжлийн бодлого: Анхдугаар таван жилийн төлөвлөгөө баталж, улс орныхоо хөгжлийг шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөх болов. Дайны болон түүний дараах жилүүдэд мал аж ахуйг хөгжүүлэх тухайд чухалчлан анхаарч, 1942 оны дайны хүнд хэцүү цаг үеэр улс орныхоо эдийн засгийг хамгаалах, өсгөх, соёл боловсролын салбарыг хөгжүүлэх талаар олон арга хэмжээ авч хэрэгжүүлэв. 1940 оны 5-р сарын 24-нд Сайд нарын зөвлөлийн 21-р тогтоолоор Сайд нарын зөвлөлийн дэргэд “Улсын төлөвлөх, тэгшитгэх, Улсын тоо бүртгэлийн газар”-ыг Сайд нарын зөвлөлийн дэргэд “Төлөвлөгөө, тоо бүртгэл, хянан шалгах газар” болгон өөрчлөв.

Зураг 3. Сайд нарын зөвлөлийн 21 дүгээр хурлын тэмдэглэлээс



Эх сурвалж: Архивын ерөнхий газар

Эдийн засгийг нэгтгэн удирдах шаардлага улам өсөж ирснийг харгалзан Улсын бага хурлын Тэргүүлэгчдийн 1945 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 106 дугаар тогтоолоор Улсын төлөвлөгөөний комиссыг байгуулав. Улсын төлөвлөгөөний комисс нь жил, таван жилийн төлөвлөгөө, улмаар 10-20 жилийн хугацааны эдийн засаг, нийгмийн хөгжлийн төсөөлөл, зорилтот программ боловсруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байв. Улсын төлөвлөгөөний комисс нь улс ардын аж ахуйг хөгжүүлэх төлөвлөгөөг зохиох, тоо бүртгэлийг эрхлэн явуулах, тус улсын бүх эд хогшил, материал, үнэ бүхий зүйлийн фондыг бүртгэх, хуваарилах, тэдгээрийг зөв зарцуулахад хяналт тавих, улс ардын аж ахуйн төлөвлөгөөний биелэлтэд болон нам, засгийн гаргасан бүх тогтоол шийдвэрийн биелэлтэд үргэлжийн хяналт шалгалт тавьж байжээ. Монгол Улсын ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх найман удаагийн таван жилийн төлөвлөгөөг баталсан байна.

Ололт: Дэлхийн хоёрдугаар дайны дараа 1945 онд болсон Ялалтын бага хурлын үр дүнд Монгол Улсын тусгаар тогтнолыг ЗХУ, БНХАУ албан ёсоор хүлээн зөвшөөрч, Монгол Улсын тусгаар тогтнол олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөж, НҮБ-ын гишүүн орноор элсэв. 1961 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн болж, өрнөдийн орнуудтай дипломат харилцаа тогтоов.

1941 оноос хойших эхний арван гаруй жилд кирилл үсэг дээр үндэслэсэн монгол үсэгт сургах ажлыг орон даяар эрчимтэй зохиож, аймаг, хотын төвд кирилл монгол үсгийн багш нарыг бэлтгэх тусгай курс байгуулж, анхны 268 багш бэлтгэн гаргав.

Нэгдэлжих хөдөлгөөн ялж, аж үйлдвэрийн суурь тавигдан ажилчин анги бүрдэж эхлэв.

1959 онд амины малыг ахин тоолж нийгэмчлэх ажил өрнөв. Ардууд өмч хөрөнгөө нэгтгэн хамтран ажиллах бололцоотой болж, нэгдлийг түшиглэн эмнэлэг, сургууль бий болж төв суурин газар үүсэх болов. Аж үйлдвэрийн комбинатыг шинээр тоноглож, мах комбинат, дулааны цахилгаан станц, тоосго, савангийн завод, аймгуудад 200 орчим хүнсний үйлдвэр баригдав.

Улс ардын аж ахуйн салбаруудад оруулсан хөрөнгө оруулалт 1940 оны байдлаар 17.2 сая төгрөг байсан бол 1960 онд нийт хөрөнгө оруулалт 579.4 сая төгрөг болж 33 дахин өсөв.

1950-1960 онуудад ДНБ 10.1 хувь өсөж хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн орон болов.

Сургамж: 1990 он хүртэл Улс ардын аж ахуйг хөгжүүлэх сайн төлөвлөгөөтэй байсан ч түүний хэрэгжүүлэх санхүү, хөрөнгө оруулалтын асуудлыг бүрэн шийдвэрлэж чадаагүй. Малын тоог хангай, говийн нутагт ялгавартайгаар тогтоосон нь малчдын зүгээс малаа өсгөх идэвх сонирхлыг бууруулав. Малыг нэг дор олноор суурилж, төрөлжүүлж маллах болсон нь бэлчээрийн даацыг багасгах, улмаар байгальд зарим сөрөг нөлөөг үзүүлэв.

Эдийн засаг, нийгмийн хөгжилд ахиц дэвшил гаргаж байсан ч, зөвхөн хуваагдсан дэлхийн нэг лагерьтай эдийн засгийн харилцаа үүсгэснээр өөрийгөө дэлхийн өндөр хөгжилтэй барууны орнуудаас тусгаарлаж эхлэв. Энэ үед улс орны хөгжил илт урагш ахисан ч манайд тусалж байсан ЗХУ болон социалист орнууд бусад өндөр хөгжилтэй орнуудаас илт хоцорч байсан учраас шинжлэх ухаан, техникийн хамгийн орчин үеийн дэвшлийг тэр бүр мэдэрч хүлээн авч чадаагүй юм.

1966–1989 он: СОЦИАЛИСТ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ ЭРЧИМЖСЭН ҮЕ

“СОЦИАЛИСТ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ”

Улс төр: Эдгээр он жилүүдэд социалист лагерийн орнуудтай “Эдийн засгийн харилцан туслалцах нягт хамтын ажиллагаа” өрнүүлж, үндэсний сэхээтэн, ажилчин анги бий болж, ойролцоогоор 110,000 орчим инженер, техникийн ажилчдыг гадаад, дотоодод бэлтгэв.

Аж үйлдвэр, ХАА-н орон болж, хөгжлийн хурдаар дэлхийд тэргүүлэх орнуудын нэг болов.

Хөгжлийн бодлого: Социалист нийгэм эдийн засгийг хөгжүүлэхэд Улс ардын аж ахуйн салбар хооронд, үйлдвэрлэл хэрэглээний хооронд зөв тэнцвэр баримтлах, улс орны үйлдвэрлэх хүчнийг хамгийн зүй зохистой байрлуулах, хөдөлмөр, эд материал, санхүүгийн нөөцийг үр бүтээлтэй ашиглах, дотоодын бүх нөөц бололцоог дээд хэмжээгээр дайчлах, хоорондоо уялдаа холбоотой, бие биеэ нөхөн хангадаг эдийн засгийн салбар бий болгоход анхаарч байжээ.

Улс төр, нийгэм, эдийн засаг, соёл, оюун санааны үзэл сурталд томоохон дэвшил гарав.

Атар газрыг эзэмших, эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, түүний хүрээнд

хөдөлмөрлөх хүчний хөгжил байршлыг тогтоон, аж үйлдвэржилтийн бодлого боловсруулав.

Ололт: 1978-1984 онуудад “БНМАУ-ын хөдөө аж ахуйг хөгжүүлэх ба хүн амын хүнсний хангамжийг сайжруулах зорилтот программ”, “БНМАУ-ын Эрдэс баялгийн бааз байгуулах болон геологи-хайгуулын ажлыг хөгжүүлэх программ”, “БНМАУ-ын үйлдвэрлэх хүчний хөгжил, байршлын ерөнхий схем” зэрэг 15-20 жилийн урт хугацааны бодлогыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр боловсруулжээ.

Соёлын хувьсгал буюу бүх нийтээр бичиг үсэгтэй болж, их дээд сургуулиуд төрөлжиж, техник мэргэжлийн сургууль, техникум, дээд сургуулийн тогтолцоо бий болов.

Нэгдэлжих хөдөлгөөн ялж, энэ хугацаанд Дархан Эрдэнэт, Чойбалсан гээд олон арван хотуудыг бүтээн байгуулж, төмөр зам, автозам, иргэний агаарын тээвэр, худалдааны трест, материал техникийн хангамжийн баазуудыг байгуулан олон зуун үйлдвэрийг байгуулжээ.

Атар газрыг эзэмшиж, газар тариаланг хөгжүүлэх замаар хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, мал аж ахуйн тогтвортой өсөлтийг хангах, орчин үеийн техник, технологи нэвтрүүлэх, эдийн засгийн хөгжлийг хурдасгах шаардлагын дагуу атрын гурван удаагийн аян өрнүүлэв.

1940 онд үйлдвэрлэж байсан аж үйлдвэрийн жилийн бүтээгдэхүүнийг 1980 онд есөн өдрийн дотор үйлдвэрлэдэг болжээ.

1980-1990 оны үед үндэсний орлогын жилийн дундаж өсөлт 6.1 хувь, бүтээгдэхүүний өсөлтийн жилийн дундаж хурдац аж үйлдвэрт 8.7 хувь, ХАА-д 4.25 хувь байсан бөгөөд улсын хэмжээнд хөдөлмөрийн бүтээмж жил тутам дөрвөн хувиар дээшилж байжээ.

1988 онд Улсын төлөвлөгөөний комиссыг өөрчлөн Төлөвлөгөө, эдийн засгийн улсын хороо байгуулсан бөгөөд уг хороо нь 1990 он хүртэл хоёр жилийн хугацаатай ажиллажээ.

1986-1990 оны байдлаар улсын үйлдвэрлэл-техникийн зориулалттай бараа 83 хувь, хүн амын өргөн хэрэгцээний бараа 17 хувийг эзэлж байв.

Сургамж: Маш сайн боловсруулсан урт хугацааны бодлоготой байсан хэдий ч санхүү, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэж чадаагүй, зөвхөн ЗХУ-ын зээл тусламжид дулдуйдаж байжээ.

Иргэдийн эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх боломж сул, чөлөөт хэвлэл байхгүй байсан бөгөөд зах зээлийн түлхэх зарчимд суурилсан аж үйлдвэрлэлийн тогтолцооны гажуудал үүсэх болов.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн сул талуудыг арилгаж чадаагүй. Зөвхөн ЗХУ болон социалист орнуудтай хийх болсон гадаад худалдаа эдийн засгийн хөгжлийг боомилж эхлэв.

ЗХУ болон социалист орнуудын түүхий эд бэлтгэх бааз орон болж хувирсан байв. Улс орны экспортын нөөц боломж нь импортын хэрэгцээнээс дутуу байсан ба экспорт, импортын энэ зөрүүгээс болоод ЗХУ-аас хүүгүй болон 2 хувийн хүүтэй барааны зээл авч байжээ.

1989–2019 он: АРДЧИЛСАН ХУВЬСГАЛЫН 30 ЖИЛ

“ХҮМҮҮНЛЭГ АРДЧИЛСАН, ИРГЭНИЙ НИЙГЭМ БАЙГУУЛАХ, ЭРХ ЧӨЛӨӨ, ХҮНИЙ ЭРХ, ТӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЗАХ ЗЭЭЛ”

Улс төр: БНМАУ-д ардчилсан хөдөлгөөн өрнөж, нийгэм эдийн засгийн өөрчлөлт хийгдэн, Ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдав. БНМАУ-ын өмч хувьчлалын тухай хууль 1991 оны 5 сарын 22-нд батлагдсанаар улсын өмчийг цэнхэр болон ягаан тасалбараар иргэдэд тараан хувьчлах эхлэл тавигдав.

1991 онд ОУВС, ДБ, АХБ-ны гишүүнээр элсэв.

Гадаад зөвлөхүүдийн заавраар “Эдийн засгийг зах зээлийн зохицуулалтад шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 20 дугаар тогтоол гаргаснаар гипер-инфляц хүчтэй явагдаж, Монгол банкнаас 4 тонн алт алдагдаж, эдийн засаг бүрэн уналтад оров.

Банкны хуулийг 1991 оны 4-р сард баталж, хоёр шатны банкны тогтолцоотой болсон нь зөв зүйтэй эхлэл байв.

1991-1992 онд зах зээлийн чөлөөт эдийн засгийн тогтолцоонд шилжсэнээр төвлөрсөн төлөвлөгөө, зохицуулалтыг бүрэн халсан, өмч хөрөнгөө хувьчилсан, үнэ тарифыг чөлөөлсөн, мөнгө, санхүү банк, татвар, төсвийн тогтолцоо, журмыг шинэчилсэн, гадаад худалдаа чөлөөтэй болсон зэрэг зэрэг хууль, эрх зүйн үндсийг бүрэлдүүлжээ.

1993.05.27-нд Валютын чөлөөтэй хөвөх ханшийн дэглэмд шилжив.

1996 онд Ардчилсан эвсэл ялснаар өмч хувьчлах явцыг улам бүр эрчимжүүлэн малыг малчдад, орон сууцыг иргэдэд хувьчилж, улсын өмчийн аж ахуйн нэгжүүдийг хувьчлав.

Улс төрийн тогтворгүй байдал, улс төрийн намууд дахь эрх мэдлийн зөрчил энэ үеэс эхэлж Засгийн газруудын дундаж наслалт 1.8 жил болов.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэн, уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж эхлэв. ЗХУ-ын өрийн асуудал шийдвэрлэгдсэнээр гадаад өр эрс буурсан боловч олон нэртэй бонд гаргаснаар улс орон гадаад өрийн дарамтад оров.

Хөгжлийн бодлого: Шинэ Үндсэн хууль батлагдан, Монгол Улс хүмүүнлэг, ардчилсан нийгэм байгуулах, чөлөөт зах зээлийн эдийн засгийн бодлого хэрэгжүүлж, эдийн засаг дахь төрийн оролцоо эрс багасав.

1990 онд Нийгэм, эдийн засгийн улсын хороо, Үндэсний хөгжлийн яам нэртэйгээр зохион байгуулагдан хоёр жил ажиллаж байжээ.

1992-1996 онуудад Монгол Улсын Засгийн газрын үндсэн бүтцэд “Үндэсний хөгжлийн газар”-ыг байгуулав.

1996 онд Улсын Их Хурлын 26 дугаар тогтоолоор “Монгол Улсын Хөгжлийн үзэл баримтлал”, 1998 онд Засгийн газрын 82 дугаар тогтоолоор хоёр дахь баримт бичиг “Монгол Улсын 21-р зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр”-ийг баталжээ. Монгол Улсын Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоолоор Монгол Улсын “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг батлав.

Хувийн хэвшил бүрэлдэн тогтож, эдийн засагт үзүүлэх нөлөө бодитой болж, зах зээлийн эдийн засгийн харилцаа төлөвшив.

2007 онд Мянганы сорилтод суурилсан “Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ыг боловсруулж мөрдөж эхлэв. Хүүхдийн мөнгө, залуу гэр бүлийг дэмжих мөнгө зэрэг нийгэм рүү чиглэсэн хавтгайрсан мөнгөн урсгал нэмэгдэх болов. Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо, Эдийн засгийн хөгжлийн яам байгуулах замаар хөгжлийн бодлого, төлөвлөлтийг хийхийг оролдсон боловч үр дүнд хүрээгүй. Засгийн газар тогтворгүй ажиллаж байлаа. Моргейжийн сан байгуулан ипотекийн зээл олгож эхэлснээр барилгын салбар эрчимтэй хөгжиж эхлэв.

Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээ байгуулснаар эдийн засагт их хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэх болж, нийгмийн халамжийн бодлого хавтгайрав. Олон улсын хөгжлийн байгууллагуудтай хамтран ажиллахаас татгалзан, Монгол Улс Хөгжлийн банкны бонд, Чингис, Самурай бондуудыг олон улсад гаргав. Үр дүнд нь гадаад өрийн дарамтад орлоо.

2016 онд Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилго 2030 баримт бичгийг үндэслэн 2016 оны 2-р сард УИХ-аас “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” урт хугацааны бодлогын баримт бичгийг батлав.

2017 онд Олон улсын валютын сангийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдаж, төсвийн хатуу бодлого явуулах болов.

Бүх шатанд сахилга хариуцлагын асуудлыг Засгийн газрын түвшинд анхаарч хэрэгжүүлснээр төрийн өмчийн зарим компаниуд ашигтай ажиллав.

Экспортын орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр гадаад харилцааг эдийн засагжуулах, нүүрсний экспорт нэмэгдсэнээр эдийн засагт эерэг үр дүн гарав. Тавантолгойн дэд бүтэц, хилийн боомтыг өргөжүүлэх чиглэлээр эрчимтэй ажиллах болсноор хөрөнгө оруулагчдын итгэл сэргэж, Олон улсын эрсдэлийн индексүүд сайжирлаа.

Ололт: Монгол Улсын шинэ ардчилсан Үндсэн хууль батлагдаж, төрийн байгууламж, байгуулалтыг тодорхой болгов. Парламентын засаглал, ардчилал хөгжүүлснээр иргэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжтой болж чөлөөт хэвлэл хөгжиж, ардчилсан, эрх чөлөөт улс болов.

1990 он хүртэлх хугацаанд захиргааны шинжтэй байсан гадаад, дотоод шилжих хөдөлгөөн харьцангуй чөлөөтэй болов. 1991 оны 5-р сард БНМАУ-ын өмч хувьчлах тухай хууль батлагдаж, иргэд өмчтэй болж хувийн хэвшлийн салбар хөгжих суурь тавигдсан бөгөөд өнөөдөр хувийн хэвшил манай улсын ДНБ-ний 70 гаруй хувийг бүрдүүлэх боллоо.

Зах зээлийн харилцаанд шилжсэнээр эдийн засаг жам ёсоороо хөгжиж 1990 оны түвшинтэй харьцуулахад манай улсын ДНБ-ний хэмжээ 12 дахин өсөв.

Хөгжлийн банк байгуулагдаж. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль батлагдлаа.

Сургамж: Улс төр, нийгэм, эдийн засгийг нэгэн зэрэг шууд өөрчилсөн нь алдаа болсон. Парламентад олонх цөөнхийн хяналтын харилцаа байвч, улс төрийн тогтвортой байдал зарим тодорхой үеүүдэд хангагдаагүй байв.

Улс төрийн системд асар их өөрчлөлт гарав. Зах зээлд шилжих тодорхой хөтөлбөр төлөвлөгөө байхгүй, төрийн зүгээс тодорхой зохицуулалт үгүй болж, хууль хяналтын тогтолцоо үйлчлэхээ больсон. Гадаадын зөвлөхийн зааварчилгаагаар үндэслэл муутай 20-р тогтоолыг батлан хэрэгжүүлснээр Гипер инфляц явагдан барааны хомстол үүсэв /shock threapy/.

Эдийн засаг дахь төрийн оролцоог хэт багасгаснаар ажилгүйдэл, ядуурал ихсэж, нийгмийн ялгаа гарч эхэлсэн бөгөөд өнөөдөр манай улсын гурван хүн тутмын нэг нь ядуу амьдарч байна.

1990-1996 онуудад худалдаа, тээврийг хувьчилснаар аж үйлдвэрүүдийн бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо нуран унаж, үндэсний аж үйлдвэрүүд бүрэн уналтад оржээ. Алт дилерийн хэрэг гэгчээр Монгол банкнаас дөрвөн тонн алт алдагдсанаар улс орны эдийн засагт том хохирол учруулав.

Энэ цаг үед улс орны хөгжлийг төлөвлөхгүйгээр, зах зээлийн далд гарт даатгасан нь том алдаа байлаа. 1990 оноос нийгэм, эдийн засгийг судалгаа, үндэслэл муутай шинэтгэх оролдлого хийгдэж эхэлсэн нь эдийн засагт сөргөөр нөлөөлжээ.

Бодит эдийн засаг, үйлдвэрлэлийн өсөлт хөгжил, ард түмний аж амьдралын дээшлэлт, нийгмийн үйлчилгээний салбарын ололт, дэвшлийн бодит үр дүнгийн өсөлт тааруу байлаа. Эдийн засгийн тогтолцоог цочмог хөндөж эхэлсэн нь 1990 оноос хойш, ялангуяа 1993 оны хооронд эдийн засгийн уналт, хямрал маш хүчтэй боллоо.

1990 оныг өмнөх он буюу 1989 онтой харьцуулахад үндэсний орлого дөрвөн хувиар, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 4.5 хувиар, ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэл бараг дөрвөн хувиар тус тус буурав.

Нэг хүн амд ноогдох ДНБ-ий хэмжээ 1995 онд үндсэндээ 1980 оны түвшинд байсан тул манай орны эдийн засагт бүтэн 15 жилийн ухралт болжээ.

Монгол Улсад 1990 оноос өмнө үр тариа, төмс, хүнсний ногооныхоо хэрэгцээг хангаад зарим жил гадаадад экспортолдог байв. Гэтэл газар, тариалангийн салбарт ихээхэн уналт болов. 1985-1989 оны таван жилийн дунджаар нэг жилд хураан авсан үр тарианы хэмжээ 819,640 тонн байсан бол 1994-1998 оны мөн таван жилийн дунджаар нэг жилд 248,534 тонн болж даруй 3.3 дахин багасжээ. Мөн дээрх харьцуулсан хоёр таван жилийн хугацаанд хурааж авсан төмс, хүнсний ногооны хэмжээ 2.3 дахин буурав. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний хэмжээг зэрэгцүүлэх үнээр харьцуулахад 1997 онд 1989 оныхоос даруй 32 хувиар бага болов. Аж үйлдвэрийн дэд салбаруудаар авч үзвэл уул уурхайгаас бусад салбарт их хэмжээний уналт болсон. Тухайлбал арьс шир боловсруулдаг үйлдвэрлэлийн хэмжээ 51 дахин, ноос ноолуурын бүтээгдэхүүн, нэхмэл хувцасны үйлдвэрлэл гурав дахин бага болсон. ДНБ-ий үйлдвэрлэлд аж үйлдвэрийн салбарын хувийн жин шинэтгэлийн өмнө 35.6 хувьд хүрч байсан бол 1997 оны байдлаар 20 хувь болов.

Засгийн газрын гишүүдээ мэргэжлийн бус хүмүүсээр бүрдүүлэхээс гадна Засгийн газар өөрөө тогтворгүй болж эхэллээ. Засгийн газрын дундаж наслалт 1.8 жилд хүрэв.

Хэдийгээр бодлого боловсруулж байсан боловч улс төр тогтворгүй байсан

тул хэрэгжилт муу байв. Улс төрийн элитүүд нь авлигад автсан, мөн олон удаагийн УИХ-ын чуулган ирц хүрэхгүйгээс болж хуралдаж чадахгүй байсан нь олон түмний дургүйцлийг хүргэж байв.

Баян хоосны ялгаа эрс нэмэгдэж, ядуурал гүнзгийрэв. Хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн эрс нэмэгдэв.

Сонгуулийн амлалтаар нийгмийн халамжийн оновчгүй бодлого хавтгайрав.

Уул уурхайгаас үүдэлтэй байгаль орчны асуудал үүсэх болжээ. Эдийн засаг, уул уурхай, түүний түүхий эдийн үнийн нөлөөнөөс хамаарах болов. Газар тариалангийн хувьд 1998 онд 188,300 тонн үр тариа хурааж авсныг 1960 онтой харьцуулбал 28 хувиар багасжээ.

Хавтгайрсан нийгмийн халамж зорилтот бүлэгтээ хүрч чадсангүй. Моргейжийг богино хугацаанд дэмжсэнээр валютын ханш өслөө.

Чингис бонд зэрэг томоохон бондуудыг босгон дэд бүтэц, хувийн хэвшлийн төслүүдийг санхүүжүүлсэн боловч амжилт олоогүй, улс орныг томоохон өрөнд оруулж, дефолт зарлах хэмжээнд хүргэв.

Төсвийн сахилга бат суларч, олон төсөвтэй болов. Монгол банкнаас Үнэ тогтворжуулах хөтөлбөр, Хятадын Ардын банкттай байгуулсан СВОП гэрээ валютын нөөцийг шавхан мөнгөний бодлого алдагдав.

УИХ, Засгийн газар, шүүх эрх мэдлийн байгууллага, төрийн байгууллагад итгэх иргэдийн итгэл сулрав. Нийгмийн хүрээнд нэгдмэл байдал алдагдав. Нийгмийн амьдралын бүх хүрээнд авилгад идэгджээ.

Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд хийсэн шинжилгээ

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэнээс хойших 30 орчим жилийн хугацаанд нийгмийн өмнөх тогтолцооны үеийн төрийн төвлөрсөн төлөвлөгөөт зохицуулалт халагдаж, харин зах зээлийн харилцааны зохицуулалтын хууль зүй тогтол үйлчилдэг болсон билээ. Хэдийгээр нийгмийн өөр тогтолцоонд шилжсэн ч эдийн засаг, санхүүгийн хязгаарлагдмал нөөцийг зөв зохистой хуваарилах болон үр ашигтай зарцуулхад хөгжлийн бодлого төлөвлөлт чухал ач холбогдолтой юм.

Үндэсний хөгжлийн газрын 2019 оны 2 сарын 28-ны өдрийн байдлаар гаргасан мэдээ судалгаанаас үзэхэд Монгол Улсад 1990 оноос хойш нийтдээ 567 хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулан баталж ажиллаж ирснээс өнөөгийн байдлаар 203 нь хүчинтэй, 68 нь хүчингүй болсон, 294 нь хуулийн хугацаа дуусгавар болсон, 3 нь зогссон байна. Одоогийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй бодлогын баримт бичгүүдийн 51-ыг УИХ-ын, 145-ыг Засгийн газрын тогтоолоор баталжээ. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хувь батлагдахаас өмнөх хугацаанд батлан хэрэгжүүлж ирсэн хөгжлийн бодлогын эдгээр баримт бичгүүдэд дор дурдсан нийтлэг дутагдал байжээ. Үүнд:

- Үзэл баримтлал, бодлого, бодлогын үндэс, стратеги, үндсэн чиглэл, үндэсний хөтөлбөр, хөтөлбөр, дэд хөтөлбөр, төлөвлөгөө, мастер төлөвлөгөө, чиглэл, жагсаалт гэх мэт янз бүрийн нэртэй, хоорондоо уялдаагүй маш олон бодлогын баримт бичгийг боловсруулан

баталжээ. Эдгээрээс бодлого, стратеги, төлөвлөгөө, мастер төлөвлөгөө, чиглэл, жагсаалт гэх мэт төрөл нь өнөөдөр хүчин төгөлдөр байгаа Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд заагаагүй баримт бичиг байна.

Хүснэгт 1. Хүчин төгөлдөр үйлчилж буй хөгжлийн бодлогын баримт бичгүүд

УИХ-ын тогтоолоор баталсан – 51			Засгийн газрын тогтоолоор баталсан – 145		
№	Баримт бичгийн төрөл	Тоо	№	Баримт бичгийн төрөл	Тоо
1	Үзэл баримтлал	5	1	Бодлого	12
2	Бодлого	23	2	Стратеги	9
3	Бодлогын үндэс	1	3	Үндэсний хөтөлбөр	70
4	Стратеги	2	4	Хөтөлбөр	29
5	Үндсэн чиглэл	6	5	Дэд хөтөлбөр	2
6	Үндэсний хөтөлбөр	8	6	Мастер төлөвлөгөө	1
7	Хөтөлбөр	1	7	Төлөвлөгөө	13
8	Төлөвлөгөө	3	8	Чиглэл	5
9	Чиглэл	1	9	Жагсаалт	3
9	Чиглэл	1			

- Эдгээр баримт бичгүүд нь хэрэгжих санхүүгийн баталгаагүйн дээр УИХ-ын ээлжит сонгуулийн үр дүнгээр Засгийн газар солигдоход дараачийн Засгийн газар нь хэрэгжүүлэхгүй орхидог тул залгамж чанаргүй байжээ.
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл явц үндсэндээ замбараагүй байдлаар явагдаж ирсэн байна.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй дунд хугацааны хөгжлийн баримт бичгийн 34.8 хувь нь 2010 оноос өмнө батлагдсан, 28.0 хувь нь дуусгавар болох хугацаа заагаагүй, харин 32.4 хувь нь 2020 оноос өмнө дуусгавар болохоор байна. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030”-ыг баталсан УИХ-ын 2016 оны 19 тоот тогтоолын 2.2-т “Монгол Улсын Их Хурал болон Засгийн газраас баталсан үндэсний хэмжээний болон салбарын, салбар дундын хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдийг энэхүү үзэл баримтлалд нийцсэн эсэхийг 2016 онд багтаан хянаж, шаардлагатай тохиолдолд шинэчлэн боловсруулах”-ыг Засгийн газарт үүрэг болгосны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 2 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсгээр одоогийн хүчинтэй байгаа бодлогын баримт бичгүүдийг дараах дөрвөн чиглэлийн дагуу үнэлсэн.

1. Бодлогын баримт бичиг нь “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”-ийн 6 дугаар зүйлд нийцэж байгаа байдал,
2. Бодлогын баримт бичгийн зорилго, зорилт тус бүр нь хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэй эсэх,

3. Бодлогын баримт бичиг нь Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилт, “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр” болон салбарын дунд хугацааны бодлогын зорилтуудтай уялдаж байгаа байдал,
4. Бодлогын баримт бичгүүд хэрэгжсэнээр гарах үр дүн нь “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаа байдал.

Үнэлгээ хийгдсэн 168 баримт бичгийн 39 /65 бодлого/ хувь нь Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө хэрэгжиж байсан бол 61 /103 бодлого/ хувь нь хууль хэрэгжиж эхэлснээс хойш батлагдсан байна. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн 103 бодлогын дийлэнх буюу 78 хувь /80 бодлого/ нь нэршлийн хувьд хуульд нийцэж байгаа нь сайшаалтай хэдий ч үлдсэн 22 хувь нь /23 бодлого/ хуулийг мөрдлөг болгож батлагдаагүй байна. Хугацааны хувьд нийт бодлогын баримт бичгийн 31 хувь /52 бодлого/ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд нийцээгүй байна. Тус хууль хэрэгжиж эхэлснээс хойш батлагдсан 103 бодлогын 22 хувь /23 бодлого/ хуульд нийцээгүй байна. 2015 оноос хойш батлагдсан 103 бодлогын баримт бичгийн 22 хувь нь нэршлийн хувьд, 27 хувь нь хугацааны хувьд хуульд нийцэлгүй байгаа байдлыг дүгнээд үзэхэд хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Түүнчлэн, үнэлэгдсэн бодлогын баримт бичгийн 76 хувь /123 бодлого/ Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журамд нийцээгүй байна.

Энэхүү үзүүлэлт нь Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогыг үе шаттайгаар, нэгдмэл, цогц байдлаар хэрэгжүүлэх, үр дүнгийн нэгдмэл байдлыг хянадаг тогтолцоо бүрдээгүйтэй холбоотой байна. Тогтолцоо бүрдээгүй тохиолдолд урт хугацааны бодлого үр дүнтэй хэрэгжих бололцоогүй юм.

Үндэсний аудитын газраас 2018 онд “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн тайлан”-д үзэл баримтлал болон энэхүү хууль батлагдсантай холбогдуулан хөгжлийн бодлогыг уялдуулах, зарим шаардлагагүй бодлогыг зогсоох, шинэчлэн боловсруулах ажил удаашралтай байна гэж дүгнэсэн.

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030”-д эдийн засгийн чиглэлээр 22, нийгмийн чиглэлээр 12, байгаль орчны чиглэлээр 6, засаглалын чиглэлээр 4, нийт 44 зорилтыг 3 үе шаттай хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн байна. Эдгээр зорилтуудтай эдийн засаг, нийгэм, байгаль орчны дэд салбарууд болон засаглалын хүрээнд мөрдөж буй хөгжлийн дунд хугацааны бодлого, хөтөлбөрүүдтэй харьцуулан авч үзэхэд төдийлөн нийцэхгүй байна.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Үндэсний аудитын газар Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийж үзээд хөгжлийн бодлогын баримт бичгийг хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөж боловсруулах ажил хангалтгүй, бодлогын олон хувилбар боловсруулалгүй зөвхөн нэг хувилбарт суурилсан төлөвлөлт хийдэг, төлөвлөлт нь судалгаанд суурилагагүй, баримт бичгийн төсөл нь боловсруулалтын шаардлага хангаагүй байхад Засгийн газарт оруулж хэлэлцүүлэх зөвшөөрөл өгдөг, хөгжлийн зорилго, зорилт ба хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт уялдаа муутай төлөвлөгддөг, хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан төрийн захиргааны холбогдох байгууллагууд хуульд заасан үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байна гэж тус тус дүгнэжээ. Үүнээс үзэхэд энэ хуулийн хэрэгжилт төдийлөн хангалттай биш байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд урт хугацааны бодлогын баримт бичигт дунд хугацааных, дунд хугацааны бодлогод богино хугацааных уялдаатай байхаар хуульчилсан байдаг. Гэвч одоо мөрдөж буй дунд хугацааны ихэнх бодлогын баримт бичгүүд нь урт хугацааныхтай төдийлөн уялдаатай биш байна. Түүнчлэн жил бүрийн Нийгэм, эдийн засгийн Хөгжлийн үндсэн чиглэл болон улс, орон нутгийн төсөв нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг л хэрэгжүүлэхэд чиглэгдэж, бусад дунд, урт хугацааны бодлогын баримт бичигтэй уялдаж чадахгүй байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд дунд хугацааны бодлогын баримт бичгийн хугацааг 3-5 жил мөн 8-10 жил гэж хоёр янзаар тусгасан нь оновчтой биш байна.

Жил бүрийн улсын төсвийн төлөвлөлт нь Төсвийн тухай хуулийн дагуу доороос дээшээ чиглэсэн босоо хэлбэрийн зохицуулалтын механизмаар дамжин хэрэгжиж ирсэн. Өөрөөр хэлбэл, төсвийн төлөвлөлт нь сум дүүргээс аймаг, нийслэл рүү, тэдгээрээс Сангийн яам руу, түүнээс Засгийн газарт нэгтгэгдэж, улмаар УИХ-д орж батлагддаг. Харин хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдийг гол төлөв салбарын яам, Засгийн газрын түвшинд Ажлын хэсэг байгуулан дээрээс төлөвлөдөг практик давамгайлж ирсэн. Орон нутгаас буюу дороос нэг их санал авч төлөвлөхгүй байна. Иймд хөгжлийн бодлого төлөвлөлт болон төсвийн төлөвлөлтийн босоо зохицуулалт нийцтэй биш байна гэж дүгнэж болно.

Зарим салбарт төлөвлөлтийн босоо тогтолцооны сум-аймаг-салбар гэсэн хэлбэртэй зохицуулалт яамдаар (ХХААХҮЯ, Сангийн яам, ХНХЯ, БСШУСЯ, БОАЖЯ гэх мэт) дамжин үйлчилж байгаа боловч хангалтгүй байна.

Эдийн засгийн бүсүүд (Баруун, Хангай, Төв, Зүүн, Улаанбаатарын бүс)-ийн статистик мэдээлэл нь зөвхөн уг бүсэд хамрагдсан аймгуудын статистик мэдээллийг механикаар нэгтгэсэн тоо мэдээ төдий болохоос биш, бүсийн хэмжээгээр төлөвлөсөн хөгжлийн бодлоготой уялдаагүй байна.

Салбарын болон орон нутгийн түвшний бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахдаа хэвтээ чиглэлээр оролцогч талуудын оролцоог хангах, санал авч байгаа нь байдал ёс төдий байна. Бүс, орон нутагт

хөгжлийн шат шатны салбарын бодлогыг тодорхойлохдоо яам хоорондын ажлын уялдаа сул байна.

Түүнчлэн томоохон төсөл, хөтөлбөрийг дэд бүтцийн болон орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулах нь чухал. Жишээ нь, Оюутолгой төслийг Өмнөговь аймаг, Ханбогд сумын хөгжлийн бодлоготой болон эрчим хүчний нэгдсэн хөтөлбөртэй, усны хөтөлбөртэй нягт уялдуулах асуудлыг дурдаж болно.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулийн дагуу хэвтээ хэлбэрийн бодлого, зохицуулалтад Сангийн яам голлох байр суурьтай байна. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн талаар Сангийн яам нь салбарын яамдаас саналыг нь авч нэгтгэж Засгийн газарт оруулах, эсвэл яамдын боловсруулсан тухайн баримт бичгийн төслийг Засгийн газрын хуралдаанд оруулах зөвшөөрөл өгөх үүрэгтэй ажиллаж байна. Энэ үе шатанд Үндэсний хөгжлийн газрын оролцоо бага, Сангийн яам ба уг газар хоорондын ажлын уялдаа холбоо үндсэндээ алга байна. Салбарын яамдууд хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг боловсруулан Засгийн газарт оруулахдаа Үндэсний хөгжлийн газраас санал авдаггүй тохиолдол ч их байна Үүнээс үзэхэд хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэвтээ хэлбэрийн зохицуулалтын үйлчлэл ч хангалттай бус байна гэж дүгнэж болохоор байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ТУСГАСАН ЧИГ ҮҮРГИЙН ХУВААРЬ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн дагуу хөгжлийн бодлого төлөвлөлттэй холбоотой чиг үүргийг дараах байдлаар хуваарилж хуульчилсан байдаг. Үүнд:

Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудал:

- Улсын хөгжлийн цогц бодлого;
- Эдийн засгийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, салбар, дэд бүтцийн зохистой харьцааг тогтоох асуудал;
- Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого;
- Гадаадын хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалт, бүртгэл Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудал;
- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн бодлого

Сангийн сайдын эрхлэх асуудал:

- Макро эдийн засгийн бодлогын төлөвлөлт, зохицуулалт;
- Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийн асуудал;
- Нэгдсэн төсвийн талаарх судалгаа, төлөвлөлт;
- Төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалт, санхүүжилтийн үйл ажиллагаа.

Ерөнхий сайдын болон Сангийн сайдын эрхлэх асуудалд зохих хэмжээний давхардал байгаагийн зэрэгцээ Үндэсний хөгжлийн газар нь Ерөнхий

сайдын дэргэдэх тохируулагч агентлагийн хувьд дээрх чиг үүргүүдээс хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг л хариуцан ажиллаж байна. Бүсчилсэн хөгжил болон хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого төлөвлөлтийг Үндэсний хөгжлийн газар, харин дунд хугацааны болон үндсэн чиглэлийг Сангийн яам салган хариуцаж байгааг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулийн шинэчилсэн найруулгаар уялдуулан зохицуулах шаардлагатай байна.

Одоо мөрдөгдөж байгаа хуулиар урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн тайлан Үндэсний хөгжлийн газарт шууд ирдэггүй тул нэгдсэн мэдээллийн сан үүсгэхэд хүндрэлтэй байна. Иймд Үндэсний статистикийн хороо, Сангийн яам, Үндэсний хөгжлийн газарт болон холбогдох бусад газрууд дахь мэдээллийн салангид баазыг нэгтгэж, нэгдмэл уялдаа холбоо бүхий мэдээллийн сан бүрдүүлэх нь хөгжлийн бодлого төлөвлөлтийг сайжруулах нэг чухал хүчин зүйл мөн.

Одоогийн байдлаар макро эдийн засгийн бодлого төлөвлөлтийн чиглэлээр Сангийн яаманд 6 мэргэжилтэн, Үндэсний хөгжлийн газарт мөн 5-6 хүн ажилладаг, тэдний хоорондын ажлын уялдаа болон чадавх сул байгааг анхаарч цаашид бодлого, төлөвлөлтийн нэгдмэл зохицуулалтад шилжихийн тулд хүний нөөцийн чадавхыг зөв төвлөрүүлж ашиглах нь зүйтэй юм.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ТОГТОЛЦООНЫ ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ЗАРИМ ТУРШЛАГА

Дэлхийн улс орнуудад хөгжлийн бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт нь тухайн улс орны хүн амын тоо, газар нутгийн болон эдийн засгийн хэмжээ, бүтэц, хөгжлийн түвшингээс хамаарч харилцан адилгүй байна. Гэвч нийтлэг хэд хэдэн зүйл байгааг тэмдэглэх нь зүйтэй Үүнд:

НЭГ. Улс орон бүрд хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлж байна.

- Урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал, бодлого нь хөгжингүй улс орнуудад НҮБ-аас хэрэгжүүлж байгаа тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай илүү нийцсэн үзүүлэлтүүдийг сонгосон, байгаль орчин, экологи, хүний хөгжил, боловсролд түлхүү хандсан байна.
- Харин хөгжиж байгаа улс орнуудын хувьд эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх (ялангуяа ажилгүйдэл, ядуурал, дундаж давхаргын хүрээг тэлэх, эдийн засгийн бүтцийг боловсронгуй болгох, хурдцыг нэмэгдүүлэх г.м)-эд чиглэсэн хөгжлийн 10-15 жилийн үзэл баримтлал боловсруулан хэрэгжүүлж байна.
- Макро түвшинд хөгжлийн дунд хугацааны төлөвлөлтийг төсөл, хөтөлбөрийн нарийн тооцоо судалгаанд үндэслэн хэрэгжүүлж байна. БНСУ, Япон улс, Сингапур, Европын дийлэнх улс орнуудад макро түвшний 5 жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлж байна.
- Богино хугацааны төлөвлөлтийг бүх улс орон хэрэгжүүлж байна. Аж ахуйн бүх нэгж салбарынхаа хүрээнд хамрагдаж үйлдвэрлэл,

үйлчилгээнийхээ хэмжээ, чанар, стандарт, технологио нэгтгэж байна. Ялангуяа Япон, БНСУ-д микро түвшний бодлого, түүнийг макро бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх үйл ажиллагаа илүү сайн байна. БНХАУ-д өмчийн хэлбэр харгалзахгүйгээр жилийн төлөвлөгөөтэй ажиллаж байна.

ХОЁР. Дэлхийн улс орнуудад тухайлбал, хөгжиж байгаа бүх улс оронд урт, дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлтийг үндэсний хэмжээнд тодорхой нэг байгууллага нэгтгэн зангидаж бүрэн хариуцан гүйцэтгэж байна.

- Нэршлийн хувьд Засгийн газрын Тамгын газар (Япон), Хөгжил, шинэтгэлийн яам, Төлөвлөлтийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Бодлого, төлөвлөлтийн яам, эсвэл хороо, Хөгжлийн яам гэх мэт олон хэлбэртэй боловч агуулга, бүтцийн хувьд улс орныхоо хөгжлийн асуудлыг иж бүрэн уялдуулан зохицуулах эрх, үүрэгтэй байна.
- Чиг үүргийн яам, газрууд нь салбарынхаа дотоод бодлого, төлөвлөлтийг бүрэн хариуцаж хөгжил, төлөвлөлт хариуцсан дээд байгууллагадаа тайлагнаж, уялдуулах үүрэгтэй ажиллаж байна.

ГУРАВ. Зарим улс орны бодлого хөгжлийн үйл ажиллагааны зохион байгуулалтыг авч үзвэл:

- Япон Улсад Ерөнхий сайдын шууд удирдлага дор Засгийн газрын хэрэглэх газрын түвшинд Улсын эдийн засаг, төлөвлөлт, Шинжлэх ухаан технологи, инновац, Нийгмийн бодлогын зөвлөл ажиллаж байна.
- Малайз Улсад Засгийн газрын шууд харьяанд Үндэсний хөгжил, төлөвлөлтийн зөвлөл ажиллаж байна.
- Финланд Улсад Засгийн газрын бүтцэд Эдийн засаг, ажил эрхлэлтийн яам үйл ажиллагаа явуулж, хөгжлийн бодлого төлөвлөлтийг хариуцаж байна.
- БНСУ-д Төлөвлөлт, санхүүгийн яам ажилладаг. Түүний харьяанд Статистикийн ерөнхий газар, татвар, гаалийн газрууд ажилладаг. Энэ яам дэргэдээ Солонгосын хөгжлийн хүрээлэн гэсэн судалгааны том байгууллагатай юм.
- Турк улсад Ерөнхий сайдын дэргэд Хөгжлийн стратеги ба Нордикийн орнуудтай хамтран ажиллах сайд ажилладаг бөгөөд жилийн хөтөлбөр, эдийн засгийн загварчлал, стратеги, эдийн засгийн сектор, нийгмийн сектор, гадаад эдийн засгийн харилцаа, орон нутгийн хөгжил гэсэн бүтэцтэйгээр ажиллаж байна.

ДӨРӨВ. Монгол Улс 1960-1990 оны хооронд бодлого, төлөвлөлтийн асуудлыг тэр үеийн Сайд нарын зөвлөлийн нэгдүгээр орлогч даргын удирдсан Улсын төлөвлөгөөний комисс хариуцаж, урт, дунд, богино хугацааны бодлого төлөвлөлтийн асуудлыг уялдуулан зохицуулж, чиг үүргийн яамд нь салбарын бодлого төлөвлөлт, аймаг, орон нутгийн төлөвлөлтийг зохицуулж байв.

Улсын төлөвлөгөөний комиссын дэргэд Монгол Улсын үйлдвэрлэх хүчний хүрээлэн ажиллаж байв.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр “Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна” гэж заасан.

Монгол Улсын бодлого хөгжлийн асуудлыг нэг тодорхой байгууллага бүрэн хариуцаж зохицуулах шаардлага урган гарч байна. Үүнтэй уялдуулан Монгол Улсын бодлого төлөвлөлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт зайлшгүй хийх нь энэ хуулийг хэрэгжүүлж ирсэн хоёр жилийн үр дүнгээс харагдаж байна.

Үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулах Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн яамыг сэргээн байгуулж, Монгол Улсын хөгжлийн урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлого, богино хугацааны төлөвлөлт, макро эдийн засаг, зээл тусламжийн бодлого, шинжлэх ухаан, технологи, инновац, төр, хувийн хэвшлийн түншлэл, хөрөнгө оруулалтын асуудлыг бүрэн хариуцуулж, түүний дэргэд хөгжил байршлын судалгаа, мэдээлэл төвлөрсөн хүрээлэн ажиллуулах шаардлагатай гэж үзэж байна.

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН ЗАГВАР: УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН СУУРЬ ҮНЭТ ЗҮЙЛ

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын суурь үнэт зүйлс нь эзэнт гүрнээс өнөөдрийг хүртэлх түүхэн үечлэл, алдаа оноо, үл давтагдах нүүдэлчин соёл, сэтгэлгээ, хөрвөх чадвартай Монгол хүний ирээдүйг төсөөлөх оюун санааны давхцал байх болно.

Өнгөрсөн, одоо, ирээдүйн давхцал нь **оюун санаа, хурд, мөн чанар** гэсэн төгс холбоост хадгалагдаж буй бөгөөд **Алсын хараа 2050** урт хугацааны хөгжлийн бодлого нь үндэсний дахин давтагдашгүй онцлогт суурилсан, дэлхийн дэвшилтэт үзэл санаатай хослуулсан **Монгол Улсын хөгжлийн загвар** байх болно.

Ирэх 30 жилийн хугацаанд өнгөрсөн, одоо, ирээдүйн орчилд бидний **оюун санаа, хурд, мөн чанар** амилж, тэргүүлэгч гүрэн болох алсын хараа биеллээ олох болно.

“Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлого буюу Монгол хөгжлийн загвар биеллээ олох суурь нөхцөл нь **Монгол хүн** байна. Хүн амаа эх оронч, эрүүл чийрэг, дэлхийд өрсөлдөх боловсролтой, өмч хөрөнгөтэй болгох цогц бодлого хэрэгжүүлснээр хүн амынхаа 80 хувийг дундаж давхарга руу оруулах болно.

Өвөрмөц мөн чанар дэвшилтэт үзэл баримтлалыг хослуулсан Монгол Улсын хөгжлийн загварыг гаргаснаар бид бүхэн сургаар биш судалгаагаар, хувь хүний биш хуулийн засаглалыг тогтоож, тэгш бус байдлыг багасгаж, удирдагчаа үнэлдэг нийгмийн соёлыг бүрдүүлж, бодлого боловсруулж, хэрэгжүүлэгч нарт тавих шаардлагыг өндөрсгөнө.

Мөн тэргүүлэх салбараа зөв тодорхойлж чадсанаар урагшлан хөгжих зөв тогтолцоонд шилжиж, жам ёсны эдийн засгийн эрүүл орчин бүрэлдүүлэн дундаж давхаргаа зузаалж Монгол Улсаа ирэх 30 жилийн хугацаанд нийгмийн болон эдийн засгийн хөгжлөөрөө тэргүүлэгч орон болгоно.

Хүснэгт 2. Суурь үнэт зүйл

Суурь үнэт зүйл	Хэмжээс	Өнгөрсөн	Одоо (2019)	Ирээдүй (2050)
		Монголын Эзэнт гүрэн	Монгол Улс	Монгол Улс
Оюун санаа	Сайн засаглал	Сэцэдийн зөвлөл- Их засаг хууль	Тогтворгүй засаглал- тодорхой бус хөгжлийн философи	Хуулийн засаглал- хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм
	Ногоон хөгжил	Мөнх хөх тэнгэр	Байгалийн баялагт шүтсэн	Ногоон амьдралын хэв маяг
	Нийгмийн хөгжил	Мөнх хөх тэнгэрийн дор хүн бүхэн тэгш	Дэлхийн хөгжлийн суурь үзүүлэлт хангалтгүй нийгэм	Дундаж орлоготой боловсролтой, эрүүл, идэвхтэй иргэд
Хурд	Эдийн засаг	Дэлхийн баялгийг хуваарилагч	Уул уурхайгаас хамааралтай эдийн засаг	Олон тулгуурт эдийн засаг-өндөр хөгжилтэй улс
	Дэд бүтэц- бүсчилсэн хөгжил	Торгоны зам, морин өртөө	Таатай байршил- үр ашиггүй хуваарилалт	Мэдээллийн технологийн дэвшилд тулгуурласан хөгжил
Мөн чанар	Монгол хүн	Монголын эзэнт гүрний иргэн	Ирээдүйдээ итгэлгүй- хуучнаа санагалзагчид	Ирээдүйдээ итгэл төгс-чинээлэг дундаж давхаргад хамаарах хүн
	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	Үл давтагдах нүүдэлчин соёл, сэтгэлгээ	Үнэт зүйлээ гээсэн Монгол	Үндэсний ижилсэл- ондоошлын гүн ухамсар дархлаатай үндэстэн
	Үндэсний аюулгүй байдал	Пакс Монголика- Алтан гэрэгэ	Хоёр том гүрний хооронд оршиж буй Монгол Улс	Өрсөлдөх чадвар бүхий Монгол Улс

Алсын хараа: Монгол Улс 2050 он гэхэд байгаль, хэл, хил, соёлоо тогтвортой хадгалсан, нийгмийн болон эдийн засгийн хөгжлөөрөө тэргүүлэгч орон болно.

Хөгжлийн бодлогын түлхүүр үг: Эрчит Монгол (Energitic Mongolia)

АЛСЫН ХАРАА 2050

УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЭРХЭМ 9 ЗОРИЛГО:

- 1. Үндэсний нэгдмэл үнэт зүйл**-“Үндэсний нэгдмэл үнэт зүйлийн гүн ухамсар дархлаатай улс үндэстэн болно”.
- 2. Хүний хөгжил**- “Монгол Улсын Хүний хөгжлийн индексийг 0.9-д хүргэж, аз жаргалын индексээр дэлхийн эхний 10 орны тоонд багтана”.
- 3. Амьдралын чанар ба дундаж давхарга**-“Сэтгэл хангалуун амьдрах нөхцөлөөр тэтгэгдсэн дундаж давхаргыг 2050 он гэхэд нийт хүн амын 80 хувьд хүргэнэ”.
- 4. Эдийн засаг**-“ДНБ 6.1 дахин нэмэгдэж нэг хүнд оногдох ДНБ 3.6 дахин өсөж, 15,000 ам.долларт хүрч, дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын босгыг давна”.
- 5. Сайн засаглал** “Тогтвортой засаглал тогтож, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно”.
- 6. Ногоон хөгжил** “Ногоон хөгжлийг эрхэмлэн байгаль орчны тогтвортой байдлыг хангана”.
- 7. Амар тайван, аюулгүй нийгэм**-“Үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалах гадаад дотоод таатай орчин бүрдэнэ”.
- 8. Бүсчилсэн хөгжил**- “Бүс нутгийн эдийн засгийн интеграцад нэгдсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, өрсөлдөх чадвартай улс доторх бүсүүдийг хөгжүүлнэ”.
- 9. Улаанбаатар ба дагуул хот** “Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй хот болгон хөгжүүлнэ”.

Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын гол цөм нь Монгол хүн байж хөгжлийн бодлогын зорилго бүр Монгол хүний сайн сайхан байдлыг дээшлүүлэхэд чиглэх болно.

Дэлхий нийтийн хөгжлийн үзэл баримтлалын дагуу Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын суурь эхлэлтийн цэг нь ногоон хөгжил байх бөгөөд байгаль орчны нөөц бололцоо, газар зүйн байршлын давуу тал дээрээ үндэслэн эдийн засаг, дэд бүтэц, бүс нутгийг хөгжүүлэх болно.

Эдийн засгийн хөгжлийн үр дүнд бий болгосон баялгийг хүндээ хүргэж нийгмийн хөгжлийг бий болгоно. Ухамсартай, боловсролтой иргэд ирээдүйд байгаль орчноо зохистой ашиглах болно.


Гол тулгуур гурвалжингийн дотор талд ногоон хөгжил, эдийн засгийн хөгжил, нийгмийн хөгжлийн үр нөлөөг хүндээ хүргэх дотоод тулгуур бүтцийг тодорхойлж өгсөн. (Зураг 4)

Эдийн засгийн хөгжлийг нийгмийн хөгжилд үр дүнтэй хүргэх арга зам нь засаглалын бодлого буюу Сайн засаглал байна. Хэрэв хүн өөрөө л хичээвэл хуулийн орчин нь шударга учир хүн бүрд тэгш боломж бүрэлдэнэ.

Нийгмийн хөгжлийн үр дүнд үндэсний нэгдмэл үнэт зүйлээ эрхэмлэсэн, нийгмийн оролцоотой иргэдийг төлөвшүүлснээр ногоон хөгжлийн үндэс суурь тавигдах болно.

Ногоон хөгжлийн болон эдийн засгийн хөгжлийн бодлого нь үндэсний аюулгүй байдлын бодлого дээр тулгуурлах болно.


Зураг 4. Гол тулгуур гурвалжин



Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын эцсийн эрхэм зорилго нь чинээлэг-дундаж давхаргыг бий болгох явдал юм. Үүний тулд баялаг бүтээхийг хүссэн иргэн бүрд нээлттэй, шударга бизнесийн орчин, тэгш үйлчилдэг хуулийн засаглал ижил боломжийг олгох болно.

Баялгийн хуваарилалтын хамгийн төгс, зохистой хувилбарыг зөв талстай, юунд ч үл автах хатуу “Очир эрдэнэ”-ээр дүрслэн илэрхийлж байгаа болно.

Зураг 5. Баялгийн хуваарилалтын зохистой хувилбар



Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого нь 9 зорилго, нийт 50 зорилттой ба гурван 10 жилээр буюу 2020-2030 он, 2031-2040 он, 2041-2050 он гэсэн 3 үе шаттайгаар зорилт тус бүрийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон.

“Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ыг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журамд тавигдсан шаардлагын дагуу Засгийн газраас боловсруулан УИХ-д өргөн барьж байна.

МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

ДЭЛХИЙН ХӨГЖЛИЙН ХАНДЛАГА ХААШАА ЯВЖ БАЙНА ВЭ?

2008 оны санхүүгийн хямралын дараа глобал эдийн засаг 10 гаруй жилийн хугацаанд сэргэж, АНУ-ын Холбооны нөөцийн банк 2017 оноос бодлогын хүүгээ өсгөж эхэлсэн боловч, том гүрнүүдийн зөрчилдөөнөөс үүдэн глобал эдийн засагт тодорхой бус байдал нэмэгдэж, уналт руу орох эрсдэл хуримтлагдаж эхэллээ. Энэ орчинд дэлхийн төв банкууд алтны нөөцөө нэмж эхэлсний дээр хөрөнгө оруулалтын багцад алт чухал байр эзлэх болсноор алтны үнэ өсөж эхэллээ. АНУ-д Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ 2019 оны 7 дугаар сард сүүлийн 10 жилд анх удаа бууруулж, богино хугацаатай үнэт цаасны хэлцлийн хүү нь урт хугацаатай хэлцлийн хүүнээс өндөр болж эхэлсэн нь хямралын дохиог өгөв. Харин Хятадын эдийн засгийн өсөлт удааширсны үр дүнд зарим эрдэс бүтээгдэхүүний эрэлтийг багасгаж, улмаар тэдгээрийн үнийг бууруулахад хүргэж байна. Ийм байдал нь Монгол Улсын гол экспортын эрдэс бүтээгдэхүүний үнийн төсөөллүүдэд сөрөг нөлөө үзүүлж төсвийн орлого дутагдаж, гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ буурах төлөвтэй байна. Дэлхийн эдийн засаг уналтад орох өөр нэг дохио нь Евро бүсийн хамгийн том эдийн засаг болох Германы эдийн засгийн өсөлт саарч, аж үйлдвэрийн салбарын хувийн жин

буурч буй явдал юм.

Энэ удаагийн дэлхийн эдийн засгийн хүндрэл нь 2008 оны санхүүгийн хямралаас ялгаатай, илүү удаан хугацаанд үргэлжлэхээр байна. Өмнөх хямрал нь эрэлтийн шалтгаанаар өдөөгдөж байсан бол энэ удаагийнх АНУ-Хятадын хоорондын худалдааны, ханшны болон технологийн дайнаас үүдэлтэй удаан хугацаанд үргэлжлэх хүчин зүйлсээс хамаарахаар байна. Өмнөх хямралын хор хөнөөлийг төсөв, мөнгөний тэлэх бодлогоор даван туулсан бол энэ удаа эдгээр мөчлөг сөрсөн эдийн засгийн бодлогуудын аль нь ч туслахгүйг зарим эдийн засагчид онцолж байна. Энэ удаагийн хямралын шалтгаан нь *нэгдүгээрт*, АНУ-Хятадын хоорондын худалдааны дайн болон валютын ханшны сулрал, хоёр тал бие биендээ ногдуулахаар болж байгаа импортын тарифуудыг нэмэгдүүлснээр АНУ нь Хятадыг ханшны дайн эхлүүлэгч гэж нэрлээд байна; *хоёрдугаарт*, технологийн салбар дахь АНУ-Хятадын хоорондын хүйтэн дайн, хиймэл оюун ухаан, роботчлол, 5G зэрэг ирээдүйн аж үйлдвэрийн салбар дахь ноёрхлын төлөөх тэмцэл ширүүслээ. Хөрөнгө оруулагчид цаашид дунд, урт хугацаандаа хүү буурна гэсэн хүлээлттэй байгаа боловч энэ нь АНУ-ын эдийн засаг суларч, Холбооны нөөцийн сангийн бодлогын хүү өмнөх 10 жилтэй адил тэг орчим байна гэсэн хүлээлтийг давхар агуулж байна. *Гуравдугаарт*, газрын тосны нийлүүлэлттэй холбоотой эрсдэлүүд гарч эхлэв. Худалдааны дайн нь эрчим хүчний нөөцийн эрэлтийг бууруулж, үнэ, ханш буурахад сөргөөр нөлөөлөх хэдий ч АНУ болон Ираны хоорондын зөрчилдөөн нь эсрэг нөлөө үзүүлэхээр байна. Худалдааны, ханшийн дайн болон технологийн өрсөлдөөн улс орнуудад эдийн засгийн уналт, өндөр инфляцыг нэгэн зэрэг бий болгох буюу импортын хэрэглээний бүтээгдэхүүн, завсрын орцууд, технологийн бүрдлүүд болон энергийн үнийг өсгөн глобал нийлүүлэлтийн сүлжээг тасалдуулах замаар үйлдвэрлэлийг бууруулахад хүргэж болзошгүй юм. Түүнчлэн нь дэлхийн тавцанд улс орнууд харилцан нэг нэгэнтэйгээ сэргэлдэх нөлөөг бий болгож, энэ нь удаан хугацаанд үргэлжлэх тохиолдолд мөнгөний болон төсвийн бодлого тэлэх нь өмнөх хямралтай адил нөлөөтэй эсэх нь эргэлзээтэй болно.

Глобал эдийн засаг, зах зээлд хурж буй ‘хар үл’ ирэх 5-10 жилд томоохон сорилтыг бий болгож байна. Дараагийн 10 жилд нүүрс, төмрийн хүдрийн үнэ буурах, алтны үнэ тогтвортой өндөр түвшинд хадгалагдах, зэсийн болон газрын тосны үнэ өсөх төсөөлөлтэй байна. Энэ нь нийт дүр зургаараа манай урсгал тэнцлийн алдагдалд нэмэлт дарамт учруулахаар байна.

Харин цаашдын дэлхийн хөгжлийн хандлагыг хөгжиж буй орнуудын даяаршил, их гүрнүүдийн дангаарчлалын бодлого, дэлхийн хүн амын өсөлт, уур амьсгалын өөрчлөлт, ногоон эдийн засаг, аж үйлдвэрийн IV хувьсгал тодорхойлохоор байна.

ДАЯАРШИЛ БА ИХ ГҮРНҮҮДИЙН ДАНГААРЧЛАЛ. Өнгөрсөн зууны төгсгөлөөс дэлхий дахиныг хамарсан даяаршлын явц нь Монгол Улсад хөгжлийн шинэ боломж, сорилтуудын аль алиныг нь бий болгов. Даяаршлын үйл явц улс хооронд шинэ санаа, шинэ мэдлэгийн урсгалыг үүсгэж, түүх соёл, хүрээлэн буй орчин зэрэг хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлсийн талаар шинэ хандлагыг бий болгож ирэв. Даяаршлын үйл явц мэдээлэл харилцаа холбоо, технологи дамжуулалт, соёлын харилцаагаар

дамжин улс орны эдийн засаг, нийгмийн амьдралд нөлөөлж, технологи дамжуулалтыг дагалдсан бүтээмжийн өсөлт, мэдээлэл харилцаа холбоог дагалдсан мэдлэгийн өсөлт, соёлын харилцааг дагалдсан нийгмийн амьдралын шинэ амьдралын хэв маяг үүсэн бүрэлдэж байна. Даяаршлын үйл явцыг дагалдан улс хоорондын худалдаан дахь тарифын болон тарифын бус хориг саадууд багасахын хэрээр өрсөлдөөн нэмэгдэж, үйлдвэрлэл зардал багатай бүс нутгууд руу шилжилт хийж, үүнийг дагалдан бүтээгдэхүүн үйлчилгээний үйлдвэрлэлийн өртөг зардал, үнэ буурах хандлагатай боллоо. Хямд ажиллах хүчин, үйлдвэрлэлийн хямд орцуудыг хайсан хөрөнгө оруулалтын урсгал дэлхийн эдийн засгийн төв болон бүс, олон улсын хөдөлмөрийн хуваарь, улс орнуудын эдийн засаг, бизнесийн бүтэц тогтолцоо, хөдөлмөрийн зах зээлд томоохон өөрчлөлтүүдийг бий болгож байна.

Даяаршил эдийн засгийн төдийгүй нийгэм, соёлын томоохон өөрчлөлтүүдийг араасаа дагуулж байна. Гадны соёлын нөлөө хотжих үйл явцыг эрчимжүүлж, хөдөө орон нутгаас төв сууринг чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөнийг улам бүр идэвхжүүлэх нь гарцаагүй юм. Үүнийг дагалдан орон нутаг эзгүйрэх, зах зээл нь улам бүр хумигдах, хот хөдөөгийн тэгш бус байдал нэмэгдэх, нийслэлд хүн амын хэт төвлөрөл үүсэх зэрэг зохисгүй хандлагууд үргэлжлэх хандлага хэвээр байна.

Гэхдээ АНУ болон Хятадын сүүлийн жилүүдэд баримталж буй бодлого, Брикситийн үйл явц зэрэг төвөөс зугтаах, бие даасан 'үндэсний үзэл' бас эрчээ авч байна. Энэ үйл явц цаашид хэр тогтвортой үргэлжлэх тодорхой бус байдал өндөр хэвээр байна.

Манай улсын хувьд глобал худалдааны сүлжээнд нэгдэн орох, худалдааг хөнгөвчлөх, олон улсын стандартуудыг хангах асуудал чухал байна. Энэ үүднээс эдийн засгийн агуулгаар даяаршилд үргэлжлүүлэн нэгдэн орох хэрэгцээ өндөр байна. Харин геополитик, гадаад зах зээлээ тэлэх агуулгаар их гүрнүүдийн бодлогыг анхааралтай ажиглаж, түүнд нийцүүлэн шуурхай хариу үзүүлэх нь стратеги чухал байна.

ХҮН АМ ЗҮЙН ӨӨРЧЛӨЛТ. Хөгжиж буй орнууд дахь төрөлтийн өндөр түвшний нөлөөгөөр ирэх 30 жилд дэлхийн хүн амын тоо 7.5 тэрбумаас 9.7 тэрбум хүртэл өснө гэсэн урьдчилсан тооцоо гараад байна. Нэг талаас, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр тариалангийн талбай, малын бэлчээрийн хэмжээ жилээс жилд хумигдаж, ургамлын гарц буурах, нөгөө талд хүн амын тоо өсөх гэсэн эсрэг тэсрэг хандлагууд нэгэн зэрэг явагдаж байгаа нь дэлхий дахины хэмжээнд хоол хүнс, хувцасны хэрэглээг улам бүр нэмэгдүүлэх төлөвтэй байна. Энэ нь нөгөө талаас манай улсын мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний эрэлтийг нэмэгдүүлж, эдгээр салбарын хөгжилд томоохон түлхэц өгөх нь гарцаагүй юм.

Дэлхийн олон улс оронд явагдаж буй хүн амын дундаж наслалт нэмэгдэх хандлагатай байна. Хүн амын дундаж наслалтад гарч буй өөрчлөлтийг дагалдан нийт хүн амд хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувийн жин буурч, нийгмийн халамж үйлчилгээний зардлыг нэмэгдүүлэх болно.

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ, НОГООН ЭДИЙН ЗАСАГ. Аливаа улс орон урт хугацаанд тогтвортой хөгжих гол арга нь эдийн засгийн үйл ажиллагааг хүн,

байгалийн аль алинд нь ээлтэй болгох явдал бөгөөд байгалийн баялгийг илүү үр өгөөжтэй ашиглах замаар эдийн засаг, нийгэм, байгаль орчны тогтвортой хөгжлийг урт хугацаанд хадгалах зорилготой 'ногоон эдийн засаг'-ийн хөгжлийн хандлага нь хомстож буй нөөцүүдийг хэмнэлттэй, шавхагдахгүй нөөцийг зохистой ашиглахад чиглэж байна. Дэлхий нийт энэ чиг хандлага руу тууштай ороод байна.

Хот суурин газрын хүн амын хэт төвлөрлөөс үүдэлтэй агаар, хөрс, усны бохирдол, малын тоо толгойн өсөлтийн нөлөөгөөр талхлагдсан бэлчээр нутаг, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр бий болсон хөрсний доройтол ба цөлжилт, олборлох үйлдвэрлэлийн салбараас үүдэлтэй хөрс ба усны бохирдол, усны хомдсол зэрэг нь манай орны хувьд тулгамдаж буй асуудлууд юм. Манай улсын хувьд хөдөө аж ахуй болон уул уурхай нь эдийн засгийн тэргүүлэх салбарууд бөгөөд хотжилт дагасан орчны бохирдол тулгамдаж буй асуудал тул 'ногоон эдийн засаг'-ийн зарчмуудыг одооноос мөрдөх шаардлага өндөр байна. Иймд цэвэр эсвэл 'ногоон' технологид тулгуурласан эдийн засгийг хөгжүүлэх замаар урт хугацаанд нүүрлэж болзошгүй байгаль орчны хямралаас зайлсхийх нь чухал юм. Үүний тулд нөөцийг үр ашигтай ашиглах тогтолцоог бий болгох, байгаль орчны хяналтыг сайжруулах, 'ногоон' дэд бүтцийг бий болгох, сэргээгдэх эрчим хүчийг ашиглах, хог хаягдлыг дахин боловсруулах, үндэсний эдийн засгийн чадавх өсөхийн хэрээр байгалийн сэргээгдэх баялгийг ашигладаг үйлдвэрлэлийг хөгжүүлэх, өндөр ашиг шимтэй мал үржүүлэх, өндөр ургац өгдөг таримал ургамлыг ургуулах замаар ногоон эдийн засгийг хөгжүүлэх боломжтой.

АЖ ҮЙЛДВЭРИЙН IV ХУВЬСГАЛ. Энэ хувьсгал нь глобал үйлдвэрлэлийн өртгийн сүлжээний удирдлага, зохион байгуулалтад тооны болон чанар дэвшлийг авч ирсэн шинэ эринийг бий болгож байна. Аж үйлдвэрийн энэ шинэ үе шат нь автоматжуулалт, харилцаа холбоо болон даяаршлыг улам гүнзгийрүүлэхэд чиглэж байна. Энэ хувьсгалын үе шат нь бүхэлдээ технологи, түүний ялгаатай хэлбэрүүдэд анхаарлаа хандуулж байна: виртуал бодит байдал, хиймэл оюун ухаан, том өгөгдөл, клауд тооцоолол, орчин үеийн дизайн програмчлал, процесс симуляци, 3 хэмжээст хэвлэлт, нано болон биотехнологи, квант тооцоолол зэрэг болно.

Энэ хувьсгалын дүнд байгаль орчны бохирдол нэмэгдэх, зарим технологиор орлуулах боломжтой мэргэжлүүд (зээлийн шинжээч, зээлийн ажилтан, номын санч, даатгалын ажилтан, зурагчин гэх мэт) хөдөлмөрийн зах зээлээс хасагдах, улмаар орлогын тэгш бус байдал нэмэгдэх эрсдэлүүд бий болж байна. Харин хүн хоорондын харилцаанд суурилсан мэргэжлүүдийн эрэлт нэмэгдэхээр байна.

Иймд бид мэдлэгт суурилсан эдийн засгийг бүтээх, энэ аж үйлдвэрийн хувьсгалын сүлжээнд нэгдэх стратеги чухал байна.

МОНГОЛ УЛСЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын нөхцөл байдлын шинжилгээг нэгтгэн улсын давуу тал, сул тал, хөгжлийн боломж, аюул эрсдэлийг тодорхойлоход дараах байдалтай байна.

Хүснэгт 3. Монгол Улсын хөгжлийн өнөөгийн нөхцөл байдал

<p>ДАВУУ ТАЛ</p> <ul style="list-style-type: none"> - Дэлхийд өөрийн хувь нэмрээ оруулсан баялаг түүх, Монгол нүүдлийн соёл иргэншлийн үнэт зүйлстэй; - Нүүдэлчдийн нийгэм, соёлын давуу тал; - Тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, өөрсдийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, олон улстай харилцан тэгш эрхтэй хамтран ажиллах чадавх; - Гадаад, дотоод зөрчил, мөргөлдөөнгүй; - Оюуны өндөр чадамжтай иргэд, Монгол хүүхэд, залуучууд оюуны спорт, уралдаанд дэлхийд тэргүүлэх чадамж өндөртэй; - Өргөн уудам нутаг дэвсгэр, Бэлчээрийн мал аж ахуй, органик газар тариалан эрхэлж, хүнсээ дотоодоосоо бүрэн хангах чадавх; - Байгалийн арвин нөөц баялаг; - Түүхийн эдийн хамгийн том хэрэглэгч буюу эрэлтэй зах зээлтэй хамгийн ойр байршил; - Төв ба Дундад Ази, Европын орнуудыг Зүүн хойд, Зүүн өмнөд Азийн орнуудтай холбох транзит тээвэрт тохиромжтой газар зүйн байршил; 	<p>ХӨГЖЛИЙН БОЛОМЖ</p> <ul style="list-style-type: none"> - Монгол соёлын нэгдмэл үнэт зүйлийг сэргээх, гадаад дахь нөлөө, орон зайг тэлэх, аялал жуулчлал, соёлын үйлдвэрлэлийн боломж; - Дэлхийн тэргүүлэх 2 эдийн засаг (зах зээл)-д ойр байрлал хоёр хөрштэй найрсаг хамтын ажиллагаа, зах зээл, эдийн засгийн ирээдүйн боломж; - Мэдээлэл технологийн эрчимжилт, аж үйлдвэрийн 4-р хувьсгалын үр нөлөөний зардал бууруулах, шинэ бүтээгдэхүүн гаргалтыг хурдасгах, үр ашгийг нэмэгдүүлэх байдал; - Даяаршлын хүрээнд үйлдвэрлэлийн хямд орцуудыг хайсан гадны хөрөнгө оруулалтыг татах боломж өндөр; - Байгалийн цэвэр, органик бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж экспортлох боломж; - Дэд бүтэц, төмөр зам, тээвэр логистикийн төвийн тогтолцоо бүрдүүлж зах зээлийн хараат байдлаас гарах боломж; - “Гуравдагч хөршийн бодлого”-ын хүрээнд дэлхийн хамтын нийгэмлэгийн дэмжлэг. 	<ul style="list-style-type: none"> - Дэлхийн банкны гаргасан судалгаагаар 2050 он гэхэд дэлхийд хөгжлөөрөө тэргүүлэх 10 орны тоонд багтах 2 том их гүрний дунд оршдог; - Социализмын үеийн төлөвлөлтийн арвин туршлага 	<p>Харьцангуй экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж</p>
		<p>СУЛ ТАЛ</p> <ul style="list-style-type: none"> - Төрийн бодлого тогтворгүй, залгамж холбоогүй, сонгууль дагасан дөрвөн жилийн циклтэй, хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах институц бүрдээгүй; - Хүнд суртал, авлига их; - Бизнес эрхлэх орчин муу; - Хүн амын нягтшил бага, тархай суурьшилтай, хил орчмын нутаг дэвсгэрийн хүн ам цөөн, амьдрах орчин муу; - Хүн амын дунд харьцангуй сэргийлж болох өвчлөлөөс сэргийлэх мэдлэг, хандлага дутмаг; - Хөдөлмөрийн нөөц хязгаарлагдмал, мэргэжлийн өндөр ур чадвар, мэдлэгтэй хүний нөөц дутмаг; - Бүтээмжгүй, хоцрогдсон технологитой, бүтээгдэхүүний чанараар дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвар сул; - Хөрөнгө санхүү, валютын нөөц ихээхэн хязгаарлагдмал - Байгалийн нөөцийн жигд бус тархалт, үнэлэмж хангалтгүй - Экспортын гол нэрийн бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнийн хэлбэлзэл, гадаад эрэлтийн өөрчлөлт зэрэг хүчин зүйлсээс хамаарах эмзэг байдал өндөр; 	<p>АЮУЛ, ЭРСДЭЛ</p> <ul style="list-style-type: none"> - Соёлын үнэт зүйлийн нөлөө алдагдаж байгаа; - Засаглал сул, бодлого тогтворгүй байдал нь хөрөнгө оруулалтын орчныг муутгаж, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг түлхэх аюултай; - Гадаад өрийн дарамт өндөр - Эдийн засгийн өрөөсгөл бүтэц, тогтворгүй өсөлт. Уул уурхайгаас хэт хамаарал бүхий эдийн засгийн бүтэцтэй, Экспорт, импортын хувьд ганц зах зээлээс хараат байдал өндөр; - Баялгийн хараал, “Голланд өвчин”-д нэрвэгдэх, Хэт уул уурхай хөдөлмөр зарцуулалт багатай салбарын өсөлтийг дагалдан ажлын байр хомстох, орлогын зааг ялгаа гүнзгийрэх, эдийн засгийн үндсэн бүтэц алдагдах аюултай; - Томоохон орд газруудыг эргэлтэд оруулах, бусад төрөлжсөн бараа, үйлчилгээ бий болгож хөгжүүлэхэд урт хугацаа шаардлагатай; - Бүс нутгийн геополитикийн тогтворгүй байдал, - Бүсийн шинэ зах зээлд хувь эзлэх өрсөлдөөнд ялагдах магадлал их - Баян хоосны ялгаа их - Олон их дээд сургуультай боловч боловсролын чанар муу

<ul style="list-style-type: none"> - Уур амьсгалын эрс тэс нөхцөлтэй, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл байгаль, цаг агаараас ихээхэн хамааралтай; - Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг мэдрэмтгий, байгалийн нөхөн сэргэх чадвар сул; - Тивийн болон бүс нутгийн олон улсын гол зам харилцаанаас алслагдсан, далайд гарах шууд гарцгүй; дэд бүтцийн хөгжил сул - Төрийн албаны боловсон хүчний бодлого алдагдсан, мерит тогтолцоо бүрдэж чадаагүй. - Цацраг идэвхт болон химийн хорт бодисын хяналт сул; 	<ul style="list-style-type: none"> - Хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа их, ажилгүйдэл, ядуурлын түвшин өндөр; - Хүн амын хэт төвлөрлөөс үүдсэн хөрс, утаа орчны бохирдол их; - Хот усны нийлүүлэлтээ хангаж дийлэхгүй болох аюултай - Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагавар; - Дунд болон урт хугацаанд хөдөлмөрийн насны хүн амын хувийн жин харьцангуйгаар буурах, ажиллах хүчин дутагдах, гадагш чиглэсэн “тархины урсгал” нэмэгдэх эрсдэл өндөр; - Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болсон зүрх судас, хорт хавдрын өвчлөл, нас баралт өндөр байгаа бөгөөд нэмэгдэх хандлагатай; - Хүнд ноцтой гэмт хэргийн өсөлт, хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ нэмэгдэх аюултай; - Кибер аюул заналд өртөх, мэдээллийн аюулгүй байдал сул.
--	---

ДАВУУ ТАЛДАА ТУЛГУУРЛАН ХӨГЖЛИЙН БОЛОМЖОО ТОДОРХОЙЛОХ НЬ

- Монголын нүүдлийн соёл иргэншлийн өвийг баяжуулан хөгжүүлж, дэлхийд соёл урлагийн бүтээл туурвин таниулж, орлого олох;
- Өөрийн орны археологи, палеонтологийн судалгаагаар түүхээ арвижуулан уран бүтээл туурвин дэлхийн тайз дэлгэцийн зах зээлд гаргах;
- Монгол үндэсний наадам, уралдаан тэмцээнийг олон улсын болон олимпын спорт болгон хөгжүүлэх;
- Монголын уламжлалт хүнсийг хэрэглэхэд хялбар, боловсронгуй болгон сайжруулж стандартжуулан гадаад зах зээл дээр монгол үндэсний хоолны сүлжээ бий болгох;
- Оюуны чадамжтай ард иргэдээ хөгжүүлэн өрсөлдөх чадвартай мэргэжилтэн бэлтгэж бүс нутагт орчин үеийн оюун ухаан, техник, технологийн, үйлчилгээ үзүүлэх;
- Байгалийн ургамал, малын түүхийг эдээр төрөл бүрийн эм, биотехнологи, гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортлох;

- Гэр болон ахуйн хэрэгслийг боловсронгуй болгож гамшгийн үеийн байгууламж, сууц бий болгон экспортлох;
- Уламжлалт оньсон тоглоомоор орчин үеийн цахим тоглоом үйлдвэрлэлээр танигдсан сор бүтээгдэхүүн бий болгож улс орноо сурталчлан таниулах;
- Иргэдийн оролцоотой, нүүдлийн соёл иргэншил, түүх, байгаль, ахуйн аялал жуулчлал хөгжүүлэх
- Дэлхийд тэргүүлэх эдийн засагтай хоёр хөрштэй эдийн засгийн интегралчлал хөгжүүлэн дамжин өнгөрүүлэх тээвэр, худалдааг хөгжүүлэх;
- Газарзүйн байршлын давуу талыг ашиглан дэлхийн болон бүс нутгийн агаарын тээврийн карго урсгалын зангилаа төв, эдийн засгийн чөлөөт бүс байгуулан хөгжүүлэх;
- Мэдээллийн технологийн хөгжлийн давуу талыг ашиглан улс орны нийгэм, эдийн засаг, байгаль орчны хамгаалал, засаглалын ил тод байдлыг хангах, авлигаас сэргийлэх;
- Дотоодын ААН-үүдэд сургалт хийх, шинэчлэн зохион байгуулах замаар гадаадын шууд хөрөнгө оруулалттай холбох харилцааг бэхжүүлэх, улмаар хөрөнгө оруулалт, бизнесийн орчинг сайжруулах;
- Тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, олон улстай харилцан тэгш эрхтэй хамтран ажиллах чадавх дээр тулгуурлан өөрийн орны нутаг дэвсгэрт НҮБ болон түүний харьяа бүс нутгийн байгууллагуудыг үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх, урамшуулах замаар бүс нутгийн НҮБ-н суурин газруудыг бий болгож, тусгаар тогтнолоо улам баталгаажуулах.

БОЛОМЖИЙГ ЭРЭЛХИЙЛЖ СУЛ ТАЛАА АРИЛГАХ НЬ

- Өөрийн орны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн түүхэн туршлагыг бусад улс орнуудын зах зээлийн үеийн төлөвлөлтийн туршлагатай хослуулан төрийн бодлогын тогтвортой байдал, залгамж чанарыг бий болгох;
- Орчин үеийн мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжлийг ашиглан мэдээллийн ил тод байдлыг бий болгон, олон нийтийн оролцоонд тулгуурлан авлига, хүнд суртлыг бууруулах, улмаар устгах;
- Орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжсэн дэд бүтэц, логистикийн сүлжээг бий болгох, хил орчмын хуралдаа, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах, алслагдмал бүс нутгийн иргэдийн амьдрах орчин болон, бизнесийн таатай орчин бий болгох;
- Эрүүл мэндийн салбарт мэдээллийн технологи болон шинжлэх ухаан, технологи, инновацийг хөгжүүлэх, өвчин үүсгэх шалтгааныг илрүүлэх замаар хүн амыг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Хувийн хэвшлийн судалгаа хөгжүүлэлтийг бүх талаар дэмжих замаар Шинжлэх ухаан, технологи, инновацийг үйлдвэрлэлд нэвтрүүлэн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх;

- Гадаад худалдаа, бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо, логистикийн сүлжээ бий болгох эрхзүйн орчинг бий болгох замаар нийлүүлэлтийн гаралтай инфляцыг тэглэх, банк санхүүгийн салбарын шинэчлэл хийх замаар банкны хүүг бууруулан зохих түвшинд хүргэж валютын нөөцийг тасралтгүй нэмэгдүүлэх;
- Төсвийн хөрөнгө оруулалтаар геологи, хайгуулын ажлыг эрчимжүүлэн ашигт малтмалын нөөцийг нэмэгдүүлэх;
- Уур амьсгалын эрс тэрс нөхцөлөөс сэргийлэх нөөцийн удирдлагын тогтолцоог бий болгох;
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ойжуулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, усан сан, толио үүсгэх, говийн бүс рүү ус дамжуулах хоолойг барьж байгуулах;
- Шинжлэх ухаан, их дээд сургууль, хувийн хэвшлээс шилдэг хүний нөөцийг судлах, төрийн албаны тогтолцоонд мэдлэг, чадвараар дэвших өрсөлдөөнт орчинг бүрдүүлэх;
- Цацраг идэвхт болон химийн хорт бодисын үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалт, ашиглалт, устгалын мэдээллийн нэгдсэн санг бий болгон хяналтыг сайжруулах.

ДАВУУ ТАЛДАА ТУЛГУУРЛАН ЭРСДЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ НЬ

- Уламжлалт ёс зан заншил, нүүдлийн соёл иргэншил, түүх дээр тулгуурлан үндэсний нэгдмэл үнэт зүйл бий болгох, үндэсний бахархал бий болгоход соён гэгээрүүлэх үйл ажиллагаа тогтмол явуулах, хүүхэд залуусыг гадны соёлын түрэмгийллээс сэргийлэх;
- Нийгмийн баримжаат зах зээлийн эдийн засаг, засаглалыг хөгжүүлэн төрийн бодлого, төлөвлөлтийг урт хугацаанд тогтвортой байлгах, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бий болгох;
- Баялгаар далласан хөрөнгө оруулалтын бодлогыг халж, харилцан ашигтай үр дүнд чиглэсэн хөрөнгө оруулалтын бодлого боловсруулж, тууштай мөрдөх;
- Уул уурхайн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийг хөгжүүлэх;
- Эдийн засгийн коридорыг хөгжүүлэн гуравдагч зах зээлд гарах зардлыг бууруулах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, мөн, агаарын тээврийг либералчлах замаар өртөг өндөр, овор багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэн агаарын тээврээр гуравдагч орнуудтай эдийн засгийн интеграцад орох;
- Уул уурхайн орлогоос тодорхой хувийг төвлөрүүлэн Баялгийн сан байгуулж, уул уурхайн бус салбар болон нийгмийн салбарыг хөгжүүлэх;
- Томоохон орд газруудыг эргэлтэд оруулах менежментийг сайжруулах, хөрөнгийн зах зээл, хөрөнгө оруулалт татах орчинг бүрдүүлэх;
- Дэлхийн хамтын нийгэмлэгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, хүлээн зөвшөөрүүлэхэд гадаад бодлогыг чиглүүлэх;

- Япон судлал, хятад судлал, солонгос судлал, орос судлалыг тухайн орны хөгжлийн бодлого, төлөвлөлт, эдийн засаг, шинжлэх ухаан технологийн судалгаагаар өргөжүүлэн Технологийн хөгжлийн судалгааны төв байгуулах;
- Орлого ихтэйгээс татвар илүү авч орлого багатай нийгмийн бүлгийн хэрэгцээг хангах замаар орлогын тэгш байдлыг хангах;
- Салбарын яам, мэргэжлийн холбоодын оролцоотой, эрэлтэд суурилсан дээд боловсролын тогтолцоог хөгжүүлэх;
- Эдийн засгийн бүсчлэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах бодлого, боловсруулж, хэрэгжүүлэх;
- Улаанбаатар хотын усан хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, ус дамжуулах хоолой байгуулах, гадаргын усны хуримтлал бий болгох усан сан байгуулах, саарал усны хэрэглээг нэмэгдүүлэх замаар ундны ус хэмнэх;
- Компанийн нийгмийн хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх замаар өрсөлдөхүйц цалин, урамшууллыг дэмжих;
- Генийн өөрчлөлттэй бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, худалдаалах, тээвэрлэх, дагалдах, дамжин өнгөрүүлэхийг хориглох;
- Нас баралтын тэргүүлэх өвчлөлөөс сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох, эмчлэх талаар Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, иргэдэд зүрх судас, хорт хавдрын өвчлөлөөс сэргийлэх, хандлагыг өөрчлөх үндэсний дархлаа бий болгох;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хөрш орнууд болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, эрсдэлтэй иргэдийн хяналтыг чангатгах;
- Олон улсын туршлага судлан байнга мэдээлэл солилцох Кибер халдлагаас сэргийлэх үндэсний тогтолцоог бүрдүүлэх.

СУЛ ТАЛАА БАГАСГАХ, ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛАХ НЬ

- Гадны соёлын түрэмгийллээс сэргийлэх, хязгаарлах арга хэмжээ авах, үндэсний соёлын дархлааг бий болгох суртал ухуулга, контент бий болгож, тайз дэлгэцийн цуврал бүтээл бий болгох, сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт үндэсний бахархал, үнэт зүйлийн талаар тусгахад төрөөс онцгойлон анхаарах;
- Урт хугацаанд улс орны өмнө тулгарч байгаа асуудлаар улс төрийн намууд зөвшилцөлд хүрч, улс төр эдийн засгийн бодлого боловсруулж, тууштай хэрэгжүүлэх;
- Улс орны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай байгаа гадаадын хөрөнгө оруулалтын эрэлт хэрэгцээг салбар бүрээр тодорхойлсон бодлого боловсруулж, тууштай хэрэгжүүлэх;
- Гадаад өрийг дахин хуваарилан зохион байгуулах замаар төсөвт ирэх дарамтыг бууруулах, эдийн засгийн үр ашиггүй төсөл, хөтөлбөрийн хэрэгжүүлэхгүй бай;

- Уул уурхайн түүхий эрдсийн экспортыг хязгаарлах, дотоодын хэрэгцээг бүрэн хангасны дараа илүүг экспортлох зарчмаар дотоодын боловсруулах үйлдвэрүүдийг түүхий эдээр хангах эрх зүйн татварын орчинг бүрдүүлэх, уул уурхайн бус, ажлын байр ихээр нэмэгдүүлэх дэвшилтэд технологи бүхий төслийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд хөрөнгө оруулалтын нэн таатай орчинг бий болгох;
- Томоохон орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулах, уул уурхайн орлогоос Баянгийн сан бий болгох эдийн засгийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;
- Нийгмийн дундаж давхаргыг нэмэгдүүлэх тусгайлсан бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;
- Хот, хөдөөгийн ялгааг бууруулахад бүсчилсэн хөгжлийн оновчтой бодлого, Улаанбаатар, дагуул хотуудыг хөгжүүлэх тусгайлсан бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;
- Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох ногоон хөгжлийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;
- Хүн амын ядуурал, тэгш бус байдал, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт зэрэг нийгмийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх хүний хөгжлийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх.

БИДЭНД ЯМАР ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ ТУЛГАРЧ БАЙНА ВЭ?

Ядуурлын түвшин өндөр байна. Манай улсын ядуурлын түвшин 2018 оны байдлаар 28.4 хувьтай байгаа нь өндөр үзүүлэлт. Өөрөөр хэлбэл, нийт хүн амын 28.4 хувь нь өдөрт 1.9 ам.доллараас бага орлогоор амьдарч байна. Сүүлийн 25 жилд манай эдийн засаг хурдацтай тэлж, нэг хүнд ногдох ДНБ Дэлхийн банкны Атласын арга ашиглан оны үнээр тооцоход 4009 ам.долларт хүрсэн хэдий ч, ядуурал дорвитой буурахгүй, орлогын ялгаа нүдэн дээр нэмэгдэж байна. Эдийн засгийн сэргэлтээс нийгмийн үзүүлэлтүүд (ядуурал, тэгш бус байдал, боловсрол, эрүүл мэнд, цэвэр ус, цэвэрлэх байгууламж, инноваци, хүмүүн капитал, дэд бүтэц гэх мэт) рүү шилжих үндсэн суваг нь улсын төсөв болж байна. Хэдийгээр эдийн засгийн өсөлт нь өрхийн орлогоор дамжих боломжтой хэдий ч хүн амын дийлэнх хэсэгт орлогын дорвитой өсөлт ажиглагдахгүй байна. Ялангуяа, манай улсад ядуурал сүүлийн 30 жилд 'ужгирсан' тул ядуурлын шугамаас бага орлого олж байгаа иргэд хөдөлмөр эрхлэх боломж, чадавх байхгүй гэж хэлж болно. Улсын төсвөөс нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх зориулалтаар олгож буй санхүүжилт хангалтгүй, зорилтот бүлэгтээ хүрч чадахгүй, үр ашигтай бус (орлогын дахин хуваарилалтын оновчтой механизм бүрдээгүй) зэрэг олон асуудлууд гарч байна. Тухайлбал, нийгмийн халамжийн хөтөлбөрүүд зорилтот бүлэгт бүрэн чиглээгүй, зорилтот бүлгийг тодорхойлохдоо өрх, иргэний амьжиргааны түвшинд бус категорин аргад илүү суурилсан хэвээр байна. Халамжид зарцуулж байгаа хөрөнгийн өсөлт нь ядуурлыг

бууруулахад үзүүлэх нөлөөлөл бага, бэлэн мөнгөний нөхцөлт бус хөтөлбөрүүд ихтэй, үйлчилгээнд суурилсан хөтөлбөрүүд багатай байна¹. Нийгмийн халамжийн үйлчилгээний хамрах хүрээ хэт өргөн болж жилд дунджаар 800 орчим мянган хүнийг хамруулж, 4 хүн тутмын нэгд төрөөс халамж үзүүлж байгаа нь зорилтот бүлэгт чиглээгүйг харуулж байна.

Түүнчлэн эдийн засгийн өсөлт нь тогтвортой бус, глобал зах зээл дээрх эрдэс түүхий үнэ, эрэлтээс хамааран хэлбэлзэж байгаа нь ажлын байр, орлогын өсөлт тогтвортой байж, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх боломжийг хязгаарлаж ирлээ. Энэ нь дунджийн доод орлогын ангилалд байгаа иргэд, өрхийн ядууралд орох эмзэг байдлыг нэмэгдүүлж байна. Манай улс өмнөх өр төлбөрөө төлөх, суурь дэд бүтцийн асуудлууддаа анхаарч, харин нийгмийн асуудлууддаа дорвитой шийдэж чадахгүй байх хооронд он жилүүд өнгөрсөөр ирлээ.

Ажилгүйдэл дорвитой буурахгүй байна. Ядуурал, ядууралд орох эмзэг байдал өндөр байх суурь шалтгаан нь ажилгүйдэл болж байна. Ажилгүйчүүдийн боловсролын түвшинд гарч буй өөрчлөлтөд анхаарал хандуулах шаардлагатай байна. Тухайлбал, нийт бүртгэлтэй ажилгүйчүүдэд өндөр боловсролтой, мэргэжилтэй иргэдийн эзлэх хувийн жин нэмэгджээ. Энэ нь хөдөлмөрийн зах зээлд боловсролын түвшин, мэргэжлийн байдлаарх эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрт харьцаа ихээхэн алдагдсан байгаад анхаарал хандуулах шаардлагатайг сануулж байна. Ажилгүйдлийн шалтгааны талаарх судалгаагаар 2017 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт ажилгүйчүүдийн тоо 100.3 мянга байснаас 49.3 хувь нь ажил хайгаад олдохгүй, 12.2 хувь нь мэргэжилд тохирох ажил олдохгүй байгаа, 11.1 хувь нь мэргэжил, дадлага, туршлага байхгүйн улмаас ажилгүй байгаа зэргийг нэрлэсэн нь зонхилох шалтгаанууд болж байна. ҮСХ-ноос 2015 онд хийгдсэн хэтийн тооцоогоор, Монгол Улсын хүн амын тоо 2045 он гэхэд 5.0 саяд хүрэхээр байна. Нийт хүн амын 60.6 хувийг 15-64 насны хүн ам, 9.0 хувийг 65, түүнээс дээш насны бүлэг бүрдүүлэхээр байна. Үүний зэрэгцээ 2023 оноос Оюу толгой бүрэн хүчин чадлаар ажиллаж эхэлснээр 8000 орчим өндөр ур чадвартай ажилтан ажлын байргүй болох нөхцөл байдал үүснэ. Иймд эдгээр ур чадвартай ажилчдыг ажиллуулах үүднээс томоохон олборлолт, үйлдвэрлэлийн төслийг залгуулаад эхлүүлэх хэрэгцээ өндөр байна. Энэ нь нэг талаас тэтгэврийн насыг хойшлуулах, нийгмийн халамжийн зардал өсөх, дараагийн 25 жилд чанартай ажлын байрыг нэмэгдүүлэх шаардлага нэмэгдэж байгаа дохио юм.

Эдийн засгийн сэргэлтийн он жилүүдэд ч улирлын шинж чанараас хамааран ажилгүйдэл өндөр хувьтай байсаар байна. Уул уурхай зэрэг орлого өндөртэй салбарууд нь хөдөлмөр шингээлт багатай, харин барилгын салбар нь улирлын шинж чанартай ажил эрхлэлтийг бий болгож байна. Хөдөө аж ахуй, үйлчилгээ зэрэг хөдөлмөр шингээлт өндөртэй салбаруудын бүтээмж муу байгаагаас цалин, хөлс бага байна. Нөгөө талаас эдийн засгийн идэвхжил, уналтын мөчлөг богино байгаа нь бизнес

¹ Хүүхдийн мөнгийг оролцуулахгүйгээр нийгмийн халамжийн үйлчилгээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар 414.61 тэрбум төгрөгийг зарцуулсан нь ДНБ-ий 1.29 хувь, хүүхдийн мөнгийг оруулан тооцвол, ДНБ-ий 2.0 хувь болж байна. Харин дундаж орлоготой гадны улс орнууд ДНБ-ийхээ 1.6 орчим хувийг, өндөр орлоготой улс орнууд ДНБ-нийхээ 1.9 орчим хувийг нийгмийн халамжийн арга хэмжээнд зарцуулдаг байна.

тогтвортой байж, ажлын байр нэмэгдэх боломжийг хязгаарлаж байна. Иймд тогтвортой, чанартай ажлын байрыг бий болгох асуудал чухал байна. Үүний тулд хувиараа хөдөлмөр эрхлэх боломж, ЖДҮ-ийг дэмжих, аялал жуулчлал дагасан үйлчилгээний салбаруудыг өргөжүүлэх, техник, технологийн дэвшилд тулгуурлан бүтээмжийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварт суурилсан боловсруулах аж үйлдвэрийг хөгжүүлэх асуудал чухал байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагааг бодит хөрсөнд буулган идэвхжүүлэх шаардлага хэвээр байна.

Авилгал хөгжлийг боомилж байна. Бидний дайсан бол авилгал юм. Авилгал нь бидэнд үндсэн хуулиар олгогдсон тэгш боломжийг алга болгож, үнэнч байдал, шударга ёсыг устгаж байна. Өнөөдөр бүх түвшинд авилгал газар авч, эдийн засаг, нийгэм, байгаль орчны ноцтой сөрөг үр дагаварт хүргэж эхлээд байна. Бид авлигалгүй, хуулийн өмнө хүн бүр ижил хариуцлага хүлээх нийгмийг бүтээхгүй бол дор бүрнээ хичээсэн ч, хүссэн үр дүн, хөгжилд хүрч чадахгүй. Авлигалын индексээр Монгол Улс 100 оноос 37 оноо авч, 180 орноос 93-т эрэмбэлэгдэж байна. УИХ-аас 2016 онд баталсан “Авлигалын эсрэг үндэсний стратеги 2016-2023”-ийг амжилттай хэрэгжүүлж чадах эсэх нь эхний том сорилт болно.

Засаглал сул, бодлого тогтворгүй. Тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангаж чадах эсэхэд засаглалыг сайжруулах асуудал чухал үүрэгтэй. Ардчилсан нийгэмд шилжээд дөнгөж 30 жил болж байгаа, институц бүрдээгүй, байгалийн баялагтай манай орны хувьд засаглалын чанараас их зүйл хамаарна. Сул засаглал нь олон сувгаар дамжин хөрөнгө оруулалтын орчныг муутгаж гадаадын шууд хөрөнгө оруулалтыг түлхэх, төсвийн сахилга батгүй байдлаас үүдэн улсын өрийг нэмэгдэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо хангалттай бүрдээгүйгээс банкуудын корреспондент харилцаанд дарамт бий болох сөрөг үр дагаврыг бий болгоно. Энэ хүрээнд авлигалыг устгах, хуулийг бүх нийтээр даган мөрддөг болох, шүүхийн шударга тогтолцоо бүрдэх, төсвийн сахилга бат, засаглалыг сайжруулах, санхүүгийн салбарын хяналтыг дээшлүүлэх, төв банкны засаглал, үйл ажиллагааны бие даасан байдлыг бэхжүүлэх шаардлага тавигдаж байна.

Бидэнд Монгол банкнаас төсвийн шинжтэй үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй байх, төсвийн сахилга батыг хангах (нэгдсэн төсөв+хөгжлийн банк+концесс+төсвийн шинжтэй үйл ажиллагаа гэсэн олон эх сурвалжийг давтахгүй байх), төсвийн болон гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, банкны салбарын эрсдэл даах чадавхыг сайжруулах асуудал түүхэн сургамж болж үлдлээ. Төсвийн сахилга батыг хангах асуудал дан ганц хэт тэлэлтийг хэрэгжүүлэхгүй байхаас гадна төрийн засаглалын асуудал юм. Үүний цаана хууль, журмыг даган мөрдөх, авлигаас ангид байх, төр мэргэшсэн, үр ашигтай ажиллах зэрэг олон асуудлууд давхар агуулагдана.

Улс төрийн тогтворгүй байдлыг даган бодлогын тогтворгүй байдал хэвшил болж ирлээ. Хөгжлийн тулгуур асуудлууд дээр нэгдсэн зөвшилцөлд хүрч, харин түүнийг хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлэх асуудал дээр улс төрийн намууд бодлогоо уралдуулдаг дэлхийн жишигт очих шаардлага бидний өмнө байна. Сүүлийн 28 жилийн хугацаанд Монгол Улс ОУВС-гийн хөтөлбөрийг зургаан удаа авч, нийт 14 жилд нь тус сангийн хөтөлбөртэй

явсаар өнөөдөртэй золголоо. Шилжилтийн дараах он жилүүдэд буюу 1991-2000 онд гурван хөтөлбөр хэрэгжүүлсэн бол 2001-2010 онд хоёр хөтөлбөр, харин 2010 оноос хойш 2017 онд “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна. Монгол Улс зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэнээс хойших 28 жилийн хугацаанд нийгэм, эдийн засгийн хөгжлийн хувьд тодорхой амжилтад хүрээд байна. Гэвч улс орны макро эдийн засгийн болон хөгжлийн бодлого тогтворгүй явж ирлээ. Сүүлийн 28 жилийн хугацаанд Монгол Улс Ерөнхий сайд 15, Сангийн 15 сайд (нэрийн давхардлыг хасвал тус бүр 14), Монгол банкны 8 ерөнхийлөгчтэй байжээ. Сүүлийн таван жилээр үзэхэд, Ерөнхий сайд 4, Сангийн сайд 5-тай байв. Тогтвортой эдийн засгийн бодлого, төрийн бодлогын залгамж халаа манай оронд туйлын чухал байна.

Дотоод хуримтлал багатай. Үндэсний хуримтлал нь дотоод хөрөнгө оруулалт, хэрэглээг хангахад хүрэлцэхгүй байгаагаас Монгол Улс урсгал тэнцлийн өндөр алдагдалтай явж ирлээ. Үүнийг гадаадын шууд хөрөнгө оруулалт болон гадаад өрөөр санхүүжүүлж ирлээ. Гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирэх нь олон эерэг дам нөлөөг бий болгож, өсөлтөд эерэгээр нөлөөлдөг хэдий ч сүүлийн жилүүдэд нэг хүнд ногдох ДНБ өссөн хэдий ч нэг хүнд ногдох ҮНО-ын өсөлт бага байх дүр зураг ажиглагдаж эхэллээ. Энэ нь гадаадын шууд хөрөнгө оруулалтаас манай улсад үлдэх үр өгөөжид онцгой анхаарах шаардлагыг анхааруулж байна. Улсын гадаад өрийн хэмжээ ч жил дараалан өссөөр ДНБ-ий 220 хувьд хүрсэн нь манай эдийн засгийн эмзэг байдлын нэмэгдүүлж, хүүний дарамтыг нэмэгдүүлж байна.

Байгалийн баялагт тулгуурлах хөгжлийн загвар нь байгалийн баялгийн орлогыг нэмэгдүүлж, түүнийг баялгийн сандаа хуримтлуулж, түүнээс урт хугацааны тогтвортой өсөлт, хөгжилд хүргэх үр ашигтай хөрөнгө оруулалт хийх явдал билээ. Иймд баялгийн сангийн тогтолцоог цогцоор бүрдүүлж, нөөц хөрөнгө хуримтлуулах шаардлага өндөр байна. Эдийн засгийн дархлааг бий болгоход гадаад албан нөөцийг үргэлжлүүлэн нэмэгдүүлэх, төсвийн алдагдлыг өсгөхгүй байж, улсын өрийн ДНБ-нд эзлэх хувийг тогтвортой бууруулж, төсвийн орон зай бүрдүүлэх асуудал чухал байна. Цаашид эдийн засгийн дотоод, гадаад тэнцвэрийг хангахын тулд гадаад эх үүсвэрийг бүрдүүлэх, өмнөх өрийн нөхцөлийг муутгахгүйгээр сунгахад олон улсын санхүүгийн байгууллага, доноруудын дэмжлэг, санхүүжилт цаашид ч зайлшгүй чухал болж байна.

Орлогын тэгш бус байдал нь боломжийн тэгш байдалд хүргэх эрсдэлтэй байна. Орлогын тэгш бус байдал нэмэгдэхийн хэрээр өндөр төлбөртэй хувийн сургууль, эмнэлэг нэмэгдэж байна. Нөгөө талд нь, орлого багатай өрхийн хүүхдүүд сургууль явахгүй, эмнэлгийн үйлчилгээ, вакцинд хамрагдаж чадахгүй, хоол тэжээлийн дутагдалд орох байдал ажиглагдаж байна. Төрийн орлогын дахин хуваарилалтын оновчтой механизм бүрдэхгүй, сургууль, эмнэлгийн үйлчилгээ зэрэг нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжрахгүй тохиолдолд ядуу өрхөд төрсөн хүүхэд бие бялдар, оюуны мэдлэгийн хувьд боломжийн тэгш бус байдалд орж, улмаар хөдөлмөрийн зах зээл дээр ч өрсөлдөх чадваргүй болохоор байна. Боломжийн тэгш бус байдал нь нийгмийн ялгарлыг бий болгож, орлого өндөртэй бүлгийг гадуурхах, улмаар зөрчилдөөнд ч хүргэх эрсдэлтэй. Өнөөдөр өнгө мөнгө, эрх мэдлийг шүтсэн үзэл давамгайлж байгаа нь

Монгол хүний 'хүн болох' төлөвшилд ч сөргөөр нөлөөлж байна. Иймд нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, бүх түвшинд шударга ёс, тэгш байдлыг эрхэмлэх ('улааныг харж урвахгүй, шарыг харж шарвахгүй' байх) шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Хот, орон нутгийн хөгжлийн ялгаа эрс өсөж, шилжилт хөдөлгөөн нэмэгдлээ. Нийгмийн үйлчилгээнд хамрагдах хот, хөдөөгийн ялгаа байсаар байна. Жишээ нь, орон нутагт их дээд сургууль хомс, нарийн мэргэжлийн эмнэлгийн үйлчилгээнд хот, суурин газар ирж хамрагдаж байна. Үүний зэрэгцээ орон нутагт ажлын байр хомс, зах зээл хумигдмал зэрэг нь их, дээд сургууль төгсөгчид орон нутаг руу эргэн буцах боломжийг хязгаарлаж байна. Тухайлбал, бусад бүсүүдтэй харьцуулахад Улаанбаатар хотын хүний хөгжлийн индекс хамгийн өндөр байна. Энэ нь орон нутгаас Улаанбаатар хот руу шилжих хөдөлгөөн эрчимжихэд хүргэсээр байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд Улаанбаатар хотын хүн амын жилийн дундаж өсөлт 5.6 хувьтай байна. Улаанбаатар хотод шилжиж ирсэн хүн бүр ажилтай байж, орлого, амьдралын чанар дээшилж байна уу гэвэл үгүй юм. Энэхүү шилжих хөдөлгөөн энэ хэвээр үргэлжлэх тохиолдолд хотын төвлөрөл, түүнийг дагасан асуудлууд нэмэгдэх, хөдөө орон нутгийн хөгжил улам хоцрогдож, эзэнгүй дэх эрсдэлтэй байна. Иймд хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг арилгах, шилжих хөдөлгөөнийг эсрэг чиглэлд өөрчлөх бодит хэрэгцээ байна. Үүний тулд орон нутагт болон хот, суурины зах зээлд холбох дэд бүтцийг барьж байгуулах, их дээд сургууль, эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, бизнес эрхлэх боломжийг дээшлүүлэх, орон нутгийн давуу талд тулгуурлан ажлын байрыг нэмэгдүүлэх шаардлага тавигдаж байна.

Хотжилтын асуудал. Улаанбаатар хот болон бусад суурин газар руу чиглэсэн шилжих хөдөлгөөн нь хүн амын хэт төвлөрөл, хэт ачааллыг бий болгож агаар, усны бохирдол, замын түгжрэл, инженерийн дэд бүтцийн хомстол зэрэг тулгамдсан асуудлуудыг бий болгож байна. Энэ нь эргээд өвчлөл нэмэгдүүлэх, нийгмийн стресс бий болгох, ая тухтай орчинд амьдрах боломжийг ч хязгаарлаж байна. Улаанбаатар хотод нийт хүн амын 40 хувь нь амьдарч байгаа бөгөөд энэ дүн цаашид ч үргэлжлэн өсөхөөр байна. Улаанбаатар хотын тэлэлт, инженерийн дэд бүтэц өсөн нэмэгдэж буй ачааллыг үргэлжлүүлэн шингээх боломж хязгаарлагдмал юм. Иймд хотжилтын дэд бүтцийг сайжруулах, улсын нийслэлийг шилжүүлэх бодит шаардлагыг бий болгож байна. Нийслэл шилжүүлэх ажлыг төрийн байгууллагууд, их дээд сургуулиудаас эхний ээлжид хамруулах байдлаар шуурхай эхлэх нь зүйтэй байна.

Бизнес эрхлэх орчин муу байна. Дэлхийн банкны 'Бизнес эрхлэх хялбар байдлын индекс'-ээр Монгол Улс 190 орноос 74-т эрэмбэлэгдэж байна. Манай улсын хувьд зээл авах боломж, барилгын зөвшөөрөл авах зохицуулалтаар эхний 25-т эрэмбэлэгдэж байна. Бизнес анх эрхлэх боломж, татварын ачаалал, өмчийн бүртгэл болон гэрээний хэрэгжилт хангуулалтын үзүүлэлтээр 49-87-д эрэмбэлэгдэж байна. Харин хил дамнасан худалдаа эрхлэхэд тулгарч буй бэрхшээл, цахилгаан, эрчим хүчний хангамж болон маргаан шийдвэрлэх процессын үзүүлэлтээр 117-152-т эрэмбэлэгдэж байна. Иймд өрсөлдөх чадвараа дээшлүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг даллан дуудахын тулд хойш нь татаж буй үзүүлэлтүүд дээр онцгой

анхаарал хандуулах шаардлага гарч байна. Үүний тулд цахилгаан, эрчим хүчний хэрэгцээг дотооддоо бүрэн хангадаг болох, түүний шугам сүлжээг сайжруулах, гадаад худалдаа эрхлэхэд хилийн наана болон хилийн цаана байгаа барьеруудыг хөнгөвчлөх, хууль хяналтын байгууллагууд маргаан, зөрчлийн шуурхай, шударга шийдэх зэрэг асуудлуудыг эн тэргүүнд шийдвэрлэх хэрэгцээ байна. Үүний зэрэгцээ төрийн үйлчилгээг чирэгдэл багатай, шуурхай, хүртээмжтэй үзүүлэхэд орчин үеийн техник, технологиуд түлхүү ашиглах нь зүйтэй.

Эдийн засгийн өрөөсгөл бүтэц, тогтворгүй өсөлт. Монгол Улсын эдийн засгийн бүтэцэд 1994 онд хөдөө аж ахуйн салбар 32.3 хувийг эзэлж байсан бол 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 10.8 хувь болж буурсан байхад аж үйлдвэр түүний дотор уул уурхайн салбарын хувийн жин 28.5-аас 41.5 хувь, үйлчилгээний салбар 39.2-оос 47.7 хувь болж тус тус өсөөд байна.

Нийт экспортод эрдэс түүхий эдийн экспортын эзлэх хувийн жин 90 орчимд хувьд хүрсний дээр Гадаадын шууд хөрөнгө оруулалтын дийлэнх нь уул уурхайн нэг төсөл дээр орж ирж байна. Уул уурхайн салбараас хэт хамааралтай манай улсын эдийн засгийн өрөөсгөл бүтэц нь эдийн засгийн өсөлт тогтвортой байж, нийгмийн үзүүлэлтүүдэд шилжих боломжийг хязгаарлаж ирлээ. Сүүлийн 20 жилд манай улсын эдийн засагт 3-4 жил тутамд өрнөл, уналтын мөчлөг тохиолдож байгаа нь богино хугацааны өсөлтийн нөлөө нь өрхийн амьжиргаа, нийгмийн үзүүлэлтүүдийг сайжруулах боломжийг хязгаарлаж байна. Түүнчлэн, эдийн засгийн өсөлт нь уул уурхайн зэрэг капитал багтаамжтай цөөн салбар, компаниудад бий болж байгаа нь хүртээмжтэй өсөлт сул байх, өсөлтөөс бий болсон орлого нь импорт (машин тоног төхөөрөмж, шатахуун, эрчим хүч гэх мэт), үйлчилгээ (тээврийн, зураг төсөл, барилга байгууламж зэрэг зөвлөх үйлчилгээ), ногдол ашгийн төлбөрт эргээд гадагшаа гарахад хүргэж байна. Түүнчлэн манай улсын нийт экспортод БНХАУ-ын эзлэх хувь 90 орчим хувьд хүрээд байна. Энэ нь БНХАУ-ын эдийн засгийн өсөлтөд гарч болох аливаа савалгаа гадаад эрэлтээр дамжин дотоод эдийн засагт хүчтэй нөлөөлөх нэг эрсдэл болж байна.

Иймд богино, дунд хугацаандаа эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах, дархлааг дэмжих макро эдийн засгийн бодлого (ГВАН нэмэгдүүлэх, төсвийн сахилга бат хангах, мөнгөний болон төсвийн бодлого оновчтой хослол гэх мэт) хэрэгжүүлэх, бүтцийн бодлогын хүрээнд бүтээмжийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, эдийн засгийг олон тулгууртай болгох зэрэг ажлыг зоримог, шуурхай эхлүүлэх шаардлага өндөр байна.

Дэд бүтцийн сул хөгжил, өрсөлдөх чадварын сул байдал. Төсөв, мөнгөний бодлого нь эдийн засгийн эрэлтийн талд голлон нөлөөлдөг тул богино хугацааны хэлбэлзлийг бууруулахад голлон чиглэдэг. Хэдийгээр манай эдийн засагт тэлэх бодлогууд хэрэгжсэн он жилүүдэд ч эдийн засгийн бүтцийн буюу эдийн засгийн нийлүүлэлтийн талд нөлөөлдөг, илүү урт хугацааны өрсөлдөх чадвар, бүтээмжийг дэмжсэн бодлогууд хаягдаж ирлээ. Тухайлбал, эрдэс бүтээгдэхүүнээ хямд өртөгтэй, байгаль экологид хор хөнөөлгүй, шуурхай экспортлох, мөн үндэсний тээвэр, ложистик, хилийн боомтын асуудлыг шийдвэрлэж чадаагүй л байна. Үндэсний аюулгүй байдлын нэг чухал хэсэг болох эрчим хүчний хэрэгцээгээ дотооддоо бүрэн

хангахгүй байна. Мөн эдийн засгийн тэргүүлэх салбаруудын өрсөлдөх чадварыг дэмжсэн, нэмүү өртөг илүү шингээх дэд бүтцийн асуудлууд (төмөр зам, эрдэс бүтээгдэхүүнийг дотооддоо нэг шат боловсруулах гэх мэт) шил шилээ даран хүлээгдэж байна. Бүр цаашлаад эдийн засгийг олон тулгууртай болгохтой холбоотой нэг ч томоохон алхам эхлүүлээгүй байна. Эдгээрийн үр дагаварт урсгал дансны алдагдал өссөөр, бид богино хугацааны асуудлуудтайгаа ноцолдсоор байна. Эдийн засгийн бүтэц, салбар хоорондын уялдаа алдагдсан асуудал нь бидэнд хоёр зүйлийг сануулж байна. Нэгдүгээрт, өнгөрсөн хугацаанд авсан их хэмжээний өрүүд хэр үр ашигтай хөрөнгө оруулалт болсон бэ. Хоёрдугаарт, нэгэнт өндөр түвшинд хүрээд байгаа өрийн дарамттай үед энэхүү дэд бүтцийн бодлогыг цаашид хэрэгжүүлэх нь зохистой эсэх? Гэвч аль аль нь үндэсний эдийн засгийн хувьд маш өндөр үр ашигтай байх тэр төсөл, хөтөлбөрт л санхүүжилт хийхээс өөр сонголт үлдээгүйг анхааруулж байна.

Бүтээмжийн доогуур байдал. Манай улсад цалин хөлс харьцангуй бага түвшинд байгааг тайлбарлах нэг гол хүчин зүйл нь бүтээмж болж байна. Өөрөөр хэлбэл, нэг ажилтанд ногдож буй орлогын өсөлт бага байгаа нь тус ажилтны цалин бага байхад хүргэж байна. Монгол Улсын бүтээмжийн дундаж түвшин 3.6 сая төгрөг байгаа бөгөөд уул уурхайн салбарт хамгийн их буюу 7.7 сая, хөдөө аж ахуйн салбарт хамгийн бага буюу 1.1 сая төгрөг байна. Хөдөлмөрийн бүтээмж хамгийн бага байгаа хөдөө аж ахуй, бөөний болон жижиглэн худалдааны салбарт нийт ажиллагчдын харгалзан 28.8 хувь болон 16.5 хувь нь ажиллаж байна. Эдгээр бүтээмж багатай салбаруудын дундаж цалин ч мөн бага байна.

Манай улсад хөдөлмөрийн хөлсний үнэлэмж бага байгаагаас ажил хөдөлмөр эрхлэх сонирхол буурах хандлагатай гарч байна. Ажил хөдөлмөр эрхэлсэн ч амьдралын наад захын хэрэгцээг хангахгүй, өрхийн орлогоос зарлага нь хэт давсан байдлын улмаас хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс ядуучуудын эгнээнд орох аюул нүүрлэж байна. 2019 онд дундаж цалин 1.1 сая төгрөг, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ сард 320.0 мянган төгрөг байна. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага цалин хөлстэй ажиллагчид нийт ажиллагчдын 8.0 хувийг эзэлж байна. Харин улсын хэмжээний дундаж цалин хөлстэй дүйцэх хэмжээ хүртэлх буюу 900.0 мянга хүртэл төгрөгийн цалинтай ажиллагчид нийт ажиллагчдын 70.1 хувийг эзэлж байна. Нийт ажиллагчдын ердөө 10.3 хувь нь 1.5 сая төгрөгөөс дээш хэмжээний цалин хөлс авч байна.

Дундаж давхаргыг өсгөх асуудал нь иргэдийн хөдөлмөр эрхлэлт, орлогыг нэмэгдүүлэх, улмаар эдийн засгийн хувьд тодорхой түвшинд хүрснээр нийгэм, улс төрийн хувьд идэвхтэй оролцоотой болгох явдал. Үүний тулд чанартай ажлын байрыг бий болгох, цалин хөлс нь тухайн иргэн ая тухтай орон байранд амьдрах, чанартай хоол хүнс хэрэглэх, шаардлагатай үйлчилгээнд хамрагдах, тодорхой түвшний хуримтлал бүрдүүлэхэд боломжийг олгох ёстой. Харьцангуй цөөн хүн амтай манай орны хувьд цалин, хөлс энэ түвшинд хүрч өсөхийн тулд нэг талаас ажиллах хүчний мэдлэг, ур чадвар өндөр түвшинд байх, нөгөө талд нь техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, хөдөлмөрийн бүтээмжийг эрс нэмэгдүүлэх шаардлагатай болно.

Дан ганц хөдөлмөрийн бүтээмжээс гадна үйлдвэрлэлд ашиглаж буй бүх түүхий эд, орцуудын бүтээмжид анхаарах шаардлагатай.

Өртэй эдийн засаг. Эдийн засаг сүүлийн 2-3 жилд сэргэж байгаа хэдий ч эмзэг байдал өндөр хэвээр байна. Тухайлбал, ОУВС-ийн тодорхойлолтоор Монгол банкны гадаад валютын албан ёсны цэвэр нөөцөөс төв банкны тэнцлийн болон тэнцлийн гадуурх өр төлбөрийг хассан дүн дөнгөж эерэг болж байна. Засгийн газрын өр ДНБ-ий 73 хувь хувьтай тэнцэж байна.

Манай улсын өрхийн сектор, хувийн сектор, улсын сектор бүгд өрийн дарамттай болоод байна. Өр, зээл нь нэг талаас ирээдүйд орлогыг барьцаалан өнөөдрийн хэрэглээ, хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх боломжийг олгож байгаа хэдий ч, хэт өндөр түвшинд хүрч, өрийн тогтвортой байдал алдагдах тохиолдолд хүнд байдалд оруулдаг. Өрхийн секторын өр сүүлийн 6 жилд эрс нэмэгдэж ДНБ-ий 40 хувьд хүрлээ. Энэ нь өрхүүдийн санхүүгийн эмзэг байдлыг нэмэгдүүлж байна. Тухайлбал, глобал эрдэс түүхий эдийн зах зээлийг даган эдийн засагт уналт бий болох тохиолдолд ажилгүйдэл нэмэгдэх, өрхийн орлого буурах замаар өрхүүд өр, зээлийн төлбөрөө цаг хугацаандаа төлж чадахгүйд хүрэх эрсдэлтэй. Энэ нь тус зээлийг олгосон санхүүгийн байгууллагуудад ч хүнд цохилт болж, эдийн засгийг бүхэлд нь уналт руу түлхэхэд хүрдэг. Иймд цаашид бодлогын түвшинд өрхийн өрийн дарамтыг нэмэгдүүлэхгүй байх, өрхийн зээлийн өсөлтийг орлогын өсөлттэй уялдуулах шаардлага тавигдаж байна.

Хувийн секторын хувьд өр, зээлийг харьцангуй санхүүгийн хувьд үр ашигтай хэлбэрээр ашиглах боломжтой хэдий ч, өрөөс үүдэлтэй санхүүгийн эмзэг байдал өндөр байна. Тухайлбал, гадаад валютын актив, өр төлбөрийн зөрүү нь сөрөг байгаа нь ханшийн сулралтаас алдагдал хүлээх, улмаар тэнцэл огцом муудаж, үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэх, зээл төлбөрөө хугацаандаа төлөхөд хүндрэлтэй болохоор байна. Үүний дээр эдийн засгийн мөчлөгийн уналтын үед борлуулалт буурах тул нэмэлт ачааллууд орж ирнэ. Банкны салбараас хувийн секторт олгосон зээлийн хувьд чанаргүй зээлийн харьцаа 20 хувь даваад байна.

Улсын секторын гадаад өрийн ДНБ-нд эзлэх хувь 2016 оны эцэст өндөр түвшинд хүрч, өрийн дефолтын асуудал яригдаж байсан бол сүүлийн 3 жилд буурсаар тогтвортой түвшинд буурч ирээд байна. Гэхдээ гадаад валютаар илэрхийлэгдэх өр давамгайлж байгаа нь ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан эргэн өсөх эрсдэл өндөр хэвээр байна. Түүнчлэн төсвийн бодлогын сахилга батыг энэ хэвээр цаашид ч үргэлжлүүлэхгүй тохиолдолд эргэн хурдан өсөх эрсдэлтэй.

Монгол Улсын нийт гадаад өр 29.7 тэрбум долларт хүрч, ДНБ-ий 220 хувьтай тэнцэж байна. Энэ нь гадаад өрийн хүүний төлбөрийн төлбөрийн тэнцэлд орж ирэх дарамтыг нэмэгдүүлж байна. Гадаадын хөрөнгө оруулагчид, зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагууд ч энэ өрийн тогтвортой байдалд анхаарлаа хандуулж байна.

Монголын зүйр үгэнд анхааруулсанчлан бид өөдлөн хөгжихийн тулд бид бүх түвшинд өрийн эмзэг байдлыг бууруулах шаардлагатай. Ялангуяа, иргэн бүр хариуцлагатай зээлдэгч байх, үүний тулд санхүүгийн боловсролтой, өөрийн эрх, үүргийг мэддэг байхад анхаарал хандуулах нь чухал байна.

Засгийн газрын хувьд өрийн стратегийг амжилттай хэрэгжүүлэх, томоохон санхүүжилт шаардсан шийдвэрүүдэд өрийн тогтвортой байдлыг давхар харгалзаж байх ёстой боллоо. 'Өртэй эдийн засаг'-ийн макро эдийн засгийн бодлого ч зарим талаар ялгаатай (ГВАН нэмэгдүүлэх, улсын секторын өр, ДНБ-ий харьцааг бууруулах, инфляцыг алгуур бууруулах, валютын ханшийг хэт чөлөөтэй явуулахгүй байх гэх мэт) байх ёстой.

Байгаль экологийн хүндрэл. Уул уурхай, мал аж ахуйн өргөжилтийг дагасан байгаль экологийн хүндрэлүүд гарч байна. Малын тоо хурдацтай өсөж, сүргийн бүтцэд ямааны эзлэх хувийн жин нэмэгдсэнээр бэлчээрийн даац хэтэрч, хөрсний доройтол бий болж байна. Хөрсний доройтол, цөлжилт нь зүүн Азийн бүс нутагт хүчтэй шороон шуурга гарахад нөлөөлж байна.

ХӨГЖИЛД ХӨТЛӨХ ЯМАР НӨӨЦ, БОЛОМЖ БИДЭНД БАЙНА ВЭ?

Хөгжилд хөтлөх арвин нөөц, боломж, чадавх Монголчууд бидэнд байна. Эдгээрээс тоймлон дурдвал:

Тусгаар тогтносон, бүрэн эрхт байдал. Дотоод эв, зөийг сахиж, нэгдсэн зөвшилцөлд хүрч хэмээн холбогдох шийдвэрүүдийг бие даан, шуурхай гаргаж, олон улсын дэмжлэгийг авч хэрэгжүүлэх боломж, чадавх байна.

Түүх, соёл, урлагийн арвин өв баялаг. Дэлхийн түүхэнд тодрон гарч, Ази-Европын хооронд урьд нь байгаагүй соёл, худалдааг шинэ түвшинд авчирч байсан өвөг дээдсийн арвин баялаг түүх бидэнд байна. Бид нүүдлийн соёл, иргэншил (байгаль, хүн, мал аж ахуйн өвөрмөц харилцан шүтэлцээ)-ийг хадгалж ирсэн үндэстэн билээ. Эдгээр нь өвөг, дээдсийн бидэнд үлдээсэн үнэлшгүй үнэт өв, бидний бахархал, үнэт зүйл юм. Энэ өвийг сэргээж, байгалийн өвөрмөц тогтоцтой хослуулж, сурталчлан таниулж чадсанаар аялал жуулчлалын өлгий нутаг боломж байна.

Байгалийн нөөц, баялаг. Манай улсад Менделеевийн үелэх системийн бараг бүх элемент бүртгэгдсэн бөгөөд энэ нь ашигт малтмалын арвин их баян улс болохыг илтгэж байна. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр өнөөгийн байдлаар 80 гаруй төрлийн ашигт малтмал бүхий 1000 гаруй орд газар, 8000 гаруй илрэл бүртгэгдээд байна. Монгол Улсын зөвхөн 17 нэр төрлийн² ашигт малтмалын нөөцийн одоогийн олж үнэлгээ 3.1 их наяд ам.доллартай тэнцүү буюу 1 хүнд 1 сая ам.долларын байгалийн баялгийн нөөц ногдож байна. Үүнээс 708 тонн алтны нөөцийн зах зээлийн үнэлгээ 29.9 тэрбум ам.доллар, 460 сая тонн төмрийн хүдрийн үнэлгээ 32.1 тэрбум ам.доллар, 1.2 тэрбум тонн коксжих нүүрсний нөөцийн үнэлгээ 296.4 тэрбум ам.доллар, 31.5 тэрбум тонн эрчим хүчний нүүрсний үнэлгээ 1.9 их наяд ам.доллар, 79.5 сая тонн зэсийн нөөцийн үнэлгээ 529.5 тэрбум ам.доллар, 101.6 сая тонн хайлуур жоншны нөөцийн үнэлгээ 39.6 тэрбум ам.доллар, 332.6 сая тонн газрын тосны нөөцийн үнэлгээ 21.8 тэрбум ам.доллар, 11.5 сая тонн

² Эдгээрт алт (үндсэн), алт (шороон), мөнгө, төмрийн хүдэр, коксжих нүүрс, эрчим хүчний нүүрс, цайр, зэс, хайлуур жонш, газрын тос, уран, фосфорит, молибден, газрын ховор элемент, цагаан тугалга, хар тугалга, гянтболд орно.

молибдений нөөцийн үнэлгээ 277.1 тэрбум ам.доллар тус тус бүрдүүлж байна(үүний 30 орчим сая тонн нь Оюу толгой ордод хамаарна)³. Өөрөөр хэлбэл, бид байгалийн баялгаа оновчтой удирдаж, эдийн засгийн эргэлтэд оруулж, 'зөв' хөрөнгө оруулалт хийж чадвал манай улсыг тогтвортой өсөлт, хөгжилд хүргэх арвин их санхүүгийн нөөц газрын хэвлийд байна.

Газар нутаг: Бэлчээрийн мал аж ахуй, газар тариалан эрхлэх боломж.

Бидэнд өвөг дээдсээс өвлөн үлдээсэн өргөн уудам газар нутаг байна. Манай улсын газрын нутгийн нийт талбайн 73.4 хувийг хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 12.5 хувийг ойн сан бүхий газар, 4.8 хувийг усан бүхий газар эзэлж байна. Өөрөөр хэлбэл, хөдөө аж ахуй түүний дотор мал аж ахуйн эдэлбэр газрын нөөц харьцангуй их байна. Монгол Улсын хэмжээнд 2018 оны байдлаар 1.2 сая га тариалангийн нийт талбай байгаагийн 58.3 хувь нь ашиглагдаж, харин 41.7 хувь атаршиж ашиглагдахгүй байна.

Хөдөө аж ахуйн салбар үүний дотор мал аж ахуй нь эдийн засаг, хөдөлмөр эрхлэлт, экспортын орлого, дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлд жинтэй байр суурь эзэлж байна. Энэ салбараас хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний 80 орчим хувийг үйлдвэрлэж, экспортын орлогын 10 орчим хувийг бүрдүүлж байна. Нийт хүн амын гуравны нэг нь зөвхөн мал аж ахуйн орлогоор амьдарч байна. Манай улсын мал, сүрэг нь эх газрын эрс тэс, экологийн нөхцөлд байгалийн урт хугацааны шалгарал, мал маллагааны олон зууныг дамжиж ирсэн ардын сонгон үржүүлгийн үр дүнд байгаль-цаг уурын хатуу ширүүн нөхцөлд дасан зохицож, биологийн онцгой шинжийг хадгалдгаар онцлог юм. Монгол үүлдрийн мал нь жилийн дөрвөн улиралд бэлчээрийн маллагаанд байж, үржин төлжиж ашиг шимээ өгдөг давуу талтай. Манай улсад 2018 оны байдлаар нийт мал сүргийн тоо толгой 66.5 сая (үүнээс адуу 3.9 сая, үхэр 4.4 сая, тэмээ 0.46 сая, хонь 30.6 сая, ямаа 27.1 сая) байна. Эдгээр нь манай улс эко хүнс үйлдвэрлэлийн томоохон нөөц боломжтойг илтгэнэ.

Оюуны өндөр чадавхтай иргэд. Монгол хүүхэд, залуучууд оюуны спорт, уралдаанд дэлхийд тэргүүлэх эгнээнд явж байна. Тухайлбал, шатар, даам, ой тогтоолтын төрлүүдээр дэлхийд тэргүүлж байна. Суурь шинжлэх ухааны олон улсын олимпиадууд ч өндөр амжилт үзүүлж, дэлхийн мэдээлэл, технологийн том компаниудад Монгол залуучууд амжилттай ажиллаж, шинэ нээлт, бүтээлүүд хийж байна. Энэ нь монголчууд бид уул уурхайд тулгуурласан эдийн засгаас оюуны мэдлэгт тулгуурласан эдийн засаг руу шилжих нөөц, боломжтойг илтгэж байна.

Гадаад, дотоод зөрчил, мөргөлдөөнгүй. Бид түүхэн хугацаанд найрсаг гадаад харилцааны бодлогыг амжилттай хэрэгжүүлж ирсэн бөгөөд дэлхийн тэргүүлэх улс орнуудтай стратегийн түншлэлийн харилцааг бэхжүүлж ирлээ. Энэ хүрээнд өндөр хөгжилтэй орнуудтай улс төр, эдийн засаг, батлан хамгаалах, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг эрчимтэй хөгжүүлж байна.

Үндэсний үнэт зүйл дээрх нэгдмэл, эв зетэй байдал нь хөгжлийн нэг чухал тулгуур юм.

Дэлхийн тэргүүлэх 2 эдийн засаг (зах зээл)-т ойр байрладаг. Манай

³ Зэс, молибдений нөөцийн 30 орчим сая тонн нь Оюу толгой ордод хамаарна.

улс дотоод зах зээлийн шингээлт багатай, далайд гарцгүй хэдий ч, дэлхийн тэргүүлэх 2 том зах зээл хаяа дэрлэн оршиж байгаа нь туйлын давуу талыг бий болгож байна. Бид олон улсын стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн, үйлчилгээг тэдний эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн хүргэх асуудал л сорилт болж байна. Бид орчин үеийн техник, технологийн дэвшилд тулгуурлан хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлсэн, эко хүнс, эрдэс бүтээгдэхүүний боловсруулалт, аялал жуулчлал зэрэг ахиу өртөг шингээсэн экспортын бүтээгдэхүүн, үйлчилгээнд голлон төвлөрөх ёстой болно. Экспортыг хөнгөвчилж, дэд бүтцийг барьж байгуулан өрсөлдөх чадварыг хангаснаар экспортыг төрөлжүүлэх боломж нээлттэй байна.

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ЮУНД ЧИГЛЭХ ЁСТОЙ ВЭ?

Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын шинжилгээ, түүнээс урган гарах стратегид тулгуурлан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого нь дараах асуудлуудыг эн тэргүүнд шийдвэрлэх нь чухал байна. Үүнд:

- Монголын уламжлалт соёл, аж төрөх ёсоо дээдэлж, үндэсний нэгдмэл үнэт зүйлс, үндэсний бахархлыг бий болгох, түүнд тулгуурлан үндэсний онцлогтой бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгон гадаад орнуудад таниулах;
- Монгол хүний аюулгүй байдлыг хангаж, хөгжүүлэх, иргэдийн ажил хөдөлмөр эрхлэх боломжийг хангах, амьдралын чанарыг дээшлүүлэх;
- Нийгмийн тэгш бус байдлыг халж, дундаж давхаргыг эрс нэмэгдүүлэх;
- Эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг бий болгох;
- Газрын хэвлийн доорх, дээрх баялгаа үндэсний, иргэн бүрийн баялагт хөрвүүлэх, баялгийн сангийн оновчтой тогтолцоо бүрдүүлэх;
- Өрсөлдөх чадвар бүхий, өндөр технологид суурилсан эдийн засгийн салбаруудыг хөгжүүлж, эдийн засгийн бүтцийг олон тулгуурт болгох;
- Орлогын дахин хуваарилалтыг сайжруулах, бизнесийн орчинг сайжруулах чиглэлд санхүүгийн салбарт шинэчлэл хийх;
- Мэдлэг, технологи болон инновацид суурилсан эдийн засаг руу шилжиж буй глобал чиг хандлагатай хөл нийлүүлэн алхах;
- Шинжлэх ухаан, инновацийг төрийн бодлого, үйлдвэрлэлд тасралтгүй нэвтрүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх;
- Ардчилал, хүний эрх, сайн засаглалыг бэхжүүлэх;
- Төв рүү тэмүүлэх, төвөөс зугтаах хүчний аль аль нь үйлчилж буй шинэ эринд геополитикийн асуудалд анхаарах;
- Даяаршил, либералчлалын эрин үед Монголын эрх ашиг, глобал эрх ашгийн “тэнцвэр”-ийг олох;
- Эдийн засгийн өрсөлдөх чадварыг бэхжүүлэх, бүс нутгийн тэгш

хөгжлийг бүрдүүлэх чиглэлд дэд бүтцийг байгуулах, бүсчилсэн хөгжлийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;

- Байгаль орчныг хамгаалж, ногоон хөгжлийг дэмжих;
- Улаанбаатар хот түүний дагуул хотыг зохистой хөгжүүлэн төвлөрлийг сааруулах.

Хөгжлийн урт хугацааны бодлогыг цаашид Үндэсний нэгдмэл үнэт зүйл, Хүний хөгжил, Амьдралын чанар ба дундаж давхарга, Эдийн засаг, Сайн засаглал, Ногоон хөгжил, Амар тайван, аюулгүй нийгэм, Бүсчилсэн хөгжил, Улаанбаатар хот ба дагуул хот гэсэн 9 чиглэлээр судлан боловсруулах шаардлагатай байна гэж үзлээ.

1. ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ

Өнөөдөр манай улсад **Үндэсний үнэт** зүйл гэдгийг ард иргэд байтугай судлаач эрдэмтэд бүрэн гүйцэд томъёолж амжаагүй, үнэт зүйлсийн судалгаа одоогоор дөнгөж эхлэлтийн байдалтай байна. Соёл урлагийн их сургууль, Удирдлагын академи, Үндэсний брэндийн зөвлөл тус тусын үнэт зүйлийн судалгааг (2018-2019) хийгээд удаагүй байна. Судалгааг олон нийтэд түгээх, сурталчлах ажлыг энэ цаг үед зохион байгуулж үндэсний үнэт зүйлсийг нэгдмэл байлгах шаардлага тулгарсаар байна.

Дэлхийн олон улсуудад өөрсдийгөө “Сор үндэстэн” (Nation-Brand) болгох ажил ид өрнөж байна. Гэтэл манайханд “Сор үндэстэн” (Nation-Brand) гэх ойлголтыг дэлгүүрийн бараа бүтээгдэхүүн гэдгээс ялган салгаж ойлгохгүй байна. Түүх, соёлын талаарх нэгдмэл үзэл бодол сарниж, олон янзын үзэл дэлгэрэх хандлага байна. Түүх соёлын мэргэжлийн биш хүмүүс өөр өөрсдийн үзэмж дур зоргоор хандаж, төрийн бус байгууллага, нийгэмлэгүүд байгуулж, бодит баримт, түүхэн үнэнээс зөрөөтэй дүгнэлт гарган, түүгээр жирийн ард олныг төөрөгдүүлэх явдал гарсаар байна. Үүнээс үүдэн үндэсний нэгдмэл байдал, соёлын дархлаа, үндэсний аюулгүй байдлын асуудал давхар хөндөгдөж байна.

Үндэсний тулгуур үнэт зүйлсийг эгнэгт өөрсдийн халдашгүй брэнд болгох, үндэсний ижилсэл, ондоошлоо бүтээх үйл хэрэг хоёр хэлбэрээр өрнөж байна.

1. Өөрийн түүх соёлын тухай эх сурвалж дахь нэг мөр, нэг үгийг ашиглан дөвийлгөж, том түүх бүтээх, заримдаа санаанаасаа зохиох
2. Өөрийн түүх, соёлын баялаг эх сурвалжаас бодит түүх, байсан үнэт зүйлээ нэхэн сэргээх, түүхэн үнэнийг тогтоох ийм хоёр зүйлийн оролдлого гарч байна. Сүүлийн жишээ нь бидэнтэй шууд холбоотой. Манай орны хувьд өөрийн гэсэн давуу болон сул тал байгааг товч авч үзвэл:

ДАВУУ ТАЛ: Монголын түүх, соёлын сурвалжууд дэлхийн олон хэлээр (араб, перс, хятад, латин, төвөд, орос) эмх цэгцтэй байж байна. Энэ талын асар их уламжлалтай тул зарим улс орон шиг санаанаасаа зохиох шаардлагагүй, түүхийн эх сурвалжийг судалж, нэхэн сэргээх ажлыг эрчимжүүлэх аваас өргөн боломж байсаар байна.

Манай оронд түүх, хэл, соёл, археологи, палеонтологийн судалгаагаар шинэ шинэ ололт нээлтүүд гарч, үндэсний үнэт зүйлийн хүрээ, агуулга, төрөл зүйл улам өргөссөөр байна. Монгол улс бол үндэстэн угсаатны хоорондын дайсагнал, хурц зөрчил, тэмцэлгүй нэг хэл, соёлтой нэг үндэстэн гэдгээрээ онцлог талтай билээ. Нөгөөтээгүүр дэлхийн бусад улс орны зүгээс Монголын түүх, соёлыг сонирхох сонирхол улам нэмэгдэж, өөрийн давтагдашгүй мөн чанараараа гайхагдах болж байна.

СУЛ ТАЛ: Үндэсний үнэт зүйлийн талаарх орчин үеийн ойлголтын түвшин доогуур, түүх, соёл, уламжлалын тухай мэдлэг өнгөцхөн, боловсролын тогтолцоонд эзлэх байр суурь сул байгаагаас, нэн ялангуяа хүүхэд залуусын дунд харийн нөлөө түрж, гадаадын соёл, шашин суртахуунд автах байдал их болж байна. Үүний улмаас түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйл, булш, хиргисүүрийг ухаж төнхөх, зарж үрэх, үнэт олдворыг гадагш гаргадаг бүлэглэлүүд идэвхжиж, хуулийн хариуцлага хүлээдэггүй байдал даамжирчээ. Энэ бүгд үндэсний ижилсэл, соёлын дархлаа, үндэсний аюулгүй байдалд ноцтой эрсдэл учруулсаар байна.

Монголчууд эртнээс эдүгээг хүртэл эх орон, газар нутаг, тусгаар тогтнол, уламжлалт амьдрах ухаан, үндэсний өв соёл, эв нэгдэл, эрдэм боловсрол, ахмад үе, ахас ихсээ хүндэлж, ажил хөдөлмөр, байгаль дэлхийгээ дээдэлж ирснээс гадна эх хэл, гэр бүл, үр хүүхэд, хүн хүнээ дээдлэх ёсыг өндөрт өргөсөөр түүхэн он цагийг туулж өнөөг хүрсэн билээ.

Сүүлийн үеийн судалгаагаар монгол үндэсний хэл бичиг, өв соёл, нүүдлийн ахуй, түүх соёлын дурсгал, урлагийн бүтээлүүд нийгмийн хөгжлийн амаргүй замыг туулж, өнөө үетэй золгох хүртэл үндсэн агуулга, шинж чанар, үнэлэмж, үнэ цэнээ хадгалан үлдэж, Монголын ард түмний амьдралд хүндтэй байр эзэлсэн хэвээр байна. Гэвч монгол аж төрөх ёс, ахуй амьдралын энгийн боловч амин чухал үнэт зүйлсийг орчин цагийн хүмүүс хадгалж, уламжлуулах байтугай үнэ цэн, ач холбогдол, утга учрыг нь мэдэхгүй, тоомсорлохгүй байгаа нь сүүлийн жилүүдэд тод анзаарагдах болов. Энэ талаар “Улс орон, өвөг дээдсийнхээ түүх, уламжлалт өв соёл, зан заншил, урлагаа үл тоох, умартах, бүр үгүйсгэх хандлага хүртэл цухалзаж, гаднын кино, урлагаар дамжсан үзэл суртал, соёл ахуйд их автаж байгаа нь илт анзаарагдах боллоо. Товчхондоо манай иргэдийн оюун санааны дархлаа сул байна гэж би үздэг” гэж засгийн газрын тэргүүн нэгэнтээ хэлсэн нь үндэсний соёл, өв уламжлалаа алдах нь үнэн хэрэгтээ үндэсний үнэт зүйлгүй болох, цаашлаад үндэсний ижилсэлгүй болж гаднын соёлд уусах аюултайг илэрхийлсэн хэрэг.

2. ХҮНИЙ ХӨГЖИЛ

Монгол Улсын хүн ам 2018 оны байдлаар⁴ 3.2 саяд хүрч, дундаж наслалт 70.2 нас болж нэмэгдсэн дүр төрх харагдаж байна. Энэ тоо баримт нь урт хугацааны бодлого боловсруулж, төлөвлөн хэрэгжүүлэхэд харгалзах чухал хүчин зүйл болж байна.

Хувь хүний амьдралын чанарыг илтгэдэг, дэмждэг, тухайн улс орны хөгжлийн түвшинг харуулдаг, тэргүүлдэг салбар бол боловсрол юм. Монгол

⁴ Үндэсний Статистикийн Хороо, 2018

Улсын боловсролын тогтолцооны өнөөдрийн нөхцөл байдлыг авч үзэх юм бол цогц суурь судалгаанд суурилагүй, улс төрийн шийдэл давамгайлсан, зохих бэлтгэлийг бүрэн хангаагүй богино хугацаанд хэрэгжүүлэхийг зорьсон шинэчлэлийн бодлого, стратеги, тэдгээрийн хэрэгжилтийн менежментийн зарим алдаа, дутагдлаас шалтгаалж хувь хүний болон нийгмийн хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байна.

Сургуулийн өмнөх боловсролын хувьд, төрөөс авч хэрэгжүүлсэн бодлого, түүнийг дэмжих төсвийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, эрхзүйн орчин зэрэг нь бусад улсуудад үлгэр болохуйц эерэг туршлага хуримтлуулсан гэж хэлж болно. Хүн амын өсөлтийг дагаад сургуулийн өмнөх боловсролын хүртээмж тасралтгүй өсөж байна. Сүүлийн 10 гаруй жилд сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын өсөлтөөс үүдэн цэцэрлэгт хүмүүжсэн хүүхдийн эзлэх хувь 9.2 пунктээр нэмэгдэж, багшийн тоо ч мөн 3.6 мянгаар нэмэгдсэн байна. Хэдийгээр эерэг тоо баримтуудын дээрх зарим жишээ нь Монголын сургуулийн өмнөх боловсролын өнөөгийн хөгжлийн хүрсэн ололт амжилтыг илтгэж байгаа хэдий ч 10 хүүхэд тутмын 2 нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж чадахгүй байгаа, хот суурин газрын сургуулийн өмнөх боловсролын байгууллагын бүлэг дүүргэлт, багшийн хүйсийн харьцаа, хамрагдаж байгаа малчдын болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, сургалтын хөтөлбөр, багшийн арга зүй, орчны чанар, хүртээмж зэрэг асуудлууд шийдлээ хүлээсээр байна.

Монгол Улсын ерөнхий боловсролын сургууль 12 жилийн тогтолцоонд бүрэн шилжээд байна. 2018-2019 оны хичээлийн жилийн байдлаар, тухайн түвшний боловсролын үндсэн үзүүлэлтийн нэг болох хамран сургалтын жинг 10 жилийн өмнөхтэй харьцуулбал бага боловсролын цэвэр жин 2.5 пунктээр, суурь боловсролын хувьд 16.0 пунктээр өссөн байна. Сүүлийн 10 жилд бүлэг дүүргэлт харьцангуй буурч байгаа хэдий ч бага ангийн 1 бүлэгт л гэхэд суралцаж байгаа хүүхдийн улсын дундаж 31 болж, 10 жилийн өмнөхөөсөө 3.7 пунктээр өссөн нь хот, суурин газрын сургуулийн хэт их ачаалал /38 сургуулийн бүлэг дүүрэгт 38.0-54.4/, ээлжийн тоо /28 сургууль 3 ээлжээр хичээллэж байгаа/, нөгөө талдаа сум, орон нутгийн сургуулийн хүүхдийн тоо цөөрч байгаа нь урт хугацааны цогц бодлого боловсруулж, хэрэгжүүлэх хэрэгцээг бий болгож байна. Сүүлийн жилүүдэд ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулга, технологи, үнэлгээний журам, сурах бичгүүд нь ойрхон өөрчлөгдөж, боловсролын салбарт хөгжлийн стратеги, залгамжтай цогц бодлого хэрэгжихгүй ирснээс сургалтын чанарт ахиц гарахгүй байна. 1990 оноос хойш ерөнхий боловсролд хэрэгжүүлж байсан сургалтын хөтөлбөр нь “багш төвтэй” мэдлэг эзэмшүүлэх багшлахуйгаас “хүүхэд бүрийн төлөөх” чадвар, хандлага төлөвшүүлэх суралцахуй руу чиглэн хөгжиж байна. Боловсролын парадигмын энэхүү өөрчлөлтийг хэрэгжүүлэх гол хүчин зүйл бол багш, түүний арга зүй, хандлагын өөрчлөлт юм.

Нийгэм, эдийн засаг, зах зээлд гарч буй өөрчлөлтөд хамгийн их мэдрэмжтэй байх салбар бол мэргэжлийн болон дээд боловсрол юм. Өнөөдөр монголчууд хүний хөгжлийн индексээрээ 188 орноос 92-рт⁵ эрэмбэлэгдэж байгаа боловч өрсөлдөх чадварын индексээрээ 138 орноос 102-т⁶ жагсаж байна. Мэргэжлийн болон дээд боловсрол, сургалтын өнөөгийн нөхцөл байдлыг авч үзвэл гаргаж буй бүтээгдэхүүн нь зах зээл, ажил олгогчийн эрэлт, хэрэгцээг бүрэн хангаж

⁵ <http://hdr.undp.org/en/countries/profiles/MNG>

⁶ http://www3.weforum.org/docs/GCR2016-2017/05FullReport/TheGlobalCompetitiveness-Report2016-2017_FINAL.pdf

чадахгүй байна. 2019 оны 2 сарын байдлаар⁷ хөдөлмөр эрхлэлтийн түвшин 54.6 хувь, ажиллах хүчний оролцооны түвшин 60.8 хувь, ажилгүйдлийн түвшин 10.1 хувь байгаа бөгөөд хөдөлмөр эрхлэлтийн эдгээр үндсэн үзүүлэлтүүдэд тодорхой эерэг үр дүн гарахгүй хэвээр байна байна. Ажил эрхлэхгүй байгаа олон шалтгааны дотор 12.9 хувь нь мэргэжилд тохирох ажил олдохгүй, 9.4 хувь нь мэргэжил дадлага, туршлага байхгүй, 3.9 хувь нь ажил олгогчийн зүгээс тавьсан шаардлагад тэнцэхгүй байгаа нь мэргэжлийн болон дээд боловсролын төгсөгч өнөөдрийн зах зээлийн хэрэгцээ, шаардлагыг хангахгүй, ирээдүй хэтийн хөгжлийн чиг хандлагатай уялдахгүй байгааг харуулж байна. Манай улсад хөдөлмөрийн хөлсний үнэлэмж бага байгаагаас ажил хөдөлмөр эрхлэх сонирхол буурч, ажил хөдөлмөр эрхэлсэн ч амьдралын наад захын хэрэгцээг хангахгүй, өрхийн орлогоос зарлага нь хэт давсан байдлын улмаас хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс ядуучуудын эгнээнд орох аюул нүүрлэж байна.

Идэвхтэй амьдралын хэв маягтай Монгол хүнийг төлөвшүүлж, эрүүл мэнд, биеийн тамир, спортын үйлчилгээг өвдсөн хойно нь авах биш, эрүүл амьдралынхаа нэг хэсэг болгох зарчимд суурилан хөгжихийг цаг хугацаа шаардаж байна. Монгол хүний “Эрүүл байдал”-ыг удаан хугацаанд хадгалах “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ”-ний суурь тавигдсан хэдий ч өндөр хөгжилтэй улс орнуудын тогтолцоотой адил төлөвшөөгүй байна. Хүн амын дунд сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд нийтлэг, урьдчилан сэргийлж, эрт үед нь илрүүлж, эмчлэх боломжтой халдварт бус өвчин зонхилж, хүн амын нас баралтын 77.0 хувь, салбарын нийт төсвийн 70 гаруй хувийг зарцуулж байна. Хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаанд, зүрх-судасны тогтолцооны өвчин (10000 хүн амд 17.45), хавдар (10000 хүн амд 13.03), гэмтэл, хордлого, нас баралтын гадны шалтгаан (10000 хүн амд 8.49), хоол боловсруулах тогтолцооны өвчин (10000 хүн амд 3.73), амьсгалын тогтолцооны өвчин (10000 хүн амд 1.95) орж байна. Улс орны нийгэм эдийн засгийн хөгжилтэй холбоотойгоор эрүүл мэнд, биеийн тамир, спортын тусламж үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт техник технологи нэвтэрч, өвчнийг эрт илрүүлэх, оношлох, үйлчилгээ үзүүлэх талаар нэлээдгүй ахиц гарч хүн амын дундаж наслалт нэмэгдэж байна. Өнөөдрийг хүртэл эрүүл мэнд, биеийн тамир, спортын салбарт салангид, салбар, байгууллага төвтэй загвар давамгайлж ирсэн. Хүн төвтэй, салбар дундын уялдаа, залгамж холбоог дэмжсэн бодлого, механизм, менежментийн орон зай нээлттэй хэвээр хадгалагдсаар байна.

Эмийн чанар, үнэ, зохисгүй хэрэглээ, эм, эм ханган нийлүүлэлтийн тогтолцоог боловсронгуй болгох хэрэгтэй байна.

Манай хүн амын дунд цус ойртолт их болж байгааг анхаарах шаардлагатай байна.

Иргэн хүн аз жаргалтай, сэтгэл хангалуун амьдрах чухал хүчин зүйл бол нийгмийн хамгаалал, баталгаа байдаг. Нийгмийн даатгалын харилцааг зохицуулсан багц хуулийг 1995 оноос мөрдөж эхэлснээс хойш нийт хүн амын 94 хувь нь эрүүл мэнд, нийгмийн даатгалд даатгуулж, даатгалын сангаас жилд дунджаар давхардсан тоогоор 6,0 гаруй сая хүнд тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлыг олгодог бүх нийтийг хамарсан нийгмийн хамгааллын томоохон салбар болж төлөвшөөд байгаа хэдий ч нийгэм, эдийн засагт бизнесийн шинэ төрлийн харилцаа, ажил, үйлчилгээ,

⁷ Үндэсний Статистикийн Хороо, 2019

тэдгээрийг гүйцэтгэхтэй холбоотой олон төрлийн гэрээ, хэлцэл, бий болж, нийгмийн даатгалын үйлчилгээ хүртэгчийн тоо өсөж, сангийн зарлага хурдацтай нэмэгдэх хандлагатай байна. Улс төрийн нөлөөтэй бодлого, хууль тогтоомжийн өөрчлөлт нь нийгмийн даатгалын санг алдагдалд оруулахад нөлөөлж байна. Мөн 2030 оноос цааших хугацаанд Монгол Улсын хүн амын насны бүтцийн өөрчлөлтөөс хамаарч, хүн амын насжих үйл явц эхэлж, ахмад настны тэтгэвэр, тэтгэмж, урт хугацааны асаргаа сувилгаатай холбоотой нийгмийн зардал нэмэгдэх хандлагатай байна.

Нийгмийн халамжийн тогтолцооны хувьд өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, хүүхэд, эхчүүдэд төрөөс тэтгэвэр, тэтгэмж олгож, тусламж, үйлчилгээг үзүүлж байна. Нийгмийн халамжийн үйлчилгээний хамрах хүрээ хэт өргөн болж жилд дунджаар 800 орчим мянган хүнийг хамруулж, 4 хүн тутмын нэгд төрөөс халамж үзүүлж байгаа нь зорилтот бүлэгт чиглээгүйг харуулж байна. Нийгмийн халамжийн хөтөлбөрүүд зорилтот бүлэгт бүрэн чиглээгүй, зорилтот бүлгийг тодорхойлохдоо өрх, иргэний амьжиргааны түвшинд биш категорин аргад илүү суурилсан байна. Нийгэмд амьжиргааны түвшинг тодорхойлж буй аргачлалыг тойрсон шүүмжлэл их, халамжид зарцуулж байгаа хөрөнгийн өсөлт нь ядуурлыг бууруулахад үзүүлэх нөлөөлөл бага байна.

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдлыг авч үзвэл, ажиллах хүчний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин, ажилгүйдлийн түвшин, ажилгүйдлийн тоо зэрэг хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүдэд тодорхой эерэг үр дүн гарахгүй хэвээр байна. Тухайлбал, 2010-2018 онд ажиллах хүчний оролцооны түвшин 61.6-61.1 хувь, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 55.5-56.3 хувь, ажилгүйдлийн түвшин 7.9-7.8⁸ хувь тус тус байгаа нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагаа хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлтэд эерэг үр дүнг бий болгохгүй байгааг харуулж байна. Өндөр боловсрол эзэмшсэн, мэргэжилтэй ажилгүй иргэдийн тоо нэмэгдсээр байгаа нь хөдөлмөрийн зах зээлд боловсролын түвшин, мэргэжлийн байдлаар эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрт харьцааг ихээхэн анхаарах шаардлагатай болсныг харуулж байна.

Аж үйлдвэрийн 4-р хувьсгал, хиймэл оюун ухааны хөгжилтэй нүүр тулах цаг хугацаа ирж байгаа нь шинэ цаг үеийн эдийн засаг, нийгмийн харилцааг бий болгож эхэллээ. Өнөөдөр Монгол Улсад шинжлэх ухаан, инновацийн хөгжилд зориулж буй буй санхүүжилтийг авч үзвэл 2020 онд 36.3 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 0.25 хувь байна. Гэтэл дэлхийн дундаж үзүүлэлт 1.7 хувь байна. Мэдээллийн технологи, шинэ материалын технологи, биотехнологи, сэргээгдэх эрчим хүч зэрэг тэргүүлэх чиглэлүүд шийдлээ хүлээж байна. Түүнчлэн эрдэмтэн судлаачдын хөдөлмөрийн үнэлгээ, үнэлэмж доогуур, судалгаа, нотолгоонд суурилсан бодлого, үйл ажиллагаа хэрэгжихгүй байгаа, дээд боловсрол, шинжлэх ухааны уялдаа холбоогүй хөгжил, мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах механизм бүрэн бүрдээгүй, инновацийн зөөлөн дэд бүтэц бий болоогүй зэрэг асуудлуудыг урт хугацааны цогц бодлогын хүрээнд шийдвэрлэх боломжтой.

Монгол Улсын аз жаргалын индекс 2016 онд 14.3⁹ байгаа ба дэлхийн 140 орноос

⁸ Үндэсний Статистикийн Хороо, 2018

⁹ ҮСХ, 2017. “Монгол Улсын аз жаргалын индексийг олон улсын түвшинтэй харьцуулсан судалгаа”

136-рт эрэмбэлэгдэж, үзүүлэлт тус бүрээр, тогтвортой сайн сайхан байдлаар 90, хүн амын дундаж наслалтаар 95, экологийн нөөцийн эргэлтээр 14 дүгээр байранд тус тус орсон нь хүн амын сайн сайхан байдал, амьдралаас авах сэтгэл ханамжийн түвшин доогуур байгааг харуулж байна. Улаанбаатар хотын агаар дахь тоосонцор (PM2.5)-ын агууламжийн жилийн дундаж ДЭМБ-ын Агаарын чанарын зөвлөмжид зааснаас даруй 20 дахин их байгаа нь 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын өвчний шалтгаант нас баралтыг 33 хувиар, насанд хүрэгчдийн уушгины архаг бөглөрөлийн шалтгаант нас баралтыг 19 хувиар, зүрхний шигдээсийн шалтгаант нас баралтыг 27 хувиар, уушгины хавдрын шалтгаант нас баралтыг 24 хувиар тус тус нэмэгдүүлсэн байна¹⁰. Нөгөөтэйгээр ҮСХ-ны 2018 оны судалгаагаар¹¹, судалгаанд хамрагдсан өрхийн нийт хүн амын 86.9 хувь ундны усны сайжруулсан эх үүсвэр ашигладаг, 88.8 хувь сайжруулсан ариун цэврийн байгууламж хэрэглэдэг өрхөд амьдардаг байна.

Хүн амын хүнсний нийт хэрэглээний 50 хувийг импортоор оруулж ирдэг улс орныг хүнсний аюулгүй байдлын хувьд эрсдэлтэй гэж үздэг. Мөн генийн өөрчлөлттэй хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг бууруулах, улмаар зогсоох нь иргэдийн эрүүл мэндэд тустай. Манай улсын хувьд хүнсний бүтээгдэхүүний 40-50 хувь, жимс жимсгэнийг 90 орчим хувийг импортоор, тэр дундаа өмнөд хөрш БНХАУ-аас оруулж ирж байна. Монгол хүний хүнсний хэрэглээнд мах, гурилан бүтээгдэхүүн зонхилж, эрдэс амин дэмийн гол эх үүсвэр болдог жимс, жимсгэнэ, нарийн ногоо бага хэвээр байна. Судалгаагаар¹², хүн амын дунд зонхилон тохиолдож буй хоол тэжээлээс хамааралтай эмгэгийн тэргүүлэх шалтгаан нь “Өрхийн хүнсний баталгаат байдал алдагдсан явдал” болохыг тогтоожээ. Мөн монгол өрх, гэр бүлийн 23 хувьд хүнсний баталгаат байдал ноцтой алдагдаж “өлсгөлөн”-гийн хэмжээнд хүрсэн бол 28 хувьд “дунд зэрэг” гэсэн үнэлэлттэй гарчээ. Үүнээс улбаалан хүн амын дундах аминдэм, эрдэс бодисын дутагдал харьцангуй их, хорт хавдрын өвчлөл илт нэмэгдсэн зэрэг нь Монгол Улс хүн ардынхаа хүнсний аюулгүй байдлыг хангах тогтолцоогоо шинэчлэх цаг болсныг харуулж байна.

3. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА

Монгол Улсын хүн ам 2018 оны байдлаар¹³ 3.2 сая, хүн амын жилийн дундаж өсөлтийн хурд 1.9 хувь, нэг эмэгтэйн амьдралынхаа туршид төрүүлж буй хүүхдийн тоо 2.9, хүн амын төрөлтөөс тооцсон дундаж наслалт 70.2 жил байна. Дэлхийн 232 орноос хүн амын тоогоороо 136, төрөлтийн түвшнээрээ 66, дундаж наслалтаараа 143-т эрэмбэлэгдэж байна¹⁴. Дундаж наслалт эрэгтэйчүүд (66.1 жил), эмэгтэйчүүд (75.8 жил)-ийн хооронд 9.7 жилийн зөрүүтэй байгаа ба эрэгтэйчүүдийн дундаж наслалт удаан нэмэгдэж байна. Нийт хүн амын 30.9 хувийг 0-14 насны хүүхэд, 3.9 хувийг 65, түүнээс дээш настан, үлдсэн 65.2 хувийг 15-64 насны хүн ам тус тус эзэлж байна.

Дэлхийн улс орнуудтай харьцуулахад, хүн амын насны бүтцийн хувьд

¹⁰ ЭМЯ 2013, “Улаанбаатар хотын агаарын бохирдол, эрүүл мэндийн нөлөөлөл”

¹¹ ҮСХ, 2019. “Монгол Улс: Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа 2018”, Нэгдсэн тайлан


¹² Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв 2017, “Хоол тэжээлийн үндэсний судалгаа”

¹³ Үндэсний Статистикийн Хороо, 2018

¹⁴ <http://worldpopulationreview.com/>

идэрших хандлага бүхий, хүн ам зүйн цонхны үе нээлттэй улс орны эгнээнд багтаж байна. ҮСХ-ноос 2015 онд хийгдсэн хэтийн тооцоогоор¹⁵, Монгол Улсын хүн амын тоо 2050 он гэхэд 5.4 саяд хүрэх бөгөөд хүн амын жилийн дундаж өсөлтийн хурд 1.8 хувь орчимд байна.

Зураг 6. Хүн амын өсөлт, өөрчлөлт, 2009-2050



Нийт хүн амын 30.4 хувийг 0-14 насныхан, 60.6 хувийг 15-64 насны хүн ам, 9.0 хувийг 65, түүнээс дээш насны настангууд эзлэхээр байгаа нь хүн ам насны бүтцийн хувьд насжих хандлагад шилжих төлөвийг илтгэж байна. Хүн амыг амьжиргааны түвшнээр харвал, 2018 оны байдлаар, нийт хүн амын 28.4 хувь ядуурлын үндэсний шугамаас доогуур ядуу зүдүү амьдарч байна. Гэхдээ ядуурлын хамралт өмнөх оныхоос 1.2 пунктээр буурчээ.

Зураг 7. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд


¹⁵ Үндэсний Статистикийн Хороо, 2017. “Хүн амын 2015-2050 оны шинэчилсэн хэтийн тооцоо”



Хүн амыг хэрэглээгээр нь эрэмбэлэн 20, 20 хувиар тэнцүү тооны 5 бүлэгт хуваавал, Монгол Улсын нийт хүн амын дийлэнх буюу 67 хувь нь нэг сард 86.0-306.0 мянган төгрөгийн хэрэглээтэй бүлэгт амьдарч байна. Хүн амын хамгийн ядуу 20 хувийнхны хэрэглээ хүн амын хамгийн чинээлэг 20 хувийнхны хэрэглээнээс даруй 5.2 дахин бага байна. Тухайлбал, 2018 оны ядуурлын шугамыг 25 хувиар нэмэгдүүлэхэд л одоо байгаа ядуучуудын (28.4 хувь, 905 мянган хүн) тоон дээр 475 мянган хүн (нийт хүн амын 14.9 хувь) нэмэгдэхээр буюу хүн амын 15 хувь ядууралд нэмж өртөх эрсдэлтэй байна.

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдлыг авч үзвэл, ажиллах хүчний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин, ажилгүйдлийн түвшин, ажилгүйдлийн тоо зэрэг хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүдэд тодорхой эерэг үр дүн гарахгүй хэвээр байна. Тухайлбал, 2010-2018 онд ажиллах хүчний оролцооны түвшин 61.6-61.1 хувь, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 55.5-56.3 хувь, ажилгүйдлийн түвшин 7.9-7.8 хувь тус тус байгаа нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагаа хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлтэд эерэг үр дүнг бий болгохгүй байгааг харуулж байна.

Зураг 8. Хөдөлмөрийн зах зээлийн зарим үзүүлэлтүүд



Монгол Улсын хувьд албан бус хөдөлмөр эрхлэлт сүүлийн жилүүдэд эрчимтэй нэмэгдэж, энэ төрлийн хөдөлмөр эрхлэлт нэлээдгүй өрхийн орлого, амьжиргааны гол эх үүсвэр болж байна. Албан бус салбарт 2018 оны байдлаар 220.7 мянган хүн хөдөлмөр эрхэлж байна.

Манай улсын эдийн засагт бичил, жижиг үйлдвэр зонхилж байна. Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийг ажиллагчдын тоогоор харвал, 86.2 хувь нь 1-9 ажиллагчтай, 6.0 хувь нь 10-19 ажиллагчтай, 4.9 хувь нь 20-49 ажиллагчтай, үлдсэн цөөхөн хувь нь 50, түүнээс дээш ажиллагчтай байна.

Монгол Улсын бизнесийн орчны судалгаа¹⁶ (21 аймаг, 9 дүүргийн 2010 аж ахуйн нэгжийг хамруулсан)-ны дүнгээс харахад, шинэ бизнес эхлүүлэхэд шаардлагатай хөрөнгө санхүүжилт дутагддаг (62-64 хувь), техникийн (тусгай зөвшөөрөл) нөхцөл авахад төрийн байгууллагын хүнд суртал их (65-67 хувь), татварын орчин тааламжгүй (58 хувь), батлан даалтаар санхүүжилт авах боломж муу (54 хувь), санхүүжилтийн орчин үеийн хэлбэр (angel investor, venture)-үүд муу хөгжсөн (48 хувь), экспорт, импорт хийх талаар мэдээллийн олдоц муу (56 хувь), гадаад зах зээлийн түншлэгч олох хэцүү (53 хувь), түүхий эд, тоног төхөөрөмжийн олдоц муу (53-54 хувь) зэрэг хүндрэлүүд бизнес эрхлэгчдийн дунд нийтлэг, түгээмэл тохиолдож байна. Мөн бизнес эрхлэх орчинг сайжруулахын тулд төр засгаас, тухайлбал, татварын дарамтыг багасгах оновчтой бодлогоор хөнгөлөлт үзүүлэх, зээлийн хүүг бууруулах, зээлийн хэмжээнд уян хатан хандах, банк санхүүгийн байгууллагын зээлийн үйлчилгээний үйл явцыг хялбаршуулах, дотоодын

¹⁶ МУИС-ийн Бизнесийн сургууль, МҮХАҮТ, 2017. "Монголын бизнесийн орчны судалгаа 2016"

хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, авлига, хээл хахууль, хүнд суртлыг арилгах, шударга өрсөлдөөн, эдийн засгийн таатай орчинг бий болгох асуудалд нэн тэргүүнд анхаарлаа хандуулахыг хүссэн байна.

Манай улсын хувьд 2018 оны байдлаар, Улаанбаатарт амьдарч байгаа нийт өрхийн 174,491 өрх нийтийн зориулалттай орон сууцанд, 3,664 өрх амины орон сууцанд, 107,878 өрх гэр хорооллын байшинд, 101,136 өрх монгол гэрт амьдарч, 284 өрх өөрийн орон гэргүй байна. Орон нутагт 194 мянга гаруй өрх амьдарч байгаагаас 58.8 мянган өрх нийтийн болон амины орон сууцанд, 135 мянга гаруй өрх монгол гэр, гэр хорооллын байшинд амьдарч байна.

Улаанбаатар хотын гэр хорооллыг төвийн, дундын, захын гэр хороолол гэж ангилан үзвэл, дунд болон захын гэр хороолол маш том талбайг эзэлж байна. Эдгээр нь дулааны болон ариутгах татуурга зэрэг инженерийн шугам сүлжээ, хог хаягдал зайлуулах систем байхгүй хэсэгт байрлаж байна. Гэр хорооллын ихэнх өрх төвийн бүсийн нэгдсэн сүлжээнээс эрчим хүчээ авч байгаа ч бусад нийтийн аж ахуй, үндсэн дэд бүтэц хангалтгүй байна. Ялангуяа, ариутгах татуургын сүлжээнд холбогдсон өрх маш бага байна. Гэр хорооллын дэд бүтцийн хөгжил хангалтгүй байгаагаар холбогдуулан шийдвэрлэх олон асуудал тулгарч байна. Үүнээс хамгийн ноцтой нь бохир ус зайлуулах систем хангалтгүй байгаагаас болж хөрсний элэгдэл, газрын доорх усны бохирдлыг нөхөн сэргээх боломжгүй болж байгаль орчинд ихээхэн хохирол учруулж байна. Одоогоор, төрөөс гэр хорооллын иргэдэд байгаль орчинд ээлтэй төхөөрөмж, байгууламж ашигласны урамшуулал, хөнгөлөлт олгодоггүй.

БХБЯ-ны судалгаагаар¹⁷, ирэх таван жилд нийслэлийн 216 мянга гаруй өрх, орон нутгийн 121.9 мянган өрх орон сууц худалдан авах хүсэлтээ илэрхийлсэн бөгөөд нийслэлд 16.3 хувь буюу 35,497 өрх, аймгуудад 9.6 хувь буюу 11,738 өрх худалдан авах чадвараар баталгаажсан судалгаа гарчээ. Гэр хороололд амьдардаг нийслэлийн 73,336 өрх, орон нутгийн 37,266 өрх байшингаа инженерийн хангамжид холбуулах, нийслэлд 44,747 өрх, орон нутагт 32,048 өрх орон сууц түрээслэн амьдрах хэрэгцээтэй байна.

Монгол Улсын аз жаргалын индекс 2016 онд 14.3¹⁸ байгаа ба дэлхийн 140 орноос 136-рт эрэмбэлэгдэж, үзүүлэлт тус бүрээр, тогтвортой сайн сайхан байдлаар 90, хүн амын дундаж наслалтаар 95-р байранд тус тус орсон нь хүн амын сайн сайхан байдал, амьдралаас авах сэтгэл ханамжийн түвшин доогуур, амьдралын чанар сайнгүйг харуулж байна.

Дундаж давхаргыг тодорхойлсон нийтлэг тодорхойлолт, судалгааны арга зүй аргачлал дэлхий нийтэд байдаггүй, улс орон бүр өөр өөрийн хөгжлийн онцлогт тохируулан арга зүйгээ боловсруулан хэрэглэсээр иржээ. Эдийн засагчид дундаж давхаргыг тодорхойлохдоо орлогын үзүүлэлтийг голлодог бол нийгмийн салбарын бусад судлаачдын хувьд өргөн хүрээний асуудлыг, тухайлбал, орлогоос гадна тэдний хөрөнгө чинээ, амьдралын сэтгэл ханамж, санхүүгийн болон тэтгэврийн үеийн аюулгүй, эрсдэлгүй байдал, боловсрол, эрүүл мэнд зэрэг асуудлыг бүгдийг хамруулдаг байна.


Монгол Улсын хувьд өнөөдрийн байдлаар дундаж давхаргыг тодорхойлсон арга зүй, аргачлал алга байна. Дундаж давхаргын талаар судалгаа хийсэн

¹⁷ БХБЯ, 2018

¹⁸ ҮСХ, 2017. "Монгол Улсын аз жаргалын индексийг олон улсын түвшинтэй харьцуулсан судалгаа"

судлаачид ялгаатай аргачлалыг ашиглан судалгаа хийн дундаж давхаргыг тодорхойлохыг оролджээ. Зарим судлаачид¹⁹, зөвхөн орлогын үзүүлэлт ашиглан дундаж давхаргыг тодорхойлон, уг орлогын үзүүлэлтэд харьяалагдах өрх, хүн амын шинж байдлыг тодорхойлсон бол зарим судлаачид²⁰ орлого, зарлагын бус олон хэмжээст үзүүлэлтээр дундаж давхаргыг тодорхойлон судалсан байна.

Зураг 9. Дундаж давхаргын нийт хүн амд эзлэх хувь, 2002-2017



Өрхийн нийгэм эдийн засгийн түүвэр судалгааны мэдээлэлд тулгуурлан тооцсон²¹ Монголын дундаж давхаргын эзлэх хувь хэмжээг харвал, нийт хүн амын 59-60 орчим хувь (медиан орлогын 67-200 хувь тодорхойлолтоор) дундаж давхаргад хамаарч байгаа ба сүүлийн 3 жилд үл ялиг буурсан ч 2008 оноос хойш дундаж давхарга хүчтэй тэлсэн байдал ажиглагдаж байна.

Гэхдээ зарим судлаачид Монгол Улсын хүн амын дундаж давхаргын тэлэхээс илүүтэй ядуучуудын эгнээ руу орох байдал ажиглагдаж байгаа гэжээ. Тухайлбал, 2014 оноос хойших инфляцын түвшний өсөлт (17 хувь), хүнсний барааны үнийн өсөлт (28 хувь) нь чинээлэг давхаргад ямар нэгэн нөлөө үзүүлээгүй бол дундаж давхаргын иргэдэд 20-30 хувийн дарамтыг бий болгосон байна²². Түүнчлэн 2014 оны байдлаар²³, Улаанбаатар бүсэд

¹⁹ З.Манлайбаатар нар, 2019. "Монголын дундаж давхаргын судалгаа", Ц.Амартүвшин нар, 2014. "Дунд орлоготой орны дундаж орлоготой хүн амын бүлгийн шинжилгээ: Монгол Улсын жишээ"

²⁰ Удирдлагын академи, 2017. "Нийгмийн дунд давхрааны төлөв байдал: Улаанбаатар хотын өрхийн судалгаа"

²¹ З.Манлайбаатар, Б.Түвшинтөгс, 2019. "Монголын дундаж давхаргын судалгаа"

²² Удирдлагын академи, 2017. "Нийгмийн дунд давхрааны төлөв байдал: Улаанбаатар хотын өрхийн судалгаа"

²³ ҮСХ, 2017. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2017 оны 4-р сар

16.4 хувь байсан ядуурлын түвшин ердөө хоёр жилийн хугацаанд 24.8 пункт болж, даруй 8.4 пунктээр өссөн нь дундаас доод давхаргад шилжин орсон хүн амын хувь мөн хэмжээгээр нэмэгдсэнийг илэрхийлж байж ч болох талтай.

Ийнхүү зөвхөн орлогын үзүүлэлтээр дундаж давхаргыг тодорхойлох нь хэтэрхий өрөөсгөл тул орлогын үзүүлэлтээс гадна хүн ам зүй, нийгэм-соёл, эдийн засгийн зэрэг олон талт хэмжээсээр хэмжих нь зүйд нийцэх тул Монгол Улсын хувьд цаашид дараах байдлаар дундаж давхаргыг тодорхойлон ашиглахыг санал болгон, улмаар энэхүү бодлогын баримт бичигт энэ тодорхойлолтыг хангасан хүн амыг “дундаж давхарга”-д хамааруулан авч үзэх болно. Үүнд:

“Орлогын голчийн 67-200 хувьтай тэнцэх хэмжээний орлоготой, байнгын хөдөлмөр эрхэлдэг, орон сууцанд амьдардаг, жилд ядаж нэг удаа эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамрагдаж чаддаг, жилд ядаж нэг удаа гэр бүлээрээ өөрсдийн хүссэн улс орон руу аяллаар явах боломжтой, хадгаламж хуримтлалтай (хүүхдийнхээ ирээдүйд зориулсан эсвэл өрхийн санхүүгийн эрсдэлт байдлыг даван туулах хэмжээний), нийгмийн идэвх оролцоо сайтай хүн амыг **“Дундаж давхарга”**-ын гэж үзнэ”.

Дундаж давхарга бол аливаа улс орны хөгжлийн гол тулгуур. Дэлхийн улс орнуудын туршлагаас харахад, дундаж давхаргаа дэмжсэн, ялангуяа, өрх, гэр бүлийн хөгжих боломж, зохистой хөдөлмөр эрхлэлт, татвар, зээлийн уян хатан бодлого, орон сууцаар хангах, өөрийгөө тэтгэн амьдрах боломж бололцоо олгох, эрүүл мэнд, боловсролын зардлыг хуваалцах, тэтгэврийн үеийн хамгаалал, амьжиргаа болон санхүүгийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн тусгайлсан бодлогуудыг авч хэрэгжүүлж байна.

Харамсалтай нь, манай улсын хувьд дундаж давхаргад чиглэсэн тусгайлсан бодлого байхгүй, нийт хүн амын ядуурал, ажилгүйдлийг бууруулахад чиглэсэн бодлогын арга хэмжээг олон жил хэрэгжүүлсэн ч хүн амын ядуурал, ажилгүйдлийн түвшинд дорвитой өөрчлөлт орохгүй, хүн амын тэгш бус байдал улам бүр нэмэгдэх хандлагатай байна. Сүүлийн 10 жилийн хугацаанд орон сууцны зах зээл ихээхэн хөгжиж, шинээр ашиглалтад орсон орон сууцны тоо хэмжээ нэмэгдсэн ч худалдан авагчдын дунд анх удаа орон сууц худалдан авагчдын хувь хэмжээ маш бага, орон сууцаар хангагдах ёстой өрх, гэр бүлүүд төлбөрийн чадвар муутайгаас тэр бүр худалдан авч чадахгүй байна. Мөн залуучуудын дунд аж ахуй эрхлэлтийн хандлага сул, энэ талын мэдлэг ур чадвар муугаас өөрийгөө тэтгэн амьдрах боломжгүй, ажилгүйдэлд өртөх байдал өндөр байна. Түүнчлэн, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ хэт өндөр өртөгтэй, өрх гэр бүлүүд эрүүл мэндийн эрсдэлт байдал ороход л ядуучуудын эгнээ рүү шилжих магадлал нэмэгдэж байна.

Ийм учраас дундаж давхаргын эгнээг тэлэх, ялангуяа, дундаж давхаргынхны бүх талын эрсдэлийг бууруулж, хамгаалахад чиглэсэн тусгайлсан бодлогыг нэн тэргүүнд боловсруулан хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага байна. Тухайлбал, зохистой хөдөлмөр эрхлэлтийг бий болгож, цалин хөлсний түвшинг нэмэгдүүлэх, гарааны бизнес болон бичил, жижиг, дунд бизнесийг дэмжиж, хүн амын өөрийгөө тэтгэн амьдрах боломжоор хангах, орон сууцны хангамжийг сайжруулах, татварын хэмжээ, зээлийн

хүүг бууруулах, хуримтлал, амьдралын баталгаат аюулгүй байдлыг хангах, хүүхэд, залуучуудын боловсролд оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэх зэрэг бодлогын арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

4. ЭДИЙН ЗАСАГ

Монголын ард түмний чинээлэг аж амьдралын чанарын ахиц, хүний хөгжилд хүрэх арга хэрэгсэл, урьдчилсан нөхцөл нь эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлт тул дараагийн 30 жилд Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн өмнө тавигдаж буй хөгжлийн бодлого, зорилго, зорилтуудыг гадна талдаа дэлхий ертөнцөд гарч буй эдийн засаг, улс төр, нийгэм, хүмүүнлэг, соёл, хүн ам зүйн болон шинжлэх ухаан, технологийн орчин нөхцөлд гарч болох өөрчлөлтүүдтэй, дотоод талдаа улс орны өмнө тулгараад буй, цаашид тулгарч болох асуудлуудыг өөрийн орны онцлог нөхцөл байдалд нийцүүлэн тодорхойлов.

Нөхцөл байдлын оношилгоог асуудал - шалтгаан- шийдвэрлэх арга зам – бодлогын зорилт гэсэн урт хугацааны төлөвлөлтийн нийтлэг аргачлалаар гүйцэтгэж хөгжлийн төлөвлөлтийн гол үзүүлэлтүүдийг төсөөлөх зорилгоор эдийн засгийн голлох нөөц, бүтэц, удирдлагын чадавхын түвшний судалгааны үр дүнд дунд хугацааны ерөнхий тэнцлийн динамик загвар (CGE) болон урт хугацааны оновчлолын динамик загварыг төлөвлөгөөт үе шатуудад хүрэх үр дүнг төсөөлөх гол арга зүйн хэрэгсэл болгон ашигласан. Загварчлалд тулгуурласан тооцоо 2019-2050 онуудаар Монгол орны онцлогт тохирсон, салбаруудын хөдөлмөр багтаамж, капитал багтаамж, нөөцийн хангамжийн үзүүлэлтүүдийг ашиглан тооцсон болно.

Гадаад орчны оношилгоо. Эдүгээ хүн төрөлхтөн шинжлэх ухаан технологийн хурдацтай хөгжил, хүний буруутай үйл ажиллагаанаас хамааралтай байгаль цаг уурын дулаарал, зохисгүй хэрэглээнээс үүдэлтэй нөөцийн хомстол, улам бүр харилцан хамааралтай болж буй эдийн засаг, нийгмийн тогтолцоо, даяаршлын эрин үед амьдарч байна.

Даяаршлын үйл явцыг дагалдан улс хоорондын худалдаан дахь тарифын болон тарифын бус хориг саадууд багасахын хэрээр өрсөлдөөн нэмэгдэж, үйлдвэрлэл зардал багатай бүс нутгууд руу шилжих хандлага олон улсын хэмжээнд бий болж, дэлхий дахинаа улс орнуудын эдийн засаг, бизнесийн бүтэц тогтолцоо, хөдөлмөрийн зах зээлд томоохон өөрчлөлтүүдийг бий болгов. Хөрш орнуудын эдийн засгийн түргэн хурдацтай өсөлт, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны өргөжилт, дундаж давхаргаа тэлэхэд чиглэсэн бодлого нь Монгол улсын уул уурхай, эрчим хүч, дэд бүтэц, МАА, түүнийг дагасан боловсруулах үйлдвэрлэлийн салбарт хөгжлийн эерэг шинэ шинэ боломжуудыг нээхийн хамт эдгээр улсуудын үйлдвэрлэлийн өндөр потенциал, бүтээмж, өрсөлдөх чадвар нь манай орны үндэсний үйлдвэрлэлийн хөгжилтөд сөргөөр нөлөөлөх талтай байна.

Хөгжингүй орнууд аж үйлдвэрийн шинэ хувьсгалыг дагалдан үйлдвэрлэлд их өгөгдөл, мэдээллийн технологи, хиймэл оюун ухаанд суурилсан автоматжуулалт, робот техникийн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах

хандлага хүчтэй явагдаж эхэллээ. Энэ үйл явц үйлдвэрлэлийн ба логистикийн зардал буурах, шинэ бүтээгдэхүүн зах зээлд асар түргэн гарах, хэрэглэгчид өөрт шаардлагатай бүтээгдэхүүнээ өөрөө зохион бүтээх боломж бүрдүүлэх, байгалийн нөөц болон эрчим хүчний хэрэглээ илүү үр ашигтай болгох зэрэг нөөц баялгийг хадгалж хамгаалах эерэг хандлагуудыг бий болгож байгаа боловч хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчний эрэлт, цалин хөлсийг бууруулах, зарим төрлийн ажил мэргэжлийг устгаж үгүй болгох, шинэ шинэ мэргэжил үүсэх, боловсролын зах зээл дэх ажил мэргэжлийн эрэлтийг өөрчлөх, хүн ам болон салбаруудын орлогын тэгш бус хуваарилалтыг улам бүр гүнзгийрүүлэх, хүмүүсийн техник технологийн дэвшилд хандах хандлагад сөргөөр нөлөөлөх магадлалтай юм.

Хөгжиж буй орнууд дахь төрөлтийн өндөр түвшний нөлөөгөөр ойрын 30 жилд дэлхийн хүн амын тоо 7.5 тэрбумаас 9.7 тэрбум хүртэл өснө гэсэн урьдчилсан тооцоог IPSOS судалгааны байгууллагаас гаргажээ. Нэг талд, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр тариалангийн талбай, малын бэлчээрийн хэмжээ жилээс жилд хумигдах, ургамлын гарц буурах, нөгөө талд хүн амын тоо өсөх гэсэн эсрэг тэсрэг хандлагууд нэгэн зэрэг явагдаж байгаагаас дэлхийн хэмжээнд хоол хүнс, хувцас хунарын хүрэлцээ улам бүр муудах төлөвтэй байна. Үүнийг дагалдан манай улсын мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний гадаад зах зээлийн эрэлт нэмэгдэж, эдгээр салбарын хөгжилд томоохон түлхэц өгөх магадлалтай.

Байгалийн баялгийг илүү үр өгөөжтэй ашиглах замаар эдийн засаг, нийгэм, байгаль орчны тогтвортой хөгжлийг урт хугацаанд хадгалах зорилготой “ногоон эдийн засаг”-ийн концепц дэлхийн үйлдвэрлэл, хэрэглээний хөгжлийн ирээдүйн хандлагыг тодорхойлох боллоо.

АНУ, БНХАУ-ын хооронд үүссэн улс төр, эдийн засгийн харилцааны хямрал, зарим бүс нутгууд дахь хямрал, эдийн засгийн зогсонги байдал зэрэг нь дэлхийн үйлдвэрлэл хэрэглээ, улс орнуудын хоорондох худалдаа эдийн засгийн харилцаанд тодорхойгүй байдлуудыг үүсгэж, түүхий эдийн үйлдвэрлэл, худалдаа, үнийг тогтворгүй байдалд оруулав. Нөгөө талаас, тус улсын эдийн засаг эрчимтэй хөгжлийнхөө замд орсон сүүлийн 30 гаруй жилийн туршид барилга, зам гүүр барих ажил эрчимтэй өрнөж, хүн амын дийлэнх хэсэг нь оршин суудаг бүс нутгууддаа шаардлагатай орон сууц, дэд бүтцийнхээ дийлэнх хэсгийг барьж байгуулсан тул барилгын материал, хар төмөрлөг, эрчим хүчний хэрэглээ алгуур буурах хандлага үүсэж болзошгүй бөгөөд тус улсад цаашид өрнөх бүтээн байгуулалтын гол хэсэг нь хөгжлийн хувьд хоцрогдонгүй, хүн амын нягтаршил харьцангуй багатай төв, баруун бүсүүдэд өрнөх магадлалтай.



Эх сурвалж: <https://asiareport.com/>

Хоёр их гүрний дунд орших байршил нь манай орны хувьд улс төр, эдийн засаг, нийгмийн харьцангуй тогтвортой гадаад орчныг бүрдүүлж байдаг боловч хөрш орнуудаас хамаарах хэт хамаарлыг үүсгэж, далайд гарцгүйн улмаас эдгээр орны нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээврийн өртөг зардал өндөр байгаагаас манай орон гадаад тээвэрлэлтийн зардал хамгийн өндөртэй орнуудын тоонд орох болсон. Тээврийн хамгийн өндөр зардалтай улс орон бүтээгдэхүүнийг хамгийн бага зардлаар үйлдвэрлэх үйлдвэрлэлийн стратегийг барихаас гадна тээврийн зардлаа бууруулах үндсэн арга замуудыг хэрэгжүүлэх бодлого, чадавхтай байх ёстой.

Дотоод орчны оношилгоо. Дэлхийн далай тэнгис, зам харилцааны гол сүлжээнээс алслагдсан байршилтай, өргөн уудам нутаг дэвсгэр, сийрэг тархан суурьшсан хүн ам, байгаль цаг уурын эрс тэс уур амьсгал бүхий, хоёр их гүрний дунд орших геополитикийн орон зай бүхий өөрийн орны хөгжлийн дахин давагдашгүй өвөрмөц нөхцөл байдал, орлого багатай цөөн хүн бүхий жижиг зах зээлүүд, бие биенээсээ алслагдсан үйлдвэрлэгч ба хэрэглэгч, өндөр өртөг бүхий үр ашиг багатай нүсэр дэд бүтэц зэрэг нь манай орны урт хугацааны хөгжилд нөлөөлөх бодитой оршиж байгаа дотоод суурь хүчин зүйлс, нөхцөл болно.

Сүүлийн 30 жилд Монгол улс ардчилсан нийгэм, зах зээлийн тогтолцоонд шилжих түүхэн шилжилтийг амжилттай хийж, хөгжлийн амаргүй сорилтуудыг амжилттай даван туулж, эдүгээ хүний хөгжил харьцангуй өндөр түвшин бүхий, дэлхийн дунджаас доогуур орлоготой орон болон хөгжиж байна. Гэхдээ Монгол улс эдийн засгийн өрсөлдөх чадварын индексээр дэлхийн 140 орноос 99-р, бизнесийн орчны индексээр дэлхийн 190 орноос 74-р, хүний хөгжлийн үзүүлэлтээр дэлхийн 177 орноос 92-р байрыг эзэлдэг нь хөгжлийн олон үзүүлэлтээр бүс нутгийн улс орнууд, дэлхийн дунджаас доогуур байдалтай байна.

Өнгөрсөн жилүүдэд хууль эрхзүйн тогтолцоондоо засаглалын тэнцвэртэй байдлыг тогтоож чадаагүй, бүс нутгийн засаглалын чадавх сул буйн улмаас засгийн газрууд ойр ойрхон өөрчлөгдөж, засаглалын институц тогтвортой хөгжиж чадаагүйн зэрэгцээ боловсон хүчний бодлого алдагдаж, мерит тогтолцоо бүрдэж чадаагүйгээс бодлого тогтворгүй, төр засгийн аль ч түвшинд боловсон хүчний чадавх сул доогуур түвшинд байна. Авлига,

албан тушаалын гэмт хэргүүд буурахгүй байгаагаас засаг төрдөө итгэх иргэдийн итгэл алдарч, нийгмийн болон эдийн засгийн идэвх муу, оролцооны түвшин доогуур хэмжээнд байна.

Бодлого тогтворгүй, оновчгүй байсны зэрэгцээ популист амлалтууд хэрээс хэтэрч, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа зорилго чиглэл муутай, зорилтот бүлэг рүү чиглээгүй, зардал өндөр, үр өгөөж муутай байдлаар хэрэгжиж иржээ. Ийм байдлын улмаас нийгмийн үйлчилгээ, халамж, хамгааллын бодлого төсвийн алдагдлыг өсгөж, гадаад өр зээл нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг сааруулах хэмжээнд нөлөөлөл үзүүлэх хэмжээнд очсон байна.

Эдүгээ Монгол Улсын ДНБ-ий үйлдвэрлэлийн 1/3, нийт ажиллах хүчний 2/5, нийт экспортын 90 гаруй хувь нь байгалийн эрдэс, түүхий эд олборлох уул уурхайн салбарт ногдож байна. Ийнхүү улсын эдийн засаг цөөн салбараас хэт хамааралтай, өрсөлдөх чадвар сул, боловсруулах аж үйлдвэр хөгжлийн хувьд хоцрогдмол, нэмэгдсэн өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэггүйгээс улс орны эдийн засаг гадаад зах зээлээс хараат, эмзэг тогтворгүй байгаа.

Гадаад зах зээлийн нөхцөл байдал, байгаль цаг уураас хэт хамааралтай эдгээр салбаруудын хэт тэлэлт нь эдийн засаг, төсвийн тогтворгүй байдлын үндсэн шалтгаан нь болж байна. Төсөв тэлэх үед зардлуудаа нэмж, үр ашиг муутай хөрөнгө оруулалтуудыг эхлүүлдэг, төсөв танасан үед нэгэнт өссөн зардал, хөрөнгө оруулалтаа зээлээр санхүүжүүлэх байдлаар явж ирсний улмаас Монгол Улс олон улсын хэмжээнд хамгийн өндөр өр зээл ихтэй, эдийн засаг нь өндөр эрсдэлтэй орнуудын тоонд орох болсон. Гадаад өр өндөр түвшинд хүрсэн тул зээлжих зэрэглэл доогуур, эрсдэлтэй нөхцөл байдалд байгаа тул гадаадын хөрөнгө оруулалт бага, гадаад зээл өндөр хүүтэй байна.

Хэдийгээр олборлох үйлдвэрлэлийн салбар төсвийн болон экспортын орлогын өсөлтөд чухал нөлөөтэй боловч хөдөлмөр зарцуулалт багатай энэ салбарын өсөлтийг дагалдан ажлын байр хомстох, орлогын зааг ялгаа гүнзгийрэх, тэгш бус байдал нэмэгдэх зэрэг олон асуудал үүссэн байна. Олборлох үйлдвэрлэлийн салбарт бий болсон өсөлтийг хөдөлмөр зарцуулалт ихтэй салбар, ядуурал ихтэй бүс нутгууд руу чиглүүлэх бодлого байхгүй нөхцөлд ажилгүйдэл, ядуурал, тэгш бус байдал зэрэг нийгмийн шинжтэй асуудлуудыг шийдэх өөр гарц шийдлийг олоход бэрхтэй юм.

Эрдэс, түүхий эдийн экспортод тулгуурласан эдийн засгийн нэмэгдсэн өртөг бүтээх чадварыг дээшлүүлэхгүйгээр бүтээмжийг нэмэгдүүлэх боломжгүй юм. Аж үйлдвэржилт түүхий эдийг эрэлттэй, хүмүүсийг зохистой хөдөлмөр эрхлэлттэй болгох замаар эдийн засагт байгаа нөөцүүдийг хөдөлгөөнд оруулах үндсэн арга төдийгүй техник технологийн дэвшлийг нэвтрүүлэх, ажиллагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх замаар эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, тээврийн зардлыг бууруулах, гадаад зах зээлээ тэлэх, эдийн засгаа төрөлжүүлэх, гадаад худалдааны балансыг сайжруулан, мөнгө санхүүгийн эрсдэлтэй эмзэг байдлаас сэргийлэх үндсэн арга зам болно.



Эх сурвалж: Ройтерс агентлаг

Монгол Улс зах зээлд шилжсэн эхний жилүүдэд аж үйлдвэрийнхээ түүхий эдийг хангаж байсан ХАА-н нэгдэл, САА-уудыг тарааж хувьчлан, аж үйлдвэр хөдөө аж ахуйн салбарыг холбож байсан бэлтгэн нийлүүлэлт, тээвэр логистикийн дэд бүтцээ нураасны улмаас олон салбарууд уналтад орж Монголчуудын дийлэнх хэсэг нь бүтээмж багатай ХАА, худалдаа, үйлчилгээний салбарт ажиллаж байгаагаас хөдөлмөр эрхэлж буй хүмүүс орлого багатай, ядуу зүдүү аж төрөхийн зэрэгцээ гадагш дотогш чиглэсэн шилжилт хөдөлгөөн, хүн амын хэт төвлөрөл үүсэх нөхцөл бүрдсэн.

Эдгээр асуудлыг зохицуулахын тулд тодорхой бүс нутгийн хэмжээнд томоохон хот суурин газруудыг бодлогоор үүсгэн хөгжүүлэх, орон нутагт хөрөнгө оруулах, үйлдвэрлэл хөгжих үндсэн нөхцөлийг бүрдүүлэх, үүний тулд хөрөнгө оруулалтыг тодорхой бүс нутагт төвлөрүүлэх, орон нутгийн үйлдвэрлэлийг татаас, татварын бодлогоор дэмжих зэргээр жижиг зах зээлүүдээ бодлогоор томруулж, хөрөнгө оруулагч ашиг олж чадахуйц хэмжээний зах зээлүүдийг орон нутагт бий болгох нь онцгой чухал ач холбогдолтой. Орон нутгийн нөхцөлд зохицсон жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, төв орон нутгийг холбосон дэд бүтцийг барьж байгуулах, зөв зохион байгуулалттай нийлүүлэлтийн сүлжээг бүрдүүлэх нь хөдөөгийн эдийн засгийг хөгжүүлж, бүс нутгуудын хөгжлийн ялгааг бууруулахад төдийгүй хүн амын тогтвор суурьшил, хөдөлмөр эрхлэлт, ядуурал, тэгш бус байдлыг бууруулах, “үнийн хайч”-ийг багасгах зэрэг олон талын ач холбогдолтой.

Монгол орон байгалийн унаган төрхөө харьцангуй хэвээр хадгалж үлдсэн дэлхийн цөөн орны нэг боловч хотжилт, уул уурхайн өргөжилт, мал сүргийн хэт өсөлт зэрэг хүний үйл ажиллагаа болон байгаль, цаг агаарын хувьсал өөрчлөлтөөс шалтгаалан байгаль орчин доройтон бохирдох, байгалийн нөөц баялаг хомстох, улмаар экосистемийн тэнцвэр алдагдах

байдал ажиглагдах боллоо. Уур амьсгалын өөрчлөлт манай оронд дэлхийн дунджаас хэд дахин хүчтэй явагдаж байгаль, цаг агаараас ихээхэн хараат байдаг эдийн засгийн салбаруудад үзүүлэх эрсдэл, дарамт улам бүр нэмэгдэж, гол, булаг, шандны ус багасаж хатаж ширгэх, мөнх цэвдэг, мөстөл хайлах, хөрс бэлчээр доройтон цөлжих, ой мод түймэр болон хортон шавжид өртөх, байгаль цаг агаарын аюулт үзэгдлийн давтамж, эрчим, хамрах хүрээ тэлэх болов.

Байгаль цаг уурын эрс тэс нөхцөл байдал нь зарим төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг явуулах боломж нөхцөлийг боогдуулж, халаалт дулаан, түлш гэх мэт нэмэлт зардлуудыг өсгөж байдгаас гадна эдийн засгийн олон салбарын үйлдвэрлэлийг улирлын чанартай явуулах зайлшгүй шаардлагыг бий болгодог нь улс орны эдийн засаг, хүмүүсийн амьжиргааг тогтворгүй төлөв байдалд оруулж, эдгээр салбар эдийн засагт нь давамгайлсан бүс нутагт ажилгүйдэл, ядуурал өндөр хэмжээнд байх эрсдэл үүсдэг.

Манай орон хязгаарлагдмал усны нөөцтэй орны тоонд ордог боловч ашигт малтмалын олборлолт эрчимжсэн, ус хангамжийн эх үүсвэр дээрээ газрын зөвшөөрөл олгож, суурьшлын бүсүүдийг бий болгосон, хотжилт зэргээс шалтгаалан өсөн нэмэгдэж буй усны хэрэгцээгээ хангах, баталгаат цэвэр ундны ус хэрэглэх боломжууд муудаж, усан хангамжийн эх үүсвэрийн аюулгүй байдал алдагдаж байна. Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийн сөрөг нөлөөллүүдтэй зэрэгцэн хог хаягдал, уул уурхайн хаягдал, малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн хаягдал, агаарын бохирдол зэргээс үүдэлтэй хөрсний бохирдол үүсэж, хог хаягдлын менежмент ихээхэн хоцрогдож байна.

Энэ бүхнээс үндэслэн дүгнэхэд, эдүгээг хүртэл хуримтлагдсан олон асуудал бидний хийсэн сонголтын дүнд үүссэн болохыг хүлээн зөвшөөрч, цаашдын бодлогын сонголтуудаа илүү ухаалаг, илүү алсыг харсан байдлаар хийх нь чухал байна. Эдүгээ манай орон эдийн засгийн бодлогын хүрээнд ойрын жилүүдэд нэг талдаа өсөн нэмэгдэж буй гадаад өрийг бууруулах, нөгөө талд эдийн засгийн өсөлтийг хангаж хуримтлал үүсгэн, ядуурлыг бууруулах, улмаар эдийн засгийн тогтвортой хөгжлийн үндэс суурийг тавих гэсэн амаргүй зорилтуудыг хамтатган хэрэгжүүлэх шаардлагатай байгаа юм.

5. ЗАСАГЛАЛ

Монгол Улс 1992 оны Үндсэн хуулиар төрийн байгууламж, засаглалын хэлбэр, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын тогтолцоо, төрийн удирдлагын зарчмуудыг улс төрийн олон ургалч үзэл, ардчилсан дэглэмийн үнэт зүйл, шалгуурт нийцүүлэн шинээр тодорхойлсон. Ийнхүү Үндсэн хуульд нийцүүлэн улс төрийн шинэ тогтолцооны суурийг бэхжүүлэх УИХ-ын тухай, Засгийн газрын тухай, Ерөнхийлөгчийн тухай, Шүүхийн тухай, Улс төрийн намын тухай, Сонгуулийн тухай, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төрийн албаны тухай, Яамны эрх зүйн байдлын тухай, Агентлагийн эрх зүйн байдлын тухай гэх мэт хуулиудыг батлан мөрдүүлж, шаардлагатай үед шинэчлэн өөрчлөх замаар эрх зүйн орчин бүрдүүлсээр даруй 27 жилийг үдээд байна. Угтаа бол засаглалын суурь зарчмууд, тэдгээртэй уялдсан

харилцааны зохицуулалт ойлгомжтой, тодорхой болж, хөгжлийг дэмжих, зөв чиглүүлэх орчин бүрдэж, бэхжих боломжит хугацаа өнгөрчээ. Хэдий тийм боловч Монгол Улсад засаглалын тогтвортой, үр дүнтэй байдал улам бүр алдагдаж, хариуцлага, хяналт бүх түвшинд суларч, шударга ёсны болон хууль дээдлэх зарчим цаасан дээрх тунхаг төдий зүйл болоход ойрхон байна. Үүний улмаас төрийн бодлого, үйл ажиллагааны залгамж чанар алдагдан, төрийн захиргаа, үйлчилгээнд хүнд суртал, шат дамжлага нэмэгдэж, мэргэшсэн бус тогтолцоо, харилцаа, хандлага газар авч, засаглалын үйл явцад иргэдийн итгэл алдрах боллоо. Ийнхүү бий болоод байгаа нөхцөл байдлын хүрээнд дараах дүн шинжилгээ хийгдэж байна:

Ард түмний төлөөллийн байгууллага болохын хувьд УИХ-ын бодлого тодорхойлох, хууль батлах чадавх сайн байх учиртай. Гэтэл УИХ-ын чадавх суларч, УИХ-аас гаргаж буй хууль тогтоомж, бодлого шийдвэрт нийтийн ашиг сонирхол бус улс төр, бизнесийн бүлэглэлийн явцуу сонирхол, нөлөө нэмэгдэх хандлагатай болсон. Түүгээр зогсохгүй УИХ-ын гишүүдийн нэр хүнд, УИХ-д чиглэсэн иргэдийн итгэл суларч байна. Дэлхийн банкны засаглалын судалгааны иргэдийн дуу хоолой ба хариуцлага гэсэн үнэлгээнд Монгол Улсын индекс 57.1²⁴ байгаа бөгөөд 204 орноос 88-д эрэмбэлэгдсэн байна. Өөрөөр хэлбэл бодлого тодорхойлох үйл явц дахь иргэдийн оролцоо дундаас ялимгүй дээгүүр байгаа юм. Иймд УИХ-ын хууль тогтоох чадавхыг нэмэгдүүлэх нь дан ганц хууль тогтоох байгууллагыг бэхжүүлэх төдий бус парламентын засаглалыг бэхжүүлэх нөхцөл болно.

УИХ-ын гишүүд улс орны хөгжил, бодлогын асуудалд анхаарал хандуулах гэхээсээ илүүгээр сонгогдсон тойрогтоо хамааралтай байдлаар бодлого, шийдвэрт хандах нь давамгайлах болсон. Үүнийг нэг талаар сүүлийн жилүүдэд бий болсон улс төрийн популизм, нөгөө талаар сонгуулийн мажоритар тогтолцоотой холбож үздэг. Ялангуяа сонгуулийн мажоритар тогтолцоо нь Монгол Улсыг сонгуулийн 76 тойрог, 76 сонирхлын бүсэд хуваагдах нөхцөл рүү түлхэх болсон. Үүний үрээр үндэсний хэмжээний бодлого тодорхойлох, томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд ашиглагдах захиргааны болон санхүүгийн нөөц үр дүнгүй, үр ашиггүй сүйтгэгдэх нөхцөл байдал үүссэн. Өөрөөр хэлбэл улс төрчид маргаашийн сонгуулийг бодох, сонгогдсон тойргийнхоо явцуу эрх ашгийг үндэсний хэмжээний томоохон бодлого, хөтөлбөрөөс илүүд үзэх улс төрийн соёл хэвшил боллоо. Иймд нэг талаар сонгуулийн тогтолцоог үндэсний нийтлэг сонирхлыг хангаж чадахуйц хэлбэрээр шинэчлэх, нөгөө талаар УИХ-ын бодлого тодорхойлох чадавхыг дээшлүүлэх зорилт дэвшүүлж байна.

Сүүлийн жилүүдэд улс төрийн талцал, хуваагдал эрчтэй өрнөж байгаа нь Засгийн газар тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлсэнгүй. Тухайлбал, 1992-2017 онд байгуулагдсан (У.Хүрэлсүхийн Засгийн газрыг оролцуулахгүйгээр) 14 Засгийн газар дунджаар 21.1 сар буюу 1.75 жилийн настай байлаа. Энэ хугацаанд нийт 14 Ерөнхий сайд томилогдсон ба тэдний 12 нь бүрэн эрхийн хугацаагаа дуусгалгүй огцорчээ. Дэлхийн

²⁴ Засаглалын индексийг хамгийн муу 0, хамгийн сайн 100 байхаар тооцдог бөгөөд 2018 оны судалгаанд 204 орон, бус нутаг үнэлэгджээ. Засаглалын индексийг Дэлхийн банк 1996 оноос тооцож эхэлсэн бөгөөд дурдсан хугацаанд иргэдийн дуу хоолой ба хариуцлагын индексийн дундаж 56.5 байв. Өөрөөр хэлбэл тус үзүүлэлтэд ямар нэг ахиц гарсангүй.

банкны засаглалын үнэлгээгээр 1996 оноос хойших хугацаанд Монгол Улс дахь улс төрийн тогтвортой байдлын индексийн дундаж 70.9, 2018 оны индекс 74.29 байна. Улс төрийн тогтвортой байдлыг хүсэн хүлээсэн түвшинд хангаж чадаагүйгээс үр дагавар нь бодлого, хэрэгжилтийн тогтворгүй байдалд шууд тусгалаа олсоор ирлээ. Иймд Засгийн газрын тогтвортой байдлыг хангаж, сонгодог парламентын засаглалын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэгдсэн шинэчлэл хийх бодит шаардлага тавигдаж байна.

Шүүгч болон хууль хяналтын байгууллага нь хариуцлага хүлээх эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй, шүүгчид мэргэжлийн болон ёс зүйн хариуцлага тооцох механизмын үр нөлөө суларсан. Үүний улмаас иргэдийн шүүх, хууль хяналтын байгууллагад итгэх итгэл суларч, шүүх засаглалын хараат бус байдлыг алдагдуулахад нөлөөлж байна. Дэлхийн банкны “Засаглалын судалгааны хуулийн засаглал” гэсэн үнэлгээнд Монгол Улсын индекс 44.1 байгаа бөгөөд 209 орноос 116-д эрэмбэлэгджээ. Ардчилсан засаглалын тулгуур нь хуулийн хэрэгжилтийг нийгмийн бүхий л хүрээнд хангах, иргэн, байгууллага бүр хуулийн өмнө тэгш байх явдал билээ. Ингэж гэмээ нь хүний хөгжлийг хангасан сайн засаглал тогтож чадна. Иймд шүүх эрх мэдлийн байгууллагууд төдийгүй нийгмийн бүхий л хүрээнд хуулийн хэрэгжилтийг хангах Үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх зорилт тавигдаж байна.

Сонгуулийн мөчлөг хэт ойр, одоо үйлчилж байгаа сонгуулийн мажоритар тогтолцоо нь төрийн бодлогын нэгдмэл, тогтвортой байдлыг хангахгүй байна. Засаглалын үйл явц нь “УИХ-ын сонгуулийн өмнөх жилээс эхлэн сонгуульд бэлтгэх” – “УИХ-ын сонгуулийн жилд бодлогод суурилсан биш, санал татах популист үйл ажиллагааны шийдвэрүүд гаргаж сурталчлахад төрийн үйл ажиллагаа чиглэх” – “УИХ-ын сонгуулийн дараа албан тушаалын томилгоо, бялуу хуваалт” – “Орон нутгийн сонгуульд бэлтгэх” – “Орон нутгийн сонгуулийн дараа Засаг дарга болон нутгийн захиргааны байгууллагуудын бусад томилгоо” – “Ерөнхийлөгчийн сонгуулийн бэлтгэл” – “Ерөнхийлөгчийн сонгууль, түүнийг дагасан томилгоо” – “Шинээр томилогдсон төрийн албан тушаалтнууд ажилтайгаа танилцаж, баг бүрдүүлэх нэрийдлээр халаа сэлгээ хийх” – “Сонгуулийн популист амлалтаа хөтлөгдөн өмнө явж байсан бодлого, үйл ажиллагааг зогсоох, өөрчлөх, шинээр хийх” – “УИХ-ын дараагийн сонгуулийн бэлтгэл” гэсэн “чөтгөрийн тойрог”-т орсон байна. Иймд сонгуулийн тогтолцоо, сонгуулийн соёлын шинэчлэл нь улс төрийн орчны шинэчлэл, засаглалын шинэчлэлийн бүрдэл хэсэг байхаар асуудалд хандах нь зүйтэй гэж үзлээ.

Улс төрийн намууд өнөөг хүртэл төлөвшиж чадаагүй, намууд нь бодлогын нам гэхээсээ илүүтэйгээр улс төр, бизнесийн тодорхой бүлэглэл шинжтэй болж, албан тушаалд хүрэх гол арга хэрэгсэл болох хандлага илтэд ажиглагдах боллоо. Монгол Улсад дээд шүүхэд бүртгэлтэй 32 улс төрийн нам үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч өнгөрсөн 27 жилд Монгол Ардын Нам, Ардчилсан Нам ээлжлэн засгийн эрх мэдлийг хэрэгжүүлж иржээ. Монгол Ардын Нам дурдсан хугацааны 62.4 хувьд засгийн эрх мэдлийг дангаар болон улс төрийн бусад намтай эвсэн хэрэгжүүлсэн бол Ардчилсан нам 37.6 хувьд засаглажээ. Хэдий тийм боловч улс төр тогтворгүй, төрийн захиргаа, төрийн алба мөн адил тогтворгүй, бодлого тодорхой бус популист шинжтэй байсаар ирлээ. Үүнийг улс төрийн

намуудын бодлого тодорхойлж, улс төрийн өрсөлдөөнд мэргэшсэн түвшинд оролцох чадавх бүрдээгүйтэй холбож ойлгох нь зүйтэй. Иймд улс төрийн намуудыг бодлогын нам болгон шинэчлэх шаардлага тавигдаж байна.

Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхэд захиргааны хүнд суртал, дүрэм журам тодорхой бус, албан хаагчдын мэргэшсэн бус, шуурхай бус байдал, сөрөг хандлагаас үүдэлтэй бэрхшээл саад нийтлэг шинжтэй болсон. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж тааруу, уян хатан бус байгаагаас иргэд, хувийн хэвшлийг дэмжсэн төрийн бодлого, зохицуулалтын үр дүн, үр нөлөө суларч байна. Тухайлбал, 2018 онд Дэлхийн банкны засаглалын судалгаагаар Монгол Улсын Засгийн газрын үр нөлөөний индекс 45.6 байгаа бөгөөд 209 улсаас 114-т эрэмбэлэгдсэн байна. Энэ нь төрийн бодлого, хэрэгжилт муу, төрийн үйлчилгээ иргэдийн хүсэн хүлээсэн шаардлагыг бүрэн хангахгүй байгааг илтгэнэ. Иймд: 1) төрийн үйлчилгээг үр дүнд чиглэгдсэн, уян хатан хэлбэрээр зохион байгуулах, 2) төрийн үйлчилгээг орон зай, цаг хугацааны саадыг даван туулж чадахуйц, хүнээс хамааралгүй, хүнд сурталгүй болгоход чиглэгдсэн “Цахим Монгол” шилжилт хийх нь зүйтэй юм.

Төрийн захиргааны байгууллагууд чиг үүргийн давхардал, хийдэл их, бүтэц, зохион байгуулалт нь оновчтой биш, сонгууль бүрийн дараа өөрчлөгдөх хандлагатай болсон. Үүнтэй уялдан Монгол Улсын хөгжлийн бодлогыг урт хугацаанд нь нэгтгэн зангидах, уялдуулан хангах институцийн чадавх бэхжихгүй байна. Тухайлбал, 2018 оны байдлаар Монгол Улсын зохицуулалтын чадварыг тодорхойлох индекс 54.7 байгаа бөгөөд 209 орноос 95-т эрэмбэлэгдсэн. Индексийн хэмжүүр нь дундаас ялимгүй дээш гарсан байх бөгөөд засгийн газар, төрийн захиргааны байгууллагуудын бодлого тодорхойлж, хэрэгжүүлэх чадавх мэдэгдэхүйц сул байгааг илтгэж байна. Иймд төрийн захиргааны байгууллагуудын чиг үүрэгт дүн шинжилгээ хийж, оновчтой хуваарилан, төрийн албыг мэргэшсэн, үр дүнтэй ажиллах хэлбэрээр зохион байгуулах, түүнд шаардлагатай эрх зүй, зохион байгуулалт, мэдлэг чадвар, технологи, хандлагын шинэчлэл хийх зүй ёсны шаардлага тулгамдаад байна.

Авлига, ашиг сонирхлын зөрчил, албан тушаалын гэмт хэрэг нэмэгдэх хандлагатай болжээ. 2018 онд Дэлхийн банкны засаглалын үнэлгээгээр авилгын индекс 39.9 байгаа бөгөөд 209 орноос 126 дугаар байранд жагсжээ. Үндсэндээ авлига, ашиг сонирхлын зөрчил газар авч энэ нь нийгэм, эдийн засгийн хөгжил, улс төрийн шинэчлэлд шууд чөдөр тушаа болсоор байна. Авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх үйл ажиллагаа нь хууль өөрчлөх, хяналт шалгалт тавих, хариуцлага хүлээлгэх төдийхнөөр хязгаарлагдахгүй. Нэгэнтээ бий болсон нөхцөл байдалтай үндэсний хэмжээнд тэмцэх шаардлагатай болжээ. Иймд авлига, ашиг сонирхлоос сэргийлэх үндэсний тогтолцоо бүрдүүлэх, нийгмийн бүхий л хүрээнд авлигалыг үл тэвчих хандлага тогтооход чиглэгдсэн шинэ үзэл баримтлал, арга зам санал болгож байна.

6. НОГООН ХӨГЖИЛ

Хот руу чиглэсэн их нүүдэл, хотын төлөвлөлтгүй тэлэлт, дэд бүтцийн байгууламжийн хүрэлцээгүй байдал, техник, технологийн хоцрогдол, ядуурал зэрэг олон хүчин зүйлийн нөлөөгөөр хот, суурин газрын агаар, орчин бохирдож, хүний амьдрах орчин, эрүүл мэндэд хортойгоор нөлөөлж байна. Өвлийн улиралд Улаанбаатар хот болон Баянхонгор, Даланзадгад, Дархан, Арвайхээр, Ховд, Эрдэнэт зэрэг хот суурин газрын агаар дахь утаа тоосонцор, хүхэрлэг хий зэрэг хорт бодисын хэмжээ агаарын чанарын стандартаас хэтэрч бохирдох болсон.

Манай орон хязгаарлагдмал усны нөөцтэй орны тоонд ордог. Гэхдээ усны нөөцийн дийлэнх буюу 80 орчим хувь нь нийт нутаг дэвсгэрийн 30 хувьд хангайн бүсэд бүрэлдэн бий болдог. Гэтэл говийн бүсэд ашигт малтмалын олборлолт эрчимжиж, аж үйлдвэрлэлийн гол түшиц газар болгохоор төлөвлөж байгаа ч өсөн нэмэгдэх усны хэрэгцээг хангаж чадахгүй усны хомстол нүүрлэх, улмаар үйлдвэрлэлийн хүчин чадлыг хязгаарлах нөхцөл үүсэж байна.

Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувь аймаг, нийслэлд ихээхэн ялгаатай байна. Улаанбаатарт баталгаат ус хангамж өндөр хувьтай байгаа ч Баян-Өлгий, Баянхонгор, Архангай, Ховд, Хөвсгөл, Завхан, Увс зэрэг аймгийн ихэнх хүн ам гадаргын усыг амьдрал ахуйдаа шууд хэрэглэж байгаа нь эдгээр аймгуудын хувьд ундны ус хангамжийн эрүүл ахуй, чанарын асуудал эрсдэлтэй байдалд оруулж байна.



Эх сурвалж: <https://www.daesunglee.com/4368648-futuristic-archaeology#16>

Нийслэл болон аймгийн төвүүдийн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, тэжээгдлийн мужид газар олголт хийгдэж суурьшлын бүс бий болсноор газрын доорх усны нөөц бохирдох нөхцөл үүсэж байгаа ба энэ нь цаашдаа хүн амын ундны ус хангамжийн эх үүсвэр аюултай байдалд хүрэхээр байна. Иймд ус хангамжийн эх үүсвэр, түүнчлэн газрын доорх цэнгэг усны ордуудыг улсын болон орон нутгийн хамгаалалтад авах ажлыг шуурхай зохион байгуулж ажиллах шаардлагатай байна.

Сүүлийн жилүүдэд улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл тусламжаар ариутгах татуургын байгууламжийг шинээр барих, шинэчлэх ажил хийгдэж байгаа ч сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдах хүн амын эзлэх хувь хангалтгүй хэвээр байна. Нийт 130 гаруй цэвэрлэх

байгууламжийн ихэнхийнх нь үйл ажиллагаа доголдсон, эвдрэлтэй байгаагаас жилд 120 сая гаруй шоо метр бохир ус байгальд хаягдаж, Туул, Хараа, Орхон, Хангал зэрэг голын усыг эрдэс болон органик бодисоор бохирдуулж байна.

Хотжилтын нөлөөгөөр гэр хороолол тэлж, стандартын шаардлагад нийцэхгүй ариун цэврийн байгууламж ашиглаж байгаа нь ус, хөрсний бохирдлын гол эх үүсвэр, халдварт өвчин дэгдэх суурь нөхцөл болж байна. Нийслэлийн гэр хорооллын 200 гаруй мянган өрхийн ариун цэврийн байгууламжийн 80 хувь нь стандартад нийцэхгүй байна. Улсын хэмжээнд 4543 га талбай бүхий 391 хог хаягдлын төвлөрсөн цэгт жилд 2.5 сая тн хог хаягдал зайлуулагдаж байна. Аюултай хог хаягдлыг байгаль орчинд халгүй аргаар устгах, булшлах, хоргүйжүүлэх зориулалтын төвлөрсөн байгууламж байхгүйгээс их хэмжээний хаягдал хуримтлагдан зориулалтын бус газар хадгалагдаж байгаа нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд ноцтой хохирол учруулах эрсдэлийг бий болгож байна.

Монгол Улс газарзүйн байршил, уур амьсгалын нөхцөл, эдийн засгийн салбарын бүтэц, хүн амын амьдралын хэв маяг зэргээс улбаалан уур амьсгалын өөрчлөлтөд нэн эмзэг орны тоонд ордог. Уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар нь байгаль, цаг агаараас ихээхэн хараат эдийн засгийн салбаруудад үзүүлэх эрсдэл, дарамтыг улам бүр нэмэгдүүлж, гол ус хатаж ширгэх, мөнх цэвдэг, мөстөл хайлах, хуурайшилтын улмаас хөрс, бэлчээр доройтон цөлжих, ой мод түймэр, хортон шавжид өртөх, байгаль, цаг агаарын аюулт үзэгдлийн давтагдал, эрчим, хамрах газар нутаг нэмэгдэх байдалд хүргэж байна. Сүүлийн 70 гаруй жилийн хугацаанд агаарын жилийн дундаж температур 2.24 хэмээр дулаарч, ууршиц ихсэж, тал хээр, говь цөлийн бүсэд хуурайшил 3-10 хувь, ойт хээрийн бүс, өндөр уулын бүслүүрт 10-15 хувиар тус тус нэмэгдсэн байна. Мөн ган, зуд болон хүчтэй салхи, шороон ба цасан шуурга, ширүүн аадар, уруйн үер зэрэг ус, цаг агаарын аюулт үзэгдлийн давтагдал сүүлийн хорь гаруй жилд 2 дахин ихсэж, тэдгээрээс үүдсэн эдийн засгийн хохирол нэмэгдсэн.

Уур амьсгалын дулаарал нь эрчимжсэн ууршилт, цэвдэг, мөстлийн хайлалтаар дамжин усны нөөцөд сөргөөр нөлөөлж байна. Жишээ нь Алтайн өндөр уулсын мөстлийн хэмжээ сүүлийн 70 гаруй жилд гучаад хувиар буурсан. 1971 онд Монгол орны нийт газар нутгийн 63 хувь үргэлжилсэн болон алаг цоог цэвдэгтэй байсан бол 2016 оны судалгаагаар 29.3 хувь болж буурсан. Уур амьсгалын өөрчлөлтийн эдгээр үр дагавар нь байгаль, цаг агаараас ихээхэн хараат мал аж ахуй, газар тариалан, дэд бүтэц, барилгын үйлдвэрлэл, хүний эрүүл мэнд зэрэг нийгэм, эдийн засгийн салбарт илүү сөргөөр нөлөөлж байна.

Монгол Улсын нийт бэлчээрийн 90 орчим хувь нь цөлжилт, газрын доройтлын үйл явцад өртөх эрсдэлтэй нутагт ордог. Уур амьсгалын өөрчлөлтийн зэрэгцээ бэлчээрийн даац хэтрэлд, газар тариалан, уул уурхай, дэд бүтцийн салбарын үрэлгэн, хоцрогдсон технологи ашиглалт, олон салаа зам, хот суурины төлөвлөлтгүй тэлэлт зэрэг хүний хүчин зүйлийн нөлөөгөөр цөлжилт, газрын доройтол эрчимжиж байна. 5 жил тутамд хийдэг цөлжилтийн үнэлгээний дүнгээр 2015 онд нийт нутгийн 76.8 хувь нь их, бага хэмжээгээр цөлжилт, газрын доройтолд өртөөд байгаа

бөгөөд үүнээс хүчтэй, нэн хүчтэй доройтсон газар 23 хувийг эзэлж байна. Ялангуяа Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Орхон-Сэлэнгийн сав нутаг, Хэрлэн голын сав, Төв Халхын тэгш өндөрлөгт цөлжилт, газрын доройтлын үйл явц нэмэгдсэн байна. Доройтлын 49 хувийг хүний үйл ажиллагаа, 51 хувийг байгалийн хүчин зүйлээс үүдэлтэй гэж судлаачид үздэг.

Цөлжилтийг эрчимжүүлэхэд хүргэж байгаа нэг хүчин зүйл нь олон жилийн турш бэлчээрийн даацыг хэтрүүлэн ашиглаж, талхлагдалд оруулж байгаа явдал юм. Бэлчээрийн зохицуулалтгүй хэт ашиглалт нь байгалийн ургамалд нөхөн төлжих хугацаа, боломж олгохгүй хомстох, улмаар устахад хүргэж байна. 2015 оны байдлаар 112.7 сая га бэлчээрийн 70 гаруй хувь нь ямар нэгэн хэмжээгээр талхлагдалд орж, ургац 20-30 хувиар буурч, ургамлын зүйлийн бүрдэл цөөрч, малд идэмжтэй, тэжээллэг үетэн болон алаг өвст бэлчээр хумигдаж, шарилжит, нэг наст ургамлын эзлэх хувь ихсэж доройтолд орсон байна.

Уур амьсгалын ирээдүйн төсөөллөөс харахад цаашид манай орны нутаг дээр ган, зудын эрчимшил нэмэгдэх магадлал өндөр байна. Ган, зудын давтагдал ихсэх, малын зүй бусын хорогдол нэмэгдэх, ашиг шим буурах нь ялангуяа зах зээлээс алслагдсан нутгийн малчдын амьдралд сөргөөр нөлөөлж, төв рүү чиглэсэн нүүдэл ихсэх, нийслэл, бусад хот суурин газрын төвлөрөл, ачаалал үргэлжлэн нэмэгдсээр байх төлөвтэй байна.

Олон мянган жилийн турш бүрэлдэн бий болдог үнэт нөөц хөрсний үржил шим, чийгийг алдагдуулан доройтолд оруулж, цөлжилтийн цэгэн голомтыг нэмэгдүүлэх нэг гол хүчин зүйл нь тариалангийн газрын зохисгүй ашиглалт юм. Атар газар эзэмшсэнээс хойших 50 гаруй жилд 1.2 сая га талбайг хагалж ашигласан боловч 700 мянга гаруй га талбай элэгдэлд орж эргэлтээс хасагдаж, хөрсний ялзмаг 2 дахин буурсан байна.



Эх сурвалж: Economist.

Уул уурхайн үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж байгаа ч олборлолт, ашиглалтын хоцрогдсон технологи, дэд бүтцийн байгууламжийн уялдаагүй, оновчгүй төлөвлөлтөөс болж байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажил хоцрогдож байгаль орчин, иргэдийн амьдрах орчинд сөрөг нөлөөлж байна.

Уул уурхайн үйл ажиллагаанаас 27070 га талбай эвдрэлд орсноос 11375 га-д буюу 42 хувьд техникийн нөхөн сэргээлт, 7425 га-д буюу 27 хувьд биологийн нөхөн сэргээлтийг тус тус хийсэн байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм.

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй экосистемийн хилийн шилжилт, цөлжилт, бэлчээрийн талхлагдал зэрэг нь байгалийн ургамал, амьтны тархац нутаг хумигдах, амьдрах орчин нь доройтоход хүргэж байгаа ба улмаар биологийн олон янз байдлыг хамгаалж, устах, хомстхоос сэргийлэх, байгалийн тэнцлийг хадгалахад томоохон сорилтыг бий болгож байна. Тухайлбал, дэлхийн сүүлчийн хуурай хээрт олон зуу, мянгаараа нүүдэллэн амьдардаг цагаан зээрийн популяцыг хамгаалах, тал хээрийн биологийн олон янзыг аварч авч үлдэхэд манай орны зүүн, зүүн хойд хэсэг, Дорнод Монгол, Монгол Дагуурын бүс нутаг онцгой ач холбогдолтой юм.

Байгалийн ашигт ургамлыг их хэмжээгээр түүж бэлтгэж байгаа нь Монгол орны ургамлын аймаг, биологийн олон янз байдалд сөрөг нөлөөлж байгалийн үнэт баялаг устах аюул нүүрлээд байна. Ургамлын улаан дансны бүртгэлд байгаа нэн ховор, ховор ургамлыг олон улсын аргачлалаар үнэлэхэд амьдрах орчны дарамт, хэт ашиглалтын улмаас ургамлын зүйлийн 11 хувь устаж байгаа, 26 хувь устаж болзошгүй, 37 хувь эмзэг буюу байгальд устах эрсдэл өндөр, 15 хувь ховордож болзошгүй байгааг тогтоосон. Иймд нэн ховор, ховор амьтан, ургамал болон бичил биетний омог, эд, эсийн өсгөврийн үндэсний ген банк байгуулах зайлшгүй шаардлагатай. Монгол улсын ойн сан бүхий газар 18'321 мян.га буюу нийт нутаг дэвсгэрийн 11.7 хувийг эзэлж, ойрхог чанар 7.9 хувь байна. Сүүлийн 5 жилийн дүнгээр ойгоор бүрхэгдсэн талбай 864.5 мян.га-аар багасч, ойрхог чанар 7.9 хувь болж 0.56 хувиар буурсан нь ойн түймэр, хөнөөлт шавжны олшрол, хууль бус мод бэлтгэлтэй холбоотой.

Уур амьсгалын өөрчлөлт, дулаарлын улмаас хүн, мал амьтны халдварт өвчний дэгдэлт ихсэх, шинэ болон дахин сэргэж байгаа өвчний төрөл нэмэгдэх, хил дамжин орж ирэх, байгалийн голомт, тархалтын бүсийн халдвар дэгдээх эрсдэл нэмэгдэх, өвчин үүсгэгчийн хувьсал хурдан явагдаж, өндөр хоруу чанартай, тэсвэртэй омог шинээр бий болох зэрэг эрсдэлүүд тулгарч болзошгүй гэж судлаачид үзэж байна. Ялангуяа дулаарлын нөлөөгөөр дэлхий дахинаа шавж, үе хөлтнөөр дамжин халдварлах вирусийн болон нянгийн гаралтай өвчний тархалтын хүрээ тэлж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, даван туулахын тулд дэлхий нийтээр уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндсэн хоёр стратеги барьж байна. Монгол Улс 1992 онд НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцод, 2016 онд Парисын хэлэлцээрт нэгдэн орж, уг хэлэлцээрийн хүрээнд бий болсон санхүүжүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах талаар хүчин чармайлт гаргаж байна.

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад улс орон бүр хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад оруулах хувь нэмрээ (NDC) тодорхойлсон. Монгол Улсын хувьд тодорхойлсон хувь нэмрээ Ногоон хөгжлийн бодлого, Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрт тулгуурлан боловсруулсан бөгөөд эрчим хүч, барилга, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, хог хаягдлын салбарт хэрэгжүүлэх байгальд ээлтэй ногоон бодлого, арга хэмжээний үр дүнд эдийн засгийн хөгжил өнөөгийн хандлагаар явна гэсэн төсөөлөлтэй

харьцуулахад 2030 он гэхэд хүлэмжийн хийн нийт ялгарал 22.7 хувиар буурахаар байна. Эдгээр хувь нэмрээ биелүүлэхэд Конвенцын хүрээнд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн механизм, арга хэрэгслээр дамжуулан шинэ технологи нэвтрүүлэх, санхүүгийн дэмжлэг авах боломж, нөхцөл хэр байхаас ихээхэн хамаарах юм.

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг нийгэм, эдийн засгийн бүх салбарт цаг алдалгүй авах шаардлагатай. Юуны өмнө хөрсний үржил шим, бэлчээрийг хамгаалах, бороо цас мөсний усыг хуримтлуулах, малын ашиг шимийг нэмэгдүүлж, халуун хуурай нөхцөлд тэсвэртэй таримал тариалах, усалгааны хэмнэлттэй технологи нэвтрүүлэх зэрэг ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна. Энэ хүрээнд мөн хүлэмжийн хий багатай үйлдвэрлэл, байгальд ээлтэй тэргүүний техник технологи нэвтрүүлэх, үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэх, эрчим хүчний сэргээгдэх болон бусад шинэ эх үүсвэрийг өргөнөөр ашиглах ногоон төслүүд, үйл ажиллагааг эдийн засгийн салбаруудад хэрэгжүүлэх шаардлагатай байна.

7. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ

Өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд гамшгийн улмаас дэлхийн олон хүний амь нас үрэгдэж, хүн ам, олон нийт, улс орны аюулгүй байдал, сайн сайхан аж байдалд сөргөөр нөлөөлж, 700 гаруй мянган хүн амь насаа алдаж, 1.4 сая гаруй хүн гэмтэж бэртэн 23 орчим сая хүн орон гэргүй болсон байна. 1.5 тэрбум гаруй хүн гамшигт ямар нэг байдлаар нэрвэгджээ. Нийт учруулсан хохирлын хэмжээ нь 1.3 их наяд ам.доллар болжээ.

Энэ нөхцөлд гамшгийн эрсдэлийг бууруулах болон одоо тулгарч буй хүндрэл бэрхшээлүүдийг шийдвэрлэхийн тулд иргэд, олон нийт, улс орнуудын эдийн засаг, нийгэм, эрүүл мэнд, соёл, боловсролын салбарын гамшигтай тэмцэх, тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэхэд хөрөнгө оруулалт хийх, аюулын төрөл бүрээр эрт зарлан мэдээллийн систем, бэлэн байдлыг хангах, хор уршгийг арилгах, сэргээн босгох, нөхөн сэргээх үйл ажиллагааг бэхжүүлэх нь чухал байна.

НҮБ-аас гаргасан тоо баримтаас харахад, компьютерын гэмт хэргээс учирч буй хохирол нь мансууруулах бодисын хууль бус эргэлтээс олдог орлоготой тэнцэх болжээ.

Монгол Улсын хувьд олон улсын банк, санхүүгийн байгууллагын заавар зөвлөмж, их гүрнүүдийн тусламж, нөлөө ивээл, үндэстэн дамнасан бизнес бүлэглэлүүдийн хөрөнгө оруулалт, хандив, тусламж, зарчмын цоо шинэ үүрэгтэй болсон мэдээлэл, харилцаа холбооны технологийн үсрэнгүй хөгжил, орон зай, цаг хугацаа, хүний эрх, үндсэн эрх чөлөө, ардчиллын асуудал гээд аюулгүй нийгмийн агуулгад эерэг сөргөөр нөлөөлж болох харилцан хамаарал, уялдаа бүхий олон талын хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлага тулгардаг.

Манай улсын хувьд батлан хамгаалах салбарт улс төр, дипломатын аргыг урьтал болгон гадны цэргийн аюулаас сэрэмжлэх бодлогоо энхийг эрхэмлэсэн тодорхой зарчимд тулгуурлаж буйгаа дэлхий нийтэд зарлаад, гуйвалтгүй хэрэгжүүлж байна.

Манай цэргийн алба хаагчид цэргийн дипломат албанаас гадна НҮБ болон олон улсын бусад байгууллага, олон үндэстний цэргийн хүчний бүрэлдэхүүнд оролцон үүргээ амжилттай гүйцэтгэх болсон юм. Монгол Улсын Зэвсэгт хүчнээс олон улсын энхийг дэмжих ажиллагааны шугамаар давхардсан тоогоор нийт 17,000 гаруй цэргийн алба хаагч үүрэг гүйцэтгэсэн, цаашид ч үргэлжлэн гүйцэтгэх юм. Энэ нь манай Зэвсэгт хүчний төдийгүй Монгол Улсын нэр хүндийг дэлхийн тавцанд өргөхөд чухал ач холбогдолтой. Олон улсын терроризмтой холбоотойгоор аюулгүйжүүлэх гол чиглэл нь санхүүгийн болон бусад бүртгэл, хяналт шалгалт, үй олноор хөнөөх зэвсэглэлд тавих хяналт болж байна.

Монгол Улс кибер дайн, кибер тагнуулын асар их чадамжтай хоёр гүрний дунд оршиж энэ хоёр орноор дайруулан дэлхийн мэдээллийн сүлжээнд холбогддогийг аюулын улаан зэрэглэлд байна хэмээн ойлгож болно.

Монгол Улсад кибер болон мэдээллийн аюулгүй байдлын хууль эрх зүйн орчин бүрдээгүй, кибер болон мэдээллийн аюулгүй байдлын мэргэжилтэн хомс, кибер хил хязгаар байхгүй, кибер довтолгооноос хамгаалах, хариу үйлдэл үзүүлэх чадамж муу, мэдээллийн аюулгүй байдал хангах чиглэлд хөрөнгө оруулдаггүй, интернетийн агуулгыг хянадаггүй, төрийн мэдлийн мэдээллийн нэгдсэн дотоод сүлжээ байхгүй, төрийн байгууллагад интернет болон дотоод сүлжээ нь хоорондоо холилдсон, интернетэд олон гарцаар замбараагүй холбогддог, төрийн байгууллага дотоод сүлжээндээ утасгүй технологи ашигладаг зэрэг сул талтай байна.

Монгол Улс гамшгийн эрсдэлийн хувьд цаг агаарын дулаарлаас үүдэлтэйгээр ган, зуд, цасан болон шороон шуурга, ой, хээрийн түймэр, цөлжилт, хэт халалт, хүйтрэлт зэрэг байгалийн гамшгаас гадна хүн, мал, амьтны гоц халдварт өвчин, хортон шавж, үлийн цагаан оготныг тархалт, үйлдвэр, тээврийн хэрэгсэл, химийн хорт бодис, тэсэрч дэлбэрэх бодисын осол нэмэгдэж байна.

Жилд дунджаар 3000 гаруй аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол тохиолдож, гамшгийн улмаас хүний амь нас эрсдэж, эд хөрөнгө, байгалийн ихээхэн хэмжээний хохирол учирч, эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлж байна. Гамшгийн нөлөөллөөс үүсэх хор уршгийг хохирол багатай даван туулах асуудал нь гамшгаас хамгаалах чадавхаас ихээхэн хамаардаг ч манай орны гамшгаас хамгаалах чадавх сул байна. Гамшгаас хамгаалах салбарын мэргэжлийн хүний нөөц дутагдалтай, аврах ажлын зориулалттай багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангамж хүрэлцээгүй, тэдгээрийн техникийн үзүүлэлт хоцрогдонгуй байна.

Сүүлийн 20 жилд уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал болон хүний зохисгүй үйл ажиллагааны нөлөөгөөр манай улсад ган, зуд, аянга, аадар бороо, хүчтэй шороон болон цасан шуурга, мөндөр, уруйн үер зэрэг байгаль, цаг агаарын аюулт үзэгдлийн тоо, төрөл нэмэгдэж, тэдгээрийн давтамж ойртон, үүний улмаас нийгэм, эдийн засагт учруулсан хохирлын хэмжээ 2 дахин нэмэгдсэн байна. Монгол орны агаарын хэмийн жилийн дундаж 2050 он гэхэд 2.1-3.0 хэмээр дулаарах урьдчилсан тооцооноос үзэхэд цаашид хүний эрүүл мэнд, амь нас эрсдэх, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд аюул, хохирол учруулах явдал мөн хэмжээгээр нэмэгдэх хандлагатай байна.

8. БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ

Аливаа улсын төрийн бодлогын нэг гол чиглэл нь газар нутгийнхаа өнцөг булан бүрд оршин суух иргэдийн ахуй амьдралын таатай нөхцөлийг бүрдүүлэх асуудал юм. Үүнийг шийдвэрлэх үндсэн арга нь нутаг дэвсгэрийн эдийн засгийн орон зайн зохион байгуулалт буюу бүсчлэн хөгжүүлэх явдал байсаар иржээ.

Энэ үүднээс бүсчилсэн хөгжлийн бодлого нь эрх зүй, удирдлага зохион байгуулалт, эдийн засгийн цогц арга хэмжээг агуулж байдаг бөгөөд хөгжлийн үйл явцыг орон зайн зарчмаар буюу улс бүс хооронд, бүсүүд хоорондын харилцааны үүднээс удирдах үйл ажиллагааны хүрээ юм. Нэг үгээр хүн ам шигүү суурьшсан газарт аж үйлдвэрийн төвлөрлийг багасгах, хөгжлөөр дорой бүс нутгийн эдийн засгийг өөд татах, бүс нутгийн бизнесийн орчныг сайжруулах замаар хэрэгжих учиртай.

Монгол Улс хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг багасгах, эдийн засгийн өсөлтийг түргэтгэх, бүс нутаг, салбар хоорондын аж ахуйн хоршилд, дагналт, төрөлжилтийг хөгжүүлэх, нутаг дэвсгэрийн орон зайн оновчтой бүтэц, зохион байгуулалтыг бий болгох зорилгоор “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” батлан гаргаад даруй 18 жил өнгөрөв. Өнөөдрийн түвшнээс дүгнэн үзвэл, энэхүү бодлогын хэрэгжилтийн үр дүн хангалтгүй байна.



Эх сурвалж: <https://www.discovermongolia.mn/>



Эх сурвалж: Tam Eastley/NPR Berlin

Зарим ахиц дэвшил гарсныг үгүйсгэх аргагүй ч эдгээр нь эрх баригч намын мөрийн хөтөлбөр, сонгуулийн амлалтын асуудал байсан.

Жил ирэх тусам хүндрэл, бэрхшээл хуримтлагдсаар үйлдвэрлэл үйлчилгээ, хүн амын төвлөрөл улам нэмэгдэж байна. Үүнийг газар нутгийн дөнгөж 0.3 хувийг эзэлдэг нийслэл хотод хүн амын 46.1 хувь суурьшиж, улсын ДНБ-ий 65.9 хувийг бүрдүүлж буй нийслэл хотын дүр зургаас тодорхой харж болно.

Бүсчлэн хөгжих нь зүйтэй гэсэн үзэл хандлагыг бодлогын түвшинд томьёолон тавьсан боловч бүс нутгууд хөгжин дэвших нийгмийн идэвхжилт, сэтгэл зүйн орчин бүрдүүлж, төр, иргэн, аж ахуйн нэгжийн хамтын ажиллагааг хангаж чадаагүй байна.

Түүнээс гадна төрийн бодлого залгамж холбоогүй, сонгууль дагасан дөрвөн жилийн циклтэй, нэг улс төрийн хүчин төрийн эрхэнд гармагцаа урьдахаа үгүйсгэж, огт өөр зүйл ярьж эхэлдэг нь урт хугацааны тууштай бодлоготой хөгжих боломжийг хааж байна.

2005 онд бүсүүдийн хөтөлбөр батлагдсан ч хэрэгжүүлэх арга хэмжээний санхүүжилтийг ДХТХ-ний мэдэгдэл, төсвийн төсөөлөлтэй холбох асуудал орхигдож ирсний зэрэгцээ бүс нутгийн хөгжлийг дэмжих олон арга механизмыг ашиглаж чадаагүй, хэрэгжүүлэх институцийг бүрдүүлээгүй орхисон, бүсчлэлийн бодлогоор төвлөрлийг сааруулах зорилт шийдвэрлэгдээгүй зэрэг олон шалтгааныг дурдаж болно.

Монгол орны алслагдсан зах хязгаар нутаг зам харилцаа муутай, ганц төвөөсөө холдох тусам бараа, үйлчилгээний үнэ өндөр байдаг нь газарзүйн байршил иргэдийн амьжиргааны өртгийг тодорхойлогч гол хүчин зүйл болж, сийрэг суурьшсан хүн амд нийгмийн үйлчилгээг хүргэж, дэд бүтцээр хангах нь ихээхэн хүндрэлтэй асуудал хэвээр байсан, одоо ч хэвээр байна.

Иймээс төрийн бүсчлэлийн бодлогын мөн чанар бол нутаг дэвсгэрийн орон зайн зохион байгуулалтын арга хэрэгсэл, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн тэнцвэртэй, харилцан уялдсан цогц хөгжлийг хангах, төрөөс хөгжлийн бодлогыг хөтлөн чиглүүлж, удирдан зохицуулах, шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэх механизм гэдгийг сайтар ойлгож, бүсчилсэн хөгжлийн зорилтууд, эдийн засгийн бүсчлэлийн схемээ эргэж харах, бүс нутгуудын байгалийн баялаг, түүхий эдийн нөөц, газарзүйн байршил, тэргүүн ээлжид хөгжүүлэх төрөлжилтийн салбар зэргийг тооцож, тухайн бүс нутгийн онцлогт тохирсон үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжин хөгжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлэх нь өнөөгийн шатны тулгамдсан асуудал болж байна.

9. УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ

Хотын хүн амын өсөлтийг дагаад хамран сургалт тасралтгүй өсөж 2018 оны байдлаар 76.6 хувьд хүрсэн нь улсын дунджаас 5,3 хувиар доогуур байна. Сүүлийн 10 жилд цэцэрлэгийн тоо 435-аар, хамран сургалт 11.7 хувиар өссөн боловч 10 хүүхдийн 2 нь гэртээ байна. Цэцэрлэгийн нэг ангид дунджаар төрийн өмчийн цэцэрлэгт 44 хүүхэд, төрийн бус өмчийн цэцэрлэгт 21 хүүхэд сурч байна. Нийслэлд 2018 онд нийт 672 цэцэрлэг 797 хичээлийн байранд үйл ажиллагаа явуулсан байна.

Бага, дунд боловсролын хувьд 2018-2019 оны хичээлийн жилд Монгол Улсын хэмжээнд ерөнхий боловсролын 803 сургууль үйл ажиллагаа явуулснаас 245 (30.5 хувь) нь нийслэлийн нутаг дэвсгэрт байрлаж байна. Сүүлийн 10 жилд ерөнхий боловсролын сургуулийн тоо 18.3 хувиар, суралцагчдын тоо 42.8 хувиар, багшийн тоо 37.3 хувиар нэмэгдсэн нь сайн талтай ч нэг ангид ногдох хүүхдийн тоо буурахгүй бүр зарим хэсгээрээ /

хотын төвд нэг ангид 50-60 хүүхэд/ нэмэгдэх хандлагатай байсаар байна. Нийслэлийн хэмжээнд 3 ээлжээр 23 сургуулийн 188 бүлэгт 7743 суралцагч хамрагдаж байгаа бөгөөд нийт сургуульд 08 цагаас 18 цагийн цагийн хооронд тасралтгүй үндсэн сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Сургууль, цэцэрлэг, эмнэлгийн байгууллагад сурч, ажиллаж, үйлчлүүлж байгаа иргэд сүрьеэ, томуу томуу төст өвчин тусах эрсдэл хамгийн өндөр байна. Өвлийн улиралд утаа, хүйтний байдлаас шалтгаалан цонхоор агаар оруулж агаар сэлгэлт хийх боломжгүй байдаг ба судалгаагаар судалгаанд хамрагдсан сургууль, цэцэрлэгийн анги танхим дахь дотоод агаарын чанар стандарт хэмжээнээс 3-10 дахин их буюу бага насны хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх хэмжээнд байна.

Улаанбаатар хот нь байгаль газар зүйн байрлал, далайн түвшнээс 1250-2000 м өргөгдсөн, Хэнтийн нурууны уулархаг мужийн бага Хэнтийн нуруунаас эх авсан Туул голын баруун талын салбар уулсын цутгал голын хөндий хоорондын уулс, хойшлоод Толгойтын нуруу, дархан цаазат Богдхан уулыг хамарсан нутаг дэвсгэртэй.

Улаанбаатар хотын хүн амын механик өсөлт, үйлдвэрлэл үйлчилгээ өргөжин хөгжиж цэвэр усны хангамж, бохир усны цэвэрлэгээ, гүний болон гадаргуугийн усан орчны бохирдол, нөөц, хангамж, хамгаалалтын асуудал нь тулгамдаж байна.

Гэр хороололд суурьшиж буй айл өрх, гэр хороолол дахь сургууль, цэцэрлэг, эмнэлэг, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийг дулаанаар хангаж буй төрөл бүрийн хийц, хүчин чадал бүхий 3000 гаруй халаалтын зуухнаас гарч буй утаа, тортог агаарын бохирдлын 80 гаруй хувийг эзэлдэг бол 331564 авто тээврийн хэрэгсэл, 3 дулааны цахилгаан станц, хог хаягдал, хөрснөөс дэгдэх тоос зэрэг нь агаарын бохирдлын үлдсэн 20 хувийг хамаардаг.

Улаанбаатар хотоос жилд дунджаар 1.1 сая тонн хог хаягдал гарч, 95 хувийг төвлөрсөн цэгт дарж булшилдаг, хог хаягдал дахин боловсруулах жижиг дунд үйлдвэрүүд 2016 оноос эхлэн эрчимтэй байгуулагдаж, иргэд оршин суугч, аж ахуйн нэгж байгууллагууд нь хог хаягдлаа эх үүсвэр дээр ангилан ялгаж ажлыг хийж эхлээд байна. Хотын хэмжээнд шатахуун түгээх станц, нефтийн агуулахууд 6.37 га талбайд байршуулснаараа хүрээлэн буй орчныг нефтийн бохирдлоор бохирдуулж байна.

Нийслэлийн ногоон бүсийн ойн сангийн талбай 116257 га байх ба үүнээс ойгоор бүрхэгдсэн талбай 95234 га, ойгоор бүрхэгдээгүй талбай 17543 га байна. Нийслэлийн нутаг дэвсгэрт таримал ойн шаардлага хангаж, титэм нийлсэн таримал ой 13 га байгаагийн 1 га нь Толгойтын зүүн салаанд, Богдхан уулын Хүүшийн аманд 12 га тус тус бүртгэгдсэн байна. Ногоон бүсийн нутаг дэвсгэрт түймэрт өртсөн талбай 959 га, 0.2 га ба түүнээс доош өтгөрөлттэй тармаг модод 4812 га, ойжуулалтын шаардлага хангасан талбай 975 га байна.

Нийслэл Улаанбаатар хот нь 2018 оны байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 66.6 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд хотын эдийн засгийн 58.4 хувийг үйлчилгээний, 41.3 хувийг аж үйлдвэр, барилгын салбар,

0.4 хувийг хөдөө аж ахуйн салбар эзэлж байна. Нийслэлийн эдийн засагт худалдаа зочид буудал, зоогийн газар боловсруулах үйлдвэрлэл, уул уурхай, олборлолт, санхүү, бизнес, тээвэр, мэдээлэл, холбооны үйл ажиллагаа хамгийн их эзлэх хувийн жинтэй байна. Эдийн засгийн бодит өсөлт жилд дунджаар 8.7 хувь байсан ба хамгийн их өсөлт барилга, аж үйлдвэрийн салбарт гарсан байна. Нэг хүнд ногдох ДНБ 2018 онд зах зээлийн дүнгээрээ 14.96 сая төгрөг байна.

Улаанбаатар бүс нь босоо тэнхлэгт Ази, Европыг холбосон эдийн засгийн коридорын дагуу хийгдэж байгаа АН-3 хурдны авто зам, одоогийн төмөр зам, хэвтээ тэнхлэгт мянганы замын дагуу байрлаж байна. Мөн өмнө хэсэгт Хөшигийн хөндийд олон улсын нисэх онгоцны шинэ буудал ашиглалтад орсон нь чухал ач холбогдолтой байна.

Улаанбаатарын бүсэд Улаанбаатар хот, Налайх, Багануур, Багахангай дүүргүүд, хотыг тойрсон Сонгино-Био, Шувуу, Өлзийт, Гачуурт, Хонхор, Жаргалант, Рашаант, 361-н гарам, Тэрэлж гэх мэт төвлөрсөн хот, тосгод хамрагдана.



Эх сурвалж: RETalk Asia

Төлөвлөлтөөр Улаанбаатар хотын нийт нутаг дэвсгэрийг төлөвлөлтийн 47 нэгж хороололд хувааж, засаг захиргаа, худалдаа, үйлчилгээ, соёл, нийгмийн дэд бүтцийн үйлчилгээний иж бүрэн цогцолбор төлөвлөлтийг хийхээр тусгагдсан. Улаанбаатар хотын дагуул, хаяа хот тосгодыг түүхий эд боловсруулах, түлш эрчим хүч, уул уурхай, барилгын материалын болон хөдөө аж ахуй, хүнс хөнгөн үйлдвэрлэл, аялал жуулчлалын чиглэлээр хөгжсөн, оршин суугчдын амьдралын бизнес эрхлэх хөрөнгө оруулалтын тохилог, таатай орчин бүрдсэн 15 дагуул хаяа хот тосгодтой байхаар төлөвлөсөн.

Улаанбаатар хотын инженерийн дэд бүтцийн эх үүсвэрүүдийн хүчин чадал боломжит хэмжээнд байгаа боловч, дамжуулах түгээх сүлжээний хүртээмж харилцан адилгүй, насжилт өндөртэй, тоног төхөөрөмжүүд хуучирсан, сүлжээний алдагдал их байна. Цаашид төвлөрсөн сүлжээгээр хотын суурьшлын хэсгийг бүрэн хангах боломжгүй учраас бие даасан хэсэгчилсэн инженерийн хангамжийн шийдлийг хөгжүүлэх, шинэ техник технологийг нэвтрүүлэх шаардлага тулгарч байна.

Хотын цахилгаан эрчим хүч хэрэглэгчдийг Монгол Улсын төвийн эрчим

хүчний системээс буюу ДЦС-2, ДЦС-3, ДЦС-4 дүгээр цахилгаан станцуудаас “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ны Улаанбаатар салбарын 110кВ-ын 20 дэд станц, “Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ны эзэмшлийн 35кВ-ын 17 дэд станцаар дамжуулан цахилгаан эрчим хүчээр хангадаг. Нийслэлийн нутаг дэвсгэрт байрлах 3 дулаан цахилгааны станц нь нүүрсээр ажилладаг бөгөөд үр ашгийн түвшин нь олон улсын стандартаас доогуур байна. Нийт хэрэглэж буй нүүрсний 64.3 хувь буюу 3.2 сая тн нүүрсийг 4 дүгээр цахилгаан станц дангаараа хэрэглэж байгаа бол, 31.8 хувь буюу 1.6 сая тн нүүрсийг 3 дугаар цахилгаан станц, 3.9 хувь буюу 0.2 сая тн нүүрсийг 2 дугаар цахилгаан станц тус тус хэрэглэж байна. Нийслэлийн бүсийн эрчим хүчний хэрэглэгчдийг Төвийн эрчим хүчний системээс Улаанбаатарын Цахилгаан дамжуулах сүлжээ, Налайх, Багануур, Баянчандмань, мөн Эрдэнэт Булганы шугамаас цахилгаанаар хангаж байна. Цахилгаан шугам сүлжээний нийт урт 2600 км орчим байна.

Хотын оршин суугчдын дулааны эрчим хүчийг төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнээс буюу дулаан цахилгаан хослон үйлдвэрлэдэг ДЦС-2, ДЦС-3, ДЦС 4-р станцууд, Амгалан дулааны станцаас, халаалтын 170 зуухны газар буюу хэсэгчилсэн дулаан хангамжийн бие даасан системээс, ердийн галлагаатай зуух гэсэн 3 төрлөөр хангаж байна. Дулаан цахилгаан хослон үйлдвэрлэдэг ДЦС-2, 3, 4 станцууд, Амгалан дулааны станцын үйлдвэрлэсэн дулааны эрчим хүчийг 14 магистрал 379.5 км урт дулааны төв шугам, даралт өргөх насосын 9 станцаар дамжуулан 2951.7 Гкал/ц ачаалал бүхий 9200 гаруй барилга байгууламжийг дулаанаар хангаж байна.

2019 оны байдлаар Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулах шаардлагатай бүсэд төр болон хувийн хөрөнгө оруулалттай 100кВт-аас дээш хүчин чадалтай усан халаалтын зуух 290 байгууламжийн 507 зуух байна.

Улаанбаатар хотын ус хангамжид өдөрт 145,000-170,000м³ усыг олборлон нийлүүлж, батлагдсан нөөцийн 58 хувийг ашиглаж байгаа бөгөөд үйлдвэр, бусад салбарын усны хэрэглээ өдөрт-177000м³ байна. 2019 оны эхний хагас жилийн байдлаар Улаанбаатар хотын орон сууцны тоолууртай хэрэглэгчийн өдрийн хэрэглээ 127 литр, зөөврийн ус түгээх байраар үйлчлүүлж буй хэрэглэгчийн өдрийн хэрэглээ 7.3 литр, төвлөрсөн шугамд холбогдсон ус түгээх байраар үйлчлүүлж буй хэрэглэгчийн хэрэглээ 8.7 литр, 24 цагаар тасралтгүй ажилладаг ухаалаг ус түгээх байраар үйлчлүүлж буй хэрэглэгчийн өдрийн хэрэглээ 10.7 литр байна. Улаанбаатар хотын ус хангамжийг үндсэн 7, жижиг 3 эх үүсвэрийн 218 гүний худаг, 9 дамжуулан шахах насос станц, 586 км цэвэр усны шугам, 11 түгээх усан сан, 614 ус түгээх байраар дамжуулан хангадаг.

Улаанбаатар хотын барилгажсан хэсгийн ариутгах татуургын шугам сүлжээний барилга байгууламж нь бохир ус цуглуулах 20 гол коллекторын Ф150/1400мм голчтой 218.8 км шугамаар дамжин төв цэвэрлэх байгууламжид цэвэрлэгдэж байна.

Улаанбаатар хот нь бохир усны төв цэвэрлэх байгууламжаас гадна 8 бага оврын цэвэрлэх байгууламжтай. Хотын хүн амын 60 хувь нь төвийн шугам сүлжээнд холбогдсон байна. Гэр хорооллын айл өрхүүд нүхэн болон био жорлонгуудад бохир усаа хаядаг. Одоогийн байдлаар төв цэвэрлэх

байгууламж нь хоногт дунджаар 160,000-190,000м³ бохир усыг хүлээн авч механик болон биологийн цэвэрлэгээг хийж, хэт ягаан туяагаар халдваргүйжүүлж Туул голд нийлүүлж байна.

2011 оноос интернет, телевиз, яриа хосолсон гурвалсан /triple play/ үйлчилгээний хэлбэр нэвтрүүлэхээр техникийн боломжийг бий болгон Мобиком, Скайтел, Юнител компаниуд хэрэглээнд нэвтрүүлж эхэлсэн. Одоогийн байдлаар Монгол Улсын нийт интернет хэрэглэгчийн тоо 2.6 сая хүрч, 2010 оноос 13 дахин өссөн ба 2016 оноос 8.5 хувь илүү өссөн байна. Интернет протоколд суурилсан олон сувгийн үйлчилгээ эрхлэгчдийн тоо 642.0 мянга буюу орон сууцтай өрхийн 92 хувьд нэвтэрсэн. Харилцаа холбооны системийн технологийн хөгжил хурдацтай байна.



Эх сурвалж: <https://kvartira.mirtesen.ru/>

Авто замын сүлжээ

Улаанбаатар 2018 онд 401.7 мянган тээврийн хэрэгсэл тоологдож 2013 оны суурь түвшинтэй харьцуулахад тээврийн хэрэгслийн тоо 64 хувиар өссөн дүн гарсан. Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийт авто замын сүлжээний нийт урт 1051.5 км байна. Хотын барилгажсан нутаг дэвсгэрт хатуу хучилттай авто замын дундаж нягтрал 2.1 км/км² байгаа нь олон улсад харьцуулахад 21 дахин бага байна.

Улаанбаатар хотод нийтийн тээврийн 34 байгууллагын 1225 автобус, 609 такси бүртгэлтэйгээс өдөрт шугамд 866 тээврийн хэрэгсэл, нийтийн тээврийн үндсэн 83, туслах 15, хот орчим 14, буухиа 17 нийт 130 чиглэлд, 3629.7 км чиглэлийн урттай үйлчилж байна. Мөн өдөр тутамд 609 такси тээврийн хэрэгсэл иргэдэд үйлчилж байна.

Улаанбаатарын бүсийн доторх хаяа дагуул хот суурингууд, дорвитой хөгжиж чадахгүй байгаагийн улмаас логистикийн үйл ажиллагаа сул хөгжсөн. Ачаа тээврийн эргэлт нь агаарын тээвэр, авто тээвэр, төмөр замын тээвэр гэсэн 3 төрлөөр хөгжиж байна. Ачаа эргэлт нь олон улсаас Улаанбаатар хотыг чиглэсэн, Улаанбаатар хотыг дамжин өнгөрөх, Улаанбаатар хотоос гадагш чиглэсэн урсгалтай байна. Одоогоор төмөр замын үндсэн магистрал даган

ихэнхдээ хотын 1 ба 2 дугаар бүсэд байрласан ачааны 9 терминал байна. Нийт зам талбайн хэмжээ нь 271923 м2, салаа төмөр замын урт 10136 м, ачаа ачиж буулгах талбай 53502 м2, хяналтын талбай 74212 м2 байна. Нийт 40000 м2 талбайтай 11 дулаан, 28000 м2 талбайтай 37 хүйтэн агуулахтай байна.

1992 онд шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш Улсын Их Хурлаас Нийслэл хот болон, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгонтой холбоотой хууль эрх зүйн орчныг бүрдүүлсээр ирсэн хэдий ч нийслэл хотын хүн амын өсөлт, төрийн байгууллагын төвлөрөл, үйлдвэрлэл, эдийн засгийн төв бүс нутаг болж хөгжсөнтэй холбоотойгоор эрх зүйн зохицуулалтын хувьд тодорхой хүндрэл, бэрхшээлтэй асуудлууд тулгарч байна. Тухайлбал, 2019 онд нийслэлийн хэмжээнд орчны аюулгүй байдал алдагдсан 5'423 зөрчил дутагдал илэрч, нийт зөрчил дутагдлын дийлэнх буюу 25 хувь нь явган замын засвар ашиглалт, 11.5 хувь нь авто замын эвдрэл, орц гарц, 21 хувь нь инженерийн шугам сүлжээний ашиглалт зэрэг асуудлууд эзэлж байх тул амьдралын таатай орчныг хэмжих хотын стандартуудыг баталж, мөрдүүлэх шаардлагатай байна.

Төрийн бодлого нь гуйвж шарвахгүй, түмэн олон нь улс орны хөгжлийн төлөвийн талаар нэгдсэн ойлголттой байж, зөвшилцөлд хүрэхэд Монголын хөгжлийн урт хугацааны бодлого онцгой үүрэг гүйцэтгэнэ. Хөгжлийн бодлого нь улс төрийн орчноос үл хамааран төрийн бодлогод тусч, хэрэгжих ёстой. Цаг үеийн нөхцөл байдал, шинэ судалгааны үр дүнгүүдэд суурилан өөрчлөгдөж, улам баяжин хөгжих 'амьд' баримт бичиг байх нь зүйн хэрэг юм. Энэ бодлогын баримт бичгийн төсөл нь Монгол төрийн бодлого мэргэн байж, үр дүнтэй хэрэгжихэд тус дэм болно гэдэгт итгэл дүүрэн байна.



МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

2020–2050 ОН





1 ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ

Орчин үеийн шинжлэх ухааны арга зүйгээр нарийвчлан судалж, хөдөлшгүй бодит баримтад үндэслэсэн “нэг хэл, нэг түүх, нэг соёл, нэг итгэл үнэмшлийг” нийт хүн амд төлөвшүүлж, үндэсний ижилсэл-ондоошлын гүн ухамсар дархлаатай үндэстэн-улс байгуулахад тулгуур болохуйц нэгдмэл үнэт зүйлсийг цогцлооно.

2 ХҮНИЙ ХӨГЖИЛ

Чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалтай, аз жаргалтай амьдралын ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн нийгмийн идэвхтэй МОНГОЛ ХҮН-ийг хөгжүүлж, Хүний хөгжлийн индексийг 0.9-д хүргэж, аз жаргалын индексээр эхний 10 орны тоонд багтах болно.

3 АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, идэвхтэй бүтээлч гэр бүлийг төлөвшүүлэн, хэрэгцээндээ нийцсэн байр сууц бүхий, хөрөнгө оруулалтын таатай орчин, нөхцөлд өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэн өрх, гэр бүл, өөрийгөө тэтгэн амьдрах боломжтой, сэтгэл хангалуун амьдрах нөхцөлөөр тэтгэгдсэн дундаж давхаргыг 2050 он гэхэд нийт хүн амын 80 хувьд хүргэх болно.

4 ЭДИЙН ЗАСАГ

Урт хугацааны хөгжлийн бодлогын үр дүнд эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засгаа бүрдүүлж чадсан улс орон болно. Ингэснээр 2050 он гэхэд ДНБ 6.1 дахин, нэг хүнд ногдох ДНБ 3.6 дахин нэмэгдэж 15000 ам.долларт хүрнэ.

5 САЙН ЗАСАГЛАЛ

Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг - тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр - хувийн хэвшил - иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүхий л хүрээнд өргөжин, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно.

6 НОГООН ХӨГЖИЛ

Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж байгаль орчны тогтвортой байдлыг ханган, үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлэн, хүний амьдралын чанарыг сайжруулна.

7 АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ

Улсын батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангана.

8 БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ

Үндэсний соёлоо дээдэлсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцад нэгдсэн, өрсөлдөх чадвартай, харьцангуй тэнцвэртэй бүсүүдийг хөгжүүлэнэ.

9 УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ

Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ



ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ

ДЭЛХИЙН МОНГОЛ

НҮҮДЛИЙН СОЁЛ ИРГЭНШИЛТ
МОНГОЛ

МОНГОЛ ХЭЛ БИЧИГ

ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ЭВ НЭГДЭЛ

ЭРДЭМ СУДЛАЛ, НИЙГМИЙН СОЁН
ГЭГЭЭРЭЛ

ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ

“Үнэт зүйл” гэсэн ойлголт аливаа улс үндэсний хувьд дотоод мөн чанар, ижилсэл-ондоошил (“national identity”)-той уялдаатай байдаг. Ард түмний оюун санаа, хүсэл эрмэлзэл, дотоод мөн чанарын нэгдлийг олох нь аливаа улс орны хувьд амин чухал асуудал байдаг бөгөөд энэ нь улс орнуудын оршин тогтнох, хөгжин дэвжихийн үндэс болдог.

Монголчууд монголоороо аж төрж, бусдаас ялгаран орших чухал хүчин зүйл нь үндэсний соёл гэж үзвэл юуны түрүүнд монгол үндэсний нэгдмэл үнэт зүйлсийг тодорхойлж, түүнийг төрөөс бодлогоор дэмжин цогцлоох нь эн тэргүүний зорилго болно.

Хүн төрөлхтөний соёл, эдийн засаг, нийгмийн бүхий л салбарт нэгдэн нийлэх үйл явц бий болж, даяаршил нэгэнт бодитой болсон энэ онцлог цаг үед үндэстэн өөрийн төрөлх язгуур шинжээ хадгалах нь тухайн үндэстний оршин тогтнох эсэхийг шийдэх гол арга зам юм. Тухайн улс, үндэстэн, угсаатны соёлын үнэт зүйлд харшлах гадны соёлын сөрөг хэлбэрийг эсэргүүцэх, түүнээс зайлсхийх, өөрт ашигтай шинэ цагийн соёлд дасан зохицох, хүлээн зөвшөөрөх гэсэн хариу үйлдлүүд буюу үндэсний соёлын дахин давтагдашгүй цогц байдлыг хадгалах чадвар нь соёлын дархлаатай байх боломж юм. Тиймээс үндэстний язгуур шинж, ижилсэл, ондоошлыг хадгалах гол хүчин зүйл нь үндэсний нэгдмэл үнэт зүйл, түүнд тулгуурласан соёлын дархлаа билээ.

Хүн ёс, хүн чанар, хууль ёс, мэдлэг боловсрол, ёс суртахуун, тэгш байдал, шударга ёс, эрх чөлөө, эв эе, эрдэм, эв дүй, иргэдийн оролцоо, нийтэд ил тод байх, эрхэмлэх шүтээн, бишрэл, итгэл үнэмшил, эрүүл мэнд, хариуцлагатай байдал, бүтээлч чанар, өөртөө итгэлтэй байдал зэрэг



Эх сурвалж: Хү хамтлагийн албан ёсны цахим хуудас

хувь хүний болон нийгмийн үнэт зүйлсийг олноор дурдаж болох боловч тусгаар тогтнол бүхий ЭХ ОРОН, газар нутаг, тэнд оршин суугч МОНГОЛ ХҮН, үндэстний дахин давтагдашгүй шинж чанарыг хадгалах НҮҮДЛИЙН АХУЙ, түүнээс урган гарсан ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛ, УРЛАГИЙН БҮТЭЭЛ, орчин үетэй хөл нийлүүлэн хөгжих УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛИЙН ТӨГС ЗОХИЦОЛ-гүйгээр дээрх бүгд ухвар мөчид болох юм. Нөгөөтээгүүр хувь хүний болон нийгмийн түвшний үнэт зүйлс нь үндэсний онцлогтой нягт уялдаж, эх орны эрх ашиг, монгол хүний онцлог, нүүдлийн ахуй, түүх, соёл, урлагийн бүтээлдээ уламжлал, шинэчлэлийн тэнцвэрт харьцаанд шингэн сүлэлдэж ҮНДЭСНИЙ ИЖИЛСЭЛ-ийг бүтээх учиртай. Иймд энэ зорилгын хүрэх үр дүнг дараах байдлаар тодорхойллоо.



Орчин үеийн шинжлэх ухааны арга зүйгээр нарийвчлан судалж, хөдөлшгүй бодит баримтад үндэслэсэн “нэг хэл, нэг түүх, нэг соёл, нэг итгэл үнэмшлийг” нийт хүн амд төлөвшүүлж, үндэсний ижилсэл-ондоошлын гүн ухамсар дархлаатай үндэстэн-улс байгуулахад тулгуур болохуйц нэгдмэл үнэт зүйлсийг цогцлооно.



Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн хөгжлийн үе шатуудыг тодорхойллоо.

ДЭЛХИЙН МОНГОЛ

ЗОРИЛТ 1.1 Дэлхий дахинд Монгол үндэсний үнэт зүйлсийн дархлаа тогтож, монгол соёлыг түгээн дэлгэрүүлж, гадаад нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлэх, хилийн чанад дахь монголчууд, монгол угсаатны хамтын ажиллагаа төлөвшинө.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
МОНГОЛ СОЁЛЫН ХҮРЭЭ	МОНГОЛ СОЁЛЫН ОРОН ЗАЙ	МОНГОЛ СОЁЛЫН ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭЛТ
Олон улс дахь Монгол үндэсний үнэт зүйлсийн дархлааг бэхжүүлж, монгол соёлын хүрээг тэлэх үе	Монгол Улсын гадаад нэр хүнд, үнэлэмж дээшилж, монгол соёлыг түгээн дэлгэрүүлэх үе	Олон улс дахь Монгол үндэсний үнэт зүйлсийн дархлаа тогтож, нүүдэлчин монгол соёлын түрэлт бий болох үе
<ol style="list-style-type: none"> Монгол хүний үнэт зүйлийг хүн бүрд хэвшүүлж, бусдаас ялгарах онцлог давуу талаа дэлхий нийтэд таниулах Монголын түүх, соёлыг олон улсад, дэлхий нийтэд сурталчлан таниулах Монголын Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг /МОУХАН/, MICA / Mongolian International Cooperation Agency/ олон улсын байгууллагыг байгуулах Хилийн чанад дахь монгол соёлын өвийг хамгаалах Үндэсний соёл, спорт, хоол хүнс судлалыг хөгжүүлж, дэлхийд таниулах 	<ol style="list-style-type: none"> Дэлхийд оюунаараа өрсөлдөхүйц иргэнийг бэлтгэх Монголын түүх, соёлыг олон улсад, дэлхий нийтэд сурталчлан таниулах хөтөлбөрүүдийг өргөжүүлэх Хилийн чанад дахь монголчууд, монгол угсаатнуудын оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэн өргөжүүлж, хэл, соёл, уламжлалаа хадгалан хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх Үндэсний соёл, спорт, хүнс хоолны үйлчилгээг түгээн дэлгэрүүлэх 	<ol style="list-style-type: none"> Монгол соёлыг олон улсын хэмжээнд сурталчлан таниулах үндэсний онцлог бүхий соёлын хөтөлбөрүүд бий болгох, түгээх Дипломат харилцаатай дэлхийн улс бүрд “Нүүдлийн соёл иргэншлийн төв” байгуулах, тус төвөөр дамжуулан Монголын соёлыг түгээн дэлгэрүүлэх Үндэсний агуулга бүхий олон ангит кино, тайз, дэлгэцийн бүтээлийг хөгжүүлж түгээх Нүүдэлчдийн давуу талд суурилсан менежментийн ур чадварыг хөгжүүлэх, улмаар монгол соёлын түрэлт бий болгох

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 1.1.1. Монгол хүний бусдаас ялгарах онцлог давуу талыг “Бүтээлч сэтгэлгээ, оюуны чадвар өндөр, дасан зохицох чадвартай, эрчист Монгол” хэмээн тодорхойлж, энэ чанарыг хүн бүрд хэвшүүлж, хүүхдийг бага наснаас нь төлөвшүүлнэ.
- 1.1.2. Монгол хүнийг насан туршид нь хөгжүүлэхдээ ураг байх үеэс эхлэн хүний нас, хөгжлийн онцлогт тохирсон эрүүл мэнд, соёл урлаг, боловсролын цогц уялдаатай үйлчилгээ үзүүлнэ.
- 1.1.3. Дэлхийд танигдсан оюуны болон соёлын өвийг бүтээгч хувь хүн, баг, хамт олныг дэмжиж алдаршуулах, дараа үеийнх нь залгамж халааг бэлтгэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ. Эдгээр оюуны болон соёлын, биет бус өвийн бүтээлүүдийг дагасан уламжлал, ёс заншил, үндэсний онцлог бүхий брэнд үйлдвэрлэлийг хөгжүүлж экспортлох боломжийг нэмэгдүүлнэ.
- 1.1.4. Олон улсын түвшинд зохион байгуулагдаж буй олимпиад, уралдаан, тэмцээнд оролцож, амжилт үзүүлсэн суралцагч, багш, багийг дэмжиж урамшуулан алдаршуулна.
- 1.1.5. Монголын Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг /МОУХАН/, MICA /Mongolian International Cooperation Agency/ олон улсын байгууллагыг байгуулж, гадаад харилцаа, хамтын ажиллагааны цар хүрээг өргөжүүлнэ.
- 1.1.6. Нүүдэлчдийн соёлыг олон улсад сурталчлах үндэсний агуулга бүхий олон ангит кино, бүжгэн жүжиг, багт бүжиг гэх мэт урлаг, соёлын хөтөлбөр, агуулгыг бий болгон хөгжүүлж, тогтмол зохион байгуулагддаг үйл ажиллагаа, хөтөлбөрүүдийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгон дэлхий нийтэд таниулан хэрэглэж хэвших ба үндэсний онцлогтой 4 улирлын аялал жуулчлалын хөтөлбөрүүд бий болгоно.
- 1.1.7. Хилийн чанад дахь монгол иргэдийг дэмжих, өв соёлоо хадгалж хамгаалахад нь дэмжлэг үзүүлэх, монгол хэл, соёлын агуулга бүхий сурах бичиг, ном товхимол, цахим агуулга, бүтээлүүд бий болгон түгээх, монгол иргэд болон монгол төрийн харилцаа, хамтын ажиллагааг дэмжсэн “Дэлхийн монголчууд” хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлнэ.
- 1.1.8. Дэлхийн монгол туургатнуудад нүүдлийн соёл, уламжлалаа хадгалж үлдэх, ахуй соёлын онцлог, нийтлэг болон ялгаатай байдлыг харьцуулсан судалгаа хийх, чуулга, уулзалт, томоохон фестиваль үйл ажиллагааг хамтран зохион байгуулж хэвших, энэ чиглэлээр “Монгол туургатны хэл, соёл, уламжлалыг хадгалж хөгжүүлэх” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.1.9. Хилийн чанад дахь монгол соёлын өвийг сурвалжлан олох, судлах, нэгдсэн каталог хийх, эх орондоо эргүүлэн залах, энэ чиглэлээр бусад улс оронтой идэвхтэй хамтран ажиллана.

- 1.1.10. Хилийн чанад дахь монголчууд, монгол угсаатнуудын оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэн өргөжүүлж, хэл, соёл, уламжлалаа хадгалан хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх ба монгол хэл, соёлын төвүүдийн үйл ажиллагааг дэмжин өргөтгөж, тухайн улс орны монгол хэл, соёлын сургалт, хөтөлбөрүүдийг бий болгон хэрэгжүүлнэ.
- 1.1.11. Монгол хүний үнэлэмжийг дэлхий дахинд нэмэгдүүлэх, нэр хүндээ өндөрт авч явах шаардлагыг хүн бүрд тавих ба ёс зүйн зөрчил, хулгай, залилан, хүчин гэх мэт гэмт хэрэгт холбогдож байсан иргэдийг гадаадад зорчих эрхийг тодорхой хугацаагаар хязгаарладаг эрх зүйн зохицуулалт хийнэ.
- 1.1.12. Монголын уламжлалт 5 өнгийн идээ ундаа / цагаан идээ (цагаан), мах шүүс (улаан), тосон төрлийн идээ (шар), үр тариа, эмийн ургамал, жимс жимсгэнэ (ногоон), архи, рашаан ундаа (хар)/-ыг ашиглан дөрвөн улирал, хүний насны онцлогт тохирсон хоол, тэжээл-сор бүтээгдэхүүнийг хөгжүүлж, улмаар дэлхийд таниулж, монгол хүнс хоолны сүлжээ байгуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.
- 1.1.13. Монголын уламжлалт спорт, наадам, наадгайг (бөх, сурын харваа, шагайн харваа гэх мэт) хөгжүүлэх, үндэсний баг, тамирчдаа дэмжих, морин болон тэмээн спортын (морин поло, тэмээн поло) төв байгуулж үндэсний багтай болох, гадаад, дотоодын баг, тамирчдын урьж тоглуулах тогтолцоог хөгжүүлж, спортын зарим төрлүүдийг олон улсын болон олимпын төрөлд оруулах, түүгээр дамжуулан өөрийн орны соёлыг түгээн дэлгэрүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ.
- 1.1.14. Түр байрлах, соёл урлагийн арга хэмжээ зохион байгуулах, байгалийн гамшиг, цэрэг дайн, самууны улмаас дүрвэгсэд, хуарангийн үйл ажиллагаанд тохируулан гэр, банагийг хөгжүүлэн хялбаршуулж, олон улсын хэрэглээ болгон түгээн дэлгэрүүлнэ.
- 1.1.15. Үндэсний оньсон тоглоомыг хөгжүүлэн оюун ухаан тэлэх тоглоом болгон хөгжүүлж, цахим хувилбарыг нь бий болгон олон улсад түгээж, онлайн бизнес болгон хөгжүүлнэ.



Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, 2019

НҮҮДЛИЙН СОЁЛ ИРГЭНШИЛТ МОНГОЛ

ЗОРИЛТ 1.2 Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээгч монгол хүн төвтэй нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болно.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020-2030)	II үе шат (2031-2040)	III үе шат (2041-2050)
ӨВ СОЁЛОО ДЭЭДЛЭГЧ СОЁЛЫН ДАРХЛАА БҮХИЙ МОНГОЛ ХҮН	ҮНДЭСНИЙ ИЖИЛСЭЛ БҮХИЙ АЗИЙН МОНГОЛ	НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛСИЙГ БҮТЭЭГЧ НҮҮДЛИЙН СОЁЛ ИРГЭНШИЛТ ДЭЛХИЙН МОНГОЛ
Нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлэх үе	Монголчуудын үндэсний ижилсэл бэхжиж, нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болох үе	Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээгч монгол хүн төвтэй нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болох үе
<ol style="list-style-type: none"> 1. Хүмүүнлэг, оюунлаг, ёс суртахуунтай, үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай монгол хүнийг бэлтгэх 2. Нүүдлийн соёл иргэншлийг хамгаалахад чиглэсэн төрөлжсөн байгууллагуудыг дэмжих 3. Үндэсний сор бүтээл /Brand/, үндэсний шинэлэг бүтээл /content/ зэргийг Монголын нүүдлийн соёлын онцлогт тохируулан бүтээх үйл явцыг өрнүүлэх 4. Хүүхдийн соёлын өв, хөгжлийн төв байгуулах 	<ol style="list-style-type: none"> 1. Үндэсний үнэт зүйлд суурилсан соёлын дархлааг тогтвортой бэхжүүлж, уламжлал шинэчлэлийн тэнцвэрт харьцааг хэвшүүлэх 2. Байгаль дэлхийд ээлтэй нүүдлийн соёл иргэншлийн бэлгэ тэмдэг болсон монгол гэрийг сайжруулан хэрэглэхэд хялбар болгон түгээн дэлгэрүүлэх 3. "Нүүдлийн соёл иргэншлийн үндэсний хүрээлэн"-г өндөр уулын бүсэд байгуулснаар үндсэн таван бүс бий болж, аажмаар өргөтгөх, эрс өндрийн нүүдлийг сэргээх 4. Соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах, бүтээн үргэлжлүүлэх, өвлөн уламжлах үйл ажиллагаанд оролцогч талуудыг дэмжих 	<ol style="list-style-type: none"> 1. Үндэсний өв соёл, нүүдлийн ахуй бүрэн хамгаалагдаж, уламжлал, шинэчлэлийг хослуулсан, нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болох 2. "Нүүдлийн соёл иргэншлийн үндэсний хүрээлэн"-гүүдийн үйл ажиллагааг уялдуулж, нүүдлийн соёл иргэншлийн тэргүүлэх улсын түвшинд хүрэх 3. Үндэсний ижилсэл, өв соёлын талаарх ард нийтийн хандлага бүрэн төлөвшихөд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 1.2.1. Монгол гэр бүл бол соёлын төрөл зүйлийг цогцоор нь шингээсэн соёлын голомт учир “Гэр бүл-Монгол соёлын анхдагч орчин” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж “Монгол хүүхэд”, “Монгол гэр бүл”, “Монгол төрийн гэр бүлийн талаарх бодлого” гэсэн гурвалсан холбоо үүсэх юм. Монгол гэр бүлийг уламжлалт соёлын ахуй орчин болохынх нь хувьд төрөөс дэмжих, гэр бүлийн уламжлалт үнэт зүйлсийг хадгална.
- 1.2.2. Иргэн бүрийг угийн бичигжүүлэх, өвөг дээдэс, угийн хэлхээгээ мэддэг болгохоос гадна иргэний бүртгэлийн мэдээллийн системд угийн хэлхээг тодорхойлон монгол хүний удмын санг хамгаална.
- 1.2.3. Дэлхийд ховор мал аж ахуйд суурилсан нүүдэлчин соёл, түүний унаган төрхөөрөө хадгалагдан үлдсэн өвөрмөц байдал, олон угсаатны бүлгүүдийн зэрэгцэн орших сонирхол татам соёлын илрэлүүд, хүн амын гарын ур дүй, хийж бүтээх авьяас, нутгийн олон түмний эелдэг найрсаг, зочломтгой зан хийгээд бахархам түүх. Энэ бүгд Монголын аялал жуулчлалын гол дүр төрх мөн. Тиймээс “Өөрсдийн язгуур соёл, түүний өвөрмөц илрэлийг аяллын бүтээгдэхүүн болгохдоо ойлгомжтой, хүртээмжтэй, өөриймсөг, жинхэнэ мөн чанараар нь хүргэхийг урьтал болгож түүндээ санхүү, эд материал, хүн хүчний нөөцийг хангалттай зориулж эцсийн үр дүндээ үндэсний соёлыг гайхан биширч, хүндлэх хандлагыг буй болгох” гэсэн гол өгөөжийг бүтээх, ялангуяа дотоодын жуулчдад үндэсний өв соёл, нүүдлийн ахуйдаа суралцах, түүгээрээ бахархах үзэл төлөвшүүлж, соёлын дархлааг нь дэмжинэ. Нөгөө талаар нүүдлийн соёл, ахуйг хадгалж, тээж яваа малчин өрх, өв соёлоо дээдлэгч монгол гэр бүлийн нийгэм, эдийн засгийн асуудлыг дэмжих нэгдсэн тогтолцоо бүрдүүлж, хэрэгжүүлнэ.
- 1.2.4. Боловсролын нэгдсэн тогтолцоо, сургалтын хөтөлбөрт нүүдэлчин ахуй, зан заншил, өв соёлын агуулгыг тусгаж, цэцэрлэгт үндэсний өв соёл, уламжлалт тоглоом наадгай хангаж, хүүхэд багачууд, суралцагчдад энэ төрлийн мэдлэг, чадвар эзэмшүүлнэ.
- 1.2.5. Хүүхэд залуучуудын театр, хүүхэлдэйн театр, номын сан, кино театр, дугуйлан, цэцэрлэгт хүрээлэн гэх мэт соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх хүүхэд хөгжлийн төвүүдийг дэмжих, шаардлагатай тоног төхөөрөмж, номын хөмрөг, хувцас хэрэглэлээр хангана. Номын сангийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.
- 1.2.6. Үндэсний ижилсэл, соёлын дархлаатай монгол хүнийг бэлтгэхэд чиглэсэн өв соёлын өргөө, соёлын төвүүд, үндэсний спортын дугуйлангуудын үйл ажиллагааг дэмжих ба Соёлын биет бус өв, язгуур урлагийн шавь сургалтыг бий болгосон бүлэг, хамт олон, өвлөн уламжлагчдыг дэмжиж, урамшуулах тогтолцоог бий болгоно.
- 1.2.7. Улс орон даяар үнэт зүйлс, үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр гарсан судалгааны үр дүнгээр зорилтот нэвтрүүлгүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлж, үндэсний хэмжээний цуврал лекц, ярилцлага зохион байгуулагчдыг төрөөс дэмжинэ.
- 1.2.8. “Дэлхийн нүүдлийн соёл, иргэншлийн голомт” байгууллагыг байгуулах, Дэлхийн нүүдэлчдийн төв болох цогц хөтөлбөрийг төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлнэ.
- 1.2.9. “Нүүдлийн соёл иргэншлийн үндэсний хүрээлэн”-г бүс нутгийн онцлогт тохируулан байгуулах буюу Говийн бүсэд палеонтологийн задгай музей, хангайн бүсэд археологийн хотууд (Хүннүгийн язгууртны, буган хөшөөний цогцолбор, Өглөгчийн хэрэм, Аваргын балгас г.м.), Хөвсгөл, тайгын бүсэд цаатны отог, дархад бөөгийн отог, Даян дээрхийн агуйн цогцолбор, Монголын Эзэнт гүрний түүх, нүүдэлчдийн өв соёлын онцлогтой “Нүүдэлчин” олон улсын түвшний кино үйлдвэрлэлийн төвийг тус тус байгуулах ба тэдгээрийг дагасан аялал, жуулчлалын хөтөлбөрүүд бий болгож хөгжүүлнэ.
- 1.2.10. Улаанбаатар хотын хурдны тойрог зам дагуу “Соёл, урлагийн цогцолбор”, Монгол багт бүжгэн жүжгийн театр байгуулах, энэ төрлийн бүжгэн жүжгийн цомнол, бүтээлүүд бий болгох, урлагийн сургалт, уран бүтээлийг үндэсний өв, соёлд түшиглэн орчин цагийн бүтээл /контент/ хөгжүүлэх, судалгааны инкубатор төвийг төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан байгуулж үйл ажиллагааг нь дэмжинэ.
- 1.2.11. Соёлын үйлдвэрлэл, соёлын бүтээлч аялал жуулчлалыг Монголын нүүдлийн соёлын онцлогт тохируулан нутагшуулж, үндэсний загвартай болох, үндэсний үнэт зүйлийг бүтээх, хадгалах, хамгаалах, аялал жуулчлалын эргэлтэд оруулахад зориулсан мэдээллийн систем, цахим технологи нэвтрүүлнэ.

МОНГОЛ ХЭЛ БИЧИГ

ЗОРИЛТ 1.3. Монгол хэл бичгээ үндэсний үнэт зүйлийн бүрдэл болгон иргэн бүр чанартай эзэмшиж хэрэглэж хэвшинэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
МОНГОЛ ХЭЛ БИЧИГ-ОРШИХУЙН ДАРХЛАА	МЭДЛЭГ ШИНГЭСЭН МОНГОЛ ХЭЛ	МОНГОЛ ХЭЛ БИЧИГ-ҮНДЭСНИЙ ҮНЭТ ЗҮЙЛ
Үндэсний монгол хэл, бичгээ чанартай эзэмшиж, хэрэглэж хэвших үе	Мэдлэг шингэсэн монгол хэл бий болгох үе	Монгол хэл, бичиг үндэсний нэгдмэл үнэт зүйлийн бүрдэл болж төлөвших үе
<ol style="list-style-type: none"> 1. Хүн бүрийн эх хэлний боловсролыг дээшлүүлэх, бүх шатны сургалтын байгууллагад монгол хэл, бичгийн боловсролыг суралцагчдад чанартай эзэмшүүлэх 2. Монгол хэл, бичгийг нийтээр болон гадны иргэд эзэмших таатай нөхцөл бүрдүүлж, нийтийн болон албан хэргийн түвшинд зөв хэрэглэж хэвших, албан хэргийг хос бичгээр хөтлөх 3. Үндэсний хэл, бичгийн хэрэглээний уламжлалыг хадгалж, шинэчлэлийг хийхэд шинжлэх ухааны байгууллагуудыг дэмжих 4. Монгол хэлийг суралцагч гадаад иргэдийг дэмжих тэтгэлэгт хөтөлбөрүүд болон олон улсад зориулсан Монгол хэлний шалгалтын үндэсний хөтөлбөрийг бий болгох 	<ol style="list-style-type: none"> 1. Мэдлэг шингэсэн монгол хэлний орчин бүрдүүлж, монгол хэлний үгсийн баялаг санг хамгаалах сан хөмрөг бий болгох 2. Монгол хэлийг хамгаалж, мэдлэг шингэсэн монгол хэлийг бүтээх 3. Гадаад улс орнуудад байгуулагдсан болон шинээр байгуулах монгол хэл, соёлын төвүүдийг дэмжих 	<ol style="list-style-type: none"> 1. Ард нийтийн монгол хэл, бичгийн боловсролыг төгөлдөржүүлэх, нэгдмэл үнэт зүйл болгон төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх 2. Монгол хэлтэй гадаад хүмүүс, тэднээр дамжин монгол хэлийг гадаадад сурталчлах болон сургах үйл ажиллагааг эрчимжүүлж, монгол хэлний орчин бий болгох

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.3.1. Дэлхийн шинжлэх ухаан, техник, технологийн нэршил, нэр томъёог монгол хэлэнд нутагшуулан баяжуулах, Мэдлэг шингэсэн монгол хэлний үгсийн санг бий болгох ажлыг тогтмолжуулж, нийтийн хялбаршуулсан болон шинжлэх ухааны салбар бүрийн мэргэжлийн нэр томъёоны толиудыг боловсруулах, цахим хэлбэрээр түгээх, нийтийн хэрэглээнд нэвтрүүлнэ.

- 1.3.2. Монгол хэл, бичгийн хэрэглээнд учирч буй бүх төрлийн алдаа, гажуудлуудыг арилгах, хүн бүр эх хэл, соёлоо дээдэлж зөв бичиж хэрэглэж хэвших, байгууллага, хамт олон нийгмийн хариуцлагын хүрээнд монгол хэл, бичгээр зөв бичсэн мэдээ, мэдээлэл нийтэлдэг болгон хэвшүүлнэ.
- 1.3.3. Төрийн болон албан хэрэг хөтлөлтийн монгол хэл, бичигт тавигдах шалгуур үзүүлэлтийг өндөрсгөж хариуцлагын тогтолцоонд шилжих, төрийн албан хаагчаас монгол хэлний шалгалт авч, шалгуур хангасан байх шаардлага тавихаас гадна төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулах бэлтгэлийг бүрэн хангаж хөтөлнө.
- 1.3.4. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа бүх байгууллагын нэр хаягийг монгол бичиг, кирилл бичгээр бичих тухай журамлаж стандарт мөрдүүлэн нийгмийн соёлыг дээшлүүлнэ.
- 1.3.5. Нутгийн хэл, соёл, аман аялгууг хадгалах, хамгаалах чиглэлд бүтээлч хөтөлбөрүүд хэрэгжүүлэх ба монгол хэл, бичгийг гадаад, дотоодод түгээн дэлгэрүүлж буй байгууллага, багш, суралцагчдыг урамшуулах, дэмжинэ.
- 1.3.6. Гадаад иргэдэд монгол хэл заах сургууль, тэнхимийг нэмэгдүүлж зуны сургалтыг дэмжинэ.
- 1.3.7. Гадаадад сурч, ажиллаж амьдарч байгаа Монгол улсын иргэд, ялангуяа хүүхэд багачуудад монгол хэл бичиг сурах эх, хэрэглэгдэхүүн бүтээж түгээх, Монгол хэлээ олон улсад сурталчлах, монгол хэлээр ярилцагч гадаад иргэдийг алдаршуулна.
- 1.3.8. Үндэсний монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлж “Монгол бичиг”-ээр хэвлэгддэг ном, сонин, сэтгүүлийг нэмэгдүүлэн хэвлэлийн газар байгуулах ба нөгөө талаар Монгол хэл, бичгийн цахим хэрэглээг нэмэгдүүлнэ.



Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, 2019

ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ЭВ НЭГДЭЛ

ЗОРИЛТ 1.4. Төрт ёсны уламжлал, түүх соёлын дурсгал, утга зохиол, урлагийн бүтээлээр үндэсний бахархал төлөвшүүлж, эх оронч үзэл, эв нэгдлийг нягтруулна.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ ДОР ЭВ НЭГДЛИЙГ ДЭЭДЛЭГЧ МОНГОЛ	ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ-ЭВ НЭГДЛИЙН ГАГНААС	НЭГДМЭЛ ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, НЯГТАРСАН ЭВ НЭГДЭЛ
Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, хамтын үнэт зүйлс, тэмүүлэл, эх оронч үзэл, эв нэгдлийг бэхжүүлэх үе	Үндэсний бахархлыг иргэн бүрийн үйл хэрэгт шингээж, түүнд тулгуурласан үндэсний эв нэгдлийг төлөвшүүлэх үе	Төрт ёсны уламжлал, түүх соёлын дурсгал, утга зохиол, урлагийн бүтээлээр үндэсний бахархал төлөвшиж, эв нэгдэл нягтрах үе
1. Монголчуудын уламжлалт төрт ёсоо дээдлэх эх оронч үзэл, үндэсний эв нэгдлийг сэргээх 2. Өв тэгш, үндэсний ухамсарт эх оронч монгол хүнийг хөгжүүлэх 3. Төрийн ёслол, хүндэтгэлийн үйл ажиллагаанд үндэсний онцлогтой болгох 4. Түүх соёлын дурсгал, урлагийн бүтээлүүд, утга зохиолд тулгуурлан үндэсний бахархлыг сэргээх, биет болон биет бус өвийг хадгалах, хамгаалах, өвлүүлэх	1. Археологи, палеонтологийн дурсгалын төрөл зүйлийг эдийн засгийн үнэлгээгээр үнэлэх 2. Дэлхийд өрсөлдөх үндэсний археологич, палеонтологичдыг бэлтгэх, чадамжийг дээшлүүлэх, судлаач, эрдэмтэн бэлтгэх 3. Үндэсний болон сонгодог урлагийг түгээгч мэргэжлийн байгууллагуудын барилга байгууламжийн дэд бүтэц, орчин нөхцөл, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, хөгжмийн зэмсгээр бүрэн хангаж шинэчлэх 4. Үндэсний эв нэгдэл, нийгмийн зөвшилцлийг алдагдуулах эрсдэлийг хянах, түүнээс сэргийлэх чадавхыг бэхжүүлэх	1. Төрт ёсны уламжлал, түүх соёлын дурсгал, утга зохиол, урлагийн бүтээлээр үндэсний бахархал төлөвшүүлэх 2. Улс төр, эдийн засаг, нийгэм, шашин зэрэг бүхий л хүрээнд эв нэгдлийг нягтруулахад чиглэсэн үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.4.1. Улс, үндэстний эх орон, газар нутаг, тусгаар тогтнолоороо бахархах үзлийг сэргээж, Монголчуудын уламжлалт төрт ёсны үзэл, сургаалыг орчин үед нийцүүлэн хөгжүүлж эх оронч үзэл, үндэсний эв нэгдлийг төлөвшүүлнэ.

- 1.4.2. Монголын түүхэн их удирдагчдын намтар, төрт ёсны уламжлал судлалыг нийтэд түгээн бахархлыг сэргээн Чингис хааныг нийтээр хүлээн зөвшөөрсөн үндэсний эцэг болгон тунхаглаж, Чингис хааны тахилгыг сэргээнэ.
- 1.4.3. Газар усны нэрүүдийг эх байдлаар нь нэрлэх, өөрөөр нэрлэгдэх болсон нэрүүдийг эх сурвалжид тулгуурлан хуучнаар нь сэргээж, тахилгат уул ус, газар нутгийн уламжлалт зан үйлийг эх байдлаар нь сэргээнэ.
- 1.4.4. Үндэсний уламжлалт баяр наадам, цагаан сарыг тэмдэглэхдээ үндэсний ижилслийг баталгаажуулах бэлгэдлийн өдрүүд болгон хэвшүүлнэ.
- 1.4.5. Төрийн ёслол, хүндэтгэлийн үйл ажиллагааны дүрэм журмыг үндэсний онцлогт нийцүүлэн дахин шинэчилнэ.
- 1.4.6. Үндэсний археологийн хөгжлийг дэмжиж, үнэт зүйлсийг хадгалан, Хархорум хотын туурь тэргүүтэй дурсгалуудыг сэргээн бэхжүүлж, археологи, палеонтологи, угсаатны зүйн чиглэлээр төрөлжсөн музей, сан, судалгааны төвүүдийг байгуулна.
- 1.4.7. Үндэсний бахархал болсон ном судар, баримтат өвүүдийг нийтэд таниулна.
- 1.4.8. Үндэсний сонгодог урлагийн дэг сургууль буюу заах аргагүйг магадлан итгэмжлүүлж, баталгаажуулах, “Монголын үндэсний сонгодог урлаг” хэмээн дэлхийд танигдах бүтээлийг дэмжинэ.
- 1.4.9. Монгол Улсын угсаатны бүлгүүдийн онцлог, зон олны ёс заншил, амьдралын хэв маягт үндэсний хэв шинжийг бүрдүүлэх, нэгдмэл үзэл ухамсар төлөвшүүлнэ.
- 1.4.10. Монгол Улсад түүх, соёлын өвийг сүйтгэгчидтэй хийх тэмцлийг орон даяар өрнүүлж, хууль сахиулах болон тусгай чиг үүрэгтэй байгууллагуудын хариуцлагыг нэмэгдүүлнэ.
- 1.4.11. Үнэ цэн бүхий археологийн дурсгалт газрыг аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх үнэлгээ хийж, дурсгалт газруудыг газрын харилцааны мэдээллийн кадастрын санд бүртгэж, хамгаална.
- 1.4.12. Музейн үзмэр, эд өлгийн зүйл, урлагийн бүтээлийн улсын бүртгэлийн үнийг үнэлэх, даатгалын үнэлгээгээр үнэлнэ.
- 1.4.13. Археологийн үнэ цэнт дурсгалт газрын хамгаалалтын зэрэглэл, ангиллыг шинэчлэж, дурсгалт газрыг хамгаалах соёлын өв харгалзагч, эзэнтэй болгоно.
- 1.4.14. Зохион байгуулалттайгаар шашны гаж урсгалуудыг санхүүжүүлэх, хүний эрх чөлөөнд халдахаас сэргийлэх, зайлсхийх, шаардлагатай тохиолдолд хориглох арга хэмжээг авна.
- 1.4.15. Археологийн дурсгалт газар, шашны үйл явдалд үндэслэсэн эвент, фестивалыг бий болгож, палеонтологийн үнэт зүйлсийг тусгай сонирхлын үнэ цэнтэй аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгоно.

- 1.4.16. Дэлхийн болон монгол сонгодог зохиолууд, үндэсний онцлогтой утга зохиолын бүтээлүүдээс бүрдсэн бичил номын сан, гэрийн номын сантай болгох аян өрнүүлж хүүхэд залууст заавал унших ном, сонсох подкаст, үзэх кино, вэб хуудсыг бий болгоно.
- 1.4.17. Үндэсний бахархал болсон ном судар, баримтат өвүүдийг нийтэд таниулах цуврал бүтээлч үйл ажиллагааг улсын болон хувийн номын сангуудад түшиглэн зохион байгуулна.
- 1.4.18. Үндэсний сонгодог урлагийн дэг сургуулийг баталгаажуулах чиглэлээр уртын дуу, морин хуур, хөөмий, бий биелгээ, цуур зэрэг хөтөлбөрийг үндэсний хэмжээнд магадлан итгэмжлүүлнэ.
- 1.4.19. Сонгодог урлагийн нэн шаардлагатай мэргэжлээр олон улсын нэр хүндтэй сургуульд мэргэжилтэн бэлтгэж, суралцуулна.
- 1.4.20. Үндэсний агуулга бүхий урлагийн шинэ урсгал бүтээгч залуу уран бүтээлчдийн санал, санаачилгыг дэмжиж, үндэстний орчин цагийн бүтээлийн өнгө төрхийг тодорхойлно.

ЭРДЭМ СУДЛАЛ- НИЙГМИЙН СОЁН ГЭГЭЭРЭЛ

ЗОРИЛТ 1.5. Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэл болсон нүүдлийн соёл иргэншил, Монголын түүх, хэл соёл, ёс заншил, шашин, гүн ухааны судалгаа хийж нийтийн хүртээл болгож хэвшиж, нийгмийн соён гэгээрлийг өндөр түвшинд хүргэнэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
ҮНДЭСНИЙ ҮНЭТ ЗҮЙЛСИЙН СУДАЛГАА – СОЁН ГЭГЭЭРЭЛ	СУДАЛГААНЫ ҮР ДҮН ТӨР, НИЙГЭМД	ҮНЭТ ЗҮЙЛ БҮХИЙ НИЙГМИЙН СОЁН ГЭГЭЭРЭЛ
Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэлүүдийн судалгааг салбар тус бүрээр гүнзгийрүүлэн хийж, нийтийн хүртээл болгох үе	Гүнзгийрүүлсэн судалгааны бүхий л үр дүнг төр, нийгмийн амьдралд хэрэгжүүлэх үе	Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэлээр судалгааны бүхий л үр дүнгийн хэрэгжилт хэвшил болж, нийгмийн соён гэгээрэл өндөр түвшинд хүрэх үе

- | | | |
|---|--|---|
| 1. Үнэт зүйлийн суурь, хавсарга болон гүнзгийрүүлсэн судалгааг тогтворжуулах | 1. Техник, технологийн шинэчлэлд тулгуурласан судалгаа шинжилгээний аргуудыг үндэсний үнэт зүйлийн судлалд нэвтрүүлэх | 1. Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэл болсон нүүдлийн соёл иргэншил, Монголын түүх, хэл соёл, ёс заншил, шашин, гүн ухааны судалгааны бүхий л үр дүнг олон нийтийн хүртээл болгож, нийгмийн соён гэгээрлийг өндөр түвшинд хүргэх |
| 2. Судалгааны шинэ эх хэрэглэгдэхүүнүүдийг эрэн сурвалжилж, бүртгэн судалгааны эргэлтэд оруулах | 2. Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэлийн гүнзгийрүүлсэн судалгааны үр дүнг төр, нийгмийн амьдралд хэрэгжүүлэх үндэсний хэмжээний хөтөлбөр хэрэгжүүлэх | |

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 1.5.1. Соёл судлал, соёлын ажилтны хөгжлийг дэмжиж мэргэжлийг нь дээшлүүлнэ.
- 1.5.2. Монгол хэл шинжлэлийн түүхэн судалгаа хийж, монгол хэлний эрдмийн хэл зүй бичнэ.
- 1.5.3. Үндэсний утга зохиол, ном судар, баримтат өвүүдийг бүртгэн, цуглуулагчдыг алдаршуулж урамшуулна.
- 1.5.4. Алтайн төрөл хэлнүүд ба монгол хэл, аялгуунуудын харьцуулсан иж бүрэн судалгаа хийж олон нийтийн хүртээл болгоно.
- 1.5.5. Археологи, палеонтологийн судалгааг үнэт зүйлийн судалгааны тэргүүлэх чиглэл болгож үндэсний хэмжээний судалгааны төслийг хэрэгжүүлнэ.
- 1.5.6. Монгол хүний ёс суртахууны хэм хэмжээний талаарх судалгааг өргөжүүлэн хүүхэд залуус, төрийн албан хаагч, хүчний байгууллагын ажиллагсдын ёс суртахууны нарийвчилсан судалгааг хийнэ.
- 1.5.7. Монгол Улсын түүхийн судалгааг гүнзгийрүүлэн, өмнө судлагдсан түүхийн бүтээлүүдийг нийтэд таниулах, Монгол улсын нэгдсэн түүх бичиж, хэвлүүлнэ.
- 1.5.8. Дэлхийн номын сангууд болон угсаатны музей, эрдэм шинжилгээний байгууллага, хувь хүмүүст хадгалагдаж байгаа бичгийн дурсгал, түүхэн сурвалж бичгийн өвийг бүртгэж мэдээллийн сан бүрдүүлэх, эрдэм шинжилгээ судалгааны эргэлтэд оруулна.
- 1.5.9. Тахилгат уул ус, газар нутгийг олж тогтоох, тухайн тахилгат газарт хэрэглэдэг сан судар, түүх домог, холбогдох уран бүтээл, эдлэл хэрэглэгдэхүүнийг эрэн сурвалжилж олж тогтооно.
- 1.5.10. Монголын төрт ёсны түүхтэй холбоотой Хүрэл ба түрүү төмрийн үе болон Хүннү, Сяньби, Монголын эзэнт гүрний үед холбогдох археологийн малталт судалгааны үндэсний төслийг хэрэгжүүлнэ.

ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ ЗОРИЛГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

Хүснэгт 1.1. Үндэсний нэгдмэл үнэт зүйл зорилгын хэрэгжилтийн хяналт,
үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин

Тайлбар: * тэмдэглэгээ бүхий шалгуур үзүүлэлтийг шинээр тооцдог болно.

#	Шалгуур үзүүлэлт (indicator)	Хэмжих нэгж	Суурь түвшин	2030	2040	2050	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хаанаас авах эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах аргазүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
1	ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ										
1	Үндэстэн брэндийн индекс	байр	-	70-аас дээш	60-аас дээш	50-иас дээш	Чанарын үзүүлэлтээр дүгнэх, Үндэстэн брэндийн индексийг 50-р байранд оруулах	Дэлхийн банк	Судалгаа	Жил бүр	Үндэсний брэндийн бодлогын зөвлөлийн ажлын алба
2	Төрийн албан хаагчдын Монгол хэл, бичгийн шалгалтын улсын дундаж оноо*	дундаж оноо	-	80+	90+	100	Бүх төрийн албан хаагчдаас Монгол хэл, бичгийн шалгалт авах ажил зохион байгуулж суурь түвшинг тогтоох	Төрийн албаны зөвлөл	Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулах	3 жил тутам	Төрийн албаны зөвлөл
3	Шинэ бүтээл патентын мэдүүлэг, дотоодын мэдүүлэг	тоо	82	200+	400+	600+		Оюуны Өмчийн Газар	Статистик тоо баримт	Жил бүр	Оюуны өмчийн газар
4	Дэлхийд танигдсан бүтээлийн тоо	тоо	-	5+	20+	100+	Олон улсын уралдаан тэмцээн, хит парад, бокс оффист эхний 10 байр эзлэх	Олон улсын түвшинд үнэлгээ үзүүлэх байгууллагын мэдээ мэдээлэл, олсон орлого	Судалгаа	Жил бүр	Гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага



ХҮНИЙ ХӨГЖИЛ

БОЛОВСРОЛ

ЭРҮҮЛ МЭНД

ГЭР БҮЛ

ШИНЖЛЭХ УХААН, ИННОВАЦИ

ХҮНД ЭЭЛТЭЙ АМЬДРАХ ОРЧИН

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

УДМЫН САН

ХҮНИЙ ХӨГЖИЛ

Монгол Улс ардчилсан, хүмүүнлэг нийгмийг цогцлоож, хүний эрх, оролцоо, тэгш эрх, үнэт зүйлийг дээдэлсэн нийгмийн хөгжил нь иргэн бүрийн идэвхтэй оролцооноос хамаарна. Идэвхтэй, эрүүл, эрдэм боловсролтой, эх оронч иргэний асуудал бол хүний хөгжилтэй салшгүй холбоотой асуудал юм.

Сүүлийн 30 орчим жилийн хөгжлийн замналаа эргэн дүгнэвэл эдийн засгийн өсөлтөд чиглэсэн төрийн бодлого давамгайлж, амьдралын чанар, нийгмийн баялгийн хүртээмж, тэгш байдлыг орхигдуулж иржээ.

Ирэх 30 жилд монгол хүн бүр эрүүл аж төрж, аз жаргалтайгаар урт наслах, насан туршдаа чанартай, тэгш хүртээмжтэй боловсрол эзэмшиж, хангалуун амьдрах орчинг бий болгоход гол зорилго оршино.

Хүүхэд, залуучууд маань дэлхийн жишигт хүрсэн чанартай боловсрол эзэмшиж, идэвхтэй амьдралын хэв маягтай болж төлөвшиж, амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгааллын үйлчилгээ, шинжлэх ухаан, технологийн үр шимийг хүртэж, амьдралын ээлтэй орчинд аж төрөхөд чиглэсэн энэхүү зорилгын хүрэх үр дүнг дараах байдлаар тодорхойллоо.

|| *Чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалтай, аз жаргалтай амьдралын ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн нийгмийн идэвхтэй МОНГОЛ ХҮН-ийг хөгжүүлж, Хүний хөгжлийн индексийг 0.9-д хүргэж, аз жаргалын индексээр эхний 10 орны тоонд багтах болно.*



Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн хөгжлийн үе шатуудыг тодорхойллоо.

БОЛОВСРОЛ

ЗОРИЛТ 2.1 Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
ЭРХ ТЭГШ, ТЭГШ ХАМРУУЛСАН БОЛОВСРОЛ	НАСАН ТУРШИЙН ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ	СУРАЛЦАХ СОЁЛ БҮРДСЭН НИЙГЭМ
Хүн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцооны шинэчлэлийн үе	Чанартай боловсрол олгох, насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлэх үе	Насан туршдаа суралцахуйг дэмжсэн нээлттэй боловсролын тогтолцоог бэхжүүлэх үе
<ol style="list-style-type: none"> Салбарын хүрээнд судалгаа, нотолгоонд суурилсан бодлого, хөгжлийн төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх удирдлагын тогтолцоог бэхжүүлж, олон талт түншлэлийг бий болгох Иргэн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлэн, тэгш хамруулж, бүх шатны боловсролын залгамж холбоог хангаж, сургалт, үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэх Суралцагчийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг хангасан, бүтээлч, чадварлаг багш, хүний нөөцөөр хангах Боловсролын салбарын удирдлагын мэдээллийн системийг бүрэн хөгжүүлж, хэрэглэж хэвших, нээлттэй боловсролын тогтолцоог хөгжүүлж нэгдсэн платформ бий болгон хүн бүр орон зай, цаг хугацаанаас үл хамааран өөрийн хүссэн чиглэлээр насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлэх 	<ol style="list-style-type: none"> Бүсийн төв, аймаг орон нутагдах ЕБС, МСҮТ, политехник коллеж, технологийн коллеж, их сургуулиудын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх Бүх насны иргэд, нийгмийн салбар бүрийг хамарсан насан туршийн боловсролын нээлттэй, уян хатан тогтолцоог бэхжүүлэх Олон улсын шаардлага хангасан дээд боловсролын сургалтын байгууллагын тоог нэмэгдүүлж, чанарыг дээшлүүлэн олон улсад эрэмбэлэгдсэн, хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөр бүхий үндэсний судалгааны их сургуультай болох Боловсролын засаглал, удирдлагын тогтолцоог тодорхой болгож, тасралтгүй сайжрах хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх 	<ol style="list-style-type: none"> Боловсролын бүх шатанд суралцахыг хүссэн хүнд хоёр дахь боломжийг олгосон, сургалтын уян хатан арга замуудтай, харилцан уялдаа бүхий бусадтай хамтран амьдрах, ажиллах чадавх (үнэт зүйлс, зан үйл, амьдралын хэв маяг) бүхий иргэнийг бэлтгэх Нээлттэй сургалтын хөтөлбөр, агуулгыг баяжуулж, боловсролын бүх шатанд хиймэл оюун ухаанд суурилсан технологийг нэвтрүүлэх

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

САЛБАРЫН ХҮРЭЭНД СУДАЛГАА, НОТОЛГООНД СУУРИЛСАН БОДЛОГО, ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЖ, ОЛОН ТАЛТ ТҮНШЛЭЛИЙГ БИЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР

- 2.1.1. Боловсролын чиглэлээр суурь болон хавсарга судалгааг тогтмол хийж хэвших ба бүх шатны боловсролын сургалтын байгууллагын байршил, хүчин чадал, нөөц, нормативын нэгдсэн зураглал, судалгаа, шинжилгээний мэдээллийн санг бий болгон, судалгаа, нотолгоонд суурилсан бодлого, хөгжлийн төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх удирдлагын тогтолцоог сайжруулна.
- 2.1.2. Боловсролын мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулан эрх, үүргийн оновчтой хуваарилалт хийх ба олон талт түншлэлийг дэмжиж ажиллана.
- 2.1.3. Мэргэжлийн холбоодтой хамтарч ажиллах, түншлэлийг бэхжүүлэн зарим төрлийн үйл ажиллагааг мэргэжлийн холбоодод шилжүүлж, бие даасан - хараат бус үйл ажиллагаа явуулах зохицуулалт хийнэ.
- 2.1.4. Сургалтын байгууллагын санхүүжилтийг төгөлдөржүүлэн, суралцагч нэг бүрийг амжилттай сургахад чиглүүлнэ.
- 2.1.5. Боловсролд хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт үзүүлэх тогтолцоог бий болгоно.
- 2.1.6. Боловсролын мэргэжлийн байгууллагуудын дэргэд түшиц сургалт судалгаа, инновацийн нэгжүүдийг бий болгож ажил олгогч, мэргэжлийн холбоод, эрдэмтэн багш, судлаачдын түншлэлийг бэхжүүлнэ.
- 2.1.7. Төрөөс хараат бус бие даасан хүний нөөцийн бодлогын үндэсний зөвлөл байгуулан салбар бүрийн мэргэжлийн холбоодтой хамтран мэргэшлийн үндэсний хүрээг тогтоож, хэрэгжүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн нээлттэй нэгдсэн цахим мэдээллийн систем бий болгох, техник мэргэжлийн болон дээд боловсролын бодлого тодорхойлоход шаардлагатай мэдээллийг Боловсролын салбарын мэдээллийн санд нэгтгэж, хөтөлж хэрэглэж хэвшинэ.
- 2.1.8. Боловсролын байгууллагын бүх түвшинд дотоод хяналт-мониторинг, үнэлгээ хийх, өөрийн үнэлгээний тогтолцоог чанаржуулж, соёлыг бий болгоно.
- 2.1.9. Боловсролын байгууллага, сургалтын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын хөндлөнгийн хяналт шинжилгээг олон улсын жишиг аргачлалаар хийдэг тогтолцоонд шилжиж төрөөс хараат бус бие даасан институцийг бэхжүүлнэ.
- 2.1.10. Их дээд сургууль, МСҮТ, ЕБС-ийг тухайн орон нутаг, бүс нутгийн хүний хөгжлийн төв болгон хөгжүүлж насан туршийн боловсролын тогтолцоог бэхжүүлэх ба бүх насны иргэд, нийгмийн салбар

бүрийг хамарсан насан туршийн боловсролын нээлттэй, уян хатан тогтолцоог бэхжүүлнэ.

- 2.1.11. Их сургууль, МСҮТ-үүд төгсөгчдийнхөө мэргэжил дээшлүүлэх асуудлыг хариуцдаг тогтолцоо бий болгож насан туршийн боловсролын үйлчилгээний чиглэлийг нэмэгдүүлэн насанд хүрсэн суралцагчдын ажил эрхлэх ур чадварыг нэмэгдүүлэх, амьдрах чадварын сургалтын хүрээнд төдийгүй шинэ чадвар эзэмшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр бий болгож хэрэгжүүлэхэд олон талт оролцоог хангана.
- 2.1.12. Боловсролын тогтолцооны гадна байгаа, завсардаж, хоцорч байгаа суралцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулна.
- 2.1.13. Сургуулийн насны хүн амын тооны өсөлтөд тулгуурлан бүх шатны сургалтын байгууллагын дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй орчин бий болгож чанартай үйлчилгээ үзүүлэх орчин бүрдүүлнэ.

Хүснэгт 2.1. Сургуулийн насны хүн амын тоо (мянган хүн)

Боловсролын түвшин	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
Сургуулийн өмнөх	326.0	327.2	327.3	326.3	324.8	316.7	329.3	380.7	450.5	489.4
Бага	361.3	376.5	389.4	399.4	405.2	403.0	394.7	415.0	482.9	524.5
Суурь	231.9	243.4	254.7	266.6	280.1	324.1	321.3	315.4	334.7	363.6
Бүрэн дунд	112.1	119.6	127.4	134.9	141.9	181.3	194.6	190.0	189.4	205.7
Мэргэжлийн	28.0	29.9	31.8	33.7	35.5	45.3	48.6	47.5	47.3	51.4
Дээд	168.4	167.2	170.3	177.8	188.6	248.2	310.4	317.2	308.2	334.7

ИРГЭН БҮРД ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ ЭРХ ТЭГШ БОЛОМЖ БҮРДҮҮЛЭН, ТЭГШ ХАМРУУЛЖ, БҮХ ШАТНЫ БОЛОВСРОЛЫН ЗАЛГАМЖ ХОЛБООГ ХАНГАЖ, СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ


- 2.1.14. Сургуулийн өмнөх боловсрол нь хүүхдийн төлөвшил, хөгжлийн суурь үе хэмээн үзэж хүүхдийн цэцэрлэгийн үйлчилгээний болон сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн цогц үйл ажиллагаа зохион байгуулна.
- 2.1.15. Сургуулийн өмнөх боловсролыг бага насны хүүхдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор цэцэрлэгийн барилга, байгууламж, хүүхдийн орны тоог эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн үе шаттай нэмж, бүлэг дүүргэлтийг норматив хэмжээнд барих, орчны стандартын дагуу хүүхэд бүрд ээлтэй, эрүүл, аюулгүй орчинг бий болгон тохижуулна. Хүснэгт 1-ээс харахад сургуулийн өмнөх боловсролын насны хүүхдийн тоо тогтмол байгаа боловч Улаанбаатар хот, зарим аймгийн төвд цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх ба 2025 он гэхэд 3600, 2030 он гэхэд 4600 ортой цэцэрлэг барина.

- 2.1.16. Цэцэрлэгийн хүүхдийн хоолны мөнгийг 1-3, 4-6 настай хүүхдийн хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээг үндэслэн жил бүр шинэчлэн тогтоож шаардлагатай нэмэгдэл төсвийг эцэг, эх, асран халамжлагчаас гаргуулах тогтолцоог бий болгоно.
- 2.1.17. Малчин өрхийн хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол олгох явуулын гэр цэцэрлэг ажиллуулах, эцэг эхчүүдийн боловсролыг дээшлүүлэх замаар тэдний оролцоонд түшиглэсэн хүүхдийн хөгжлийг дэмжинэ.
- 2.1.18. Цэцэрлэгийн багшийн ажлын чанарыг сайжруулах, сургалтын үйл ажиллагаанд бэлдэх, хүүхдийг ажиглах, судалгаа хийх, өөрийгөө хөгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлж, 2021 оноос эхлэн 30-аас дээш бүлэг дүүргэлттэй ангид, 2023 оноос эхлэн бүлэг бүрд 2 ээлжийн бүлгийн багш ажиллуулна.
- 2.1.19. Хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдлыг тооцсон сургалтыг чанартай зохион байгуулахад чиглэсэн тусгай хэрэгцээт боловсролын мэргэжилтэнг цэцэрлэг бүрд ажиллуулна.
- 2.1.20. Хүүхэд харах үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, 1-2 насны хүүхдийг хамруулах боломжтой болгох эрх зүйн орчин бүрдүүлж энэ төрлийн үйлчилгээ эрхэлж буй байгууллагад тавигдах шаардлага, стандартыг батлан, дагаж мөрдүүлнэ.

БАГА, ДУНД БОЛОВСРОЛ

- 2.1.18. Сургуулийн барилга, байгууламж, суудлын тоог эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн үе шаттай нэмэгдүүлж бүлэг дүүргэлтийг норматив хэмжээнд барих, орчны стандартын дагуу хүүхэд бүрд ээлтэй, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх тохижуулна. 2030 он хүртэлх нэмэгдэх шаардлагатай суудлын тооцоог аймаг, дүүргээр ангилж зургаар харуулав.

Зураг 2.1. ЕБС-д нэмэх шаардлагатай суудлын тоо, 2030 он



Эх сурвалж: БСШУСЯ, АХБ, Боловсролын салбарын өгөгдөл


мэдээллийн боловсруулалтын тайлан, 2019

- 2.1.19. Сургуулийн дотуур байр, ногоон хөгжлийн байгууламж, спортын болон урлагийн заал, цайны газар мэдээлэл зүйн сургалтын танхимыг стандартын дагуу тохижуулж сургалтын байгууллагын орчны стандартыг хангах, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан тохируулгат орчин бүрдүүлж, цэвэр ус, ариун цэврийн байгууламжийг хүүхэд, хэрэглэгчдэд ээлтэй болгох ажлыг үе шаттайгаар төлөвлөж хэрэгжүүлнэ.
- 2.1.20. Бага, дунд боловсролын чанарыг дээшлүүлж, сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйд Монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний хөгжил, төлөвшил, хос хэл, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлийг тусган хэрэгжүүлнэ.
- 2.1.21. Суралцагчдын сурлагын амжилтад нөлөөлөх хүчин зүйлийн судалгааг тогтмол хийж үр дүнд үндэслэн бодлого, төлөвлөлт хийж хэвшинэ.
- 2.1.22. Сурагч болон багшид сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, суралцагчдад мэргэжлээ сонгох, ирээдүйгээ төлөвлөхөд нь зөвлөн туслах чиг үүрэгтэй сэтгэл зүйч, мэргэжилтнийг сургууль бүрд ажиллуулна.
- 2.1.23. Сэтгэл зүйч болон хүний хөгжлийн чиглэлээр хос мэргэжилтэн бэлтгэнэ.
- 2.1.24. Сургуулийн дотуур байрны менежментийг сайжруулан багш нарын ажлын ачааллын 10 хүртэлх хувьд дотуур байранд сурагчдын хөгжлийг дэмжих чиглэлээр хийсэн сургалт, хөгжлийн үйл ажиллагааны цагийг тооцдог байх зохицуулалт хийж дотуур байрны хүүхэд хамгааллыг сайжруулна.

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ДЭЭД БОЛОВСРОЛ

- 2.1.25. Судалгааны их сургууль байгуулан Ази тив, бүс нутагтаа бусдаас ялгарах давуу тал бүхий хөтөлбөрүүдээ төрөөс дэмжиж геологи, палеонтологи, монгол судлалаар хүний нөөцийг бэлтгэх ба эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд болох уул уурхай, хөдөө аж, ахуй, хүнс, хөнгөн үйлдвэр, эрчим хүч, бүтээлч аж үйлдвэр, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийг үе шаттай бэлтгэнэ.
- 2.1.26. Их сургууль, МСҮТ-үүдийн хөтөлбөрүүдийн ангиллыг элсэлтийн бодлого, ажиллах хүчний тооцоотой уялдуулан шинэчлэн үндсэн болон хавсарга мэргэжлээр зэрэг суралцах хөтөлбөрийн системийг бий болгоно.
- 2.1.27. Мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын байгууллагуудыг олон улсын шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх, төгсөгчдийн ажил эрхлэлтийг болон ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгаа хийж, хөтөлбөр сайжруулах, хамтын ажиллагааг бэхжүүлэх, хичээлийн 20-иос доошгүй багц цагийг дадлагын хөтөлбөрт шилжүүлэх бөгөөд орон нутаг дахь бүс нутгийн онцлог, эдийн засгийн тэргүүлэх чиглэлтэй уялдсан байна.

Зураг 2.2. Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэлтэй уялдсан мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрийн чиглэл



Эх сурвалж: Үндэсний Хөгжлийн Газар

2.1.28. Олон улсын их сургуулиудын салбар сургуулийг Монголд байгуулах эрх зүйн таатай орчныг бүрдүүлэн гадаад хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

2.1.29. Их сургуулиудын нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх, нийгэмд үйлчлэх хүрээг тэгш, сургуулийн үнэлгээний тогтолцоонд өөрчлөлт хийнэ.

СУРАЛЦАГЧИЙН ХӨГЖЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ ХАНГАСАН, БҮТЭЭЛЧ, ЧАДВАРЛАГ БАГШ, ХҮНИЙ НӨӨЦӨӨР ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

2.1.30. Боловсролын салбарын хүний нөөцийн цогц бодлого хэрэгжүүлж, чадварт суурилсан мерит зарчмаар албан тушаал, мэргэжлийн хөгжлөө тодорхойлох боломжтой тогтолцоо бий болгох, салбарын хүний нөөцийн жендэрийн тэгш байдлыг хангах, хөдөө орон нутагт очиж ажиллах хүний нөөцийг орон байраар хангах зэрэг арга хэмжээ авна.

2.1.31. Бүх шатны сургалтын байгууллагын багшийн стандартыг мэргэжлийн, заах арга зүйн, судалгааны, МХХТ-ийн, гадаад хэлний гэх мэт чадваруудаар ялган тодорхойлж багшийн хөгжил, хүний нөөцийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлж бүх шатны сургалтын байгууллагыг мэргэжлийн багшаар хангана.

2.1.32. Хүн амын өсөлттэй динамиктай холбоотойгоор ЕБС-д шаардлагатай бага ангийн болон мэргэжлийн багш нарыг бэлтгэж, мэргэжлийг нь тогтмол дээшлүүлнэ.

Хүснэгт 2.2. Цэцэрлэгт шаардлагатай багшийн урьдчилсан тооцоо, 2021-2050

Бүлэг	2021	2022	2023	2024	2025	2030	2035	2040	2045	2050
Бага	2,739	2,733	2,722	2,707	2,689	2,643	2,827	3,353	3,929	4,268
Дунд	2,735	2,734	2,728	2,718	2,703	2,635	2,764	3,228	3,815	4,144
Ахлах	2,712	2,732	2,732	2,726	2,716	2,637	2,715	3,112	3,699	4,018
Бэлтгэл	2,682	2,706	2,727	2,727	2,721	2,642	2,672	2,997	3,575	3,883
Нийт	15,466	15,513	25,864	25,802	25,706	25,175	26,026	29,460	34,126	36,723

Тайлбар: 16-18 насны хүн амын 80 хувь нь бүрэн дунд, 20 хувь нь мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суралцахаар тооцов.

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, 2019

Хүснэгт 2.3. ЕБС-д шаардлагатай багшийн урьдчилсан тооцоо, 2025, 2030

№	Хичээл	2025		2030	
		Нийт	Шинэ	Нийт	Шинэ
1	Бага анги	12265	3428	12696	5158
2	Монгол хэл, Уран зохиол, Үндэсний бичиг	5257	3001	5762	3838
3	Математик	3783	1774	4147	2433
4	Мэдээллийн технологи	1097	498	1203	691
5	Физик	1774	925	1944	1221
6	Биологи	1774	1056	1944	1332
7	Хими	1774	1145	1944	1408
8	Газарзүй	1182	671	1296	860
9	Түүх	1488	949	1631	1171
10	Нийгэм судлал, Иргэний боловсрол	2677	1737	2934	2133
11	Дүрслэх урлаг, Зураг зүй, Технологи	4187	2536	4590	3181
12	Дуу хөгжим	2204	1286	2416	1633
13	Биеийн тамир	3601	1865	3947	2467
14	Эрүүл мэнд	1269	976	1391	1141
15	Англи хэл	3653	1301	4004	1998
16	Орос хэл	1041	429	1141	619
Нийт		49025	23576	53082	31.284

Эх сурвалж: БСШУСЯ, АХБ, Боловсролын салбарын өгөгдөл мэдээллийн боловсруулалтын тайлан, 2019

2.1.33. Цэцэрлэг, ЕБС-ийн багш, туслах багшийн ажлын ачааллыг ажлын байр, хөдөлмөрийн онцлогтой уялдуулж шинэчлэх, уян хатан болгох, тэдний үйл ажиллагааг үр дүнгээр нь үнэлдэг тогтолцоотой болгож шинэчлэх, цалин хөлс, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох, бодит цалингийн

хэмжээг үе шаттай нэмэгдүүлж, багшийн хөдөлмөрийн үнэлгээг үндэсний хэмжээний цалингийн шатлалын дээд 10 хувьд байлгана.

2.1.34. Багш бэлтгэх сургалтын чанарын баталгаажуулалтын тусгай шалгуур үзүүлэлт бий болгож, сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлагыг нэмэгдүүлж, сургалтын байгууллагад багшлах эрхийн баталгаажуулалтыг үе шаттай хийдэг тогтолцоог бэхжүүлнэ.

2.1.35. Цэцэрлэг, ЕБС-ийн удирдах ажилтанд тавигдах шаардлага, удирдах ажилтныг бэлтгэх, томилох тогтолцоо, ажил үүргийн хуваарийг шинэчилж, сургалтын чанарыг хангах чиг үүргийг нэмэгдүүлж, гүйцэтгэлийн үнэлгээг сайжруулан сургалтын байгууллагын менежментийн чадавхыг дээшлүүлнэ.

2.1.36. Багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх тогтолцоог шинэчилж багш өөрөө санаачилгаараа хөгжих тогтолцоог бэхжүүлнэ.

2.1.37. Багшийн хөгжилд дэмжлэг үзүүлэх сургалт арга зүйн байгууллагын чадавхыг дээшлүүлж, үйл ажиллагааг өргөтгөн багш бэлтгэдэг их дээд сургуулиудад түшиглэсэн төвүүд бий болгож хамтын ажиллагааг нь дэмжинэ. Багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалт, үйл ажиллагаанд олон талт оролцоог хангаж сургалт явуулдаг төр, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлнэ.

БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН УДИРДЛАГЫН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙГ БҮРЭН ХӨГЖҮҮЛЖ, ХЭРЭГЛЭЖ ХЭВШИХ, НЭЭЛТТЭЙ БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦООГ ХӨГЖҮҮЛЖ НЭГДСЭН ПЛАТФОРМ БИЙ БОЛГОН ХҮН БҮР ОРОН ЗАЙ, ЦАГ ХУГАЦААНААС ҮЛ ХАМААРАН ӨӨРИЙН ХҮССЭН ЧИГЛЭЛЭЭР НАСАН ТУРШДАА СУРАЛЦАХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

2.1.38. Боловсролын салбарын мэдээллийн системийг бүрэн хөгжүүлж, бүх түвшинд нэвтрүүлэн салбарын бодлого, төлөвлөлт, хяналт, мониторинг хийх үйл ажиллагаанд хэрэглэж хэвших, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж хамгаалах ажлыг тогтмол хийнэ. Энэ чиглэлийн хүний нөөцийг бэлтгэж үйл ажиллагааг нь тогтворжуулан боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагад мэдээллийн системийн хөгжил тогтвортой ажиллагааг хариуцсан нэгж ажиллуулна.

2.1.39. Нээлтэй боловсролын тогтолцоог бий болгон онлайн, зайн сургалтын нэгдсэн платформыг хөгжүүлэн бүх шатны боловсролын сургалтын байгууллагыг цахим хэрэглээнд бүрэн шилжүүлж бүх насны суралцагч, иргэдэд зориулсан онлайн сургалтын хөтөлбөр, агуулга (MOOC, OER) боловсруулан түгээх, албан бус боловсролын тогтолцоог хүлээн зөвшөөрнө.

2.1.40. Багш нарын МХХТ-ийг сургалтад ашиглах, онлайн, зайн сургалт хөтлөх, англи хэлний чадварыг дээшлүүлэх, ЕБС-ийн МХХТ-ийн сургалтын агуулга, стандартыг олон улсын түвшинд хүргэж суралцагчдад цахим бичиг үсгийн боловсрол олгох, цахим орчинд аюулгүй байдлаа хангах чадвар олгох, иргэд, олон нийтэд зориулсан МХХТ-ийн чадварыг дээшлүүлэх сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах ажлыг эрчимжүүлж сургалт явуулдаг бүх төрлийн байгууллагыг оролцоог хангаж хамтарч ажиллана.

ЭРҮҮЛ МЭНД

ЗОРИЛТ 2.2 Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020-2030)	II үе шат (2031-2040)	III үе шат (2041-2050)
ЭРҮҮЛ БИЕ-САРУУЛ УХААН	АМЬДРАЛЫН ЗӨВ ДАДАЛ ХЭВШИЛ	ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ
Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй тогтолцооны шинэчлэлийн үе	Амьдралын зөв дадал, хэвшилтэй иргэн төлөвшүүлэх үе	Эрүүл амьдралын хэв маягийг дэмжих үе
<ol style="list-style-type: none"> Иргэн, гэр бүл, ажил олгогчийн оролцоонд тулгуурласан нийгмийн эрүүл мэндийн/нийтийн эрүүл мэнд/ тусламж үйлчилгээний үндэсний тогтолцоо бүрдүүлэх Нотолгоонд суурилсан орчин үеийн оношилгоо, эмчилгээний техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилт, даатгалын тогтолцоо бүрдүүлэх Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн үндэсний эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдүүлэх Эрүүл мэндийн хүний нөөцийн хангалт, үр чадвар нийгмийн хамгааллыг сайжруулах 	<ol style="list-style-type: none"> Амьдралын зөв дадал, хэвшлийг дэмжих тогтолцоо бүрдүүлэх Урт хугацааны даатгалын тогтолцоо бүрдүүлж, хайбрид технологид суурилсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлэн, нэг цэгээс тусламж үйлчилгээг авах тогтолцоо бүрдүүлэх 	<ol style="list-style-type: none"> Эрүүл дундаж насжилтаар бүсийн хэмжээнд тэргүүлэх 10 орны нэг болж, Хувь хүний ген, хоол тэжээлийн онцлог зэрэг хувь хүний эрүүл мэндийн онцлог чиглэсэн хиймэл оюун ухаанд тулгуурласан эрүүл мэндийн үйлчилгээг нэвтрүүлэх

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ИРГЭН, ГЭР БҮЛ, АЖИЛ ОЛГОГЧИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН/ НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНД/ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 2.2.1. Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа өвчлөл, эндэгдлийн шалтгааныг нотолгоонд болон хувь хүний онцлогт тохируулан урьдчилан сэргийлэх, оношлох тогтолцоог санхүүжилтийн аргатай нь уялдуулан бүрдүүлж, үйл ажиллагааг хэвшүүлнэ.
- 2.2.2. Манай ард иргэд тухайн төвөөр амьдралдаа нэгээс доошгүй удаа заавал орж үзэж зөвлөгөө авдаг Нийгмийн эрүүл мэндийн загвар төвийг нийслэл хотод, нийгмийн эрүүл мэндийн төвийг бүх аймаг, хотод байгуулан хөгжүүлнэ.
- 2.2.3. Иргэн бүрийг 2 жил тутамд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд заавал хамрагддаг болгож хэвшүүлнэ.
- 2.2.4. Төрийн болон аж ахуйн нэгж байгууллага бүр ажилтан албан хаагчдаа эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулж, жил бүр урьдчилан сэргийлэх цогц үзлэг, шинжилгээнд хамруулдаг соёлыг хэвшүүлнэ.
- 2.2.5. Урьдчилан сэргийлэх анагаах ухааны чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, төгсөлтийн өмнөх болон дараах онолын, дадлага сургалтын чанарыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгож хөгжүүлнэ.
- 2.2.6. Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх судалгаа, мэдээлэл, сургалт сурталчилгааны салбар хоорондын хамтын ажиллагааны тогтолцоог бүрдүүлнэ.
- 2.2.7. Хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хэрэглээг хязгаарлах, архи, тамхи, эм, чихэрлэг ундааны онцгой албан татварын тодорхой хувийг эрүүл мэндийг дэмжих санд төвлөрүүлэх, хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлд хүчин зүйлийг бууруулах үйл ажиллагааг санхүүжүүлнэ.
- 2.2.8. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ГҮЙЦЭТГЭЛД ТУЛГУУРЛАСАН САНХҮҮЖИЛТ, ДААТГАЛЫН ТОГТОЛЦОО БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 2.2.9. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, өвчлөл, шилжилт хөдөлгөөн, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт, хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулна.

ЭРҮҮЛ МЭНД



ЭРҮҮЛ
АМЬДРАЛЫН
ДАДАЛ,
ХЭВШЛИЙГ
УРАМШУУЛАН
ДЭМЖСЭН
ЭРҮҮЛ МЭНДИЙН
ДААТГАЛЫН
ОНОВЧТОЙ
ТОГТОЛЦОО

ХИЙМЭЛ
ОЮУН УХААНД
СУУРИЛСАН
ЭРҮҮЛ МЭНД

ИРГЭН БҮР
2 ЖИЛ тутамд ЭРҮҮЛ МЭНДИЙН
урьдчилсан сэргийлэх үзлэгт
ЗААВАЛ хамрагдана



- 2.2.10. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд эрүүл мэндийн тусламжийн ачааллыг тэнцүүлж хүн амд чанартай, аюулгүй, тэгш хүртээмжтэй “Үйлчлүүлэгч төвтэй” тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавх бүхий эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудыг дэмжинэ.
- 2.2.11. Оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, иргэд эх орондоо цогц оношлуулж, эмчлэгдэх, гадны иргэдийг татан ирүүлж оношлох, эмчлэх зорилгоор олон улсын жишигт нийцсэн төвүүдийг байгуулна. (Зүрх судасны төв, Эд, эрхтэн шилжүүлэн суулгах үндэсний төв, яаралтай тусламжийн үндэсний төв...)
- 2.2.12. Яаралтай, түргэн тусламжийн үндэсний тогтолцоог шинэчлэн өөрчилж онгоц, агаарын тээврийн үйлчилгээг тусламж, үйлчилгээнд нэвтрүүлнэ.
- 2.2.13. Иргэдийг эрүүл мэндийнхээ улмаас санхүүгийн эрсдэлд орохоос сэргийлэх боломжтой бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. /Эрүүл мэндийн даатгалын сангаас өндөр үнэтэй эмчилгээ, оношилгоог санхүүжүүлэх, Хувийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх.../
- 2.2.14. Төрөөс хариуцах иргэдийн шимтгэл, албан бус салбарын даатгуулагчдын хамралт, шимтгэлийн хэмжээг өсгөх замаар эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх, төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн даатгалын сангаас олгох зардлын ялгааг үе шаттайгаар арилгана.
- 2.2.15. Төрийн өмчийн эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудыг санхүүжилтийн болон удирдлагын бие даасан хэлбэр рүү шилжүүлэх үйл ажиллагааг туршин хэрэгжүүлнэ.
- 2.2.16. Эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй байдлыг сайжруулах, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг боловсронгуй болгох зорилгоор Магадлан итгэмжлэлийн бие даасан төрөөс хараат бус байгууллагатай болно.
- 2.2.17. Үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлж гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг бүрэн нэвтрүүлнэ.
- 2.2.18. Монголын уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлж экспортод гарах гарцыг дэмжин “брэнд” болгоно.
- ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭГ ӨРГӨЖҮҮЛЭН ҮНДЭСНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР
- 2.2.19. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал, бүртгэл, импорт,

түгээлт, цахим хяналтын тогтолцоог бүхий эмийн зохицуулалтын нэгдсэн байгууллага байгуулна.

- 2.2.20. Эмчилгээ, оношилгоо, сургалтад алсын зайн анагаах ухааныг / теле медицин/ өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүх түвшинд ашиглаж хэвшинэ. Алслагдсан сумын эрүүл мэндийн төвөөс холбогдож үйлчлүүлэгч зөвлөгөө авах боломжийг бүрдүүлнэ.
- 2.2.21. Хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээ, эрүүл мэндийн технологийн үнэлгээнд үндэслэн эрүүл мэндийн технологийн төлөвлөлт, ашиглалт, нэвтрүүлэлт, чанарын хяналт, засвар үйлчилгээний нэгдсэн тогтолцоо бүрдүүлнэ.
- 2.2.22. Эрүүл мэндийн технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг дэмжинэ.
- ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХАНГАЛТ, УР ЧАДВАР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР
- 2.2.23. Хүн амын хэрэгцээ, тусламж үйлчилгээний зохион байгуулалт төлөвлөлттэй уялдуулан хүний нөөц бэлтгэх орон нутгийн хэрэгцээг хангах хүний нөөцийг төлөвлөх, сургах, урамшуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 2.2.24. Эрүүл мэндийн чиглэлээр сургалт эрхэлж буй байгууллагад олгох тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэлд тавигдах шаардлагыг шинэчилж үйл ажиллагааг боловсронгуй болгоно.
- АМЬДРАЛЫН ЗӨВ ДАДАЛ, ХЭВШЛИЙГ ДЭМЖИХ ТОГТОЛЦОО БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР
- 2.2.25. Хүн амд эрүүл аж төрөх, амьдралын зөв дадал эзэмшүүлэх ажлыг хүүхэд наснаас нь хэвшүүлэх зорилгоор цэцэрлэгийн хүүхдүүдэд зориулсан тусгай хөтөлбөр хэрэгжүүлж, дадлагын хичээл тогтмол оруулна.
- 2.2.26. Сургууль бүрд эрүүл зөв амьдралын дадал олгох тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлж, хүүхдүүд чөлөөт цагаараа эрүүл мэнд, бие бялдрын зөв дадал эзэмших анги, танхим байгуулж ажиллуулна.
- 2.2.27. Аймаг, сум, дүүрэг, хороо бүрд иргэд эрүүл зөв хооллолт, стрессээ удирдах, хөдөлгөөний хомстлоос сэргийлэх, бие бялдраа хөгжүүлэх дасгал хөдөлгөөн, иог, бүжиг хийх зэрэг цогц үйлчилгээ авах боломж бүхий “Эрүүл зөв амьдрал” жижиг төвүүд ажиллуулах боломжийг төр засаг, хувийн хэвшлийн оролцоотойгоор дэмжин хөгжүүлнэ.
- 2.2.28. Эрүүл зөв дадал хэвшил эзэмшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах багш, мэргэжилтэн, сургагч багш нарыг бэлтгэж мэдлэг чадварыг нь тогтмол сайжруулах боломжийг бүрдүүлнэ.

2.2.29. Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлийн судалгааг олон улсын түвшинд хэрэглэдэг стандартын дагуу хийх эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөтгөж, судалгаа хийх байгууллагад тавигдах шаардлагыг тодорхой болгож, чадавхжуулна.

ИРГЭД УРТ ХУГАЦААНЫ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ДААТГАЛЫН ТОГТОЛЦОО БҮРДҮҮЛЖ, ДААТГАЛЫН САНГИЙН ҮЛДЭГДЛИЙГ БҮРЭН АШИГЛАЖ ИРГЭДЭД ШААРДЛАГАТАЙ ТУСЛАМЖ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ТОГТОЛЦОО БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

2.2.30. Хүн амд эрүүл зөв амьдралын дадал хэвшүүлэх төвүүдийн тасралтгүй, урт хугацаанд хөгжих, ажиллах боломжийг бүрдүүлэх үүднээс Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

2.2.31. Иргэд оношилгоо, эмчилгээний олон улсын жишигт нийцсэн төвүүдэд (Зүрх судасны төв, Эд, эрхтэн шилжүүлэн суулгах үндэсний төв, яаралтай тусламжийн үндэсний төв...) өндөр өртөгтэй оношилгоо, эмчилгээ хийлгэх зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх боломжийг бүрдүүлнэ.

2.2.32. Эрүүл мэндтэй холбоотой асуудлаар амьдралын сүүлийн шатанд орсон өвчтөн болон хөгжлийн бэрхшээл, өндөр настай хүмүүс асаргааны төвд урт хугацаагаар эмчлүүлж, сувилуулах үйлчилгээний төлбөрийг эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

ЭРҮҮЛ ДУНДАЖ НАСЖИЛТААР БҮСИЙН ХЭМЖЭЭНД ТЭРГҮҮЛЭХ 10 ОРНЫ НЭГ БОЛЖ, ХУВЬ ХҮНИЙ ГЕН, ХООЛ ТЭЖЭЭЛИЙН ОНЦЛОГ ЗЭРЭГ ХУВЬ ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ОНЦЛОГТ ЧИГЛЭСЭН ХИЙМЭЛ ОЮУН УХААНД ТУЛГУУРЛАСАН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ НЭВТРҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

2.2.33. Анагаах ухаан, эрүүл мэндийн салбарын тусламж, үйлчилгээг хиймэл оюун ухаанд тулгуурлан хөгжүүлснээр аливаа өвчин эмгэгийг эрт илрүүлж, эмчлэх боломж бүрдэнэ.

2.2.34. Алслагдмал сум орон нутаг, хот, нийслэлд амьдарч байгаа хүмүүст үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар ижил түвшинд очиж, цахим эрүүл мэндийн системд бүрэн шилжинэ.

ГЭР БҮЛ

ЗОРИЛТ 2.3 Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжиж идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлнэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
ГЭР БҮЛД ЭЭЛТЭЙ ТОГТОЛЦОО	БҮТЭЭЛЧ ГЭР БҮЛ	ӨРХ, ГЭР БҮЛ, ЧАНАРТАЙ АМЬДРАЛ
Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжих үе	Идэвхтэй бүтээлч иргэн, гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлэх үе	Нийгмийн идэвхтэй, бүтээлч гэр бүлийг дэмжих орчинг бүрдүүлэх үе
<ol style="list-style-type: none"> Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжсэн судалгаа, нотолгоонд суурилсан гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын үр ашигтай тогтолцоо бүрдүүлэх Залуу гэр бүлийг дэмжсэн орчин, нөхцөл бүрдэж, цогц үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэх 	<ol style="list-style-type: none"> Хүн амын бүлгүүдийг, тэр дотроо залуу болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дэмжсэн, бүтээмжтэй ажил, хөдөлмөр эрхлүүлж, ижил үнэ цэнтэй ажилд ижил цалин хөлс олгох тогтолцоог бүрдүүлэх олон талт хөгжил, хамгааллын цогц тогтолцоо төлөвшүүлэх Гэр бүл, хувь хүний хөгжлийн хэрэгцээг дэмжсэн орчин, нөхцөл бүрдүүлж, цогц үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэх 	<ol style="list-style-type: none"> Хүн амын амьдралын чанарыг сайжруулахад чиглэсэн цогц үйл ажиллагааг хэрэгжүүлж, дэлхийд үнэлэгдэхүйц Монгол иргэнийг төлөвшүүлэх

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

СУДАЛГАА, НОТЛОГООНД СУУРИЛСАН ХҮН АМЫН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ДЭМЖСЭН, ГЭР БҮЛД ЭЭЛТЭЙ БОДЛОГО, ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ҮР АШИГТАЙ ТОГТОЛЦОО БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

2.3.1. Хүн амын тоо хэмжээ цөөнтэй манай орны хувьд хүн амын төрөлтийн түвшинг эргэн нөхөгдөх түвшин (нэг эмэгтэйд ногдох төрөлтийн түвшинг 2.1 ба түүнээс дээш)-гээс дээш байлгаснаар хүн амын өсөлтийг тогтвортой хангах, насны бүтцийг өсөлтөө дэмжсэн

байхад хүргэх ба хүн амын төрөлтийг дэмжих гэр бүлд ээлтэй хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

- 2.3.2. Монгол хүний хөгжлийн цогц судалгаанд үндэслэн төрөөс хүн ам, гэр бүл, хүүхэд, залуучууд, идэр, ахимаг настны талаар баримтлах бодлогыг боловсруулж, салбар дундын бодлого зохицуулалтыг сайжруулна.
- 2.3.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар өрхийн орлогыг тогтмол нэмэгдүүлнэ.
- 2.3.4. Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох аргачлалыг боловсронгуй болгож, гэр бүлийн гишүүн бүрд үзүүлэх нийгмийн халамжийн тусламж, дэмжлэгийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.3.5. Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний нэгдсэн, цогц тогтолцоог бүрдүүлнэ.

ЗАЛУУ ГЭР БҮЛИЙГ ДЭМЖСЭН ОРЧИН, НӨХЦӨЛ БҮРДҮҮЛЖ, ЦОГЦ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 2.3.6. Хүүхдийн тоо, наснаас хамааруулан хөнгөлөлт эдлүүлэх, хуримтлал бий болгох тогтолцоо бүрдүүлнэ.
- 2.3.7. Залуучуудын эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжих, бодит хуримтлал бий болгоход чиглэсэн “Залуу гэр бүл” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 2.3.8. Ажил хөдөлмөр эрхэлдэг эцэг эхэд ажил-ар гэрийн амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлнэ. (эцэг эхийн ажлын цагийн зохицуулалтыг оновчтой, сонголттой болгох, хагас цагийн хөдөлмөр эрхлэлт, зайнаас ажиллахыг дэмжих),
- 2.3.9. Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Оюутны хөдөлмөрийн бирж” байгуулж хөгжүүлнэ.
- 2.3.10. Гадаадад сурч, ажиллаж, амьдарч байгаа иргэдийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 2.3.11. Залуу гэр бүлд сэтгэл зүйн чиглэлээр зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлж, мэргэжлийн, судалгааны болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллана.

ШИНЖЛЭХ УХААН, ИННОВАЦИ

ЗОРИЛТ 2.4 Олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, инновацийн тогтолцоог хөгжүүлнэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020-2030)	II үе шат (2031-2040)	III үе шат (2041-2050)
ИННОВАЦИЙН ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО	ҮНДЭСНИЙ ИННОВАЦИЙГ ДЭЛХИЙД	ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ
Шинжлэх ухаан, судалгаа хөгжүүлэлт, инновацийн үр ашигтай үндэсний тогтолцоог бүрдүүлэх үе	Үндэсний шинжлэх ухаан, инновацийг дэлхийн зах зээлд гаргах тогтолцоо бүрдүүлэх үе	Олон улсад өрсөлдөх чадвартай шинжлэх ухаан, технологийн салбарыг хөгжүүлэх үе
<ol style="list-style-type: none"> Мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор судалгаа хөгжүүлэлт, инновацийн санхүүжилтийн олон эх үүсвэрт тогтолцоо бүхий төр- шинжлэх ухаан-үйлдвэрлэл, бизнесийн түншлэлийн таатай орчныг бүрдүүлэх Үндэсний инновацийн тогтолцооны дэд бүтцийг байгуулж, мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах тогтолцоо бий болгох Эрдэм шинжилгээний ажилтны цалин хөлс, урамшууллын тогтолцоог шинэчилж, чадварлаг эрдэмтдийг бэлтгэх үндэсний тогтолцоо бий болгож, олон улсын томоохон судалгаанд оролцох боломжийг нэмэгдүүлэх 	<ol style="list-style-type: none"> Нано-, био-, мэдээллийн технологи, хиймэл оюун ухаан зэрэг шинжлэх ухаан, инновацийн тэргүүлэх чиглэлд оруулах хөрөнгө нөөц болон бусад дэмжлэгийг нэмэгдүүлж, ногоон, дижитал эдийн засаг, оюуны үйлдвэрлэлийн бүс нутгийн жишигт хүргэх Олон улсад танигдсан чадварлаг эрдэмтдийг бэлтгэх, тэдгээрийн глобал судалгаанд оролцох хэмжээг нэмэгдүүлэн, урамшуулах механизм бүрдүүлэх 	<ol style="list-style-type: none"> Нано-, био-, мэдээллийн технологи, хиймэл оюун ухаан зэрэг тэргүүлэх чиглэл, ногоон, дижитал эдийн засаг, оюуны үйлдвэрлэлийн салбарт дэлхийн жишигт хүрсэн тоглогч болох

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ШИНЭ МЭДЛЭГИЙГ ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭД ОРУУЛАХ, ТӨР – ШИНЖЛЭХ УХААН – ҮЙЛДВЭРЛЭЛ, БИЗНЕСИЙН ТҮНШЛЭЛИЙН ТААТАЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 2.4.1. Төрөөс хувийн хэвшлийн судалгаа хөгжүүлэлтийн хөрөнгө оруулалтыг бодлого, татварын орчноор дэмжинэ.
- 2.4.2. Хувийн хэвшлийн технологийн хөгжүүлэлтийг дэмжих тогтолцоо, бүтцийг оновчтой бүрдүүлж, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 2.4.3. Улс орны өмнө тулгарч байгаа асуудлуудыг шийдвэрлэхэд эрдэм шинжилгээний болон үйлдвэрлэл, бизнесийн байгууллагын хөрөнгө оруулалтыг дэмжиж, грант төсөл хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- 2.4.4. Шинжлэх ухаан, инновацийн салбарт хөрөнгө оруулалт, санхүүжилтийн олон эх үүсвэрт тогтолцоо бүрдүүлэн, төр, хувийн хэвшлийн түншлэлийн механизм бий болгож, гадаадын дэвшилтэт технологи нутагшуулахад чиглэсэн соёлыг төлөвшүүлнэ.
- 2.4.5. Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарын эрх зүйн орчныг шинэчилж, инновацийн үйл ажиллагааг дэмжих, хөрөнгө оруулалт хийхэд чиглэсэн тусгай зориулалтын сангууд /инновацийн сан, венчи сан, эндаумент сан/-ыг байгуулна.

ҮНДЭСНИЙ ИННОВАЦИЙН ТОГТОЛЦООНЫ ДЭД БҮТЦҮҮДИЙГ БАЙГУУЛЖ, МЭДЛЭГИЙГ ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭД ОРУУЛАХ ТОГТОЛЦОО БИЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР

- 2.4.6. Мэдлэгийн үйлдвэрлэл дэх хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангаж, шинэ мэдлэг бий болгоход гаргасан зардлын тодорхой хэсгийг төрөөс нөхөн төлдөг тогтолцоотой болно.
- 2.4.7. Шинэ мэдлэгийг бүтээгдэхүүн, үйлчилгээ болгон хэрэглээнд нэвтрүүлэхэд хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж, грант олгоно.
- 2.4.8. Олон улсын түвшинд судалгаа хөгжүүлэлтийн ажил явуулахад шаардагдах материаллаг орчин, чанар, үйлчилгээний стандартыг бий болгоно.
- 2.4.9. Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэхэд шаардлагатай технологийн үнэлгээний төв, технологийн инкубатор, шинжлэх ухааны парк зэрэг дэд бүтцийг байгуулна.
- 2.4.10. Аж үйлдвэрийн тэргүүлэх салбарт дэвшилтэт болон шинэ технологи, бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгосон, нэвтрүүлсэн, нутагшуулсан аж ахуйн нэгжийг гааль, татвар, зээлийн бодлогоор дэмжинэ.

- 2.4.11. Тоон технологи ашиглан мэдээлэл, үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэхэд чиглэсэн инновацийн үйл ажиллагааг төр, иргэн, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын түншлэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛТНЫ ЦАЛИН ХӨЛС, УРАМШУУЛЛЫН ТОГТОЛЦООГ ШИНЭЧИЛЖ, ЧАДВАРЛАГ ЭРДЭМТЭН БЭЛТГЭХ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО БИЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР

- 2.4.12. Судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнд суурилсан шагнал, урамшууллын тогтолцоог бий болгоно.
- 2.4.13. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээл, патент бүрийг урамшуулах тогтолцоог бий болгоно.
- 2.4.14. Шинэ бүтээлийн нийгэм, эдийн засгийн ач холбогдол үнэлэн, үр өгөөжийн тодорхой хувиар шагнах санхүүгийн тогтолцоог бүрдүүлнэ.
- 2.4.15. Шинжлэх ухаан, технологийн санг олон улсын адил төстэй сангуудын жишиг, хөгжлийн бодлогод нийцүүлэн өөрчлөн зохион байгуулна.
- 2.4.16. Эрдэм шинжилгээний хүрээлэн, их сургуулийг сургалт, судалгаа хөгжүүлэлт, инновацийн төв болгон хөгжүүлнэ.
- 2.4.17. Аж ахуйн нэгж, олон нийтэд инноваци, энтэрпренёршипийн боловсрол олгох, инновацийн соёлыг түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, шинжлэх ухаан, технологи, танин мэдэхүйн төрөл бүрийн контент бүтээх ажлыг дэмжинэ.
- 2.4.18. Тэргүүлэх чиглэлээр судалгаа хөгжүүлэлтийн ажил эрхэлдэг эрдэм шинжилгээний ажилтны чадвар, бүтээлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг олон улсын үнэлгээний жишигт нийцүүлж, үр дүнд тохирсон цалин, урамшууллын тогтолцоог бүрдүүлнэ.
- 2.4.19. Олон улсын жишигт нийцсэн докторын дараах судалгаа, сургалтын тогтолцоо бий болгон хөгжүүлнэ.
- 2.4.20. Эрдэмтэн, судлаачид олон улсын томоохон судалгаанд оролцох боломжийг нэмэгдүүлж, оролцоог дэмжинэ.

ХҮНД ЭЭЛТЭЙ АМЬДРАХ ОРЧИН

ЗОРИЛТ 2.5 Амьдралын хэрэгцээ хангасан эрүүл, ая тухтай, таатай орчин бүрдүүлж баталгаат хүнсээр хангана.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
ЭРҮҮЛ БАТАЛГААТ ОРЧИН	АМЬДРАХ ТААТАЙ ОРЧИН	ӨРХ, ХҮН АМД ЭЭЛТЭЙ АМЬДРАХ ОРЧИН
Эрүүл баталгаат орчин бий болгох үе	Амьдралын таатай орчин бүрдүүлэх үе	Амьдралын хэрэгцээ хангагдсан орчин бүрдүүлэх үе
<ol style="list-style-type: none"> Орон сууц, ногоон байгууламжийн стандартыг мөрдөж, эрүүл баталгаат амьдрах орчныг бий болгох Агаар, ус, хөрс, дуу чимээний бохирдлыг багасгаж, цэвэр, ногоон байгууламж бүхий орчинтой болгох Эрүүл мэндийн болон орчны тандалт, нөлөөллийн үнэлгээ хийх тогтолцоог бий болгож бэхжүүлэх Хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлэх Инноваци нэвтрүүлсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж аюулгүй, тэжээллэг хэрэгцээт хүнсээр хангадаг болох 	<ol style="list-style-type: none"> Тохилог, амьдралын таатай орчин бүрдүүлж, орон сууцны хотхон, хорооллын төлөвлөлтийг олон улсын стандарт, шаардлагад нийцүүлэн хог хаягдлын зохистой менежментийг хэвшүүлэх Ногоон бүс, бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах, нэг хүнд ногдох цэцэрлэгжсэн талбайн хэмжээг нэмэгдүүлэх замаар хот, суурин газрын ногоон байгууламжийг хот төлөвлөлтийн стандартад нийцүүлэх Хүнсний хангамж, нийлүүлэлтийн үйл ажиллагаанд тавих эрүүл ахуй, аюулгүй байдлын стандарт шаардлагыг боловсронгуй болгож, баталгаат хүнсний үйлдвэрлэлийн тогтвортой систем бий болгон органик, баяжуулсан, зохицуулах үйлчилгээтэй болон эрүүл хүнсний хэрэглээтэй болох 	<ol style="list-style-type: none"> Орчны бохирдлоос шалтгаалсан хүний эрүүл мэнд, эдийн засагт учрах сөрөг нөлөөлөл бүрэн арилж, хот, сум, суурингуудад авто зогсоол, оршин суугчид амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэхэд зориулсан ногоон байгууламж, усан сан, биеийн тамирын талбай бүхий тохилог эко орчинг бүрдүүлэх Монгол брэндийн эко хүнс экспортлох нөхцөлийг сайжруулж, хүнсний боловсруулах салбарыг хөгжлөөр тэргүүлэх

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ОРОН СУУЦ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН НОРМ, СТАНДАРТЫГ МӨРДӨЖ, ЭРҮҮЛ БАТАЛГААТ АМЬДРАХ ОРЧНЫГ БИЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР

- Орон сууцны 1 хүнд оногдох талбайн хэмжээг нэмэгдүүлж дэлхийн жишигт хүргэнэ.
- Орон сууцны чанар, стандартыг ханган, гал түймэр, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт үзэгдэлд тэсвэртэй байх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээнд холбогдсон амины орон сууцны хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэн 2050 он гэхэд бүх төрлийн орон сууцыг инженерийн шугам сүлжээтэй болгоно.
- Орон сууцны халаалт, эрчим хүчний эх үүсвэрийг сэргээгдэх эрчим хүчээр хангана.
- Нэг хүнд оногдох ногоон байгууламжийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлж дэлхийн жишигт хүргэнэ.
- Ногоон байгууламжийн усалгаанд хур тунадасны болон саарал усыг бүрэн ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.

АГААР, УС, ХӨРС, ДУУ ЧИМЭЭНИЙ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД САЙЖИРЧ, ЦЭВЭР, НОГООН БАЙГУУЛАМЖ БҮХИЙ ОРЧИНТОЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР

- Агаар орчны бохирдлыг бууруулахад иргэдийн оролцоог хангах, хандлагыг өөрчлөх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулна.
- Агаар болон орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр болон хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Сайжруулсан түлш, цэвэр түлшний хэрэглээг нэмэгдүүлэх, НӨАТ-аас чөлөөлөнө.
- Хог хаягдлын цогц менежмент 3R-ийг хэрэгжүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах, дахин боловсруулах, ашиглах загвар төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, загвар төсөл хэрэгжүүлэх, ногоон байгууламж бүхий талбайг нэмэгдүүлнэ.
- Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламж болон бусад хот, суурин газрын ариутгах татуургын байгууламж, үйлдвэрийн урьдчилан цэвэрлэх байгууламжийг байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологиор өргөтгөж, шинэчилнэ.
- Төвлөрсөн дэд бүтцийн системд холбогдох боломжгүй хэрэглэгчийг хэсэгчилсэн бие даасан инженерийн хангамжид холбох, бичил дэд төвүүдийг байгуулах төслийг үе шаттай хэрэгжүүлнэ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОН ОРЧНЫ ТАНДАЛТ, НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОЖ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

2.5.13. Орчны эрүүл мэндийн үзүүлэлтийн шаардлага, стандарт, тохирлуудыг олон улсын стандарт руу ойртуулан тохируулж, шинэчилнэ.

2.5.14. Илчлэг, транс тос, чихэр, давсны агууламж өндөр хүнс, чихэрлэг ундааны үйлдвэрлэл, худалдааг татварын бодлогоор хязгаарлах, хүнсний аюулгүй байдлын хууль эрх зүйн орчин бүрдүүлнэ.

ХҮНСНИЙ СҮЛЖЭЭНИЙ БҮХ ҮЕ ШАТАНД БҮРТГЭЛ, ЧАНАРЫН УДИРДЛАГА, ХЯНАЛТ, БАТАЛГААЖУУЛАЛТЫН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

2.5.15. Генийн өөрчлөлттэй бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, худалдаалах, хадгалах, дамжуулан тээвэрлэхийг хориглоно.

2.5.16. Үрийн сан, хөрс хамгаалалт, хөрс боловсруулалт, тариалалт, усалгаа, хураалт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалт, жижиглэн худалдааг хамарсан төмс, хүнсний ногооны мөшгөлтийн мэдээллийн тогтолцоог бий болгон хүнсний аюулгүй байдлыг бүрэн хянаана.

2.5.17. Малын бэлчээр, усалгаа, тэжээл, вакцин хэрэглээний аюулгүй байдлыг ханган үйлдвэрлэлийн аргаар бэлтгэсэн мах, махан бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, түүний хяналт мэдээллийн тогтолцоог бий болгоно.

2.5.18. Импортын хүнсний бүтээгдэхүүнийг шинжлэх, хяналтын лабораторийг байгуулж, чадавхжуулах, бүртгэлийн хяналтыг чангатгана.

2.5.19. Хүнсний боловсруулах үйлдвэрүүдэд аюулын дүн шинжилгээ болон эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо, хүнсний аюулгүй байдлын чанарын удирдлагын тогтолцоо, хүнсний хэлхээ (дамжлагуудын)-ний хяналтын тогтолцоо, стандартыг нэвтрүүлнэ.

АЮУЛГҮЙ, ТЭЖЭЭЛЛЭГ ХЭРЭГЦЭЭТ ХҮНСЭЭР ХАНГАДАГ БОЛОХ ЧИГЛЭЛЭЭР

2.5.20. Хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтворжуулах, хүнсний сүлжээний бүх шатанд бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, хүнсний салбарын стандартуудыг олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилтэт стандартад хүргэхэд чиглэсэн төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.

2.5.21. Органик, баяжуулсан, зохицуулах үйлчлэлтэй, инноваци нэвтрүүлсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ.

2.5.22. Хил дамнасан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хяналт шинжилгээ, лаборатори байгуулах, тандалт, хариу арга хэмжээний механизмыг бий болгоно.

2.5.23. Өрхийн хүнсний баталгаат байдал алдагдлаас ядуу, эмзэг бүлгийн хүн амыг хамгаалах нийгмийн хамгааллын арга хэмжээг бэхжүүлнэ.

2.5.24. Малын эрүүл мэндийг хамгаалах Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

ЗОРИЛТ 2.6 Хөдөлмөрийн эдийн засгийн тэнцвэрийг хангаж, мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, иргэн бүрийг ажилтай, орлоготой болгоно.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020-2030)	II үе шат (2031-2040)	III үе шат (2041-2050)
ТЭНЦВЭРТЭЙ ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ, БҮТЭЭМЖИД СУУРИЛСАН ОНОВЧТОЙ ТОГТОЛЦОО	БҮТЭЭМЖИД СУУРИЛСАН ОНОВЧТОЙ ТОГТОЛЦОО	АЖИЛТАЙ, ОРЛОГОТой МЭРГЭЖИЛТЭН
Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангах, хэрэгцээнд суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бэхжүүлэх үе	Бүтээмжид суурилсан, хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бэхжүүлэх үе	Мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, хүн бүр ажилтай, орлоготой болох орчин нөхцөл бүрдүүлэх үе
<ol style="list-style-type: none"> 1. Мөнгө, санхүүгийн бодлогоор ажлын байр нэмэгдүүлэх, ажлын байрны статистик мэдээллийг аймаг, сум, дүүргээр гаргах 2. Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй, ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж, нээлттэй боловсролын зарчимд тулгуурласан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн тэгш, хүртээмжтэй орчин бүрдүүлэх 3. Хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 4. Оюуны хөдөлмөрийг дэмжсэн онлайн, зайн ажлын байрыг нэмэгдүүлэн, тогтолцоог нь дэмжиж хөгжүүлэх 	<ol style="list-style-type: none"> 1. Эдийн засгийн тэргүүлэх чиглэл, ажлын байрны шингээлт ихтэй аж үйлдвэр, хөнгөн үйлдвэрлэл, бүтээмжтэй үйлчилгээний салбарууд, орчин үеийн дижитал салбар, эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хөдөлмөрийн үнэлгээ, цалин хөлсний оновчтой механизм бүрдүүлэх 2. Олон улсад оюуны бүтээл, МТ-ийн болон зөвлөх үйлчилгээг үзүүлэх тогтолцоог дэмжих зуучлагч компани, төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлэх 	<ol style="list-style-type: none"> 1. Дижитал эринд шаардагдах ур чадварыг эзэмшүүлэх, хөгжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах, хөдөлмөр эрхлэлтийг ажлын байр бий болгох төр, хувийн хэвшлийн түншлэлийн оновчтой тогтолцоо бүрдүүлэх

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

МӨНГӨ, САНХҮҮГИЙН БОДЛОГООР АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ, АЖЛЫН БАЙРНЫ СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙГ АЙМАГ, СУМ, ДҮҮРГЭЭР ГАРГАХ ЧИГЛЭЛЭЭР

- 2.6.1. Мөнгөний бодлогыг ажлын байр нэмэгдүүлэхэд чиглүүлнэ.
- 2.6.2. Байнгын ажил олгох хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 2.6.3. Ажлын байр олноор бий болгож байгаа ААН, байгууллагуудыг урамшуулна.
- 2.6.4. Ажлын байрны мэдээллийг аймаг, сум, дүүргээр гаргаж, хөдөлмөр эрхлэлтийн шилжилт хөдөлгөөнийг зохицуулах механизмыг бүрдүүлнэ.
- 2.6.5. ДНБ-нд цалин болон түүнтэй тэнцэх орлогын эзлэх хувиар шалгуур үзүүлэлт болгон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын хүрэх үр дүнг тогтооно.

НЭЭЛТТЭЙ БОЛОВСРОЛЫН ЗАРЧИМД ТУЛГУУРЛАСАН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, ХЭРЭГЦЭЭНД НИЙЦСЭН ТЭГШ, ХҮРТЭЭМЖТЭЙ ОРЧИН БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 2.6.6. Гэр бүлийн анхдагч хэрэгцээг цалин, орлогынхоо 50 хувиар хангах цалингийн тогтолцоог шинэчилнэ.
- 2.6.7. Иргэдийн цалин, урамшууллыг тогтмол нэмэгдүүлэхэд Компанийн нийгмийн хариуцлагын хөтөлбөрийг дэмжин урамшуулна.
- 2.6.8. Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй, ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох мэргэжлийн чиглэлээр хүний нөөц бэлтгэх бодлого, "AI ирээдүй" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 2.6.9. Мэргэшлийн үндэсний хүрээг тогтоох, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангах тогтолцоог бэхжүүлнэ.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 2.6.10. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн салбар дундын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 2.6.11. Ажлын байр ихээр нэмэгдүүлж байгаа ААН, хувийн хэвшлийг алдаршуулна.
- 2.6.12. Гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн ханган нийлүүлэлтийн хэрэгцээг хангахад дотоодын ААН-үүдийг уялдуулан хөгжүүлэх Үндэсний ханган нийлүүлэлтийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ. Хүн амын бүлэг бүрийн онцлогт уялдсан хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.6.13. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжихэд чиглэсэн шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлнэ.
- 2.6.14. Ажилгүйдлийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно.
- 2.6.15. Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, гадаад иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг хүн амын аюулгүй байдлыг хангах болон мэргэжлийн өндөр ур чадвар, технологийг хөдөлмөрийн зах зээлд нутагшуулах бодлоготой уялдуулна.

УДМЫН САН

ЗОРИЛТ 2.7 Монгол хүний удмын санг хамгаалж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлж, монгол хүний хөгжлийг дэмжинэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020-2030)	II үе шат (2031-2040)	III үе шат (2041-2050)
УДАМТ МОНГОЛ-ӨВ СОЁЛ	УДМЫН ХЭЛХЭЭ БА НӨХӨН ҮРЖИХҮЙ	МОНГОЛ ОВГИЙН ДАРХЛАА
Угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээх, дэмжих үе	Удмын сангийн аюулгүй байдлыг хангах үе	Монгол хүний генийг хамгаалах судалгаанд суурилсан бодлого хэрэгжүүлэх үе
<ol style="list-style-type: none"> 1. Угийн бичиг хөтлөх, цус ойртолтыг багасгах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх 2. Хүн бүр удмаа мэдэж, угийн бичгээ хөтлөх үндэсний уламжлалыг сэргээн хөгжүүлэх 3. Цус ойртолтоос сэргийлж, удамшлын өвчин болон төрөлхийн согогтой хүүхдийн эрт оношилгооны чадавхыг дээшлүүлэх 4. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаачдын тооны зохист түвшинг хадгалах, хяналт тавих 	<ol style="list-style-type: none"> 1. Цус ойртолтоос хамгаалах 2. Иргэдийн удмын хэлхээг тодорхойлох мэдээллийн систем хөгжүүлэх хэрэгжүүлэх 3. Удамшлын өвчин, эмгэг согог, оюун ухааны хомстолтой хүүхэд төрөхөөс урьдчилан сэргийлэх, эмнэлэг, удамшил зүйн хяналтын тогтолцоог хөгжүүлэх 	<ol style="list-style-type: none"> 1. Хувь хүний генетикийн чадварт суурилсан судалгааг хөгжүүлэх 2. Хүн амын генетикийн тооцооллын аргаар аймаг бүрийн хүн амд шууд цус ойртолтын (FIS) болон нийт цус ойртолтын (FIT) коэффициентийг тооцоолж, дүн шинжилгээнд үндэслэсэн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх 3. Хүн бүр удмын мэдээлэл агуулсан цахим үнэмлэхтэй болох

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 2.7.1. Хүн бүр удмаа мэдэж, угийн бичгээ хөтлөх үндэсний уламжлалыг сэргээн хөгжүүлж, угийн бичиг хөтлөх, цус ойртолтыг багасгах үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 2.7.2. Цус ойртолтоос сэргийлж, удамшлын өвчин болон төрөлхийн согогтой хүүхдийн эрт оношлогооны чадавхыг дээшлүүлнэ.
- 2.7.3. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаачдын тооны зохист төвшинг хадгалж, бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно.
- 2.7.4. Ургийн үеэс эхлэн монгол хүний насны онцлогт тохирсон эрүүл мэнд-бие бялдар, боловсрол- эх оронч хүмүүжил олгох хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 2.7.5. Гэрлэлт бүртгэл, гэрлэлт салалтын талаар угийн бичигт тэмдэглэн үлдээх талаар зохицуулалт бий болгож, удам угсаагаа сайтар сахисан гэр бүлийг дэмжих, урамшуулах арга хэмжээ хэрэгжүүлнэ.

ХҮНИЙ ХӨГЖИЛ ЗОРИЛГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

Хүснэгт 2.4. Хүн ба нийгмийн хөгжил зорилгын хэрэгжилтийн хяналт,
үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин

Тайлбар: * тэмдэглэгээ бүхий шалгуур үзүүлэлтийг шинээр тооцдог болно.

#	Шалгуур үзүүлэлт (indicator)	Хэмжих нэгж	Суурь түвшин	2030	2040	2050	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хаанаас авах эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах аргазүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
2	НИЙГМИЙН ХӨГЖИЛ										
1	Хүний хөгжлийн индекс	индекс	0.74	0.8	0.85	0.9	2018 он суурь түвшин	Үндэсний статистикийн хороо	Албан ёсны статистик мэдээ	жилд 1 удаа	Үндэсний статистикийн хороо
2	Тэгш байдлыг хангасан сургуулийн эзлэх хувь*	хувь		85	90	100	Аюулгүй орчин бүрдсэн, Хүүхдийг үе тэнгийн дарамтаас хамгаалсан, хамран сургах тойргийнхоо эмзэг бүлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бүрэн хамруулсан, багшийн ажиллах орчин бүрдсэн	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Түүвэр судалгаа	2 жилд 1 удаа	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
3	СӨБ-д хамрагдсан малчдын хүүхдийн хувь	хувь		85	90	100	Малчин өрхөд буй хүүхдээс СӨБ-д хамрагдсан хувийг тооцно.	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	статистик мэдээ	жилд 1 удаа	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
4	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт хамран сургалтын бохир жин	хувь	75.3	95	99	100	2018 он суурь түвшин	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	статистик мэдээ	жилд 1 удаа	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5	Бага боловсролын хамран сургалт хамран сургалтын бохир жин	хувь	96.6	100	100	100	2018 он суурь түвшин	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	статистик мэдээ	жилд 1 удаа	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
6	Суурь боловсролын хамран сургалтын бохир жин	хувь	97.1	100	100	100	2018 он суурь түвшин	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	статистик мэдээ	жилд 1 удаа	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

#	Шалгуур үзүүлэлт (indicator)	Хэмжих нэгж	Суурь түвшин	2030	2040	2050	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хаанаас авах эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах аргазүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
7	Бага боловсролын шалгуурт суурилсан шалгалт, хөндлөнгийн үнэлгээний гүйцэтгэл	дундаж хувь	41.7	75	80	90	2018 он суурь түвшин	Боловсролын үнэлгээний байгууллага	Түүвэр судалгаа	жилд 1 удаа	Боловсролын үнэлгээний байгууллага
8	Суурь боловсролын шалгуурт суурилсан шалгалт, хөндлөнгийн үнэлгээний гүйцэтгэл	дундаж хувь	37.1	75	80	90	2018 он суурь түвшин	Боловсролын үнэлгээний байгууллага	Түүвэр судалгаа	жилд 1 удаа	Боловсролын үнэлгээний байгууллага
9	Бүрэн дунд боловсролын шалгуурт суурилсан шалгалт, хөндлөнгийн үнэлгээний гүйцэтгэл	дундаж хувь	39.9	75	80	90	2018 он суурь түвшин	Боловсролын үнэлгээний байгууллага	Түүвэр судалгаа	жилд 1 удаа	Боловсролын үнэлгээний байгууллага
10	7-14 насны хүүхдийн унших суурь чадвар эзэмшсэн хувь	хувь	61.6	75	80	90	2018 он суурь түвшин	Үндэсний статистикийн хороо	Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа	5 жилд 1 удаа	Үндэсний статистикийн хороо
11	7-14 насны хүүхдийн тоо бодох суурь чадвар эзэмшсэн хувь	хувь	51.5	75	80	90	2018 он суурь түвшин	Үндэсний статистикийн хороо	Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа	5 жилд 1 удаа	Үндэсний статистикийн хороо
12	Төгссөний дараа мэргэжлээрээ ажил эрхэлж буй МСҮТ төгсөгчдийн эзлэх хувь*	хувь	-	95	100	100	хөдөлмөр эрхлэлтийн мөшгөх судалгаа хийнэ.	Мэргэжлийн боловсрол, сургалтын төв	статистик мэдээ	жилд 1 удаа	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
13	Төгссөний дараа мэргэжлээрээ ажил эрхэлж буй их, дээд сургууль төгсөгчдийн эзлэх хувь*	хувь	-	95	100	100	хөдөлмөр эрхлэлтийн мөшгөх судалгаа хийнэ.	Их сургууль	статистик мэдээ	жилд 1 удаа	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
14	Төгссөний дараа мэргэжлээрээ олон улсад, бүс нутагт ажил эрхэлж буй төгсөгч*	тоо	-		1000	1000	хөдөлмөр эрхлэлтийн мөшгөх судалгаа хийнэ.	Их сургууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын төв	статистик мэдээ	жилд 1 удаа	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

#	Шалгуур үзүүлэлт (indicator)	Хэмжих нэгж	Суурь түвшин	2030	2040	2050	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хаанаас авах эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах аргазүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
15	Стандартын шаардлага бүрэн хангасан орчин бүрдүүлсэн бүх шатны сургалтын байгууллагын эзлэх хувь, СӨБ, ЕБС, ИДС, МСҮТ-өөр	хувь	-	95	100	100		Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	статистик мэдээ	жилд 1 удаа	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
16	Ажил мэргэжлийн ур чадвараа сүүлийн 1 жилд дээшлүүлсэн иргэдийн хөдөлмөрийн насны хүн амд эзлэх хувь*	хувь	-	70	85	90	Мэргэжил дээшлүүлэх сургалт, үйл ажиллагааны бүх хэлбэрийг оруулж тооцно.	Насан туршийн боловсролын үндэсний төв	статистик мэдээ	жилд 1 удаа	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
17	Багш, салбарын ажилтны дундаж цалингийн хэмжээ	мянган төгрөг	760.2	1509.2	2069.8	2630.5		Үндэсний статистикийн хороо	статистик мэдээ	жилд 1 удаа	Үндэсний статистикийн хороо
18	Бүлэг дүүргэлт / нэг бүлэгт ногдох цэцэрлэгийн хүүхдийн дундаж тоо, бага, дунд, ахлах, бэлтгэл бүлэг/	тоо	33	20-30	20-30	20-30		Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Жилийн тайлан, холбогдох статистик мэдээллийн маягт, Боловсролын суурь мэдээллийн системийн өгөгдөл	жилд 1 удаа	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
19	Бүлэг дүүргэлт, хот /нэг ангид ногдох ЕБС-д суралцагчдын дундаж тоо/	тоо	хотод 35, хөдөө - 28	25	25	25		Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Жилийн тайлан, холбогдох статистик мэдээллийн маягт, Боловсролын суурь мэдээллийн системийн өгөгдөл	жилд 1 удаа	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

#	Шалгуур үзүүлэлт (indicator)	Хэмжих нэгж	Суурь түвшин	2030	2040	2050	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хаанаас авах эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах аргазүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
20	Бүх бүлэг дүүргэлт норматив хэмжээнд байгаа сургууль, цэцэрлэгийн эзлэх хувь	хувь		85	90	100		Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Жилийн тайлан, холбогдох статистик мэдээллийн маягт, Боловсролын суурь мэдээллийн системийн өгөгдөл	жилд 1 удаа	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
21	Ээлжийн коэффициент	тоо	-	2	1.5	1		Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Жилийн тайлан, статистик мэдээ, Боловсролын суурь мэдээллийн систем	жилд 1 удаа	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
22	Эко сургууль хөтөлбөрт хамрагдсан сургуулийн хувь	хувь		80	100	100		Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Жилийн тайлан, статистик мэдээ, Боловсролын суурь мэдээллийн систем	жилд 1 удаа	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
23	Эко цэцэрлэг хөтөлбөрт хамрагдсан цэцэрлэгийн хувь	хувь		30	50	80		Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Жилийн тайлан, статистик мэдээ, Боловсролын суурь мэдээллийн систем	жилд 1 удаа	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
24	Нийт сургалтын байгууллагуудаас нээлттэй боловсролын нэгдсэн платформд хөтөлбөр байршуулсан сургалтын байгууллагын эзлэх хувь*	хувь	-	60+	60+	60+		Насан туршийн боловсролын үндэсний төв	Нээлттэй боловсролын нэгдсэн платформ дахь статистик үзүүлэлт	жилд 1 удаа	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

#	Шалгуур үзүүлэлт (indicator)	Хэмжих нэгж	Суурь түвшин	2030	2040	2050	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хаанаас авах эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах аргазүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
25	Нээлттэй боловсролын нэгдсэн платформд байршуулсан хөтөлбөрийн тоо*	тоо	-	600	800	1500		Насан туршийн боловсролын үндэсний төв	Нээлттэй боловсролын нэгдсэн платформ дахь статистик үзүүлэлт	жилд 1 удаа	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
26	Нийт суралцагчдад/хүн амд нэгдсэн платформ байршуулсан хөтөлбөрийг судалсан суралцагчдын эзлэх хувь*	хувь	-	600000	1000000	2000000		Насан туршийн боловсролын үндэсний төв	Нээлттэй боловсролын нэгдсэн платформ дахь статистик үзүүлэлт	жилд 1 удаа	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
27	15-49 насны эрэгтэйчүүдийн хүн амд МХХТ-ийн ур чадвартай эрэгтэйчүүдийн эзлэх хувь	хувь	29.7	80	100		Энэ судалгаагаар зөвхөн 15-49 насаар гардаг. Хүйсээр тусдаа гардаг.	Үндэсний статистикийн хороо	Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа	5 жилд 1 удаа	Үндэсний статистикийн хороо
28	15-49 насны эмэгтэйчүүдийн хүн амд МХХТ-ийн ур чадвартай эмэгтэйчүүдийн эзлэх хувь	хувь	31.6	80	100		Энэ судалгаагаар зөвхөн 15-49 насаар гардаг. Хүйсээр тусдаа гардаг.	Үндэсний статистикийн хороо	Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа	5 жилд 1 удаа	Үндэсний статистикийн хороо
29	15-24 насны эрэгтэйчүүдийн хүн амд МХХТ-ийн ур чадвартай эрэгтэй залуучуудын эзлэх хувь	хувь	44.9	80	100		Олон улсын тодорхойлолтоор 15-24 насны хүнийг залуучууд гэж үздэг	Үндэсний статистикийн хороо	Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа	5 жилд 1 удаа	Үндэсний статистикийн хороо
30	15-24 насны эмэгтэйчүүдийн хүн амд МХХТ-ийн ур чадвартай эмэгтэй залуучуудын эзлэх хувь	хувь	42.9	80	100		Олон улсын тодорхойлолтоор 15-24 насны хүнийг залуучууд гэж үздэг	Үндэсний статистикийн хороо	Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа	5 жилд 1 удаа	Үндэсний статистикийн хороо
31	Гадаад хэл дээр боловсруулсан онлайн сургалтын хөтөлбөр*	тоо	-	20+	100+	300+		Боловсролын суурь мэдээллийн систем	Боловсролын суурь мэдээллийн систем	жилд 1 удаа	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

#	Шалгуур үзүүлэлт (indicator)	Хэмжих нэгж	Суурь түвшин	2030	2040	2050	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хаанаас авах эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах аргазүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага	
32	1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин	промилль	13.4	8.0	4.5	2.3		2018 он суурь түвшин	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Үндэсний статистикийн хороо	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Захиргааны статистик мэдээлэл	Жилд 1 удаа	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
33	1000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн харьцаа	промилль	27.1	15.0	10.0	5.0		2018 он суурь түвшин	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Үндэсний статистикийн хороо	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Захиргааны статистик мэдээлэл	Жилд 1 удаа	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
34	Тухайн жилд товлот дархлаажуулалтын хамрагдалт	хувь	98.9	100	100	100		2018 он суурь түвшин	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Халдарт өвчин судлалын үндэсний төв	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Захиргааны статистик мэдээлэл	жилд 1 удаа	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
35	Тавт вакцины 3 дах тунгийн хамралтын хувь	хувь	98.6	Суурь үзүүлэлтээс доошгүй	Суурь үзүүлэлтээс доошгүй	Суурь үзүүлэлтээс доошгүй		Тавт вакцины 3 дах тунг бүрэн хамралтын тун гэнэ.	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Халдарт өвчин судлалын үндэсний төв	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Захиргааны статистик мэдээлэл	жилд 1 удаа	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

#	Шалгуур үзүүлэлт (indicator)	Хэмжих нэгж	Суурь түвшин	2030	2040	2050	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хаанаас авах эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах аргазүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
36	Улаанбурхан-Гахайн хавдар-Улаануудын /УГУ/ эсрэг вакцины 2 дахь тунгийн хамралтын хувь	хувь	98.0	Суурь үзүүлэлтээс доошгүй	Суурь үзүүлэлтээс доошгүй	Суурь үзүүлэлтээс доошгүй	УГУ-ын эсрэг вакцины 2 дах тунг бүрэн хамралтын тун гэнэ.	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Халдарт өвчин судлалын үндэсний төв	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Захиргааны статистик мэдээлэл	жилд 1 удаа	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
37	Эрүүл мэндийн салбарын нийт зардалд иргэний шууд төлөх төлбөр	эзлэх хувь	41	23	18	15	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, 2012, Дэлхий нийтийн эрүүл мэндийн зардлын зураглал. Женев хот	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Захиргааны статистик мэдээлэл	Жилд 1 удаа	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
38	Артерийн даралт ихсэх	хувь	71.7	93.7	100.0	100.0	2018 он суурь түвшин	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Эрүүл мэндийн хөгжлийн төв	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Захиргааны статистик мэдээлэл	жилд 1 удаа	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
39	Чихрийн шижин	хувь	67.8	97.0	100.0	100.0	2018 он суурь түвшин	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Эрүүл мэндийн хөгжлийн төв	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Захиргааны статистик мэдээлэл	жилд 1 удаа	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

#	Шалгуур үзүүлэлт (indicator)	Хэмжих нэгж	Суурь түвшин	2030	2040	2050	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хаанаас авах эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах аргазүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
40	Умайн хүзүүний хорт хавдар	Хувь	37.4	51.9	61.9	71.9	2018 он суурь түвшин	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Эрүүл мэндийн хөгжлийн төв	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Захиргааны статистик мэдээлэл		Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
41	Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн тоо	тоо	2824700	3752549	4596540	5010310	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Захиргааны статистик мэдээлэл	Жилд 1 удаа	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
42	Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн хувь	хувь	88.9	95.0	100.0	100.0	2018 он суурь түвшин	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Захиргааны статистик мэдээлэл	Жилд 1 удаа	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
43	Эрүүл мэндийн тэргүүлэх болон нэн шаардлагатай чиглэлээр бэлтгэгдсэн хүний тоо	тоо	678	950	1400	1750	2019 оны суурь түвшин	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	ОУ-ын аргачлал, судалгаа, статистик мэдээлэл, тайлан	Жилд 1 удаа	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

#	Шалгуур үзүүлэлт (indicator)	Хэмжих нэгж	Суурь түвшин	2030	2040	2050	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хаанаас авах эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах аргазүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
44	Эрүүл мэндийн тэргүүлэх чиглэлээр бэлтгэгдсэн хүний тоо /гадаад сургалт/	тоо	120	150+	200+	250+	2019 оны суурь түвшин	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Эрүүл мэндийн хөгжлийн төв	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Захиргааны статистик мэдээлэл	Жилд 1 удаа	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
45	Эрүүл мэндийн нэн шаардлагатай чиглэлээр бэлтгэгдсэн хүний тоо / дотоод сургалт-сувилахуйн чиглэлээр/	тоо	558	800	1200	1500	2019 оны суурь түвшин	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Эрүүл мэндийн хөгжлийн төв	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Захиргааны статистик мэдээлэл	Жилд 1 удаа	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
46	Нийгмийн даатгалд хамрагдсан хөдөлмөрийн насны идэвхтэй хүн ам	хувь	73.6	88	96	100	Монгол Улсын нийгмийн хамгааллын суурь түвшинг тодорхойлолт, зардал. Олон улсын хөдөлмөрийн байгууллага. 2015	Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	ОУ-ын аргачлал, судалгаа, статистик мэдээлэл, тайлан	Жилд 1 удаа	Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
47	Урт хугацааны тусламж, үйлчилгээнд хамрагдсан ахмад настан (хөгжлийн төв гэх мэт)	хувь	-	88	96	100		Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Жилийн тайлан	Жилд 1 удаа	Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
48	Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарын санхүүжилтийн ДНБ-д эзлэх хувь	эзлэх хувь	0.18	1.25	1.75	2	2018 он суурь түвшин	Шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ЮНЕСКО-гийн Шинжлэх ухааны "2030 он хүрэх зам" тайлан илтгэл	Жилийн тайлан	Жилд 1 удаа	Шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Шинжлэх ухааны академи, Их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага

#	Шалгуур үзүүлэлт (indicator)	Хэмжих нэгж	Суурь түвшин	2030	2040	2050	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хаанаас авах эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах аргазүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
49	Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарын санхүүжилтийн төсвийн бус санхүүжилт	эзлэх хувь	-	1.75	2.25	2.5	2018 он суурь түвшин	Шинжлэх ухааны академи	Жилийн тайлан	Жилд 1 удаа	Шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Шинжлэх ухааны академи, Их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага
50	Эрдэм шинжилгээний тоног төхөөрөмжийн парк шинэчлэл	хувь	-	100			2019 он суурь түвшин	Шинжлэх ухааны академи	Жилийн тайлан	Жилд 1 удаа	Шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Шинжлэх ухааны академи, Их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага
51	Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын жилийн дундаж агууламж	мкг/м3	64	25	-	-	2018 он суурь түвшин	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Хяналт, мониторингийн дүн	Жилд 1 удаа	Шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
52	Улаанбаатар хотын агаар дахь PM10 тоосонцрын жилийн дундаж агууламж	мкг/м3	141	50	-	-	2018 он суурь түвшин	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Хяналт, мониторингийн дүн	Жилд 1 удаа	Шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

#	Шалгуур үзүүлэлт (indicator)	Хэмжих нэгж	Суурь түвшин	2030	2040	2050	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хаанаас авах эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах аргазүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
53	Органик, баяжуулсан, зохицуулах үйлчилгээтэй инноваци нэвтрүүлсэн шинэ бүтээгдэхүүн	тоо	-	15	20	25	2019 он суурь түвшин	Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Жилийн тайлан	Жилд 1 удаа	Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
54	Ажиллах хүчний оролцооны түвшин	хувь	61	65	67	70	2018 оны түвшин	Үндэсний статистикийн хороо, Ажиллах хүчний судалгаа	Үндэсний хэмжээний түүвэр судалгаа	Улирал бүр	Үндэсний статистикийн хороо
55	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	хувь	56.3	60	70	80	2018 оны түвшин	Үндэсний статистикийн хороо, Ажиллах хүчний судалгаа	Үндэсний хэмжээний түүвэр судалгаа	Улирал бүр	Үндэсний статистикийн хороо
56	Ажилгүйдлийн түвшин	хувь	8.6	7	5	3	2018 оны түвшин	Үндэсний статистикийн хороо, Ажиллах хүчний судалгаа	Үндэсний хэмжээний түүвэр судалгаа	Улирал бүр	Үндэсний статистикийн хороо
57	Угийн бичиг хөтөлдөг өрхийн нийт өрхөд эзлэх хувь*	хувь	-	50+	70+	100	Угийн бичиг хөтлөлтийн бүртгэлийг улс даяар зохион байгуулах	Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Судалгаа	5 жилд 1 удаа	Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага



АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ БА ДААТГАЛЫН
ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛ

ОРЛОГОД НИЙЦСЭН ОРОН БАЙР

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА ГАРААНЫ БИЗНЕС

ДУНДАЖ ДАВХАРГЫГ ДЭМЖСЭН
САНХҮҮЖИЛТ

ЭРҮҮЛ, ИДЭВХТЭЙ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ

ГАЗРЫН ХАРИЛЦАА

АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА

“Эдийн засагч” сэтгүүл судалгааны албанаас эрхлэн бэлтгэдэг “Ардчиллын индекс”-ийн 2014 оны тайланд ардчилалд сэтгэл ханамжгүй байдал дахинд ажиглагдаж байгааг онцолж, ардчилалд аюул учруулж буй үндсэн шалтгаан нь нийгмийн болон орлогын тэгш бус байдал болохыг тэмдэглэсэн.

Монгол улс 36.5 жин коэффицитайгоор 103 дугаарт эрэмбэлэгдэж байгаа нь ардчилал хөгжөөд 30 жил болсон манай улсын хувьд хангалтгүй үзүүлэлт юм. Тэгш бус байдал нийгмийн бухимдал үүсгэж, улмаар улс төрийн болон нийгмийн тогтворгүй байдал үүсгэдгийг Монгол улс өнгөрсөн 30 жилд хангалттай амсав.

Тэгш бус байдлыг шийдэх гарц бол дундаж орлоготой иргэдийн хувь хэмжээг нэмэх юм. Энэхүү урт хугацааны хөгжлийн бодлогод дундаж орлоготой иргэдийг дэмжих тусгайлсан зорилт дэвшүүлж, амьдралын чанарт анхаарал хандуулж байгаа нь төр засгийн зүгээс орлогын тэгш бус байдлын эсрэг цогц байдлаар анхаарал хандуулж буй анхны томоохон алхам юм.

Аливаа улсын нийгмийн хөгжлийн бодлогын эцсийн зорилго бол хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар хүн амынхаа орлогыг нэмэгдүүлэн амьдралын чанарыг дээшлүүлэх буюу иргэдээ бүх талаар хөгжүүлж, тав тухтай, сэтгэл хангалуун амьдрах нөхцөлөөр хангахад чиглэсэн байдаг. Тухайн улсын хүн амын янз бүрийн бүлэг, давхаргын хувьд амьдралын чанарын баталгаа хангагдсан эсэх нь тэдний өөрсдийн амьдралдаа хэр зэрэг сэтгэл ханамжтай байгаагаас ихээхэн шалтгаална. Ялангуяа, тухайн улсын хүн

амын дундаж давхаргынхны амьдралдаа сэтгэл ханамжтай байгаа эсэх нь улс орны нийгэм, эдийн засаг, улс төр тогтвортой байхад ихээхэн үүрэг гүйцэтгэдэг. Дундаж давхарга бол улс орны бүтээгдэхүүн үйлчилгээний тогтвортой хэрэглээ, өсөлтийн гол суурь, шинийг эрэлхийлэгч, эрсдэл гаргагч энтрепренер, хүмүүн ба санхүүгийн капитал хуримтлуулагч, итгэлцлийг нэмэгдүүлж, хэлцлийн зардлыг бууруулагч, ил тод байдал, хариуцлагыг шаардах улс төрийн гол хүчин билээ.

Дундаж давхаргыг тодорхойлсон нийтлэг тодорхойлолт, судалгааны арга зүй аргачлал дэлхий нийтэд байдаггүй, улс орон бүр өөр өөрийн хөгжлийн онцлогт тохируулан арга зүйгээ боловсруулан хэрэглэсээр иржээ. Эдийн засагчид дундаж давхаргыг тодорхойлохдоо орлогын үзүүлэлтийг голлодог бол нийгмийн салбарын бусад судлаачдын хувьд өргөн хүрээний асуудлыг, тухайлбал, орлогоос гадна тэдний хөрөнгө чинээ, амьдралын сэтгэл ханамж, санхүүгийн болон тэтгэврийн үеийн аюулгүй, эрсдэлгүй байдал, боловсрол, эрүүл мэнд зэрэг асуудлыг бүгдийг хамруулдаг байна.

Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах замаар ядуу өрхийн орлогыг нэмэгдүүлэх замаар дундаж давхаргын эгнээг өргөжүүлэх, энэ бүлгийн хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэхийг улс орнууд хөгжлийн бодлогын гол тэргүүлэх чиглэл болгодог. Манай улсын хувьд дундаж давхаргыг тэлэх, тэднийг дэмжсэн тусгайлсан бодлого байдаггүй. Иймд энд дундаж давхаргын хүн амын амьдралын чанарын асуудлыг өрх, гэр бүлийн амьжиргааны түвшин, орон сууц, хөдөлмөр эрхлэлт, аж ахуй эрхлэх сэтгэлгээ, хандлага зэрэг асуудлуудын хүрээнд авч үзэхийн зэрэгцээ дундаж давхаргын хүн амыг дэмжих санхүүгийн механизмын талаарх тусгайлсан бодлого, арга хэмжээг онцгойлон анхаарсан болно. Мөн дундаж давхаргыг өөрийн орны онцлог байдлыг харгалзан, тодорхойлсон ба энэ зорилгын хүрэх үр дүнг дараах байдлаар тодорхойллоо.



Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, идэвхтэй бүтээлч гэр бүлийг төлөвшүүлэн, хэрэгцээндээ нийцсэн байр сууц бүхий, хөрөнгө оруулалтын таатай орчин, нөхцөлд өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэн өрх, гэр бүл, өөрийгөө тэтгэн амьдрах боломжтой, сэтгэл хангалуун амьдрах нөхцөлөөр тэтгэгдсэн дундаж давхаргыг 2050 он гэхэд нийт хүн амын 80 хувьд хүргэх болно.



Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн хөгжлийн үе шатуудыг тодорхойллоо.

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ БА ДААТГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛ

ЗОРИЛТ 3.1 Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлнэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020-2030)	II үе шат (2031-2040)	III үе шат (2041-2050)
ХҮРТЭЭМЖТЭЙ НИЙГМИЙН ДААТГАЛ	БАТАЛГААТАЙ НИЙГМИЙН ХАМГААЛАЛ	АМЬДРАЛЫН БАТАЛГАА-НИЙГМИЙН ХАМГААЛАЛ
Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчлэх үе	Эрсдэлээс сэргийлсэн нийгмийн хамгааллын тогтолцоог сайжруулах үе	Амьдралын чанарыг сайжруулахуйц нийгмийн хамгааллын цогц үйлчилгээ үзүүлэх үе
<ol style="list-style-type: none"> 1. Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх 2. Тэтгэврийн даатгалыг олон давхаргад тогтолцоонд шилжүүлэх 3. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хүн амын эмзэг бүлгүүдийг бүрэн хамруулах 4. Ядуу, эмзэг бүлгийн өрх, иргэний амьжиргаанд хүрэлцэхүйц хэмжээний нийгмийн халамжийн тусламж, дэмжлэгийг үзүүлэх 	<ol style="list-style-type: none"> 1. Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлох 2. Ирээдүйн тэтгэврийн нөөц санг ашигт малтмалын орд газрын орлого болон ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрээс бүрдүүлэх 3. Тэтгэврийн даатгалын хагас хуримтлалын тогтолцоонд хэсэгчлэн шилжүүлэх, 1979 оноос хойш төрсөн даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг бодит орлого болгох 4. Ядуу, эмзэг бүлгийн хэрэгцээ, орон нутгийн онцлогт нийцсэн халамжийн шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлэх, 5. Ахмад настанд урт хугацааны тусламж үйлчилгээ үзүүлэх хөгжлийн төвүүдийг байгуулах, 	<ol style="list-style-type: none"> 1. Тэтгэврийн даатгалын тогтолцоог бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжих үе шатыг эхлүүлэх 2. Нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээг өрх, иргэдийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААА

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

- 3.1.1. Албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байгаа иргэд болон малчдыг нийгмийн даатгалд даатгуулах тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 3.1.2. Нийгмийн даатгалын хууль эрхзүйн орчинг боловсронгуй болгоно.
- 3.1.3. Бүх ахмад настанд суурь тэтгэвэр олгоно.
- 3.1.4. Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлнэ.
- 3.1.5. Нийгмийн даатгалын мэдээллийн системийг боловсронгуй болгож, хяналтыг сайжруулна. Орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран өрхийн болон хувиараа үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийг нийгмийн даатгалд заавал даатгуулах чиглэлээр сургалт сурталчилгаа хийнэ.
- 3.1.6. Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлно.
- 3.1.7. Ирээдүйн тэтгэврийн нөөц санг ашигт малтмалын орд газрын орлогоос болон ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрээс бүрдүүлнэ.
- 3.1.8. Тэтгэврийн даатгалын хагас хуримтлалын тогтолцоонд хэсэгчлэн шилжүүлэх, 1979 оноос хойш төрсөн даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг бодит орлого болгоно.
- 3.1.9. Тэтгэврийн даатгалын тогтолцоог бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжих үе шатыг эхлүүлнэ.

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

- 3.1.10. Иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, амралт, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, сурч боловсрох, хөгжих цогц орчныг бүрдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
- 3.1.11. Нийгмийн халамжийн тусламж, дэмжлэгийг ядуу, эмзэг бүлгийн хэрэгцээнд нийцсэн, амьжиргааг нь дээшлүүлэхэд чиглүүлнэ.
- 3.1.12. Нийгмийн халамж хүртэгсдийн мэдээллийн санг блокчейн технологид суурилан боловсронгуй болгож, нийгмийн хамгааллын үйл ажиллагааг сайжруулна.

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ



АМЬДРАЛЫН БАТАЛГААГ
ХАНГАХУЙЦ НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ЦОГЦ
ТОГТОЛЦОО



ХҮРТЭЭМЖТЭЙ
НИЙГМИЙН
ХАМГААЛАЛ



ОЛОН
ДАВХАРГАТ
НИЙГМИЙН
ДААТГАЛ

ХҮН



Аймаг, дүүрэг бүрт - Ахмад настанд урт хугацааны тусламж үйлчилгээ үзүүлэх хөгжлийн төвүүдийг байгуулна.

Монгол Улсад өнөөгийн байдлаар нийгмийн халамж, хүн амын өсөлтийг дэмжих чиглэлийн 6 хуулийн хүрээнд 12 төрлийн нийгмийн халамж, үйлчилгээний хөтөлбөрүүд хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Нийгмийн халамжийн тэтгэвэр
2. Асаргааны тэтгэмж
3. Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж
4. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээ
5. Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ
6. Боловсрол эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ
7. Хүнсний эрхийн бичгийн хөтөлбөр
8. Эхийн алдар одонтой эхийн тэтгэмж
9. Жирэмсэн болон 0-3 насны хүүхэдтэй эхийн тэтгэмж
10. Алдар цолтой ахмад настны нэмэгдэл, хөнгөлөлт
11. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх хөнгөлөлт, тусламж
12. Хүүхдийн мөнгөн тэтгэмж

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ТЭТГЭВЭР АВАГЧИД ТЭТГЭВРИЙН ТӨРЛӨӨР 2017 ОН

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	ТЭТГЭВЭР АВАГЧИД /мянган хүн/	ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ /сая төг/
ӨНДӨР НАСНЫ	282.6	1 065 561.9
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН	72.7	210 394.3
ТЭЖЭЭГЧЭЭ АЛДСАНЫ	22.2	64 397.6
ЦЭРГИЙН ТЭТГЭВЭР	16.0	101 589.7

- 3.1.13. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бусад төрөл, эрүүл мэнд зэрэг шаардлагатай нийгмийн үйлчилгээнд хамруулахад холбон зуучилна.
- 3.1.14. Аймаг, сум, хороо, багийн нутаг дэвсгэрийн хэмжээнд ядуу өрх бүрийн амьжиргааг дээшлүүлэх, тэднийг хөгжүүлэх, хамгаалахад чиглэсэн үйл ажиллагааг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хүрээнд зохион байгуулна.
- 3.1.15. Ядуу, эмзэг бүлгийн хэрэгцээ, орон нутгийн онцлогт нийцсэн халамжийн шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлнэ.
- 3.1.16. Ахмад настанд урт хугацааны тусламж үйлчилгээ үзүүлэх хөгжлийн төвүүдийг байгуулна.
- 3.1.17. Нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээг өрх, иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хөгжүүлнэ.
- СУДАЛГАА, НОТОНГООНД СУУРИЛСАН ХҮН АМЫН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ДЭМЖСЭН, ГЭР БҮЛД ЭЭЛТЭЙ БОДЛОГО, ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ҮР АШИГТАЙ ТОГТОЛЦОО БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР**
- 3.1.18. Хүн амын өсөлт, хөгжил, эрэлт хэрэгцээний цогц судалгаанд үндэслэн төрөөс хүн ам, гэр бүл, хүүхэд, залуучууд, ахмадын талаар баримтлах бодлогыг шинэчлэх, салбар дундын бодлого зохицуулалтыг сайжруулна.
- 3.1.19. Эхний ээлжид эмзэг бүлгийн өрхийн нэг гишүүнийг ажлын байраар хангах бодлого баримтална.
- 3.1.20. Ядуу өрхийн багаас доош боловсролтой, ажил эрхлээгүй өрхийн тэргүүлэгч, насанд хүрсэн гишүүдийг мэргэжилтэй ажилтан бодлогын хүрээнд мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг ахиулах сургалтад хамруулна.
- 3.1.21. Ядуу өрхийн сургуулийн бага ангийн хүүхдийн ном, сурах бичгийн түрээсийн тогтолцоо, эргэлтийн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, хүүхдийн дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлт үзүүлэх, дотуур байранд амьдрах хоол, унааны зардлын тодорхой хувийг улсаас төлнө.
- 3.1.22. Ядуу өрхийн хүүхдийг цэцэрлэг, сургуульд бүрэн хамрагдах, боловсролтой болох боломжоор хангах, мэргэжлийн, дипломын сургалтын тэтгэлэгт хамруулах замаар ядуурлаас ангид боловсролтой, мэдлэгтэй монгол хүнийг бэлтгэхэд анхаарна.
- 3.1.23. Ядуурлын түвшингээс доогуур болон ойролцоо хэрэглээтэй өрхийн сургуулийн насны хүүхдэд дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлт үзүүлнэ.

- 3.1.24. Иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, амралт, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, сурч боловсрох, хөгжих цогц орчныг бүрдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
- 3.1.25. Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох аргачлалыг боловсронгуй болгож, гэр бүлийн гишүүн бүрд үзүүлэх нийгмийн халамжийн тусламж, дэмжлэгийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 3.1.26. Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний нэгдсэн, цогц тогтолцоог бүрдүүлнэ.
- ЗАЛУУ ГЭР БҮЛИЙГ ДЭМЖСЭН ОРЧИН, НӨХЦӨЛ БҮРДҮҮЛЖ, ЦОГЦ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР**
- 3.1.27. Хүүхдийн тоо, наснаас хамааруулан хөнгөлөлт эдлүүлэх, хуримтлал бий болгох механизм бүрдүүлнэ.
- 3.1.28. Залуучуудын эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжих, бодит хуримтлал бий болгоход чиглэсэн “Залуу гэр бүл” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 3.1.29. Ажил хөдөлмөр эрхэлдэг эцэг эхэд ажил-ар гэрийн амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлнэ. (эцэг эхийн ажлын цагийн зохицуулалтыг оновчтой, сонголттой болгох, хагас цагийн хөдөлмөр эрхлэлт, зайнаас ажиллахыг дэмжих)
- 3.1.30. Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Оюутны бирж” байгуулж хөгжүүлнэ. Гадаадад сурч, ажиллаж, амьдарч байгаа иргэдийг дэмжих “Зөгийн үүр 2” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.1.31. Залуу гэр бүлд сэтгэл зүйн чиглэлээр зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлж, мэргэжлийн, судалгааны болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллана.
- 3.1.32. Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, технологийн дээд сургуульд мэргэжил эзэмшүүлэх замаар ажилгүй иргэдийг ажлын байраар ханган амьжиргааны түвшинг нь дээшлүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 3.1.33. Цус ойртолтоос хамгаалах салбар дундын цогц арга хэмжээ авна.

АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА

Улс орны хөгжлийн гол үзүүлэлт бол хүн амын амьдралын чанар байдаг. Хүн амын тогтвортой өсөлтийг хангаж, идэвхтэй бүтээлч гэр бүлийг төлөвшүүлэн, хэрэгцээндээ нийцсэн орон сууц бүхий, хөрөнгө оруулалтын таатай орчин, нөхцөлд өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэн өрх, гэр бүл, өөрийгөө тэтгэн амьдрах боломжтой, идэвхтэй амьдралын зөв дадал хэвшилтэй, сэтгэл хангалуун амьдрах нөхцөлөөр тэтгэгдсэн дундаж давхаргыг 2050 он гэхэд нийт хүн амын 80 хувьд хүргэх бодлого хэрэгжүүлэх болно.

ХҮН АМЫН ОРЛОГОД НИЙЦСЭН, ОРЧИН ҮЕИЙН ЧАНАР, СТАНДАРТЫН ШААРДЛАГА ХАНГАСАН, ОРШИН СУУГЧДЫН ТАВ ТУХ, АМЬДРАХ ТААТАЙ ОРЧИН, ХЭРЭГЦЭЭТ ҮЙЛЧИЛГЭЭГ ЦОГЦООР ШИЙДСЭН НОГООН БАРИЛГЫН ШИЙДЭЛ БҮХИЙ ОРОН СУУЦ



А. АЗ ЖАРГАЛТАЙ ГЭР БҮЛ

В. ХҮН АМЫН ОРЛОГОД НИЙЦСЭН, НОГООН ШИЙДЭЛ БҮХИЙ ЧАНАРТАЙ ОРОН

С. ЭНТЕРПРАЙЗИНГ ХАНДЛАГА БА БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ЭЭЛТЭЙ ОРЧИН

АМЬДРАЛЫН ЧАНАРЫН БҮРДЭЛ ХЭСГҮҮД



Д. ДУНДАЖ ДАВХАРГАД ЭЭЛТЭЙ БАНК, САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛАХ БОДЛОГО



Е. ИДЭВХТЭЙ АМЬДРАЛЫН ХЭВШИЛТЭЙ ИРГЭН ТӨЛӨВШҮҮЛЭХ БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ЧАНАР, ҮР ДҮНТЭЙ ТОГТОЛЦОО

ОРЛОГОД НИЙЦСЭН ОРОН БАЙР

ЗОРИЛТ 3.2 Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй, эрэлт хэрэгцээнд нийцсэн байр сууцаар хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020-2030)	II үе шат (2031-2040)	III үе шат (2041-2050)
ХУДАЛДАН АВАХ ЧАДВАРТ НИЙЦСЭН ОРОН СУУЦ	ЧАНАРТАЙ БАЙР, СУУЦ	ТОХИЛОГ БАЙР, СУУЦ
Өрх, гэр бүлийг худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй сууцаар хангах нөхцөлийг бүрдүүлэх үе	Худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй ногоон хөгжлийн загварт нийцсэн орон сууцны чанар, стандартыг сайжруулах үе	Хэрэгцээнд нийцсэн чанартай, тохилог орон сууцны хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх үе
1. Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй сууцаар хангах тогтолцоог бий болгох 2. Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэх	1. Гэр хорооллын нөхцөлийг сайжруулж, хүн амын худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй, ногоон шийдэл бүхий чанартай орон сууцны хүрэлцээ, хангамжийг сайжруулах	1. Өрх, гэр бүлийг эрэлтэд нийцтэй, худалдан авах чадварт тохирсон, чанартай, тохилог орон сууцаар хангах

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ӨРХ, ГЭР БҮЛИЙН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРТ НИЙЦСЭН ӨРТӨГТЭЙ СУУЦААР ХАНГАХ ОРЧИН БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 3.2.1. Нийслэл, түүний дагуул, хаяа хот, тосгон, орон нутагт, хүн амын орлогод нийцсэн, ногоон хөгжлийн загварт тохирсон орон сууц нийлүүлэлтийг бодлогоор дэмжинэ.
- 3.2.2. Худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий орон сууцны зураг төслийг боловсруулж, норм, стандарт, холбогдох хууль эрхзүйн орчныг боловсронгуй болгоно.
- 3.2.3. Хот, суурины хөгжлийн төлөвлөлтийн дагуу орон сууцжуулах хөтөлбөр, төслийг үе шаттай хэрэгжүүлж, иргэдийг орлогод нийцсэн аюулгүй, ая тухтай орон байртай болоход дэмжлэг үзүүлнэ. (монгол гэр төсөл, амины болон нийтийн орон сууц барих төсөл, түрээсийн орон сууц төсөл болон бусад).
- 3.2.4. Төр, орон нутаг, хэвийн хэвшлийн оролцоотой 60000 айлын сан бүхий "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.2.5. Хот, суурин газрын гэр хорооллыг иргэдийн оролцоотойгоор дахин төлөвлөх, төвлөрсөн, хэсэгчилсэн, бие даасан инженерийн дэд бүтцэд холбогдсон орон сууцны хороолол болгон хөгжүүлнэ.

3.2.6. Орон сууцны төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдэд татварын болон санхүүгийн дэмжлэг /хөнгөлөлттэй зээл болон бусад/ үзүүлэх замаар тухайн орон сууцны тодорхой хувийг бага, дунд орлоготой иргэдэд түрээслүүлэх, хямд үнээр борлуулах замаар орлогод нийцсэн орон сууцаар хангана.

3.2.7. Зайлшгүй орон байраар хангагдах шаардлагатай зорилтод/ орлогогүй/ бүлгийн иргэдийг төрийн өмчийн халамжийн түр орон сууцаар хангадаг байх тогтолцоог нэвтрүүлнэ.

3.2.8. Орон сууцны төлөвлөлтөд оршин суугчид амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх нийгмийн дэд бүтэц, ногоон байгууламж, усан сан, биеийн тамирын талбай бүхий тохилог орчин бүрдүүлэх стандарт хэрэгжүүлж, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлнэ.

ТӨЛБӨРИЙН ЧАДВАРТ НИЙЦСЭН ОРОН СУУЦНЫ САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР.

3.2.9. Орон сууцны санхүүжилтийн тогтолцоог шинэчлэх, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тогтооно.

3.2.10. Орон сууцны даатгалын тогтолцоог боловсронгуй болгох, татварын бодлогоор дэмжинэ.

3.2.11. Худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй орон сууцны хэрэгцээг хангахад чиглэгдсэн хуримтлалтай дүйцүүлэх хөрөнгө оруулалт, хөнгөлөлтийн санг (matching fund, central provident fund) хослуулсан ипотекийн зээлийн уян хатан, олон хувилбарт бодлогыг хэрэгжүүлнэ.

3.2.12. Ногоон орон сууцыг нэвтрүүлэх бодлогын болон санхүүгийн дэмжлэгийн тогтвортой систем /тогтолцоо/ бүрдүүлнэ.

3.2.13. Гэр хорооллын дундын болон захын бүсийг нэн тэргүүнд инженерийн дэд бүтэцтэй болгоход улс, орон нутгийн төсөв болон бусад хөрөнгө оруулалтын үүсвэрийг зориулах, иргэдийн хүсэл, санаачилгад үндэслэн дэд бүтэц бүхий газрыг төр эсхүл хувийн хэвшлийн орон сууцаар шууд солих замаар дараагийн орон сууц баригдах талбайг бий болгоно.

3.2.14. Гэр хорооллын өрхийн газрыг өөрсдийн нь идэвх, санаачилга, оролцоонд тулгуурлан дахин зохион байгуулах, нийгмийн болон инженерийн дэд бүтэц, ногоон байгууламж, тоглоомын талбай бий болгох үйл ажиллагааг бодлогоор дэмжих, улсын төсөв болон бусад хуулиар хориглоогүй эх үүсвэрээс санхүүжүүлэх боломжийг бий болгоно.

3.2.15. Орон сууцны төсөлд ухаалаг, байгалийн нөөцийн хэмнэлттэй, дэвшилтэт техник, технологи бүхий дэд бүтцийг улс, орон нутгийн төсвийн хөрөнгө, гадаад, дотоодын зээл, тусламж, концессын гэрээгээр барьж байгуулах, нэвтрүүлэхийг банк, санхүүгээр дэмжинэ.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА ГАРААНЫ БИЗНЕС

ЗОРИЛТ 3.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх арга, ур чадварыг хөгжүүлж, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020-2030)	II үе шат (2031-2040)	III үе шат (2041-2050)
БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ЭРЧИМЖИЛТ	ӨРСӨЛДӨХҮЙЦ БИЗНЕС ЭРХЛЭЛТ	ОЛОН УЛСАД ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ БИЗНЕС ЭРХЛЭЛТ
Хөдөлмөр эрхлэлт, энтерпрайзинг хандлага болон ур чадварыг хөгжүүлэн дэмжих, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх үе	Жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх үе	Бичил, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх үе
<ol style="list-style-type: none"> 1. Ажилгүйдлийг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуу өрхийн орлогыг нэмэгдүүлэх замаар дундаж давхаргыг өргөтгөх 2. Залуучуудад бизнес эрхлэх зорилгодоо хүрэхэд шаардлагатай бүх төрлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, орчин нөхцөл бүрдүүлэх 3. Бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих орчныг бэхжүүлж, төлөвшүүлэх 	<ol style="list-style-type: none"> 1. Инноваци, технологи нэвтрүүлэх, мэдлэг хуваалцах чиглэлээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн нөхцөлийг бүрдүүлж, экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, экспортын зах зээлд нэвтрэхэд дэмжлэг үзүүлж, бичил, жижиг, дунд бизнес олон улсад өрсөлдөх боломж нөхцөлөөр хангах 	<ol style="list-style-type: none"> 1. Олон улсад өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэлтийн соёл бүрэн төлөвшүүлж, инноваци, шинэ технологи, мэдлэг шингэсэн бичил, жижиг, дунд бизнесийн хөгжлийг дэлхийн жишигт хүргэх

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААА


ҮНДЭСНИЙ ЭКСПОРТЛОГЧ ТОМООХОН КОМПАНИУДАД ОРОН НУТГААС ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ТОГТВОРТОЙ БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ СҮЛЖЭЭ, ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ НЬ ЭДИЙН ЗАСГИЙН БОЛОН САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ, ХӨНГӨЛӨЛТ, УРАМШУУЛЛЫН БОДЛОГООР ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР

- 3.3.1. Аймаг, сумдын нөхөрлөл, хоршоо, иргэд гэр бүлээрээ ба хувиараа бизнес эрхлэхийг санхүүгийн болон зах зээлтэй холбох, өртгийн сүлжээний кластер байгуулах энэхүү хөтөлбөрийн зохион байгуулалттай ажлын байр бий болгох төслүүдийг улс, аймгийн бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээнд холбоно.
- 3.3.2. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг шууд худалдаалах төвийг сумдад байгуулж, борлуулалтын сүлжээ бий болгоно.
- 3.3.3. Жижиг, дунд үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийг дэмжих нийтийн өмчийн хадгалалт борлуулалтын цогцолбор байгуулна.
- 3.3.4. Хоршоонд гишүүнээр элсэн ажиллах хүсэлтэй ажилгүй, ядуу өрх, иргэдийн саналыг нэгтгэн бүртгэж, зуучлах үйл ажиллагааг зохион байгуулна.
- 3.3.5. Орон нутгийн иргэний бие даасан, бүтээлч байдлыг дэмжих зорилгоор “Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн” аяныг өрнүүлэх, сум бүрт аяныг удирдан зохион байгуулна.
- 3.3.6. Салбарын тогтвортой хөгжлийг хангахад шаардлагатай мэдээллийн сан бүхий мэдээллийн системийг бий болгоно.
- 3.3.7. Хүнсний үйлдвэрлэлийн түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, үйлдвэрлэх загвар төслүүдийг орон нутгийн онцлогт тулгуурлан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. (сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах, мал нядлах, мах, махан бүтээгдэхүүн, дайвар бүтээгдэхүүн боловсруулах, загасны аж ахуй, зөгийн аж ахуй, төмс, хүнсний ногоо тарих, хадгалах, боловсруулах, хүлэмжийн аж ахуй, жимс, жимсгэнэ боловсруулах, үр тарианы аж ахуй, талх, нарийн боовны цех, цэвэр ус үйлдвэрлэх, ургамлын цай үйлдвэрлэх болон бусад);
- 3.3.8. Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, үйлдвэрлэх загвар төслүүдийг орон нутгийн онцлогт тулгуурлан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. (арьс ширний анхан шатны тордолтын цех, арьс ширэн жижиг эдлэлийн цех, ноос, ноолуур бэлтгэн нийлүүлэх, яс боловсруулах цех, сүлжмэлийн цех, эсгий, эсгий эдлэлийн цех, оёдлын цех, мод, модон эдлэлийн цех, ойн хаягдал түүхий эд боловсруулах цех, модны үрсэлгээ, суулгацын аж ахуй, техник, тоног төхөөрөмжийн үйлчилгээний цех, мал бордох болон бусад);
- 3.3.9. Малчид, ногоочдын аж ахуй эрхлэх газрыг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгоно.
- 3.3.10. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, барилгын салбарын бага, дунд, эцсийн шатны боловсруулалт хийсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслүүдийг хэрэгжүүлнэ.

ГЭРЭЭТ ХАДГАЛАМЖИЙН САН

Орон сууцны хадгаламжийн санг амжилттай хэрэгжүүлсэн улсын нэг Сингапурын санхүүжилтийн схемийг харуулав. Тус улсын орон сууцны зээлийг Орон сууц, хөгжлийн газар (ОСХГ) болон Хөдөлмөрийн яамнаас удирддаг хуримтлалын сангаас олгодог. Тус сан нь хөдөлмөр эрхлэгчдийн цалингийн 30%-ийг 2.5%-ийн хүүтэйгээр хуримтлуулж, эх үүсвэр татдаг бөгөөд зээл авах сонирхолтой иргэд тухайн санд байршуулсан өөрийн нэрийн хадгаламжаа орон сууцны зээлийн урьдчилгаа болон зээлийн төлбөр төлөх зэргээр ашиглах боломжтой. Цаашилбал орлогын түвшин багатай иргэд орон сууцны үнийн 90 хүртэлх хувийн зээлийг зах зээлээс бага хүү (2.6%)- тэй, урьдчилгаа төлбөр төлөх шаардлагагүйгээр авах боломжтой байдаг. Харин орон сууцны зээл авах шаардлага хангаагүй, эсвэл хувийн орон сууц худалдан авах сонирхолтой өрхүүд банкнаас 5-10 хувийн урьдчилгаа төлбөртэй, зах зээлийн хүү (5.3%)-ээр зээл авах сонголттой байдаг.


ГЭРЭЭТ ХАДГАЛАМЖИЙН ТОГТОЛЦОО



Эх сурвалж: Орон сууцны зээлийн тогтолцоо: Олон улсын харьцуулалт С.Мөнхчимэг, С.Билгүүнзул

ЭДИЙН ЗАСГИЙН АЧ ХОЛБОГДОЛ

ХУРИМТЛАЛЫН САН



ЗАЛУУЧУУДАД ЭНТРЕПЕНЕРАЛ ЗОРИЛГОДОО ХҮРЭХЭД ШААРДЛАГАТАЙ БҮХ ТӨРЛИЙН ДЭМЖЛЭГ, ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ОРЧИН НӨХЦӨЛ БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 3.3.11. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, барилгын салбарын бага, дунд, эцсийн шатны боловсруулалт хийсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслүүдийг хэрэгжүүлнэ.
- 3.3.12. Энтерпрайзинг хүсэл тэмүүллийг дэмжих үр нөлөө бүхий экосистемийг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.
- 3.3.13. Хүн амын энтерпрайзинг хандлага, ур чадвар, зан үйл болон үйл ажиллагааг нэмэгдүүлэхэд чиглэсэн зан үйлийн интервенцийг хэрэгжүүлнэ.
- 3.3.14. Залуу энтрепренершип үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 3.3.15. Гарааны бизнес эрхлэгч залууст бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, дэд бүтцийг хөгжүүлнэ. /хурдасгуур хөтөлбөр, менторшип, co-working space, түрээсийн хөнгөлөлт/
- 3.3.16. Гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлэх (angel investment, venture capital fund), санхүүгийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ.
- БИЧИЛ, ЖИЖИГ, ДУНД БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ ОРЧИНГ БЭХЖҮҮЛЭХ, ТӨЛӨШҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР**
- 3.3.17. Үндэсний томоохон аж ахуйн нэгж, гадаадын хөрөнгө оруулалттай ААН-ийг бичил, жижиг, дунд бизнестэй холбох ханган нийлүүлэлтийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 3.3.18. Төрийн худалдан авалтаар бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих, шаардлагатай түүхий эд, тоног төхөөрөмжөөр хангах, хэрэгцээтэй хүний нөөц бэлтгэх, мэргэжилтэй ажилчдын мэдээллийн санг бүрдүүлнэ.
- 3.3.19. Томоохон ААН, төрийн худалдан авалтын гэрээг үндэслэн бичил, жижиг, дунд бизнесийг зээлийн барьцаа шаардахгүйгээр зээл олгох нөхцөл бүрдүүлнэ.
- 3.3.20. Зээлийн батлан даалтын санг сурталчлах, үйл ажиллагааг нь өргөжүүлж сайжруулна.
- 3.3.21. Бичил, жижиг, дунд бизнест чиглэсэн санхүүгийн урамшууллыг өргөжүүлнэ.
- 3.3.22. Санхүүгийн байгууллагын нийлүүлж буй зээлийн бүтээгдэхүүнийг бизнес эрхлэгчдэд хүртээмжтэй ба нийцэмжтэй болгох талаар санхүүгийн салбарынхантай хамтран ажиллана.
- 3.3.23. Бизнесийн үйл ажиллагааг албан хэлбэрт шилжүүлэхэд дэмжлэг болох үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулна.
- 3.3.24. Экспорт, импортын зах зээлтэй холбоотой мэдээллийг цахимжуулж, экспортын зах зээлд нэвтрэх ур чадварыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

ДУНДАЖ ДАВХАРГЫГ ДЭМЖСЭН САНХҮҮЖИЛТ

ЗОРИЛТ 3.4 Дундаж давхаргыг дэмжсэн санхүүгийн үйлчилгээ үзүүлж эрсдэлээс хамгаална.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
ДУНДАЖ ДАВХАРГЫН ЭРЭЛТЭД НИЙЦСЭН САНХҮҮЖИЛТ	ДУНДАЖ ДАВХАРГАД ЗОРИУЛСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	ХАМГААЛАГДСАН ДУНДАЖ ДАВХАРГА
Дундаж давхаргыг дэмжсэн санхүүгийн үйлчилгээг бэхжүүлэх үе	Дундаж давхаргыг бэхжүүлэх үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийх үе	Дундаж давхаргыг санхүүгийн эрсдэлээс бүрэн хамгаалах үе
1. Зорилтот санхүүжилт, хөнгөлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдүүлэх	1. Дундаж давхаргын эрэлтэд нийцүүлсэн зорилтот санхүүжилт, хөнгөлөлтийг тасралтгүй хөгжүүлж, дэмжих үйл ажиллагаанд зориулсан төсвийн хуваарилалт/ зарцуулалтыг нэмэгдүүлэх	1. Дундаж давхаргын өрх, гэр бүлд ээлтэй банк, санхүүгийн үйл ажиллагаа тогтворжиж, олон улсын жишигт нийцүүлэн хөгжих, эрсдэлээс хамгаалагдах бодлого хэрэгжиж, өрх, гэр бүл өөрийгөө тэтгэн амьдрах боломжтой болох

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ЗОРИЛТОТ САНХҮҮЖИЛТ, ХӨНГӨЛӨЛТИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТОГТОЛЦОО БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 3.4.1. Дундаж давхаргад ээлтэй банк /байгуулах/ санхүүгийн үйл ажиллагааг дэмжин хөгжүүлнэ.
- 3.4.2. Барьцаа хөрөнгийн, зээл авах хүсэлтэй бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд Засгийн газрын зүгээс санхүүжилтийн баталгаа гаргах үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ.
- 3.4.3. Бичил, жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх зээлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх замаар эрэлтэд нийцсэн зээлийн бүтээгдэхүүн (итгэлийн зээл, лизинг санхүүгийн шинэ төрлийн олон хэлбэрийн үйлчилгээ) бий болгоно.
- 3.4.4. Дундаж давхаргын өрхийн хүүхдүүдийн боловсрол эзэмших, STEM боловсрол эзэмшихэд зориулсан тэтгэлэг бий болгоно.
- 3.4.5. Дундаж давхаргын эрэлтэд нийцүүлэн тохируулна. (боловсролын тэтгэлэг, гарааны бизнес, бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан зорилтот хөрөнгө оруулалтын татварын хөнгөлөлт, урамшуулал гэх мэт)

ЭРҮҮЛ, ИДЭВХТЭЙ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ

ЗОРИЛТ 3.5. Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, биеийн тамир, спортын ээлтэй орчин бүрдүүлнэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020-2030)	II үе шат (2031-2040)	III үе шат (2041-2050)
ИДЭВХТЭЙ АМЬДРАЛЫН ЗӨВ ДАДАЛ ХЭВШИЛ	ЭРҮҮЛ БИЕ-САРУУЛ УХААН	ИДЭВХТЭЙ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ
Биеийн тамир, спортын чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцоо бүрдүүлэх үе	Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн төлөвшүүлэх биеийн тамир, спортын чанар, үр дүнтэй тогтолцоо хөгжүүлэх үе	Биеийн тамир, спортын идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүл төлөвших үе
<ol style="list-style-type: none"> Иргэн бүрд нийтийн биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог бүрдүүлэх Биеийн тамир, спортын үйлчилгээний чанар, гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилт, даатгалын тогтолцоо боловсронгуй болох Биеийн тамир, спортын салбарт цахим үйлчилгээ нэвтэрч, үндэсний нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх Биеийн тамир, спортын салбарын хүний нөөцийн хөгжил, чадавхжуулалт, дэмжлэгийг нэмэгдүүлэх 	<ol style="list-style-type: none"> Идэвхтэй амьдралын дадал хэвшлийг дэмжих тогтолцоо бүрдэж, хот суурингуудын орон сууцны хотхон, хорооллын төлөвлөлтөд биеийн тамир, спортоор хичээллэх, амьдралын дадал хэвшилтэй болгох олон улсын стандарт, шаардлагад нийцсэн, тохилог, таатай орчин бий болгох Амьдрал, ажил, мэргэжлийн хэв маяг, агуулгын өөрчлөлттэй холбоотойгоор биеийн тамир, спортын тэргүүлэх чиглэлийг хөгжүүлж, авьяасыг дэмжсэн механизм бүрдүүлэх 	<ol style="list-style-type: none"> Хиймэл оюун ухаанд тулгуурласан үйлчилгээг нэвтрүүлж, биеийн тамир, спортоор хичээллэх өдөр тутмын амьдралын идэвхтэй дадал хэвшилтэй иргэн, гэр бүл төлөвших

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ИРГЭН БҮРД, НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛД СУУРИЛСАН НЭЭЛТТЭЙ, УЯН ХАТАН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 3.5.1. Биеийн тамирыг бүх нийтийн хөдөлгөөн болгох, иргэн, гэр бүлийн хэрэгцээнд нийцсэн идэвхтэй амьдралын дадал хэвшил төлөвшүүлэх насан туршийн боловсролын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 3.5.2. Улс орныг хамарсан бүх нийтийн спорт, спартакиадыг 4 жил тутамд зохион байгуулна.
- 3.5.3. Хүүхэд, залуучуудын бие бялдрын хөгжлийг дэмжих зорилгоор заавал биелүүлэх спортын норм, нормативыг насны ангиллаар тогтоож мөрдүүлнэ.
- 3.5.4. Хүн амын идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжих, идэвхтэй амьдралын аж төрөх ёсны хэрэглээ, хэрэгсэл болгох судалгаа, сургалт, сурталчилгааны механизм бүрдүүлнэ.
- 3.5.5. Олон улсын шаардлага, стандартад нийцсэн орчинд нийтийн биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх орчин, нөхцөл бүрдүүлнэ.

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ГҮЙЦЭТГЭЛД ТУЛГУУРЛАСАН САНХҮҮЖИЛТ, ДААТГАЛЫН ТОГТОЛЦОО БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР

- 3.5.6. Биеийн тамир, спортын үйлчилгээний төрөл, гүйцэтгэлтэй уялдсан хараат бус магадлан итгэмжлэл бүхий чанарын удирдлагыг нэвтрүүлнэ.
- 3.5.7. Нийтийн биеийн тамир, спортын санхүүжилтийг боловсронгуй болгох, хувь хүний хэрэгцээг хангасан байдал, чанартай үйлчилгээ, гарц болон гүйцэтгэлд тулгуурлан санхүүжүүлэх механизм бүрдүүлнэ.

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРТ ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ НЭВТЭРЧ, ҮНДЭСНИЙ НЭГДСЭН МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 3.5.8. Биеийн тамир, спортын салбарын мэдээллийн технологийн удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах мэдээллийн нэгдсэн бааз, платформ бий болгоно.
- 3.5.9. Нийтийн биеийн тамир, спортын технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг дэмжинэ.

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ, ЧАДАВХЖУУЛАЛТ, ДЭМЖЛЭГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 3.5.10. Биеийн тамир, спортын үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, шилжилт хөдөлгөөн, тусламж, үйлчилгээний эрэлт, хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулна.
- 3.5.11. Биеийн тамир спортын хөтөлбөрөөр сургалт эрхэлж буй байгууллагад олгох тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэлд тавигдах шаардлагыг шинэчлэх, чиг үүргийг нь хараат бус, мэргэжлийн байгууллагад шилжүүлнэ.
- 3.5.12. Хүүхэд, залуучуудын авьяасыг нээх, шилдэг тамирчдын бэлтгэх, хөгжүүлэх тогтолцоог боловсронгуй болгоно.
- 3.5.13. Биеийн тамир спортын нэн шаардлагатай болон тэргүүлэх чиглэл, мэргэшлээр хүний нөөц бэлтгэх, орон нутгийн хэрэгцээ хангах чиглэлээр хүний нөөцийг төлөвлөх, сургах, урамшуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

ГАЗРЫН ХАРИЛЦАА

ЗОРИЛТ 3.6. Ухаалаг, иргэн төвтэй газрын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх замаар тэгш байдал, шударга ёс, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангана.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ НЭГДМЭЛ УДИРДЛАГА, НЭГДСЭН ТОГТЛОЦОО	УХААЛАГ ГАЗРЫН ХАРИЛЦАА	ТОГТВОРТОЙ ГАЗРЫН ХАРИЛЦАА
Монгол Улсын газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх үе	Байрлалд суурилсан орон зайн мэдээлэл бүхий ухаалаг, иргэн төвтэй газрын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог нэвтрүүлэх үе	Ухаалаг, иргэн төвтэй газрын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх замаар тэгш байдал, шударга ёс, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангах үе
<ol style="list-style-type: none"> Газар, түүний нөөцийг зохистой, үр дүнтэй ашиглах, иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод газрын харилцааны орчин бүрдүүлэх Газрын бирж, олон зориулалттай кадастрын нэгдсэн системийг нэвтрүүлж, газрын нэгдмэл сан, түүний ашиглалтад тавих төрийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгох Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг бий болгох, газрыг хамгаалах, нөхөн сэргээх тогтолцоо бүрдүүлэх Монгол улсын геодезийн сүлжээг шинэчлэн сайжруулж, нийт нутаг дэвсгэрийг бүх төрлийн масштабын байр зүйн зургаар бүрэн хангах 	<ol style="list-style-type: none"> Газрын хяналт, удирдлагын нэгдсэн тогтолцоо бий болгож бэхжүүлэх Үндэсний орон зайн мэдээллийн нэгдсэн платформ бий болгож хөгжүүлэх, хэрэглэж хэвших 	<ol style="list-style-type: none"> Хүртээмжтэй, ухаалаг газрын удирдлага, менежментийн тогтолцоог бий болгох, бэхжүүлэх

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 3.6.1. Мэдлэгт суурилсан, иргэд, олон нийтийн оролцоотой газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөлтийн системийг бий болгоно.
- 3.6.2. Ухаалаг газрын кадастрын нэгдсэн системийг байгуулж, иргэн төвтэй төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.

- 3.6.3. Улсын хэмжээнд газар ашиглалтын зориулалт бүрээр тооллого явуулж, зурагжуулж, мэдээллийн санд бүртгэнэ.
- 3.6.4. Цахим үйл ажиллагаатай газрын биржийг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд байгуулж, газар, үл хөдлөх хөрөнгө /ҮХХ/-ийн нэгдсэн системийг бий болгоно.
- 3.6.5. Газрын нэгдмэл сангийн ангилал бүрээр газрын төлөв байдал, чанарын мониторингийн сүлжээ байгуулж үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангана.
- 3.6.6. Улсын хэмжээнд газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг зохион байгуулж, газар ашиглалтын хяналтын системийг хэрэгжүүлнэ.
- 3.6.7. Олон улсын геодезийн сүлжээнд холбогдсон, байнгын ажиллагаатай станцуудаас бүрдсэн геодезийн хэмжил зүйн дэд бүтцийг монгол орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулж, тэдгээрийн тоон мэдээллийг хэрэглэгчдэд түгээх цахим тогтолцоог бий болгоно.
- 3.6.8. Монгол орны газар нутгийг бодит агшны мэдээлэл бүхий байр зүйн тоон зургаар зурагжуулж, хэрэглэгчдэд шуурхай хүргэж, хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн байр зүйн болон баталгаажсан нэг маягийн суурьтай сэдэвчилсэн газрын зураг, атласаар хангана.
- 3.6.9. Хот байгуулалт, инженерийн дэд бүтэц, барилга байгууламжийг төлөвлөх, барьж байгуулах, өргөтгөх, ашиглах үеийн геодезийн хэмжлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ.
- 3.6.10. Газар, байгаль, нийгэм-эдийн засгийн нөхцөл, нөөц, чадавхад тулгуурлан газар ашиглалт, хамгаалалтын үр ашгийг дээшлүүлэх, газрыг иргэд болон эдийн засгийн хувьд үндэслэл сайтай, үр ашигтай, экологийн тэнцвэрт байдлыг хангасан газар зохион байгуулалтыг хөгжүүлж, газрын нөөцүүдийг оновчтой ашиглаж хэвшинэ.
- 3.6.11. Зайнаас тандан судлалын технологид суурилсан газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг хөгжүүлж, нэвтрүүлнэ.
- 3.6.12. 3D, 4D газрын кадастрын нэгдсэн системийг бий болгож хөгжүүлнэ.
- 3.6.13. Хиймэл оюун ухаан болон блокчейн технологид суурилсан газрын үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг бий болгоно.
- 3.6.14. Дэвшилтэд технологид суурилсан гурван газар, үл хөдлөх хөрөнгийн системийг хөгжүүлнэ.
- 3.6.15. Улсын хэмжээнд 3 хэмжээст байр зүйн болон газар доорх инженерийн шугам сүлжээний зургийг зохионо.
- 3.6.16. Геодезийн олон улсын VLBI станц байгуулна.
- 3.6.17. Байрлалд суурилсан орон зайн мэдээллийн нийгэм, эдийн засагт үзүүлэх өр өгөөжийг нэмэгдүүлнэ.
- 3.6.18. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартуудыг нутагшуулж, байгаль, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн үр дүнтэй газрын удирдлага, менежментийг хэрэгжүүлэх инноваци ба түншлэлийг бий болгоно.

АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА ЗОРИЛГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

Хүснэгт 3.1. Амьдралын чанар ба дундаж давхарга зорилгын хэрэгжилтийн хяналт, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин

Тайлбар: * тэмдэглэгээ бүхий шалгуур үзүүлэлтийг шинээр тооцдог болно.

#	Шалгуур үзүүлэлт (indicator)	Хэмжих нэгж	Суурь түвшин	2030	2040	2050	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хаанаас авах эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах аргазүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
3	АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА										
1	Дундаж давхаргын иргэдийн хувь*	хувь	16.2	55	70	80	Дундаж давхаргын хүн амын тоог нийт хүн амын тоонд харьцуулж тооцно. Тооцсон арга зүй: Нэг хүнд өдөрт ногдох хэрэглээг олохдоо өрхийн сарын нийт хэрэглээг ам бүлийн тоонд хувааж, мөн нэг өдөрт ногдох хэмжээнд шилжүүлсэн. Улмаар тухайн оны PPP-ээр илэрхийлэгдэх долларт шилжүүлсэн. Дараа нь тухайн дүнгүүдээ дэлхийн банкны 5 ангийн аль ангид багтаж байгаагаар хуваарилж, тухайн ангид эзлэх хүн амын хувийн жингээ олсон.	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа	Үндэсний хэмжээний түүвэр судалгаа	жил бүр	Үндэсний статистикийн хороо
2	Төрөлтийн нийлбэр коэффициент (нэг эмэгтэйд ногдох)	нэг эмэгтэйд ногдох хүүхдийн тоо	2.9	3.3	3.4	3.5	15-49 насны нэг эмэгтэйн амьдралынхаа туршид төрүүлсэн дундаж хүүхдийн тоо	Үндэсний статистикийн хороо	захиргааны статистик мэдээлэл	жил бүр	Үндэсний статистикийн хороо
3	Хүн амын жилийн дундаж өсөлтийн хурд	хувь	1.9	1.6	1.7	1.8	Нийт хүн амын жилийн дундаж өсөлт өөрчлөлтийг хувиар илэрхийлсэн утга	Үндэсний статистикийн хороо	захиргааны статистик мэдээлэл	жил бүр	Үндэсний статистикийн хороо
4	Хүн амын дундаж наслалт	жил	70.2	71.2	72.9	73.5	Төрөлтөөс тооцсон дундаж наслалтын хэмжээ	Үндэсний статистикийн хороо	захиргааны статистик мэдээлэл	жил бүр	Үндэсний статистикийн хороо

#	Шалгуур үзүүлэлт (indicator)	Хэмжих нэгж	Суурь түвшин	2030	2040	2050	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хаанаас авах эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах аргазүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
5	Хөдөөгийн хүн амын эзлэх хувь	хувь	32.6	40	45	50	Хөдөөгийн хүн амын тоог улсын нийт хүн амын тоонд харьцуулж тооцно	Үндэсний статистикийн хороо	захиргааны статистик мэдээлэл	жил бүр	Үндэсний статистикийн хороо
6	Орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамрагдсан зээлдэгчдийн тоо	Зээлдэгч	71073	90000	110000	130000	Орон сууцны хөнгөлөлттэй зээл авсан иргэдийн тоог арилжааны банкны, зах зээлийн хүүгийн нөхцөлтэй зээл авсан иргэдийн тоотой харьцуулсан харьцуулалт	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Барилга хот, байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төрийн орон сууцны корпораци, Монгол банк, Арилжааны банк, Монголын Ипотекийн Корпораци	Банкуудын зээлдэгчдийн мэдээллийн сан	Жил бүр	Барилга хот, байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төрийн орон сууцны корпораци, Монгол Банк, Монголын Ипотекийн Корпораци
7	Орон сууцны хөнгөлөлттэй зээлд анх удаа хамрагдаж буй зээлдэгчдийн тоо	зээлдэгч	26289	35000	45000	55000	Өөрийн өмчлөлийн орон сууцгүй иргэдийг төрөөс 1 удаад дэмжиж орон сууцтай болгох зохицуулалтаар тооцож байна.	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Барилга хот, байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төрийн орон сууцны корпораци Монголбанк, арилжааны банк, Монголын Ипотекийн Корпораци	Зээлдэгчдийн мэдээллийн сан	Жил бүр	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Барилга хот, байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төрийн орон сууцны корпораци Монголбанк Монголын Ипотекийн Корпораци

#	Шалгуур үзүүлэлт (indicator)	Хэмжих нэгж	Суурь түвшин	2030	2040	2050	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хаанаас авах эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах аргазүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
8	Инженерийн бүрэн хангамжтай Орон сууцаар хангагдсан өрхийн эзлэх хувь	хувь	25.3	35.8	42.8	49.8	Орон сууцанд амьдардаг нийт хүн амын тоог улсын нийт хүн амын тоонд харьцуулж тооцно. 2015 оны завсрын тооллогоор гарсан дүн. 2020 оны хүн ам, орон сууцны тооллогоор энэ үзүүлэлт шинэчлэгдэнэ гарна.	Үндэсний статистикийн хороо	Хүн ам, орон сууцны тооллого	5 жил тутам	Үндэсний статистикийн хороо
9	Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны санхүүжилтийн хөнгөлөлт (татаас, татварын хөнгөлөлт гэх мэт) эдэлсэн иргэдийн хувь*	хувь	СЯ, ТЕГ-аас суурь болон хүрэх түвшинг тодорхойлж гаргана.				Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны санхүүжилтийн хөнгөлөлт (татаас, татварын хөнгөлөлт гэх мэт) авсан иргэдийн тоог нийт орон сууц худалдан авсан иргэдийн тоонд харьцуулж тооцно	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Барилга хот, байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төрийн орон сууцны корпораци, Монгол банк, Арилжааны банк, Монголын Ипотекийн Корпораци	татварын мэдээллийн сан	Жил бүр	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Барилга хот, байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төрийн орон сууцны корпораци, Монгол банк, Монголын Ипотекийн Корпораци
10	Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны санхүүжилтийн нийт хөнгөлөлтийн хэмжээ*	сая.төг	СЯ-наас суурь болон хүрэх түвшинг тодорхойлж гаргана.				Төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны санхүүжилтийн нийт хөнгөлөлтийн хэмжээ, сая.төг	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Барилга хот, байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төрийн орон сууцны корпораци, Нийслэлийн орон сууцны корпораци	Үндэсний статистикийн хороо, Барилга хот, байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төрийн орон сууцны корпораци, Нийслэлийн орон сууцны жилийн ажлын тайлан	Жил бүр	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Барилга хот, байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төрийн орон сууцны корпораци, Нийслэлийн орон сууцны корпораци

#	Шалгуур үзүүлэлт (indicator)	Хэмжих нэгж	Суурь түвшин	2030	2040	2050	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хаанаас авах эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах аргазүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
11	Орон сууцны фонд	мян.м2	16428.1	20174.7	23580.8	26986.8	Талбайн хэмжээ (өрөөний тоо гэх мэт) нь нэмэгдсэн төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны тоо, орон сууцны төрлөөр	Барилга хот, байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төрийн орон сууцны корпораци, Нийслэлийн орон сууцны корпораци	Барилга хот, байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төрийн орон сууцны корпораци, Нийслэлийн орон сууцны корпорацийн жилийн ажлын тайлан	Жил бүр	Барилга хот, байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төрийн орон сууцны корпораци, Нийслэлийн орон сууцны корпораци
12	Гэр хорооллоос орон сууцны цогцолбор, хотхон болж өөрчлөгдсөн нийт талбай (өрхийн)-н тоо	тоо	1800	45000	75000	100000	Гэр хорооллоос орон сууцанд шилжин амьдарсан нийт (өрх)-ийн тоо	Барилга хот, байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	Жил бүр	Барилга хот, байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газар
13	Гэр хорооллын өрхүүдээс ногоон сууцтай болсон өрх	хувь	-	10	15	20	Гэр хорооллын өрхүүдээс ногоон сууц (байгаль орчинд ээлтэй, ашиглалтын зардал багатай)-тай болсон өрхийн дүнд эзлэх хувь	Барилга хот, байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төрийн орон сууцны корпораци, Нийслэлийн орон сууцны корпораци	Барилга хот, байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төрийн орон сууцны корпораци, Нийслэлийн орон сууцны корпорацийн жилийн ажлын тайлан	Жил бүр	Барилга хот, байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төрийн орон сууцны корпораци, Нийслэлийн орон сууцны корпораци

#	Шалгуур үзүүлэлт (indicator)	Хэмжих нэгж	Суурь түвшин	2030	2040	2050	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хаанаас авах эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах аргазүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
14	Шинээр нэмэгдсэн гарааны бизнесийн тоо (Тайлант хугацаанд шинээр байгуулагдсан аж ахуйн нэгжийн тоо)	тоо	2641	8857	14509	20161	Тухайн жилд шинээр нэмэгдсэн гарааны бизнесийн тоо, үйл ажиллагааны төрлөөр	Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын жилийн ажлын тайлан	жил бүр	Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
15	Идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн тоо	тоо	62128	120218	173026	225835	Идэвхтэй үйл ажиллагаа эрхэлж байгаа жижиг, дунд үйлдвэр, үйл ажиллагааны төрлөөр	Хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Жижиг дунд үйлдвэрлэлийн сангийн жилийн ажлын тайлан	жил бүр	Хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Жижиг дунд үйлдвэрлэлийн сан
16	Тайлант хугацаанд шинээр байгуулагдсан жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн ажиллагчдын тоо	тоо	2335	6136.38	9592.18	13048	Жижиг, дунд үйлдвэрийн шинээр бий болгосон ажлын байр, үйл ажиллагааны чиглэлээр	Хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Жижиг дунд үйлдвэрлэлийн сангийн жилийн ажлын тайлан	жил бүр	Хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Жижиг дунд үйлдвэрлэлийн сан
17	Экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээгээ гаргадаг жижиг, дунд үйлдвэрийн тоо	тоо	358	885	1365	1845	Экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээгээ гаргадаг жижиг, дунд үйлдвэрийн тоо, үйл ажиллагаа ба бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлөөр	Хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын жилийн ажлын тайлан	жил бүр	Хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Жижиг дунд үйлдвэрлэлийн сан



ЭДИЙН ЗАСАГ

ЧИНЭЭЛЭГ МОНГОЛ

ЭДИЙН ЗАСГИЙН ТЭРГҮҮЛЭХ
ЧИГЛЭЛҮҮД

УХААЛАГ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ

БҮС НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ БРЭНД
БҮТЭЭГДЭХҮҮН

ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САН

ЭДИЙН ЗАСАГ

Монгол Улс хөгжил дэвшлийнхээ түүхэн чухал цаг үеийг туулж байна. Сүүлийн 30 орчим жилийн туршид Монгол Улсын эдийн засаг хурдацтай өсөж байгаа боловч тэгш бус байдал, ажилгүйдэл, ядуурал зэрэг нийтийг хамарсан томоохон асуудлууд байсаар байна. Ардчилсан нийгэм болон зах зээлийн эдийн засгийг бүтээн байгуулж буй Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн шинэ орон зайг тодорхойлох зорилготой энэхүү баримт бичигт хөгжил дэвшлийн гол зорилго болсон ард түмний сайн сайхан байдлыг хангахын тулд нэгдүгээрт, эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, техник технологийг илүү эрчимтэй бөгөөд үр ашигтай байдлаар хөгжүүлэх бодлогыг тодорхойлох; хоёрдугаарт, улс орны ирээдүйн хөгжлийн зорилго, зорилтуудыг эдийн засгийн гадаад, дотоод орчин нөхцөлд гарч болзошгүй өөрчлөлт болон дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн томъёолох; гуравдугаарт, дээр дурдсан нөхцөл байдлыг харгалзан улс орны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрээнд хэрэгжүүлэх бүхий л үйл ажиллагааны цаг хугацаа, эрэмбэ дарааллыг харилцан уялдаатай байдлаар зөв тогтоохыг тус тус зорьсон болно. Ингэхдээ улс үндэстнийхээ аюулгүй байдал, үндэсний өв соёл, экологийн тэнцвэрт байдлыг хамгаалах асуудалд илүү өндөр ач холбогдол өгч, хамтатган авч үзэж байгаагаараа онцлогтой.

Эдийн засгийн тооцоо хийсэн ажлын хэсгээс ерөнхий тэнцвэрийн динамик загварыг (CGE) төлөвлөгөөт үр дүнгээ төсөөлөх гол арга зүйн хэрэгсэл болгон ашигласан. Эхний арван жилийн эдийн засгийн хөгжлийн тооцоолол, төсөөллийг 1) суурь хувилбар буюу эдийн засгийн хөгжлийн өнөөгийн хандлага цаашид хэвээр үргэлжлэх, төрийн оролцоо, зохицуулалтыг өнөөгийн түвшинд байлгах, 2) “ногоон эдийн засаг” хувилбар буюу малын тоо толгойн өсөлтийг бэлчээрийн даацад нийцүүлэх, 3) “томоохон төсөл хөтөлбөрүүдийн нөхцөлийг оруулан тооцсон хувилбар” буюу “ногоон эдийн засаг” хувилбар болон бизнесийн болон дэд бүтцийн томоохон төслүүдийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүнг хамтатгах хувилбар гэсэн гурван хувилбараар хийж гүйцэтгэсэн.

2020-2030 онд ДНБ-ий үйлдвэрлэлийн хэмжээ 2018 оны валютын ханшаар 32.1 тэрбум долларт хүрэх, 1 хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 8299 долларт хүрэхээр байна. Энэ үед ДНБ-ий 31.4 хувийг уул уурхай, олборлох салбар, 14.6 хувийг боловсруулах аж үйлдвэр, 10.5 хувийг худалдааны салбар бүрдүүлэхээр байна.

2031-2040 онд ДНБ-ий үйлдвэрлэлийн хэмжээ 2018 оны валютын ханшаар 54 тэрбум долларт хүрэхэд 1 хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 12004 долларт хүрч өснө. Энэ үе шатанд боловсруулах аж үйлдвэр болон тээвэр, логистикийн салбарт хамгийн өндөр өсөлт бий болгохоор байна.

2041-2050 онд ДНБ-ий үйлдвэрлэлийн хэмжээ 2018 оны валютын ханшаар 77.7 тэрбум долларт хүрч, 1 хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 15000 долларт хүрч өснө. Энэ үед ДНБ-ий 27.4 хувийг боловсруулах аж үйлдвэр, 25.3 хувийг уул уурхай, олборлох салбар, 11.6 хувийг тээвэр логистикийн салбар бүрдүүлэхээр байна. Эдгээр салбаруудаас гадна эрчим хүч, аялал жуулчлал болон бүтээлч эдийн засгийн салбаруудад мөн өндөр өсөлт бий болохоор байна. Өөрөөр хэлбэл, ирэх 30 жилд манай эдийн засагт бүтцийн эрс өөрчлөлт гарч, боловсруулах аж үйлдвэр болон бусад шинэ салбарууд хөгжиж, эдийн засаг бодитойгоор олон тулгуурт болох нөхцөл бүрдэж байна. Монгол Улсын эдийн засгийн гадаад зах зээлээс хамааралтай эмзэг байдал арилж, хэрэглэгч эдийн засгаас үйлдвэрлэгч эдийн засаг руу шилжиж, дараах үндсэн салбараар эдийн засгийн бүтэц тодорхойлогддог болно.

Үүнд:

1. Боловсруулах аж үйлдвэр (Хүнд, Хөнгөн, Хүнс)
2. Олборлох болон боловсруулах үйлдвэрлэлийн зохимжтой харьцаа бүхий уул уурхайн аж үйлдвэр
3. Эрчим хүч
4. Тээвэр, логистикийн салбар
5. Аялал жуулчлал
6. Мэдлэгжсэн, бүтээлч эдийн засаг /Creative Industry/ зэрэг болно.

Урт хугацааны хөгжлийн бодлогын үр дүнд эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засгаа бүрдүүлж чадсан улс орон болно. Ингэснээр 2050 он гэхэд ДНБ 6.1 дахин, нэг хүнд ногдох ДНБ 3.6 дахин нэмэгдэж 15000 ам.долларт хүрнэ.

Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн хөгжлийн үе шатуудыг тодорхойллоо.



Орчин үеийн эдийн засгийн судалгаанд өргөн ашиглах болсон мэдээллийн томоохон бааз суурь, программ хангамжид суурилсан макро эдийн засгийн тооцооллыг хийдэг Ерөнхий тэнцвэрийн динамик загварыг өөрийн жижиг, нээлттэй, эдийн засгийн нөхцөлд нийцүүлэн хөгжүүлж, төсөөллийг хийхэд ашиглалаа.

Тооцооллыг гурван үндсэн хувилбараар хийв. Үүнд:

1. Суурь хувилбар
2. “Ногоон эдийн засаг” хувилбар
3. Томоохон төсөл хөтөлбөрүүдийг оруулан тооцсон хувилбар

Суурь хувилбар бол эдийн засгийн хөгжлийн өнөөгийн хандлага цаашид хэвээр үргэлжилж, эдийн засгийн амьдралд оролцох төрийн оролцоо болон зохицуулалтыг өнөөгийн түвшинд нь байлгах хувилбар юм. “Ногоон эдийн засаг” хувилбар нь малын тоо толгойн өсөлтийг бэлчээрийн даацад нь нийцүүлэх хувилбар бөгөөд ийм арга хэмжээг яаралтай аваагүй нөхцөлд бэлчээр хомсдож, даац нь хүрэлцэхгүйн улмаас мал аж ахуйн салбар уналтад орох томоохон эрсдэлтэй. Томоохон төсөл хөтөлбөрүүдийг оролцуулсан хувилбар нь “ногоон эдийн засаг” хувилбар болон хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгагдсан бизнесийн болон дэд бүтцийн томоохон төслүүдийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүнг хамтатган харуулна.


ЧИНЭЭЛЭГ МОНГОЛ

Хувилбар бүрт эдийн засгийн өсөлтийн хэмжээ харилцан адилгүй байна. 2018 оны байдлаар манай улсын ДНБ-ий хэмжээ 11.7 тэрбум ам доллар, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 3879 ам.долларын хэмжээнд байна.

Эдийн засгийн өсөлтийн энэ хандлага хэвээр үргэлжилсэн нөхцөлд ДНБ-ий хэмжээ 2025 онд 21.0 тэрбум ам.долларт, 2030 онд 29.4 тэрбум ам.долларт, 2035 онд 40.1 тэрбум ам.долларын хэмжээнд хүрэхээр байна. ҮСХ-оос гаргасан хүн амын өсөлтийн тооцооны дээд хувилбарыг ашиглан тооцоолоход нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2018 оны зэрэгцүүлэх үнээр 2025 онд 5878 ам.доллар, 2030 онд 7616 ам.долларт хүрэхээр байна. Эдгээрийг тухайн оны үнээр илэрхийлбэл, нэг хүнд ногдох ДНБ 2025 онд 6917 ам.доллар, 2030 онд 9895 ам.долларын хэмжээнд байхаар байна.


Малын тоо толгойд зохицуулалт хийх “ногоон эдийн засаг” хувилбараар дээрх тооцооллыг давтан хийхэд ДНБ-ий хэмжээ оны үнээр 2025 онд 20.8 тэрбум ам.доллар, 2030 онд 28.5 тэрбум ам.доллар, 2035 онд 38.7 тэрбум ам.долларын хэмжээнд тус тус байх болно. Харин нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2018 оны зэрэгцүүлэх үнээр 2025 онд 5819, 2030 онд 7402 ам.доллар, оны үнээр харгалзан 6848, 9617 ам.долларын хэмжээнд тус тус байх юм.

Зураг 4.2. Эдийн засгийн өсөлтийн тооцоо



Томоохон төслүүдийг эргэлтэд оруулснаар эдийн засгийн өсөлт хурдсаж, ДНБ-ий хэмжээ оны үнээр 2025 онд 22.4 тэрбум ам.долларт, 2030 онд 32.0 тэрбум ам.долларт тус тус хүрэхээр байна. Ингэснээр нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2018 оны зэрэгцүүлсэн үнээр 2025 онд 6270, 2030 онд 8299 ам.долларт, оны үнээр 2025 онд 7378, 2030 онд 10783 ам.долларт хүрэх юм.

Зураг 4.3. Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ




Аль ч хувилбарын тооцооноос үзэхэд, ДНБ-ий бүтцэд томоохон өөрчлөлт гарч, олборлох үйлдвэрлэлийн болон бизнесийн үйлчилгээний салбаруудын эзлэх хувийн жин өссөөр байх төлөвтэй байна.

2018 оны байдлаар улсын хэмжээнд 1253.0 мянган хүн ажил эрхэлж, сард дунджаар 640 мянган төгрөгийн цалин авч байна. Дундаж цалингийн хэмжээг ҮСХ-оос 2018 онд боловсруулан гаргасан салбар хоорондын тэнцлийн тоо баримтуудаас тооцоолон гаргасан болно. ҮСГ-аас газраас гаргасан судалгаагаар тогтоогдсон бодит цалингийн хэмжээ үүнээс нэлээд өндөр тоо байдаг боловч энэ нь авч буй цалингийн дундаж хэмжээ юм. Гэвч хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн багагүй хэсэг нь улирлын чанартай үйлдвэрлэл эрхэлдгийн улмаас жилийн ихэнх хугацаанд тогтсон орлогогүй байдаг тул дундаж цалингийн хэмжээ үүнээс хавьгүй доогуур хэмжээнд байна.

Суурь хувилбараар ажиллагсдын тоо 2025 он гэхэд 1543 мянгад, 2030 он гэхэд 1807 мянгад хүрэх төлөвтэй байгаа бөгөөд дундаж цалингийн хэмжээ 2017 оны зэрэгцүүлсэн үнээр 2025 онд 746 мянган төгрөгт, 2030 онд 788 мянган төгрөгт тус тус хүрэхээр байна.

Зураг 4.4. Дундаж цалингийн төсөөлөл




Харин “ногоон эдийн засаг” хувилбарыг сонгон авсан нөхцөлд ХАА-н салбарын ажлын байрны тоо үлэмж хэмжээгээр хорогдох бөгөөд нийт ажлын байрны тоо 2025 он гэхэд 1510 мянгад, 2030 он гэхэд 1711, 2035 он гэхэд 2010 мянгад хүрэхээр байна. Харин дундаж цалингийн хэмжээ энэ хувилбарт бусад хувилбаруудтай харьцуулахад харьцангуй доогуур хэмжээнд, дундаж цалингийн хэмжээ 2017 оны зэрэгцүүлсэн үнээр 2025 онд 732 мянган төгрөгт, 2030 онд 742 мянган төгрөгт тус тус хүрэхээр тооцоологдлоо.


Томоохон төсөл хөтөлбөрүүдийг оруулсан тооцоогоор улсын хэмжээний нийт ажлын байрны тоо 2035 он гэхэд 1606 мянгад, 2030 он гэхэд 1916 мянган төгрөгт хүрэх магадлалтай байгаа бөгөөд дундаж цалин 2025 онд 2017 оны зэрэгцүүлсэн үнээр 772 мянган төгрөгт, 2030 он гэхэд 808 мянган төгрөгийн хэмжээнд байх тооцооны үр дүн гарлаа.

Тооцооны үр дүнгээс үзэхэд, эдийн засгийг хөгжүүлэх бодлогын хувилбар тус бүрийн хувьд шаардагдах ажлын байрны тоо харилцан адилгүй байгаа бөгөөд томоохон төсөл хөтөлбөрүүдийг эргэлтэд оруулснаар тэдгээрийн шууд болон шууд бус нөлөөгөөр 2025 он гэхэд 64 мянга, 2030 он гэхэд 110 мянга ажлын байрыг шинээр үүсгэх боломжтой байна.


Зураг 4.5. Ажиллах хүчний төсөөлөл, салбараар, 2018 он




Зураг 4.6. Ажиллах хүчний төсөөлөл, салбараар, 2025 он



Зураг 4.7. Ажиллах хүчний төсөөлөл, салбараар, 2030 он



Зураг 4.8. Ажиллах хүчний хэрэгцээ



ЗОРИЛТ 4.1. Макро эдийн засгийн тогтвортой орчинг бүрдүүлж, дундаж давхаргыг нийгмийн зонхилох бүлэг болгоно.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
ӨРИЙН ДАРАМТГҮЙ ТОГТВОРТОЙ ЭДИЙН ЗАСАГ	ХУРИМТЛАЛТАЙ МОНГОЛ	ЧИНЭЭЛЭГ МОНГОЛ
Засгийн газрын хугацаа тулсан гадаад өр төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэж, үр ашгийг дээшлүүлэх, макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангаж, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх үе	Үндэсний хуримтлал бүхий макро эдийн засгийн орчинг бүрдүүлэх үе	Макро эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг хангаж, бүрэн ажил эрхлэлттэй, инфляцын нам түвшин бүхий макро эдийн засгийн орчинг бүрдүүлж, дундаж давхаргыг нийгмийн зонхилох бүлэг болгох үе
<ol style="list-style-type: none"> Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж, өрийн дарамтыг бууруулж, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих нөхцөлийг бүрдүүлэх Төсвийн хөрөнгийг нийгэм, эдийн засгийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төсөв, санхүүгийн тогтолцоог бий болгох Эдийн засаг жил бүр тогтвортой өсөж, ажил эрхлэлт тасралтгүй нэмэгдүүлэх Бизнесийн таатай орчин бүрдүүлж, иргэдийн худалдан авах чадварыг дээшлүүлэх Хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх 	<ol style="list-style-type: none"> Үндэсний хуримтлалын хэмжээг нэмэгдүүлж, зээлжих зэрэглэлийг сайжруулах 	<ol style="list-style-type: none"> Дундаж давхаргыг нийгмийн зонхилох бүлэг болгон бүрдүүлэх

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛЖ, ӨРИЙН ДАРАМТЫГ БУУРУУЛЖ, ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 4.1.1. Уул уурхайн томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахдаа олон улсын стандарт, хэм хэмжээг чандлан мөрдөнө.
- 4.1.2. Гадаадын зээлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдэд зардал, үр өгөөжийн тооцооллыг хийж, зөвхөн үр ашигтай төслүүдийг санхүүжүүлэх тогтолцоо бүрдүүлж, хөгжүүлнэ.
- 4.1.3. “Ирээдүйн өв сан”-д орлого төвлөрүүлэх, баялгийн сангийн хөрөнгийг оновчтой удирдан, гадаад эдийн засгийн эрсдэл даах систем нэвтрүүлнэ.
- 4.1.4. Болзошгүй өр төлбөрийн төсөвт үзүүлэх нөлөөллийг үнэлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог хөгжүүлнэ.
- 4.1.5. Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрийг төлж, хугацаанаас нь өмнө худалдан авч, дахин санхүүжүүлэх арга хэмжээ авна.
- 4.1.6. Ил тод байдал, хамтын ажиллагаанд тулгуурлан гадаадын хөрөнгө оруулалтыг татах, гадаад дотоодын хөрөнгө оруулагчид хоорондын хамтын ажиллагаа, холболтын сувгийг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.


ТӨСВИЙН ХӨРӨНГИЙГ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛД ЧИГЛҮҮЛСЭН, ҮР АШИГТАЙ, ҮР ДҮНТЭЙ, ХАРИУЦЛАГАТАЙ ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ТОГТОЛЦОО БИЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР

- 4.1.7. Улсын төсвийн сахилга бат, санхүү, мөнгө, зээлийн бодлого, зохицуулалтын удирдлагыг сайжруулна.
- 4.1.8. Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг үе шаттай бууруулж, улмаар ашигтай болгож, хуримтлал үүсгэж, төсвийн тогтвортой байдлыг хангана.
- 4.1.9. Хөгжлийг дэмжих бодлого, төслийн ТЭЗҮ боловсруулах судалгааны институт байгуулж ажиллуулна.
- 4.1.10. Эдийн засгийн мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлнэ.
- 4.1.11. Татварын шинэ хуулийг хэрэгжүүлж, төсвийн орлогын бааз суурийг өргөжүүлнэ.
- 4.1.12. Тансаг зэрэглэлийн бараа, бүтээгдэхүүний импортын татвар, зохицуулалтыг үр ашигтай хэрэгжүүлнэ.

ӨРИЙН ДАРАМТГҮЙ ТӨР

ГАДААД ӨРИЙН ДАРАМТ /САЯ АМ.ДОЛЛАР/

Монгол Улсын Засгийн газар 2021-2024 онд төлөх нийт 2.9 тэрбум ам.долларын гадаад үнэт цаасны төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах замаар төлөх өрийн оновчтой зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.




ХҮРЭХ ҮР ДҮН

1. Засгийн газрын **ӨРИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООГ** сайжруулж, Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хэмжээг **40-ӨӨС ДООШ ХУВЬД** хүргэнэ.
2. Төсвийн хөрөнгийг нийгэм, эдийн засгийн хөгжилд чиглэсэн, **ҮР АШИГТАЙ, ҮР ДҮНТЭЙ, ХАРИУЦЛАГАТАЙ** төсөв, санхүүгийн тогтолцоо бий болсон байна.
3. Мөнгөний нийлүүлэлтийн хэмжээ нь гадаад валютын албан нөөцийн өсөлттэй уялдсан, гадаад валютын улсын нөөц нь **ЭРСДЭЛ ДААХУЙЦ** хэмжээнд хүрч өссөн байна.



ДУНД ХУГАЦААНЫ ӨРИЙН СТРАТЕГИ

ЗОРИЛТ: Засгийн газрын хугацаа тулсан гадаад өр төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэж, төсөв, санхүүгийн эрсдэлийг бууруулж, үр ашгийг дээшлүүлэх



ГАДААД ВАЛЮТЫН АЛБАН НӨӨЦ НЬ ЭРСДЭЛ ДААХУЙЦ ХЭМЖЭЭНД ХҮРЧ ӨСГӨХ ЧИГЛЭЛЭЭР

- 4.1.13. Инфляцыг зорилтот түвшинд хадгалж, эрсдэл даахуйц гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхийг дэмжсэн мөнгөний бодлого хэрэгжүүлнэ.
- 4.1.14. Төв банкны гадаад өрийг бууруулах зорилгоор БНХАУ-ын Ардын банкттай байгуулсан своп хэлцлийн хүрээнд үүссэн өр төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэнэ.

ЭДИЙН ЗАСАГ ЖИЛ БҮР ТОГТВОРТОЙ ӨСӨЖ, АЖИЛ ЭРХЛЭЛТИЙГ ТАСРАЛТГҮЙ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 4.1.15. Макро эдийн засгийн зорилттой нийцүүлж, төсөв, мөнгөний бодлогыг харилцан хослуулан хэрэгжүүлнэ.
- 4.1.16. Санхүүгийн системийн эмзэг байдлыг бууруулах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.
- 4.1.17. Байгальд ээлтэй үр ашигтай, цэвэр технологи, хэмнэлттэй хэрэглээг дэмжсэн тогтвортой, эрсдэл даах ногоон эдийн засгийн хөгжлийг дэмжих ногоон санхүүжилт, татвар татаас, худалдан авалт урамшууллын тогтолцоог хөгжүүлнэ.
- 4.1.18. Дамжин өнгөрүүлэх тээвэр, худалдаа, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг тээвэр, логистик, хилийн дэд бүтцийн хамт байгуулан эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангана.
- 4.1.19. Алт цэвэршүүлэх үйлдвэр болон бусад технологийн түүхий эдэд суурилсан гадаадын томоохон хөрөнгө оруулалтыг татах замаар эдийн засгийн экспоненциал өсөлтийг бий болгоход анхаарч ажиллана.

БИЗНЕСИЙН ТААТАЙ ОРЧИН БҮРДҮҮЛЖ, ИРГЭДИЙН ХУДАЛДАН АВАХ ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 4.1.20. Эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах замаар бизнес эрхлэгчид шинээр хөрөнгө оруулалтын эх үүсвэр бий болгох таатай орчныг бүрдүүлэхэд чиглэнэ.
- 4.1.21. Бизнесийн шударга өрсөлдөөнийг дэмжсэн эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн бодлого хэрэгжүүлнэ.
- 4.1.22. Орчин үеийн технологи ашиглах ур чадвартай ажилчид бэлтгэх, бүтээмжид тохирсон цалин олгоно.

- 4.1.23. Экспортын тэргүүлэх ач холбогдол бүхий салбаруудын бараа бүтээгдэхүүний судалгаа, маркетингийг дэмжинэ.

ҮНДЭСНИЙ ХУРИМТЛАЛЫН ХЭМЖЭЭГ НЭМЭГДҮҮЛЖ, ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

- 4.1.24. Төсөв, мөнгө, зээл, гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын харилцан уялдаатай бодлого хэрэгжүүлж, эдийн засгийн өсөлт болон бүтцийн өөрчлөлтийн ололтыг цаашид тогтвортой хадгална.
- 4.1.25. Хадгаламж, хуримтлалыг нэмэгдүүлэх дадлыг бий болгоно.
- 4.1.26. Хуримтлал-эх үүсвэрийг нэмэгдүүлж, хүүг бууруулах замаар үндэсний үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

ДУНДАЖ ДАВХАРГА НИЙГМИЙН ЗОНХИЛОХ ХЭСГИЙГ БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 4.1.27. Макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг хадгалж, ажилгүйдлийг нам түвшинд тогтвортой хадгална.
- 4.1.28. Зээлийн хүүг хөгжингүй орнуудын түвшинд хүргэж, тогтвортой хадгална.
- 4.1.29. Байгальд ээлтэй, хаягдал багатай, үр ашигтай, хэмнэлттэй эдийн засгийн бүтцийг бий болгох бодлого баримтална.
- 4.1.30. Хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх чиглэлээр
- 4.1.31. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, дэмжих суурь нөхцөлийг бүрдүүлж, ханган нийлүүлэлтийг хөгжүүлэх үндэсний бодлого, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 4.1.32. Гадаадын хөрөнгө оруулалтын эрэлт хэрэгцээг салбараар, байршлаар тодорхойлон, байршил, салбар бүрийн онцлогоос хамааран хөрөнгө оруулалтыг татах бодлогыг шинэчлэн боловсруулна.
- 4.1.33. Гадаадын хөрөнгө оруулалтыг дотоодын ААН-үүдтэй холбох холбоосыг бий болгох зорилгоор сургалт хийх, шинэчлэн зохион байгуулах, улмаар хамтран ажиллах орчинг сайжруулна.
- 4.1.34. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын санаачилгыг дэмжих тухай хууль боловсруулж хэрэгжүүлнэ.
- 4.1.35. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлогыг олон улсын жишигт хүргэн шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ.

ЭДИЙН ЗАСГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД

Дэлхийн зах зээл дэх үнийн түвшин тогтвортой байх нөхцөлд суурь хувилбараар хийсэн тооцооллоор манай улсын экспорт 2018-2030 онуудад жилд дунджаар 4.2-6.3, импорт 4.0-6.8 хувиар өсөхөөр байна. Дурдсан хугацааны үргэлжлэлд экспорт 1.71, импорт 1.77 дахин өсөж, 2017 оны зэрэгцүүлэх үнээр экспорт 13.9 тэрбум ам.долларт, оны үнээр 17.1 тэрбум ам.долларт, импорт 1.77 дахин нэмэгдэж, 2017 оны зэрэгцүүлэх үнээр 11.4 тэрбум ам.долларт, оны үнээр 14.5 тэрбум ам.долларт хүрэх тооцоо гарав.

“Ногоон эдийн засаг” хувилбараар 2018-2030 онуудад экспорт жилд дунджаар 4.0-6.8 хувь, импорт жилд дунджаар 4.1-6.3 хувь, дурдсан хугацааны туршид экспорт 1.69 дахин, импорт 1.75 дахин өсөх тооцоо гарч байна. Ингэснээр 2030 он гэхэд манай улсын экспорт 2017 оны зэрэгцүүлэх үнээр 13.4 тэрбум ам.долларт, оны үнээр 16.9 тэрбум ам.долларт, импорт 2017 оны зэрэгцүүлэх үнээр 11.3 тэрбум ам.долларт, оны үнээр 14.3 тэрбум ам.долларт хүрэхээр байна.

Харин томоохон төслүүдийг оруулсан тооцоогоор, тэдгээр төслийн нөлөөгөөр экспорт жилд 2.2-31.6 хувь, импорт 3.5-32.9 хувиар өсөж, дурдсан хугацааны туршид экспорт 2.56 дахин, импорт 2.62 дахин өсөх тооцоо гарч байна. 2030 он гэхэд экспорт 2017 оны зэрэгцүүлэх үнээр 20.1 тэрбум ам.долларт, импорт 16.9 тэрбум ам.долларт, оны үнээр экспорт 25.6 тэрбум ам.долларт, импорт 21.5 тэрбум ам.долларт хүрэх тооцоо гарлаа.

ЗОРИЛТ 4.2. Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно.

Хүснэгт 4.1. Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлснээр гарах үр дүнгийн прогноз

Үзүүлэлт / он	2030	2040	2050
ДНБ /2018 оны ханшаар/	32.1 тэрбум ам.доллар	54.0 тэрбум ам.доллар	77.7 тэрбум ам.доллар
1 хүнд ногдох ДНБ	8299 ам.доллар	12004 ам.доллар	14682 ам.доллар
Эдийн засгийн салбарын ДНБ-нд эзлэх хувь:			
Уул уурхай	31.4%	26.8%	25.3%
Боловсруулах аж үйлдвэр	14.6%	20.3%	27.4%
Тээвэр, логистикийн аж ахуй	4.8%	9.7%	11.6%
Бусад	49.2%	43.2%	35.7%

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020-2030)	II үе шат (2031-2040)	III үе шат (2041-2050)
ТҮҮХИЙ ЭД ЭКСПОРТЛОГЧООС БОЛОВСРУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЛОГЧ	ЗҮҮН ХОЙД АЗИЙН ОРГАНИК ХҮНС, ЭРЧИМ ХҮЧНИЙ ИДЭВХТЭЙ ТОГЛОГЧ	ОЛОН ТУЛГУУРТ ЭДИЙН ЗАСАГТАЙ МОНГОЛ
Эдийн засгийн бүтцийн шинэчлэлтийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, импортыг орлох болон экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх үе	Хүнд, хөнгөн болон эрчим хүч, барилгын материалын үйлдвэрлэлийн хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх үе шат луу шилжих үе	Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, олон тулгуурт тогтвортой эдийн засагтай улс болох үе
<ol style="list-style-type: none"> Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэх ХАА-н бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, мах болон ноос ноолууран бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх Үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх Бүтээлч аж үйлдвэрлэл (соёл урлаг, кино урлаг, дуу хөгжим, дизайн архитектур)-ийн хөгжлийн бодлогын суурийг тавих Мэдээллийн технологийн салбарыг дэмжиж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх Боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдүүлэх Эдийн засгийн хөгжлийг дэмжих дэд бүтцийг хөгжүүлэх Хөгжлийг тэтгэх холимог тээврийг хөгжүүлэх Иргэний нисэхийн дэд бүтэц, ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх 	<ol style="list-style-type: none"> Боловсруулах салбар давамгайлсан эдийн засгийн бүтцийг бүрэлдүүлж, хүнсний аюулгүй байдлыг хангах Бүтээлч аж үйлдвэрийг эдийн засгийн бие даасан салбар болгон хөгжүүлэх Эрчим хүчний эх үүсвэрүүдийг нэмэгдүүлж, экспортлогч орон болох Олон улсын стандартад нийцсэн холимог сүлжээ бүрдүүлэх 	<ol style="list-style-type: none"> Эдийн засгийн тэргүүлэх салбаруудын дэлхийн зах зээл дэх байр суурийг бэхжүүлэх

ОРГАНИК ХҮНС, ЭРЧИМ ХҮЧНИЙ ИДЭВХТЭЙ ТОГЛОГЧ

АЧ ХОЛБОГДОЛ

Жижиг эдийн засагтай, хуримтлал багатай манай улсын хувьд эдийн засгийн хязгаарлагдмал нөөцийг тэргүүлэх ач холбогдол бүхий салбаруудад чиглүүлж, экспортын баримжаатай хөгжүүлснээр эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах боломжтой.


Монгол Улсын харьцангуй давуу тал, нөөц боломж, гадаад зах зээлийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ шаардлага зэрэгт үндэслэн **УУЛУУРХАЙ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ БОЛОН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ТҮҮНД ТҮШИГЛЭСЭН ХӨНГӨН ҮЙЛДВЭР, ЭРЧИМ ХҮЧ, ЛОГИСТИК АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, МЭДЛЭГЖСЭН БҮТЭЭЛЧ ЭДИЙН ЗАСГИЙН** салбаруудыг тэргүүлэх салбаруудаар тодорхойлон үе шаттайгаар хөгжүүлэх шаардлагатай байна.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ


ОРГАНИК ХҮНС, ЭРЧИМ ХҮЧНИЙ ИДЭВХТЭЙ ТОГЛОГЧ БОЛСНООР:

ДНБ-д эзлэх уул уурхайн салбарын хувийн жин 30.6 хувьд,

бүтээгдэхүүний экспортын хэмжээ 2 дахин нэмэгдэнэ. Эрчим хүч болон барилгын материалын үйлдвэрлэлийн хэрэгцээг



ДНБ-д эзлэх ХАА-н салбарын эзлэх хувийн жин 9 хувьд хүрч, ХАА-н салбарын боловсруулсан



ХИЙГДЭХ АЖИЛ

I ҮЕ ШАТ (2020-2030)

ЭРҮҮЛ ХҮНС, ЭРЧИМ ХҮЧНИЙ СУУРИЙГ ТАВИНА

Малын эрүүл мэндийг сайжруулах замаар хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, түүхий эдийг боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг урамшуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх

II ҮЕ ШАТ (2031-2040)

ОРГАНИК ХҮНС, ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ

Дэвшилтэд технологийн шинэчлэл хийх, эко хүнс үйлдвэрлэх, логиستيкийн тогтолцоог хөгжүүлэх, Сэргээгдэх эрчим хүч болон эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийн ашиглалтыг нэмэгдүүлэх

III ҮЕ ШАТ (2041-2050)

ЦӨМИЙН ЭРЧИМ ХҮЧТЭЙ МОНГОЛ

Ураны их хэмжээний нөөцөө ашиглан хамгийн найдвартай, аюулгүй технологиор боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, экспортлох

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙГ ХӨГЖҮҮЛЖ, БОЛОВСРУУЛАЛТЫН ТҮВШИНГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 4.2.1 Уул уурхайн томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулахдаа олон улсын стандарт, хэм хэмжээг чандлан мөрдөнө.
- 4.2.2 Уул уурхайн түүхий эдийг боловсруулан, нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг байгаль орчинд ээлтэй, тогтвортой арга зарчмаар хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын дэвшилтэт хэлбэрүүдийг дэмжинэ.
- 4.2.3 Газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж, түүний дэд бүтцийн сүлжээг байгуулах, нефть-химийн үйлдвэр байгуулна.
- 4.2.4 Газрын гадаргын, үерийн болон борооны усыг хуримтлуулах, гол мөрний урсцад тохируулга хийх замаар аж үйлдвэрийн салбарын усны хэрэгцээг хангана.
- 4.2.5 Геологийн судалгааны ажлыг эрчимжүүлж, дунд, урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг хангах эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ.

ХАА-Н БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОЛОВСРУУЛАЛТЫН ТҮВШИНГ НЭМЭГДҮҮЛЖ, МАХ БОЛОН НООС НООЛУУРАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 4.2.6. Малыг эрүүлжүүлэх ажлыг эрчимжүүлэх замаар хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангаж, хүнсний бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.
- 4.2.7. Ноолуурын салбарыг дэмжиж, самнасан ноолуур болон эцсийн бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.
- 4.2.8. Мал амьтны гаралтай арьс, шир, ангийн үс, ноосыг бүрэн боловсруулж, оёмол, сүлжмэл бэлэн бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.
- 4.2.9. Гадаад дотоодын хамтарсан хөрөнгө оруулалтыг дэмжих зохицуулалтын механизмыг бий болгон хэрэгжүүлнэ.
- 4.2.10. Олон улсын зах зээлийн үнийн нөлөөлөлд бага өртдөг экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон экспортын таатай орчинг бүрдүүлэх төрийн бодлогын хэрэгжилтийг хангана.
- 4.2.11. Хур борооны усыг хуримтлуулах, хэмнэлттэй, үр ашигтай технологи нэвтрүүлэх замаар ХАА-н салбарын усны хэрэгцээг хангана.

ҮНДЭСНИЙ ОНЦЛОГ, БҮХИЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЖ, ОЛОН УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЗАХ ЗЭЭЛД ӨРСӨЛДӨХ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 4.2.12. Аялал жуулчлалын гадаад сурталчилгаа, маркетингийн үйл ажиллагааг эрчимжүүлж, олон улсын аялал жуулчлалын сүлжээнд нэгдэнэ.
- 4.2.13. Аялал жуулчлалын үйлчилгээний стандартуудыг олон улсын жишигт нийцүүлэн мөрдүүлнэ.

- 4.2.14. Зарим тусгай хамгаалалттай газар нутгийг байгальд ээлтэй эко аялал жуулчлалын зориулалтаар төлөвлөн хөгжүүлнэ.
- 4.2.15. Хөвсгөл нуурын БЦГ-т “Тогтвортой аялал жуулчлал”-ыг хөгжүүлж, Орхоны хөндийд “Аялал жуулчлалын үндэсний парк”, Хэнтий аймагт “Мянганы суут хүн их эзэн Чингис хаан”, “Их Монгол Улс, Монголын Эзэнт гүрэн”, “Шихихутаг нууц товчоо”, “Хүлэгбаатар Боорчи - Андлалын Өргөө”, “Монголын нууц товчоо” зэрэг аялал жуулчлалын цогцолборуудыг барьж байгуулна.
- 4.2.16. Баруун бүсэд-Адал явдалт, тусгай сонирхлын, Хангайн бүсэд-Байгалийн, амралт зугаалгын, Төвийн болон Улаанбаатарын бүсэд-Албан, бизнесийн, Говийн бүсэд-Байгалийн, палеонтологийн, Зүүн бүсэд-Түүхэн (биет соёлын өвүүдэд тулгуурласан) аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлэх, Баруун бүс, Орхоны хөндийд “Аялал жуулчлалын үндэсний парк” байгуулна.
- 4.2.17. “Их Түмэн голын санаачилга” хөтөлбөр болон Торгоны зам, Цайны замын дагуу аялал жуулчлалын үйлчилгээ, худалдааг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

БҮТЭЭЛЧ АЖ ҮЙЛДВЭРЛЭЛ (СОЁЛ УРЛАГ, КИНО УРЛАГ, ДУУ ХӨГЖИМ, ДИЗАЙН АРХИТЕКТУР)-ИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН СУУРИЙГ ТАВИХ ЧИГЛЭЛЭЭР

- 4.2.18. Бүтээлч аж үйлдвэрийг дэмжих институц, эрх зүйн орчинг бүрдүүлж, бэхжүүлнэ.
 - 4.2.19. Бүтээлч аж үйлдвэрийг хөгжүүлэхэд шаардлагатай боловсон хүчин (продюсер, маркетингийн мэргэжилтэн, уран бүтээлчид)-ийг өндөр хөгжилтэй оронд бэлтгэх(менторшип, ажлын байран дээрх сургалт), гадаад, дотоод хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжинэ.
 - 4.2.20. Бүтээлч аж үйлдвэрлэлийн тэргүүлэх салбар, чиглэлүүдийг тодорхойлж, брэнджүүлэх, кластерийг хөгжүүлнэ.
 - 4.2.21. Бүтээлч аж үйлдвэрийн салбарыг гадаадад сурталчлах, зах зээлийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.
 - 4.2.22. Бүтээлч аж үйлдвэрийг дэмжих санхүүгийн тогтолцоог бүрдүүлнэ.
- ### МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН САЛБАРЫГ ДЭМЖИЖ, ЭДИЙН ЗАСАГТ ОРУУЛАХ ХУВЬ НЭМРИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР
- 4.2.23. Мэдээллийн технологийн салбарыг экспортод чиглүүлэн хөгжүүлэх институцийн тогтолцоог бүрдүүлнэ.
 - 4.2.24. Мэдээлэл технологийн судалгаа, шинжилгээг өргөжүүлж, мэдлэгч суурилсан инновацийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, зөөлөн болон хатуу дэд бүтцийг хөгжүүлнэ.
 - 4.2.25. Мэдээллийн технологийн кластерийг хөгжүүлэх, гадаад зах зээлд гарахад дэмжлэг үзүүлнэ.
 - 4.2.26. Мэдээллийн технологийн салбарыг дэмжих санхүүжилтийн тогтолцоог бий болгох

ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ ТӨСӨЛ



**ҮЙЛДВЭР БАЙГУУЛСНААР
НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ
ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ**

ЗОРИЛГО:

Эрчим хүчний өнөө үеийн хамгийн гол эх үүсвэр болох газрын тосны олборлолт, бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон түүний хангамжийн асуудал аливаа улс орны үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой байдал, нийгмийн хөгжил дэвшилд хүргэх хамгийн чухал нөхцөл болсоор ирсэн. Монгол Улсын Засгийн газар 2017 онд Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр Дорноговь аймгийн, Алтанширээ суманд “Газрын тос боловсруулах үйлдвэр” барих төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэснээс хойш шат дараалсан судалгааны ажлууд хийгдэж, одоогоор үйлдвэрийн инженерчлэл, зураг төслийн ажил хийгдэж эхлээд байна.



- Бүх төрлийн татвар болон ногдол ашгаас улсын төсөвт дорвитой хувь нэмэр орох болно.
- Газрын тосны олборлолт, тээвэрлэлт, боловсруулалтыг дагаад эдийн засгийн бусад салбарууд хөгжиж, ажлын байр нэмэгдэнэ.
- Гадагш гарах валютын урсгал нилээд хэмжээгээр буурна.
- Монгол улс эдийн засгийн нэгэн шинэ тулгууртай, эрчим хүчний бааз суурьтай болно
- Техник, технологийн дэвшлийг авчирна

Хүчин чадал:	Жилд 1.5 сая тонн тос боловсруулах
Үйлдвэрийн байршил:	Дорноговь аймаг, Алтанширээ сум
Боловсруулах тос:	Тамсагийн сав газрын түүхий тос
Үйлдвэрээс гарах бүтээгдэхүүн:	ШШХ, автобензин, дизель, онгоцны түлш, зуухны түлш
Бүтээгдэхүүний чанар:	MNS & Евро V стандарт
Жилд ажиллах хугацаа:	8000 цаг (8750 цаг ажиллах боломжтой)
Гүн боловсруулалтын технологи:	Гидрокрекинг + Висбрекинг

ЗОРИЛТ:

Дотоодын түүхий эдээ боловсруулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, эдийн засгаа түлш шатахуунаар ханган, цаашилбал аж үйлдвэрийн цогцолборын томоохон бүрэлдэхүүн хэсэг болох нефть-химийн үйлдвэрийн суурийг бий болгоход оршино.



**2024 ОНД:
ТҮЛШ
ШАТАХУУНЫ
ҮЙЛДВЭРЛЭЛ**

ШИНГЭРҮҮЛСЭН ХИЙ
АВТОБЕНЗИН
ДИЗЕЛЬ
ОНГОЦНЫ ТҮЛШ
ЗУУХНЫ ТҮЛШ



**2026 ОНД:
НЭМҮҮ ӨРТӨГ
ШИНГЭСЭН
БҮТЭЭГДЭХҮҮН**

ТОС
ТОСОЛГООНЫ
МАТЕРИАЛ
ПАРАФИН ВАКС



**2030 ОНД:
НЕФТЬ-ХИМИЙН
ЦОГЦ АЖ ҮЙЛДВЭР**

НЕФТЬ-ХИМИЙН
ҮЙЛДВЭРЛЭЛ
ХИМИЙН ТҮҮХИЙ ЭД

ДАРХАН АРЬС ШИРНИЙ ЦОГЦОЛБОР

Төсөл хэрэгжүүлэгч: ДАРХАН АРЬС ШИРНИЙ ЦОГЦОЛБОР ХХК
 Хөрөнгө оруулалт: ₮586 ТЭРБУМ
 Төслийн зорилго: АРЬС ШИР, НООС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР, ТҮҮНИЙ ДЭД БҮТЦИЙГ БАЙГУУЛАХ

ДАШЦ нь жилдээ **10 сая** ширхэг арьс шир боловсруулах **13 үйлдвэр, 10 мянган тонн ноос** боловсруулах ноос, ноолуур угаах самнах үйлдвэр, түүний цэвэрлэх байгууламж, дэд бүтцийн барилга байгууламжыг барьж байгуулна.




ЭДИЙН ЗАСГИЙН АЧ ХОЛБОГДОЛ

ЭДИЙН ЗАСГИЙН БҮТЦИЙГ БҮТЭЭМЖ БА АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ОРОЛЦООТОЙ ХАРЬЦУУЛСАН ГРАФИК



ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨ 2019-2034



АЖИЛЛАХ ХҮЧ

Мал аж ахуйн салбар нь хамгийн их ажлын байр бий болгож, эдийн засгийн тогтвортой байдлыг хангадаг. Цогцолборын хүрээнд 20 мянган малчин өрхийг тогтмол орлоготой болгох бол шууд бус дам нөлөөгөөр 300 мянган малчин өрхийн орлого нэмэгдэнэ.



МАН-н салбар нь хөдөлмөрийн зах зээлийн 30 орчим хувийг бий болгож байгаа хэдий ч бүтээмж маш бага байна. Энэхүү салбарт нэмүү өртөг бүтээсэн боловсруулах салбарыг хөгжүүлж бүтээмжийг дээшлүүлэх нь зайлшгүй болоод байна.

“МАЛЫН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭДИЙГ БОЛОВСРУУЛЖ, НЭМҮҮ ӨРТӨГ БИЙ БОЛГОХ БОДЛОГО НЬ МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТҮЛХҮҮР, СТРАТЕГИЙН ЧУХАЛ САЛБАР БОЛООД БАЙНА”

Монголын эдийн засгийн хөдөлгүүр болох уул уурхайн салбар нь ажил эрхлэлтийн дөнгөж 4%-ийг эзэлж байна. Энэ нь тогтвортой эдийн засгийн бодлогод буюу эдийн засгийн суурь бүтцэд төдийлөн сайнаар нөлөөлж чадахгүй байна.

БҮТЭЭЛЧ АЖ ҮЙЛДВЭРЛЭЛ

Монгол орны хувьд өөрийн орны онцлогт нийцсэн, гадаад орчны өөрчлөлттэй уялдсан эдийн засгийн шинэ салбаруудыг хөгжүүлэх хүрээнд Монгол хүний авьяас, чадварыг хөхүүлэн дэмжиж, чанар, шинэ санаа, оюуны өмч, мэдлэг, технологид тулгуурласан **“БҮТЭЭЛЧ АЖ ҮЙЛДВЭРЛЭЛ”-ИЙН САЛБАРЫГ** тодорхойлон хөгжүүлнэ.



Энэхүү шинэ салбар нь түүхий эд, тоног төхөөрөмж, капитал зэрэг үйлдвэрлэлийн хүчин зүйлсийг бага шаарддагаас гадна бүтээмж өндөртэй, үр ашиг ихтэй гэдгээрээ онцлог байна. Иймд **ПРОГРАММ ХАНГАМЖ, АРХИТЕКТУР, ДИЗАЙН, КИНО УРЛАГ, ДУУ ХӨГЖИМ** зэрэг бүтээл үйлдвэрлэлийг дэмжих эрхзүйн орчин, дэд бүтцийг бүрдүүлж, өндөр хөгжилтэй орнуудад мэргэжилтэн бэлтгэж, дэлхийн зах зээлтэй холбохоор зорьж байна.

Эх сурвалж: Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөх Үйлдвэрлэлийн Яам

4.2.27.Төрийн үйл ажиллагааг цахимжуулахад үндэсний програм хангамжийн компаниудыг түлхүү оролцуулна.

4.2.28.Мэдээллийн технологи болон цахим худалдааны салбар дахь хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах, хөрөнгө оруулагчдын ашиг сонирхлыг дэмжинэ.

БОЛОВСРУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЫН ХЭМЖЭЭ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

4.2.29.Худалдааны зохицуулалтын хуулийг батлах, импортын тарифын зохицуулалтаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийг дэмжинэ.

4.2.30.Эдийн засгийг төрөлжүүлэх, аж үйлдвэржүүлэх, бүс нутгуудын хөгжлийг дэмжих эрх зүйн болон хөрөнгө оруулалтын оновчтой зохицуулалтыг бий болгоно.

4.2.31. Барилгын материал, мал амьтны гаралтай болон уул уурхайн түүхий эдийг боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг урамшуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

4.2.32.Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг бүрэн хангасан нэгдсэн системийг бүрдүүлнэ.

4.2.33.Түгээх сүлжээний автоматжуулсан ухаалаг, үр ашигтай системийг үе шаттай нэвтрүүлнэ.

4.2.34. Эрчим хүчний салбарыг хөгжүүлэх бодлого нь.


4.2.35.Хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээг хэвшүүлж усны аюулгүй байдлыг хангах, эрдэс баялгийн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг цэвэрлэх байгууламжтай байх шаардлага тавьж хэрэгжүүлнэ.

Эрчим хүчний салбарыг хөгжүүлэх бодлого нь улс орныг үйлдвэржүүлэх бодлого, бүсчлэн хөгжүүлэх бодлого, томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай шууд уялдаатайгаар хэрэгжих учиртай. Монгол улс эрчим хүчний хэрэглээ өндөртэй уул уурхайн болон хүнд үйлдвэрийн төслүүдийг хэрэгжүүлэх гэж буйтай холбоотойгоор цаашид эрчим хүчний хэрэглээ эрс нэмэгдэх хандлагатай байх нь хэтийн тооцооноос харагдаж байна.

Эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээний эхний 10 жилийн хэтийн тооцоогоор суурь хувилбарт эрчим хүчний салбарын үйлдвэрлэл 2025 он гэхэд одоогийнхоос 33.2 хувиар, ажлын байрны тоо 33.2 хувь, бүтээмж 20.0 хувь, салбарын ДНБ 30.8 хувь, ажиллагсдын бодит цалин 17.2 хувиар тус тус өсөх тооцоо гарч байна. 2030 он гэхэд салбарын үйлдвэрлэл 53.8 хувь, ажлын байрны тоо 53.8 хувиар, бүтээмж 28.7 хувиар, салбарын нэмэгдсэн өртөг 49.4 хувь, ажиллагсдын бодит цалин 23.9 хувиар өсөх тооцоо гарч байна.

“Ногоон эдийн засаг” хувилбарыг хэрэгжүүлсэн нөхцөлд салбарын үйлдвэрлэл 2025 он гэхэд 33.2 хувиар, 2030 онд 53.8 хувиар тус тус өсөх тооцоо гарч байна. Үйлдвэрлэлийн өсөлтийг дагалдан салбарын ДНБ 2025

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ТЭРГҮҮЛЭХ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД



он гэхэд одоогийнхоос 30.6 хувиар, 2030 он гэхэд 49.1 хувиар тус тус өсөх болно. Энэ хувилбарыг хэрэгжүүлсэн нөхцөлд ажлын байрны тоо 2025 он гэхэд одоогийнхоос 33.2 хувиар, 2030 он гэхэд 53.8 хувиар, салбарын хөдөлмөрийн бүтээмж 2025 он гэхэд 20.0 хувь, 2030 он гэхэд 28.7 хувиар тус тус өсөх болно. Энэ хувилбараар тооцоолсон тооцоогоор ажиллагсдын бодит цалингийн хэмжээ 2025 он гэхэд 17.1 хувиар, 2030 он гэхэд 23.6 хувиар тус тус өсөх тооцоо гарлаа.

Томоохон төсөл хөтөлбөрүүдийг эргэлтэд оруулах хувилбараар тооцож үзвэл, салбарын үйлдвэрлэлийн хэмжээ 2025 он гэхэд 46.7 хувиар, ДНБ-ий хэмжээ 42.4 хувиар, ажлын байрны тоо 46.7 хувиар, бүтээмж 32.2 хувиар, ажиллагсдын бодит цалин 28.5 хувиар өсөх болно. 2030 он гэхэд салбарын үйлдвэрлэл 84.9 хувиар, салбарын ДНБ 84.4 хувиар, ажлын байрны тоо 84.9 хувиар, бүтээмж 54.7 хувиар, ажиллагсдын бодит цалин 53.9 хувиар тус өсөхөөр байна.

Аж үйлдвэржүүлэх бодлогыг амжилттай хэрэгжүүлэх, орон нутагт үйлдвэрлэл хөгжих боломжийг бий болгох, олборлож буй нүүрсээ өртөг нэмэгдүүлэх, нүүрсний импортыг бууруулахын тулд эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, цахилгаан станцуудыг барьж байгуулах ажилд анхаарахаас гадна эрчим хүчний нэгдсэн системийг үүсгэн хөгжүүлэх асуудалд илүүтэй анхаарах шаардлагатай байна.

Эрчим хүчний салбарт олон нийлүүлэгчтэй болох замаар улсын монополийг задлах, үнэ тарифийг чөлөөлөх бодлогыг хэрэгжүүлэх нь урт хугацаанд өөрийн хямд түүхий эдэд тулгуурласан эрчим хүчний үр ашигтай үйлдвэрлэлийг хөгжүүлэх, зүй зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эрчим хүчний найдвартай, аюулгүй байдлыг хангах үүднээс чухал ач холбогдолтой болно. Эрчим хүчний нэгдсэн сүлжээг байгуулах нь энэ бүх ажлын эхлэл юм. Эрчим хүчний найдвартай, аюулгүй байдлыг хангах үүднээс томоохон суурин газарт эрчим хүчний цагираг сүлжээг байгуулах, эрчим хүчний эх үүсвэрүүдийг зөв байршилд байршуулах зэрэг анхаарах бусад чиглэлүүд бий.

ҮНДЭСНИЙ ТЭЭВЭР, ЛОГИСТИКИЙН ТОГТОЛЦООГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

4.2.36. Холимог тээврийн салбарт инноваци, дэвшилтэд техник технологи, дижитал шилжилтийг нэвтрүүлж, салбарын аюулгүй, найдвартай байдлыг хангана.

4.2.37. Агаарын тээврийн либералчлалыг хэрэгжүүлж, нислэгийн чиглэл тоог нэмэгдүүлэн, авиа компаний өрсөлдөөнийг дэмжинэ.

4.2.38. Олон улсын чанартай тээвэр, логистикийн төвүүдийг байгуулж, үндэсний тээвэр логистикийн тогтолцоог хөгжүүлнэ.

БОЛОВСРУУЛАХ САЛБАР ДАВАМГАЙЛСАН ЭДИЙН ЗАСГИЙН БҮТЦИЙГ БҮРЭЛДҮҮЛЖ, ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

4.2.39. Тариалангийн дэвшилтэд технологид нийцсэн техникийн шинэчлэл хийж, ухаалаг, эрчимжсэн газар тариаланг хөгжүүлж, эко хүнс үйлдвэрлэнэ.

4.2.40. Үйлдвэрийн аргаар боловсруулсан хүнсний бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх, түүхий эдийн хадгалалт, тээвэрлэлт, үйлдвэрлэл, борлуулалтад чиглэсэн тээвэр, логистикийн тогтолцоог хөгжүүлнэ.

4.2.41. Гадаад, дотоод зах зээлд чиглэсэн гүн боловсруулалтын технологид суурилсан хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

4.2.42. Импортыг орлох барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжинэ.

4.2.43. Монгол Улсын соёл, аялал жуулчлалын төвүүдийг зорилтот зах зээлийн орнуудад байгуулж, гадаад сурталчилгааг сайжруулан, аялал жуулчлалын томоохон төв, паркуудыг байгуулж, шашин, соёл, спорт, адал явдалт аялал зэрэг улирлын хамаарал багатай аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

БҮТЭЭЛЧ АЖ ҮЙЛДВЭРИЙГ ЭДИЙН ЗАСГИЙН БИЕ ДААСАН САЛБАР БОЛГОН ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

4.2.44. Бүтээлч аж үйлдвэрийн салбарын дотоод төрөлжилтийг хангах бодлогод тулгуурлан гадаад зах зээлд байр сууриа олсон брэндүүдийг бий болгоно.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭХ ҮҮСВЭРҮҮДИЙГ НЭМЭГДҮҮЛЖ, ЭКСПОРТЛОГЧ ОРОН БОЛОХ ЧИГЛЭЛЭЭР

4.2.45. Азийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдон, эрчим хүч экспортолно.

4.2.46. Эрчим хүчний салбарт шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлж, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг огцом нэмэгдүүлнэ.

4.2.47. Эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийг ашиглах, түүний дотор бага хүчин чадлын цөмийн станц байгуулах судалгаа хийнэ.

ОЛОН УЛСЫН СТАНДАРТАД НИЙЦСЭН ХОЛИМОГ СҮЛЖЭЭ БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

4.2.38. Авто зам, төмөр зам, агаарын тээвэр болон тээвэр логистикийн төвүүдийн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэн хийж, олон улсын стандартад нийцүүлнэ.

ЭДИЙН ЗАСГИЙН ТЭРГҮҮЛЭХ САЛБАРУУДЫН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ БАЙР СУУРЬ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

4.2.39. Эрчимтэй хөгжиж байгаа дэвшилтэд технологийн түүхий эдийн талаар тусгайлсан бодлого боловсруулж, гадаадын өндөр технологийн хөрөнгө оруулалтыг татна.

4.2.50. Боловсруулах салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэлхийн брэндийн түвшинд хөгжүүлнэ.

4.2.51. Уул уурхайн салбарыг байгальд хал багатай, хариуцлагатай эдийн засгийн салбар болгон хөгжүүлнэ.

4.2.52. Эрчим хүчний үйлдвэрлэлд нар, салхи, биомасс, шингэн болон хийн түлш, газрын гүний дулаан, түлшний элемент, бусад шинэ эх үүсвэрийг ашиглаж, олон улсын зах зээлд эрчим хүч нийлүүлэх бодлогыг эрчимжүүлнэ.

4.2.53. Эрчим хүчний тэнцэлд цөмийн эрчим хүчний байр суурийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

4.2.54. Аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн тогтвортой хөгжлийн салбар болгон хөгжүүлнэ.

4.2.55. Бүтээлч аж үйлдвэр болон мэдээлэл технологийн үйлдвэрийг эдийн засгийн бүтцэд тогтвортой хөгжлийн салбар болгон хөгжүүлнэ.

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДЭД БҮТЭЦ, ЕРӨНХИЙ ЗОРИУЛАЛТЫН НИСЭХИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

4.2.56. Дэлхийн агаарын навигацийн нэгдсэн төлөвлөгөөтэй уялдуулан техник технологийн дэвшилд суурилсан агаарын навигацийн үйлчилгээг хөгжүүлнэ.

4.2.57. Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлнэ.

УХААЛАГ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Санхүүгийн салбарыг бэхжүүлэх нь эдийн засаг тогтвортой өсөх суурь болдог.


Санхүүгийн зах зээлийн эрсдэлийг бууруулах, хөрөнгийн шилжих хөдөлгөөнийг сайжруулах, санхүүгийн зах зээлийн чадамжийг нэмэгдүүлэх нь эдийн засгийн өсөлтийг дэмжих үйл явц юм. Санхүүгийн зах зээлийн эрсдэлийг бууруулах гэдэг нь банк төвтэй системд үүсэж болзошгүй эрсдэлийг санхүүгийн бусад салбар болох хөрөнгө, даатгал, бичил санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх, үйлчилгээний чанар төрлийг нэмэгдүүлэх замаар олон тулгуурт, хүртээмжтэй болгохыг хэлдэг.

Санхүүгийн зах зээлийн гүнзгийрэл, хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсад түгээмэл хэрэглэгддэг хөрөнгийн зах зээлийн хэрэгслүүдийг хөгжүүлж, дэд бүтэц, эрсдэлийн удирдлагыг сайжруулж, оролцогчдын мэдлэгийг дээшлүүлснээр эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, бодит эдийн засагт үзүүлэх мөчлөгийн нөлөөг сааруулах боломжтой.

Монгол Улсад санхүүгийн салбарын дэд бүтцийг сайжруулахад технологийн дэвшлийг ашиглах, санхүүгийн үүсмэл хэрэгсэл, үнэт цаас, буцаан худалдан авах нөхцөлтэй санхүүжилтийн бусад хэрэгслийн эрх зүйн орчинг бүрдүүлэх, мөнгө, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх замаар гадаад хөрөнгийн эх үүсвэрийг зардал багатай татах онцгой ач холбогдолтой юм. Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, дэмжих, хөрөнгө оруулалтын боломжийг нэмэгдүүлэх, зах зээлийн хүртээмж, үр ашгийг дээшлүүлэх бодлого баримталж байна.

Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн олон тулгуурт санхүүгийн зах зээлийг хөгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ.


Зураг 4.15. Санхүүгийн салбарын бүтэц



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2018 оны байдлаар Монголын үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 2511.8 тэрбум төгрөг байгаа бөгөөд 2000 онтой харьцуулахад 19 жилийн хугацаанд 62.0 дахин өсжээ. Харин хөрвөх чадварын үзүүлэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 8.4 хувь байна. Харин нийт зах зээлийн үнэлгээг ДНБ-д харьцуулсан дүн 8.1 хувьтай байна.

Зураг 4.16. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ ба хөрвөх чадварын үзүүлэлт



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

IPO, FPO түүхэн замнал: “Монголын хөрөнгийн бирж” ХК 1991 онд байгуулагдаж 1992 онд МХБ-ээр дамжуулан 475 улсын өмчит компанийг хувьчилсан түүхтэй. Үүнээс хойш 2005 онд “Монгол шилтгээн” ХК МХБ-ээр дамжуулан анхдагч зах зээлээс хөрөнгө татан төвлөрүүлсэн нь Монголын анхны IPO гаргасан тохиолдол болсон юм. 2005 оноос хойш 2018 он хүртэл нийт 23 компани IPO хийж нийт 114.0 тэрбум төгрөгийн хөрөнгийг анхдагч зах зээлээс татан төвлөрүүлээд байна. Сүүлийн үед анхдагч зах зээлийн арилжааны захиалга өндөр дүнгээр давж биелэх болсон нь иргэдийн хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэг, мэдээлэл нэмэгдэж, энэхүү салбарт хөрөнгө оруулах сонирхол нэмэгдсэнтэй холбон тайлбарлаж болох юм. Хөрөнгө оруулагчдын арилжаанд оролцох идэвх, сонирхол нэмэгдэх нь цаашид зах зээл тогтвортойгоор өсөн дэвжихийн үндэслэл юм.


Зураг 4.17. IPO түүхэн замнал



Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

Дэлхийн эдийн засгийн форумаас гаргадаг “Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан-2018”-д Монгол улсын нийт нээлттэй компаниудын ЗЗҮ-г ДНБ-д харьцуулан тооцсон үзүүлэлтээр нийт 140 улсын 99 дүгээрт жагсаж байна.

Зураг 4.18. Улс орнуудын ЗЗҮ-г харьцуулсан үзүүлэлт /тэрбум ам.доллар/



Эх сурвалж: Дэлхийн банк

Аливаа зах зээл хөгжлийн эхэн шатандаа асар олон бэрхшээлтэй тулгардаг. Гэвч тэдгээр бэрхшээлийг зөв тодорхойлж, цаашид хэрхэн зохицуулалт хийх аргачлалыг боловсруулж чадвал энэ нь эргээд давуу тал болох нь олон байдаг. Манай орны хувьд хөрөнгийн зах зээл бусад санхүүгийн зах зээлтэй харьцуулахад нийт зах зээлд эзлэх хувь бага, иргэд хөрөнгийн зах зээлийн үр ашгийн талаар мэдлэг, мэдээлэл бага учраас төдийлөн сонирхдоггүй байсан. Сүүлийн жилүүдэд хэрэглэгч болон компаниуд хөрөнгийн зах зээлийн тухай идэвхтэй сонирхож нэг талаас компаниуд хөрөнгө оруулалт татах, нөгөө талаас иргэд хөрөнгө оруулалт хийх үзэгдэл ажиглагдаж буй хэдий ч хангалттай түвшинд хүрч чадахгүй байна.

Хэдийгээр манай орны хөрөнгийн зах зээлийн үзүүлэлт бусад улс оронтой харьцуулахад бага байгаа хэдий ч сүүлийн жилүүдэд банкнаас бусад санхүүгийн салбар болох хөрөнгийн зах зээл, даатгалын салбарын үзүүлэлт хурдацтай нэмэгдэж, эдгээр зах зээлийг сонирхох иргэд, хөрөнгө оруулагчдын тоо жил ирэх тутам нэмэгдэж байна.

ЗОРИЛТ 4.3 Олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон, олон тулгуурт, хүртээмжтэй санхүүгийн системийг хөгжүүлнэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
ОЛОН ТУЛГУУРТ, ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ	ОЛОН УЛСАД ӨРСӨЛДӨХҮЙЦ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ	УХААЛАГ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ
<p>Эдийн засгийг тэтгэсэн, уян хатан, дижитал технологид суурилсан олон талт санхүүгийн үйлчилгээг хөгжүүлэх үе</p>	<p>Томоохон хөрөнгийн биржүүдтэй хамтран дотоодын санхүүгийн хэрэгслийг чөлөөтэй арилжаалах, мэргэжлийн тоглогчдын оролцоо, хөрөнгө оруулалт татах боломж бүрдүүлэх, дэлхийн хөрөнгийн зах зээлд оролцох түвшний дижитал санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх үе</p>	<p>Санхүүгийн бүх төрлийн үйлчилгээг технологийн дэвшил, хиймэл оюун ухаанд суурилан дэлхийн түвшинд хөгжүүлэх үе</p>
<ol style="list-style-type: none"> Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өсөж, биржийн бус болон үүсмэл санхүүгийн зах зээл дээр хийгдэж буй арилжааны дүнг нэмэгдүүлэх Даатгалын салбарын тогтвортой байдлыг хангах эрх зүйн орчин бүрдүүлж, салбарын хамрах хүрээг нэмэгдүүлэх Бичил санхүүгийн байгууллагуудыг чадавхжуулан, эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулж, үйл ажиллагааны хүрээг тэлэх Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог боловсронгуй болгох Банк санхүүгийн зах зээлийн эрсдэл даах, найдвартай байдлыг хангах 	<ol style="list-style-type: none"> Томоохон хөрөнгийн зах зээл дээр дотоодын бүтээгдэхүүнийг чөлөөтэй арилжаалдаг болох Даатгалын салбарын гүнзгийрэлтийн түвшинг олон улсын жишигт хүргэх Бичил санхүүгийн зах зээлийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэн санхүүгийн салбарт эзлэх хэмжээг нэмэгдүүлэх 	<ol style="list-style-type: none"> Олон улсад өрсөлдөхүйц хөрөнгийн зах зээлийг хөгжүүлж зах зээлийн үнэлгээг нэмэгдүүлэх Технологийн дэвшлийн тусламжтайгаар хэрэглэгч бүр өөрийн хэрэгцээнд тохирсон даатгалын бүтээгдэхүүнийг хэрэглэх боломжтой зах зээлийг бүрдүүлэх Технологийн дэвшилд суурилсан бичил санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, БИРЖИЙН БУС БОЛОН ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР ХИЙГДЭЖ БУЙ АРИЛЖААНЫ ДҮН НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 4.3.1. Олон улсын стандартад нийцсэн шаардлага, шалгуур үзүүлэлтийг тогтоох, дэд бүтцийг хөгжүүлж өргөжүүлэх, дундын зуучлагчдын чадавхыг дээшлүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 4.3.2. Хөрөнгө оруулагчдын кибер аюулгүй байдлыг хангах, технологид суурилсан хөрөнгийн зах зээлийг цогцлоох үүднээс холбогдох эрх зүйн болон дэд бүтцийн шинэчлэлтүүдийг хэрэгжүүлнэ.
- 4.3.3. Зах зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт болон нийлүүлэлтийг дэмжиж, хөрөнгө оруулагчдын төрөл, оролцоог нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний шинж чанараас хамаарсан ялгаатай зах зээлүүдийг хөгжүүлнэ.
- 4.3.4. Гарааны бизнесийг санхүүжүүлэх Venture capital сан зэрэг мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг бий болгон хөгжүүлнэ.

ДААТГАЛЫН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРДЭЖ, САЛБАРЫН ХАМРАХ ХҮРЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 4.3.5. Даатгалын тулгуур зарчмуудыг бүрэн хангаж, даатгалын бодлогод омбудсмен нэвтрүүлнэ.
- 4.3.6. Даатгалын зах зээлийн тогтвортой байдлыг хангах, системийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэлийн удирдлагын зохицуулалтын тогтолцоог сайжруулж Solvency II стандартыг бүрэн нэвтрүүлнэ.
- 4.3.7. Гадны хөрөнгө оруулалттай урт хугацааны даатгалын компаниудыг дэмжиж, өрсөлдөөнийг нэмэгдүүлнэ.
- 4.3.8. Урт хугацааны даатгалын үйл ажиллагааны эрх зүйн орчинг сайжруулан, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 4.3.9. Давхар даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно.
- 4.3.10. Технологид суурилсан даатгалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний эрх зүйн орчинг боловсронгуй болгон бодлогоор дэмжинэ.

БИЧИЛ САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫГ ЧАДАВХЖУУЛАН, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 4.3.11. Бичил санхүүгийн байгууллагыг чадавхжуулах, нэгдэн нийлэх үйл ажиллагааг дэмжинэ.
- 4.3.12. Гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулалтын орчинг сайжруулан, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- 4.3.13. Бичил санхүүгийн байгууллагын төлбөрийн нэгдсэн систем, түүний хяналтын системийг хөгжүүлнэ.
- 4.3.14. Бичил санхүүгийн байгууллагын эрсдэлийн удирдлагын системийг нэвтрүүлнэ.

4.3.15. Технологид суурилсан бичил санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх, түүнийг зохицуулж хянахад шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлж, санхүүгийн технологийн стандартуудыг зах зээлд нэвтрүүлнэ.

4.3.16. Бичил санхүүгийн зах зээлд байгаль орчинд ээлтэй ногоон зээл, санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх, санхүүгийн байгууллагуудад байгаль, орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлнэ.

МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР

4.3.17. МУТС тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагатай харилцах уялдааг сайжруулж, ФАТФ болон мөнгө угаахтай тэмцэх Ази номхон далайн бүсийн бүлгийн тогтоох харилцан үнэлгээний шаардлагыг бүрэн хангана.

БАНК, САНХҮҮГИЙН ТОГТОЛЦООНЫ ЭРСДЭЛГҮЙ, НАЙДВАРТАЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

- 4.3.18. Олон улсад мөрдөж байгаа банкны хяналт шалгалтын зарчим, зохицуулалтын арга хэрэгслийг нэвтрүүлнэ.
- 4.3.19. Системийн нөлөө бүхий банкуудыг хувьцаат компанийн хэлбэрт оруулж, хувьцааг хөрөнгийн бирж дээр арилжаалдаг болох эрхзүйн зохицуулалтыг бүрдүүлнэ.
- 4.3.20. Зээлийн хүүг бууруулж, бизнесийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

АЗИЙН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР ДОТООДЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ЧӨЛӨӨТЭЙ АРИЛЖААЛДАГ БОЛОХ ЧИГЛЭЛЭЭР

- 4.3.21. Их өгөгдөлд суурилсан алгоритмын болон өндөр давтамжтай арилжааны платформыг нэвтрүүлэн, хөрөнгийн зах зээл дэх технологийн дэвшлийг тогтмол хөгжүүлнэ.
- 4.3.22. Технологийн дэвшил, их өгөгдөлд суурилсан хяналт шалгалтын технологи (суптек), зохицуулалтын технологи (регтек)-ийг зохицуулалтын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлнэ.

4.3.23. Хиймэл оюун ухаанд суурилсан хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээг нэвтрүүлнэ.

ДААТГАЛЫН САЛБАРЫН ГҮНЗГИЙРЭЛТИЙН ТҮВШИНГ ОЛОН УЛСЫН ЖИШИГТ ХҮРГЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 4.3.24. Даатгалын гэрээний стандартыг тогтоож, бүртгэлийн процессыг хялбаршуулах, кибер даатгалыг хөгжүүлнэ.
- 4.3.25. Даатгалын зах зээлийн эрсдэлийг урьдчилан сануулах системийг бүрэн нэвтрүүлнэ.
- 4.3.26. Даатгуулагчдын кибер аюулгүй байдлыг хангах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрхзүйн орчинг бүрдүүлнэ.

4.3.27. Дүрмийн сан, нөөц сангийн хөрөнгийн зах зээл дэх хөрөнгө оруулалтыг идэвхжүүлнэ.

4.3.28. Тэтгэврийн сан, хувийн тэтгэврийн даатгалын хөрөнгөөр хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх орчинг бүрдүүлнэ.

БИЧИЛ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ОЛОН УЛСЫН ЖИШИГТ НИЙЦҮҮЛЭН САНХҮҮГИЙН САЛБАРТ ЭЗЛЭХ ХЭМЖЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

4.3.29. Хоршоодын гишүүн төвтэй зохицуулалтын орчинг бий болгох, мини банкны эрх зүйн орчинг нэвтрүүлнэ.

4.3.30. Дотоодын бичил санхүүгийн үйлчилгээг гадны зах зээлд нэвтрүүлж эхэлнэ.

ОЛОН УЛСАД ӨРСӨЛДӨХҮЙЦ ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЖ ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

4.3.31. Олон улсад өрсөлдөхүйц, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын тоглох талбар болон хөгжинэ.

4.3.32. Хөрөнгийн зах зээлийн харилцаанд ашиглагдах технологийн шийдлүүд нь дэлхийн хөгжингүй орнуудтай эн зэрэгцэнэ.

ТЕХНОЛОГИЙН ДЭВШЛИЙН ТУСЛАМЖТАЙГААР ХЭРЭГЛЭГЧ БҮР ӨӨРИЙН ХЭРЭГЦЭЭНД ТОХИРСОН ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХЭРЭГЛЭХ БОЛОМЖТОЙ ЗАХ ЗЭЭЛИЙГ БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

4.3.33. Даатгалын үйл ажиллагааг бүрэн тоон системд шилжүүлэх, хувийн мэдээллийн түүхэнд суурилан хураамж тогтооно.

4.3.34. Даатгалын компаниудын хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

4.3.35. Даатгалын зах зээлд ашиглагдах технологийн шийдлүүд нь дэлхийн хөгжингүй орнуудтай эн зэрэгцэнэ.

ТЕХНОЛОГИЙН ДЭВШИЛД СУУРИЛСАН БИЧИЛ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

4.3.36. Биометрик мэдээлэл, түүний нууцлал, ашиглалт, хамгаалалттай холбоотой эрхзүйн зохицуулалтийг нэвтрүүлэн боловсронгуй болгоно.

4.3.37. Биометрик мэдээллийн хяналт шалгалтын системийг бүрэн нэвтрүүлнэ.

4.3.38. Их өгөгдөлийн сангийн мэдээллийн нууцлал, кибер аюулгүй байдлыг хангана.

4.3.39. Бичил санхүүгийн зах зээлд ашиглагдах технологийн шийдлүүд нь дэлхийн хөгжингүй орнуудтай эн зэрэгцэнэ.

БҮС НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Дэлхийн зах зээл дэх үнийн түвшин тогтвортой байх нөхцөлд суурь хувилбараар хийсэн тооцооллоор манай орны экспорт 2018-2030 онуудад жилд дунджаар 4.2-6.3 хувь, импорт 4.0-6.8 хувиар өсөхөөр байна. Дурдсан хугацааны үргэлжлэлд экспорт 1.71, импорт 1.77 дахин өсөж, 2017 оны зэрэгцүүлэх үнээр экспорт 13.9 тэрбум ам.долларт, оны үнээр 17.1 тэрбум ам.долларт, импорт 1.77 дахин нэмэгдэж, 2017 оны зэрэгцүүлэх үнээр 11.4 тэрбум ам.долларт, оны үнээр 14.5 тэрбум ам.долларт хүрэх тооцоо гарав.

“Ногоон эдийн засаг” хувилбараар 2018-2030 онуудад экспорт жилд дунджаар 4.0-6.8 хувь, импорт жилд дунджаар 4.1-6.3 хувь, дурдсан хугацааны туршид экспорт 1.69 дахин, импорт 1.75 дахин өсөх тооцоо гарч байна. Ингэснээр 2030 он гэхэд манай улсын экспорт 2017 оны зэрэгцүүлэх үнээр 13.4 тэрбум ам.долларт, оны үнээр 16.9 тэрбум ам.долларт, импорт 2017 оны зэрэгцүүлэх үнээр 11.3 тэрбум ам.долларт, оны үнээр 14.3 тэрбум ам.долларт хүрэхээр байна.

Томоохон төслүүдийг оруулсан тооцоогоор, тэдгээр төслийн нөлөөгөөр экспорт жилд 2.2-31.6 хувь, импорт 3.5-32.9 хувиар өсөж, дурдсан хугацааны туршид экспорт 2.56 дахин, импорт 2.62 дахин өсөх тооцоо гарч байна. 2030 он гэхэд экспорт 2017 оны зэрэгцүүлэх үнээр 20.1 тэрбум ам.долларт, импорт 16.9 тэрбум ам.долларт, оны үнээр экспорт 25.6 тэрбум ам.долларт, импорт 21.5 тэрбум ам.долларт хүрэх тооцоо гарлаа.

Гадаад худалдааны бодлогын хүрээнд дотоодын үйлдвэрлэлийг хамгаалж хөгжүүлэх, экспортын бараа бүтээгдэхүүний өртгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн уялдуулсан тарифыг бий болгох, шинээр үйлдвэрлэхээр төлөвлөж буй аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг экспортлох таатай нөхцөлүүдийг урьдчилан бүрдүүлэх, үүний тулд тодорхой улс орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудалд онцгойлон анхаарах нь зүйтэй.

ЗОРИЛТ 4.4 Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэж, худалдааг хөнгөвчилнө.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
БҮС НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА	ГУРАВДАГЧ ХӨРШИД ХҮРСЭН ЭДИЙН ЗАСАГ	АЗИЙН МОНГОЛ
Хөрш орнуудыг дамжсан эдийн засгийн коридорыг хөгжүүлэх, БНХАУ, ОХУ-тай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулж, бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэх замаар эдийн засгийн гадаад харилцааг эрс нэмэгдүүлэх үе	Хөрш орнууд болон гуравдагч хөрш улсуудтай гадаад харилцааны тэнцвэртэй хөгжлийн түвшинг хангах үе	Ази-Номхон далайн бүс нутаг дахь эдийн засаг, худалдааны интеграцад идэвхтэй оролцож, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар, худалдааг нэмэгдүүлэх үе
1. Монгол Улс, БНХАУ, ОХУ гурван улсын эдийн засгийн коридор бий болж, гадаад харилцааны тэнцвэртэй байдлыг хангах Монгол Улс бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэж, худалдааг хөнгөвчлөх	1. Дэлхийн түвшинд нэр хүнд бүхий өрсөлдөх чадвартай Зүүн хойд Азийн хөрөнгө оруулалтын гол төв болгох	1. Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцогч болох

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

МОНГОЛ УЛС, БНХАУ, ОХУ ГУРВАН УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН КОРИДОР БИЙ БОЛЖ ГАДААД ХАРИЛЦААНЫ ТЭНЦВЭРТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

- 4.4.1. Монгол Улсын хөгжлийн өнөөгийн шаардлагыг харгалзан үзэж ДХБ-д элсэхэд авсан амлалтыг эргэн харах саналыг гишүүн орнуудад тавих замаар гадаад худалдааны зохицуулалтыг боловсронгуй болгоно.
- 4.4.2. Зах зээл болон байгалийн нөөц баялагт ойр, ажиллах хүчний хангалттай хэмжээний нөөцтэй, аж үйлдвэрийг хөгжүүлэх тааламжтай орчин бүрдсэн бүс нутгийг сонгон чөлөөт бүсийг хөгжүүлнэ.
- 4.4.3. Бараа, үйлчилгээг худалдах, тээвэрлэх, хянах, хөрөнгө оруулах, зах зээлд нэвтрэх нөхцөлүүдийг ил тод болгох, бүртгэл ба мэдээллийн нэгдсэн системийг бий болгох, цаасгүй технологи нэвтрүүлэх, эрсдэлд суурилсан удирдлага ба хяналтыг бий болгоно.


4.4.4. Эдийн засгийн коридорын хүрээнд “Талын зам” хөтөлбөрийг хэрэгжүүлж, Монгол Улсын газар нутаг дээгүүр дамжин өнгөрөх байгалийн хийн хоолойг барих асуудлыг гурван талт хэлэлцээрийн үр дүнд шийднэ.

4.4.5. Эдийн засгийн коридор бий болгох гурван талт хэлэлцээрийг боловсронгуй болгож, Монгол Улс тээвэр, логистик, хот байгуулалт, хил дамнасан худалдаа, аялал жуулчлалын дэд бүтцийн бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлнэ.

Зураг 4.19. Төмөр замын сүлжээний зураглал



Зураг 4.20. БНХАУ болон ОХУ хоорондох байгалийн хийн дамжуулах хоолойн зураглал



ГУРАВДАГЧ ХӨРШИД ХҮРСЭН ЭДИЙН ЗАСАГ БИЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР

4.4.6. Агаарын тээврийн либералчлах замаар агаарын тээврийн зангилаа төв болгон хөгжүүлнэ.

- 4.4.7. Хөшгийн хөндийн нисэх онгоцны буудлыг түшиглэн Эдийн засгийн чөлөөт бүс байгуулж, тус бүсэд бага овортой, өртөг өндөртэй бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлнэ.
- 4.4.8. Олон улсын агаарын карго тээврийн логикийн төв байгуулж, ачааны төвлөрөл бий болгоно.
- 4.4.9. Нисэх буудлыг түшиглэсэн олон худалдааны төв байгуулж, худалдааны аялал жуучлалыг хөгжүүлнэ.

Зураг 4.22. Монгол – Орос – Хятад улсын эдийн засгийн коридорын бүтэц зохион байгуулалтын зураглал



МОНГОЛ УЛС БҮС НУТГИЙН ЭДИЙН ЗАСАГ, ХУДАЛДААНЫ ИНТЕГРАЦАД НЭГДЭЖ, ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ ЧИГЛЭЛЭЭР

- 4.4.10. Улс орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулж, тарифын болон тарифын бус саад тотгорыг бууруулна.
- 4.4.11. Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэх, худалдааг хөнгөвчлөх замаар урт хугацаанд өрсөлдөх чадвар бүхий цөөхөн салбарт эдийн засгаа төрөлжүүлэн хөгжүүлэх, экспортын боломж, зах зээлээ тэлэх бодлого явуулна.
- 4.4.12. Цөөхөн улс орон, цөөн зах зээлээс хараат байдлаасаа ангижрахын тулд тээврийн өртөг зардлаа бууруулах, нэмэгдсэн өртөг бүтээх, үүний тулд аж үйлдвэржилтийн томоохон төслүүдэд хөрөнгө оруулах чадвартай, харилцан ашигтайгаар хамтран ажиллана.
- 4.4.13. Гадаад, дотоод зах зээлүүдтэй холбогдохын тулд тээвэр логикийн нэгдсэн сүлжээг хөгжүүлэх, дэд бүтцээ үр өгөөжтэй байлгахын тулд дамжин өнгөрөх тээврийн гэрээ хэлэлцээрүүдийг сайжруулж хэрэгжүүлнэ.
- 4.4.14. Дотоодын боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг гадны өрсөлдөөнөөс хамгаалах бодлого зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

ДЭЛХИЙН ТҮВШИНД НЭР ХҮНД БҮХИЙ ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ ЗҮҮН ХОЙД АЗИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГОЛ ТӨВ БОЛОХ ЧИГЛЭЛЭЭР


- 4.4.15. АНУ, Европын холбооны зүгээс Монгол Улсад үзүүлэх CGP + системийн хүрээнд худалдааны хөнгөлөлт эдлэх эрх зүйн зохицуулалтыг хийж малын гаралтай бэлэн экспортын бараа, бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлнэ.
- 4.4.16. Зүүн хойд Азийн орнуудын эдийн засаг, худалдааны интеграцад Монгол Улс идэвхтэй оролцож "Түмэн гол" төслийг хэрэгжүүлэхэд Монгол улс идэвх санаачилгатай оролцоно.
- 4.4.17. АНУ-тай байгуулсан стратегийн түншлэлийн хэлэлцээрийн хүрээнд худалдааны хамтын ажиллагааг өргөтгөх замаар хөрөнгө оруулалт, технологийн хэлбэр рүү шилжүүлнэ.

БҮС НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНД ИДЭВХТЭЙ ОРОЛЦОГЧ БОЛОХ ЧИГЛЭЛЭЭР


- 4.4.18. Ази-Номхон далайн бүс нутаг дахь эдийн засаг, худалдааны интеграцад идэвхтэй оролцож, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар, худалдааг нэмэгдүүлнэ.
- 4.4.19. АСЕАН-ийн хэлэлцээртэй нэгдэн орж худалдаа, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн интеграцад нэгдэх ажлыг эхлүүлнэ.
- 4.4.20. Зүүн хойд Азийн аж үйлдвэржсэн улсууд болох Япон, Бүгд Найрамдах Солонгос улстай худалдааны хамтын ажиллагааны хүрээг өргөтгөж технологийн хамтын ажиллагааны хэлбэр рүү шилжүүлнэ.

ИННОВАЦИЙН ЭДИЙН ЗАСАГ

Сүүлийн үед инновацийн ач холбогдолд илүүтэй анхаарсан эдийн засгийн өсөлтийн талаарх шинэ онол болон номлолууд гарч ирж байна. Тэдгээрийг ерөнхийд нь нэгтгэн Инновацийн эдийн засаг (institutional economics, new growth economics, evolutionary economics, neo-Schumpertarian economics) гэх болжээ. Энэхүү шинэ эдийн засаг нь мэдлэг, технологи, энтрепренершип, инновацийг эдийн засгийн өсөлтийн гол жолоодогч болгож томъёолсоноороо капиталын хуримтлалд тулгуурласан уламжлалт эдийн засгийн өсөлтийн загвараас ялгаатай билээ. Тиймээс өнөөгийн мэдлэгт суурилсан эдийн засгийн ирэн үед Инновацийн эдийн засгийн үзэл баримтлал бидний хөгжлийн хөтөч байх болно.



ИННОВАЦИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ НЬ ДАРААХ ҮНДСЭН ХҮЧИН ЗҮЙЛҮҮДИЙН ҮР ДҮНГЭЭС БИЙ БОЛДОГ. ҮҮНД:



	I ҮЕ ШАТ (2021-2030)	II ҮЕ ШАТ (2031-2040)	III ҮЕ ШАТ (2041-2050)
ГОЛ ЗОРИЛГО	Инновацийг зах зээлд нэвтрүүлэх арга зам болох энтрепренершипыг дэмжих тогтолцоог бүрдүүлэх	Үндэсний хэмжээнд уламжлалт бус буюу инновацийн эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх	Олон улсын түвшинд Монголын инновацийн эдийн засгийн бүтээгдэхүүнүүдийг гаргах
БОДЛОГЫН ГОЛ ФОКУС	Үндэсний хэмжээнд энтрепренерлэг сэтгэлгээ болон бизнесийн хэлбэрийг хөгжүүлэх тогтолцоог хөгжүүлэх	Импортыг орлох боломж бүхий уламжлалт бус инновацлаг бизнесүүдийг дэмжих	Экспортод чиглэсэн олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай инновацлаг бизнесийг дэмжих
ҮНДСЭН ОРОЛЦОГЧИД	ЗГ, Их сургууль, Санхүүжүүлэгч, Мэргэжлийн холбоод, АНН	ЗГ, энтрепренерүүд, инновацлаг корпорациуд	ЗГ, энтрепренерүүд, инновацлаг корпорациуд, гадны түншүүд
ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН	Энтрепренершипын экосистем	Үндэсний өрсөлдөх чадвартай, инновацлаг бизнесүүд	Экспорт чиглэсэн, гадны зах зээл дээр гарсан үндэсний инновацлаг бизнесүүд
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТҮВШИН	Үндэсний хэмжээнд	Үндэсний хэмжээнд	Олон улсын түвшинд

ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ БРЭНД БҮТЭЭГДЭХҮҮН

ЗОРИЛТ 4.5 Олон улсад өрсөлдөх чадвартай бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
КЛАСТЕР ХӨГЖИЛ, БҮТЭЭМЖТЭЙ ҮЙЛДВЭРЛЭЛ	БҮС НУТГИЙН НЭМҮҮ ӨРТГИЙН СҮЛЖЭЭНИЙ ИДЭВХТЭЙ ТОГЛОГЧ	ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ БРЭНД ҮЙЛДВЭРЛЭЛ
Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг инновацид тулгуурлан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх үе	Бүс нутгийн болон олон улсын чанар, стандартын тогтолцоог нэвтрүүлэх, цахим худалдааг хөгжүүлэх замаар бүс нутгийн нэмүү өртгийн сүлжээнд холбогдож ажиллах үе	Технологийн дэвшил, ур чадвартай хүний нөөц, цахим худалдаанд тулгуурлан дэлхийд өрсөлдөх чадвартай, инновацид суурилсан брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийлүүлэх үе
1. Судалгаа, шинжилгээ, шинэ санаа, оюуны бүтээл, брэндэд тулгуурласан гадаад зах зээлд чиглэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх 2. Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийн бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын тогтолцоог кластерийн зарчмаар хөгжих нөхцөлийг бүрдүүлэх	1. Бүс нутгийн эдийн засгийг дэмжих экспортын төрөлжил-тийг бий болгох	1. Инновацид суурилсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

СУДАЛГАА, ХӨГЖҮҮЛЭЛТ, ШИНЭ САНАА, ОЮУНЫ БҮТЭЭЛ, БРЭНДЭД ТУЛГУУРЛАСАН ГАДААД ЗАХ ЗЭЭЛД ЧИГЛЭСЭН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 4.5.1. Бизнес инкубатор төвүүдийг байгуулах, тэдгээрийн хүний нөөцийн ур чадварыг дээшлүүлэх, үйл ажиллагааг дэмжинэ.
- 4.5.2. Инноваци, технологи нэвтрүүлэх, мэдлэг хуваалцах чиглэлээр

төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд ажиллах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

- 4.5.3. Эдийн засагт дижитал салбаруудыг хөгжүүлэх бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 4.5.4. Үйлдвэрлэлийн автоматжуулалт, технологи болон мэдээлэл технологийн ололтыг өргөнөөр нэвтрүүлнэ.
- 4.5.5. Нано технологи, био технологи, ногоон технологи, оюуны бүтээлд тулгуурласан үйлдвэрлэлийг дэмжиж, хөрөнгө оруулалтын таатай орчноор хангана.

БИЧИЛ, ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭЛТ, БОРЛУУЛАЛТЫН ТОГТОЛЦООГ КЛАСТЕРЫН ЗАРЧМААР ХӨГЖИХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 4.5.6. Жижиг, дунд үйлдвэрлэгчдийн хөгжлийг дэмжих институцийн тогтолцоог бүрдүүлж, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
- 4.5.7. ЖДҮ эрхлэгчдэд дэлхийн өртгийн сүлжээнд тавигддаг шаардлагуудыг хангах удирдлагын болон ажиллах хүчний ур чадварыг дээшлүүлэх, технологийн дэвшил, инновацийг нэвтрүүлэх, бүтээгдэхүүний чанар, стандартыг сайжруулна.
- 4.5.8. Гадаад орнуудад суугаа дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан жижиг, дунд үйлдвэрлэлд шаардлагатай технологийн инновацийн талаарх мэдээлэл авах, олон улсын үзэсгэлэн, яармаг болон бизнес уулзалтууд зохион байгуулах замаар хөрөнгө оруулалтын түншлэлийг өргөжүүлнэ.
- 4.5.9. Жижиг, дунд үйлдвэрийн салбарт олгож буй төрийн болон олон улсын байгууллагын зээл, тусламжийн санхүүжилтийг үр ашигтай болгож, оролцогч талуудын уялдааг сайжруулна.
- 4.5.10. Санхүүжилтийн бусад эх үүсвэр, лизинг болон факторингийн талаарх ойлголт, хэрэглээг нэмэгдүүлэх, экспортын чиглэлийн үйлдвэр эрхлэгчдэд зориулсан батлан даалт, даатгалыг нэвтрүүлнэ.
- 4.5.11. Томоохон аж ахуйн нэгж, үйлдвэрийн нийгмийн хариуцлагын хүрээнд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих санал санаачилгыг урамшуулах, дэмжих замаар кластерын хөгжлийг хангана.

БҮС НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙГ ДЭМЖИХ ЭКСПОРТЫН ТӨРӨЛЖИЛТИЙГ БИЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР

- 4.5.12. Дижитал салбаруудын бодлого, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангана.
- 4.5.13. Бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих дэд бүтэц болон үйлдвэрлэлийн цогцолбор байгуулж, шинэ салбарыг хөгжүүлнэ.
- 4.5.14. Чөлөөт бүсийг хөгжүүлж, хил дамнанас худалдааны байнгын сүлжээг байгуулна.

ИННОВАЦИД СУУРИЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ЭКСПОРТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

4.5.15. Технологийн дэвшил, ур чадвартай хүний нөөцөд тулгуурлан дэлхийд өрсөлдөх чадвартай, инновацид суурилсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

4.5.16. Дэлхийд өрсөлдөх чадвартай жижиг, дунд үйлдвэрийг салбарыг хөгжүүлнэ.

ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САН

ЗОРИЛТ 4.6 Эдийн засгийн төрөлжилт, инновац, шинэ технологи, хүний хөгжил, ногоон хөгжлийн зорилтуудыг дэмжих чадавхтай олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн баялгийн санг бий болгоно.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
ҮР АШИГТАЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ЗОРИЛТЫГ ХАНГУУЛАГЧ САН БАЙНА	ОЛОН УЛСАД ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДСӨН ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САН БАЙНА
Баялгийн сан байгуулж, санхүүгийн үр ашигтай төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийх үе	Мега, нийгэм-эдийн засгийн хөгжлийг дэмжих төсөл хөтөлбөр болон гадаадын санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах замаар эдийн засгийг дэмжих, баялгийн сангийн хөрөнгийг арвижуулах үе	Эдийн засгийн төрөлжилт, инновац, шинэ технологи, ногоон хөгжлийн зорилтуудыг дэмжих чадавхтай олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн баялгийн санг төлөвшүүлэх үе
1. Хөрөнгийн удирдлагыг нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх, санхүүгийн үр ашигтай төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэн дэмжих, хөрөнгийн хуримтлалыг бий болгох тогтолцоог бүрдүүлж, хөгжүүлэх	1. Мега төслүүдэд хөрөнгө оруулалт хийх болсноор нийгмийн ач холбогдол бүхий төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж, улмаар иргэдийн амьжиргааг дээшлүүлэх чадавхыг бүрдүүлэх	1. Макро эдийн засгийн тогтворжилтыг хангах, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн баялгийн сантай болох

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

БАЯЛГИЙН САН БАЙГУУЛЖ, САНХҮҮГИЙН ҮР АШИГТАЙ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮДЭД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ ЧИГЛЭЛЭЭР

4.6.1. Эрх зүйн орчныг төгөлдөржүүлэх, үйл ажиллагааны зохион байгуулалтын шинэчлэлт хийнэ.

4.6.2. Баялгийн сангийн засаглалын зохистой зарчмуудыг тодорхойлох, холбогдох дүрэм, журмыг батлуулна.

4.6.3. Баялгийн сангийн тухай хуульд заасан орлогын эх үүсвэрээс санд хөрөнгө төвлөрүүлэх, хуульд заасан арга хэлбэрээр хөрөнгийг арвижуулна.

4.6.4. Сангийн тухайн жилийн нийт хөрөнгийн зарим хэсгийг олон улсын санхүүгийн зах зээл дээр зээлжих зэрэглэл нь АА болон түүнтэй адилтгах үнэлгээтэй, өгөөж нь тодорхой санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийж эхэлнэ.

МЕГА, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР БОЛОН ГАДААДЫН САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ЗАМААР ЭДИЙН ЗАСГИЙГ ДЭМЖИХ, БАЯЛГИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ АРВИЖУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

4.6.5. Сангийн хөрөнгөөс том хэмжээний төсөлд, эсхүл эдийн засгийн төрөлжилтийг хангах, иргэдийн аюулгүй байдал, тав тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн төсөлд хөрөнгө оруулалт хийж эхэлнэ.

4.6.6. Хөрөнгө оруулалт нэн шаардлагатай салбарууд болох зам тээвэр, эрчим хүч, усны менежмент, харилцаа холбоо зэрэг салбаруудыг дэмжиж, цаашлаад уул уурхай дагасан дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлэн дотогшоо чиглэсэн хөрөнгө оруулалт хийнэ. Томоохон хэмжээний хөрөнгө оруулалт шаардсан дэд бүтцийн төслүүдийн санхүүжилтийг сангийн эх үүсвэрээр шийдвэрлэнэ.

4.6.7. Иргэдийн аюулгүй байдал, тав тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн нийгмийн хөгжлийг дэмжих төслүүдэд хөрөнгө оруулалт хийнэ.

ЭДИЙН ЗАСГИЙН ТӨРӨЛЖИЛТ, ИННОВАЦ, ШИНЭ ТЕХНОЛОГИ, НОГООН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДЫГ ДЭМЖИХ ЧАДАВХТАЙ ОЛОН УЛСАД ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДСӨН БАЯЛГИЙН САНГ ТӨЛӨВШҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

4.6.8. Санхүүгийн бүх төрлийн үйлчилгээг технологийн дэвшил, хиймэл оюун ухаанд суурилан дэлхийн түвшинд хөгжүүлэх дижитал санхүүгийн үйлчилгээ хөгжүүлэх чиглэлээр хөрөнгө оруулалт хийнэ.

4.6.9. Торгоны зам, Цайны замын дагуу аялал жуулчлалын үйлчилгээ, худалдааг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрт хөрөнгө оруулалт хийнэ.

4.6.10. Мэдлэгийн эдийн засгийг дэмжих зорилго бүхий хөрөнгө оруулалтын шинэ хэлбэрүүдийг нэвтрүүлнэ.

4.6.11. Монгол Улсын иргэдэд давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг хүртээнэ.

ЭДИЙН ЗАСАГ ЗОРИЛГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

Тайлбар: * тэмдэглэгээ бүхий шалгуур үзүүлэлтийг шинээр тооцдог болно.

Хүснэгт 4.2. Эдийн засаг зорилгын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин

#	Шалгуур үзүүлэлт (indicator)	Хэмжих нэгж	Суурь түвшин	2030	2040	2050	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хаанаас авах эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах аргазүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
4	ЭДИЙН ЗАСАГ										
1	ДНБ, 2018 оны үнээр	тэрбум ам.доллар	13.1	32.1	54	77.7	2018 оны үнээр ДНБ-ийг бодох	Үндэсний Статистикийн Хороо, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	жилд 1 удаа	Засгийн газар
2	Уул уурхайн салбарын ДНБ-д эзлэх хувь	хувь	24.3	31.4	26.8	25.3	Эдийн засгийн салбаруудын хөгжлийн түвшинг ДНБ-д эзлэх хувиар хэмжинэ.	Үндэсний Статистикийн Хороо, Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	жилд 1 удаа	Засгийн газар
3	Боловсруулах аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувь	хувь	10.9	14.6	20.3	27.4	Эдийн засгийн салбаруудын хөгжлийн түвшинг ДНБ-д эзлэх хувиар хэмжинэ.	Үндэсний Статистикийн Хороо	Салбарын тайлан	жилд 1 удаа	Засгийн газар
4	Тээвэр агуулахын салбарын ДНБ-д эзлэх хувь	хувь	4.6	4.8	9.7	11.6	Эдийн засгийн салбаруудын хөгжлийн түвшинг ДНБ-д эзлэх хувиар хэмжинэ.	Үндэсний Статистикийн Хороо, Авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	Салбарын тайлан	жилд 1 удаа	Засгийн газар
5	Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ	ам.доллар	4009	8299	12000	15000	/2018 оны үнээр илэрхийлсэн/	Үндэсний Статистикийн Хороо	Салбарын тайлан	жилд 1 удаа	Засгийн газар
6	Жилийн дундаж эдийн засгийн өсөлт	хувь	7.2	6	6	6		Үндэсний Статистикийн Хороо	Салбарын тайлан	жилд 1 удаа	Засгийн газар
7	Инфляц	хувь	8.1	6	4	2	Мөнгөний оновчтой бодлогыг инфляцын түвшнээр хэмжинэ.	Үндэсний Статистикийн Хороо, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	жилд 1 удаа	Засгийн газар

#	Шалгуур үзүүлэлт (indicator)	Хэмжих нэгж	Суурь түвшин	2030	2040	2050	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хаанаас авах эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах аргазүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
8	Ядуурлын түвшин	хувь	28	15	10	5	Иргэдийн амьжиргааг ядуурлын түвшин, бодит худалдан авах чадварыг ажилгүйдэл болон инфляцын түвшнээр хэмжинэ. Тооцоололд суурилсан тул ТХҮБ 2030-ын энэ үзүүлэлт зөрүүтэй байгаа.	Үндэсний Статистикийн Хороо	Салбарын тайлан	жилд 1 удаа	Засгийн газар
9	Экспорт	сая ам.доллар	7011.8	20000	36000	52000	Дотоодын үйлдвэрлэл сайжирснаар бүтээгдэхүүн экспортолж эхэлнэ.	Үндэсний Статистикийн Хороо	Салбарын тайлан	жилд 1 удаа	Засгийн газар
10	Хүлээн авах гадаад жуулчдын тоо	сая хүн	0.6	2	4	6	Аялал жуулчлалын салбарын хөгжлийг Монгол Улсад ирж буй жуулчдын тоогоор хэмжинэ.	Үндэсний Статистикийн Хороо	Салбарын тайлан	жилд 1 удаа	Засгийн газар
11	Дамжин өнгөрөх ачаа, тээвэр	сая тонн	3.4	10	20	30		Үндэсний Статистикийн Хороо	Салбарын тайлан	жилд 1 удаа	Засгийн газар



САЙН ЗАСАГЛАЛ

УХААЛАГ ЗАСАГЛАЛ

УХААЛАГ БҮТЭЦ

ЦАХИМ МОНГОЛ (ИРГЭН, ТӨР,
ХУВИЙН ХЭВШЛИЙН НЭГДСЭН
СИСТЕМ)

ЧАДВАРЛАГ, ЁС ЗҮЙТЭЙ ТӨРИЙН АЛБА

ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН НИЙГЭМ

АВЛИГАГҮЙ ЗАСАГЛАЛ



САЙН ЗАСАГЛАЛ

Улс орны хөгжлийн үзэл баримтлал, арга замыг тодорхойлж, чиглүүлэн, зохицуулах гол институт нь төр бөгөөд төрийн бодлого, үйл ажиллагаа нь хөгжлийг сааруулах, гацаах бус харин дэмжих, таатай нөхцөл бүрдүүлэх, үр дүнтэй, үр нөлөөтэй зохион байгуулахад чиглэх учиртай. Засгийн газрын бодлого, үйл ажиллагаа тогтвортой, ил тод, хариуцлагатай, хяналттай байх нь бусад салбарын бодлого, үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлж, нийгмийн бүхий л хүрээнд тогтвортой байдлыг үүсгэж, улмаар хөгжилд хөтөлдөг.

Тухайн нийгмийн тогтолцоо, эдийн засгийн бодит нөхцөл байдалд тулгуурлан төрийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх, үнэлж дүгнэх, үр нөлөөг нь тооцох үр дүнтэй, зохистой арга хэлбэрийг Олон улсын байгууллагуудын хүрээнд **"Сайн засаглал"** гэж тодорхойлдог. Засаглал нь дан ганц засгийн газар, төрийн байгууллагуудын удирдлагаар хэрэгждэг уламжлалт хандлага шинэчлэгдэн, засаглалын үйл явцад иргэд, иргэний нийгэм, хувийн хэвшлийн оролцоог хангахыг чухалчлах болсон. Өөрөөр хэлбэл, төр, засгийн газар дангаараа хөгжлийг удирдан чиглүүлж, хэрэгжүүлэх бус төр, иргэн, иргэний нийгэм, хувийн хэвшлийн оролцоотой хамтын үйл ажиллагаа гэж ойлгох болсон. Үүнийг **Монгол Улсад хүний хөгжлийг хангах сайн засаглалын суурь арга зүй** болгон дэвшүүлж байна.

Үндэсний хөгжлийн тулгууруудын нэг яах аргагүй засаглалын асуудал бөгөөд нийгмийн бүхий л хүрээ, түвшинд тодорхой сорилт, асуудал дагуулж, шийдвэрлэх арга замыг шаардаж байна. Иймд Үндэсний хөгжлийн бодлогыг тодорхойлохдоо иргэдийн төр засгаа сонгох үйл явц дахь оролцоо; улс төрийн тогтвортой байдал; төрийн үйлчилгээний чанар, хүртээмж; төрийн албаны мэргэшсэн хийгээд улс төрөөс хараат бус байдал; төрийн эрх бүхий байгууллагуудын бодлого боловсруулж хэрэгжүүлэх, хяналт тавих, хариуцлага хүлээх чадавх; үндэсний болон орон нутгийн түвшинд хувийн хэвшлийг дэмжсэн бодлого, зохицуулалт хэрэгжүүлэх

чадавх; нийгмийн харилцаанд хууль дээдлэх, иргэн бүрд хууль тэгш үйлчлэх хуулийн засаглалыг тогтоох; авлига, ашиг сонирхлын зөрчлийг хязгаарлах **сайн засаглалыг** тогтоож, бүрэн хэвшүүлэх нөхцөлийг шалгуур болголоо.

Дээрх нөхцөлтэй уялдуулан **"Хүний хөгжлийг хангах сайн засаглал"**-ыг тогтоож, хэвшүүлэх зорилго дэвшүүлэн, хүрэх үр дүнг дараах байдлаар тодорхойллоо.

//

Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг - тогтвортой засаглал тогтоож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр - хувийн хэвшил - иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүхий л хүрээнд өргөжин, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно.

//

Хүний хөгжлийг хангах сайн засаглалыг тогтоох зорилготой уялдуулан дараах зорилтыг дэвшүүллээ. Үүнд:

- Эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцлийг оновчтой болгож, засаглалын тогтвортой байдлыг хангана.
- Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох замаар чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчилна.
- Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ.
- Иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлнэ.
- Иргэний нийгэм-Хувийн хэвшил-Төрийн түншлэлийг бэхжүүлэх замаар үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд хамаарал бүхий талуудын оролцоог хангасан зохистой тогтолцоо бүрдүүлнэ.
- Үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулна.

Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн хөгжлийн үе шатыг тодорхойллоо

УХААЛАГ ЗАСАГЛАЛ

ЗОРИЛТ 5.1 Эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцлийг оновчтой болгож, засаглалын тогтвортой байдлыг хангана.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
ТОГТВОРТОЙ, ХЯНАЛТТАЙ ЗАСАГЛАЛ	ҮР НӨЛӨӨТЭЙ ЗАСАГЛАЛ	ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН УХААЛАГ ЗАСАГЛАЛ
Эрх мэдлийн хувиарлалт, тэнцвэртэй байдал, түүнд тавих хяналтыг оновчтой болгох эрх зүйн орчныг бүрдүүлж, Тогтвортой, хяналттай Засаглалыг төлөвшүүлэх үе	Хариуцлагатай, үр нөлөөтэй засаглалыг бэхжүүлэх үе	Урт хугацааны, тогтвортой бодлогыг дэмжсэн түншлэгч Засаглалыг бий болгох үе
<ol style="list-style-type: none"> 1. УИХ-ын хууль тогтоох, бодлого тодорхойлох, төлөөлөх, хяналт тавих чадавхыг сайжруулж, парламентын засаглалыг бэхжүүлэх 2. Ерөнхий сайд танхимаа бие даан бүрдүүлж, хариуцлагаа бүрэн хүлээдэг болж, Засгийн газрын тогтвортой, үр дүнтэй ажиллах нөхцөл хангагдах тогтолцоог бий болгох 3. Шүүхийн хараат бус байдлыг хангаж, хариуцлагатай, иргэн төвтэй шүүх тогтолцоог төлөвшүүлэх 4. Улс төрийн намуудыг ашиг сонирхлын бүлэглэлийн бус, бодлогын нам болгох улс төр, нийгмийн соёл төлөвшүүлэх 5. Төрийн бодлого, үйл ажиллагааны тогтвортой байдалд эерэг нөлөөтэй сонгуулийн тогтолцоог бүрдүүлж, иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлж, иргэд-сонгогчдын хариуцлагыг сайжруулах 	<ol style="list-style-type: none"> 1. Хариуцлагатай, мэргэшсэн, ёс зүйтэй гишүүдээр УИХ-ыг бүрдүүлэх 2. Хөгжлийн урт хугацааны бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, Засгийн газрын чадавхыг бэхжүүлэх 3. Иргэдийн итгэлийг бүрэн хүлээсэн шүүх бий болгох 4. Улс төрийн намуудыг бодлогын нам болгон төлөвшүүлэх 5. Ардчилсан сонгуулийн зарчмуудыг бүрэн хангасан сонгуулийн соёл хэвшүүлэх 	<ol style="list-style-type: none"> 1. Ард түмний засаглах эрхийг хангасан, итгэл хүлээсэн УИХ төлөвшүүлэх 2. Иргэн төвтэй, мэргэжлийн Засгийн газар төлөвшүүлэх 3. Хариуцлагатай, иргэн төвтэй шүүх төлөвшүүлэх 4. Улс төрийн намуудын үйл ажиллагаа бүрэн төгөлдөржих нөхцөлийг бүрдүүлэх 5. Сонгуулийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

УИХ-ЫН ХУУЛЬ ТОГТООХ, БОДЛОГО ТОДОРХОЙЛОХ, ТӨЛӨӨЛӨХ, ХЯНАЛТ ТАВИХ ЧАДАВХ САЙЖИРЧ, ПАРЛАМЕНТЫН ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

- 5.1.1. Засаглалын хэлбэрийн гажуудлыг засаж, ардчилсан парламентын тогтолцоог бэхжүүлэх чиглэлд эрх зүй, бодлогын шинэчлэл хийнэ.
- 5.1.2. УИХ-ын гишүүдэд сонгосон иргэд нь хариуцлага тооцдог зохицуулалтыг бий болгож, УИХ-ын гишүүдийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих, шаардлагатай тохиолдолд эргүүлэн татах улс төрийн эерэг соёл, хандлагыг бүрэн төлөвшүүлнэ.
- 5.1.3. УИХ-ын гишүүнд тавих ёс зүй, сахилга хариуцлагын хууль баталж, намууд сонгуульд нэр дэвшигчдээ тодруулахдаа ёс зүй, сахилга хариуцлагын үндсэн шалгуураар гишүүд, дэмжигчдээр нээлттэй хэлэлцүүлдэг улс төрийн зөв соёлыг төлөвшүүлнэ.
- 5.1.4. Үндэсний хөгжлийн бодлого, хөтөлбөрийн уялдааг бүрэн хангах тогтолцоог бүрдүүлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл нь Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого болон Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцээгүй тохиолдолд УИХ батлахгүй байх зохицуулалтыг бий болгоно.
- 5.1.5. УИХ-аас гаргаж байгаа бодлого нь нотолгоонд суурилсан байх тогтолцоо бүрдүүлж, батлан гаргаж буй нийт бодлогын 70 хувиас доошгүйг судалгаанд суурилж боловсруулна.

ЕРӨНХИЙ САЙД ТАНХИМАА БИЕ ДААН БҮРДҮҮЛЖ, ХАРИУЦЛАГАА БҮРЭН ХҮЛЭЭДЭГ БОЛЖ, ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТВОРТОЙ, ҮР ДҮНТЭЙ АЖИЛЛАХ НӨХЦӨЛ ХАНГАГДАХ ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР

- 5.1.6. Засгийн газрын бүтцийг Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тулгуурлан тогтоох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 5.1.7. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсвийг Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогод нийцүүлэн боловсруулах тогтолцоонд шилжинэ.

ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ ХАНГАЖ, ХАРИУЦЛАГАТАЙ, ИРГЭН ТӨВТЭЙ ШҮҮХ ТОГТОЛЦООГ ТӨЛӨВШҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

- 5.1.8. Шүүх үйл ажиллагаанд цахим технологи нэвтрүүлж, үйл ажиллагааг шуурхай, чирэгдэлгүй болгоно.
- 5.1.9. Ёс зүй, цогц чадамжтай шүүхийн хүний нөөц бэлтгэх суурь тогтолцоо бий болгож, төгөлдөржүүлнэ.
- 5.1.10. Шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангах хөтөлбөр батлан хэрэгжүүлж, шүүхийн үйл ажиллагааг боловсронгуй болгон, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн шүүхэд итгэх итгэлийг дээшлүүлнэ.
- 5.1.11. Улсын Дээд Шүүхийн бүрэлдэхүүний гуравны нэгээс илүүг Ерөнхийлөгч өөрчлөх эрхгүй байх эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ



1.7

ЖИЛ

1992-2019 оны хооронд ажилласан Засгийн газруудын бүрэн эрхийн дундаж хугацаа



4

САЙД

2016-2019 оны хооронд буюу 3 жилийн хугацаанд ажилласан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын тоо



15

ЕРӨНХИЙ САЙД

1992-2019 оны хооронд ажилласан ерөнхий сайдууд, давхардсан тоогоор (Ц.Элбэгдорж, С.Баяр нар тус бүр 2 удаа)



2

ЗАСГИЙН ГАЗАР

Бүрэн эрхийн хугацаагаа дуустал бүтэн ажилласан Засгийн газрын тоо (1992-1996 оны П.Жасрайн, 2000-2004 оны Н.Энхбаяр)



3

САР

Хамгийн богино настай Засгийн газар 1998.04.23-нд байгуулагдаж 3 сар ажиллаад 1998.07.24-нд огцорчээ.

ЗАРИМ МЭДЭЭЛЭЛ БА СТАТИСТИК



9 (ЕС)

ЕРӨНХИЙ САЙД

Ерөнхий сайд танхимаа бүрдүүлснээр бодлогын залгамж чанар, тогтвортой байдал хангагдаж, Засгийн газар кабинетийн зарчимд шилжиж, үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөө дээшилнэ.

УЛС ТӨРИЙН НАМУУДЫГ АШИГ СОНИРХЛЫН БҮЛЭГЛЭЛИЙН БИШ БОДЛОГЫН НАМ БОЛГОХ УЛС ТӨР, НИЙГМИЙН СОЁЛ ТӨЛӨВШҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

- 5.1.12. Улс төрийн намуудыг улсын төсвөөс тодорхой шалгуурын дагуу санхүүжүүлж, зарцуулалтыг олон нийтэд нээлттэй, ил тод, хяналттай болгоно.
- 5.1.13. Улс төрийн намуудын дотоод ардчиллыг бүх түвшинд сайжруулж, ардчиллын үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэх, төрийн бодлогод иргэдийн оролцоог дэмжих бодлогын нам болгож төлөвшүүлнэ.
- 5.1.14. Улс төрийн намууд улс орны нийгэм, эдийн засгийн өмнө тулгарч буй голлох асуудал, түүнийг шийдвэрлэх урт хугацааны бодлого боловсруулж батлахад зөвшилцөлд хүрэх тогтолцоог бүрдүүлж хөгжлийн бодлогын тогтвортой байдлыг хангана.
- 5.1.15. Улс төрийн намыг хатуу гишүүнчлэлгүй болгоно.
- ТӨРИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОГТВОРТОЙ БАЙДАЛД ЭЭРЭГ НӨЛӨӨТЭЙ СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭДИЙН УЛС ТӨРИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЖ, ИРГЭД-СОНГОГЧДЫН ХАРИУЦЛАГЫГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР
- 5.1.16. УИХ-ын сонгуулийг холимог системээр явуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 5.1.17. УИХ-ын болон орон нутгийн сонгуулийг зэрэг явуулах нөхцөлийг бүрдүүлж, хэвшүүлнэ.
- 5.1.18. УИХ-ын болон Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийн хугацааг нэмэгдүүлнэ.
- 5.1.19. Сонгуулийн байгууллагын бие даасан, хараат бус байдлыг нэмэгдүүлж, сонгуулийн үед санал хураах үйл явцын аюулгүй байдлыг хангаж, зөрчил, маргаангүй сонгууль явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 5.1.20. Иргэд-сонгогчдын улс төрийн мэдлэгийг дээшлүүлэх шат дараалсан хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 5.1.21. Шаардлагатай тохиолдолд улс орны нийгэм, эдийн засгийн өмнө тулгарч буй бэрхшээлүүд, түүнийг шийдвэрлэх арга замын талаар асуулга боловсруулан сонгогчдоор эрэмбэлүүлэх, сонголт хийлгэх замаар иргэдийн оролцоог хангана.

УХААЛАГ БҮТЭЦ

ЗОРИЛТ 5.2 Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох замаар чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчилна.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020-2030)	II үе шат (2031-2040)	III үе шат (2041-2050)
<p>ТӨРИЙН ЧИГ ҮҮРЭГ, ЭРХ МЭДЛИЙН ОНОВЧТОЙ ХУВААРИЛАЛТ - ИРГЭНИЙ НИЙГЭМ-ХУВИЙН ХЭВШИЛ-ТӨРИЙН ИДЭВХТЭЙ ТҮНШЛЭЛ</p> <p>Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, эрх мэдлийн зааг, ялгааг оновчтой тодорхойлж, оролцоог зохистой хангасан, иргэдээ сонсдог, хувийн хэвшилтэйгээ хамтарч ажилладаг тогтолцоог төлөвшүүлэх үе</p>	<p>ЦОМХОН, ЧАДВАРЛАГ БҮТЭЦ - ИРГЭДЭЭ ДЭЭДЭЛСЭН, ХУВИЙН ХЭВШЛЭЭ ДЭМЖСЭН УХААЛАГ ЗАСАГ</p> <p>Иргэдийн эрх ашгийг дээдэлсэн, хувийн хэвшлийн хөгжлийг дэмжсэн цомхон бөгөөд үр ашигтай, үр нөлөөтэй бүтэц, зохион байгуулалтыг төрийн байгууллагуудын бүх түвшинд нэвтрүүлэх үе</p>	<p>ИРГЭН ТӨВТЭЙ УХААЛАГ ЗАСАГ - ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН УХААЛАГ БҮТЭЦ</p> <p>Төрийн бодлого, үйл ажиллагааг иргэн төвтэй болгож, ухаалаг засаглалыг дэмжсэн бүтэц, зохион байгуулалтыг бэхжүүлэх үе</p>
<ol style="list-style-type: none"> Хөгжлийн бодлого, чиг үүргийн шинжилгээнд тулгуурласан захиргааны оновчтой, уян хатан, үр дүнтэй, үр ашигтай бүтэц тогтоох Хөгжлийн бодлогод нийцсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн оновчтой хуваарилалтыг бий болгож, орон нутгийн бие даасан байдал хангах Урт хугацааны хөгжлийг нэгдсэн бодлого, удирдлагаар хангах чиг үүрэг бүхий хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгуулах 	<ol style="list-style-type: none"> Төрийн захиргааны байгууллагын бүтцийг цомхон, уян хатан, үр ашигтай болгож, төрийн байгууллагын үйл ажиллагааны хүнд суртлыг арилгах Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж бие даан хөгжих нөхцөлийг бүрдүүлэх Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгдсэн удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэх Төр нь бодлого, үйл ажиллагаагаа иргэн, хувийн хэвшилтэй хамтарч тодорхойлох тогтолцоог бэхжүүлэх 	<ol style="list-style-type: none"> Төрийн бодлого, үйл ажиллагааг иргэн төвтэй болгож, иргэн төвтэй захиргааны бүтцийг төлөвшүүлэх Төрийн үйлчилгээ иргэн бүрд шуурхай, чирэгдэлгүй хүрдэг тогтолцоог бүрдүүлж, хэвшүүлэх Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж бие даан хөгжих нөхцөлийг бүрдүүлэх Төр нь хувийн хэвшлийн хөгжлийг бүх талаар дэмжиж, дэлхийд өрсөлдөх үндэсний компаниудтай болох

- | | |
|--|--|
| <p>4. Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл явцад хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоог хангасан, хамтын ажиллагаа бэхжих нөхцөлийг бүрдүүлэх</p> | <p>5. Хөрөнгө оруулалтыг бүрэн дэмжсэн, бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэх</p> |
|--|--|

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ЧИГ ҮҮРГИЙН ШИНЖИЛГЭЭНД ТУЛГУУРЛАСАН ЗАХИРГААНЫ ОНОВЧТОЙ, УЯН ХАТАН, ҮР ДҮНТЭЙ, ҮР АШИГТАЙ БҮТЭЦ ТОГТОХ ЧИГЛЭЛЭЭР

- 5.2.1. Яам, агентлаг, төрийн захиргааны бусад байгууллага байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг үндэсний урт хугацааны бодлогын үзэл баримтлал, чиг үүргийн шинжилгээнд тулгуурлан Засгийн газрын саналыг үндэслэн УИХ шийдвэрлэдэг механизмыг бэхжүүлнэ.
- 5.2.2. Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн шинжилгээ хийж, чиг үүргийн оновчтой хуваарилах санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий нэгжийг ЗГХЭГ-ын бүтцэд бий болгоно.
- 5.2.3. Төрийн захиргааны төв байгууллагын харьяанд тухайн салбарын бодлогын болон техник технологийн судалгаа, шинжлэх ухааны үндэстэй тооцоолол, төлөвлөлтийг хийж, мэдээллээр хангахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий судалгааны алба (төв, хүрээлэн, институт гэх мэт) ажиллуулж, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангана.
- 5.2.4. Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд үзүүлэх төрийн үйлчилгээг тодорхойлж, шат дамжлагыг бууруулж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 5.2.5. Засаг захиргааны түвшин бүрд тухайн үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай захиргаа, санхүүгийн эрх мэдлийг олгоно.

ХӨГЖЛИЙН БОДЛОГОД НИЙЦСЭН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖИЙН ОНОВЧТОЙ ХУВААРИЛАЛТЫГ БИЙ БОЛГОЖ, ОРОН НУТГИЙН БИЕ ДААСАН БАЙДАЛ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

- 5.2.6. Бие даан хөгжих боломжийг бүрдүүлсэн орон нутгийн өмч, татварын боловсронгуй тогтолцоо бүхий эдийн засаг, санхүүгийн эрх мэдлийг орон нутагт шилжүүлнэ.
- 5.2.7. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж байгуулах, өөрчлөх, нэгтгэх, татан буулгах асуудлыг хөгжлийн урт хугацааны бодлогод нийцүүлэн Засгийн газрын саналыг үндэслэн УИХ шийдвэрлэдэг байх тогтолцоог бүрдүүлнэ.
- 5.2.8. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, зохион байгуулалтыг бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан төрийн үйлчилгээг үр дүнтэй хүргэх, эдийн засгийн хувьд бие даан хөгжих боломжийг хангахуйц засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарилалт хийнэ.

УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙГ НЭГДСЭН БОДЛОГО, УДИРДЛАГААР ХАНГАХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГА БАЙГУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

- 5.2.9. УИХ-д Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн байнгын хороо, Засгийн газрын бүтцэд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг байгуулж, аймаг, нийслэл, сум, дүүрэгт хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалт хариуцсан нэгжийг бий болгоно.
- 5.2.10. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж, эрх зүй, зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгож, бодлогын судалгаа хийх хүний нөөцийн чадавхыг бэхжүүлнэ.
- 5.2.11. Улсын нэгдсэн төсвийг урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тулгуурлан боловсруулж, батлах тогтолцоог бүрдүүлж бэхжүүлнэ.
- 5.2.12. Төв банкны мөнгөний бодлого нь Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн байх улс төр, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ҮЙЛ ЯВЦАД ХУВИЙН ХЭВШИЛ, ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОЛЦООГ ХАНГАСАН, ХАМТЫН АЖИЛЛАГАА БЭХЖИХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:
- 5.2.13. Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудыг оролцоог хангах, эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
- 5.2.14. Гэрээгээр гүйцэтгүүлж болох бүх төрийн чиг үүргийг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудад шилжүүлэх тогтолцоог нэвтрүүлнэ.
- 5.2.15. Иргэний нийгмийн байгууллагууд бие даан хөгжих эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 5.2.16. Иргэдийн эрх зүйн болон улс төрийн мэдлэг, соёлыг дээшлүүлж, хариуцлагатай иргэн болгож төлөвшүүлнэ.
- 5.2.17. Цахим ардчиллыг хөгжүүлж, төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэд саналаа өгөх, хяналт тавих зэргээр цахимаар оролцох боломжийг бүрдүүлнэ.

ХУВИЙН ХЭВШЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ, ХУВИЙН ӨМЧИЙГ ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙ, БОДЛОГЫН ОРЧИН БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

- 5.2.18. Хөрөнгө оруулалт, өмчийн эрхийг хамгаалах, тогтвортой байдлыг хангах бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгож, хувийн өмчийг бүрэн хамгаалсан эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 5.2.19. Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, өмч хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулна.
- 5.2.20. Банк, санхүүгийн тогтолцоог хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих бодлогод нийцүүлэн шинэчилж, хөрөнгө оруулалт, зээлийн таатай орчныг бүрдүүлнэ.
- 5.2.21. Төрийн бодлого, татварын хууль тогтоомжийн тогтвортой байдлыг хангаж, хөрөнгө оруулалтыг хамгаалах, татах таатай орчныг бүрдүүлнэ.
- 5.2.22. Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааг нэгтгэн хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжихэд чиглүүлэн, олон нийтэд нээлттэй, хяналттай тогтолцоонд шилжүүлнэ.

ЦАХИМ МОНГОЛ (ИРГЭН, ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ)

ЗОРИЛТ 5.3. Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
ҮР ДҮНТЭЙ ЦАХИМ ЗАСАГЛАЛ	ҮР НӨЛӨӨТЭЙ ЦАХИМ ЗАСАГЛАЛ	ИРГЭН ТӨВТЭЙ ЦАХИМ ЗАСАГЛАЛ
Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогын болон эрх зүйн орчныг бүрдүүлж, төлөвшүүлэх үе	Эдийн засаг, нийгмийн бүх салбарт мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшил, инновацийг нэвтрүүлэх замаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх үе	Хүний хөгжлийг дэмжсэн цахим засаглалыг хөгжүүлэх үе
<ol style="list-style-type: none"> 1. Цахим засаглалыг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, төгөлдөржүүлэх 2. Цахим мэдээллийн нэгдсэн сан, дэд бүтэц бий болгож хөгжүүлэх 3. Цаг хугацаа, орон зайнаас үл хамааран төрийн үйлчилгээг шат дамжлагагүй, шуурхай болгох 4. Төрийн байгууллагууд хоорондын болон төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын мэдээлэл солилцоо сайжирч, захиргааны зардлыг бууруулж, үйлчилгээний үр дүнг сайжруулах 5. Төрийн байгууллагын шийдвэр гаргах үйл явцад иргэд, олон нийтийн саналыг цахимаар авах нөхцөлийг бүрдүүлж, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх 	<ol style="list-style-type: none"> 1. Цахим засаглалыг хөгжүүлэх бодлого, эрх зүйн орчныг олон улсын жишигт хүргэх 2. Цахим мэдээллийн нэгдсэн санг эдийн засгийн харилцаанд бүрэн шилжүүлэх 3. Иргэдийн төрийн үйлчилгээнд зарцуулах хугацааг багасгах 4. Иргэн, төр, бизнесийн байгууллагууд мэдээлэл солилцооны үүлэн технологид бүрэн шилжүүлж, ил тод төрийн албаны тогтолцоог бэхжүүлэх 	<ol style="list-style-type: none"> 1. Хүний хөгжлийг дэмжсэн цахим засаглалын бодлого, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх 2. Цахим мэдээллийн нэгдсэн сангийн дэд бүтцийг олон улсын жишигт нийцүүлж хөгжүүлэх 3. Иргэн төвтэй, ухаалаг засаглалыг төлөвшүүлэх 4. Иргэн, төр, бизнесийн байгууллагуудын мэдээлэл солилцооны чанарыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх 5. Цахим засаглалын технологийг олон улсын жишигт хүргэн авлига, хүнд сурталгүй нийгмийн харилцааг төлөвшүүлэх

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ЦАХИМ ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БҮРДҮҮЛЖ, ТӨГӨЛДӨРЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

- 5.3.1. Мэдээллийн аюулгүй байдлын, Цахим гарын үсгийн, Мэдээллийн сангийн, Хувь хүний мэдээллийн аюулгүй байдлын зэрэг цахим засаглалыг хөгжүүлэхэд шаардагдах хууль тогтоомжийг боловсруулж батлуулан, түүнтэй нийцүүлэн холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулна.
- 5.3.2. Тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлж хэвшүүлнэ.
- 5.3.3. Цахим засаглалыг хөгжүүлэхэд шаардлагатай мэдээллийн технологийн салбарын стандарт, тушаал шийдвэр, дүрэм, журмыг боловсруулж, батална.

ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН, ДЭД БҮТЭЦ БИЙ БОЛГОЖ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

- 5.3.6. Их өгөгдөл (big data)-д суурилсан мэдээллийн нэгдсэн сан үүсгэж иргэн, төр, бизнесийн байгууллагууд цахимаар мэдээлэл солилцох, ашиглах техник технологийн дэд бүтцийг бий болгоно.
- 5.3.7. Интернетийн хурдыг нэмэгдүүлж, орон нутгийн түвшинд иргэд интернет ашиглах чадварыг сайжруулна.
- 5.3.8. Орон зайн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлж шийдвэр гаргах бүх түвшинд ашиглана.
- 5.3.9. Газарзүйн мэдээллийн системд тулгуурласан хаягжилтын нэгдсэн сан бүрдүүлж, иргэд, байгууллагын хэрэглээнд нэвтрүүлнэ.
- 5.3.10. Цахим бизнес, онлайн, зайн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

ЦАГ ХУГАЦАА, ОРОН ЗАЙНААС ҮЛ ХАМААРАН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ШАТ ДАМЖЛАГАГҮЙ, ШУУРХАЙ ХҮРГЭХ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

- 5.3.11. Төрийн байгууллагаас авдаг тодорхойлолт, зөвшөөрөл, лавлагаа, дүгнэлтийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, хөдөлгөөнт холбооны технологийг ашиглан төрийн үйлчилгээний нэгдсэн порталаас үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 5.3.12. Цахим төлбөр тооцооны системийг төрийн мэдээлэл солилцооны нэгдсэн системтэй холбоно.
- 5.3.13. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, иргэдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэхэд мэдээлэл, харилцаа холбооны дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн оролцоог дэмжиж хэрэгжүүлнэ.
- 5.3.14. Нэг иргэн-нэг бүртгэл хөтөлбөрийг эрчимжүүлж, төр иргэнээс нэг л удаа мэдээлэл авдаг тогтолцоонд шилжүүлнэ.






Зураг 5.2. Иргэн, төр, хувийн хэвшлийн нэгдсэн систем дэх цахим үйлчилгээ ба мэдээллийн сан



ЦАХИМ МОНГОЛ







ЦАХИМ ХУУЛЬ ТОГТООМЖ

-  Хууль тогтоомж, дүрэм журам
-  Мэдээллийн аюулгүй байдал
-  Цахим бүртгэл, мэдээлэл
-  Цахим шүүх
-  Цахим сонгууль





ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САН, ДЭД БҮТЭЦ

-  Их өгөгдөл (big data)
-  Тоон гарын үсэг
-  Орон зайн мэдээллийн дэд бүтэц
-  Газарзүйн мэдээллийн систем








ЦАХИМ ЭДИЙН ЗАСАГ, ХАРИЛЦАА

-  Цахим боловсрол
-  Цахим эрүүл мэнд
-  Цахим худалдаа, төлбөр тооцоо
-  Цахим хөдөлмөр эрхлэлт
-  Газар ашиглалтын бүртгэл мэдээлэл



ИРГЭН ТӨВТЭЙ ЦАХИМ ЗАСАГ

-  Хүний хөгжил
-  Цахим оролцоо
-  Цахим шийдвэр гаргалт
-  Цахим хэлэлцүүлэг, санал, гомдол
-  Цахим гүйцэтгэл, үнэлгээ

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД ХООРОНДЫН БОЛОН ТӨР, ИРГЭНИЙ НИЙГЭМ, БИЗНЕСИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦООГ САЙЖРУУЛАН, ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫГ БУУРУУЛЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 5.3.15. Төрийн байгууллагуудын мэдээлэл солилцох үүлэн тооцооллын дэд бүтцийг өргөтгөж хөгжүүлнэ.
- 5.3.16. Төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлт, албан бичиг солилцооны үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, сүлжээ бий болгоно.
- 5.3.17. Төрийн байгууллагад мэдээлэл, харилцаа холбооны технологийн зохистой хэрэглээг нэвтрүүлэх, байгууллага хооронд сайн туршлага хуваалцах, сурталчлах арга хэмжээг зохион байгуулна.
- 5.3.18. Төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэгийг тасралтгүй дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦАД ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН САНАЛЫГ ЦАХИМААР АВАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЖ ОРОЛЦООГ ХАНГАХ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

- 5.3.19. Иргэд төрийн байгууллагын албан тушаалтнуудтай цахим хэлбэрээр харилцах соёлыг хэвшүүлнэ.
- 5.3.20. Тушаал, шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг цахим хэлбэрээр хянах тогтолцоог бүрдүүлж, хэвшүүлнэ.
- 5.3.21. Мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан төрийн байгууллагын үйлчилгээнд цахим технологи нэвтрүүлэх, хүнд суртал, авлига хамгийн их үүсгэж буй үйлчилгээг цахимжуулна. (цахим гааль, цахим татвар, цахим иргэний бүртгэл, цахим шүүх, цахим газрын харилцаа, цахим эрүүл мэнд, цахим боловсрол гэх мэт)
- 5.3.22. Хууль тогтоомж боловсруулах үйл ажиллагаанд оролцох, төрийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар иргэд санал бодлоо цахим хэлбэрээр чөлөөтэй илэрхийлэх нөхцөлийг хангаж, цахим хэлэлцүүлгийн технологийг хөгжүүлнэ.
- 5.3.23. Мэдээллийн технологийн аудитын чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэн төрийн байгууллагын үйлчилгээ болон мэдээллийг цахим хэлбэрээр хүргэж байгаа байдалд үнэлгээ хийж, зөвлөмж өгөх үйл ажиллагааг хэвшүүлнэ.

ЧАДВАРЛАГ, ЁС ЗҮЙТЭЙ ТӨРИЙН АЛБА

ЗОРИЛТ 5.4 Иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлнэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
МЭРГЭШСЭН, ЧАДВАРЛАГ, ҮР НӨЛӨӨТЭЙ ТӨРИЙН АЛБА – ҮР ДҮНД СУУРИЛСАН, ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	ЦОМХОН, ЧАДВАРЛАГ ТӨРИЙН АЛБА – ОНОВЧТОЙ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	ИРГЭНЭЭ ДЭЭДЭЛСЭН ТӨРИЙН АЛБА – ИРГЭН ТӨВТЭЙ УХААЛАГ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх үе	Нийгмийн хөгжлийг дэмжсэн, үр нөлөөтэй, цомхон төрийн албыг төлөвшүүлж, төрийн үйлчилгээний менежментийг олон улсын түвшинд хүргэж, хөгжүүлэх үе	Иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлж, иргэдийн хэрэгцээнд суурилсан, иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжих үе
<ol style="list-style-type: none"> 1. Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн төрийн албыг төлөвшүүлж, бэхжүүлэх 2. Сонгуулийн үр дүнгээс үл хамааран төрийн албан хаагч тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлж, төрийн албаны шатлан дэвшүүлэх тогтолцоог боловсронгуй болгож бэхжүүлэх 3. Төрийн албанд ёс зүй, сахилга хариуцлагын оновчтой тогтолцоог бүрдүүлж, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх 4. Төрийн албан хаагч цаг хугацаа, орон зайнаас үл хамааран тасралтгүй сурч хөгжих таатай орчин бүрдүүлэх 5. Төрийн үйлчилгээний чанарын стандартыг бий болгож, төрийн үйлчилгээнд иргэд, олон нийт хяналт тавих нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн итгэлийг хүлээсэн үйлчилгээний соёлыг төлөвшүүлэх 	<ol style="list-style-type: none"> 1. Үр дүнд суурилсан цомхон төрийн албыг төлөвшүүлэх 2. Төрийн албанд шатлан дэвшүүлэх тогтолцоог бүрэн нэвтрүүлж, төрийн албан хаагчийн амьдралын баталгааг хангах 3. Төрийн албан хаагчид нийгэмд ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэх тогтолцоог бэхжүүлэх 4. Төрийн албанд суралцагч байгууллагын соёл бүрэн нэвтрүүлэх 5. Төрийн үйлчилгээг түргэн шуурхай, уян хатан, хүртээмжтэй, чанартай хүргэх хүний нөөцийн болон зохион байгуулалтын оновчтой арга хэрэгслийг нэвтрүүлж, иргэнд чиглэсэн төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах 6. Төрийн үйлчилгээний төлөвлөлт, хэрэгжүүлэлт, үр дүнгийн хяналтыг тунгалаг болгох 	<ol style="list-style-type: none"> 1. Иргэн төвтэй төрийн алба, төрийн үйлчилгээний бүтэц, зохион байгуулалт бий болгож шинэчлэх 2. Төрийн албаны нэр хүндийг өсгөж, иргэдийн хэрэгцээнд суурилсан, итгэл хүлээсэн төрийн үйлчилгээний соёлыг хэвшүүлэх 3. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулж, амьдралын баталгааг бүрэн хангах 4. Төрийн албан хаагчийн мэдлэг, чадварын түвшинг нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн дээшлүүлэх

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ЧАДАХУЙН ЗАРЧИМД СУУРИЛСАН МЭРГЭШСЭН ТӨРИЙН АЛБА ТӨЛӨВШҮҮЛЖ, БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

- 5.4.1. Төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлж, ажлын үр дүнгээс хамаарч шатлан дэвших зохицуулалтыг боловсронгуй болгоно.
- 5.4.2. Төрийн албан хаагчийн цалин хөлс, шагнал урамшуулал олгох, албан тушаал дэвшүүлэх, бууруулах, халах, чөлөөлөхөд тухайн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнгээс хамаарах тогтолцоонд бүрэн шилжүүлнэ.
- 5.4.3. Төрийн байгууллагын бүтэц, орон тоог оновчтой, үр ашигтай байх зарчимд нийцүүлэн шинэчлэн тогтоож, төрийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх, цахим технологийг нэвтрүүлэх замаар төрийн албан хаагчийн тоог бууруулна.
- 5.4.4. Төрийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг нэгдсэн зарчим, бодлого, арга зүйгээр шинэчлэн тодорхойлно.
- 5.4.5. Төрийн албанд хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллагаас чадварлаг хүний нөөцийг тодорхой хугацаанд шилжүүлэн ажиллуулах тогтолцоог бүрдүүлнэ.

СОНГУУЛИЙН ҮР ДҮНГЭЭС ҮЛ ХАМААРАН ТӨРИЙН АЛБАН ХААГЧ ТОГТВОРТОЙ АЖИЛЛАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЖ, ТӨРИЙН АЛБАНЫ ШАТЛАН ДЭВШҮҮЛЭХ ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОЖ, БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

- 5.4.6. Төрийн жинхэнэ албан хаагч сонгуулийн үр дүнгээс үл хамааран шатлан дэвших зарчмаар төрийн албанд ажиллах нөхцөл, баталгааг бүрэн хангасан улс төрийн, эрх зүйн, эдийн засгийн механизмыг бүрдүүлнэ.
- 5.4.7. Төрийн албаны хүний нөөцийг нэгдсэн бодлого, удирдлагаар хангах чиг үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллага байгуулж, хүний нөөцийн бодлогын нэгдмэл байдлыг хангана.
- 5.4.8. Төрийн албанд иргэнийг авах, албан тушаал дэвшүүлэх, чөлөөлөх, шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, түр томилох, сургаж хөгжүүлэх бодлого, зохицуулалтыг чадахуйн буюу мерит зарчимд нийцүүлнэ.

ТӨРИЙН АЛБАНД ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ОНОВЧТОЙ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ЁС ЗҮЙТЭЙ ТӨРИЙН АЛБЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

- 5.4.9. Төрийн албан хаагчийн нэр хүндийг дээшлүүлж, ажиллах нөхцөл, амьдралын баталгаагаар хангах зохистой тогтолцоо төлөвшүүлнэ.
- 5.4.10. Төрийн албан хаагчийн ёс зүй, хандлагыг ажлын гүйцэтгэлийн үнэлгээний салшгүй чухал хэсэг болгон үнэлэх тогтолцоог хэвшүүлж, сэтгэл гарган үйлчлэх соёл бий болгоно.
- 5.4.11. Ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэсэн төрийн байгууллагын

соёлыг хэвшүүлж, ёс зүйн алдаа гаргасан төрийн удирдах албан тушаалтан сайн дураараа ажлаасаа чөлөөлөгддөг байх хандлага, ёс зүйг төлөвшүүлнэ.

ТӨРИЙН АЛБАН ХААГЧ ЦАГ ХУГАЦАА, ОРОН ЗАЙНААС ҮЛ ХАМААРАН ТАСРАЛТГҮЙ СУРЧ ХӨГЖИХ ОРЧИН БҮРДЭХ ЧИГЛЭЛЭЭР:

- 5.4.12. Төрийн албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэлд, чиг үүргийн онцлогт тохирсон үе шаттай, тасралтгүй сургалтын тогтолцоог төлөвшүүлнэ.
- 5.4.13. Төрийн албаны сургалтын байгууллагын сургалт-судалгааны материаллаг орчин, хүний нөөц, технологи, арга зүйн чадавхыг бэхжүүлж, олон улсын жишигт нийцүүлэх шинэчлэл хийнэ.
- 5.4.14. Төрийн албаны сургалтад мэдээллийн технологид суурилсан олон хувилбарт аргуудыг нэвтрүүлнэ. Танхимын сургалтаас гадна онлайн, зайн сургалт, ажлын байранд сургах, онлайн сургалтыг төрийн албаны орчин үеийн шаардлагад нийцүүлэн оновчтой ашиглах тогтолцоо бүрдүүлнэ.

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН СТАНДАРТЫГ БИЙ БОЛГОЖ, ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ИРГЭД, ОЛОН НИЙТ ХЯНАЛТ ТАВИХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭДИЙН ИТГЭЛИЙГ ХҮЛЭЭСЭН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

- 5.4.15. Төрийн үйлчилгээг иргэдийн хэрэгцээнд суурилсан, түргэн шуурхай, уян хатан, хүртээмжтэй, чанартай хүргэх иргэн төвтэй төрийн үйлчилгээний стандарт боловсруулж, нэвтрүүлнэ.
- 5.4.16. Төр-үйлчилгээний чанарын хариуцлага хүлээдэг тогтолцоонд шилжинэ.
- 5.4.17. Төрийн үйлчилгээний зардал, үр ашгийн тооцоог гаргаж төрийн бодлого, шийдвэрт тусгаж хэрэгжүүлдэг, үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүн, санхүүжилт, үр нөлөөний байдалд хөндлөнгийн үнэлгээ хийж, иргэд, олон нийтэд мэдээлдэг тогтолцоонд шилжүүлнэ.


МЭРГЭШСЭН, ЧАДВАРЛАГ, ЦОМХОН ТӨРИЙН АЛБА

2021-2050 ОН



**АЖИЛЛАХ НӨХЦӨЛ,
БАТАЛГАА**

Төрийн жинхэнэ албан хаагч сонгуулийн үр дүнгээс үл хамааран тогтвортой ажиллах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.



**АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ,
ҮР ДҮН**

Хэт их бичиг цаас, тайланд тулгуурласан гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоо, аргачлалыг өөрчилж, төрийн албан хаагчийн бодит гүйцэтгэл, үр дүнг зөв тооцох арга зүйг нэвтрүүлнэ.



**ЦАХИМ
ТӨРИЙН АЛБА**

Цахим технологи ашиглан иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх тогтолцоог боловсронгуй болгож, шат дамжлагыг цөөлөн хүнд суртлыг арилгана.



**СУРГАЛТ,
ХӨГЖИЛ**

Төрийн албан хаагч цаг хугацаа, орон зайнаас үл хамааран тасралтгүй сурч хөгжих тогтолцоо бүрдүүлнэ.



**ЁС ЗҮЙ, САХИЛГА
ХАРИУЦЛАГА**

Ёс зүйн алдаа гаргасан төрийн удирдах албан тушаалтан сайн дураараа ажлаасаа чөлөөлөгддөг байх ухамсар, соёл, хандлагыг төлөвшүүлнэ.



**БҮТЭЦ,
ОРОН ТОО**

Төрийн албаны бүтэц, орон тоог оновчтой, үр ашигтай байх зарчимд нийцүүлэн шинэчлэн тогтооно.



**ЦАЛИН
ХӨЛС**

Төрийн албан хаагчийн цалин, хөлсийг үе шаттайгаар нэмэгдүүлж, дундаж давхаргад бүрэн багтах нийгмийн баталгааг хангана.



**УДИРДЛАГА, ЗОХИОН
БАЙГУУЛАЛТ**

Төрийн албыг хүний нөөцийн нэгдсэн бодлого, удирдлагаар хангах чиг үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллага байгуулна.

ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН НИЙГЭМ

ЗОРИЛТ 5.5. Иргэний нийгэм-Хувийн хэвшил-Төрийн түншлэлийг бэхжүүлэх замаар үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд хамаарал бүхий талуудын оролцоог хангасан зохистой тогтолцоо бүрдүүлнэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ХУУЛИЙН ЗАСАГЛАЛ – БҮХ ТАЛЫН ТҮНШЛЭЛ	ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАСАН ЗАСАГЛАЛ	ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН НИЙГМИЙН ХАРИЛЦАА
Хүний эрхийг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хүний эрхийг хангахад чиглэсэн олон талт түншлэлийг хөгжүүлэх үе	Хүний эрхийг хангах бодлого, эрх зүйн орчинг олон улсын жишигт хүргэх үе	Нийгмийн бүхий л харилцаанд хүний эрхийг бүрэн хангасан тогтолцоог төлөвшүүлэх үе
1. Хүний эрхийг хангасан бодлого, хууль тогтоомж боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үндэсний тогтолцоог бэхжүүлж, үр нөлөөг дээшлүүлэх 2. Төр, иргэний нийгэм, хувийн хэвшил хүний эрхийг хамгаалахад хамтарч ажиллах тогтолцоог төлөвшүүлэх	1. Хүний эрхийг хангах олон улсын сайн туршлагыг нэвтрүүлж, энэ чиглэлээр бусад улс оронтой хамтын ажиллагааг өргөжүүлэх 2. Хүний эрхийг хамгаалах чиглэлээр гадаад, дотоодын байгууллагын олон талт хамтын ажиллагааг бэхжүүлэх	1. Хүн бүрийн эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэх, хүний эрхийн түгээмэл соёл төлөвшүүлж хэвшүүлэх 2. Хүний эрхийн тухай олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлж, бусдын эрхийг хүндэтгэх хандлага төлөвшүүлэх

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАСАН БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖ БОЛОВСРУУЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЖ, ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

- 5.5.1. Хүний эрхийг хамгаалахад төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжих, хамтран ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлж, хөгжүүлнэ.
- 5.5.2. Бүх нийтэд хүний эрхийн болон эрх зүйн боловсрол олгох үндэсний тогтолцоог бэхжүүлж, хөгжүүлнэ.

5.5.3. Хүний эрхийн Үндэсний Комисс хараат бусаар үйл ажиллагаа явуулж, чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх нөхцөлийг хангаж, үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэнэ.

5.5.4. Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлж, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлнэ.

ТӨР, ИРГЭНИЙ НИЙГЭМ, ХУВИЙН ХЭВШИЛ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХАД ХАМТАРЧ АЖИЛЛАХ ТОГТОЛЦООГ ТӨЛӨВШҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

5.5.5. Хүний эрхийг хангахад төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжиж, хамтран ажиллана.

5.5.6. Төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэсэн хяналт шалгалт, сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ.

5.5.7. Засаглалын үйл ажиллагаанд иргэд эрх тэгш оролцон үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх боломж, чадавхыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлэх орчин бүрдүүлнэ.

5.5.8. Нийгмийн бүлгүүд засаглалын үйл явцад тэгш оролцох боломжийг хангасан тогтолцоог бүрдүүлнэ.

АВЛИГАГҮЙ ЗАСАГЛАЛ

ЗОРИЛТ 5.6 Үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулна.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
ШУДАРГА ЁСЫГ ЭРХЭМЛЭСЭН НИЙГЭМ	УХАМСАРТ НИЙГЭМ	АВЛИГАГҮЙ ЗАСАГЛАЛ
Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх эрх зүйн болон бодлогын орчин, шударга ёсыг эрхэмлэсэн бүх нийтийн хандлага төлөвшүүлэх үе	Авлигатай бүх нийтээр тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлэх үе	Авлигагүй нийгмийг цогцлоох үе
1. Нийгмийн бүх түвшинд шударга ёсыг бэхжүүлэх бодлогын болон эрх зүйн орчныг бүрдүүлэх 2. Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаа, зохион байгуулалтыг сайжруулж, авлига албан тушаалын гэмт хэргийг бууруулах	1. Нийгмийн бүх түвшинд авлигыг үл тэвчих хандлагыг төлөвшүүлэх 2. Авлигатай тэмцэх үр дүнтэй үндэсний тогтолцоог төлөвшүүлж, авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулах, таслан зогсоох	1. Нийгмийн бүх түвшинд шударга ёс тогтоох 2. Авлигагүй нийгэм цогцлоох

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

НИЙГМИЙН БҮХ ТҮВШИНД ШУДАРГА ЁСЫГ БЭХЖҮҮЛЭХ БОДЛОГЫН БОЛОН ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 5.6.1. Олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг монгол хүний ахуй, соёл, зан төлөвт нийцүүлэн бүх шатны боловсролын хөтөлбөрт тусган, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хэрэгжүүлж, шударга ёсны тогтолцоог төлөвшүүлнэ.
- 5.6.2. Төр, иргэний нийгэм болон бизнесийн байгууллагад авлига, ашиг сонирхлын зөрчлийг үл тэвчих сэтгэлгээ, шударга ёсны тогтолцоог эрхэмлэсэн соёлыг хэвшүүлнэ.
- 5.6.3. Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг хангах, хяналт тавих зохицуулалтыг боловсронгуй болгоно.

АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ САЙЖРУУЛЖ, АВЛИГА АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРГИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

- 5.6.4. Авлигатай тэмцэх болон шүүх, прокурорын байгууллагын авлига, албан тушаалын гэмт хэргийг шалган шийдвэрлэх чадавхыг бэхжүүлж, албан хаагчдыг мэргэшүүлж, үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэнэ.
- 5.6.5. Авлига, албан тушаалын гэмт хэргийн мэдээлэл хүлээн авах, нууцыг хадгалах тогтолцоог бэхжүүлж, энэ төрлийн гэмт хэргийг илчилсэн, мэдээлсэн хүнийг хамгаалах эрх зүйн үндсийг бүрдүүлж, авлигаас урьдчилан сэргийлэх төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа, олон нийтийн хяналтыг сайжруулна.
- 5.6.6. Авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдсон төрийн албан хаагчид оногдуулах хариуцлагыг чангатгаж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, авлигын хэргийг хянан шалгах, шийдвэрлэхтэй холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.
- 5.6.7. Төрийн байгууллагын үйл ажиллагаанд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ, стандартыг тогтоон мөрдүүлнэ.
- 5.6.8. Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж авлига үүсэх эрсдэлийг бууруулна.

САЙН ЗАСАГЛАЛ ЗОРИЛГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

Хүснэгт 5.1. Сайн засаглал зорилгын хэрэгжилтийн хяналт, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин

Тайлбар: * тэмдэглэгээ бүхий шалгуур үзүүлэлтийг шинээр тооцдог болно.

#	Шалгуур үзүүлэлт (indicator)	Хэмжих нэгж	Суурь түвшин	2030	2040	2050	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хаанаас авах эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах аргазүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
5	САЙН ЗАСАГЛАЛ										
1	Дэлхийн банкны засаглалын индекс: Засгийн газрын үр нөлөө.	хувь	45.7	71.9	80	85	Төрийн үйлчилгээ, төрийн албаны чанар, түүний улс төрийн нөлөөллөөс ангид байгаа эсэх, бодлого боловсруулалт, хэрэгжилтийн чанар, засгийн газрын бодлогод тавих хяналт, хариуцлага.	World Bank. Worldwide Governance Indicators	Экспертийн ярилцлага, тоон судалгаа	Жилд 1 удаа	Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага
2	Дэлхийн банкны засаглалын индекс: Зохицуулалтын чанар	хувь	54.8	78.2	80	85	Засгийн газрын зөв бодлого боловсруулж, хэрэгжүүлэх чадвар болон хувийн салбарын хөгжлийг дэмжиж, эрхзүйн таатай орчин.	World Bank. Worldwide Governance Indicators	Экспертийн ярилцлага, тоон судалгаа	Жилд 1 удаа	Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага
3	Дэлхийн банкны засаглалын индекс: Хуулийн засаглал.	хувь	44.7	46.7	47.7	51.8	Нийгмийн дүрэм журмыг сахих итгэл үнэмшлийн хэр хэмжээ, гэрээний хэрэгжилт, өмчлөх эрх, цагдаа болон шүүхийн чанар, гэмт хэрэг, хүчирхийлэл гарах магадлал.	World Bank. Worldwide Governance Indicators	Экспертийн ярилцлага, тоон судалгаа	Жилд 1 удаа	Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Хууль зүйн үндэсний хүрээлэн
4	Дэлхийн банкны засаглалын индекс: Иргэдийн дуу хоолой ба хариуцлага.	хувь	57.1	70.2	75.5	76.7	Тухайн улс орны иргэд төр засгаа сонгох үйл явцад оролцож чадаж байгаа эсэх, түүнчлэн үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, чөлөөт хэвлэл мэдээлэл байгаа эсэх	World Bank. Worldwide Governance Indicators	Экспертийн ярилцлага, тоон судалгаа	Жилд 1 удаа	Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага

#	Шалгуур үзүүлэлт (indicator)	Хэмжих нэгж	Суурь түвшин	2030	2040	2050	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хаанаас авах эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах аргазүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
5	Цахим засгийн хөгжлийн индекс	нэгж	0.5824	0.8	0.85	0.9	Цахим засгийн хөгжлийн индексийг тооцохдоо тухайн улс орны а) онлайн үйлчилгээ, б) харилцаа холбооны дэд бүтэц, в) хүний капиталын хүчин зүйлгэсэн дэд үзүүлэлтийг сонгож тооцоолол хийдэг	Нэгдсэн Үндэсний Байгууллага	Экспертийн ярилцлага, тоон судалгаа	Жилд 1 удаа	Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Харилцаа, холбоо, мэдээллийн технологийн газар
6	Дэлхийн банкны засаглалын индекс: Авилгын хяналт.	хувь	39.9	45.3	52.2	60	Хувийн зорилгоор төрийн эрх мэдлийг ашиглаж буй байдал, жижиг болон том хэмжээний авилгын хэлбэрүүд, элитүүд болон хувийн ашиг сонирхол төрийг "эзэлсэн" эсэх	World Bank. Worldwide Governance Indicators	Экспертийн ярилцлага, тоон судалгаа	Жилд 1 удаа	Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газар



НОГООН ХӨГЖИЛ

ЭХ БАЙГАЛЬ БА АНХДАГЧ ЭКОСИСТЕМ

БАЙГАЛИЙН БАЯЛГИЙН ҮР ӨГӨӨЖ

ҮНЭТ БАЯЛАГ УС

ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ
БАГАТАЙ, БҮТЭЭМЖТЭЙ,
ХҮРТЭЭМЖТЭЙ НОГООН ХӨГЖИЛ



НОГООН ХӨГЖИЛ

Монгол орон байгалийн унаган төрхөө харьцангуй хэвээр хадгалж үлдсэн дэлхийн цөөн орны нэг боловч хотжилт, үйлдвэржилт зэрэг хүний хүчин зүйлийн нөлөө болон байгаль, цаг агаарын хувьсал өөрчлөлтөөс шалтгаалан байгаль орчин доройтон бохирдох, байгалийн нөөц баялаг хомстох улмаар зарим газар нутагт экосистемийн тэнцвэр алдагдахад хүрээд байна.

Монгол Улс дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн өөрийн орны онцлогийг харгалзан хөгжлийн замаа тодорхойлохдоо байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж байгаль орчны тогтвортой байдлыг ханган, үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлэн, хүний амьдралын чанарыг сайжруулах зорилгыг үндэс болгоно.

Монгол орны газар нутгийн байгалийн болон экоэкосистемийн үйлчилгээний үнэ цэн, нөөц, ачаалал даах чадамж, амьдрал тэтгэх хязгаарын босгыг тогтоож хамгаалах, нөхөн сэргээх, судалгаанд суурилан хөгжлийг төлөвлөж, байгалийн баялгийг төрийн зохицуулалттайгаар эдийн засгийн эргэлтэд оруулах, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай, хаягдал багатай дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэн зохистой ашиглах, байгальд ээлтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн хөгжлийн үе шатуудыг тодорхойллоо.

ЭХ БАЙГАЛЬ БА АНХДАГЧ ЭКОСИСТЕМ

ЗОРИЛТ 6.1. Байгалийн үнэ цэн, өгөөжийг үнэлэн хамгаалж, анхдагч экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020-2030)	II үе шат (2031-2040)	III үе шат (2041-2050)
ЭХ БАЙГАЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛЭМЖ	АХИСАН ЧАДАМЖ БҮХИЙ ЭКОСИСТЕМ	ТЭНЦВЭРЖСЭН БАЙГАЛЬ ОРЧИН
Монгол орны унаган байгаль, экосистемийн үйлчилгээний үнэ цэн, даацыг тогтоож, үнэлэмжийг нэмэгдүүлж эдийн засгийн үр өгөөжийг үнэлэх үе	Экосистемийн үйлчилгээг тэтгэж үр өгөөж, хүртээмжийг нэмэгдүүлэх үе	Үнэлэмж, нөөц, нөхөн сэргэх чадавх, даацад суурилсан байгалийн нөөцийн ашиглалт, хамгааллын бодлого баримталж экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах үе
1. Байгалийн баялгийн нөөц, экосистемийн үйлчилгээний үнэ цэн, даацыг тогтоож, үнэлэх Цэнгэг усны нөөц, гол, мөрний урсац бүрэлдэх эх зэрэг онцлог экосистемийг тусгай хамгаалалтад авч, унаган байгалийг хамгаалах	1. Монгол орны унаган байгаль, экосистемийн үйлчилгээний үнэ цэн, нөөц, даацыг шинэчлэн тогтоож, үр өгөөжийг нэмэгдүүлэх Онцлог, үнэ цэн бүхий экосистемүүдийг тусгай хамгаалалтад авч, анхдагч байгалийн унаган төрх, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгалах	1. Хүрээлэн байгаа орчин, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэн эх дэлхийн экосистемийн үйлчилгээг тэтгэхэд үнэтэй хувь нэмэр оруулах


ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

БАЙГАЛИЙН БАЯЛГИЙН НӨӨЦ, ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ ЦЭН, ДААЦЫГ ТОГТООЖ, ҮНЭЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

6.1.1. Экосистемийн үйлчилгээг үнэлэх зохицуулалтыг боловсронгуй болгож үнэлэх, экологи-эдийн засгийн үнэлгээг шинэчлэх, экосистемийн үйлчилгээ, түүний үнэ цэн, ач холбогдлыг олон нийтэд тайлбарлан таниулна.

- 6.1.2. Ургамал, амьтны тархац, нөөцийн судалгааг улсын хэмжээнд үе шаттай хийж нөөцийн өөрчлөлтийг шинэчлэн тогтоож, зохистой менежментийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 6.1.3. Ой зохион байгуулалтыг тогтмол явуулж, ойн экосистемийн нөөц, төлөв байдлыг үнэлнэ.

Зураг 6.1. Ойн сан бүхий газар




ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ, ГОЛ, МӨРНИЙ УРСАЦ БҮРЭЛДЭХ ЭХ ЗЭРЭГ ОНЦЛОГ ЭКОСИСТЕМИЙГ ТУСГАЙ ХАМГААЛАЛТАД АВЧ, АНХДАГЧ БАЙГАЛИЙН УНАГАН ТӨРХ, ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАДГАЛАХ ЧИГЛЭЛЭЭР

- 6.1.4. Цэнгэг усны нөөц, урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газар, биологийн олон янз байдлын хувьд чухал газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах судалгаа хийж, өргөжүүлэх замаар онцлог экосистемийн үйлчилгээ, үнэ цэнийг нэмэгдүүлнэ.
- 6.1.5. Тусгай хамгаалалттай газар нутгийн дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлж, хамгааллын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.
- 6.1.6. Олон талт байгаль хамгааллын менежмент, техник технологийн хөгжлийг нэвтрүүлж, тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашигтай байдлыг сайжруулна.
- 6.1.7. Гадаад орны тусгай хамгаалалттай нутгийн захиргаатай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, менежментийн дэвшилтэт арга туршлагыг нэвтрүүлнэ.

- 6.1.8. Тусгай хамгаалалттай газар нутгийн нөөц, даацад тулгуурласан эко аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

Зураг 6.2. Аялал жуулчлал, тусгай хамгаалттай газар




Хүснэгт 6.1. Тусгай хамгаалалтад авах газар нутгийн хэмжээ

#	Үзүүлэлт	Суурь түвшин	2030	2040	2050
1	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ	20.1%	30	33	35
2	Улсын тусгай хамгаалалтад авсан гол мөрний урсац бүрэлдэх эхийн талбайн эзлэх хувь	48.3	60	70	75
3	Улсын тусгай хамгаалалтад авсан ойн сан бүхий газрын талбайн эзлэх хувь	39.1	50	55	60

ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ТУСГАЙ ХАМГААЛАЛТ

ХҮН ТӨРӨЛХТӨН ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮР ШИМ, ӨГӨӨЖИЙГ ХҮРТЭЖ АМЬДАРДАГ. ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭ НЬ ХАНГАХ, ЗОХИЦУУЛАХ, СОЁЛ ГЭГЭЭРЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ БОЛОН ДЭМЖИХ ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС БҮРДДЭГ.



Дархан цаазат газар: **13.7 сая га**



Байгалийн цогцолборт газар: **12.7 сая га**


Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 20.1 хувь буюу 31.4 сая га талбайг улсын тусгай хамгаалалтад хамруулж, нэгдсэн сүлжээг бүрдүүлээд байна. Гол мөрний урсац бүрэлдэх эхийн 44.7%, ойн сав бүхий газрын 36.8%-ийг хамгаалалтад авсан

Байгалийн нөөц газар: **4.8 сая га**

Дурсгалт газар: **0.10 сая га**



Дэлхийн экосистемийн үйлчилгээний үнэ цэнэ жилд **145 их наяд ам доллар** (Олон улсын ELD байгууллагын "Газрын үнэ цэнэ" тайлан) байдаг гэж үзвэл МУ-ын ТХГН-ийн экосистемийн үйлчилгээний өгөөж жилд **85 тэрбум ам доллар** буюу **220 их наяд төгрөг** болно. 2050 он хүртэл нэмж **15 сая га талбайг** тусгай хамгаалалтад авснаар жилд **8.7 тэрбум ам доллартай** дүйх үр өгөөж алдагдахаас урьдчилан сэргийлнэ.



Улсын тусгай хамгаалалттай **1.85 сая га талбай** бүхий шинэсэн ой жилд **12.23 сая тн нүүрсхүчлийн хий** шингээж байна. CO2 шингээлтийн үнэ цэнэ жилд **47.6 тэрбум төгрөг** болно.



Улсын тусгай хамгаалалттай **6.4 сая га талбай** бүхий гол мөрний урсац бүрэлдэх эхээс жилд **10'600 сая м3 ус** бүрэлдэж байгаа бөгөөд үүний өгөөж жилд **22.9 их наяд төгрөг** болно.



ТХГН-аас аялал жуулчлалын салбар нь жилд **30.0 тэрбум төгрөгийн орлого** олдог бөгөөд цаашид аялал жуулчлалын салбарын байгальд ээлтэй хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлснээр жилд **66.8 тэрбум төгрөг** болгон өсгөх боломжтой.

БАЙГАЛИЙН БАЯЛГИЙН ҮР ӨГӨӨЖ

ЗОРИЛТ 6.2. Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж, хомсдолыг бууруулан, ашиглалтын нөөц бий болгож, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлнэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭ	ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИД СУУРИЛАСАН ШИЙДЭЛ	НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ АШИГЛАЛТ
Байгалийн орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, доройтсон орчныг нөхөн сэргээж, нөөцийн хомсдолыг бууруулах, ашиглалтын нөөц бий болгох үе	Техник, технологийн ололт, инновацийг байгаль хамгаалалд ашиглаж, нөөцийн хомсдол, орчны доройтлоос сэргийлэх үе	Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж, зохистой ашиглах, шавхагддаг нөөцийг зөвхөн улсын хөгжлийн түвшинг шат ахиулахад хязгаартай ашиглах үе
<ol style="list-style-type: none"> Биологийн олон янз байдлыг хамгаалах, тархац нутаг, амьдрах орчныг нь тэтгэж хомсдолоос сэргийлэх, ашигт зүйлийг үржүүлэх, тарималжуулах, ойн агропарк байгуулах замаар ашиглалтын нөөц бүрдүүлэх Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэн, эвдрэлд орсон, доройтсон газрыг нөхөн сэргээж, аж ахуйн эргэлтэд оруулах Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулж, стандарт, хэм хэмжээг мөрдүүлэн, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог хангах Байгаль орчны хяналт-шинжилгээний сүлжээ, кадастр, мэдээллийн санг өргөжүүлж, шинэ үеийн техник, технологийн шинэчлэл хийх 	<ol style="list-style-type: none"> Технологийн хөгжлийг биологийн олон янз байдлыг хамгаалах, нөхөн сэргээх, тарималжуулах, тархац нутаг, амьдрах орчныг нь тэтгэхэд ашиглан нөөцийн хомсдолоос сэргийлэх Эвдрэлд орсон, бохирдсон газрыг нөхөн сэргээх, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлж хөрсний үржил шимийг нэмэгдүүлэхэд шинэ дэвшилтэт арга замыг тодорхойлж хэрэгжүүлэх Байгаль орчны хяналт-шинжилгээний сүлжээ, мэдээллийн нэгдсэн цахим санг өргөжүүлж, технологийн хөгжлийг нэвтрүүлэн, мэдээллийн ухаалаг цогц тогтолцоог бүрдүүлэх 	<ol style="list-style-type: none"> Байгалийн нөөцийн хомсдол, орчны доройтлыг зогсоон, нөхөн сэргээх, арвижуулах арга хэмжээг төгөлдөржүүлэн зохистой ашиглалтыг хэвшүүлэх Байгалийн орчны хяналт-шинжилгээ, мэдээллийн ухаалаг тогтолцоог хөгжүүлж хүртээмжтэй болго

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, ТАРХАЦ НУТАГ, АМЬДРАХ ОРЧНЫГ НЬ ТЭТГЭЖ ХОМСДОЛООС СЭРГИЙЛЭХ, АШИГТ ЗҮЙЛИЙГ ҮРЖҮҮЛЭХ, ТАРИМАЛЖУУЛАХ, ОЙН АГРОПАРК БАЙГУУЛАХ ЗАМААР АШИГЛАЛТЫН НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 6.2.1. Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн бүртгэл, мэдээллийн сан, генетик нөөцийн төрөлжсөн сангууд /генбанк/ байгуулж сан хөмрөгийг баяжуулах, биотехнологийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг дэмжин хөгжүүлнэ.
 - 6.2.2. Амьтан, ургамлын улаан дансыг шинэчлэх, шинээр бий болгож, ховордсон зүйлийн хамгааллын арга замыг тодорхойлж хэрэгжүүлнэ.
 - 6.2.3. Ашиглалтад өртөмтгий амьтан, ургамлыг зориудаар өсгөн үржүүлэх, тарималжуулах, ойн агропарк байгуулж, ашиглалтын нөөцийг бүсчлэн бий болгож, байгалиас шууд авч ашиглах дарамтыг бууруулна.
 - 6.2.4. Ойжуулах, ойн тэлэн ургалтыг дэмжих, нөхөн сэргээх, ой хамгааллын арга хэмжээ авах замаар ойн хомсдлоос сэргийлэн, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нийт газар нутгийн 9 хувьд хүргэж, нүүрсхүчлийн хийн шингээлтийг нэмэгдүүлнэ.
 - 6.2.5. Био аюулгүй байдлыг хангах материаллаг баазыг бэхжүүлнэ.
 - 6.2.6. Экосистем, биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж байгаа аж ахуй эрхлэлтэд олгодог татаасыг бууруулах, экосистемийг үйлчилгээг тэтгэсэн, хамгааллын үйл ажиллагааг дэмжинэ.
 - 6.2.7. Байгаль хамгааллын шинжлэх ухаан, дэвшилтэт технологид түшиглэсэн мэргэжлийн боловсролын тогтолцоог хөгжүүлнэ.
- ХӨРСНИЙ ҮРЖИЛ ШИМ, ЧИЙГИЙГ ХАМГААЛЖ, ГАЗРЫН ДОРОЙТОЛ, ЦӨЛЖИЛТӨӨС СЭРГИЙЛЭН, ЭВДРЭЛД ОРСОН, БОХИРДСОН ГАЗРЫГ НӨХӨН СЭРГЭЭЖ, АЖ АХУЙН ЭРГЭЛТЭД ОРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР
- 6.2.8. Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах, цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.
 - 6.2.9. Ногоон хүрэм төсөл хэрэгжүүлж, уул уурхай, газар тариалан, дэд бүтцийн байгууламж, хот байгуулалт, бэлчээр ашиглалтын улмаас эвдрэл, доройтолд орсон газрыг нөхөн сэргээж аж ахуйн зориулалтаар дахин ашиглах боломжтой болгож эргэлтэд оруулах, ашиглагчийн хариуцлагыг өндөржүүлнэ.
 - 6.2.10. Уул уурхай, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас бохирдсон, доройтсон, эвдэрсэн газар, газрын хэвлийг хоргүйжүүлэх, нөхөн сэргээх, хамгаалах ажлын үр дүнг дээшлүүлж, хариуцлагатай үйл ажиллагааг хэвшүүлнэ.
 - 6.2.11. Тариалангийн хагалж боловсруулах уламжлалт технологийг халж, агротехникийн болон усалгааны хэмнэлттэй дэвшилтэт технологи нэвтрүүлэх, шинээр нэмж газар хагалахгүй, зөвхөн атаршсан газрыг эргэлтэд оруулж хөрсийг тордож ашиглана.

МОНГОЛ ОРНЫ БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ

МАНАЙ ОРОНД АМЬТНЫ АЙМГААС:

- Хөхтөн 141 зүйл
- Шувуу 476 зүйл
- Загас 79 зүйл
- Мөлхөгч 22 зүйл
- Хоёр нутагтан 8 зүйл
- Сээр нуруугүйтэн -13000 зүйл бүртгэгджээ. Үүнээс 14 зүйл хөхтөн, 24 зүйл шувуу, 6 зүйл мөлхөгч, 4 зүйл хоёр нутагтан, 1 зүйл загас, 27 зүйл сээр нуруугүйтэн ховор амьтны жагсаалтад ордог.



УРГАМЛЫН АЙМГИЙН 7000 ГАРУЙ ЗҮЙЛ БҮРТГЭГДСЭН БАЙДГААС:

- Гуурст дээд ургамал 3127 зүйл
- Доод ургамал 4188 зүйл, үүнээс: Замаг 2003, Хаг 1031, Хөвд 580, Мөөг 574 зүйл

Эдгээрээс 108 төрөлд хамаарах 133 зүйл ургамал нэн ховор, 211 төрлийн 356 зүйл ургамал ховор ангилалд багтдаг.



БИЧИЛ БИЕТНИЙ ХУВЬД ОДООГИЙН БАЙДЛААР:

- Архейгийн 5 төрөл
- Бактерийн 81 төрөл
- Актиномицетийн 66 төрөл
- Мөөгөнцөрийн 178 төрөл
- Хөрөнгөнцөрийн 22 төрөл
- Хромистагийн 6 төрөл илрээд байна.



ЯАГААД ГЕНЕТИК НӨӨЦИЙГ ХАМГААЛАХ ШААРДЛАГАТАЙ ВЭ?



Монгол орны байгалийн тогтоц, эрс тэс уур амьсгал нь түүнд дасан зохицсон, жилийн ихэнх хугацааны хүйтэн, хахир хатуу нөхцөлийг даван туулах, тэсвэрлэх өвөрмөц чадвартай амьтан, ургамал, бичил биетнийг бий болгодог бөгөөд эдгээр генетик нөөц нь Монгол орны хувьд дэлхийд давтагдашгүй үнэт баялаг болно.

Манай орон биологийн болон генетик нөөц, түүнийг ахуй амьдралдаа ашиглаж ирсэн өнө эртний түүхэн уламжлалт мэдлэгээр баян орон юм. Гэвч судалгаа шинжилгээ, бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх өндөр түвшний лаборатори, мэргэжлийн боловсон хүчин, инновацийн хөрөнгө оруулалтын таатай орчин байхгүйгээс манай улс эдгээр үнэт баялаг- түүхий эдээр ханган нийлүүлэгчийн түвшинд байсаар байна.

Биологийн олон янз байдлыг хамгаалаагүйгээс бий болох үр дагавар нь уур амьсгалын өөрчлөлт, орчны бохирдол зэрэг байгаль орчны бусад асуудлын нэг адил экосистемийн үйл ажиллагааг алдагдуулах, улмаар хүн төрөлхтний оршин тогтнолд эрсдэл учруулж болно.

Биологийн нөөцийн экосистемд гүйцэтгэж байгаа хүнс тэжээл, эрчим хүчний хэрэгцээг хангах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, гоо зүйн үүргээс гадна тэдгээрт агуулагдаж байгаа генетик нөөц, биологийн идэвхт үнэ цэнэтэй нэгдлийг судалж ашиглах хүнс, хөдөө аж ахуй, эм бэлдмэл, гоо сайхны салбаруудын өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах биологийн олон янз байдлын ашиглалт, хэрэглээг зохицуулах, генетик нөөцийн уламжлалт мэдлэгээ хамгаалах, эдийн засгийн эргэлтэд оруулж ашиглах шаардлага орчин үед тулгамдаж байна.

ЯАЖ ЗОХИЦУУЛАХ ВЭ?



Генетик нөөцийн ашиглалтаас үүдэх үр шимийг шударга, эрх тэгш харилцан хүртэх харилцааг зохицуулсан олон улсын хэлэлцээр бол 2010 онд батлагдсан Нагоягийн протокол юм. Нагоягийн протокол нь генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэг, тэдгээрээс үүдэлтэй шинэ санаа, нээлтүүд, генетик нөөцийн ашиглалтаас хөгжиж байгаа хангагч орны иргэд үр өгөөж хүртэх боломжийг бүрдүүлэхэд чиглэдэг. Монгол Улсын Их Хурал Генетик нөөцийн тухай Нагоягийн протоколыг 2012 онд соёрхон баталсан.

Монгол орны нутаг дэвсгэрээс гаралтай амьтан, ургамал, бичил биетний генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг судалгаа, хөгжүүлэлтэд ашиглах, ашиглалтаас үүдэх үр шимийг тэгш, шударга харилцан хүртэх асуудлыг хуульчлах шаардлагатай байна.

МОНГОЛ ОРНЫ БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ

ГЕНЕТИК НӨӨЦИЙН АШИГЛАЛТААС ҮҮДЭХ ҮР ШИМ

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙГ ТӨРӨЛЖҮҮЛНЭ

- 2030 он гэхэд уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд бага нөөцөөр хаягдал багатай, байгалийн гаралтай цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх хэрэгцээ, шаардлагад нийцсэн шинжлэх ухаан, технологийн ололтыг хүнс тэжээл, биотүлш, биоматериал, эм, гоо сайхны бүтээгдэхүүн зэрэг биотехнологийн үйлдвэрлэлд ашиглах гадаадын хөрөнгө оруулалт, технологи дамжуулалтыг өргөжүүлнэ.

- Генетик нөөцийг ашиглах мал аж ахуй (малын уурагт тэжээлийн түүхий эд), мал эмнэлэг (вакцин, биобэлдмэл), ургамал хамгаалал (өвчин хортон шавж, мэрэгчтэй тэмцэх бэлдмэл), газар тариалан (биобордоо, жимс жимсгэнэ) хүнсний (уламжлалт исэх идээ) бүтээгдэхүүний судалгаа хөгжүүлэлт өссөнөөр хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 50 хувиар өсөн нэмэгдэнэ.

- Байгалийн гаралтай эм, уламжлалт эмийн бүтээгдэхүүний хэрэглээний эрэлтэд нийцүүлэн ардын эмчилгээ, уламжлалт анагаах ухаанд хэрэглэдэг амьтан, ургамлын ашигт чанарыг илэрхийлэгч биологийн идэвхт бодисын үйлчлэл, генийн судалгааг өргөжүүлж, рекомбинант технологийг ашиглан хүн, мал амьтны халдварт өвчний оношлуур, урьдчилан сэргийлэх ба анагаах эм бэлдмэлийн судалгаа хөгжүүлэлтийг нэмэгдүүлнэ.

- Олон улсад байгалийн гаралтай гоо сайхны бүтээгдэхүүний эрэлт ихэссэнтэй холбоотой энэ салбарт ургамал, амьтны генетик нөөцийн судалгаа, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн дотоодын чадавхыг нэмэгдүүлж, бүтээгдэхүүний чанар, үр нөлөөг сайжруулах, зах зээлд борлуулах маркетингийн зорилгоор ашиглах экзотик ургамал, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг бүртгэн хамгаална.



СОЁЛЫН БИЕТ БУС ӨВ, ОЮУНЫ ӨМЧИЙН ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛНА

Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн талаар эртний ном, судар бичгүүдэд тэмдэглэсэн ардын уламжлалт эм тан бэлтгэх, цагаан идээ боловсруулах, мал аж ахуй эрхлэхтэй холбоотой үндэсний уламжлалт мэдлэгээ бүртгэн баталгаажуулж үр дүнтэй ашиглана. Генетик нөөцийн судалгаа хөгжүүлэлт хийх, уламжлалт мэдлэгийг салбаруудад зүй зохистой ашиглах ёс зүйг төлөвшүүлнэ.

ОЛОН УЛСЫН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦООНЫ ТОГТОЛЦОО БИЙ БОЛНО

- Генетик нөөцийн ашиглалтын цахим бүртгэлээр дамжуулан Монгол орны генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн дотоод, гадаад дахь ашиглалтыг бүртгэж, Генетик нөөцийн тухай хууль, Нагояагийн протоколын хэрэгжилтийг хянах олон улсын тогтолцоог хэрэгжүүлж үр шимийг харилцан хүртэх үйл ажиллагааг өргөжүүлнэ.

СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦИЙН ХӨГЖИЛ

- Бичил биетний өсгөврийн сан, амьтан, ургамлын эд, эсийн өсгөврийн сан, ургамлын гербари, үрийн санг багтаасан генетик нөөцийн үндэсний төрөлжсөн сангууд байгуулж, нэгдсэн зохион байгуулалт, хадгалалтын горим, стандарт шаардлагын дагуу ажиллуулна.
- Ургамлын биотехнологийн чиглэлд ховор, нэн ховор ургамлын бичил үржүүлэг хийх, тарималжуулах замаар биологийн олон янз байдлын хамгаалалд бодит хувь нэмэр оруулна.

ТЕХНОЛОГИ ДАМЖУУЛАЛТ ӨРГӨЖИНӨ

Генетик нөөцийн үндэсний сангийн лабораториудын хүчин чадал өргөжин, хүний нөөц чадавхжин, олон улсын дэвшилтэт технологи стандартыг нутагшуулан молекул биологи, генетик, биохими, биоорганик химийн орчин үеийн аргуудыг ашиглан аливаа биоматериалын гарал үүсэл ангилалзүйн байршлыг тогтоох, биологийн идэвхт нэгдлийг хайх, илрүүлэх, ашиглах үйл ажиллагааг өргөжүүлнэ.

ХУВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ НЭМЭГДЭНЭ

- Биологийн олон янз байдлыг хамгаалж, түүнийг зохистой ашигласнаас үүдэх үр шимээс эрх тэгш, шударга хүртсэнээр нутгийн иргэдийн биологийн нөөцийг хамгаалах идэвх оролцоо сайжирч, хувийн хэвшил, судалгаа шинжилгээний байгууллага хоорондын хамтын ажиллагаа, итгэлцэл сайжирна.

6.2.12. Бүсийн ялгавартай, шатлан өсгөх зарчимд суурилсан газрын төлбөрийн системийг бий болгож, малын тоо толгойг бэлчээрийн даацад нийцүүлэн хязгаарлаж бэлчээр ашиглалтын ачааллыг тэнцвэржүүлнэ.

6.2.13. Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дамжуулан газрыг зохистой ашиглах, нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлнэ.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ОЛОН НИЙТЭД СУРТАЛЧЛАН ТАНИУЛЖ, СТАНДАРТ, ХЭМ ХЭМЖЭЭГ МӨРДҮҮЛЭН, БАЙГАЛЬ ХАМГААЛАЛД ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

6.2.14. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан байгаль орчны хууль тогтоомжийг сурталчлах, байгаль хамгаалах уламжлалт ёс заншлыг таниулах мэдээллийг тогтмол түгээж, байгаль хамгаалах үйлсэд иргэдийн оролцоог хангана.

6.2.15. Байгаль орчны мэдээллийн төвийн үйл ажиллагааг нүүдлийн соёл иргэншлийн үндэсний хүрээлэнгийн үйл ажиллагаатай уялдуулан олон нийтэд байгаль хамгаалал, уламжлалт ёс заншлын мэдлэг, тогтвортой хөгжлийн боловсрол олгоно.

6.2.16. Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг олон нийтэд нээлттэй болгоно.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ СҮЛЖЭЭ, КАДАСТР, МЭДЭЭЛЛИЙН СААНГ ӨРГӨЖҮҮЛЖ, ШИНЭ ҮЕИЙН ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛ ХИЙХ ЧИГЛЭЛЭЭР

6.2.17. Байгаль орчны шинжилгээний төв лабораторийг шинэчилж, орчны бохирдлын хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж чадавхжуулна.

6.2.28. Байгаль орчны мэдээллийн нэгдсэн сан, байгалийн нөөцийн ашиглалтын бүртгэл, кадастрыг технологийн хөгжлийг ашиглан боловсронгуй болгож баяжуулах, байгаль орчны е-зөвшөөрлийн системийг нэвтрүүлж мэдээллийн шуурхай байдал, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

6.2.19. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

ҮНЭТ БАЯЛАГ УС

ЗОРИЛТ 6.3. Усны нөөцийн хомсдолоос сэргийлж хуримтлуулан, хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020-2030)	II үе шат (2031-2040)	III үе шат (2041-2050)
УСНЫ УХАМСАРТАЙ ХЭРЭГЛЭЭ	УСНЫ АРИВЖУУЛСАН НӨӨЦ	УСНЫ ГАЧААЛААС ҮЛ ХАМААРАХ ХӨГЖИЛ
Усны нөөцийн шаталсан үнэ тарифын тогтолцоог бүрдүүлэн үнэлэмжийг нэмэгдүүлж хамгаалах, усны нөөцийг хуримтлуулах үе	Усны нөөцийн нэгдсэн менежментийг бэхжүүлэх, усны хуримтлалыг нэмэгдүүлж, хүртээмж, хангамжийг сайжруулах үе	Байгалийн болон зориудаар арвижуулсан нөөцийг хяналттай, зохистой ашиглаж хэвших үе
<ol style="list-style-type: none"> Усны нөөцийн үнэ тарифт шатлан өсгөх зарчмыг тогтоож, ус ашиглалтыг төлбөртэй болгон хэмнэлттэй хэрэглээ, дахин ашиглалтыг нэмэгдүүлэх Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулж, усны бохирдол, хомсдолыг бууруулах Газрын байгалийн тогтоц, голын татамд хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм, далд усан сангууд байгуулж, томоохон голууд дээр урсцын тохируулгатай, олон зориулалтаар ашиглах усан сан барьж эхлэх Хүн амыг стандартын шаардлагад нийцсэн ундны усаар хангах, усны нөөцийн эрэл, хайгуул, зураглалын ажлыг эрчимжүүлж нөөц баялгийн мэдээллийн бааз суурийг өргөжүүлэх, төлөвлөлт, менежмент хийх нөхцөлийг бүрдүүлэх 	<ol style="list-style-type: none"> Усны нөөцийн төлбөр, ус бохирдуулсны төлбөр, зөвшөөрлийн механизм, эдийн засгийн хөшүүргийг оновчтой болгох, хэмнэлттэй хэрэглээ, дахин ашиглалтыг хэвшүүлэх Стратегийн үнэт баялаг усны талаарх олон нийтийн мэдлэг, хандлага, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулж усны нөөц бохирдож, хомсдохоос сэргийлэх Хөв цөөрөм, урсцын тохируулгатай усан сан, ус нөөцлөх, дамжуулах далд систем байгуулах ажлыг эрчимжүүлж усны хуримтлалыг нэмэгдүүлэх Газрын доорх усны судалгааг өргөжүүлж, олборлолт, ашиглалт, нөхөн сэргээлтэд хамгийн тэргүүний дэвшилтэт технологи (БАТ/БЭП) нэвтрүүлэх Ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг шинэчилж өргөтгөн хүн амын 90-ээс доошгүй хувийг шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангах 	<ol style="list-style-type: none"> Усны хэмнэлт, усгүй технологи, зохистой хэрэглээг хэвшүүлэн усны нөөц бохирдох, хомсдохоос сэргийлэх, хянах Усыг хуримтлуулах, нөөцийг арвижуулахад чиглэсэн олон төрлийн дэвшилтэт арга технологийг нэвтрүүлэх Усны нөөц баялаг, ус ашиглалтын цогц мэдээллийг бүрдүүлэх, ус хангамжийн асуудлыг бүрэн шийдэх

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

УСНЫ НӨӨЦИЙН ҮНЭ ТАРИФТ ШАТЛАН ӨСГӨХ ЗАРЧМЫГ ТОГТООЖ, УС АШИГЛАЛТЫГ ТӨЛБӨРТЭЙ БОЛГОН ХЭМНЭЛТТЭЙ ХЭРЭГЛЭЭ, ДАХИН АШИГЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 6.3.1. Ус хэрэглээг бүрэн тоолууржуулж, ус ашиглалтын үр ашиг, хэмнэлтийг сайжруулна.
- 6.3.2. Усны нөөц ашигласны төлбөрийг хэрэглээний хэмжээнээс хамаарсан шатлан өсгөх зарчимд суурилж тогтоох, төлбөрийн орлогыг дахин хуваарилах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж хэрэгжүүлнэ.
- 6.3.3. Ус бохирдуулсны төлбөр, зөвшөөрлийн механизмаар дамжуулан үйлдвэрлэлийн усны дахин ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлж, усны ул мөрийг бууруулна.
- 6.3.4. Хаягдал ус дахин боловсруулах, цэвэрлэсэн усыг дахин ашиглах үйл ажиллагааг дэмжин хөгжүүлнэ.

УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН БҮС, УС ХАНГАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ЭРҮҮЛ АХУЙН БҮСИЙН ДЭГЛЭМИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ САЙЖРУУЛЖ, УСНЫ НӨӨЦИЙН БОХИРДОЛ, ХОМСДОЛЫГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

- 6.3.5. Усны хууль тогтоомжийн хэрэгжилтийг чангатгаж, нийслэл болон бусад хот суурин газрын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлж газар чөлөөлөн усны нөөц бохирдож, хомстохоос сэргийлэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 6.3.6. Сав газрын захиргаадын бүтцийг оновчлон чадавхжуулж, улсын болон сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.
- 6.3.7. Газрын доорх усны нөөц баялгаа бүртгэлжүүлж ашиглалтын зохистой менежмент явуулах, усны нөөцийн өөрчлөлт, ашиглалтын талаарх бодит мэдээллийг бий болгох үүднээс гадаргын усны харуулын тоо болон газрын доорх усны хэмжилтийн цэгийг нэмэгдүүлнэ.

ГАЗРЫН БАЙГАЛИЙН ТОГТОЦ, ГОЛЫН ТАТАМД ХУР ТУНАДАС, ХАЙЛСАН ЦАС, МӨСНИЙ УСЫГ ХУРИМТЛУУЛАХ ХӨВ ЦӨӨРӨМ, ДАЛД УСАН САНГУУД БАЙГУУЛЖ, ТОМООХОН ГОЛУУД ДЭЭР УРСЦЫН ТОХИРУУЛГАТАЙ, ОЛОН ЗОРИУЛАЛТААР АШИГЛАХ УСАН САН БАРЬЖ ЭХЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 6.3.8. Хөх морь төслийн хүрээнд өндөр уулын бүсийн Сэлэнгэ, Орхон, Эг, Хэрлэн, Ховд зэрэг томоохон гол мөрөнд урсцын тохируулгатай, олон зориулалтын цуваа усан сангууд байгуулах ТЭЗҮ, зураг төслийг боловсруулж барилгын ажлыг эхлүүлнэ.

- 6.3.9. Газрын тогтоц, голын голдирлын хэв шинжийг ашиглан хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах цувраа хөв цөөрөм, далд усан сангууд байгуулна.

- 6.3.10. Говь, хээрийн бүсэд газрын доорх усны ордын орчимд үерийн усыг тогтоон барих далан, шингээх худаг, нэвчүүлэх цөөрөм байгуулах замаар усны нөөц баялгийг арвижуулах, нөхөн сэргээх арга технологи нэвтрүүлнэ.

- 6.3.11. Аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчин, нийгмийн хариуцлагын хүрээнд газрын доорх усны ордыг хур тунадасны усаар арвижуулж нөхөн сэргээх практикийг хэвшүүлнэ.

ХҮН АМЫГ СТАНДАРТЫН ШААРДЛАГАД НИЙЦСЭН УНДНЫ УСААР ХАНГАХ, УСНЫ НӨӨЦИЙН ЭРЭЛ, ХАЙГУУЛ, ЗУРАГЛАЛЫН АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЖ НӨӨЦ БАЯЛГИЙН МЭДЭЭЛЛИЙН БААЗ СУУРИЙГ ӨРГӨЖҮҮЛЖ ТӨЛӨВЛӨЛТ, МЕНЕЖМЕНТ ХИЙХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 6.3.12. Гидрогеологийн дунд масштабын зураглал, хот, суурин газрын хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн эрэл, хайгуулын ажлыг хийж нөөцийг баталгаажуулна.


- 6.3.13. Ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг өргөтгөх, шинээр барьж, баталгаат ундны усаар хангагдсан хүн амын тоог нэмэгдүүлнэ.

Хүснэгт 6.2. 2040 оны нийт усны хэрэгцээний тооцоолол, аймгаар.

Аймаг	2040 оны усны хэрэгцээ (сая м3/жил)							
	Хүн амын унд, ахуйн ус	Нийтийн аж ахуйн үйлчилгээний & аялал жуулчлал & ногоон байгууламж	Үйлдвэрлэл	Бусад үйлдвэрлэл, эрчим хүч, барилга, зам тээвэр	Үйлдвэрлэл Уул уурхайн (олборлолт, боловсруулалт)	МАА (бэлчээрийн фермийн)	Усалгаатай талбай	Нийт
Монгол Улс	215.4	56.2	28.7	130.7	211.1	388.6	845.5	1,876.2
Баян-Өлгий	5.90	1.83	0.14	1.20	0.85	11.30	5.31	26.5
Говь-Алтай	2.00	0.32	0.22	0.24	0.00	21.20	3.43	27.4
Завхан	2.20	1.01	0.24	1.91	0.24	20.10	4.21	29.9
Увс	4.00	1.07	0.26	0.65	0.14	16.60	26.66	49.4
Ховд	4.10	0.09	0.14	0.00	0.00	18.50	8.09	30.9
Архангай	3.30	2.97	0.01	10.08	55.90	32.80	12.11	117.2
Баянхонгор	4.50	1.07	0.01	0.87	4.92	27.20	1.53	40.1
Булган	1.60	0.57	0.04	0.42	0.10	20.30	54.12	77.2
Орхон	8.20	0.00	1.15	0.00	0.00	0.30	5.08	14.7
Өвөрхангай	4.80	0.32	0.53	0.00	0.00	34.40	17.93	58.0
Хөвсгөл	5.30	2.24	0.27	1.10	0.27	33.20	24.85	67.2
Говьсүмбэр	1.00	0.00	0.00	0.00	0.00	2.90	0.15	4.1
Дархан-Уул	6.60	0.00	1.18	0.00	0.00	1.70	38.38	47.9
Дорноговь	4.30	0.66	5.07	0.00	62.94	11.40	0.62	85.0
Дундговь	1.40	1.67	0.01	3.56	6.66	21.10	0.35	34.8
Өмнөговь	3.30	1.36	0.00	3.85	9.19	14.60	1.59	33.9
Сэлэнгэ	5.00	0.00	3.41	0.00	3.35	9.30	325.60	346.7
Төв	2.00	1.52	0.10	17.23	8.95	28.90	184.05	242.7
Дорнод	4.20	0.19	0.08	1.32	27.08	12.60	62.75	108.2
Сүхбаатар	3.00	0.00	0.02	0.00	0.00	20.30	16.41	39.7
Хэнтий	2.30	1.99	0.01	12.00	19.23	27.80	49.48	112.8
Улаанбаатар	122.80	37.31	15.79	76.25	11.27	2.30	2.83	268.5

Эх сурвалж: БХБЯ, ҮХГ, ЖАЙКА, Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төслийн явцын тайлан, 2019

Зураг 6.6. 2030 оны Усны нөөцийн бүлэг



Эх сурвалж: БХБЯ, ҮХГ, ЖАЙКА, Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төслийн явцын тайлан, 2019

Хүснэгт 6.3. Усны нөөц, үнэ цэнийг нэмэгдүүлж хамгаалах, хуримтлал бий болгох тооцоо.

#	Үзүүлэлт	Суурь түвшин	2030	2040	2050
1	Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь	82.5	87	90	90
2	Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувь	69	75	82	90
3	Усны чанарын цэвэр үнэлгээтэй усны объектын эзлэх хувь	92	92	92	95
4	Үйлдвэрлэлийн зориулалтаар эргүүлэн ашиглах усны эзлэх хувь	-	40	60	80
5	Байгуулах хөв цөөрөм, далд усан сан	-	25	50	50
6	Хөх морь төслийн хүрээнд хэрэгжсэн бүтээн байгуулалтын төслийн тоо	-	1	2	2
7	Гадаргын усны харуулын тоо	153	300	350	450
8	газрын доорх усны хэмжилтийн цэгийн тоо	37	330	380	480
9	Ус хангамжийн эх үүсвэрийн нөөц тогтоосон сумдын тоо	-	15	30	30
10	Гидрогеологийн дунд масштабын зураглал хийгдсэн газар нутгийн хэмжээ, нийт нутагт эзлэх хувь	14	30	40	50

ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ БАГАТАЙ, БҮТЭЭМЖТЭЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ НОГООН ХӨГЖИЛ

ЗОРИЛТ 6.4. Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулна.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
НОГООН ТЕХНОЛОГИ, НОГООН ЭДИЙН ЗАСАГ	НОГООН ХӨГЖЛИЙН СУУРЬ	ТОГТВОРТОЙ НОГООН ХӨГЖИЛ
Үндэсний ногоон санхүүгийн тогтолцоог бий болгон хөгжүүлж, байгальд ээлтэй, үр ашигтай цэвэр технологи, хэмнэлттэй хэрэглээг дэмжих үе	Ухаалаг хэрэглээ, бүтээмжтэй үйлдвэрлэлийг төлөвшүүлж, уур амьсгалын ногоон санхүүжилтийн дотоод, гадаад эх үүсвэрийг нэмэгдүүлэх үе	Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг тасралтгүй бэхжүүлж, тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээг төгөлдөржүүлэх үе
<ol style="list-style-type: none"> 1. Байгальд ээлтэй, үр ашигтай дэвшилтэт технологи нэвтрүүлж хэрэглээ, үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх, байгалийн нөөцийг хэмнэх, хаягдалгүй эдийн засгийг /circular economy/ хөгжүүлэх 2. Эрчим хүч, хөдөө аж ахуй, барилга, тээвэр, аж үйлдвэр, хог хаягдлын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх 	<ol style="list-style-type: none"> 1. Байгальд ээлтэй, хаягдал багатай ухаалаг хэрэглээ, бүтээмжтэй үйлдвэрлэлийг хөгжүүлж нөөцийн хэмнэлт, өгөөжийг нэмэгдүүлэх 2. Уур амьсгалын өөрчлөлтийн шинэ хэлэлцээрийн хүрээнд хүлэмжийн хийн үндэсний ялгарлыг бууруулж, нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх 3. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөрийг шинэчилж хэрэгжүүлэх 	<ol style="list-style-type: none"> 1. Байгальд ээлтэй тогтвортой үйлдвэрлэл, ухаалаг хэрэглээг хэвшүүлж, ногоон хөгжлийн үзэл санааг дэлгэрүүлэх 2. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээг хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарал ба шингээлтийн зөрүүг тэглэх 3. Хог хаягдлын цогц менежментийг хэрэгжүүлж эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, хот суурин газрууд хог хаягдлын зориулалтын байгууламжтай болох4. Бүх хот суурин газар хог хаягдлын зориулалтын байгууламжтай болох

- | | | |
|--|--|--|
| <ol style="list-style-type: none"> 3. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, тэсвэрлэх чадавхыг бэхжүүлж, үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулах 4. Төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан үндэсний ногоон санхүүгийн тогтолцоог дэмжин хөгжүүлж, олон улсын санхүүгийн механизмыг ашиглан байгальд ээлтэй ногоон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх 5. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, дахин ашиглах, дахин боловсруулах 3R цогц менежментийг хэрэгжүүлж эдийн засгийн эргэлтэд оруулан дахин боловсруулсан хог хаягдлын хэмжээг нэмэгдүүлэх | <ol style="list-style-type: none"> 4. Үндэсний ногоон санхүүгийн тогтолцоо, олон улсын санхүүгийн механизмын санхүүжилтийг нэмэгдүүлж үр өгөөжтэй ашиглах 5. Хог хаягдлын цогц менежментийг хэрэгжүүлэх, барилга, зам, тээврийн салбарт хаягдалгүй технологи нэвтрүүлж, хаягдлыг бүрэн дахин боловсруулах, сэргээн ашиглах | <ol style="list-style-type: none"> 4. Ариун цэврийн байгууламжийн чанар, хүртээмжийг сайжруулж, нийт хүн амыг шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангах |
|--|--|--|

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ, ҮР АШИГТАЙ ДЭВШИЛТЭТ НОГООН ТЕХНОЛОГИ НЭВТРҮҮЛЖ ХЭРЭГЛЭЭ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БҮТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙГ ХЭМНЭХ, ХАЯГДАЛГҮЙ ЭДИЙН ЗАСГИЙГ /CIRCULAR ECONOMY/ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 6.4.1. Байгальд ээлтэй газын хэрэглээ болон бусад үр ашигтай дэвшилтэт ногоон технологийг дэмжиж татварын хөнгөлөлт бий болгоно.
- 6.4.2. Үүсэх хог хаягдлыг бууруулах, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулахад чиглэсэн Эко төлбөрийн эрхзүйн зохицуулалтыг бий болгож, хэрэгжүүлнэ.
- 6.4.3. Тогтвортой ногоон хот, ногоон барилга, амьдралын ногоон хэв маяг, нөөцийн хэмнэлт зэрэг байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадлыг дэмжин хөгжүүлнэ.
- 6.4.4. Бохирдол, хаягдлыг бууруулах, нөөцийн хэмнэлттэй байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, цэвэр үйлдвэрлэл, хэмнэлттэй хэрэглээг эдийн засгийн хөшүүргээр дэмжинэ.
- 6.4.5. Байгаль орчны менежментийн MNS ISO14000 багц стандарт нэвтрүүлэх, ногоон гэрчилгээ олгох тогтолцоог дэмжин эрчимжүүлж, үйлдвэрлэл, хэрэглээний зөв дадлыг бий болгоно.

6.4.6. Төрийн худалдан авалтыг ногоон худалдан авалтад үе шаттайгаар шилжүүлж, хувийн хэвшлийг дэмжих тогтолцоо бүрдүүлнэ.

ЭРЧИМ ХҮЧ, ХӨДӨӨ АЖ АХУЙ, БАРИЛГА, ЗАМ ТЭЭВЭР, АЖ ҮЙЛДВЭР, ХОГ ХАЯГДЛЫН САЛБАРААР ТОДОРХОЙЛСОН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАН ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫГ БУУРУУЛЖ, НҮҮРСТӨРӨГЧИЙН ШИНГЭЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

6.4.7. Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Монгол Улсын тодорхойлсон хувь нэмэр (NDC) баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэн, эрчим хүч, хөдөө аж ахуй, барилга, тээвэр, аж үйлдвэр, хог хаягдлын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулна.

6.4.8. Ойжуулах, хүлэрт намгийг хамгаалах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээж ургамлан нөмрөгийг хамгаалах, ургамалжуулах замаар хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлнэ.

6.4.9. Салбаруудын хүлэмжийн хийн ялгарлыг хэмжих, тооцоолох, тооллого хийх, магадлах, тайлагнах чадавхыг бий болгон бэхжүүлж, цахимжуулна.

6.4.10. Барилгын салбарт ногоон, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн үйлдвэрлэгч дотоодын үйлдвэрүүдийг дэмжин хөгжүүлнэ.


УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ, ТЭСВЭРЛЭХ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН САНХҮҮЖИЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭН ҮҮСЭЖ БОЛЗОШГУЙ ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

6.4.11. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний хөтөлбөрийг баталж, хэрэгжилтийг хангана.

6.4.12. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлийн даатгалын тогтолцоог судалж бүрдүүлнэ.

6.4.13. Байгаль, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж, 5-аас доошгүй байршилд радарын станц байгуулна.

Зураг 6.7. Улирлын температур, хур тунадасны ирээдүйн өөрчлөлт



ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛД ТУЛГУУРЛАСАН ҮНДЭСНИЙ НОГООН САНХҮҮГИЙН ТОГТОЛЦООГ ДЭМЖИН ХӨГЖҮҮЛЖ, ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН МЕХАНИЗМЫГ АШИГЛАН БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ НОГООН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

6.4.14. Байгальд ээлтэй ногоон төсөл, үйл ажиллагааг санхүүжүүлэх төр, хувийн хэвшлийн хамтарсан үндэсний ногоон санхүүгийн тогтолцоог байгуулж хөгжүүлнэ.

6.4.15. Байгаль орчинд ээлтэй тогтвортой санхүүгийн тогтолцоог бэхжүүлж, тогтвортой бизнесийн зарчмыг банкнаас бусад салбарт нэвтрүүлж, аж ахуйн нэгжийн байгаль орчин, нийгмийн хариуцлагыг өндөржүүлнэ.

6.4.16. Байгальд ээлтэй тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ухаалаг хэрэглээг төлөвшүүлж дэлгэрүүлэх, байгаль орчин, нийгэмд ээлтэй төсөл, үйл ажиллагааг санхүүжүүлэх үндэсний ногоон санхүүгийн тогтолцоо /ногоон банк, ногоон бонд, ногоон бирж, ногоон даатгал гм/-г шинэ шатанд гаргана.

6.4.17. НҮБ-ын Уур амьсгалын ногоон сан болон бусад олон улсын санхүүгийн механизмаар дамжуулан сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, хаягдлыг багасгах, нөөцийн ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх ногоон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

ХОГ ХАЯГДЛЫГ ЭХ ҮҮСВЭР ДЭЭР НЬ БУУРУУЛАХ, ДАХИН АШИГЛАХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЗР ЦОГЦ МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭД ОРУУЛАН, ДАХИН БОЛОВСРУУЛСАН ХОГ ХАЯГДЛЫН ХЭМЖЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

6.4.18. Химийн хорт болон аюултай бодисын бүртгэх, шилжилт хөдөлгөөнийг хянах, мөшгөх бүртгэл, мэдээллийн цахим системийг бий болгож хөгжүүлнэ.

6.4.19. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажиллагааг хэвшүүлэх, дахин боловсруулах, эрчим хүч гаргах байгаль орчинд халгүй үйлдвэрийг байгуулна.

6.4.20. Улаанбаатар хот, бүсийн төвүүд болон бусад хот суурин газарт хог хаягдлын төвлөрсөн цэгийн стандартын ландфиллын байгууламж, аюултай хог хаягдлыг түр хадгалах, устгах зориулалтын байгууламжийг үе шаттайгаар байгуулна.

6.4.21. Барилга, зам, тээврийн салбарын хатуу хог хаягдлыг байгаль орчинд халгүй аргаар устгах, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.

6.4.22. Хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөх, шинээр барьж, шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын тоог нэмэгдүүлнэ.

6.4.23. Цэвэрлэх байгууламж, гэр хорооллын ариун цэврийн байгууламжийн хаягдал лагийг байгальд ээлтэй аргаар устгах туршилтын төсөл хэрэгжүүлж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлнэ.

УУР АМЬСГАЛЫН НОГООН САНХҮҮЖИЛТ

МОНГОЛ УЛС НЬ ГАЗАРЗҮЙН БАЙРШИЛ, УУР АМЬСГАЛЫН НӨХЦӨЛ, ХҮН АМЫН АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ ЗЭРГЭЭС УЛБААЛАН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ХАМГИЙН ЭМЗЭГ, ӨРТӨМТГИЙ ОРНУУДЫН НЭГ ЮМ.

СҮҮЛИЙН
70 ЖИЛД
ЖИЛИЙН ДУНДАЖ
ТЕМПЕРАТУР



2045-2060 ОНД
ДУНДАЖ
ТЕМПЕРАТУР



2045-2060 ОН ГЭХЭД



Монгол Улс өөрийн орны өвөрмөц онцлогт тулгуурлан Монгол Улсын Ногоон хөгжлийн бодлого, Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Монгол Улсын тодорхойлсон хувь нэмэр /NDC/ зэрэг бодлогын баримт бичгийг баталж, тогтвортой хөгжлийн 3 гол тулгуур болох байгаль орчин-нийгэм-эдийн засгийг харилцан уялдаатай, цогц нэгдмэл байдлаар хөгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох зорилтуудыг тодорхойлон хэрэгжүүлж байна. Энэхүү ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын зүгээс НҮБ-ын Уур амьсгалын ногоон сан /УАНС/-тай идэвхтэй хамтран ажиллаж байна.



УУР АМЬСГАЛЫН НОГООН САН

Олон улсын хөгжлийн болон банк санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж 2019 оны байдлаар:

- УАНС-аас батлуулсан төсөл, хөтөлбөрийн санхүүжилт - 220 сая ам.доллар
- Бусад талуудаас босгосон нийт санхүүжилт - 610 сая ам.доллар
- Монгол Улс дангаар хэрэгжүүлж, үр дүнг шууд хүртэх төсөл:

Төслийн нэр	УАНС-аас	Бусад талуудаас	Үр өгөөжийг шууд хүртэх
Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бичил, жижиг, дунд бизнесийн зээлийн хөтөлбөр /2017-2025/	ХАС БАНК 19.5 сая ам.доллар зээл, 0.5 сая ам.доллар буцалтгүй тусламж	40 сая ам.доллар	3400 ААНБ
Говьсүмбэр аймгийн 10 МВт-ын Нарны сэргээгдэх эрчим хүчний хөтөлбөр /2017-2027/	ХАС БАНК 8.7 сая ам.доллар зээл	8.9 сая ам.доллар	20000 айл өрх
Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц, хотын сэргээгдэх эрчим хүчний төсөл /2019-2027/	АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК 95 сая ам.доллар зээл, 50 сая ам.доллар буцалтгүй тусламж	398.1 сая ам.доллар	10000 айл өрх, 35000 хүн



Монгол Улс зөвхөн дээрх 3 төслийг хэрэгжүүлснээр **9.4 сая тонн нүүрсхүчлийн хийтэй тэнцэх** хүлэмжийн хийн ялгарал /ХХЯ/-ыг бууруулна. /Жич: Монгол Улсын NDC-д 2030 онд эдийн засгийн хөгжлийн өнөөгийн хандлагын төсөөлөл буюу суурь сценаритай харьцуулахад 16.9 сая тонн нүүрсхүчлийн хийтэй тэнцэх ХХЯ-ыг бууруулах зорилт тавьсан/

Бууруулах хүлэмжийн хийн ялгарал	Үр өгөөжийг шууд хүртэх хүн, ААНБ-ын тоо	Бий болох ажлын байрны тоо
9.4 сая тонн CO2e	3400 ААНБ, 30000 өрх, 110000 хүн	9800

НОГООН ХӨГЖИЛ ЗОРИЛГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

Тайлбар: * тэмдэглэгээ бүхий шалгуур үзүүлэлтийг шинээр тооцдог болно.

Хүснэгт 6.4. Ногоон хөгжил зорилгын хэрэгжилтийн хяналт,
үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин

#	Шалгуур үзүүлэлт (in- dicator)	Хэмжих нэгж	Суурь түвшин	2030	2040	2050	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хаанаас авах эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах аргазүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах
6	НОГООН ХӨГЖИЛ										
1	Байгаль орчны гүйцэтгэлийн үзүүлэлт EPI	тоо	57.21	59	60	61+	2018 онд оноо- 57.21	Иелийн их сургуулийн судалгаа/Yale Center for Envi- ronmental Law & Policy	Холбогдох ОУ-ын аргачлал, тайлангууд	Жилд 1 удаа	БОАЖЯ
2	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ	хувь	20.1%	30	33	35	2019 оны суурь түвшин	БОАЖЯ	ТХЗ 15.1-ийн ОУ-ын аргачлал, Байгаль орчны статистик мэдээллийн БОХ-2 маягт	Жилд 1 удаа	БОАЖЯ
3	Улсын тусгай хамгаалалтад авсан гол мөрний урсац бүрэлдэх эхийн талбайн эзлэх хувь	хувь	48.3	60	70	75	2019 оны суурь түвшин	БОАЖЯ	ТХЗ 15.1-ийн ОУ- ын аргачлал, Байгаль орчны статистик мэдээллийн БОХ-2 маягт	Жилд 1 удаа	БОАЖЯ
4	Улсын тусгай хамгаалалтад авсан ойн сан бүхий газрын талбайн эзлэх хувь	хувь	39.1	50	55	60	2019 оны суурь түвшин	БОАЖЯ	Байгаль орчны статистик мэдээллийн БОХ-2 маягт	Жилд 1 удаа	БОАЖЯ
5	Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээ	хувь	7.90%	9	9.8	10.5	2019 онд 7.9%	БОАЖЯ	Байгаль орчны статистик мэдээллийн БОХ-2 маягт	Жилд 1 удаа	БОАЖЯ
6	Тархац, нөөцийг тогтоох нэн ховор, ховор, ашигт ургамлын зүйлийн тоо	тоо	-	200<	200<	200<	2019 оны суурь түвшин	БОАЖЯ	Жилийн тайлан	Жилд 1 удаа	БОАЖЯ
7	Тархац, нөөцийг тогтоох зэрлэг амьтны зүйлийн тоо, жилд	тоо	-	50<	50<	50<	2019 оны суурь түвшин	БОАЖЯ	Жилийн тайлан	Жилд 1 удаа	БОАЖЯ
8	Амьтан, ургамал, бичил биетний омог, эд, эс, үр хөврөлийг хадгалах генетик нөөцийн төрөлжсөн сангийн тоо	тоо		2	5	10	2019 оны суурь түвшин	БОАЖЯ		Жилд 1 удаа	БОАЖЯ, БСШУСЯ, ХХААХҮЯ

#	Шалгуур үзүүлэлт (indicator)	Хэмжих нэгж	Суурь түвшин	2030	2040	2050	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хаанаас авах эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах аргазүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах
9	Газрын доройтлын хувь	хувь	2018 онд 22.9%	22.9	22.9	22.9	2018 онд 22.9%	БОАЖЯ, ШУА-ын Газарзүй, геоэкологийн хүрээлэн	ТХЗ-ын ОУ-ын аргачлал	5 жилд нэг удаа	БОАЖЯ
10	Уул уурхайн үйл ажиллагаанаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн хэмжээ	хувь	2019 оны түвшнээс	30	60	80	2019 оны түвшнээс	БОАЖЯ, УУХҮЯ	"Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн 20... жилийн мэдээ"-ний 3-БОХ-1.3	Жилд 1 удаа	БОАЖЯ
11	Гидрогеологийн дунд масштабын зураглал хийгдэх газар нутгийн хэмжээ, нийт нутагт эзлэх хувь	хувь	14	30	40	50	2018 оны суурь түвшин	БОАЖЯ	Жилийн тайлан	Жилд 1 удаа	БОАЖЯ
12	Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь	хувь	82.5	87	90	90	2018 оны суурь түвшин	ҮСХ	ТХЗ 6.1.1 аргачлал, НҮБ-ын ХС-ийн ОУБТС-ны аргачлал	5 жилд нэг удаа	БОАЖЯ, БХБЯ, ҮСГ
13	Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн ам	хувь	69	75	82	90	2018 оны суурь түвшин	ҮСХ	ТХЗ 6.2.1 аргачлал, НҮБ-ын ХС-ийн ОУБТС-ны аргачлал	5 жилд нэг удаа	БОАЖЯ, БХБЯ, ҮСГ
14	Усны чанарын цэвэр үнэлгээтэй усны объектын эзлэх хувь	хувь	92	92	92	95	2018 оны суурь түвшин	БОАЖЯ	ТХЗ 6.3.2 шалгуурын аргачлал	Жилд 1 удаа	БОАЖЯ
15	Үйлдвэрлэлийн зориулалтаар эргүүлэн ашиглах усны эзлэх хувь	хувь	-	40	60	80	2019 оны суурь түвшин	БОАЖЯ	"Ус ашиглалтын 20... жилийн мэдээ"-ний 3-БОХ-2.2	жилд 1 удаа	БОАЖЯ
16	Байгуулах хөв цөөрөм, далд усан сан	тоо	-	25	60	80		БОАЖЯ	Жилийн тайлан	Жилд 1 удаа	БОАЖЯ
17	Хөх морь төслийн хүрээнд хэрэгжсэн бүтээн байгуулалтын төслийн тоо	тоо	-	1	50	50		БОАЖЯ	Жилийн тайлан	Жилд 1 удаа	БОАЖЯ
18	Гадаргын усны харуулын тоо	тоо	153	300	2	2	2018 оны суурь түвшин	БОАЖЯ	Жилийн тайлан		
19	газрын доорх усны хэмжилтийн цэгийн тоо	тоо	37	330	350	450	2018 оны суурь түвшин				
20	Ус хангамжийн эх үүсвэрийн нөөц тогтоосон сумдын тоо	тоо	-	15	380	480		БОАЖЯ	Жилийн тайлан	Жилд 1 удаа	БОАЖЯ

#	Шалгуур үзүүлэлт (indicator)	Хэмжих нэгж	Суурь түвшин	2030	2040	2050	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хаанаас авах эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах аргазүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах
21	Агаарын бохирдлын автомат харуулын тоо	тоо	13	15	30	30	2018 оны суурь түвшин	БОАЖЯ	Жилийн тайлан	Жилд 1 удаа	БОАЖЯ
22	Автомат станц бүхий цаг уурын өртөө, харуулын эзлэх хувь	хувь	2019 оны байдлаар өртөөдийн 92%, харуулын 26% автомат	100			2019 оны байдлаар өртөөдийн 92%, харуулын 26% автомат	ЦУОШГ	Жилийн тайлан	жилд 1 удаа	ЦУОШГ, БОАЖЯ
23	Хүлэмжийн хийн ялгарлын бууралтын хувь	хувь	-	22				БОАЖЯ	"Хүлэмжийн хийн тооллогын 20... жилийн мэдээ"-ний 3-БОХ-7	2 жилд 1 удаа	БОАЖЯ
24	Шинээр байгуулсан радарын станцын тоо	тоо		3	25	25		БОАЖЯ, ЦУОШГ	Жилийн тайлан	жилд 1 удаа	ЦУОШГ, БОАЖЯ
25	Хог дахин боловсруулалтын хэмжээ	хувь	7.6	30	1		2018 оны суурь түвшин	БОАЖЯ	"Хог хаягдлын дахин ашиглалт, боловсруулалтын 20... жилийн мэдээ" БОХ-6.3	Жилд 1 удаа	БОАЖЯ
26	Хот суурин газрын тогтмол цуглуулж, шаардлага хангасан байдлаар устгах хог хаягдлын хэмжээ	хувь	25.6	64	45	50	2018 оны суурь түвшин	БОАЖЯ	ТХЗ 11.6.1	жилд 1 удаа	БОАЖЯ, БХБЯ, АНЗДТГ
27	Байгаль орчны менежментийн тогтолцооны ISO 14000 стандарт нэвтрүүлсэн, эко тэмдэг, ногоон гэрчилгээ авсан этгээдийн тооны өсөлт	дахин	2020 оны түвшнээс	5	5		2020 оны түвшнээс	БОАЖЯ	Жилийн тайлан	Жилд 1 удаа	БОАЖЯ
28	ЗГ-ын ногоон худалдан авалтын эзлэх хувь	хувь	-	20	40	50		СЯ, ХААГ	Жилийн тайлан	Жилд 1 удаа	СЯ, ХААГ



АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ

ЗЭВСЭГТ ХҮЧИН

ДАРХАН ХИЛ

ХҮН, НИЙГМИЙН АМАР
ТАЙВАН БАЙДАЛ

ХУУЛЬ САХИУЛАХ САЛБАРЫН
ХӨГЖИЛ

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ
БАЙДАЛ

АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ

Улс орны амар тайван, аюулгүй байдал нь хөрш орнууд, оршин буй бүс нутгийн хүрээнд хязгаарлагдахаа больж хувьсан өөрчлөгдөж буй дэлхий дахины даяаршил, интеграцлал, аюулгүй байдлаас улам хамааралтай болсоор байна. Сүүлийн жилүүдэд дэлхийн их гүрнүүд, нөлөө бүхий улс орнууд нэг нь нөгөөгийнхөө эсрэг хориг арга хэмжээ авч, нөлөөний хүрээгээ тэлэхээр эрмэлзэж байгаагийн зэрэгцээ улс бус субъектийн зүгээс хийж буй террорист халдлага, хар тамхи, зэвсгийн хууль бус наймаа жилээс жилд нэмэгдэж байна.

Аливаа аюул, заналаас сэргийлэх, түүнтэй тэмцэхэд дан ганц дотоодын аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй ба үндэстэн дамнасан аюул, заналаас урьдчилан сэргийлж, даван туулахын тулд улс орнуудын хоёр талт болон олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх, хил хязгаарын дархан байдлыг хангаж, хууль сахиулах байгууллагуудын чадавхыг тогтмол бэхжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Аливаа халуун цэгүүдэд болж буй хямралыг зохицуулах, байдлыг тогтворжуулах, сэргөлдөгч талуудыг эвлэрэлд хүргэхэд олон улсын байгууллагуудын хүчин чармайлт, түүний дотор НҮБ-ын гүйцэтгэх үүрэг илт өсөж, энэ үйл явцад "цэнхэр дуулгатан"-уудын оруулах хувь нэмэр нэмэгдэж, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн урьдчилан сэргийлэх дипломат аргын үр нөлөө илт дээшилснээр түүнд "цэргийнхэн"-ий гүйцэтгэх үүрэг үлэмж нэмэгдэж байна.

Сэргөлдөгч талуудын зөрчилдөөн уламжлалт арга хэрэгслээс гадна орчин үеийн техник, технологид суурилсан шинэ үеийн арга хэрэгслийг ашиглах болж, хил хязгааргүй мэдээллийн орон зайд ашиг сонирхлоо хамгаалах, мөн давамгайл байдлыг олох сонирхол нь кибер орон зайг бодит, мэдээллийн, нийгмийн, танин мэдэхүйн үйл ажиллагааны талбартай холбож, оршин

буй газар орон, цаг хугацаанаас хамаарахгүйгээр мэдээллийн гол гол дэд бүтцийг бүрэн хянах, удирдах, мэдээллийг тэмцлийнхээ гол объект болгох зорилго агуулах болсон байна.

Түүнчлэн гамшгийн эрсдэлийг бууруулах болон одоо тулгарч буй хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд гамшигтай тэмцэх, тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалт хийх, аюулын төрөл бүрээр эрт зарлах мэдээллийн систем, бэлэн байдлыг хангах, хор уршгийг арилгах, сэргээн босгох, нөхөн сэргээх үйл ажиллагааг бэхжүүлэх нь чухал байна.

//

Иймд улсын батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангах зорилгыг дэвшүүлээ.

//

Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилгыг дэвшүүлэн хөгжлийн үе шатуудыг тодорхойлоо.

ЗЭВСЭГТ ХҮЧИН

ЗОРИЛТ 7.1. Улс орны батлан хамгаалах тогтолцоог боловсронгуй болгож, чадавхыг бэхжүүлнэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
НЭГДМЭЛ ТОГТОЛЦООТОЙ, ТЕХНОЛОГИЖСОН ЗЭВСЭГТ ХҮЧИН	МЭРГЭЖЛИЙН ЗЭВСЭГТ ХҮЧИН	ӨНДӨР ЧАДАМЖТАЙ ЗЭВСЭГТ ХҮЧИН
Батлан хамгаалах тогтолцоог төгөлдөржүүлэн, технологийн дэвшлийг нэвтрүүлж, батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх үе	Мэргэжлийн цэрэгт суурилсан, чадварлаг зэвсэгт хүчнийг бэхжүүлэх үе	Батлан хамгаалах нэгдмэл тогтолцоо бэхжих үе
<ol style="list-style-type: none"> Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлж, батлан хамгаалах чадавхыг дээшлүүлэх Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн болон тусгай техник, тоног төхөөрөмжийг шинэчилж, Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлэх Дайчилгааны эрх зүйн орчин, төлөвлөлтийг боловсронгуй болгон дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний тоог нэмж, чанарыг сайжруулах Зэвсэгт хүчний НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаа болон улс орны бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд оролцох оролцоо, чадавхыг нэмэгдүүлэх Батлан хамгаалах төсвийн тогтвортой өсөлтийг хангаж, зарим төрлийн зэвсэглэл, техникийн эд ангийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, дотоодын хэрэгцээг хангах 	<ol style="list-style-type: none"> Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх Мэргэжлийн цэрэгт суурилсан, хөдөлгөөнт, маневрын өндөр чадавх бүхий Зэвсэгт хүчинтэй болох Дайчилгааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах нөөцийг дотооддоо үйлдвэрлэж, зарим бүтээгдэхүүн нийлүүлэлтийн хараат бус байдлыг хангах Зэвсэгт хүчний Энхийг дэмжих ажиллагаанд оролцох оролцоо, чадавх бэхжүүлэх Батлан хамгаалах төсвийг хэрэглээний төсвөөс хөгжлийн төсөвт хүргэж, батлан хамгаалах аж үйлдвэрийн цогц үйлчилгээ, бүтээгдэхүүнээр захиалагч, хэрэглэгчийг бүрэн хангах 	<ol style="list-style-type: none"> Орон нутгийн хамгаалалтын тайван болон дайны байдлын үед хэрэгжүүлэх үндсэн арга хэмжээний бэлтгэлийг хангах Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын зэвсэглэл, техникийн байлдааны болон бусад үүрэг гүйцэтгэх боломжийг бүрэн хангах Дайчилгааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах нөөц бүрдүүлж, дайчилгааны бэлэн байдлын чадавхыг нэмэгдүүлэх Зэвсэгт хүчин энхийг дэмжих ажиллагаанд оролцох мэргэжлийн, чадварлаг, олон талт үүрэг гүйцэтгэх өндөр чадвартай хүний нөөцөөр хангаж, улс орны болоод бүс нутгийн хаана ч үүрэг гүйцэтгэх чадавхтай болгох Батлан хамгаалах хөгжлийн төсөвт тулгуурлан олон улсын стандарт, шаардлагыг хангасан бүтээгдэхүүн экспортлогч болох

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 7.1.1. Боловсролын бүх шатанд цэрэг-эх оронч хүмүүжил олгох сургалтын хөтөлбөр боловсруулж, тусгай анги танхим байгуулна.
- 7.1.2. Орон нутгийн хамгаалалтын тайван цагийн үндсэн арга хэмжээг зохион байгуулах чадавх, сургалтын тогтолцоог бэхжүүлж, томилгоот нэгжийн бэлтгэлжилтийг хангана.
- 7.1.3. Орон нутгийн хамгаалалтын нөөц бүрдүүлэх, мэдээллийн нэгдсэн тогтолцоо байгуулах ажлыг хэрэгжүүлнэ.
- 7.1.4. Мэргэшсэн чадварлаг байнгын бүрэлдэхүүнтэй, хөдөлгөөн, гал, цохилтын өндөр боломжтой хуурай замын цэргийн нэгтгэл, анги, салбарын тоог нэмэгдүүлж, Зэвсэгт хүчний ачаа, тээврийн боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр шаардлагатай техник, хэрэгслээр хангана.
- 7.1.5. Агаарын цэргийн командлалыг хөгжүүлж, агаарын хил, орон зайг хянах, улсын онц чухал, стратегийн ач холбогдолтой объектыг хамгаалах чадавхыг нэмэгдүүлж, Агаарын цэргийн зенит пуужингийн хороо, радиотехникийн батальонууд болон РЭТ-ийн батальон шинээр байгуулна.
- 7.1.6. Зэвсэгт хүчний нэгтгэл, анги салбаруудыг туулах чадвар сайтай тусгай зориулалтын хуягласан техник, хэрэгслээр хангана.
- 7.1.7. Цэргийн удирдлага, холбоо мэдээллийн хэрэгслийг шинэчилж, аюулгүй байдлыг хангах, кибер халдлагатай тэмцэх чадавхыг нэмэгдүүлнэ.
- 7.1.8. Дайчилгааны нөөц бий болгох батлан хамгаалахын нөөцийн менежментийн урт, дунд хугацааны бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.
- 7.1.9. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтын төвийг бүсчлэн байгуулна.
- 7.1.10. Энхийг дэмжих ажиллагааны анги, салбаруудыг орчин үеийн зэвсэглэл, техникээр хангаж, түргэн байрлах хүчин, шуурхай ажиллагааны бүлгүүд болон Зэвсэгт хүчний 2 дахь батальон, инженерийн ротыг энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгүүлнэ.
- 7.1.11. НҮБ-ын энхийг дэмжих ажиллагааны газар оронд болон олон улсын Цэргийн хүчний командлалын өндөр албан тушаалд ажиллах хүний нөөцийг бэлтгэх, үүрэг гүйцэтгүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 7.1.12. Төсвийн тухай хуульд Батлан хамгаалах төсвийг тогтвортой өсгөхөд чиглэгдсэн зүйл, заалт тусгаж, улсын төсвийн зарлагын дүнд эзлэх хувийг хуульчлан тогтооно.
- 7.1.13. Батлан хамгаалах салбарт инновацийн тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгож, тэргүүлэх чиглэлийг тодорхойлон, мэргэшсэн инженер, техникийн алба хаагчдыг үе шаттай бэлтгэх сургалтын тогтолцоог бий болгож, тэтгэлэгт хөтөлбөрт хамруулна.
- 7.1.14. Улсыг хөгжүүлэх стратегийн ач холбогдолтой бүтээн байгуулалтын ажиллагаанд оролцох анги, салбар нэгжийн чадавхыг нэмэгдүүлнэ.

ХААНЫ ЭРЭЛД ОЛОН УЛСЫН СУРГУУЛИЛТ

Олон улсад энхийг сахиулах, болон улс орнуудын бүтээн байгуулалтад оролцох бодлогын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний нэг нь бүс нутгийн аюулгүй байдал, энх тайвныг сурталчлах Хааны эрэлд олон улсын сургуулилт мөн.

Тус сургууилтыг 2003 оноос эхлэн АНУ-ын Энэтхэг-Номхон далайн командлалын дэмжлэгтэйгээр Монгол Улсын Зэвсэгт Хүчин жил бүр уламжлал болгон зохион байгуулж ирсэн. Тус сургуулилтаар энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх цэргийн багийн ажиллагааны өмнөх бэлтгэлийг зохион байгуулж, алба хаагчдын энхийг дэмжих ажиллагааны чадавхыг нэмэгдүүлж, цэргийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, НҮБ-ын энхийг дэмжих ажиллагааны арга техникийг эзэмшүүлж НҮБ-ын сургалтын батламж олгодог Монгол Улсын Зэвсэгт хүчний хамтын ажиллагааны, чадавхыг нэмэгдүүлэх арга хэмжээ юм. Цаашлаад бүс нутгийн орнуудын цэргийн итгэлцэл нөхөрлөлийг гүнзгийрүүлэн хамтын ажиллагааг өргөжүүлж мэдлэг туршлагаа хуваалцах боломжийг бүрдүүлж өгдөг ач холбогдолтой.



ЭНХИЙГ ДЭМЖИХ
АЖИЛЛАГААНЫ АНГИ
САЛБАРУУДЫГ ОРЧИН
ҮЕИЙН ЗЭВСЭГЛЭЛ,
ТЕХНИКЭЭР ХАНГАХ



ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ,
ҮЙЛ АЖИЛЛАГАА



ТҮРГЭН БАЙРЛАХ ХҮЧИН БОЛОН
ШУУРХАЙ АЖИЛЛАГААНЫ БҮЛГҮҮДИЙГ
ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЖ ЭХЛҮҮЛЭХ



ӨМНӨД СУДАН УЛСАД
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭЖ БҮЙ
МОТОБУУДЛАГЫН БАТАЛЬОНЫ
ЗЭВСЭГЛЭЛ, ТЕХНИКИЙГ
ШИНЭЧИЛЖ, НӨХӨН ХАНГАЛТ
ХИЙХ ГАЗАР ОРОН ДЭЭР ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭЖ БҮЙ БАТАЛЬОНООС
ТУСДАА ХОЁРООС ДООШГҮЙ
БАТАЛЬОНЫГ БЭЛЭН БАЙЛДАЛД
АЖИЛЛУУЛАХ

ИНЖЕНЕРИЙН РОТЫГ
НЭГДСЭН ҮНДЭСНИЙ
БАЙГУУЛЛАГЫН
СТАНДАРТ ШААРДЛАГАД
НИЙЦСЭН ТЕХНИК,
ТУСГАЙ ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖ,
ХАМГААЛАХ
ХЭРЭГСЛЭЭР ХАНГАХ



- 7.1.15. Батлан хамгаалах эрх ашигт нийцсэн технологийн инкубатор, туршилтын үйлдвэр, технологи дамжуулах төв, экосистем, шинжлэх ухааны парк байгуулж, батлан хамгаалахын болон иргэний зарим бүтээгдэхүүнийг зохион бүтээж, туршина.
- 7.1.16. Дэвшилтэт технологийг нутагшуулах замаар дотоодын зах зээл дээр өрсөлдөх чадвараа нэмэгдүүлж, гадаад зах зээлээс хараат байдлыг бууруулна.
- 7.1.17. Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж, хөрөнгийн зориулалтыг төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхэд зарцуулна.

ДАРХАН ХИЛ

ЗОРИЛТ 7.2. Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангаж, хил хамгаалалтын чадавхыг дээшлүүлнэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020-2030)	II үе шат (2031-2040)	III үе шат (2041-2050)
НЭГДМЭЛ ТОГТОЛЦООТой, ТЕХНОЛОГИЖСОН ХИЛ ХАМГААЛАЛТ	МЭРГЭШСЭН ХИЛ ХАМГААЛАЛТ	ХАЛДАШГҮЙ ДАРХАН ХИЛ
Бүсчилсэн хил хамгаалалтыг хөгжүүлж, цэргийн холбоо, зэвсэглэл, техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх үе	Мэргэшсэн хилчинд суурилсан, технологжсон хил хамгаалах албыг бэхжүүлэх үе	Хил хамгаалалтын чадавхыг бэхжүүлж, гадаадын ижил төстэй байгууллага, хөрш орнуудын түвшинд хүргэх үе
<ol style="list-style-type: none"> Хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын Олон улсын гэрээ, хэлэлцээрийг боловсронгуй болгох Бүсчилсэн хил хамгаалалтын тогтолцоог бэхжүүлж, бүс нутгийн онцлогт тохирсон хил хамгаалалтын арга тактикийг шинэчлэх, бүтцийг бий болгох Улсын хил хамгаалалт, хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд орчин үеийн цэргийн холбоо, зэвсэглэл, техник, технологи, арга туршлагыг нэвтрүүлж, албаны бэлэн байдлыг дээшлүүлэх Улсын хил хамгаалалтын зориулалттай барилга байгууламж, дэд бүтэц, инженерийн төхөөрөмжийн 50-иас доошгүй хувийг шинэчлэх 	<ol style="list-style-type: none"> Бүсчилсэн хил хамгаалалттай уялдсан удирдлага, хяналтын тогтолцоог хөгжүүлэх Мэргэшсэн гэрээт хилчний албыг бэхжүүлэх Улсын хил хамгаалалтад хиймэл оюун ухаан, хяналт шалгалтын технологийн шинэчлэлийг нэвтрүүлж, хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх чадавхыг дээшлүүлэх Улсын хил хамгаалалтын зориулалттай барилга байгууламж, дэд бүтэц, инженерийн төхөөрөмжийн 70-иас доошгүй хувийг шинэчлэх Бүс нутгийн онцлогт тохируулан хилчдийн болон ард иргэдийн нийгмийн хамгааллыг бэхжүүлэх 	<ol style="list-style-type: none"> Цахим технологид суурилсан хил хамгааллыг бэхжүүлж, найдвартай, шуурхай байдлыг хангах Хил хамгаалах албаны байнгын бэлэн байдал, чадавхыг сайжруулах Улсын хил хамгаалалтын зориулалттай барилга байгууламж, дэд бүтэц, инженерийн төхөөрөмжийн бүрэн шинэчлэх Хил хамгаалалтын чадавхыг гадаадын ижил төстэй байгууллага, хөрш орнуудын түвшинд хүргэх

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХИЛИЙН АСУУДЛААР МОНГОЛ УЛСЫН НЭГДЭН ОРСОН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, ХЭЛЭЛЦЭЭРИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР

7.2.1. Хилийн асуудлаар Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ, хэлэлцээрийг боловсронгуй болгож, хилийн шугамын дагуу хамтарсан шалгалт явуулна.

БҮСЧИЛСЭН ХИЛ ХАМГААЛАЛТЫН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЖ, БҮС НУТГИЙН ОНЦЛОГТ ТОХИРСОН ХИЛ ХАМГААЛАЛТЫН АРГА ТАКТИКИЙГ ШИНЭЧЛЭХ, БҮТЦИЙГ БИЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР

7.2.2. “Бүсчилсэн хил хамгаалалт” хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, орчин үеийн чиг хандлагад нийцсэн бүтэц, хангалтын тогтолцоог бий болгоно.

7.2.3. Хил хамгаалалтын арга, тактикийг бүсийн онцлогт тохируулан хилийн зөрчил, хууль бус үйл ажиллагаатай тэмцэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглүүлэн Монгол Улсын хил хамгаалалтын дүрмийг шинэчилнэ.

7.2.4. Алслагдсан хилийн хэсэгт отряд, застав шинээр байгуулж, хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлнэ.

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТ, ХИЛИЙН БООМТЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРЧИН ҮЕИЙН ЦЭРГИЙН ХОЛБОО, ЗЭВСЭГЛЭЛ, ТЕХНИК, ТЕХНОЛОГИ, АРГА ТУРШЛАГЫГ НЭВТРҮҮЛЖ, АЛБАНЫ БЭЛЭН БАЙДЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

7.2.5. Орчин үеийн дэвшилтэт техник, технологид суурилсан Монгол Улсын хил хамгаалалтын удирдлага, хяналтын төв, бүсийн хилийн удирдах газруудыг байгуулж, хил хамгаалалтад шилжүүлнэ.

7.2.6. Улсын хилийг агаараас хянах системд шилжүүлж, хиймэл дагуулыг хил хамгаалалтад ашиглана.

7.2.7. Улсын хил хамгаалалт, хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд орчин үеийн цэргийн холбоо, зэвсэглэл, техник, технологи, арга туршлагыг нэвтрүүлж, хангана.

7.2.8. Хилийн боомтуудыг өндөр хурдны шилэн кабелийн сүлжээнд холбоно.

7.2.9. Чөлөөт бүс болон хилийн боомтуудад орчин үеийн хяналт шалгалтын техник хэрэгсэл, дэвшилтэт технологийг үе шаттай нэвтрүүлнэ.

7.2.10. Хүний биеийн давхцахгүй өгөгдөлд тулгуурласан ухаалаг цахим гарцыг шалган нэвтрүүлэх албанд нэвтрүүлнэ.

7.2.11. Төмөр замын дэд бүтэц шийдэгдсэн хилийн боомтод төмөр замын шалган нэвтрүүлэх салбарыг шинээр байгуулна.

МЭРГЭШСЭН ГЭРЭЭТ ХИЛЧНИЙ АЛБЫГ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

7.2.12. Мэргэшсэн гэрээт хилчин бэлтгэх төвийг шинээр байгуулна.

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТЫН ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ДЭД БҮТЭЦ, ИНЖЕНЕРИЙН ТӨХӨӨРӨМЖИЙН ШИНЭЧЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

7.2.13. Бүсчилсэн хил хамгаалалтын бодлоготой уялдуулан хилийн отряд, застав, харуул, боомтын барилга, байгууламжийн тодорхой хувийг цахилгаан эрчим хүчний төвлөрсөн шугамд холбоно.

7.2.14. Улсын хил хамгаалалтын дэд бүтэц, инженер, техникийн байгууламжийг шинэчилж, хариуцсан нэгжийг бүсчлэн байгуулна.

7.2.15. Хил орчмын нутаг дэвсгэрт суурьшиж буй иргэдийн аюулгүй байдлыг хангаж, нийгмийн хамгааллыг сайжруулна.

7.2.16. Улсын хил хамгаалалтын зориулалттай “Барилга байгууламжийн шинэчлэл” хөтөлбөр гаргаж хэрэгжүүлнэ.

ХҮН, НИЙГМИЙН АМАР ТАЙВАН БАЙДАЛ

ЗОРИЛТ 7.3. Уламжлалт бус аюулын эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, хүн-нийгмийн амар тайван орчныг бэхжүүлнэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
ЧАДАВХАД СУУРИЛСАН, ТЕХНОЛОГИЖСОН ТОГТОЛЦОО	АЮУЛГҮЙ ХҮН-НИЙГМИЙН ТӨЛӨӨХ ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛЭХ ТОГТОЛЦОО	АЮУЛГҮЙ ХҮН-НИЙГЭМ
Уламжлалт бус аюулын хүчин зүйлсийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, төр, хувийн хэвшил, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх үе	Эрсдэлийг бууруулахад чиглэсэн бодлого, техникийн шийдэл, нөлөөллийн цогц арга хэмжээ хэрэгжүүлж, олон улсын хамтын ажиллагааг тогтмолжуулах үе	Эрсдэлийг даван туулах, чадавхыг бэхжүүлж, хүн-нийгмийн аюулгүй байдлын хангаж, бэхжүүлэх үе
<p>1. Хууль сахиулах болон тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын зохион байгуулалт, үүрэг гүйцэтгэх чадавхыг нийгмийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх</p> <p>2. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчинг боловсронгуй болгож, иргэдийг гэмт хэрэгт өртөх, хохирохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй тэмцэх тогтолцоонд инновацид суурилсан техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, нөлөөллийн арга хэмжээг цогцоор хэрэгжүүлснээр урьдчилан сэргийлэх чадавхыг дээшлүүлж, гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлнэ.</p>	<p>1. Шинжлэх ухааны ололтод суурилсан судалгаа, шинжилгээний төвийг өргөжүүлж, шинжилгээ хийх нөхцөлийг сайжруулах замаар хууль хяналтын байгууллагуудын харилцан ойлголцол, хамтын ажиллагааг хөгжүүлэх</p> <p>2. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үндэсний чадавхыг бэхжүүлэх чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх</p>	<p>1. Хууль сахиулах болон тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын үүрэг гүйцэтгэх чадавхыг олон улсын түвшинд өрсөлдөх хэмжээнд хүргэх</p>

3. Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлж, тогтолцоог бэхжүүлж, улсын хэмжээний гамшгийн эрсдэлийн түвшинг бүрэн тодорхойлох

3. Хот төлөвлөлтөд гамшгийн эрсдэлийг тооцох, гамшгаас сэргийлэх үндэсний болон орон нутгийн чадавхыг бэхжүүлж, гамшигт тэсвэртэй дэд бүтцийг бий болгох

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХУУЛЬ САХИУЛАХ БОЛОН ТУСГАЙ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ ЧАДАВХЫГ НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГАД НИЙЦҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 7.3.1. Дотоодын цэргийн хамгаалалтад шилжээгүй дулааны цахилгаан станц, зарим аймгийн төв болон хүн амын суурьшилд, иргэдийн хөдөлгөөний нягтаршилт ихтэй сумдын ус хангамжийн эх үүсвэрийн барилга, байгууламжийг хамгаалалтад авч, иргэдийн аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 7.3.2. Хорих байгууллагын тогтолцоог бүсчилсэн хэлбэрээр өргөжүүлэн хөгжүүлнэ.
- 7.3.3. Орон нутаг дахь цагдан хорих байрыг үе шаттайгаар шинэчлэх, олон улсын стандартад нийцсэн цагдан хорих, баривчлах байрыг шинээр барьж ашиглалтад оруулна.
- 7.3.4. Хорих ял эдлүүлэх орчин нөхцөлийг хүний эрхийг хангасан түвшинд хүргэх замаар “Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага”-ын цогцолбор барилга, байгууламжийг ашиглалтад оруулна.

ҮНДЭСТЭН ДАМНАСАН ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОЖ, ИРГЭДИЙГ ГЭМТ ХЭРЭГТ ӨРТӨХ, ХОХИРОХООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХАМГААЛАХ, ТҮҮНТЭЙ ТЭМЦЭХ ТОГТОЛЦООНД ИННОВАЦИД СУУРИЛСАН ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ДЭВШЛИЙГ НЭВТРҮҮЛЖ, НӨЛӨӨЛЛИЙН АРГА ХЭМЖЭЭГ ЦОГЦООР ХЭРЭГЖҮҮЛЖ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧАДАВХЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 7.3.5. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай /эдийн засгийн, цахим гэмт хэрэг болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хүн худалдаалах г.м/ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж, олон улсын хамтын ажиллагааг тогтмолжуулна.
- 7.3.6. Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан өргөжүүлнэ.
- 7.3.7. Нийслэл, орон нутгийн төвүүдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор хяналтын камерын нэгдсэн төв бий болгож, мэдээлэл, харилцаа холбоо, барилга байгууламжийн дэд бүтцийг орчин үеийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хөгжүүлнэ.

- 7.3.8. Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоог бэхжүүлж, мансууруулах бодис хэрэглэгч, донтогч нарт эрүүл мэнд, сэтгэл зүйн засал, нийгмийн тусламж үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх төвийг бий болгон, олон нийтэд чиглэсэн нөлөөллийн ажлыг цогц байдлаар хэрэгжүүлнэ.
- 7.3.9. Улаанбаатар хотод төвлөрсөн, орон нутаг дахь цагдаагийн байгууллага бүрд стандартын шаардлага хангасан эрүүлжүүлэх байрыг үе шаттайгаар барьж ашиглалтад оруулна.
- 7.3.10. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах төрөлжсөн түр хамгаалах байр, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод мэдээлэл, зөвлөгөө өгөх төвийг байгуулна.
- 7.3.11. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах шууд чиг үүрэг бүхий цагдаагийн алба хаагчдын ашиглах төхөөрөмжийг шинэчилж, сайжруулна.
- 7.3.12. Тусгай чиг үүрэг бүхий байгууллагууд болон хилийн боомтыг хар тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэлийг илрүүлэх орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж, түүхий эд /перкурсор/-д хяналт тавих чиг үүрэг бүхий бүтэц, нохойн сургалтын төв байгуулж, мэдээллийн нэгдсэн сан бий болгоно.

**ОРОН НУТГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ЧАДАВХЫГ НЭМЭГДҮҮЛЖ,
ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЖ, УЛСЫН ХЭМЖЭЭНИЙ ГАМШГИЙН
ЭРСДЭЛИЙН ТҮВШИНГ БҮРЭН ТОДОРХОЙЛОХ ЧИГЛЭЛЭЭР**

- 7.3.13. Гамшгийн үеийн үйл ажиллагааг орон нутгийн зөвлөлөөс мэргэжлийн түвшинд гүйцэтгэх үндэсний чадавхыг бэхжүүлж, орон нутагт анги, салбарыг үе шаттайгаар байгуулна.
- 7.3.14. Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт, хүч хэрэгслийн бэлэн байдлыг сайжруулж, гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох чадавхыг бэхжүүлнэ.
- 7.3.15. Аюулын төрөл бүрээр гамшгийн эрсдэлийг үнэлэх арга, аргачлал, загварчлал боловсруулж, эрсдэлийн үнэлгээ хийнэ.

**ШИНЖЛЭХ УХААНЫ ОЛОЛТОД СУУРИЛСАН СУДАЛГАА,
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙГ ӨРГӨЖҮҮЛЖ, ШИНЖИЛГЭЭ ХИЙХ
НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ ЗАМААР ХУУЛЬ ХЯНАЛТЫН
БАЙГУУЛЛАГУУДЫН ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦОЛ, ХАМТЫН АЖИЛЛАГААГ
ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР**

- 7.3.16. Инновацид суурилсан техник, технологийн шинэчлэлийг сайжруулж, кибер гэмт хэргээс хамааралтай цахим нотлох баримтыг бэхжүүлэх, үнэлэх, хиймэл оюун ухааныг ашиглах чадамжийг хөгжүүлж, энэ чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

**ҮНДЭСТЭН ДАМНАСАН ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ГЭМТ ХЭРЭГТЭЙ
ТЭМЦЭХ, ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ ЧАДАВХЫГ
БЭХЖҮҮЛЭХ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ НЭМЭГДҮҮЛЭХ
ЧИГЛЭЛЭЭР**

- 7.3.17. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх нэгжийн бүтэц, орон тоог өргөжүүлж, чадавхыг нэмэгдүүлэх, уг гэмт хэргийн улмаас хууль бусаар гадагш гарсан хөрөнгийг царцаах, буцаан авах талаар хоёр талт хамтын ажиллагааг хөгжүүлэх, сургалт, мэдээлэл солилцох арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулна.

**ХОТ ТӨЛӨВЛӨЛТӨД ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ ТООЦОХ, ГАМШГААС
СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ БОЛОН ОРОН НУТГИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЖ,
ГАМШИГТ ТЭСВЭРТЭЙ ДЭД БҮТЦИЙГ БИЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР**

- 7.3.18. Хотын нэн чухал дэд бүтцийг хүчитгэх, өргөтгөх, дахин барих, тогтвортой ажиллагааг нь хангах замаар нийслэл болон хүн ам ихээр төвлөрсөн хот суурин газруудад гамшигт тэсвэртэй дэд бүтэц бий болгоно.
- 7.3.19. Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хамгаалах үйл ажиллагаанд сансрын болон бусад дэвшилтэт арга технологи, техник хэрэгсэл, багаж төхөөрөмж нэвтрүүлж, гамшигтай тэмцэх үндэсний чадавхыг бэхжүүлж, олон улсын түвшинд хүргэнэ.
- 7.3.20. Гамшиг судлалын судалгаа шинжилгээг хөгжүүлж, гамшгаас учирсан хохирол, сэргээн босгох хэрэгцээг тооцох арга, технологи боловсруулж, гамшгийн мэдээллийн сан, үндэсний гамшгийн менежментийг хөгжүүлнэ.
- 7.3.21. Гамшгийн аюул, өртөнгө, эмзэг байдлыг бууруулах, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно.
- 7.3.22. Хот суурин газарт гал түймэр унтраах ангийг стандартад нийцүүлэн нэмж байгуулах, гал түймрийг илрүүлэх, унтраах чиглэлд дэвшилтэт арга технологи, шинэ техник, багаж төхөөрөмжийг нэвтрүүлнэ.

**ХУУЛЬ САХИУЛАХ БОЛОН ТУСГАЙ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ
БАЙГУУЛЛАГУУДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ ЧАДАВХЫГ ОЛОН УЛСЫН
ТҮВШИНД ӨРСӨЛДӨХ ХЭМЖЭЭНД ХҮРГЭХ ЧИГЛЭЛЭЭР**

- 7.3.23. Хууль сахиулах болон тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудад нисэхийн нэгж байгуулж, нисдэг тэрэг /автожир/-ний хангалтыг үе шаттайгаар хийнэ.
- 7.3.24. Хүмүүнлэгийн тусламжийн логистикийн төвтэй болно.

ХУУЛЬ САХИУЛАХ САЛБАРЫН ХӨГЖИЛ

ЗОРИЛТ 7.4 Хууль сахиулах салбарын эрх зүйн орчинг сайжруулан, бүтээн байгуулалтыг дэмжих, ажиллах нөхцөлийг сайжруулах, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэн өрсөлдөх чадварыг хөгжүүлнэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
МЭРГЭШСЭН, ЧАДВАРЛАГ ХУУЛЬ САХИУЛАХ АЛБА	НАЙДВАРТАЙ, ШУУРХАЙ ХУУЛЬ САХИУЛАХ АЛБА	ТЕХНОЛОГИЖСОН ХУУЛЬ САХИУЛАХ АЛБА
Хууль сахиулах салбарын эрх зүйн орчин, материаллаг баазыг бэхжүүлж, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх үе	Хууль сахиулах салбарын бүтээн байгуулалтыг дэмжиж иргэдэд үзүүлэх үйлчилгээний найдвартай, шуурхай байдлыг бэхжүүлэх үе	Өндөр технологид суурилсан үндэсний чадавхыг хөгжүүлж, аюулгүй байдлыг хөгжингүй улсын түвшинд ойртуулах үе
<ol style="list-style-type: none"> 1. Эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэх, салбарын алба хаагчдыг бэлтгэх, мэргэшүүлэх тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх 2. Салбарын хөгжил, удирдлагын тогтолцоог бэхжүүлж, байгууллагуудын барилга, байгууламж, дэд бүтцийг системтэйгээр шинэчлэн хөгжүүлэх 3. Салбарын үйл ажиллагаанд шинжлэх ухааны өндөр түвшний технологийг нэвтрүүлэх бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгож, судалгаа, шинжилгээний баазыг бэхжүүлэх 	<ol style="list-style-type: none"> 1. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем болон оюуны өмчийн эрхийн хамгаалалтын системд хиймэл оюун ухаанд суурилсан системийг нэвтрүүлэн, хөгжүүлэх 2. Салбарын инновацийн үйл ажиллагааг дэмжих, эрх зүйн орчинг бүрдүүлэх 	<ol style="list-style-type: none"> 1. Салбарын үйл ажиллагаанд технологийн дэвшилд суурилсан, хүний оролцоог багасгасан, ухаалаг системүүдийг нэвтрүүлэх

4. Шүүхийн шинжилгээний байгууллагын техник, тоног төхөөрөмж болон хүний нөөцийн чадамжийг сайжруулах

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙГ ГҮНЗГИЙРҮҮЛЭХ, САЛБАРЫН АЛБА ХААГЧДЫГ БЭЛТГЭХ, МЭРГЭШҮҮЛЭХ ТОГТОЛЦООГ ОЛОН УЛСЫН ЖИШИГТ НИЙЦҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЖ, МЭРГЭШСЭН ЧАДВАРЛАГ ХҮНИЙ НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 7.4.1. Салбарын эрх зүйн шинэтгэлийг нийгмийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төгөлдөржүүлнэ.
- 7.4.2. Алба хаагчдыг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлнэ.
- 7.4.3. Салбарын алба хаагчдын цалин, хөлсний нэмэгдлийг тухайн жилийн инфляцын өсөлт, өндөр хөгжилтэй орны ижил төрлийн байгууллагын түвшинд хүргэнэ.

САЛБАРЫН ХӨГЖИЛ, УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЖ, БАЙГУУЛЛАГУУДЫН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ, ДЭД БҮТЦИЙГ СИСТЕМТЭЙГЭЭР ШИНЭЧЛЭН ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

- 7.4.4. Яаралтай тусламжийн дуудлага, мэдээллийг хүлээн авах, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй болгож, цагдаа, онцгой байдал, эмнэлгийн түргэн тусламжийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагааны шуурхай байдлыг хангана.
- 7.4.5. Салбарын алба хаагчдын дүрэмт хувцас, зэвсэг, тусгай хэрэгсэл, тусгай зориулалтын техник хэрэгслийн чанар, стандартыг судлан тогтоож, лаборатори, үйлдвэр байгуулна.
- 7.4.6. Салбарын автомашин, тусгай зориулалтын техник хэрэгслийн хангалтыг үе шаттайгаар шинэчилнэ.
- 7.4.7. Ялын бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хангах, орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор “Цахим хяналтын төв”-ийг байгуулна.
- 7.4.8. Иргэний үнэмлэх, гадаад паспортын бичилт хийх үйлдвэрийг өргөтгөх, бэлдэц үйлдвэрлэх дотоодын үйлдвэр байгуулна.
- 7.4.9. Бүртгэлийн байгууллагын мэдээллийн баазыг бэхжүүлэх, хадгалалтыг сайжруулах зорилгоор сүүлийн үеийн өндөр хүчин чадал бүхий сервер, тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчилнэ.
- 7.4.10. Салбарын болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдыг чадавхжуулах, мэргэшүүлэх, дадлага зохион байгуулах хүчин чадал бүхий сургалтын төв байгуулна.
- 7.4.11. Оюуны өмчийн газрын байр, сургалтын төв, хөгжлийн төвийн цогцолбор барилгыг барьж олон улсын стандартад нийцсэн үйлчилгээг хөгжүүлнэ.

7.4.12. Хууль зүйн туслалцааны төв болон орон нутаг дахь улсын бүртгэлийн хэлтэс, шүүхийн шинжилгээний албаны ажиллах орчныг сайжруулж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

7.4.13. Хоригдлын ахуй нөхцөлийг нийгмийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан хөгжүүлэхэд санхүү, үйлдвэрлэлийн бодлогыг чиглүүлж эдийн засгийн үр ашгийг сайжруулна.

7.4.14. Төрийн тусгай алба хаагчдын эмнэлгийг олон улсын стандартад нийцүүлнэ.

САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШИНЖЛЭХ УХААНЫ ӨНДӨР ТҮВШНИЙ ТЕХНОЛОГИЙГ НЭВТРҮҮЛЭХ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОЖ, СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ БААЗЫГ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

7.4.15. Иргэдэд эрх зүйн албан бус боловсрол олгох чиглэлээр сургалт үйл ажиллагаа зохион байгуулна.

7.4.16. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлэх зорилгоор санхүүжилтийг нэмэгдүүлж, орчин үеийн техник, технологи болон программ хангамжийг нэвтрүүлнэ.

7.4.17. Үндэсний санах ой архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулна.

7.4.18. Монгол Улсын түүх соёлд холбогдох гадаад улсад хадгалагдаж буй баримтыг нээн илрүүлж, худалдан авах ажлыг зохион байгуулна.

7.4.19. Улсын бүртгэлийн мэдээллийн сан газарзүйн өөр байршилд нөөц сантай болгоно.

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БОЛОН ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

7.4.20. Криминалистик, шүүх эмнэлэг болон тусгай шинжилгээний хүчин чадлыг бэхжүүлж, хүний нөөцийг чадавхжуулж, техник-технологийн дэвшлийг нэвтрүүлж, шинжилгээ хийх нөхцөлийг сайжруулна.

7.4.21. Шинжилгээний лабораториудад шинжилгээ хийх шинэ арга, аргачлалыг нэвтрүүлж, ДНХ, хими, физик, биологийн лабораториудыг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, метохондр, бактериологийн шинжилгээний лабораториудыг шинээр байгуулна.

7.4.22. ДНХ-ийн нэгдсэн сан бий болгож, эрэн сурвалжлах болон нууц далд аргаар үйлдсэн, эзэн холбогдогч нь тогтоогдоогүй гэмт хэргийг илрүүлэхэд ашиглана.

ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ БОЛОН ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙН ХАМГААЛАЛТЫН СИСТЕМД ХИЙМЭЛ ОЮУН УХААНД СУУРИЛСАН СИСТЕМИЙГ НЭВТРҮҮЛЭН, ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

7.4.23. Эрх зүйн нэгдсэн систем болон оюуны өмчийн салбарт хиймэл оюун ухаанд суурилсан системийг нэвтрүүлэн хөгжүүлнэ.

7.4.24. Оюуны өмчийн хяналтын системийг боловсронгуй болгоно.

САЛБАРЫН ИННОВАЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ, ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

7.4.25. Салбарын инновацийн үйл ажиллагааг дэмжих, гарааны бизнест хөрөнгө оруулалт хийхэд чиглэсэн тусгай хөрөнгө оруулалтын сан байгуулж, ажиллах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

7.4.26. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын технологийн дэвшлийг инновацид суурилан хөгжүүлнэ.

7.4.27. Дотоод хэргийн их сургуулийн шинжлэх ухаан, инновацийн чадавхыг нэмэгдүүлнэ.

САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШИНЭ ТЕХНОЛОГИ ДЭЭР СУУРИЛСАН, ХҮНИЙ ОРОЛЦООГ БАГАСГАСАН, УХААЛАГ СИСТЕМҮҮДИЙГ НЭВТРҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

7.4.28. Хоригдогсдын хорих анги, байгууллагын дотоод үйлчилгээнд цахим картын системийг нэвтрүүлнэ.

7.4.29. Хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэл, танилтын системийг нэвтрүүлнэ.

7.4.30. Дараа үеийн суурин болон хөдөлгөөнт холбооны технологийн дэвшилд тулгуурласан цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон харилцаа холбооны шийдлийг нэвтрүүлнэ.

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

ЗОРИЛТ 7.5. Төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулж, өрсөлдөх чадвар бий болгоно.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
КИБЕР ОРЧНЫ ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ- ҮНДЭСНИЙ ЧАДАВХ	МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАР- АЮУЛГҮЙ БАЙДАЛ	МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ШИНЭТГЭЛ
Кибер аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин бүрдүүлж, технологид суурилсан инноваци, интеграцыг хөгжүүлж, эрсдэлийн менежментийн үндэсний чадавхыг бэхжүүлэх үе	Цахим мэдээллийн болон мэдээллийн технологийн инновацийг хөгжүүлж, үндэсний чадавхыг нэмэгдүүлэх үе	Цахим мэдээллийн болон мэдээллийн технологийн инновацийг хөгжүүлж, үндэсний чадавхыг нэмэгдүүлэх үе
<p>1. Кибер аюулгүй байдлыг хангах тогтолцоог бэхжүүлэх</p> <p>2. Сансрын технологийг судлан шинжлэх, эзэмших, ашиглах чадамж, дэд бүтцийг бэхжүүлж, сансрын технологид суурилсан үндэсний бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох</p> <p>3. Мэдээлэл, технологи, харилцаа холбооны систем, техник хэрэгсэл, программ хангамжийн үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн тогтолцоог бүрдүүлж, технологийн хараат байдлыг бууруулж, кибер гэмт хэрэг, кибер терроризмтой тэмцэх чадавхыг бэхжүүлэх</p>	<p>1. Мэдээллийн технологийн судалгаа шинжилгээг хөгжүүлэн, инноваци нэвтрүүлж, аюулгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх</p> <p>2. Сансрын холбооны үндэсний хиймэл дагуулын шинэ сүлжээ байгуулж, үндэсний харилцаа холбооны сүлжээний ашиглалт, хяналтын менежментийг хөгжүүлж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах</p>	<p>1. Үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, төр, иргэн, байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх чадавхыг бүс нутгийн болон олон улсын түвшинд өрсөлдөхүйц хэмжээнд хүргэх</p> <p>2. Сансрын технологийн тусламжтайгаар байгалийн гамшгаас сэрэмжлүүлэх систем, хилийн болон газар нутгийн хяналт, боловсрол, эрүүл мэндийн зайны үйлчилгээг хөгжүүлж, улс орны эдийн засаг, аюулгүй байдал, бизнесийн өрсөлдөх чадварт үр ашиг бий болгох</p>

- Мэдээлэл, технологи, харилцаа холбооны систем, техник хэрэгсэл, программ хангамжийн үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн тогтолцоог бүрдүүлж, технологийн хараат байдлыг бууруулж, кибер гэмт хэрэг, кибер терроризмтой тэмцэх чадавхыг бэхжүүлэх
- Төрийн байгууллагуудын цахим мэдээллийн сан бүрдүүлж, төрийн болон албаны нууц задарч үрэгдэхээс урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлж, төрийн нууц задруулах, үрэгдүүлэх гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах

- Төрийн байгууллагуудын цахим мэдээллийн сан, түүний дэд бүтцийн аюулгүй байдлыг хангах, чадавхыг нэмэгдүүлж, мэдээллийн аюулгүй байдлын шийдэл боловсруулах тогтолцоог бэхжүүлэх
- Төрийн болон албаны нууц задарч үрэгдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг нэмэгдүүлэх

- Мэдээлэл, технологийн салбар дахь ололтыг зөв манипуляци хийж, шинэ мэдлэг буй болгох замаар инновацийг хөгжүүлэх, аюулгүй байдлын менежментийн чадавхыг хөгжингүй улсын түвшинд ойртуулах
- Төрийн байгууллагуудын өгөгдлийн сан, төрийн болон албаны нууцыг бүрэн хамгаалах

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭМЗЭГ БАЙДЛЫГ БУУРУУЛАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХАЛДЛАГАД ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛЭХ ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

- Үндэсний мэдээллийн дэд бүтцэд халдах халдлагыг илрүүлэх, таслан зогсоох чадавх бий болгож, кибер гэмт хэрэгтэй тэмцэнэ.
- Кибер аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин бүрдүүлж, хяналт шалгалтын тогтолцоог бэхжүүлж, кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлэх, төрийн албан хаагч, иргэдийн технологийн мэдлэг, инновацийг ашиглах чадавхыг дээшлүүлнэ.
- Мэдээллийн технологийн судалгаа шинжилгээг өргөжүүлж, мэдлэгт суурилсан инновацийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, уян болон хатуу дэд бүтцийг хөгжүүлж, кибер аюулгүй байдлын чиглэлээр судалгаа, шинжилгээ хийдэг олон улсын ба бүс нутгийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, Монгол Улсын мэдээллийн аюулгүй байдлыг олон улсын түвшинд хүргэнэ.
- Үндэсний мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэд бүтцэд халдах, эдийн засаг, нийгмийн чадавхыг сулруулах оролдлоготой тэмцэх чадавх бүхий үндэсний **CERT (Computer emergency readiness team)**-ийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- Цахим мэдээллийг ангилах, тодорхойлох, үнэлэх, төрийн мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийн эмзэг, сул байдлыг илрүүлэх, эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж байх талаар холбогдох хууль, дүрэм, журамд тусган онц чухал дэд бүтэц бүхий байгууллагуудад цахим халдлагатай тэмцэх баг бий болгож мэргэшсэн хүний нөөц бэлтгэж, хөгжүүлнэ.
- Цахим мэдээллийн аюулгүй байдлын эмзэг байдлыг бууруулах, урьдчилан

сэргийлэх, халдлагад хариу үйлдэл үзүүлэх чадавхыг бэхжүүлнэ.

7.5.7. Төрийн албан хаагч, иргэдийн технологийн мэдлэг, инновацийг ашиглах чадавхыг дээшлүүлнэ.

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ, ТӨР-ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТААТАЙ ОРЧИН БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

7.5.8. Мэдээллийн технологийн судалгаа шинжилгээг өргөжүүлж, мэдлэгт суурилсан инновацийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, уян болон хатуу дэд бүтцийг хөгжүүлнэ.

7.5.9. Кибер аюулгүй байдлын чиглэлээр судалгаа, шинжилгээ хийдэг олон улсын ба бүс нутгийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, Монгол Улсын мэдээллийн аюулгүй байдлыг олон улсын түвшинд хүргэнэ.

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ИРГЭДИЙН МЭДЛЭГ, БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ, ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭГ ТӨЛӨВШҮҮЛЭХ, МЭРГЭШСЭН ХҮНИЙ НӨӨЦ БЭЛТГЭХ, ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

7.5.10. Нийгмийн сүлжээ, цахим хуудас, телевизийн нэвтрүүлэг, нийтлэл зэргээр дамжуулан олон нийтийн цахим мэдлэг боловсролыг дээшлүүлэн, соёлтой хэрэглээг нийтэд төлөвшүүлж интернэтийн зохистой хэрэглээг төлөвшүүлж, кибер орчинд хүний эрх, эрх чөлөөг хамгаалах чадавхыг бэхжүүлнэ.

САНСРЫН ТЕХНОЛОГИЙГ СУДЛАН ШИНЖЛЭХ, ЭЗЭМШИХ, АШИГЛАХ ЧАДАМЖ, ДЭД БҮТЦИЙГ БЭХЖҮҮЛЖ, САНСРЫН ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ҮНДЭСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ БИЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР

7.5.11. Сансрын технологид суурилсан гарааны, шинэ компаниуд, сансрын аялал жуулчлалын симуляци хийх нээлттэй баазын судалгаа хийж, гадаад улс орнуудтай хамтран хиймэл дагуул хөөргөж, газрын станц байгуулах хөрөнгө оруулалт татах арга хэмжээ авна.

7.5.12. Сансрын технологийн үндэсний мэргэжилтэн бэлтгэх их сургуулийн хөтөлбөр боловсруулж, сансар судлал ба өндөр технологийн институт байгуулан хөгжүүлнэ.

7.5.13. Сансрын холбооны үндэсний хиймэл дагуулын сүлжээ ашиглан үндэсний харилцаа холбооны сүлжээний ашиглалт, хяналтын менежментийг бүрдүүлэх, уялдуулах сайжруулах сүлжээг өргөтгөн байгуулж ашиглалтын хэвийн нөхцөлийг хангаж ажиллах, төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах цогц үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.

7.5.14. Сансрын технологийг судлан шинжлэх лаборатори байгуулж, үндэсний хиймэл дагуулыг үйлдвэрлэж нэвтрүүлнэ.

МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ СИСТЕМ, ТЕХНИК ХЭРЭГСЭЛ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙН ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ТЕХНОЛОГИЙН ХАРААТ БАЙДЛЫГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

7.5.15. Өрсөлдөх чадвартай мэдээлэл, харилцаа холбооны систем, техник хэрэгсэл, программ хангамж, криптографийн үндэсний үйлдвэрлэл болон мэдээллийн аюулгүй байдлын шийдэл боловсруулах тогтолцоог бэхжүүлнэ.

7.5.16. Тоон гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийг хөгжүүлж, тоон гарын үсгийг бүх нийтийн хэрэглээ болгох, тоон гарын үсгэнд суурилсан цахим үйлчилгээний нууцлал, хамгаалалтыг хангана.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЖ, ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦ ЗАДАРЧ ҮРЭГДЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЖ, ТӨРИЙН НУУЦ ЗАДРУУЛАХ, ҮРЭГДҮҮЛЭХ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ГАРАЛТЫГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

7.5.17. Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээний хамрах хүрээг өргөтгөж (төв болон орон нутаг), хамгаалагдсан интернет болон интранет сүлжээнд төрийн захиргааны байгууллагуудыг бүрэн хамруулах замаар төрийн байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог боловсронгуй болгож, хөгжүүлнэ.

7.5.18. Төрийн байгууллагуудын цахим халдлага зөрчилтэй тэмцэх CERT байгуулж, мэдээллийн урсгалыг хянах замаар эмзэг байдлыг бууруулж, цахим форенסיкийн үндэсний төвийн үйл ажиллагааг өргөтгөн шинэчилнэ.

7.5.19. Төрийн байгууллага болон Монгол Улсаас хилийн чанадад суугаа ДТГ-дыг тусгай хэрэглээний сүлжээнд бүрэн хамруулах, шифр харилцаа нэвтрүүлж, тусгай хэрэглээний радио давтамжийн зурвасын ашиглалт, давтамж хоорондын нөлөөлөлд хяналт тавих техникийн нөхцөлийг бүрдүүлнэ.

7.5.20. Онцгой болон гамшгийн нөхцөл байдлын үед ашиглах зорилгоор нийслэл, аймгийн төвүүдийг холбосон богино долгионы радио холбооны сүлжээ болон хөдөлгөөнт холбооны төвүүдийг өргөтгөж, шинэчилнэ.

7.5.21. Мэдээлэл холбооны дэд бүтцэд холбогдоогүй алслагдсан цэгүүдийг холбосон мэдээлэл дамжуулах, солилцох сүлжээг байгуулна.

7.5.22. Өрсөлдөх чадвартай мэдээлэл, харилцаа холбооны систем, техник хэрэгсэл, программ хангамж, криптографийн үндэсний үйлдвэрлэл болон мэдээллийн аюулгүй байдлын шийдэл боловсруулах тогтолцоог бэхжүүлнэ.

7.5.23. Төрийн нууцыг хууль бусаар олж авах, задруулах, үрэгдүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох чадавхыг дээшлүүлж, алба хаагчдыг мэргэшүүлнэ.

7.5.24. Үндэсний дата төвийн мэдээллийн систем, сүлжээ, өгөгдлийн сангийн хамгаалалтыг сайжруулна.

7.5.25. Үндэсний мэдээллийн дэд бүтцэд халдах халдлагыг илрүүлэх, таслан зогсоох чадавх бий болгож, кибер гэмт хэрэгтэй тэмцэнэ.

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭН, ИННОВАЦИ НЭВТРҮҮЛЖ, АЮУЛГҮЙ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

7.5.27. Төрийн цахим ой санамж болох мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн бүтэн, нэгдмэл, аюулгүй байдлыг хангаж нэг эх сурвалж бүхий мэдээлэл, нээлттэй өгөгдлийг бий болгож хөгжүүлнэ.


САНСРЫН ХОЛБООНЫ ҮНДЭСНИЙ ХИЙМЭЛ ДАГУУЛЫН ШИНЭ СҮЛЖЭЭ БАЙГУУЛЖ, ҮНДЭСНИЙ ХАРИЛЦАА ХОЛБООНЫ СҮЛЖЭЭНИЙ АШИГЛАЛТ, ХЯНАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙГ ХӨГЖҮҮЛЖ, МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

7.5.28. Сансрын холбооны үндэсний хиймэл дагуулын сүлжээ ашиглан үндэсний харилцаа холбооны сүлжээний ашиглалт, хяналтын менежментийг бүрдүүлэх, уялдуулах сайжруулах сүлжээг өргөтгөн байгуулж ашиглалтын хэвийн нөхцөлийг хангаж ажиллах, төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах цогц үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.

7.5.29. Сансрын технологийг судлан шинжлэх лаборатори байгуулж, үндэсний хиймэл дагуулыг үйлдвэрлэж, нэвтрүүлнэ.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САН, ТҮҮНИЙ ДЭД БҮТЦИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, ЧАДАВХЫГ НЭМЭГДҮҮЛЖ, МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ШИЙДЭЛ БОЛОВСРУУЛАХ ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

7.5.30. Төрийн нууцын программ хангамжийг боловсруулж, төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд нэвтрүүлж, төрийн болон албаны нууцын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулна.



Эх сурвалж: Харилцаа холбоо, мэдээлэл технологийн газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Тагнуулын ерөнхий газар

АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ ЗОРИЛГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

Хүснэгт 7.1. Амар тайван, аюулгүй нийгэм зорилгын хэрэгжилтийн хяналт, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин

Тайлбар: * тэмдэглэгээ бүхий шалгуур үзүүлэлтийг шинээр тооцдог болно.

#	Шалгуур үзүүлэлт (indicator)	Хэмжих нэгж	Суурь түвшин	2030	2040	2050	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хаанаас авах эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах аргазүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
7	АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ										
1	Дэлхийн энх тайвны индекс	индекс	1.79	1.49	1.26	1	2020 оны түвшин, хүрсэн үр дүнгээс тооцно.	Эдийн засаг, энх тайвны хүрээлэн (Institute for Economics & Peace)	Дэлхийн энх тайвны индексийн тайлан 2019	жилд 1 удаа	Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
2	Даяаршлын индекс	индекс	56.97	63.99	69.39	74.79	Суурь түвшинг 2017 оноор авсан. 2020 оны түвшин, хүрсэн үр дүнгээс тооцно.	Швейцарын Эдийн засгийн хүрээлэн	2019 KOF Globalisation Index тайлан	-	Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
3	Дотоодын нийт бүтээгдэхүүнд батлан хамгаалах салбарын зардлын эзлэх хувь	хувь	0.7	1.5	1.8	2.0	2020 оны түвшин, хүрсэн үр дүнгээс тооцно.	Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын гүйцэтгэлийн тайлан, бусад мэдээлэл	Жил бүр	Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
4	Хил хамгаалалтын үр дүн	хувь	85.0	88.0	90.0	92.0	2018 оны суурь түвшин	Хил хамгаалах ерөнхий газар	Хил хамгаалах ерөнхий газар гүйцэтгэлийн тайлан, бусад мэдээлэл	Жил бүр	Хууль зүй дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

#	Шалгуур үзүүлэлт (indicator)	Хэмжих нэгж	Суурь түвшин	2030	2040	2050	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хаанаас авах эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах аргазүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
5	Хууль сахиулах салбарын үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн байгууллагаас өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ	хувь	82.1	85.0	90.0	95.0	2020 оны түвшин, хүрсэн үр дүнгээс тооцно.	Хууль зүй дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Хэрэглэгчийн үнэлгээний тайлан	Жил бүр	Хууль зүй дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
6	Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь	хувь	40.0	43.0	49.0	52.0	2018 оны суурь түвшин	Цагдаагийн ерөнхий газар	Цагдаагийн ерөнхий газрын статистик тоон мэдээлэл	Жил бүр	Хууль зүй дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
7	Эрэн сурвалжлагдаж буй хүн, эд зүйлийн илрүүлэлтийн хувь	хувь	66.0	69.0	71.0	75.0	2018 оны суурь түвшин	Цагдаагийн ерөнхий газар	Цагдаагийн ерөнхий газрын статистик тоон мэдээлэл	Жил бүр	Хууль зүй дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
8	Кибер аюулгүй байдлын индексийн оноо	оноо	0.465	0.490	0.530	0.550	2020 оны түвшин, хүрсэн үр дүнгээс тооцно. 85-р байранд (0.465 оноогоор 193 орноос) 2018 он	Олон улсын байгууллагын судалгаа	Судалгааны тайлан	Жил бүр	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
9	Мэдээллийн аюулгүй байдлын эмзэг байдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, халдлагад хариу үйлдэл үзүүлэх төвийн тоо	тоо	0	5	20	40	2018 оны суурь түвшин	Төрийн байгууллага, хувийн хэвшил		Жил бүр	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар



БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ

ДОРНОД МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ТЭНХЛЭГ, ҮЙЛДВЭРЛЭЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, НОГООН ХӨГЖЛИЙН БҮС (ХЭНТИЙ, ДОРНОД, СҮХБААТАР АЙМАГ)

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙ, ӨНДӨР ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ, ПАЛЕОНТОЛОГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БҮС (ГОВЬСҮМБЭР, ДОРНОГОВЬ, ДУНДГОВЬ, ӨМНӨГОВЬ)

БАЙГАЛИЙН НӨӨЦ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, НОГООН ХӨГЖЛИЙН БҮС (ГОВЬ-АЛТАЙ, БАЯНХОНГОР, ӨВӨРХАНГАЙ АЙМАГ)

ӨРНӨД МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ТЭНХЛЭГ, АЛТАЙН СОЁЛ, БАЙГАЛИЙН НӨӨЦ, НОГООН ХӨГЖЛИЙН БҮС (ХОВД, БАЯН-ӨЛГИЙ, УВС АЙМАГ)

ХАНГАЙН ЭРЧИМЖСЭН ХӨДӨӨ АЖ АХУЙ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, НОГООН ХӨГЖЛИЙН БҮС (СЭЛЭНГЭ, ДАРХАН-УУЛ, ОРХОН, БУЛГАН, АРХАНГАЙ, ХӨВСГӨЛ, ЗАВХАН АЙМАГ)

ОЛОН УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТӨВ, ТЭЭВРИЙН ЗАНГИЛАА, ӨНДӨР ТЕХНОЛОГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮС (ТӨВ АЙМАГ, УЛААНБААТАР ХОТ)



БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ

Монгол Улсын бүс нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн гол баримт бичгүүд нь УИХ-ын 2001 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” түүнийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газраас батлан мөрдүүлсэн Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатарын бүсүүдийн хөгжлийн хөтөлбөр байлаа. Эдгээр баримт бичгүүдийн хүчинтэй хугацаа 2018-2020 онд дуусгавар болж, үзэл баримтлал, бодлого, хөтөлбөрийг шинээр боловсруулах эрхзүйн хэрэгцээ шаардлага байна.

Мөн “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, түүнийг хэрэгжүүлэх бүсүүдийн хөгжлийн хөтөлбөр батлагдан хэрэгжиж эхэлснээс хойш 15-20 жилийн хугацаанд Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн дотоод, гадаад орчин, түүнд нөлөөлөх орон зайн хүчин зүйлсийн харьцаа, үндэсний болон бүс нутгийн түвшинд эдийн засгийг зохицуулах арга механизм, түүнд оролцох төрийн оролцоо, чиг үүрэг ихээхэн хувьсан өөрчлөгдсөн байна.

Иймээс Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлогыг шинээр боловсруулах, макро бүсүүдийг шинээр тогтоох практик шаардлага үүсч байна.

Дэлхийн улсууд өөр өөрсдийн орны онцлогтоо тохируулан газар нутгаа бүсчлэн хөгжүүлэх асуудлыг төлөвлөн хэрэгжүүлж байна. Тухайлбал, томоохон газар нутагтай Орос, Хятад, Австрали болон Япон, Франц зэрэг улсын туршлагаас үзэхэд эдийн засгийн макро бүсүүдийг тодорхойлж, төрийн зохицуулалтыг тусгайлсан хууль, тогтоомж гаргаж, түүнийг стратегийн болон индекатив арга хосолсон нэгдсэн төлөвлөлтийн хүрээнд уялдуулан шийдвэрлэж, хэрэгжүүлж байна. Манайд ч ийм туршлага байсан бөгөөд бид үүнийг зах зээлд нийцүүлэн боловсронгуй болгох шаардлагатай байгаа юм.

Зураг 8.1. Монгол Улсын бүсчлэлийн шинэ схемийн төсөл /макро бүс/



Эх сурвалж: Үндэсний хөгжлийн газар, салбарын хөгжлийн бодлого зохицуулалтын газар

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулахдаа эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн төлөвлөлт, хэрэгжүүлэх механизмыг боловсронгуй болгох, бүс нутаг, орон нутаг, салбар хоорондын уялдаа, холбоог нягтруулах, хөрш улсуудын болон бүс нутгийн онцлогтой эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, байгалийн нөөц, газар нутгийн даац, чадавхыг улс орны эдийн засгийн тогтвортой өсөлт, нутаг дэвсгэрийн харьцангуй тэнцвэрт хөгжлийг хангах зорилгод бүрэн, үр ашигтай ашиглах зарчим шалгуурыг үндэс болгоно. Монгол Улсын эдийн засгийн макро бүсүүдийг шинэчлэн тогтооходоо, дараах хүчин зүйлийг харгалзан үзсэн болно. Үүнд:

1. үндэсний аюулгүй байдлын;
2. эдийн засаг, нийгмийн;
3. улс төр, засаг захиргааны;
4. түүх, нийгэм соёлын;
5. чиг үүргийн (функционал буюу үйлдвэрлэл, үйлчилгээний байршил, төрөлжилт);
6. орон зайн бүтэц, зохион байгуулалтын гэх мэт

Эдгээр шалгуур, үндэслэлд тулгуурлан эдийн засгийн зургаан бүсээр улс, орны нутаг дэвсгэрийн хөгжлийг төлөвлөн хэрэгжүүлэх санал боловсрууллаа.

Зураг 8.2. Монгол Улсын бүсчлэлийн шинэ схемийн төсөл /микро бүс/



Эх сурвалж: Үндэсний хөгжлийн газар, салбарын хөгжлийн бодлого зохицуулалтын газар

Мөн Монгол Улсын эдийн засгийн 83 микро бүсийн төв, түүний таталцлын төвүүдийг тодорхойлоод байна. Эдгээр төвүүдийг тодорхойлсноор салбар хоорондын уялдаа, бүсүүдийн хоршилт, төрөлжилтийг дэмжих, бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, байгалийн нөөц, чадавхыг эдийн засгийн өсөлт, нутаг дэвсгэрийн тэнцвэртэй хөгжлийг хангах, нэмүү өртгийн сүлжээ, кластер, үйлдвэрлэлийн бүсийг байгуулах, дэд бүтцийн босоо, хэвтээ тэнхлэгүүдтэй холбогдох тээвэр-логистикийн нэгдсэн сүлжээг бий болгох, ажилгүйдэл ядуурлыг бууруулах, амьдралын орчин нөхцөлийг сайжруулах, нийгмийн үйлчилгээний хангамжийг төрөөс үзүүлэх нийгмийн үйлчилгээний жишиг нормативт нийцүүлэн хангах, орон нутгийн хөрөнгө оруулалтын оновчтой төлөвлөлт хийх, хүн амын шилжилт хөдөлгөөнийг тогтворжуулж төвлөрлийг сааруулах юм.

Бүсчилсэн хөгжлийн эрхэм зорилго нь үндэсний соёлоо дээдэлсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцад нэгдсэн, өрсөлдөх чадвартай, харьцангуй тэнцвэртэй бүсүүдийг хөгжүүлэхэд оршино.

Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилгыг дэвшүүлэн хөгжлийн үе шатуудыг тодорхойллоо.

ДОРНОД МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ТЭНХЛЭГ, ҮЙЛДВЭРЛЭЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, НОГООН ХӨГЖЛИЙН БҮС (Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймаг)

ЗОРИЛТ 8.1 Дорнод Монголын талын экосистемийн унаган төрхийг хадгалж, Зүүн хойд Азийн эдийн засгийн интеграцад идэвхтэй оролцсон, ногоон технологид суурилсан хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, аялал жуулчлалын зохистой хослол бүхий бүс нутаг болгон хөгжүүлнэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
ХӨГЖЛИЙН ДЭД БҮТЭЦ – ТАЛ НУТГИЙН ХӨГЖИЛ	ЭРЧИМЖСЭН АЖ АХУЙ	ХӨГЖЛИЙН КЛАСТЕР
Дэд бүтцийн тэнхлэгийн үндсэн сүлжээг байгуулж, ХАА-н боловсруулах үйлдвэр, аялал жуулчлалыг хөгжүүлэх үе	Усалгаатай газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх үе	Өсөлтийн төвүүдэд түшиглэсэн үйлдвэрлэл, инновацийг хөгжүүлэх үе
<ol style="list-style-type: none"> Дэд бүтцийн тэнхлэг (авто зам, төмөр зам, эрчим хүч, холбоо мэдээлэл)-ийн үндсэн сүлжээг барьж Зүүн хойд Азийн орнуудын эдийн засгийн хамтын ажиллагаанд оролцох суурь нөхцөлийг бүрдүүлэх Хилийн боомт чиглэсэн авто зам, төмөр замуудыг ашиглалтад оруулж, боомтуудыг олон улсын стандартад нийцүүлэн шинэчилж, бүс дамнасан тээвэр логистикийн сүлжээнд холбогдох 	<ol style="list-style-type: none"> Усалгаатай газар тариаланг хөгжүүлэн бүсийн үр тариа, төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн хэрэгцээг ханган, бусад бүсэд нийлүүлэх Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлж, УТП байгуулан олон улсын стандарт, шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортлох 	<ol style="list-style-type: none"> Шинжлэх ухаан, өндөр технологийн туршилт, судалгаа-хөгжүүлэлтийн төв байгуулах Ногоон технологид суурилсан хөнгөн үйлдвэр, барилгын материалын үйлдвэрлэлийн кластер, төвүүдийг хөгжүүлэх Түүхэн аялал жуулчлалын кластер, төвүүдийг хөгжүүлэх

3. ХАА-н тээвэр логистикийн төвүүдийг микро бүсийн төвүүдэд байгуулж, авто замаар холбон хүнсний бараа бүтээгдэхүүн, хөдөө аж ахуйн түүхийг эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг дэмжих
4. Малын өвчингүй эрүүл, халдваргүй бүс нутаг болж, малчдад мэдээлэл хүргэх тогтолцоог хөгжүүлэн Дорнод Монголын талын эко системд зохицсон бэлчээрийн мал аж ахуйг дэмжих
5. Ногоон технологид суурилсан, экспортод чиглэсэн ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэн, бүсийн дотоод хэрэгцээг хангаж, гадаадын орнуудад экспортлох
6. Аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэн, Монголын түүхэн аялал жуулчлалын төв бүс болох
7. Газрын тос, байгалийн хийн хайгуул судалгааны ажлыг эрчимжүүлж, нөөцийг нэмэгдүүлэх
8. Мезо, микро бүсүүдийн төвийн инженерийн дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний барилга, байгууламжийн чанар, үйлчилгээний хүртээмжийг төрөөс үзүүлэх нийгмийн үйлчилгээний жишиг нормативт нийцүүлэн иргэдийн эрүүл, аюулгүй ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх

3. Экспортын чиглэлийн төмөр зам барьж, өндөр технологийн Хүнд аж үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах
4. Мезо, микро бүсийн төвүүдийг улсын чанартай авто замын сүлжээтэй холбох
5. Түүх, соёлын өвд түшиглэсэн, аялал жуулчлалын хот, сууринг олон улсын ногоон хотын норм, стандартын дагуу төлөвлөж, хөгжүүлэх

4. Соёлын болон бүтээлч аж үйлдвэрлэлийг хөгжүүлж, орон нутгийн брэнд бүтээгдэхүүн бий болгох
5. Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу бүсийн ногоон хот, суурины сүлжээг хөгжүүлэн иргэд төрж, өссөн нутагтаа аз жаргалтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

8.1.1. Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системийн хөндлөн тэнхлэгийн гол шугамд холбогдох Чойбалсан-Өндөрхаан-Багануурын ЦДАШ-ыг барьж байгуулан бүсийн эрчим хүчний хэрэгцээг хангах эх үүсвэр-Чойбалсангийн ДЦС-ыг өргөтгөнө.

Хүснэгт 8.1. Дорнод Монголын эдийн засгийн хөгжлийн тэнхлэг, үйлдвэрлэл, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бүсийн эрчим хүчний төслүүд

Төрөл	Үйл ажиллагаа	Арга хэмжээ	Нэгж	Хэрэгжих хугацаа	Нийт
				2020-2030	
Эх үүсвэр	Чойбалсангийн ДЦС	өргөтгөх	МВт	50	50
ЦДАШ	Чойбалсан-Өндөрхаан-Багануурын 220кВ-ын ЦДАШ, дэд станц	барих	км	220	220

8.1.2. Мезо, микро бүсүүдийг холбосон, мезо бүсийн төвүүдийг боомтуудтай холбосон авто замыг барьж, өргөтгөн, тээвэр логистикийн төвүүдийг байгуулна. Экспортын зориулалттай төмөр замуудыг барьж, өргөтгөн хүчин чадлыг нэмэгдүүлж, Эрэнцав, Сүмбэр, Бичигт, Ульхан, Хавирга, Баянхошуу хилийн боомтуудын барилга байгууламж, тоног төхөөрөмжийг олон улсын стандартад нийцүүлэн шинэчилж, Бичигт боомт дээр тээвэр логистикийн төв байгуулна. Дорнод аймгийн нисэх онгоцны буудлыг агаарын хөлөг хүлээн авах 4С хүчин чадалтай, байнгын ажиллагаатай олон улсын боомт болгоно.

Хүснэгт 8.2. Дорнод Монголын эдийн засгийн хөгжлийн тэнхлэг, үйлдвэрлэл, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бүсийн зам, тээврийн төслүүд

Төрөл	Үйл ажиллагаа	Арга хэмжээ	Нэгж	Хэрэгжих хугацаа		Нийт
				2020-2030	2031-2040	
Авто зам	Чойбалсан-Баруун-Урт	барих	км	190		190
	Чойр-Өндөрхаан	барих	км	225		225
	Матад-Хөөт-Баруун-Урт-Сайншанд	барих	км	470		470
	Жаргалтхаан-Өмнөдэлгэр-Биндэр	барих	км	166		166
	Говьсүмбэр-Хэнтий аймгийн Дархан сум	барих	км	93		93
	Норовлин-Дадал	барих	км	56		56
	Чойбалсан-Ульхан боомт	барих	км	223.48		223.48
	Чойбалсан-Хавирга боомт	барих	км	124.8		124.8
	Чойбалсан-Эрэнцав боомт	барих	км	124.8		124.8
	Чойбалсан-Сүмбэр	барих	км	410		410
	Баруун-Урт-Бичигт боомт	барих	км	272		272
	Өндөрхаан-Ульхан боомт	барих	км	250		250
	Бичигт-Баруун-Урт-Чойбалсан-Эрэнцав	барих	км	715		715
	Жижиг дунд оврын гүүр	барих	ш	88		88
	Эдийн засгийн мезо, микро бүсийн төвүүдийн тээвэр логистикийн төв	барих	ш	11		11
Чойбалсан тээвэр логистикийн төв	барих	ш	1		1	
Бичигт тээвэр логистикийн төв	барих	ш	1		1	
Төмөр зам	Чойбалсан-Хөөт-Бичигт	барих	км		414	414
	Хөөт-Сүмбэр	барих	км		380	380
	Эрэнцав-Хөөт-Бичигт	хос, цахилгаан				

- 8.1.3. Уур амьсгалын өөрчлөлт, Дорнод Монголын талын эко системд дасан зохицсон шилмэл омгийн малын удмын сан, тэсвэрт чанарыг хадгалж, ашиг шимийг нэмэгдүүлэн, бэлчээрийн мал аж ахуй, эрчимжсэн мал аж ахуйг зохистой хослуулан хөгжүүлсэн, малын өвчингүй эрүүл, халдваргүй бүс нутаг болгоно.
- 8.1.4. Усалгааны хэмнэлттэй, дэвшилтэт технологи бүхий усалгаатай тариаланг хөгжүүлэн бүсийн үр тариа, төмс, хүнсний ногооны хэрэгцээг хангана. Тэжээлийн ургамал тариалж, малын тэжээлийн үйлдвэр байгуулан, бүсийн хэрэгцээг хангаж, бусад бүсэд нийлүүлнэ.
- 8.1.5. УТП байгуулан олон улсын стандарт, шаардлагад нийцсэн

бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортолно. Тээвэр логистикийн төвүүдийг эдийн засгийн мезо, микро бүсийн төв, боомтуудад байгуулна.

- 8.1.6. ХАА-н түүхий эд, бүтээгдэхүүний үнэ ханш, нийлүүлэлтийн сүлжээ, тээвэр, логистикийн нөхцөл боломж, цаг агаарын аюулаас урьтаж анхааруулах мэдээг малчид, иргэдэд шуурхай хүргэж, бэлэн байдлаа хангах боломж бүрдүүлдэг орон нутгийн мэдээллийн эргэх холбоо бүхий цогцолборыг эдийн засгийн микро бүсийн төвүүд болон зарим сумдад байгуулна.
- 8.1.7. Газрын тос, байгалийн хийн хайгуул судалгааны ажлыг эрчимжүүлж, нөөцийг нэмэгдүүлнэ. Өндөр технологийн хүнд аж үйлдвэрлэлийн цогцолбор, барилгын материалын үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлнэ.
- 8.1.8. Аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэн, Зүүн хойд Азийн олон улсын аялал жуулчлалын хамтын ажиллагаанд нэгдэнэ. Хэнтий аймагт эрт болон дундад зууны үеийн Монголын төрт ёсны түүх, дурсгалын үнэт өв, нүүдлийн соёл, уламжлалт ахуйд түшиглэн “Чингис хаан аялал жуулчлалын цогцолбор” байгуулж түүхэн аялал жуулчлалыг, Дорнод аймагт Дорнод Монголын тал хээрийн шим мандлын өвөрмөц экосистем, Халх гол-Буйр нуурыг түшиглэсэн хил орчмын болон хил дамнасан аялал жуулчлалыг, Сүхбаатар аймагт Дарьгангын тэгш өндөрлөгийн үзэсгэлэнт байгальд түшиглэсэн эко аялал жуулчлалыг хөгжүүлнэ. Бүсийн төвүүдэд аялал, жуулчлалын мэдээллийн төв, аялал жуулчлалын гол чиглэл, авто замын дагуу түр буудаллах цэгүүдийг байгуулна.
- 8.1.9. Түүх, соёлын өвд түшиглэсэн, аялал жуулчлалын хот, сууринг олон улсын ногоон хотын норм, стандартын дагуу төлөвлөн хөгжүүлж, өсөлтийн төвүүдийг түшиглэн соёлын бүтээлч аж үйлдвэрлэлийг түүх, соёлын аялал жуулчлалтай хослуулсан кластеруудыг байгуулж, орон нутгийн брэнд бүтээгдэхүүн бий болгоно.
- 8.1.10. Бүсийн нийгмийн үйлчилгээний хангамжийг төрөөс үзүүлэх нийгмийн үйлчилгээний жишиг нормативт нийцүүлэн сайжруулж, Их, дээд сургуулийг геологи, уул уурхай, эдийн засаг, бизнес, худалдаа, тээвэр, логистик, гадаад харилцааны чиглэлээр, МСҮТ-ийг хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, барилга, аялал жуулчлалын чиглэлээр хөгжүүлнэ.
- 8.1.11. Бүсийн хөгжлийн хөтөлбөр, макро, мезо, микро бүсүүдийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 8.1.12. Хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төслийн хүрээнд бүсийн хот байгуулалтын хөгжлийн стратеги, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээ, барилга байгууламжийг үе шаттай барьж байгуулах, өргөтгөн шинэчлэх ажлыг хонгил (туннель)-ын системээр төлөвлөж хэрэгжүүлнэ.

Зураг 8.3. Дорнод Монголын эдийн засгийн хөгжлийн тэнхлэг, үйлдвэрлэл, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бүс

ДОРНОД МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ТЭНХЛЭГ, ҮЙЛДВЭРЛЭЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, НОГООН ХӨГЖЛИЙН БҮС

"Дорнод Монголын тал"-ын экосистемийн унаган төрхийг хадгалж, Зүүн хойд Азийн эдийн засгийн интеграцид идэвхтэй оролцсон, ногоон технологид суурилсан хөдөө аж ахуй, аялал жуулчлал, боловсруулах үйлдвэрлэлийн зохистой хослол бүхий бүс нутаг болж хөгжинө.

ЭДИЙН ЗАСГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ:



2030 он

Шинээр баригдсан улсын чанартай автозамын урт

1,815.0 км



Шинээр баригдсан ЦДАШ-ын урт

512.0 км

Шинээр нэмэгдсэн эрчим хүчний чадал

50.0 МВт




I ҮЕ ШАТ (2021-2030)

"Дорнод Монголын тал"-ын экосистемд түшиглэсэн бэлчээрийн мал аж ахуйг дэмжин, түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх, байгаль, түүх, соёлын өвд тулгуурласан хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлэх. Зүүн бүсийн эрчим хүчний системийг Төвийн эрчим хүчний системд холбох, бүсийн авто замын босоо тэнхлэгийг байгуулах.

ХӨГЖЛИЙН ДЭД БҮТЭЦ - ТАЛ НУТГИЙН ХӨГЖИЛТ



ХЭНТИЙ, СУХБААТАР, ДОРНОД



II ҮЕ ШАТ (2031-2040)

Усалгаатай газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйг экспортын баримжаатай хөгжүүлэх.

ЭРЧИМЖСЭН АЖ АХУЙ

III ҮЕ ШАТ (2041-2050)

Өсөлтийн төвдүүдэд түшиглэсэн үйлдвэрлэл, инновацийг хөгжүүлэх.

ХӨГЖЛИЙН КЛАСТЕР

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙ, ӨНДӨР ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ, ПАЛЕОНТОЛОГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БҮС (Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь)

ЗОРИЛТ 8.2 Говийн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, Зүүн Азийн эдийн засгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцсон, хариуцлагатай уул уурхай, өндөр технологид суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжсөн бүс нутаг болгон хөгжүүлнэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
ХӨГЖЛИЙН ДЭД БҮТЭЦ –ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙ	ХӨГЖЛИЙН САНХҮҮЖИЛТ	ӨНДӨР ТЕХНОЛОГИ
Говийн бүсийн хэвтээ тэнхлэгийн төмөр зам, логистикийн төв, боомтыг барьж дуусгах, байгаль орчинд ээлтэй, ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх үе	Бүс нутгийн хөгжлийг тэтгэх хуримтлалыг нэмэгдүүлж, эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг дэмжин хөгжүүлэх үе	Нано, биотехнологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх үе
<ol style="list-style-type: none"> 1. Говийн бүсийг эрчим, хүчний найдвартай эх үүсвэртэй болгож, экспортын чиг баримжаатай үйлдвэрлэл хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх 2. Стратегийн орд газруудыг хилийн боомттой холбосон авто болон төмөр замуудыг барьж, боомтуудыг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлж, уул уурхайн бүтээгдэхүүн экспортлох нөхцөлийг бүрдүүлэх 	<ol style="list-style-type: none"> 1. Зүүн хойд Азийн орнуудад цахилгаан эрчим хүчийг их хэмжээгээр экспортлох үйлдвэрлэл, дамжуулалтын бүтцийг бүрдүүлэх 2. Эдийн засгийн микро бүсийн төвүүдийг улсын чанартай авто замын сүлжээтэй холбох 3. Ашигт малтмалыг ашигласны орлогоор Баялгийн сан байгуулж, бусад бүсийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлэх, санхүүгийн чадавхыг бэхжүүлэхэд ашиглах 	<ol style="list-style-type: none"> 1. Шинжлэх ухаан, өндөр технологийн туршилт, судалгаа-хөгжүүлэлтийн төв, Их өгөгдлийн төв байгуулах 2. Ногоон технологид суурилсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж, экологийн цэвэр бүтээгдэхүүн экспортлох тээвэр, логистикийн төв, биржүүдийг байгуулах

3. Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн түүхий эдийг дотооддоо боловсруулж нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх
4. Байгаль орчинд ээлтэй, уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн цогцолбор байгуулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн экспортлох
3. Палеонтологи, археологи, түүх, соёлын аялал жуулчлалын кластер, говийн гайхамшигт амьтдын үндэсний паркийг хөгжүүлэх
4. Ногоон технологид суурилсан, экспортод чиглэсэн ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх
5. Хүнд үйлдвэрийн цогцолборууд, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын хэрэгцээг хангах барилгын материалын ханган нийлүүлэлтийн сүлжээг байгуулах
4. Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу бүсийн ногоон хот, суурины сүлжээг хөгжүүлэн иргэд төрж, өссөн нутагтаа аз жаргалтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх
5. Уламжлалт мал аж ахуй болон эрчимжсэн мал аж ахуй, усалгаатай газар тариаланг зохистой хослуулан хөгжүүлэх
6. ХАА-н тээвэр логистикийн төвүүдийг микро бүсийн төвүүдэд байгуулж, авто замаар холбон хүнсний бараа бүтээгдэхүүн, хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг дэмжих
6. Палеонтологи, археологи, түүх, соёлын өвд түшиглэсэн, аялал жуулчлалын төв, хот, сууринг олон улсын ногоон хотын норм, стандартын дагуу төлөвлөж, хөгжүүлэх
7. Аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэн, говийн байгаль, археологи, палеонтологи, нүүдлийн өв соёлд тулгуурласан эко аялал жуулчлалыг хөгжүүлж, говийн гайхамшигт амьтдын үндэсний парк байгуулах
8. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн чиглэлийн судалгааны хүрээлэн, их, дээд сургуулийг байгуулах
9. Мезо, микро бүсүүдийн төвүүд болон уул уурхай түшиглэн байгуулагдсан хот, сууринг нийгмийн үйлчилгээний жишиг нормативт нийцүүлэн хөгжүүлж, иргэдийн эрүүл, аюулгүй ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

8.2.1. Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системийн босоо тэнхлэгийн гол шугам, эх үүсвэрүүдийг барьж байгуулан бүсийн эрчим хүчний хангамжийг найдваржуулж, цахилгаан эрчим хүч экспортлох үйлдвэрлэл, дамжуулалтын бүтцийг бүрдүүлнэ. Шинэ төрлийн эрчим хүчний түүхий эдийн нөөцийн судалгаа-хөгжүүлэлтийг хийж, технологийг эзэмшинэ.

Хүснэгт 8.3. Хариуцлагатай уул уурхай, өндөр технологид суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээ, палеонтологийн аялал жуулчлалын бүсийн эрчим хүчний төслүүд

Төрөл	№	Үйл ажиллагаа	Арга хэмжээ	Нэгж	Хэрэгжих хугацаа		Нийт
					2020-2030	2031-2040	
Эх үүсвэр	1	Тавантолгойн ДЦС	барих, өргөтгөх	МВт	500	500	1000
	2	Шивээ-Овоогийн ДЦС	барих	МВт	5280		
ЦДАШ	3	Багануур-Чойрын 220кВ-ын ЦДАШ, дэд станц	барих	км	220		220
	4	Чойр-Сайншанд-Замын-Үүдийн 220кВ-ын ЦДАШ, дэд станц	барих	км	220		220
	5	Шивээ-Овоо-БНХАУ чиглэлийн 660кВ-ын ЦДАШ, дэд станц	барих	км	660		660

8.2.2. Уул уурхай, экспортын чиглэлийн авто зам болон төмөр замыг барьж, тээвэр логистикийн төвүүдийг хөгжүүлэн, хилийн боомтуудын барилга байгууламж, тоног төхөөрөмжийг олон улсын стандартад нийцүүлэн шинэчилнэ. Мезо, микро бүсийн төвүүдийг холбосон авто замуудыг барьж иргэдийг нийгмийн үйлчилгээ авах, үйлдвэрлэл бизнес эрхлэх боломжоор хангана. Мезо бүсийн төвийн нисэх онгоцны буудлыг агаарын хөлөг хүлээн авах байнгын ажиллагаатай, олон улсын боомт болгон хөгжүүлнэ.

Хүснэгт 8.4. Хариуцлагатай уул уурхай, өндөр технологид суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээ, палеонтологийн аялал жуулчлалын бүсийн авто зам, төмөр зам, тээвэр логистикийн төслүүд

Төрөл	№	Үйл ажиллагаа	Арга хэмжээ	Нэгж	Хэрэгжих хугацаа			Нийт
					2020-2030	2031-2040	2041-2050	
Боомт	21	Сайншандад тээвэр логистикийн төв барих, хуурай боомтын статустай болгох		ш	1		1	
	22	Замын-Үүдийн тээвэр логистикийн төвийг өргөтгөх, хуурай боомтын статустай болгох		ш	1		1	
	23	Гашуунсухайт, Ханги боомтыг олон улсын чанартай боомт болгох		ш	2		2	

Авто зам	1	Тавантолгой - Гашуунсухайт	барих	км	250		250
	2	Тавантолгой-Манлай-Хатанбулаг-Ханги	барих	км	465		465
	3	Баруун нарангийн 32 км авто замын төгсгөлөөс Цагаандэл уул боомт	барих	км	270		270
	4	Сайншанд-Зүүнбаян-Хатанбулаг	барих	км	200		200
	5	Даланзадгад-Баяндалай-Гурвантэс	барих	км	220		220
	6	Мандалговь-Говь-Угтаал-Чойр	барих	км	107		107
	7	Мандалговь-Эрдэнэдалай-Арвайхээр	барих	км	114		114
	8	Эдийн засгийн микро бүсийн төвүүдийн авто зам	барих	км			
	9	Эдийн засгийн мезо, микро бүсийн төвүүдийн тээвэр логистикийн төв	барих	ш	11		11
	10	Орон нутгийн хөгжил-Жижиг дунд оврын гүүр	барих	ш/гүүр	23		23
Төмөр зам	11	УБТЗ хувь нийлүүлсэн нийгэмлэгийн гол төмөр зам	хос болгох, цахилгаан-жуулах	км	200		200
	12	Тавантолгой - Зүүнбаян	барих	км	414.6		414.6
	13	Зүүнбаян - Ханги мандал	барих	км	281		281
	14	Нарийнсухайт - Шивээхүрэн	барих	км	46.2		46.2
	15	Тавантолгой - Гашуунсухайт	барих	км	267		267
	16	Сайншанд - Баруун-Урт - Хөөт	барих	км	240		240
	17	Шинэжинст - Шивээхүрэн	барих	км		300	300
	18	Шивээхүрэн-Тавантолгой	барих	км			
	19	УБТЗ хувь нийлүүлсэн нийгэмлэгийн гол төмөр	их засвар		250		250
Иргэний нисэх	20	Өмнөговь аймгийн нисэх онгоцны буудлыг олон улсын боомт болгох		4D			
Боомт	21	Сайншандад тээвэр логистикийн төв барих, хуурай боомтын статустай болгох		ш	1		1
	22	Замын-Үүдийн тээвэр логистикийн төвийг өргөтгөх, хуурай боомтын статустай болгох		ш	1		1
	23	Гашуунсухайт, Ханги боомтыг олон улсын чанартай боомт болгох		ш	2		2

8.2.3. Говийн бүс рүү ус дамжуулах хоолой барьж байгуулна.

8.2.4. Уул уурхай, хүнд үйлдвэрийн дараах цогцолборуудыг барьж, байгуулна. Үүнд:

ХҮНД ҮЙЛДВЭР:

- Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр
- Нефть-хими, кокс-хими, металлургийн үйлдвэр
- Нүүрс угаах үйлдвэр
- Нүүрс-хими, нүүрс-эрчим хүч, метан хийн Үйлдвэрлэл, технологийн парк
- Ган төмөрлөгийн үйлдвэр
- Жонш баяжуулах үйлдвэр
- Алт цэвэршүүлэх үйлдвэр

УУЛ УУРХАЙН ОРДУУД:

- Тавантолгойн нүүрсний ордыг бүрэн ашиглалтад оруулна
- Оюутолгойн далд уурхайг ашиглана
- Дорноговийн цахиурын ордыг ашиглана
- Цагаан суваргын ордыг ашиглалтад оруулна
- Хармагтайн ордыг ашиглалтад оруулна
- Литийн ордыг ашиглалтад оруулна
- Газрын ховор элементийн хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлнэ.

8.2.5. Хүнд үйлдвэрийн цогцолборууд, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын хэрэгцээг хангах барилгын материалын ханган нийлүүлэлтийн сүлжээ байгуулна.

8.2.6. ҮТП байгуулан олон улсын стандарт, шаардлагад нийцсэн ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Тээвэр логистикийн төвүүдийг эдийн засгийн мезо, микро бүсийн төв, боомтуудад байгуулна.

8.2.7. ХАА-н түүхий эд, бүтээгдэхүүний үнэ ханш, нийлүүлэлтийн сүлжээ, тээвэр, логистикийн нөхцөл боломж, цаг агаарын аюулаас урьтаж анхааруулах мэдээг малчид, иргэдэд шуурхай хүргэж, бэлэн байдлаа хангах боломж бүрдүүлдэг орон нутгийн мэдээллийн эргэх холбоо бүхий цогцолборыг эдийн засгийн микро бүсийн төвүүд болон зарим сумдад байгуулна.

8.2.8. Аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэн, олон улсын аялал жуулчлалын Торгоны зам, Цайны зам, Нэг бүс-нэг замын хамтын ажиллагаанд нэгдэнэ. Өмнөговь, Дорноговь аймгуудын Нэмэгт, Хэрмэн цав, Бүгийн цав, Шар цав, Баянзаг зэрэг газруудыг түшиглэсэн палеонтологийн аялал жуулчлалыг хөгжүүлж, Палеонтологийн судалгааны төв, музей байгуулна. Монголын говийн нэн ховор амьтад, байгаль газарзүй, ландшафтын онцлогт түшиглэсэн Говийн гайхамшигт амьтдын эко парк байгуулна. Дорноговь аймагт ноён хутагт Данзанравжаагийн түүх, шашины өв соёл, Говьсүмбэр аймагт Боржигон соёлын өв уламжлал, Дундговь аймагт нүүдлийн соёл уламжлалд тулгуурласан нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ. Замын-Үүд, Ханги, Гашуунсухайт, Шивээхүрэн боомтыг түшиглэсэн хил орчмын болон хил дамнасан

аялал жуулчлал, томоохон уул уурхайн бүтээн байгуулалтыг дагасан гео аялал жуулчлал (geotourism)-ын шинэ төрлийг хөгжүүлнэ. Бүсийн төвүүдэд аялал, жуулчлалын мэдээллийн төв, аялал жуулчлалын гол чиглэл, авто замын дагуу түр буудаллах цэгүүдийг байгуулна.

8.2.9. Бүсийн нийгмийн үйлчилгээний хангамжийг төрөөс үзүүлэх нийгмийн үйлчилгээний жишиг нормативт нийцүүлэн сайжруулж, Их, дээд сургуулийг эрчим хүч, геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, худалдаа, тээвэр логистик, этноэкологи, этноботаник, этно соёл, урлаг, палеонтологийн чиглэлээр, МСҮТ-ийг хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, барилга, аялал жуулчлалын чиглэлээр хөгжүүлнэ.

8.2.10. Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу өмнийн говийн бүсийн байгаль орчны стратегийн үнэлгээ, эрсдлийн хүчин зүйлсийн үнэлгээ, хот байгуулалтын нэгдсэн үнэлгээг хийж, бүсийн орон зайн төлөвлөлтийг нэгтгэн боловсруулна.

8.2.11. Бүсийн хөгжлийн хөтөлбөр, макро, мезо, микро бүсүүдийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.

8.2.12. Хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төслийн хүрээнд бүсийн хот байгуулалтын хөгжлийн стратеги, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээ, барилга байгууламжийг үе шаттай барьж байгуулах, өргөтгөн шинэчлэх ажлыг хонгил (туннель)-ын системээр төлөвлөж хэрэгжүүлнэ.

Зураг 8.4. Хариуцлагатай уул уурхай, өндөр технологид суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээ, палеонтологийн аялал жуулчлалын бүс

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙ, ӨНДӨР ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ, ПАЛЕОНТОЛОГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БҮС

Говийн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, хөрш орон Зүүн Азийн эдийн засгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцсон, хариуцлагатай уул уурхай, өндөр технологид суурилсан үйлдвэрлэл үйлчилгээ бүхий бүс нутаг болж хөгжинө.

ЭДИЙН ЗАСГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ:



2030 он 2040 он 2050 он

Шинээр баригдсан ЦДАШ-ын урт	658.0 км		
Шинээр нэмэгдсэн эрчим хүчний чадал	5,780.0 МВт	6,280.0 МВт	
Шинээр баригдсан улсын чанартай автозамын урт	250.0 км		
Шинээр баригдсан төмөр замын урт	1,448.8 км	1,688.8 км	2,109.8 км

I ҮЕ ШАТ (2021-2030)

Говийн бүсийн хэвтээ тэнхлэгийн төмөр зам, логистикийн төв, боомтыг барьж дуусгах, байгаль орчинд ээлтэй, ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх.

Хөгжлийн дэд бүтэц - ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙ



ГОВЬСҮМБЭР,
ДУНДГОВЬ, ДОРНОГОВЬ,
ӨМНӨГОВЬ



ТАНИХ ТЭМДЭГ

- Бүсийн таталцлын төв
- Аймгийн төв
- Сумын төв
- Бүсийн хил
- Аймгийн хил
- Сумын хил
- Гөл
- Нуур
- Хилийн боомт
- Олон улсын байнгын ажиллагаатай боомт
- Орон нутгийн байнгын ажиллагаатай боомт
- Орон нутгийн тур ажиллагаатай боомт
- Орон нутгийн шинээр байгуулах боомт

II ҮЕ ШАТ (2031-2040)

Бүсүүдийн хөгжлийг тэтгэх хуримтлалыг нэмэгдүүлж, эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг дэмжин хөгжүүлэх.

Хөгжлийн санхүүжилт

III ҮЕ ШАТ (2041-2050)

Нано, биотехнологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх.

Өндөр технологи

БАЙГАЛИЙН НӨӨЦ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, НОГООН ХӨГЖЛИЙН БҮС (Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай аймаг)

ЗОРИЛТ 8.3 Говийн уулс, тал хээрийн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, бүс нутгийн интеграцад идэвхтэй оролцсон, мал аж ахуй, аялал жуулчлал рекреацийн бүс нутаг болгон хөгжүүлнэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
ХОС ТЭНХЛЭГ	РАШААН СУВИЛАЛ-ЭРҮҮЛ МЭНДИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ	АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХОТ
Алтайн бүсийн босоо, хэвтээ чиглэлийн дэд бүтцийн үндсэн тэнхлэгүүдийг байгуулах, бэлчээрийн мал аж ахуйг дэмжих, түүхий эдийг гүн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж, нэмүү өртгийн сүлжээг бүрдүүлэх үе	Дотоодын ба олон улсын амралт, рашаан сувилал, аялал жуулчлалын сүлжээг хөгжүүлэх үе	Соёлын болон зугаа, цэнгэлийн олон улсын аялал жуулчлалын цогцолборыг хөгжүүлэх үе
1. Бүсийн босоо, хэвтээ тэнхлэгийн авто замуудыг барьж, мезо, микро бүсүүдийн төвүүдийг улс, бүсийн чанартай авто замын сүлжээтэй холбож, тээвэр, логистикийн төвүүдийг байгуулах 2. Экспортын чиг баримжаатай органик хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх 3. Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүсийн дотоодын хэрэгцээг хангах	1. Эрчим хүчний нэгдсэн системийн бүрэлдэхүүнд босоо тэнхлэгийн дагуу дэд станц, ЦДАШ барьж бүсийн эрчим хүчний хэрэглээг тогтвортой хангах 2. Эдийн засгийн микро бүсийн төвүүдийг улсын чанартай авто замын сүлжээтэй холбох 3. ХАА-н бүтээгдэхүүний тээвэр логистикийн төвүүдийг эдийн засгийн мезо, микро бүсийн төвүүдэд байгуулж, ҮТП байгуулах	1. Үйлдвэрлэл, технологи, инноваци, аялал жуулчлал, рекреацийн зохистой хослол бүхий эко бүс нутаг болгон хөгжүүлэх 2. Үндэсний түүх, өв уламжлал, ёс заншил, соёлын онцлог, байгалийн өвөрмөц дүр төрхийг агуулсан бүтээлч аж үйлдвэрлэл, соёлын үйлдвэрлэл хөгжсөн орон нутгийн ногоон хотуудын сүлжээг хөгжүүлэх

- | | |
|--|--|
| 4. Аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэн, байгаль экологийн, эрүүл мэндийн болон хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлэх | 4. Ховор, нэн ховор амьтан, ургамлыг хамгаалах, өсгөн үржүүлэх, нөхөн сэргээх үндэсний паркийг байгуулах, тусгай сонирхол, амралт, рашаан сувиллын аялал жуулчлалын үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх |
| 5. Уламжлалт анагаах ухааны чиглэлийн их дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнг байгуулах | 5. Рекреацийн нөөц болон органик бүтээгдэхүүнд түшиглэн анагаах ухаан, эрдэм шинжилгээ, судалгаа, үйлдвэрлэл, инновацийн төв байгуулах |
| 6. Мезо, микро бүсүүдийн төвүүдийг нийгмийн үйлчилгээний жишиг нормативт нийцүүлэн хөгжүүлж, иргэдийн эрүүл, аюулгүй ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх | 6. Аялал жуулчлалын хот, сууринг олон улсын ногоон хотын норм, стандартын дагуу төлөвлөж, хөгжүүлэх |

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

8.3.1. Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системийн босоо тэнхлэгийн шугам, дэд станцыг барьж байгуулан бүсийн эрчим хүчний хангамжийг найдваржуулна.

Хүснэгт 8.5. Байгалийн нөөц, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бүсийн эрчим хүчний төслүүд

Төрөл	№	Үйл ажиллагаа	Арга хэмжээ	Нэгж	Хэрэгжих хугацаа	Нийт
					2031–2040	
ЦДАШ	1	Шинэ нийслэл-Арвайхээр-Баянхонгорын 220кВ-ын ЦДАШ, дэд станц	барих	км	44	44
	2	Улиастай-Есөнбулагийн 220кВ-ын ЦДАШ, дэд станц	барих	км	194	194

8.3.2. Бүсийн босоо, хэвтээ тэнхлэгийн авто замуудыг барьж, мезо, микро бүсүүдийн төвүүдийг улс, бүсийн чанартай авто замын сүлжээтэй холбож, тээвэр, логистикийн төвүүдийг байгуулна. Өвөрхангай аймгийн нисэх онгоцны буудлыг олон улсын зэрэглэл (4C)-тэй болгоно.

Хүснэгт 8.6. Байгалийн нөөц, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бүсийн авто зам, төмөр зам, тээвэр логистикийн төслүүд

Төрөл	№	Үйл ажиллагаа	Арга хэмжээ	Нэгж	Хэрэгжих хугацаа	Нийт
					2020-2030	
ЦДАШ	1	Алтай - Улиастай	барих	км	194	194
	2	Шивээхүрэн - Арвайхээр	барих	км	451	451
	3	Бургастайн боомт - Алтай	барих	км	320	320
	4	Хужирт-Арвайхээр	барих	км	56	56
	5	Хужир-Улаанцутгалан- Найман нуур-Шаргалжуут-Баянхонгор	барих	км	270	270
	6	Эдийн засгийн микро бүсийн төвүүдийн авто зам	барих	км		
	7	Эдийн засгийн мезо, микро бүсийн төвүүдийн тээвэр логистикийн төв	барих	ш	15	15
	8	Орон нутгийн хөгжил-Жижиг дунд оврын гүүр	барих	ш	58	58

- 8.3.3. ХАА-н түүхий эд, бүтээгдэхүүний үнэ ханш, нийлүүлэлтийн сүлжээ, тээвэр, логистикийн нөхцөл боломж, цаг агаарын аюулаас урьтаж анхааруулах мэдээг малчид, иргэдэд шуурхай хүргэж, бэлэн байдлаа хангах боломж бүрдүүлдэг орон нутгийн мэдээллийн эргэх холбоо бүхий цогцолборыг эдийн засгийн микро бүсийн төвүүд болон зарим сумдад байгуулна.
- 8.3.4. Хөдөөгийн усны хангамжийг нэмэгдүүлж, бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг зохистой хослуулан хөгжүүлнэ.
- 8.3.5. Ховор, нэн ховор амьтан, ургамлыг хамгаалах, өсгөн үржүүлэх, нөхөн сэргээх үндэсний парк байгуулна. Аялал жуулчлалын гол чиглэл, авто замын дагуу түр буудаллах цэгүүдийг байгуулна.
- 8.3.6. Аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэн, Говь-Алтайн нуруу, говь, хангай, хээр хосолсон байгалийн өвөрмөц ландшафтыг түшиглэсэн байгалийн болон адал явдалт аялал жуулчлал, Хангайн нурууны өвөр хэсгийн Шаргалжуут орчмын рашааныг түшиглэсэн амралт, нөхөн сэргээх аялал жуулчлалыг хөгжүүлнэ. Бүсийн төвүүдэд аялал, жуулчлалын мэдээллийн төв, аялал жуулчлалын гол чиглэл, авто замын дагуу түр буудаллах цэгүүдийг байгуулна.
- 8.3.7. Бүсийн нийгмийн үйлчилгээний хангамжийг төрөөс үзүүлэх нийгмийн үйлчилгээний жишиг нормативт нийцүүлэн сайжруулж, Их, дээд сургуулийг уламжлалт анагаах ухаан, байгаль судлал, геоэкологи, түүх археологи, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын чиглэлээр, МСҮТ-ийг хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, барилга, аялал жуулчлалын чиглэлээр хөгжүүлнэ. Анагаах ухаан, эрдэм шинжилгээ, судалгаа, үйлдвэрлэл, инновацийн төв байгуулна.

- 8.3.8. Бүсийн хөгжлийн хөтөлбөр, макро, мезо, микро бүсүүдийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 8.3.9. Хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төслийн хүрээнд бүсийн хот байгуулалтын хөгжлийн стратеги, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээ, барилга байгууламжийг үе шаттай барьж байгуулах, өргөтгөн шинэчлэх ажлыг хонгил (туннель)-ын системээр төлөвлөж хэрэгжүүлнэ.

БАЙГАЛИЙН НӨӨЦ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, НОГООН ХӨГЖЛИЙН БҮС

Говийн болон тал хээрийн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, бүс нутгийн интеграцид идэвхтэй оролцсон, мал аж ахуй, аялал жуулчлал голлосон рекреацийн бүс нутаг болж хөгжинө.

ЭДИЙН ЗАСГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ:



2030 он

Шинээр баригдсан улсын чанартай автозамын урт

965.0 км



2040 он

Шинээр баригдсан ЦДАШ-ын урт

195.0 км

Шинээр баригдсан төмөр замын урт

850 км



I ҮЕ ШАТ (2021-2030)

Алтайн бүсийн бэлчээрийн мал аж ахуйг дэмжих, нэмүү өртгийн сүлжээг бүрдүүлэх, түүхий эдийг гүн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж, босоо, хэвтээ чиглэлийн дэд бүтцийн үндсэн тэнхлэгүүд, коридорыг байгуулах.

ХОС ТЭНХЛЭГ



**ӨВӨРХАНГАЙ,
БАЯНХОНГОР,
ГОВЬ-АЛТАЙ**



ТАНИХ ТЭМДЭГ

- Бүсийн таталцлын төв
- Аймгийн төв
- Сумын төв
- Бүсийн хил
- Аймгийн хил
- Сумын хил
- Гөл
- Нуур
- Хилийн боомт
- Олон улсын байнгын ажиллагаатай боомт
- Орон нутгийн байнгын ажиллагаатай боомт
- Орон нутгийн тур ажиллагаатай боомт
- Орон нутгийн шинээр байгуулах боомт

II ҮЕ ШАТ (2031-2040)

Дотоодын ба олон улсын амралт, рашаан сувилал, аялал жуулчлалын сүлжээг хөгжүүлэх.

**РАШААН СУВИЛАЛ, ЭРҮҮЛ
МЭНДИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ**

III ҮЕ ШАТ (2041-2050)

Соёлын болон зугаа, цэнгэлийн олон улсын аялал жуулчлалын цогцолборыг хөгжүүлэх.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХОТ

ӨРНӨД МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ТЭНХЛЭГ, АЛТАЙН СОЁЛ, БАЙГАЛИЙН НӨӨЦ, НОГООН ХӨГЖЛИЙН БҮС (Ховд, Баян- Өлгий, Увс аймаг)

ЗОРИЛТ 8.4 Монгол Алтай, Их нууруудын хотгорын экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, өндөр уулын мал аж ахуй, Өрнө-Дорныг холбосон олон улсын тээвэр, логистик, аялал жуулчлалын бүс нутаг болгон хөгжүүлнэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
ЭКОСИСТЕМ-ХАМГААЛАЛТ – АШИГЛАЛТ	АЛТАЙН ЭКО АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ	ОЛОН УЛСЫН ТЭЭВЭР ЛОГИСТИК, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ
Улсын дэд бүтцийн хөндлөн тэнхлэгийн зам, боомтыг барьж дуусгах, экосистемийн унаган төрхийг хамгаалж, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн цогцолборыг хөгжүүлэх үе	Алтайн түүх, соёл, зан заншил, байгалийн өвөрмөц онцлогт түшиглэсэн экологийн аялал жуулчлалын олон улсын бүс нутаг болон хөгжих үе	Монгол Алтай, Их нууруудын хотгорын экосистемийн давуу талд түшиглэсэн тогтвортой хөгжлийн загвар бүс нутаг болгох үе
<ol style="list-style-type: none"> Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системийн хэвтээ тэнхлэгийн шугам, дэд станц, эх үүсвэрийг барьж байгуулан бүсийн эрчим хүчний хэрэглээг тогтвортой хангах Бүсийн босоо, хэвтээ тэнхлэгийн авто зам, төмөр замыг барьж, мезо, микро бүсүүдийн төвүүдийг улс, бүсийн чанартай авто замын сүлжээтэй холбож, тээвэр, логистикийн төвүүдийг байгуулах 	<ol style="list-style-type: none"> Улсын хэвтээ, босоо тэнхлэгийн авто зам, боомт чиглэлийн авто замуудыг барьж Бага, Дундад Азийн авто замын сүлжээнд холбогдох, ХАА-н бүтээгдэхүүний тээвэр логистикийн төвүүдийг эдийн засгийн мезо, микро бүсийн төвүүдэд байгуулж, УТП байгуулах 	<ol style="list-style-type: none"> Олон улсын болон бүсийн тээвэр логистикийн төвүүдийг байгуулж, Бага, Дундад Азийн эдийн засгийн интеграцад нэгдэх Баруун бүсэд дэлхийн шим мандал, байгаль экосистем, олон угсаатны түүх, соёл, нүүдлийн соёл иргэншилд тулгуурласан олон улсын аялал жуулчлалын цогцолбор байгуулах

- | | | |
|---|---|--|
| <ol style="list-style-type: none"> Уул уурхай, хөдөө аж ахуйн түүхий эдийн нөөцөд түшиглэн боловсруулах үйлдвэрүүд байгуулах Аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэн, байгаль экологийн, тусгай сонирхлын болон хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлэх Их дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнг байгуулах, хөгжүүлэх Мезо, микро бүсүүдийн төвүүдийг нийгмийн үйлчилгээний жишиг нормативт нийцүүлэн хөгжүүлж, иргэдийн эрүүл, аюулгүй ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх | <ol style="list-style-type: none"> Өндөр уулын экосистемд зохицсон мал аж ахуй эрхэлж, органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлэх Алтайн түүх, соёл, зан заншил, байгалийн өвөрмөц онцлогт түшиглэсэн тусгай сонирхол, экологийн аялал жуулчлалыг хөгжүүлэх Аялал жуулчлалын хот, сууринг олон улсын ногоон хотын норм, стандартын дагуу төлөвлөж, хөгжүүлэх | <ol style="list-style-type: none"> Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу бүсийн ногоон хот, суурины сүлжээг хөгжүүлэн иргэд төрж, өссөн нутагтаа аз жаргалтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх |
|---|---|--|

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

8.4.1 Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системийн хэвтээ тэнхлэгийн шугам, дэд станц, эх үүсвэрийг барьж байгуулан бүсийн эрчим хүчний хэрэглээг тогтвортой хангана.

Хүснэгт 8.7. Өрнөд Монголын эдийн засгийн хөгжлийн тэнхлэг, Алтайн соёл, байгалийн нөөц, ногоон хөгжлийн бүсийн эрчим хүчний төслүүд

Төрөл	№	Үйл ажиллагаа	Арга хэмжээ	Нэгж	Хэрэгжих хугацаа		Нийт
					2020–2030	2031–2040	
Эх үүсвэр	1	Ховдын Эрдэнэбүрэнгийн УЦС	барих	МВт		100	100
ЦДАШ	2	Мянгад-Дөргөн-Улиастайн 220кВ-ын ЦДАШ, дэд станц	барих	км	380		380

8.4.2 Бүсийн босоо, хэвтээ тэнхлэгийн авто замуудыг барьж, мезо, микро бүсүүдийн төвүүдийг улс, бүсийн чанартай авто замын сүлжээтэй холбож, тээвэр, логистикийн төвүүдийг байгуулна. Увс, Ховд аймгийн нисэх онгоцны буудлыг олон улсын зэрэглэл (4С)-тэй болгоно.

8.4.3 Хилийн боомтуудын барилга байгууламж, тоног төхөөрөмжид шинэчлэлт хийж, олон улсын стандартад нийцүүлэн, нэвтрэх чадварыг нэмэгдүүлнэ. Сибирь, Красноярск, Тува, Хакасын зах зээлийг холбосон олон улсын тээвэр, логистикийн төв байгуулна.

Хүснэгт 8.8. Өрнөд Монголын эдийн засгийн хөгжлийн тэнхлэг, Алтайн соёл, байгалийн нөөц, ногоон хөгжлийн бүсийн авто зам, төмөр зам, тээвэр логистикийн төслүүд

Төрөл	№	Үйл ажиллагаа	Арга хэмжээ	Нэгж	Хэрэгжих хугацаа			Нийт
					2020-2030	2031-2040	2041-2050	
Авто зам	1	Ховдын Мягд - Загастайн давааны арын уулзвар	барих	км	426			426
	2	Эдийн засгийн микро бүсийн төвүүдийн авто зам	барих	км				
	3	Эдийн засгийн мезо, микро бүсийн төвүүдийн тээвэр логистикийн төв	барих	км				
	4	Орон нутгийн хөгжил-Жижиг дунд оврын гүүр	барих	ш/гүүр	78			78
	5	Цагааннуурын чөлөөт бүс	хөгжүүлэх					
	6	Ховд - Улаангом	барих	км		163		163
	7	Өлгий - Улаанхус - Алтай Таванбогд	барих	км		118		118
	8	Улаанхус - Хөх-Эрэгийн боомт	барих	км		113		113
	9	Булган-Ховд-Өлгий-Улаанбайшинт	барих	км		741		741
	10	Эдийн засгийн микро бүсийн төвүүдийн авто зам	барих	км				
	11	Эдийн засгийн мезо, микро бүсийн төвүүдийн тээвэр логистикийн төв	барих	ш	15			15
	12	Өлгий хотын бүсийн тээвэр, логистикийн төв	барих	ш			1	1
	13	Ховд хотын бүсийн тээвэр, логистикийн төв	барих	ш			1	1
	14	Улаангом хотын бүсийн тээвэр, логистикийн төв	барих	ш			1	1
	15	Сибирь, Красноярск, Тува, Хакасын зах зээлийг холбосон олон улсын тээвэр, логистикийн төв	барих	ш			1	1
Төмөр зам	16	Босоо чиглэлийн төмөр зам	барих	км				

- 8.4.4 ОХУ-ын зах зээлд ХАА-н бүтээгдэхүүн нийлүүлэх, хоёр талын худалдааг өргөжүүлэх зорилгоор Цагааннуурын чөлөөт бүсийг дэмжин хөгжүүлнэ. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлж тээвэр логистикийн төвүүдийг эдийн засгийн мезо, микро бүсийн төвүүдэд байгуулна.
- 8.4.5 ХАА-н түүхий эд, бүтээгдэхүүний үнэ ханш, нийлүүлэлтийн сүлжээ, тээвэр, логистикийн нөхцөл боломж, цаг агаарын аюулаас урьтаж анхааруулах мэдээг малчид, иргэдэд шуурхай хүргэж, бэлэн байдлаа хангах боломж бүрдүүлдэг орон нутгийн мэдээллийн эргэх холбоо бүхий цогцолборыг эдийн засгийн микро бүсийн төвүүд болон зарим сумдад байгуулна.
- 8.4.6 Жимс, жимсгэнийн нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж бүсийн дотоодын хэрэгцээг хангаж, экспортолно.
- 8.4.7 Түүхий эдийн нөөцөд түшиглэн коксын үйлдвэр, барилгын материалын үйлдвэр, давс, давсан бүтээгдэхүүний үйлдвэр байгуулна.
- 8.4.8 Аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэн, Төв Азийн олон улсын аялал жуулчлалын хамтын ажиллагаанд нэгдэнэ. Баян-Өлгий аймагт Монгол-Алтай, Алтай-Саяны байгалийн үзэсгэлэнт газарт түшиглэсэн байгалийн болон адал явдалт аялал, Увс аймагт Хархираа-Түргэн, Саяны уулс, Их нууруудын хотгорын байгаль газарзүйн онцлог, Ойрд түмний уламжлалт ахуй соёлыг таниулах нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал, Ховд аймагт Монгол Алтайн, Говийн их дархан газрын үзэсгэлэнт байгаль, биологийн олон янз байдал, олон ястан, угсаатны нүүдлийн ахуй соёл, өв уламжлалыг түшиглэсэн түүх, соёл, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ. Бүсийн аялал жуулчлалын гол чиглэл, авто замын дагуу түр буудаллах цэг, дэд бүтцийг байгуулна.
- 8.4.9 Алтайн соёл судлалын болон био экологийн хүрээлэн байгуулна.
- 8.4.10 Бүсийн хөгжлийн хөтөлбөр, макро, мезо, микро бүсүүдийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 8.4.11 Хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төслийн хүрээнд бүсийн хот байгуулалтын хөгжлийн стратеги, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээ, барилга байгууламжийг үе шаттай барьж байгуулах, өргөтгөн шинэчлэх ажлыг хонгил (туннель)-ын системээр төлөвлөж хэрэгжүүлнэ.



ӨРНӨД МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ТЭНХЛЭГ, АЛТАЙН СОЁЛ, БАЙГАЛИЙН НӨӨЦ, НОГООН ХӨГЖЛИЙН БҮС

Монгол Алтай, Их нууруудын хотгорын экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, өндөр уулын мал аж ахуй, Өрнө – Дорныг холбосон олон улсын тээвэр, логистик, аялал жуулчлал бүхий бүс нутаг болж хөгжинө.

ЭДИЙН ЗАСГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ:

Уламжлалт болон эрчимжсэн хөдөө аж ахуй

Өндөр уулын бүсийн аялал жуулчлал



**ХОВД,
БАЯН-ӨЛГИЙ,
УВС**

I ҮЕ ШАТ (2021-2030)

Экосистемийн унаган төрхийг хамгаалж, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн цогцолборыг хөгжүүлэх, улсын дэд бүтцийн хөндлөн тэнхлэгийн зам, боомтыг барьж дуусгах

ЭКОСИСТЕМ ХАМГААЛАЛТ - АШИГЛАЛТ

II ҮЕ ШАТ (2031-2040)

Баруун бүсийн эрчим хүчний системийг үүсгэн төвийн эрчим хүчний найдвартай системтэй холбож нэгдсэн сүлжээг хөгжүүлэх.

ЭРЧИМ ХҮЧНИЙ НЭГДСЭН СИСТЕМ

III ҮЕ ШАТ (2041-2050)

Монгол Алтай, Их нууруудын хотгорын экосистемийн давуу талд тушигласан тогтвортой хөгжлийн загвар бүс нутаг болгох

ОЛОН УЛСЫН ТЭЭВЭР ЛОГИСТИК, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

ХАНГАЙН ЭРЧИМЖСЭН ХӨДӨӨ АЖ АХУЙ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, НОГООН ХӨГЖЛИЙН БҮС

(Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Булган, Архангай, Хөвсгөл, Завхан аймаг)

Зорилт 8.5 Хангай-Хөвсгөлийн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, хүн төрөлхтний цэнгэг усны нөөцийг хамгаалсан, хөрш орон, олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцсон, аялал жуулчлал, эрчимжсэн хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэлийн зохистой хослол бүхий бүс нутаг болгон хөгжүүлнэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
ШИНЭ ХОТ – НОГООН ХӨГЖИЛ	ХӨГЖЛИЙН ДЭД БҮТЭЦ	ТҮҮХ, СОЁЛЫН ӨВ-СОЁЛЫН АЖ ҮЙЛДВЭР
Орхон-Тамирын бэлчирт нийслэлийн баримжаатай шинэ хот, Хангай ба говийн урд бүсийг холбосон босоо тэнхлэгийг байгуулж олон улсын жишигт нийцсэн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх үе	Эрчим хүчний системүүдийг холбож, нэгдсэн системийг үүсгэх, харилцаа холбооны дэд бүтцийг байгуулах үе	Нүүдлийн соёл иргэншил, монгол туургатны өв уламжлалыг сонирхсон жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх үе
1. Хэвтээ тэнхлэгийн гол шугам, дэд станцыг барьж байгуулан Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системийг бүрдүүлэх 2. Мезо, микро бүсүүдийн төвүүдийг улс, бүсийн чанартай авто замын сүлжээтэй холбож, тээвэр, логистикийн төвүүдийг байгуулах	1. Монгол Улсын дэд бүтцийн үндсэн тэнхлэг (авто зам, төмөр зам, эрчим хүч, харилцаа холбоо)-ийг бүрдүүлж дуусгах 2. ХАА-н бүтээгдэхүүний тээвэр логистикийн төвүүдийг эдийн засгийн мезо, микро бүсийн төвүүдэд байгуулах	1. Цэнгэг уст нуур, байгалийн үзэсгэлэнт газар, ан амьтан, эртний Монгол Улсын түүх, нүүдлийн соёл иргэншил, уламжлалт мал аж ахуй, амьдралын хэв маягт түшиглэсэн байгалийн, амралт зугаалгын тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх 2. Судалгаа, сургалтын байгууллагуудын тогтолцоо, чадавхад түшиглэн бизнес инкубаторыг байгуулах

- Орхон-Тамирын бэлчирт түүх соёлын өв, ногоон хөгжилд тулгуурласан нийслэлийн баримжаатай хотын байршлыг сонгож, техник эдийн засгийн үндэслэл, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх
- Уул уурхай, хөдөө аж ахуйн түүхий эдийн нөөцөд түшиглэн боловсруулах үйлдвэрүүд байгуулах
- Аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэн, байгаль экологийн, тусгай сонирхлын болон хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлэх
- Их дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнг байгуулах, хөгжүүлэх
- Мезо, микро бүсүүдийн төвүүдийг нийгмийн үйлчилгээний жишиг нормативт нийцүүлэн хөгжүүлж, иргэдийн эрүүл, аюулгүй ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх
- Эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хөгжүүлэх
- Бүсийн Шинжлэх ухаан, технологи, инновацийн төвүүдийг байгуулах, хөгжүүлэх
- Цэнгэг уст нуур, байгалийн үзэсгэлэнт газар, ан амьтан, эртний Монгол Улсын түүх, нүүдлийн соёл иргэншил, уламжлалт мал аж ахуй, амьдралын хэв маягт түшиглэсэн байгалийн, амралт зугаалгын тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх
- Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу бүсийн ногоон хот, суурины сүлжээг хөгжүүлэн иргэд төрж, өссөн нутагтаа аз жаргалтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

8.5.1. Хэвтээ тэнхлэгийн гол шугам, дэд станцыг барьж байгуулан Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системийг бүрдүүлнэ.

Хүснэгт 8.9. Хангайн эрчимжсэн хөдөө аж ахуй, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бүс эрчим хүчний төслүүд

Төрөл	№	Үйл ажиллагаа	Арга хэмжээ	Нэгж	Хэрэгжих хугацаа		Нийт
					2020-2030	2031-2040	
Эх үсвэр	1	Алтай-Улиастайн ЭХС-ийн ДЦС	барих	МВт	100		100
	2	Эрдэнэтийн ДЦС	өргөтгөх	МВт	35		35
	3	Эгийн гол УЦС	барих	МВт		315	315
ЦДАШ	4	Булган-Эрдэнэтийн 220кВ-ын ЦДАШ, дэд станц	барих	км		60	60
	5	Улаанбаатар-Улиастайн 400кВ-ын ЦДАШ, дэд станц	барих	км		1000	1000
	6	Улиастай-Мөрөнгийн 220кВ-ын ЦДАШ, дэд станц	барих	км		220	220
	7	Шинэ нийслэл-Цэцэрлэгийн 220кВ-ын ЦДАШ, дэд станц	барих	км		220	220

- 8.5.2. Монгол Улсын дэд бүтцийн үндсэн тэнхлэг (авто зам, төмөр зам, эрчим хүч, харилцаа холбоо)-ийг бүрдүүлж дуусган, үндэсний хэмжээний дэд бүтцийн удирдлагын төвийг байгуулна (төвийн үйл ажиллагааг биг дата, хиймэл оюун ухаанаар удирдах бололцоог бүрдүүлнэ).
- 8.5.3. Мезо, микро бүсүүдийн төвүүдийг улс, бүсийн чанартай авто замын сүлжээтэй холбож, тээвэр, логикийн төвүүдийг байгуулна. Хилийн боомтуудын барилга байгууламж, тоног төхөөрөмжид шинэчлэлт хийж, олон улсын стандартад нийцүүлэн, нэвтрэх чадварыг нэмэгдүүлнэ.
- 8.5.4. Байгаль нуур-Хөвсгөл нуурыг түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлэх тээврийн сүлжээг бий болгоно. Аялал жуулчлалын гол бүс нутгуудад агаарын тээврийн үйлчилгээ, хүртээмжийг нэмэгдүүлж, Завхан, Хөвсгөл аймгийн төвүүдийн нисэх онгоцны буудлыг олон улсын зэрэглэл (4C)-тэй болгоно.

Хүснэгт 8.10. Хангайн эрчимжсэн хөдөө аж ахуй, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бүс авто зам, төмөр зам, тээвэр логикийн төслүүд

Төрөл	№	Үйл ажиллагаа	Арга хэмжээ	Нэгж	Хэрэгжих хугацаа		Нийт
					2020-2030	2031-2040	
Авто зам	1	Батцэнгэл - Хануйн гүүр	барих	км	97		97
	2	Хатгал-Ханх	барих	км	180		180
	3	Арвайхээр - Шинэ нийслэл	барих	км	222		222
	4	Булган - Хишиг-Өндөр - Гурванбулаг	барих	км	133.7		133.7
	5	Хутаг-Өндөр - Тэшиг - Бага-Илэнх боомт	барих	км	124		124
	6	Бат-Өлзийт-Төвхөн хийд-Цэнхэрийн халуун ус-Цэцэрлэг	барих	км	100		100
	7	Дархан - Эрдэнэт	барих	км		190	190
	8	Мөрөн-Бүрэнтогтох-Цагаан-Уул-4 замын салаа	барих	км		250	250
	9	Мөрөн-Шинэ-Идэр-Жаргалант-Цэцүүх	барих	км		180	180
	10	Нөмрөг-Тэс-Арцсуурь	барих	км		200	200
	11	Эдийн засгийн микро бүсийн төвүүдийн авто зам	барих	км			
	12	Эдийн засгийн мезо, микро бүсийн төвүүдийн тээвэр логикийн төв	барих	км	24		24
	13	Орон нутгийн хөгжил-Жижиг дунд оврын гүүр	барих	ш/гүүр	234		234
	14	Алтанбулагийн тээвэр логикийн төвийг барьж, хуурай боомтын статустай болгох	барих				
	15	Дархан хотын тээвэр логикийн төвийг барьж, хуурай боомтын статустай болгох	барих	ш			
	16	Эрдэнэт-Овоот	барих	км	546		546
Төмөр зам	17	Улаанбаатар-Шинэ нийслэл чиглэлийн хурдны төмөр замын ТЭЗҮ, зураг төсөв					

ХАНГАЙН ЭРЧИМЖСЭН ХӨДӨӨ АЖ АХУЙ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, НОГООН ХӨГЖЛИЙН БҮС

Хангай - Хөвсгөлийн гео системийн тэнцвэрт байдлыг хадгалж, тив дэлхийн цэнгэг усны нөөцийг хамгаалсан, хөрш орон, олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцсон, аялал жуулчлал, эрчимжсэн хөдөө аж ахуй, аж үйлдвэрлэлийн цогцолбор бүхий бүс нутаг болж хөгжинө.

ЭДИЙН ЗАСГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ:

Уламжлалт болон эрчимжсэн хөдөө аж ахуй

Түүх соёлын аялал жуулчлал

Шинэ нийслэл



2030 он

Шинээр баригдсан улсын чанартай автозамын урт

862.0 км



2040 он

Шинээр нэмэгдсэн эрчим хүчний чадал

465.0 км

Шинээр нэмэгдсэн эрчим хүчний чадал 150.0 МВт

I ҮЕ ШАТ (2021-2030)

Орхон – Тамирын бэлчирт шинэ нийслэлийг байгуулан, төрийн захиргааны байгууллагуудыг шилжүүлж эхлэх, олон улсын жишигт нийцсэн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлж, хойд урд бүсийг холбосон босоо тэнхлэгийг байгуулах.

ШИНЭ НИЙСЛЭЛ - НОГООН ХӨГЖИЛ



СЭЛЭНГЭ, ДАРХАН-УУЛ, ОРХОН, БУЛГАН, АРХАНГАЙ, ХӨВСГӨЛ, ЗАВХАН



ТАНИХ ТЭМДЭГ

- Бүсийн таталцлын төв
- Аймгийн төв
- Сумын төв
- Бүсийн хил
- Аймгийн хил
- Сумын хил
- Гөл
- Нуур
- Хилийн боомт
- Олон улсын байнгын ажиллагаатай боомт
- Орон нутгийн байнгын ажиллагаатай боомт
- Орон нутгийн тур ажиллагаатай боомт
- Орон нутгийн шинээр байгуулах боомт

II ҮЕ ШАТ (2031-2040)

Улиастай - Шинэ нийслэл – Улаанбаатарыг холбосон хурдны галт тэрэг, цахилгаан тээврийн дэд бүтцийг барьж байгуулах.

ХӨГЖЛИЙН ДЭД БҮТЭЦ

III ҮЕ ШАТ (2041-2050)

Ази – Европыг холбосон хамгийн дөт тэнхлэгийг байгуулж, нүүдлийн соёл иргэншил, мангол туургатны өв уламжлалыг сонирхсон жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх.

ТҮҮХ, СОЁЛЫН ӨВ-СОЁЛЫН АЖ ҮЙЛДВЭР

- 8.5.5. Дархан хотын давуу тал, онцлогт тулгуурлан шинжлэх ухаан, технологи, инновацийн төвүүдийг байгуулна.
- 8.5.6. Эрдэнэт хотын давуу тал, онцлогт тулгуурлан уул уурхай-металлурги-химийн үйлдвэрлэл, технологийн парк байгуулна.
- 8.5.7. Газар тариалангийн бүс нутгийн эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, зорь, агуулах, элеватор үтрэмийн хүчин чадлыг нэмэгдүүлэн шинэ техник, тоног төхөөрөмжийг нэвтрүүлж хадгалалт, борлуулалтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ.
- 8.5.8. ХАА-н түүхий эд, бүтээгдэхүүний үнэ ханш, нийлүүлэлтийн сүлжээ, тээвэр, логистикийн нөхцөл боломж, цаг агаарын аюулаас урьтаж анхааруулах мэдээг малчид, иргэдэд шуурхай хүргэж, бэлэн байдлаа хангах боломж бүрдүүлдэг орон нутгийн мэдээллийн эргэх холбоо бүхий цогцолборыг эдийн засгийн микро бүсийн төвүүд болон зарим сумдад байгуулна.
- 8.5.9. Аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэн, бүсийн хэмжээнд Хангай-Хөвсгөлийн үзэсгэлэнт байгаль, биологийн олон янз байдал, цэнгэг уст нуур, рашааны нөөцөд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ. Хөвсгөл аймагт Хөвсгөл нуурын эко систем, цаатангуудын уламжлалт ахуй соёл, томоохон голын ай сав дагуух аялал, Архангай аймагт Хангайн нурууны эко систем, уламжлалт ахуй соёл, рашаан эмчилгээний аялал, Булган аймагт адууны соёлын аялал, Сэлэнгэ аймагт Сэлэнгэ мөрний ай сав дагуух адал явдалт, байгальд түшиглэсэн аялал, Өвөрхангай аймагт Орхон голын сав дагуух нүүдэлчдийн эртний түүх соёл, хот суурин газруудыг түшиглэсэн соёлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ. Бүсийн төвүүдэд аялал, жуулчлалын мэдээллийн төв, аялал жуулчлалын гол чиглэл, авто замын дагуу түр буудаллах цэгүүдийг байгуулна.
- 8.5.10. Хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төслийн хүрээнд Орхон-Тамирын бэлчирт түүх соёлын өв, ногоон хөгжилд тулгуурласан нийслэлийн баримжаатай хотын байршлыг оновчтой сонгон, техник эдийн засгийн үндэслэл, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ.
- 8.5.11. Бүсийн хөгжлийн хөтөлбөр, макро, мезо, микро бүсүүдийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 8.5.12. Хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төслийн хүрээнд бүсийн хот байгуулалтын хөгжлийн стратеги, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээ, барилга байгууламжийг үе шаттай барьж байгуулах, өргөтгөн шинэчлэх ажлыг хонгил (туннель)-ын системээр төлөвлөж хэрэгжүүлнэ.

ОЛОН УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТӨВ, ТЭЭВРИЙН ЗАНГИЛАА, ӨНДӨР ТЕХНОЛОГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮС

(Төв аймаг, Улаанбаатар хот)

ЗОРИЛТ 8.6 Улаанбаатар хот, Төвийн бүсэд бий болсон хүн ам, нийгэм, эдийн засгийн төвлөрлийг төлөвлөлттэйгөөр задлах, төв, дагуул хотуудын зохистой бүтцийг бүрдүүлж, мэдлэгт суурилсан эдийн засаг бүхий, олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай бүс нутаг болгон хөгжүүлнэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
ЗОХИСТОЙ ДЭД БҮТЭЦ-ДАГУУЛ ХОТ	НОГООН ХОТ	УХААЛАГ ХОТ
Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурласан, эрчимтэй хөгжиж буй дагуул хотуудыг үйлдвэрлэл, үйлчилгээ, логистик, хүнс, хөдөө аж ахуйн чиглэлүүдээр дагнан хөгжүүлэх үе	Төрөөс олон нийтэд үзүүлэх нийгмийн үйлчилгээний стандартыг олон улсын түвшинд хүргэх үе	Ухаалаг системд тулгуурласан, өрсөлдөх чадвартай, шинжлэх ухаан, тэргүүний технологи, инноваци нэвтрүүлсэн олон улсын худалдаа - бизнесийн төв болгон хөгжүүлэх үе
<ol style="list-style-type: none"> Төвийн бүсийн өсөн нэмэгдэж буй ЦЭХ-ний хэрэгцээг бүсийн эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар хангах Улаанбаатар хотын төвлөрлийг үе шаттайгаар сааруулж, дагуул хотуудын эдийн засгийн тогтвортой өсөлт, үр ашгийг дэмжсэн үйлдвэрлэл, нийгмийн үйлчилгээ, тээвэр логистикийн тогтолцоо бүрдүүлэх 	<ol style="list-style-type: none"> Улсын гол тэнхлэгийн төмөр замыг өргөтгөж, хүчин чадлыг нэмэгдүүлэх ХАА-н бүтээгдэхүүний тээвэр логистикийн төвүүдийг дагуул хот, микро бүсийн төвүүдэд байгуулах Эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хөгжүүлж, УТП байгуулах Бүсийн Шинжлэх ухаан, технологи, инновацийн төвүүдийг байгуулах, хөгжүүлэх 	<ol style="list-style-type: none"> Улаанбаатар-Шинэ нийслэл чиглэлийн дэд бүтцийг төлөвлөх, байгуулах Шинжлэх ухаан, технологи, инноваци, үйлдвэрлэлийн цогцолборууд байгуулах

3. Аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэн, түүх, соёл, албан бизнес, шинжлэх ухаан, байгаль экологийн, тусгай сонирхлын болон хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлэх

4. Дагуул хот, микро бүсүүдийн төвүүдийг нийгмийн үйлчилгээний жишиг нормативт нийцүүлэн хөгжүүлж, иргэдийн эрүүл, аюулгүй ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх

5. Олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн худалдаа, эдийн засгийн чөлөөт бүс, карго логистикийн төв байгуулах

3. Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу бүсийн ногоон хот, суурины сүлжээг хөгжүүлэн иргэд төрж, өссөн нутагтаа аз жаргалтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

8.6.1. Төвийн бүсийн өсөн нэмэгдэж буй ЦЭХ-ний хэрэгцээг бүсийн эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар бүрэн хангана.

Хүснэгт 8.11. Олон улсын шинжлэх ухаан, технологийн төв, тээврийн зангилаа, өндөр технологийн үйлдвэрлэл, үйлчилгээний бүсийн эрчим хүчний төслүүд

Төрөл	№	Үйл ажиллагаа	Арга хэмжээ	Нэгж	Хэрэгжих хугацаа	Нийт
					2020-2030	
Эх үүсвэр	1	УБ хотын ДЦС-3	нэмэгдүүлэх	МВт	75	75
	2	УБ хотын ДЦС-4	шинэчлэх	МВт		
	3	Багануур ДЦС	барих	МВт	400	400
	4	Төвийн бүсийн цэнэгт хураагуурын станц	барих	МВт	100	100
	5	Төвийн бүсийн усан цэнэгт цахилгаан станц	барих	МВт	220	220
ЦДАШ	6	УБ-Багануурын 220кВ-ын ЦДАШ, дэд станц	шинэчлэх	км	135	135

8.6.2. Нийслэл хот, мезо, микро бүсүүдийн төвүүдийг чөлөөт бүс, боомтуудтай холбосон төмөр зам, авто замуудыг барьж, тээвэр логистикийн төвүүдийг эдийн засгийн мезо, микро бүсийн төвүүдэд байгуулна. Чөлөөт бүс, хилийн боомтуудын барилга байгууламж, тоног төхөөрөмжид шинэчлэлт хийж, олон улсын стандартад нийцүүлэн, нэвтрэх чадварыг нэмэгдүүлнэ.

8.6.3. Багануур, Налайхын УТП-ийн дэд бүтцийг шинэчлэн үйлдвэрлэл, үйлчилгээний барилга, байгууламжуудыг барьж хөгжлийг эрчимжүүлэн, олон улсын чанар, стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, бүсийн хэрэгцээг ханган, бусад бүсүүдэд нийлүүлнэ.

8.6.4. Хөшигийн хөндийн олон улсын нисэх буудлын тээвэр логистикийн төвийг байгуулж, хуурай боомтын статустай болгоно.

Хүснэгт 8.12. Олон улсын шинжлэх ухаан, технологийн төв, тээврийн зангилаа, өндөр технологийн үйлдвэрлэл, үйлчилгээний бүсийн авто зам, төмөр зам, тээвэр логистикийн төслүүд

Төрөл	№	Үйл ажиллагаа	Арга хэмжээ	Нэгж	Хэрэгжих хугацаа			Нийт
					2020-2030	2031-2040	2041-2050	
Авто зам	1	Алтанбулаг - Дархан - Улаанбаатар	барих	км	333			333
	2	Улаанбаатар - Замын-Үүд	барих	км	660			660
	3	Улаанбаатар-Чойр	4 эгнээ барих		200			200
	4	Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвийг барих, хуурай боомтын статустай болгох		ш				
	5	Эдийн засгийн микро бүсийн төвүүдийн авто зам	барих	км				
	6	Эдийн засгийн мезо, микро бүсийн төвүүдийн тээвэр логистикийн төв	барих	км	7			7
	7	Орон нутгийн хөгжил-Жижиг дунд оврын гүүр	барих	ш/гүүр	35			35
Төмөр зам	8	Богдхан төмөр зам	барих	км				
	9	УБТЗ хувь нийлүүлсэн нийгэмлэгийн гол төмөр зам	хос болгох	км		450		450
	10	УБТЗ хувь нийлүүлсэн нийгэмлэгийн гол төмөр замыг цахилгаанжуулах		км		500		500
	11	Овоот-Арцсуурь	барих	км		245		245
	12	УБТЗ хувь нийлүүлсэн нийгэмлэгийн гол төмөр зам	хос болгох	км			450	450
	13	УБТЗ хувь нийлүүлсэн нийгэмлэгийн гол төмөр замыг цахилгаанжуулах		км			600	600
	14	Улаанбаатар-Шинэ нийслэл чиглэлийн төмөр зам	барих	км			330	330

- 8.6.5. Уур амьсгалын өөрчлөлт, хээр талын эко системд дасан зохицсон шилмэл омгийн малын удмын сан, тэсвэрт чанарыг хадгалж, ашиг шимийг нэмэгдүүлэн, бэлчээрийн мал аж ахуй, эрчимжсэн мал аж ахуйг зохистой хослуулан хөгжүүлж, нийслэл хот болон бүсийн дотоод хэрэгцээг хангана.
- 8.6.6. Усалгааны хэмнэлттэй, дэвшилтэт технологи бүхий усалгаатай тариаланг хөгжүүлэн бүсийн үр тариа, төмс, хүнсний ногооны хэрэгцээг бүрэн хангана. Тэжээлийн ургамал тариалж, малын тэжээлийн үйлдвэр байгуулан, бүсийн хэрэгцээг хангаж, бусад бүсэд нийлүүлнэ.
- 8.6.7. УТП байгуулан олон улсын стандарт, шаардлагад нийцсэн ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортолно. Тээвэр логистикийн төвүүдийг эдийн засгийн мезо, микро бүсийн төв, боомтуудад байгуулна.
- 8.6.8. ХАА-н түүхий эд, бүтээгдэхүүний үнэ ханш, нийлүүлэлтийн сүлжээ, тээвэр, логистикийн нөхцөл боломж, цаг агаарын аюулаас урьтаж анхааруулах мэдээг малчид, иргэдэд шуурхай хүргэж, бэлэн байдлаа хангах боломж бүрдүүлдэг орон нутгийн мэдээллийн эргэх холбоо бүхий цогцолборыг эдийн засгийн микро бүсийн төвүүд болон зарим сумдад байгуулна. Шинжлэх ухаан, байгаль экологийн, тусгай сонирхлын болон хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 8.6.9. Аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэн, Төв аймагт Хөшигийн хөндийн олон улсын нисэх буудлыг түшиглэсэн хотын болон бизнес (MICE) аялал, Хан Хэнтэйн нуруу, Горхи Тэрэлж, Орхон-Туул, Сэлэнгэ мөрний адаг хэсгийн үзэсгэлэнт байгальд түшиглэсэн эко аялал, эрчимжсэн хөдөө аж ахуйд түшиглэсэн агро аялал, Хүннү гүрний үеэс эхтэй Гурван голын монголчуудын төрт ёсны түүх, Бурханы шашины болон Нийслэл хүрээний түүхийг илэрхийлэх түүх, соёлын аялал, Манзушир шашин соёлын төв, Майдар хот болон Аглаг бүтээлийн хийдийг түшиглэсэн шашин соёлын аялал, төв халхын найр наадам, адууны соёл, талын нүүдэлчдийн ахуй амьдралд түшиглэсэн НИТАЖ-ыг хөгжүүлнэ. Бүсийн төвүүдэд аялал, жуулчлалын мэдээллийн төв, аялал жуулчлалын гол чиглэл, авто замын дагуу түр буудаллах цэгүүдийг байгуулна.
- 8.6.10. Түүх, соёлын өвд түшиглэсэн, аялал жуулчлалын хот, сууринг олон улсын ногоон хотын норм, стандартын дагуу төлөвлөн хөгжүүлж, өсөлтийн төвүүдийг түшиглэн соёлын бүтээлч аж үйлдвэрлэлийг түүх, соёлын аялал жуулчлалтай хослуулсан кластеруудыг байгуулж, орон нутгийн брэнд бүтээгдэхүүн бий болгоно.
- 8.6.11. Хөшигийн хөндийн олон улсын нисэх буудлын хотыг түшиглэн Шинжлэх ухаан бизнес, судалгаа, сургалт, үйлдвэрлэлийн төв байгуулна.
- 8.6.12. Бүсийн нийгмийн үйлчилгээний хангамжийг төрөөс үзүүлэх нийгмийн үйлчилгээний жишиг нормативт нийцүүлэн сайжруулж, Их, дээд сургуулийг суурь шинжлэх ухаан, архитектур, хот төлөвлөлт, цахим засаглал, мэдээллийн технологи, өндөр технологи, автоматжуулалт, түүх, археологи, палеонтологи, эдийн засаг, бизнес, худалдаа, тээвэр, логистик, гадаад харилцаа, батлан хамгаалах чиглэлээр, МСҮТ-ийг хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, барилга, аялал жуулчлалын чиглэлээр хөгжүүлнэ.
- 8.6.13. Улаанбаатар хот болон Төв аймгийг орон зайн зохион байгуулалтын хувьд цогцоор төлөвлөн, эрүүл, аюулгүй, ая тухтай амьдрах таатай орчныг бүрдүүлнэ. Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн дагуу бүсийн байгаль орчны стратегийн үнэлгээ, эрсдэлийн хүчин зүйлсийн үнэлгээ, хот байгуулалтын нэгдсэн үнэлгээг хийж, бүсийн орон зайн төлөвлөлтийг нэгтгэн боловсруулна. Дархан цаазат Богдхаан уулын экосистемийг хамгаалан, эко коридоруудыг байгуулна.
- 8.6.14. Бүсийн хөгжлийн хөтөлбөр, макро, мезо, микро бүсүүдийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 8.6.15. Хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төслийн хүрээнд бүсийн хот байгуулалтын хөгжлийн стратеги, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээ, барилга байгууламжийг үе шаттай барьж байгуулах, өргөтгөн шинэчлэх ажлыг хонгил (туннель)-ын системээр төлөвлөж хэрэгжүүлнэ.

Зураг 8.8. Олон улсын шинжлэх ухаан, технологийн төв, тээврийн зангилаа, өндөр технологийн үйлдвэрлэл, үйлчилгээний бүс

ОЛОН УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТӨВ, ТЭЭВРИЙН ЗАНГИЛАА, ӨНДӨР ТЕХНОЛОГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮС

Улаанбаатар хот, түүний орчимд бий болсон хүн ам, нийгэм, эдийн засгийн бөөгнөрөл, төвлөрлийг системтэй задалж, төв - дагуул хот тосгоны зохистой бүтэц, харьцаас тогтсон, мэдлэгт суурилсан эдийн засаг, олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай бүс нутаг болгон хөгжүүлэх.

ЭДИЙН ЗАСГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ:



УЛААНБААТАР, ТӨВ



- ТАНИХ ТЭМДЭГ**
- Бүсийн таталцрын төв
 - Аймгийн төв
 - Сумын төв
 - Бүсийн хил
 - Аймгийн хил
 - Сумын хил
 - Гөл
 - Нуур
 - Хилийн боомт**
 - Олон улсын байнгын ажиллагаатай боомт
 - Орон нутгийн байнгын ажиллагаатай боомт
 - Орон нутгийн түр ажиллагаатай боомт
 - Орон нутгийн шинээр байгуулах боомт

I ҮЕ ШАТ (2021-2030)

Төвийн бүс нь хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурласан, эрчимтэй хөгжиж буй дагуул хотуудыг үйлдвэрлэл, үйлчилгээ, логистик, хүнс, хөдөө аж ахуйн чиглэлүүдээр дагнан хөгжүүлэх.

ЗОХИСТОЙ ДЭД БҮТЭЦ - ТӨВ ДАГУУЛ ХОТ

II ҮЕ ШАТ (2031-2040)

Төрөөс олон нийтэд үзүүлэх нийгмийн үйлчилгээний стандартыг олон улсын түвшинд хүргэх

УХААЛАГ ХОТ

III ҮЕ ШАТ (2041-2050)

Ухаалаг системд тулгуурласан, өрсөлдөх чадвартай, шинжлэх ухаан, тэргүүний технологи, инноваци нэвтрүүлсэн олон улсын худалдаа - бизнесийн төв болгон хөгжүүлэх.

УХААЛАГ ХОТ

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН МИКРО БҮСИЙН ТӨВҮҮД

Хүснэгт 8.13. Монгол Улсын эдийн засгийн микро бүсийн төвүүд

Бүсийн нэр	Аймгийн нэр	№	Бүлэг суурингийн төв	Бүлгийн сумын нэр	Орон нутгийн мэдээлэл холбооны цогцолборын байршил
ЗҮҮН БҮС	Дорнод	1	Хэрлэн	1. Баянтүмэн	Хэрлэн
				2. Булган	
				3. Хөлөнбуйр	
	4. Сэргэлэн				
	5. Чойбалсан				
	6. Цагаан-Овоо				
	7. Матад				
	2	Баян-Уул	1. Баяндун		
	3	Дашбалбар	1. Чулуунхороот 2. Гурванзагал	Дашбалбар	
	Хэнтий	4	Хэрлэн	1. Баянхутаг	Хэрлэн
				2. Мөрөн	
3. Баянмөнх					
4. Галшар					
5		Батноров	1. Норовлин		
			2. Бэрх		
			3. Баян-Овоо		
6		Биндэр	1. Баян-Адрага 2. Дадал 3. Батширээт	Биндэр	
	7		Дархан	1. Бор-Өндөр 2. Иххэт	Дархан
8		Жаргалтхаан		1. Өмнөдэлгэр	
	2. Дэлгэрхаан				
	3. Цэнхэрмандал				
	4. Хэрлэнбаян-Улаан				
Сүхбаатар	9	Баруун-Урт	1. Асгат	Баруун-Урт	
			2. Сүхбаатар		
			3. Халзан		
			4. Уулбаян		
			5. Эрдэнэцагаан		
10	Онгон	1. Дарьганга	Онгон		
		2. Наран			
		3. Баяндэлгэр			
11	Мөнххаан	1. Түмэнцогт	Түмэнцогт		
		2. Түвшинширээ	Түвшинширээ		

Бүсийн нэр	Аймгийн нэр	№	Бүлэг суурингийн төв	Бүлгийн сумын нэр	Орон нутгийн мэдээлэл холбооны цогцолборын байршил
ГОВИЙН БҮС	Дорноговь	12	Сайншанд	1. Өргөн	Сайншанд
				2. Сайхандулаан	
				3. Мандах	
				4. Алтанширээ	
				5. Дэлгэрэх	
				6. Даланжаргалан	
	7. Айраг				
	13	Зүүнбаян	1. Улаанбадрах	Мандах	
			2. Хатанбулаг	Хөвсгөл	
			3. Хөвсгөл		
	14	Замын-Үүд	1. Эрдэнэ		
	Өмнөговь	15	Даланзадгад	1. Булган	Даланзадгад
				2. Мандал-Овоо	Мандал-Овоо
				3. Хүрмэн	
				4. Ханхонгор	
				5. Баяндалай	
				6. Цогт-Овоо	
	7. Номгон				
	16	Гурвантэс	1. Ноён		
			2. Сэврэй		
	17	Цогтцэций	1. Манлай	Манлай	
			18	Ханбогд	1. Баян-Овоо
Говьсүмбэр	19	Сүмбэр			1. Шивээговь
			2. Баянтал		
Дундговь	20	Сайнцагаан	1. Дэлгэрцогт	Сайнцагаан	
			2. Өлзийт		
			3. Хулд		
			4. Луус		
			5. Адаацаг		
			6. Дэрэн		
21	Эрдэнэдалай	1. Дэлгэрхангай			
		2. Сайхан-Овоо			
22	Говь-Угтаал	1. Цагаандэлгэр			
		2. Баянжаргалан			
		3. Гурвансайхан			
		4. Өндөршил			

Бүсийн нэр	Аймгийн нэр	№	Бүлэг суурингийн төв	Бүлгийн сумын нэр	Орон нутгийн мэдээлэл холбооны цогцолборын байршил
АЛТАЙН БҮС-	Өвөрхангай	23	Арвайхээр	1. Тарагт	Арвайхээр
				2. Зүүнбаян-Улаан	
				3. Хайрхандулаан	
				4. Уянга	
	5. Нарийнтээл				
	6. Баянгол				
	7. Сант				
	24	Хархорин	1. Бат-Өлзий		
			2. Хужирт		
	25	Есөнзүйл	1. Бүрд		
			2. Баян-Өндөр		
			3. Өлзийт		
	26	Гучин-Ус	1. Төгрөг	Төгрөг	
			2. Богд		
			3. Баруунбаян-Улаан		
	27	Баянхонгор	1. Баян-Овоо	Баянхонгор	
			2. Галуут		
			3. Бөмбөгөр		
			4. Өлзийт		
			5. Эрдэнэцогт		
	28	Богд	1. Баянговь	Богд	
			2. Жинст		
			3. Баянлиг		
	29	Баянцагаан	1.Шинэжинст	Баянцагаан	
			2. Баацагаан		
			3. Баян-Өндөр		
	30	Заг	1. Жаргалант	Заг	
			2. Гурванбулаг		
	31	Бууцагаан	1. Хүрээмарал		
			2. Баянбулаг		
	32	Есөнбулаг	1. Халиун	Есөнбулаг	
			2. Шарга	Шарга	
			3. Тайшир		
			4. Дэлгэр		
	33	Тонхил	1. Дарви		
	34	Баян-Уул	1. Хөхморьт	Хөхморьт	
2. Жаргалан					
35	Бигэр	1. Цогт	Баянтоорой		
		2. Эрдэнэ			
		3. Чандмань			
36	Халиун	1. Цээл			
37	Төгрөг	1. Бугат			
		2. Алтай			

Бүсийн нэр	Аймгийн нэр	№	Бүлэг суурингийн төв	Бүлгийн сумын нэр	Орон нутгийн мэдээлэл холбооны цогцолборын байршил
БАРУУН БҮС	Ховд	38	Жаргалант	1. Мянгад	Жаргалант
				2. Буянт	
				3. Ховд	
				4. Дөргөн	
	5. Эрдэнэбүрэн				
	6. Дуут				
	39	Манхан	1. Мөнххайрхан	Чандмань	
			2. Чандмань		
	40	Зэрэг	1. Цэцэг		
			2. Дарви		
			3. Мөст		
	41	Булган	1. Алтай	Булган	
			2. Үенч		
	42	Өлгий	1. Бугат	Өлгий	
			2. Сагсай		
			3. Толбо		
			4. Цэнгэл		
			5. Улаанхус		
	43	Дэлүүн	1. Булган	Ногооннуур	
			44		Алтанцөгц
			45		Буянт
			46		Цагааннуур
47	Улаангом	1. Тариалан	Улаангом		
		2. Түргэн			
48	Өмнөговь	1. Өлгий			
		2. Ховд			
49	Зүүнговь	1. Тэс	Зүүнговь		
		2. Малчин			
		3. Хяргас			
50	Баруунтуруун	1. Цагаанхайрхан			
		2. Өндөрхангай			
		3. Зүүнхангай			
51	Сагил	1. Давст			
		2. Бөхмөрөн			
52	Наранбулаг	1. Завхан	Наранбулаг		

Бүсийн нэр	Аймгийн нэр	№	Бүлэг суурингийн төв	Бүлгийн сумын нэр	Орон нутгийн мэдээлэл холбооны цогцолборын байршил
ХАНГАЙН БҮС	Сэлэнгэ	53	Сүхбаатар	1. Алтанбулаг	
				2. Шаамар	
				3. Хушаат	
				4. Түшиг	
				5. Цагааннуур	
	6. Зүүнбүрэн				
	54	Ерөө	1. Хүдэр		
			2. Жавхлант		
	55	Сайхан	1. Орхон	Сайхан	
			2. Орхонтуул		
			3. Сант		
			4. Баруунбүрэн		
	56	Мандал	1. (Түнхэл, Хэрх, Тарни)		
			2. Сүмбэр		
			3. Баянгол		
	57	Булган	1. Орхон	Булган	
			2. Бугат		
			3. Сайхан		
58	Хутаг-Өндөр	1. Баян-Агт			
		2. Тэшиг			
59	Хишиг-Өндөр	1. Бүрэгхангай			
		2. Могод			
60	Дашинчилэн	1. Баяннуур	Дашинчилэн		
		2. Гурванбулаг			
		3. Рашаант			
61	Мөрөн	1. Арбулаг	Мөрөн		
		2. Бүрэнтогтох			
		3. Түнэл			
		4. Тосонцэнгэл			
		5. Төмөрбулаг			
		6. Баянзүрх			
		7. Алаг-Эрдэнэ			
62	Рэнчинлхүмбэ	1. Цагааннуур	Рэнчинлхүмбэ		
		2. Улаан-Уул			
63	Хатгал	1. Чандмань-Өндөр			
		2. Ханх			
64	Тариалан	1. Их-Уул			
		2. Рашаант			
		3. Цагаан-Үүр			
		4. Эрдэнэбулган			
65	Шинэ-Идэр	1. Галт			
		2. Жаргалан			
66	Цагаан-Уул	1. Цэцэрлэг	Цагаан-Уул		

Бүсийн нэр	Аймгийн нэр	№	Бүлэг суурингийн төв	Бүлгийн сумын нэр	Орон нутгийн мэдээлэл холбооны цогцолборын байршил
ХАНГАЙН БҮС	Завхан	67	Улиастай	1. Цагаанхайрхан	Улиастай
				2. Алдархаан	
				3. Яруу	
				4. Эрдэнэхайрхан	
				5. Идэр	
		68	Шилүүстэй	1. Отгон	Ургамал
				2. Цагаанчулуут	
		69	Завханмандал	1. Дөрвөлжин	
	2. Ургамал				
	70	Тэс	1. Баянхайрхан		
			2. Асгат		
	71	Түдэвтэй	3. Баянтэс	Сонгино	
			1. Нөмрөг		
			2. Сонгино		
	72	Тосонцэнгэл	3. Цэцэн-уул	Тосонцэнгэл	
			4. Сантмаргац		
Архангай	73	Эрдэнэбулган	1. Ихтамир	Цэцэрлэг	
			2. Булган		
			3. Цэнхэр		
			4. Төвшрүүлэх		
			5. Чулуут		
	74	Эрдэнэмандал	1. Хайрхан	Эрдэнэмандал	
			2. Цэцэрлэг		
	75	Өгийнуур	3. Жаргалант	Өгийнуур	
1. Хашаат					
2. Өлзийт					
3. Батцэнгэл					
76	Тариат	4. Хотонт			
		1. Өндөр-Улаан			
		2. Хангай			
		3. Цахир			

Бүсийн нэр	Аймгийн нэр	№	Бүлэг суурингийн төв	Бүлгийн сумын нэр	Орон нутгийн мэдээлэл холбооны цогцолборын байршил
ТӨВИЙН БҮС	Төв	77	Багануур	1. Мөнгөнморьт	
				2. Баяндэлгэр	
				3. Архуст	
				4. Эрдэнэ	
		78	Баян	1. Баянцагаан	Баян
				2. Баянжаргалан	
		79	Зуунмод	1. Алтанбулаг	
				2. Баян-Өнжүүл	
				3. Сэргэлэн	
		80	Угтаалцайдам	1. Цээл	
				2. Аргалант	
				3. Баянцогт	
		81	Баянчандмань	1. Батсүмбэр	
				2. Борнуур	
				3. Жаргалант	
				4. Сүмбэр	
		82	Лүн	1. Баянхангай	
				2. Заамар	
				3. Өндөрширээт	
		83	Эрдэнэсант	1. Дэлгэрхаан	Бүрэн
				2. Бүрэн	

БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ ЗОРИЛГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

Хүснэгт 8.14. Бүсчилсэн хөгжил зорилгын хэрэгжилтийн хяналт,
үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин

Тайлбар: * тэмдэглэгээ бүхий шалгуур үзүүлэлтийг шинээр тооцдог болно.

#	Шалгуур үзүүлэлт (indicator)	Хэмжих нэгж	Суурь түвшин	2030	2040	2050	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хаанаас авах эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах аргазүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
8	БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ										
1	Эдийн засгийн мезо бүсийн логистикийн төвийн тоо	тоо	-	2	3	6		Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	Захиргааны статистикийн мэдээ	жил бүр	Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага
2	Эдийн засгийн микро бүсийн логистикийн төвийн тоо	тоо	-	63	59	68		Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	Захиргааны статистикийн мэдээ	жил бүр	Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага
3	Микро бүсийн төвийг улсын чанартай авто замтай холбогдох төвийн тоо	тоо	-	66	62	71		Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	Захиргааны статистикийн мэдээ	жил бүр	Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага
4	Шинээр байгуулагдсан хүнс, хөнгөн үйлдвэрийн тоо	тоо	-	2	2	2		Хүнс, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Захиргааны статистикийн мэдээ	жил бүр	Хүнс, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5	Шинээр байгуулагдсан ХААҮТП-ийн тоо	тоо	-	33	31	36		Хүнс, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Захиргааны статистикийн мэдээ	жил бүр	Хүнс, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
6	Уул уурхайн салбарт шинээр нэмэгдсэн аж ахуйн нэгжийн тоо	тоо	4	378	307	217		Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Захиргааны статистикийн мэдээ	жил бүр	Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
7	Хүнд үйлдвэрийн салбарт шинээр байгуулагдсан аж ахуйн нэгжийн тоо	тоо	1	33	26	26		Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Захиргааны статистикийн мэдээ	жил бүр	Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
8	Олон улсын зэрэглэлтэй нисэх буудлын тоо	тоо	1	8	7	9		Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	Захиргааны статистикийн мэдээ	жил бүр	Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага
9	Мэдээлэл холбооны цогцолбор	тоо	-	48	48	48		Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	Захиргааны статистикийн мэдээ	жил бүр	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар



УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ

ХҮН ТӨВТЭЙ ХОТ

ОРЧИН ТӨВТЭЙ ШИЙДЭЛ

ТӨЛӨВЛӨЛТ ТӨВТЭЙ ХӨГЖИЛ

ХОТЫН САЙН ЗАСАГЛАЛ


ДАГУУЛ ХОТ



УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ

Нийслэл Улаанбаатар хот нь Монгол Улсын газар нутгийн 0.3 хувийг эзэлдэг ч нийт хүн амын 45 хувь нь амьдарч байна. Хүн амын хэт төвлөрлөөс үүдэн агаар, орчны бохирдол, авто замын түгжрэл, инженерийн дэд бүтцийн хүртээмжгүй байдал зэрэг олон асуудлууд тулгараад байна.

Зураг 9.1. Нийслэлийн зарим статистик үзүүлэлт /2019/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Нийслэлийн төсвийн орлого жил бүр нэмэгдэж байгаа хэдий ч нийслэлийн өмнө тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэж чадахгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуульд нийслэлийн төсвийн бие даасан байдлыг хангаж өгөөгүйтэй холбоотой юм.

Хотын хүн амын амьдралыг зохицуулах, оршин суугчид руу чиглэсэн, нийтийн эрх ашигт нийцсэн, иргэдийн эрүүл, аюулгүй, тав тухтай орчныг бүрдүүлэх хотын дүрэм, стандартыг бий болгож, тулгамдсан асуудлаа өөрийн онцлогт тохируулан шийдвэрлэх хэрэгцээ зүй ёсоор урган гарч байна.

Иймд хот байгуулалтын өнөөгийн нөхцөл байдал, нийгэм эдийн засгийн өсөлт, шинжлэх ухаан технологийн хөгжил, цаг үеийн өөрчлөлтүүд, ирээдүйн хотжилтын чиг хандлагад тулгуурлан хөгжлийн бодлогын асуудлаа богино, дунд, урт хугацаагаар төлөвлөж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

“Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого - 2050” баримт бичигт Улаанбаатар ба дагуул хотуудыг хөгжүүлэх, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх дараах томоохон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

- Хүн төвтэй хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, соёлтой, өндөр мэдлэг чадвартай, ёс зүйтэй, хариуцлагатай иргэнийг төлөвшүүлж, иргэн бүрийн тэгш оролцоог хангаж, бизнес эрхлэгчдийг төрийн бодлогоор дэмжин ажлын байрыг нэмэгдүүлэх;
- Хотыг нэгдсэн стандарттай болж иргэдийн сурч хөдөлмөрлөх, аюулгүй орчинд амьдрах, зорчих орчны аятай таатай нөхцөлийг бүрдүүлэх;
- Байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, агаар, хөрс болон орчны бохирдолгүй болох;
- Хотын ирээдүйг оновчтой төлөвлөх, хот төлөвлөлтийн зөв бодлогыг хэрэгжүүлэх нь хотын хөгжлийн үндэс тул шинжлэх ухааны үндэслэлтэй, орчин үеийн бодлого шийдлийг тусгасан, төсөв хөрөнгийн зөв тооцоололтой төлөвлөлтийг боловсруулан хэрэгжүүлэх;
- Дагуул, хаяа хот, тосгодыг худалдаа, үйлчилгээ, соёл боловсрол, хөдөө аж ахуй, хүнс хөнгөн үйлдвэрлэл, тээвэр логистик, аялал жуулчлалын чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах;
- Олон төрөлт, ухаалаг нийтийн тээврийн сүлжээг бий болгон, Улаанбаатар хотыг дагуул хотуудтай холбосон зорчигч тээвэр, бүс нутагтай холбосон өндөр хурдны тээврийг нэвтрүүлж түгжрэлгүй болгох;
- Улаанбаатар хот доторх төвлөрлийг задлах зорилгоор соёл боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн дэд бүтцийн хангамж бүхий хотын шинэ төв, дэд төв, төрөлжсөн төв, олон нийтийн төвүүдийг шинээр байгуулж, олон төвт хотын тогтолцоо бүрдүүлэх;



Дээрх томоохон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсний үндсэн дээр Улаанбаатар хотыг 2050 он гэхэд “Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот” болгон хөгжүүлнэ



Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн хөгжлийн үе шатуудыг тодорхойллоо.

ХҮН ТӨВТЭЙ ХОТ

ЗОРИЛТ 9.1 Иргэдийнхээ хөгжих боломжийг хангасан эрүүл чийрэг, бүтээгч, хөдөлмөрийн үнэлэмж өндөртэй иргэдтэй хот болно.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
ИДЭВХТЭЙ ИРГЭН	БҮТЭЭГЧ ИРГЭН	ОЮУНЛАГ ИРГЭН
Нийгмийн дэд бүтцийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлж ирээдүйн оролцоог нэмэгдүүлэх үе	Иргэн төвтэй нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж, тэгш байдлыг хангасан, үр ашигтай тогтолцоог бэхжүүлэх үе	Дэлхийд өрсөлдөх чадвартай, бүтээлч, нийгмийн идэвхтэй иргэд бүхий хотын хөгжлийг дэмжих үе
<ol style="list-style-type: none"> Нийгмийн үйлчилгээний байгууллагуудын (боловсрол, эрүүл мэнд, биеийн тамир, спортын байгууллага, залуучууд, хөгжлийн төв, хүүхэд хамгаалах төв, асрамжийн газар гэх мэт) хүчин чадал, хүртээмжийг нэмэгдүүлж, бүтээн байгуулалт хийх, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах Эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэгдсэн зохицуулалттай бүсчилсэн сүлжээ байгуулж, тогтвортой үйл ажиллагааг хангах Хотын соёлт иргэнийг төлөвшүүлэхэд бүх шатны боловсролын байгууллагуудыг хамарсан төсөл хэрэгжүүлж, нийгэмд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн байгууллага, олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдийн үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэх 	<ol style="list-style-type: none"> Тодорхой нөхцөлийг хангасан бага, дунд, ахлах сургуулийг бие даасан хэлбэрээр төрөлжүүлэн хөгжүүлэх Шинэ дагуул хот, шинэ дэд төв, дүүрэг, хороонд “Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм”-ийн дагуу биеийн тамир спортын барилга байгууламжийг төлөвлөн хэрэгжүүлэх Дүүрэг бүрд олон улсын стандартад нийцсэн соёлын ордон, зарим бүсэд мэргэжлийн урлагийн байгууллагыг шинээр байгуулах 	<ol style="list-style-type: none"> Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийг суралцагчийн хэрэгцээ, шаардлагыг хангасан цогц хөгжлийн төв болгон хөгжүүлэх Техник, технологийн дэвшлийг биеийн тамир, спортын ажил, үйлчилгээнд нэвтрүүлснээр бүх насны иргэд хиймэл оюун ухаанд суурилсан спортын зөвлөн туслах үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх Хотын хүн амын хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлж, ядууралгүй хот болох

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

9.1.1. Цэцэрлэг, сургуулийн насны хүн амын тоонд үндэслэн цэцэрлэг,

ЕБС-ийн барилга, байгууламжийг шинээр барьж, өргөтгөх, замаар шаардлагатай хэмжээгээр суудлын тоог нэмэгдүүлж бүлэг дүүргэлтийг норматив хэмжээнд хүргэнэ.

Хүснэгт 9.1. Улаанбаатар хотын сургуулийн насны хүн амын тоо (мян.хүн)

Боловсролын түвшин	2021	2022	2023	2024	2025	2030	2035	2040	2045	2050
Сургуулийн өмнөх	152.1	154.9	157.7	160.4	163.0	175.8	189.0	204.6	223.0	242.2
Бага	142.4	145.0	147.6	150.1	152.6	164.6	177.0	191.6	208.8	226.8
Суурь	77.9	79.3	80.7	82.1	83.5	90.0	96.8	104.8	114.2	124.0
Бүрэн дунд	57.5	58.6	59.6	60.6	61.6	66.5	71.5	77.4	84.3	91.6

- 9.1.2. ЕБС, цэцэрлэгийн орчны стандартыг мөрдүүлнэ.
- 9.1.3. ЕБС, цэцэрлэгүүдэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж нийлүүлэх, ЕБС, насан туршийн боловсролын төв, МСҮТ-д онлайн, зайн сургалтын танхим байгуулах, цэцэрлэгүүдийг камержуулна.
- 9.1.4. Сургууль бүрд спорт, урлагийн заал, номын сан бүхий хүүхдийн цогц хөгжлийн төвийг үе шаттайгаар байгуулна.
- 9.1.5. Хамтын ажиллагаатай улс, хотуудтай багш, сурагч солилцооны хөтөлбөр, тэтгэлэгтэй суралцах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
- 9.1.6. Хүүхэд харах үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, 1-2 насны хүүхдийг хамруулна.
- 9.1.7. Насан туршийн боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, насанд хүрэгчид, ахмад настанд зориулсан сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, нийгмийн түншлэлийг бэхжүүлнэ.
- 9.1.8. Хүүхэд хамгаалах төв, асрамжийн газрын хүчин чадлыг нэмэгдүүлэх, шаардлагатай тохижилт үйлчилгээг хийнэ.
- 9.1.9. Эрүүл мэндийн байгууллагын барилга, байгууламжийг шинээр барих, өргөтгөх, засварлах, стандартын шаардлага хангасан тохижилт, үйлчилгээний орчин бүрдүүлэх, орны тоог нэмэгдүүлэх, дүүргийн жишиг эрүүл мэндийн төвийн барилгыг шинээр барина.
- 9.1.10. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэгдсэн зохицуулалттай, бүсчилсэн сүлжээг байгуулж, тогтвортой үйл ажиллагааг хангана.
- 9.1.11. Дүүргийн эрүүл мэндийн төвийг нэгдсэн эмнэлэг, дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв болгон хөгжүүлэх ба оношилгоо, эмчилгээний чадавхыг сайжруулах, ерөнхий мэс засал, дурангийн мэс засал, хавдар, хөнгөвчлөх, сэргээн засах тусламж, үйлчилгээг үе шаттай хөгжүүлнэ.
- 9.1.12. Өрхийн эрүүл мэндийн төвд үзүүлэх эмнэлгийн анхан шатлалын тусламж, үйлчилгээнд шинэ дэвшилтэт арга технологийг нэвтрүүлэх, хурдавчилсан оношилгоо, өдрийн, сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламжийг бэхжүүлнэ.

Зураг 9.2. Хүний хөгжил

ХҮНИЙ ХӨГЖИЛ

Хүний хөгжлийг дэмжин, ажиллаж амьдрах тав тухтай орчинг бүрдүүлэх замаар “Хүн төвтэй Хот” болон хөгжинө.

ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИНДЕКС



НИЙТ ИРГЭД - ТЭГШ ХҮРТЭЭМЖ



Төрийн үйлчилгээ



Хөдөлмөр эрхлэлт



Боловсрол




Эрүүл мэнд

Нийгмийн дэд бүтцийн чанар хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн оролцоог ханган **ИДЭВХТЭЙ ИРГЭД** -г төлөвшүүлнэ.

Иргэн төвтэй нийгмийн үйлчилгээний чанар хүртээмж, тэгш байдлыг хангасан үр ашигтай тогтолцоог бэхжүүлж **БҮТЭЭГЧ ИРГЭД**-ийг бэлтгэнэ.

Дэлхийд өрсөлдөх чадвартай, бүтээлч, нийгмийн идэвхтэй иргэд бүхий хотын хөгжлийг дэмжиж **ОЮУНЛАГ ИРГЭД**-тэй болно.

ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИНДЕКС БА УЛС ОРНУУД



- 9.1.13. Шинжлэх ухааны дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлэх, өндөр хөгжилтэй орны эмч, эмнэлгийн мэргэжилтнийг багаар нь урьж ажиллуулах, үндэсний мэргэжилтнийг сургаж чадавхжуулах замаар өндөр технологи, ур чадвар шаардсан тусламж, үйлчилгээг эх орондоо үзүүлдэг болно.
- 9.1.14. Эрүүл мэндийн урт хугацааны тусламж, үйлчилгээний загварыг гаргаж, сэргээн засах, хөнгөвчлөх, сувилахуйн төвийг байгуулах, энэ чиглэлд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын оролцоог хангана.
- 9.1.15. Нийгмийн Эрүүл мэндийн зөвлөлийг УБ хотын хэмжээнд байгуулж, тогтвортой үйл ажиллагааг хангана.
- 9.1.16. Дүүргийн эрүүл мэндийн төвийг нэгдсэн эмнэлэг, дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв болгон хөгжүүлнэ.
- 9.1.17. Алслагдсан дүүрэг, дагуул хотод телемедицин, цахим эрүүл мэндийн дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.
- 9.1.18. Орчин үеийн техник, технологийн дэвшлийг биеийн тамир, спортын ажил, үйлчилгээнд нэвтрүүлснээр бүх насны иргэд хиймэл оюун ухаанд суурилсан спортын зөвлөн туслах үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ.
- 9.1.19. Хотын хэмжээнд бүх насны иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлэх, биеийн тамир спортын барилга байгууламжийг төлөвлөн байгуулна.
- 9.1.20. Байгууллагын нийгмийн хариуцлагыг дээшлүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчилгээ үзүүлэх орчныг бүрэн бүрдүүлнэ.
- 9.1.21. Хотын соёлт иргэнийг төлөвшүүлэхэд бүх шатны боловсролын байгууллагуудыг хамарсан төсөл хэрэгжүүлж, нийгэмд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааг төр хувийн хэвшлийн байгууллага, олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдийн үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлнэ.
- 9.1.22. Хүн амд сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг дэмжинэ.
- 9.1.23. Зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны хангамжийг сайжруулах, орон сууцжуулна.
- 9.1.24. Хөдөлмөр эрхлэлтийн хувилбарыг төрөлжүүлж, ажил эрхлэнгээ суралцах, мэргэшэх боломжтой хөтөлбөрүүд боловсруулна.

ОРЧИН ТӨВТЭЙ ШИЙДЭЛ

ЗОРИЛТ 9.2 Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи бүхий АМЬДРАЛЫН ТААТАЙ ОРЧИНТОЙ болж хөгжинө.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020-2030)	II үе шат (2031-2040)	III үе шат (2041-2050)
ЭРҮҮЛ, ЦЭВЭР ОРЧИН	НОГООН ХОТ	АМЬДРАЛЫН ТААТАЙ ОРЧИН
Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангаж, нөхөн сэргээх, хариуцлагатай, хэмнэлттэй хэрэглээг бий болгох үе	Хотын экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан ногоон, ухаалаг технологийн үе	Хүлэмжийн хийн ялгарал багатай, байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах үе
<ol style="list-style-type: none"> Экосистемийн үнэ цэн даацыг тогтоох, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон байгалийн нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх Ойн доройтол, хомстлыг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлж ойн хэвийн өсөлтийг ханган, бүтээмжийг нэмэгдүүлэх Байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэн бохирдлын эх үүсвэрийг багасгах, агаар, хөрс болон орчны бохирдлыг бууруулах Усны нөөц, ундны усны баталгаат эх үүсвэрээр хангаж, гадаргын усыг хуримтлуулах, дахин ашиглах, усны үнэ цэнийг нэмэгдүүлэх Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд технологийн шинэчлэл хийж, хог хаягдлын төвлөрсөн цэгүүдийг цэвэрлэн, цэцэрлэгт хүрээлэнгүүд бий болгох 	<ol style="list-style-type: none"> Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах чадавх бүхий тогтолцоог боловсронгуй болгох Хот суурин газрын эко-систем, биологийн олон янз байдлыг хамгаалах, голуудын урсацыг сайжруулан, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, гүний тэжээгдлийн мужийг хамгаалах, ус дахин ашиглах технологийг хэрэгжүүлэх арга хэмжээнд бүх талын оролцоог хангаж, иргэдийн оролцоотой хяналтын тогтолцоог бүрдүүлэх Үйлдвэрлэлийн усыг эргүүлэн ашиглах, хэмнэлттэй хэрэглэх, усны нөөц бохирдож хомстохоос сэргийлэх, усны нөөцийг хуримтлуулах хөв цөөрөм, усан сан байгуулах 	<ol style="list-style-type: none"> Хүлэмжийн хийн ялгарлыг бүх төвшинд боломжит хамгийн доод хэмжээнд бууруулах Хотын ногоон байгууламжийг хамгаалах, нэмэгдүүлэх, хотын соёлыг бүрдүүлэхэд иргэдийн оролцоотой хяналтын тогтолцоог бэхжүүлэх Амьдрахад ая тухтай, эрүүл орчин бүрдүүлэх, орчны стандарт мөрдөж хэвших Ойг нөхөн сэргээх менежментийг хэрэгжүүлж, таримал ойг худалдан авах, хот орчмын ойн загварыг бий болгох Хотын хэмжээнд үүсч болзошгүй байгалийн аюулт үзэгдэл, ган зуд, цаг агаарын өөрчлөлт, халуун, хүйтэн эрс тэс уур амьсгалын улмаас иргэдийн эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөлд бүх түвшинд бэлэн байх нөхцөлийг бүрдүүлэх

- | | | |
|---|---|---|
| 6. Хотын цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, хот доторх оршуулгын газрын шарилыг чандарлаж цэвэрлэж цэцэрлэгт хүрээлэн болгох | 4. Шинээр барьж буй хороолол, хотхоны ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж, хог хаягдлын автоматаар татан авах / хог хаягдлыг татан авах шугам/ технологийг нэвтрүүлэх | 6. Ногоон бүсийн ойн экосистемийн үнэ цэнийг шинэчлэн тогтоож, ой хамгааллын олон талт арга хэмжээг хэрэгжүүлэх |
| 7. Хотын ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнгийн талбайг боломжит бүх байршилд нэмэгдүүлэх, | 5. Ахуйн хэрэглээний болон цахилгаан станцуудаас гарах үнс, лаг хог хаягдлыг дахин ашиглаж, хоёрдогч бүтээгдэхүүн үйлдвэрлэх | 7. Усны нөөцийг хуримтлуулах, зохистой ашиглах тогтвортой менежментийг хэрэгжүүлэх |
| 8. Хүнсний аюулгүй байдлыг хангах, хөдөө орон нутгаас нийлүүлдэг органик хүнсний сүлжээ бий болгох | 6. Тээврийн салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгоор нийтийн тээврийн хэрэглээг бүрэн цахилгаанжуулах | |
| 9. Бохирдол бага ялгаруулах, хог хаягдалгүй хэрэглээг нэмэгдүүлэхэд захиргааны болон урамшууллын аргыг хослуулан хэрэглэх | 7. Барилга байгууламжуудыг ногоон барилгын стандартад нийцүүлэх | |
| 10. Ойг нөхөн сэргээх цогц арга хэмжээг хэрэгжүүлж, таримал ойг худалдан авах ажлыг эрчимжүүлэх, урамшууллын хөшүүргийг хэрэглэх | 8. Гэр хорооллын болон ногоон бүсийн айл өрхүүдийн эрчим хүчний хэрэглээг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт шилжүүлэх, өрхийн үйлдвэрлэсэн цахилгааныг төвийн сүлжээнд нийлүүлэх боломжийг бүрдүүлэх | |
| 11. Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг даван туулах, гамшгийг эрт илрүүлэх, тэсвэрлэн гарах чадавхыг бэхжүүлэх | 9. Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ойн экосистемийг бий болгох, ой хамгаалал нөхөн сэргээлтийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх | |
| 12. Агаар, орчны чанарын хяналт-шинжилгээний чадавхыг олон улсын түвшинд хүргэх | 10. Хамтын оролцоотой байгалийн нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх | |

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

9.2.1. Хот суурин газрын экосистемийн үнэ цэн, экологийн даацыг тогтоох, уур амьсгалын өөрчлөлтийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийх, гамшгийн эрсдэлийг бууруулах менежментийн цогц тогтолцоог боловсронгуй болгон хөгжүүлэх, ногоон бүсийн экологийн коридоруудыг байгуулна.

- 9.2.2. Байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх замаар бохирдлын бүх эх үүсвэрийг багасгаж, дахин ашиглах саармагжуулах боломжийг бүрдүүлнэ.
- 9.2.3. Хотын уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ойн экосистемийг бий болгох, ой хамгааллын тогтвортой менежментийг хэрэгжүүлэх, экосистемийн үйлчилгээний төлбөрийн системийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.
- 9.2.4. Хөрс хамгаалах, хөрсний бохирдлыг биологийн болон технологийн аргаар нөхөн сэргээх, экологийн ач холбогдол бүхий байршлуудад ойг нөхөн сэргээж таримал ойг улсын ойн санд худалдан авах менежментийг хэрэгжүүлнэ.
- 9.2.5. Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ойн экосистемийг бий болгох, ой хамгааллын болон нөхөн сэргээлтийн тогтвортой менежментийг шинжлэх ухаан, технологийн шинэ ололтуудад тулгуурлан хэрэгжүүлнэ.
- 9.2.6. Ой, усны сан бүхий газрын хориглосноос бусад бүсэд эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн газрын төлбөрийг эрс нэмэгдүүлэх, экосистемийн үйлчилгээний төлбөр авах замаар ой, усны санд газар эзэмших сонирхлыг хязгаарлах, хуримтлагдсан орлогыг ус, ойн нөөцийг хамгаалах төслүүдэд зарцуулна.
- 9.2.7. Мод үржүүлгийн газрын үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэж, ногоон байгууламжид ашиглах суулгацын чанарыг дээшлүүлж, ашигт ургамлын төрөл зүйлийг нэмэгдүүлнэ.
- 9.2.8. Орчны чанарын хяналт-шинжилгээний чадавхыг бэхжүүлэн судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлж, лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
- 9.2.9. Нийслэлийн авто тээврийн хэрэгслээс гарах ялгарлыг бууруулах, гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг эрчимжүүлэх, агаарын бохирдлын идэвхжил ихтэй бүсийг орон сууцжуулах асуудлыг шат дараатай системтэй хэрэгжүүлснээр агаарын бохирдлыг бууруулна.
- 9.2.10. Уул уурхайн улмаас эвдэрсэн газрын нэгдсэн мэдээллийн санг үүсгэх, нөхөн сэргээлтийн технологи арга зүй, эрх зүйн орчны давхардал хийдлийг арилгана.
- 9.2.11. Усны нөөц, ундны усны баталгаат эх үүсвэрээр хангах, хамгаалах, усны үнэ цэнийг нэмэгдүүлж зохистой хэрэглээг эдийн засгийн аргаар хэвшүүлнэ.
- 9.2.12. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийг тусгай хамгаалалтад авч, дэглэмийг чанд мөрдүүлнэ.
- 9.2.13. Ундны усны нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр “Туул усан цогцолбор” төслийн ТЭЗҮ, ажлын зураг төслийг боловсруулан барилга угсралтын ажлыг хийнэ.

- 9.2.14. Ус хангамжийн эх үүсвэр, усан сан, гүний худаг, насос станцын аюулгүй байдлыг хангах нэгдсэн хяналтын төвийг байгуулж, теле хяналт, холбоо дохиоллын техник хэрэгслээр тоноглож, дамжуулах, түгээх шугамыг салгах төсөл хэрэгжүүлнэ.
- 9.2.15. Боломжит бүх байршилд гадаргын ус хуримтлуулах хөв цөөрөм, усан сан байгуулна.
- 9.2.16. Хаягдал лаг, тунадсыг боловсруулан эцсийн бүтээгдэхүүн болгох, цэвэрлэсэн усыг боловсруулж, дахин давтан ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, эргүүлэн ашиглах гол шугам сүлжээ төслийг хэрэгжүүлнэ.
- 9.2.17. Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэр, ус цэвэршүүлэх үйлдвэр, цэвэрлэх байгууламжаас гарсан хаягдал усыг дахин цэвэршүүлнэ.
- 9.2.18. Айл өрхийн нүхэн жорлон болон хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй бохирдолд байгаль орчны нэгдсэн дүгнэлт хийж, байгаль орчин бохирдуулсны нөхөн төлбөр тооцох эрх зүйн орчин бүрдүүлж гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг стандартад нийцүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.
- 9.2.19. Үйлдвэрлэлийн зориулалтаар гүний цэвэр ус ашиглах явдлыг хязгаарлах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж, саарал усны хэрэглээг нэвтрүүлнэ.
- 9.2.20. Айл өрхүүдийн стандартын бус ариун цэврийн байгууламжийг шинэчлүүлэх, ялгадсыг бордоо болгон эдийн засгийн эргэлтэд оруулна.
- 9.2.21. Хотын цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх, хот доторх оршуулгын газрын шарилыг чандарлаж цэвэрлэнэ.
- 9.2.22. Хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд технологийн шинэчлэл хийж, стандартыг бий болгох, дахин боловсруулах үйлдвэрт шилжүүлэх, хог хаягдлын төвлөрсөн цэгүүдийг цэвэрлэж, нөхөн сэргээх
- 9.2.23. Аюултай хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, саармагжуулах, устгах тогтолцоог бий болгоно.
- 9.2.24. Дахивар түүхий эдийг дахин боловсруулах жижиг, дунд үйлдвэрүүдийг төрөлжүүлэх, технологийн шинэчлэл хийх, хөгжүүлэх, хаягдалгүй технологи бүхий үйлдвэрлэлийг бий болгоно.
- 9.2.25. Нарангийн энгэр, Цагаан давааны төвлөрсөн хогийн цэгийн ландфилын талбайг бүрэн хааж, нөхөн сэргээнэ.
- 9.2.26. Хотын барилга, байгууламжийг паспортжуулах, тэдгээрийн чанар, насжилтыг тодорхойлох, газар хөдлөлтийн үед тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт хийх, эрсдэлтэй байгууламжийг хүчитгэх, эсвэл буулгаж шинэчлэн барилгажуулах ажлыг зохион байгуулна.
- 9.2.27. Улаанбаатар хотын үерийн хамгаалалтын барилга байгууламж төлөвлөх арга аргачлал, загварчлал хийх, инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө боловсруулан батлуулж, эрсдэлтэй бүсүүдэд гидрогеологийн хэмжилт хийж, хяналтын цооног байгууламж хяналтын нэгдсэн системд холбоно.
- 9.2.28. Болзошгүй аюулт үзэгдэл, ослын үеийн мэдээлэл, харилцаа холбооны тогтолцоо, нөөцийн удирдлагыг боловсронгуй болгох, инженерийн бэлтгэл арга хэмжээг бүрэн хангасан, үерийн эрсдэлгүй хот болно.
- 9.2.29. Улаанбаатар хотын ногоон байгууламжийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх, хотыг цэцэрлэгжүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, дэмжих санхүүжилт, татвар, зээл, урамшууллын оновчтой хөшүүргийг бий болгоно.
- 9.2.30. Хот суурин газрын ногоон байгууламжийн усалгааны арга технологид шинэчлэлт хийж, усалгааны горимыг мөрдүүлэх, үерийн эрсдэлтэй бүсүүдэд шинээр далан суваг барих, хөрс болон замын ус зайлуулах шугам барихдаа ус хуримтлуулах хөв цөөрөм, далд усан сангууд барьж байгуулах усыг олон зориулалтаар ашиглах, голуудын урсац тохируулга хийх шийдлийг тусган барьж байгуулна.
- 9.2.31. Гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж бүрэн камержуулах, ард иргэдийн аюулгүй байдлыг хангах, гудамж, талбайн нэр, байшин барилгын хаягийн нэгдсэн стандарт хангуулах, хотын соёлыг нэмэгдүүлнэ.
- 9.2.32. Хотын иргэдэд нийлүүлж буй хүнсний аюулгүй байдлыг хангах, хөдөө орон нутгаас нийлүүлдэг органик хүнсний сүлжээ бий болгоно.
- 9.2.33. Голын эх, ус намаг бүхий газруудыг орон нутгийн тусгай хамгаалалтад авч, барилгажихаас сэргийлэн ус шингээх чадварыг хэвээр нь хадгалах замаар үерийн эрсдэлийг бууруулна.
- 9.2.34. Улаанбаатар хотын ойн түймрээс хамгаалах шороон зурвасуудыг шинээр болон шинэчлэн байгуулах замаар түймрийн эрсдэлийг бууруулна.
- 9.2.35. Орон нутгийн хамгаалалттай газруудын сүлжээг нэмэгдүүлж, биологийн олон янз байдлын өсөж, үржих таатай нөхцөлийг бүрдүүлэн экологийн тэнцэл алдагдахаас сэргийлнэ.

Зураг 9.3. Орчин төвтэй шийдэл

ОРЧИН ТӨВТЭЙ ШИЙДЭЛ

ЦЭВЭР АГААР

ЭРҮҮЛ ХӨРС

НОГООН БАЙГУУЛАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

ЭКОЛОГИЙН КОРИДОР БАЙГУУЛАХ



Хотын эко системийн тэнцвэрт байдлыг хангасан ногоон технологи бүхий амьдрах таатай орчин бүрдсэн хот болно.



Зураг 9.4. Хаягдалгүй хот

ХАЯГДАЛГҮЙ ХОТ

ДАХИН БОЛОВСРУУЛАХ

ЭКО ПАРК

ЭРЧИМ ХҮЧ ҮЙЛДВЭРЛЭХ

Хог хаягдлыг ангилан ялгах стандартыг хэрэгжүүлэн, дахин боловсруулах эко парк байгуулж, хог хаягдлаас эрчим хүч гаргадаг болно.



ТӨЛӨВЛӨЛТ ТӨВТЭЙ ХӨГЖИЛ

ЗОРИЛТ 9.3 Орон зайн оновчтой төлөвлөлт бүхий суурьшлын зөв тогтолцоотой, эрчимтэй хөгжиж буй дагуул хотуудтай олон улсад өрсөлдөгч МЕТРОПОЛИТАН болж хөгжинө.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
ОРОН ЗАЙН ОНОВЧТОЙ ТӨЛӨВЛӨЛТ	ОЛОН ТӨВТ ХОТ	МЕТРОПОЛИТАН
Хотын төвлөрлийг задалж дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ухаалаг технологийн шинэчлэлийн үе	Дэд бүтцийн бүрэн хангамжтай, ухаалаг систем бүхий хотын хөгжлийг эрчимжүүлэх үе	Амьдралын таатай орчин бүрдсэн МЕТРОПОЛИТАН хөгжлийн үе
<ol style="list-style-type: none"> Улаанбаатар хотын газар зохион байгуулалт, төвлөрөл, суурьшсан нутаг дэвсгэрийн тэлэлт, хязгаарлалт, авто замын сүлжээ, нийтийн тээвэр, газар доорх орон зайг оновчтой ашиглах гэх мэт шаардлагатай төлөвлөлтийг тооцож хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан мэдээллийн нэгдсэн системд холбон хот байгуулалтын үйл ажиллагааг явуулна. Хот дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцжуулах Инженерийн дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлж, шинэ технологийг нэвтрүүлэн, бүрэн хангамжийн суурь түвшинг нэмэгдүүлэх Хотын орон зайн түвшинд аюулгүй байдлыг хангасан автоматжуулалт, олон төрөлт, ухаалаг нийтийн тээврийн үйлчилгээ, сүлжээг бий болгож, хэрэглээнд нэвтрүүлэх 	<ol style="list-style-type: none"> Улаанбаатар хотод Хотын төв, дэд төвүүд үүсэж, тэдгээрийг холбосон хөгжлийн коридорыг бий болгох Цахим суурьтай санхүүгийн технологи / Fintech/, цахим банк / Digital banking/, цахим мөнгө, хиймэл оюун ухаан /AI/, блокчэйн технологи /blockchain/, автоматжуулалт, үүлэн технологи, хатуу болон зөөлөн дэд бүтцийг хүчирхэгжүүлэх Нийт эрчим хүчний баланс эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийн хувийн жин нэмэгдэж, бүс нутгийн цахилгаан хангах Ачаа тээврийн Богдхан төмөр зам барьж байгуулах 	<ol style="list-style-type: none"> Амьдралын таатай орчин бүрдсэн метрополитаны жишгээр хөгжүүлэх Хиймэл оюун ухаанд суурилсан ухаалаг системийн дараагийн үе шатны технологийг хот байгуулалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх Бүс нутгийг УБ хоттой холбосон хурдтай тээврийг нэвтрүүлэх Улаанбаатар хот, дагуул хотуудын авто замын сүлжээг өргөтгөх Сэргээгдэх буюу ногоон эрчим хүчний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх ба бүс нутагтаа эрчим хүчийг тогтвортой нийлүүлэх Олон улс, тив, дэлхийн томоохон наадмуудыг хүлээн авч зохион байгуулах

- Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлэх нэгдсэн бодлого боловсруулан хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.
- Богдхан уулыг тойрох зорчигч тээврийн төмөр замыг барьж байгуулах
- Улаанбаатар хотод авто машиныг хамтран эзэмших (car pool), авто машин түрээслэх (car sharing) үйлчилгээг нэвтрүүлэх
- Хот хоорондын хөнгөн галт тэргийг нэвтрүүлэх, газар доорх тээврийн сүлжээг хөгжүүлэх ажлыг эрчимжүүлэх
- Хот тосгодыг холбосон хурдны замыг барьж байгуулах, хотын гол гудамж замуудыг холбосон туслах гудамж зам, нутаг дэвсгэрийн гудамж замын сүлжээг иж бүрэн барьж байгуулах

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 9.3.1. Улаанбаатар хотын газар зохион байгуулалт, төвлөрөл, суурьшсан нутаг дэвсгэрийн тэлэлт, хязгаарлалт, авто замын сүлжээ, зогсоол, нийтийн тээвэр, газар доорх орон зайг оновчтой ашиглах гэх мэт шаардлагатай төлөвлөлтийг тооцож хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан мэдээллийн нэгдсэн системд холбосон хот байгуулалтын үйл ажиллагааг явуулна.
- 9.3.2. Хотын төв, дэд төвүүд үүсэж, тэдгээрийг холбосон хөгжлийн коридорыг бий болгоно.
- 9.3.3. Хотыг дахин хөгжүүлэх төслийн хүрээнд бүрэн орон сууцжуулна.
- 9.3.4. Түүх, соёлын өвийг хадгалж, хамгаалах, сэргээн засварлах үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлнэ.
- 9.3.5. Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлэх нэгдсэн бодлого боловсруулан хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.
- 9.3.6. Зарим их, дээд сургуулиудыг мэргэжлийн чиглэл, салбараар нь харгалзан дагуул хотуудад кампус байгуулж шилжүүлэх замаар хотын төвлөрлийг сааруулна.
- 9.3.7. Найрамдалт хотуудтай эдийн засгийн интеграцад нэгдэх замаар гадаад худалдааны шинэ боломжуудыг нээж, худалдааны шинэ сүлжээ бий болгоно.
- 9.3.8. Газар доорх орон зайг оновчтой ашиглаж зам, тээвэр, инженерийн шугам сүлжээнд ашиглана.
- 9.3.9. Хиймэл оюун ухаанд суурилсан ухаалаг системийн дараагийн үе шатны технологийг хот байгуулалтын үйл ажиллагаанд нэвтрүүлнэ.
- 9.3.10. Олон улс, бүс нутгийн хэмжээнд өрсөлдөгч метрополитан хот болон хөгжинө.
- 9.3.11. Хотын орон зайн түвшинд аюулгүй байдлыг хангасан автоматжуулалт, олон төрөлт, ухаалаг нийтийн тээврийн үйлчилгээ, сүлжээг бий болгож, хэрэглээнд нэвтрүүлнэ.

- 9.3.12. Хотын хэвтээ чиглэл, босоо чиглэл, тойрог чиглэлийн авто замын сүлжээ, хаяа дагуул хотын замын сүлжээг барьж байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 9.3.13. Зорчигч урсгал ихтэй томоохон коридор дагуу багтаамж ихтэй зорчигч тээврийн төрлийг нэвтрүүлнэ.
- 9.3.14. “Агаарын дүүжин замын тээврийн төсөл”-ийг хэрэгжүүлж, зориулалтын зогсоол, дэд бүтцийг барьж байгуулна.
- 9.3.15. Тусгай замын автобусны сүлжээг байгуулна.
- 9.3.16. Шинээр барьж байгуулах авто зам, замын байгууламжийн хамгаалалтын зурваст орсон айл өрх, аж ахуйн нэгж, инженерийн шугам сүлжээнүүдийг нүүлгэх, шилжүүлэх, газар ашиглалт, зохион байгуулалтын менежментийг хийж, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу гудамж, замын сүлжээг барьж байгуулна.
- 9.3.17. Замын сүлжээнд ухаалаг системийг бүрэн нэвтрүүлнэ.
- 9.3.18. Авто үйлчилгээний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулж, авто үйлчилгээний салбарт баталгаат үйлчилгээний тогтолцоог сайжруулна.
- 9.3.19. Ачаа тээврийн логистикийн төвүүдийг барьж байгуулах ба хотын дэд төвүүдийг түшиглэн түгээлтийн төв байгуулах, логистикийн төвөөс түгээлтийн төв рүү хотын захын гол замуудаар хүнд даацын том оврын тээврээр тээвэрлэлт хийх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 9.3.20. Зорчигчийн урсгалаас хамааран хаяа дагуул хотуудыг холбосон их багтаамжийн тээврийг нэвтрүүлнэ.
- 9.3.21. Зорчигч тээврийн үйлчилгээний дамжин суулт хийх нэгдсэн терминал болон зогсоолуудыг нэгдсэн уялдаатайгаар барьж байгуулна.
- 9.3.22. Сургуулийн хүүхдэд зориулсан тээврийн үйлчилгээг хөгжүүлнэ.
- 9.3.23. Тээврийн хэрэгслийг цахилгаан болон хийн эх үүсвэрээр цэнэглэх сүлжээ байгуулна.
- 9.3.24. Нийтийн тээврийн удирдлага, мэдээллийн болон хяналтын төвийг шинэчлэх, замын сүлжээ, авто үйлчилгээний бүртгэл мэдээллийн нэгдсэн санг бий болгон цахим ухаалаг системийг бүрэн нэвтрүүлнэ.
- 9.3.25. Явган хүний болон унадаг дугуйн зам барьж байгуулах, өргөтгөх, нүхэн, гүүрэн гарцыг нэмэгдүүлэх, зогсоолыг төрөлжүүлэх, хяналтын системийг бий болгоно.
- 9.3.26. Хотын авто машины зогсоолын менежментийн боловсронгуй тогтолцоог бий болгоно.
- 9.3.27. Улаанбаатар хотод авто машиныг хамтран эзэмших (car pool), авто машин түрээслэх (car sharing) үйлчилгээг нэвтрүүлнэ.
- 9.3.28. Хотын такси тээврийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

- 9.3.29. Богдхан уулыг тойрох зорчигч тээврийн төмөр замыг барьж байгуулна.
- 9.3.30. Ачаа тээврийн Богдхан төмөр зам барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.
- 9.3.31. Зорчигч урсгалаас хамааруулан хаяа дагуул хотуудыг холбосон багтаамж ихтэй тээврийг нэвтрүүлнэ.
- 9.3.32. Хот тосгодыг холбосон хурдны замыг барьж байгуулна.
- 9.3.33. Бүс нутгийг Улаанбаатар хоттой холбосон тусгай замын өндөр хурдтай тээврийг нэвтрүүлнэ.
- 9.3.34. Инженерийн дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлж, шинэ шийдэл технологийг нэвтрүүлж, бүрэн хангамжид хүргэнэ.
- 9.3.35. Эрчим хүчний хэмнэлтийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 9.3.36. Төвлөрсөн дулаан хангамжийн системд холбогдох боломжгүй бүсүүдэд байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи бүхий хэсэгчилсэн, бие даасан эх үүсвэрүүд барьж, сүлжээний оргил ачааллын үед сүлжээнд нэмж холбох боломжтой байдлаар сүлжээ зохион байгуулна.
- 9.3.37. Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэн барьж ашиглалтад оруулна.
- 9.3.38. Хаягдал лаг, тунадсыг боловсруулан эцсийн бүтээгдэхүүн болгох, эргүүлэн ашиглах гол шугам сүлжээ барих төслийг хэрэгжүүлнэ.
- 9.3.39. Улаанбаатар хотын ус хангамжийн баруун доод эх үүсвэр, ус цэвэршүүлэх үйлдвэр, дамжуулах шугам барьж ашиглалтад оруулна.
- 9.3.40. Усны нөөцийн газрыг бохирдлоос хамгаалах дэглэмийг мөрдүүлэх, байгаль орчин бохирдуулсны нөхөн төлбөр тооцох эрх зүйн орчин бүрдүүлж, гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулна.
- 9.3.41. Инженерийн бэлтгэл арга хэмжээг бүрэн хангасан, үерийн эрсдэлгүй хот болно.
- 9.3.42. “Sponge city” “хөвөн систем” хөтөлбөрийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, олон улсад мөрдөгдөж буй норм стандартыг нутагшуулах, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 9.3.43. Ус дахин ашиглах технологийг бүсийн хэмжээнд хэрэгжүүлсэн байна.
- 9.3.44. Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу нийслэл болон дагуул, хаяа хот, тосгоны инженерийн бэлтгэл арга хэмжээг үе шаттай барьж байгуулах, өргөтгөн шинэчилнэ.
- 9.3.45. Хот дахин төлөвлөлтийн хүрээнд гэр хорооллыг төвлөрсөн, хэсэгчилсэн болон бие даасан инженерийн хангамжид холбох, сэргээгдэх эрчим хүчийг ашиглана.

Зураг 9.5. Олон төрөлт ухаалаг тээврийн сүлжээ

ОЛОН ТӨРӨЛТ УХААЛАГ ТЭЭВРИЙН СҮЛЖЭЭ

АВТО ТЭЭВЭР

АГААРЫН ТЭЭВЭР

ТУСГАЙ ЗАМЫН АВТОБУС (BRT)

АГААРЫН ДҮҮЖИН ЗАМЫН ТЭЭВЭР

ЦАХИЛГААН СОРОНЗОН ТЭЭВЭР

ГАЗАР ДООРХ ТЭЭВЭР

ХОТ ХООРОНДЫН ХӨНГӨН ТЭЭВЭР


БҮС НУТАГ ХООРОНДЫН ХУРДНЫ ТЭЭВЭР

Олон төрөлт, ухаалаг болон газар доорх багтаамж ихтэй нийтийн тээврийн сүлжээг бий болгон, Улаанбаатар хотыг дагуул хотуудтай холбосон зорчигч тээвэр, бүс нутагтай холбосон тусгай замын өндөр хурдны тээврийг нэвтрүүлж түгжрэлгүй, эдийн засгийн хэмнэлттэй хот болон хөгжинө.



Зураг 9.6. Улаанбаатар метрополитан

УЛААНБААТАР МЕТРОПОЛИТАН



ХӨГЖЛИЙН ТӨСӨӨЛӨЛ

Аялал жуулчлал



Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл



Соёл боловсрол, их дээд сургууль



Чөлөөт бүс, тээвэр логистик




Орон зайн оновчтой бүтэц, нутагшилт суурьшлын зөв тогтолцоотой, эрчимтэй хөгжиж буй дагуул хотуудтай, эрүүл аюулгүй, амьдралын таатай орчин бүхий олон улсад өрсөлдөгч МЕТРОПОЛИТАН болон хөгжинө.

Банк санхүү, худалдаа үйлчилгээ



Үйлдвэрлэл, технологийн парк



ХОТЫН САЙН ЗАСАГЛАЛ

ЗОРИЛТ 9.4. Сайн засаглалтай, хууль эрх зүйн тогтвортой орчинтой, орчны стандартыг хангасан хот болж хөгжинө.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ	ХОТЫН ТОГТВОРТОЙ ЗАСАГЛАЛ	ХОТЫН САЙН ЗАСАГЛАЛ
Хууль, эрх зүйн шинэчлэл хийж, хотын засаглал, нийгэм эдийн засгийн таатай орчныг бүрдүүлэх үе	Хотын тогтвортой засаглалыг бэхжүүлэх, олон улсын найрсаг харилцааны эрх зүйн орчныг бүрдүүлэх үе	Хотын сайн засаглалыг бэхжүүлэх, олон улсын тогтвортой харилцааг бэхжүүлэх үе
<ol style="list-style-type: none"> Хотын засаглалын оновчтой тогтолцоог бүрдүүлэн бүх шатны төлөвлөлт, төлөвлөгөөг боловсруулж, батлах, шийдвэр гаргахад иргэд, олон нийтийн оролцоог хангаж, иргэдийн мэдээлэл олж авах сувгийг нээлттэй, хүртээмжтэй, ил тод болгох Хотын засаглалд төр, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага, олон нийтийн оролцоо, түншлэлийг бэхжүүлэх, хувийн хэвшлийн байгууллагуудын нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийг үр ашигтай байлгахад чиглүүлэх Мэдээллийг цахимжуулж, иргэдэд төрийн үйлчилгээг цахимаар цогц байдлаар хүргэх тогтолцоог бий болгон хэрэгжүүлэх 	<ol style="list-style-type: none"> Иргэд төрийн байгууллагад очилгүйгээр цахимаар төрийн үйлчилгээг авах боломжийг бүрэн бүрдүүлэх, иргэнээ дээдэлсэн төрийн үйлчилгээний тогтолцоо бэхжүүлэх Хотын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг эдийн засаг, нийгмийн үр ашгаар эрэмбэлэн санхүүжүүлэх, хөрөнгө оруулалтын сан байгуулж, нэгдсэн менежментийн тогтолцоо бүрдүүлэх Орон нутгийн өмчит газруудыг олон нийтийн компани / IPO / болгох замаар үр ашгийг нэмэгдүүлж, менежментийг сайжруулах Ашиглаагүй үл хөдлөх хөрөнгийг үр ашигтай эзэмших, удирдах, хөгжүүлэх, эдийн засгийн чөлөөт эргэлтэд оруулах зорилго бүхий тогтолцоог бүрдүүлэх 	<ol style="list-style-type: none"> Хотын эрүүл, аюулгүй, ногоон хөгжлийг дэмжсэн, нийгмийн соёлыг төвлөрүүлсэн, байгууллага, хувь хүний ёс зүй, хотын соёлыг төлөвшүүлэх хот байх эрх зүйн зохицуулалтыг хангах Иргэд, бизнесийн төлөөлөгчид, жуулчдад таатай төрийн үйлчилгээг бэхжүүлэх, үндэстэн дамнасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх УБ хотод үйл ажиллагаа явуулж буй төр, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагын нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх

4. Хотын бүсчлэл, авто замын бүсчлэл бий болон бүсийн зэрэглэл тогтоож, бүсчлэлийн дагуу ялгаатай газрын төлбөр болон үл хөдлөх хөрөнгийн татварын хувь хэмжээ тогтоох, төвийн бүсэд зорчих тээврийн хэрэгсэлд тодорхой нөхцөл, шаардлага тавьж зорчуулах

5. Олон улсын дээд түвшний чуулга уулзалт, товлосон хөтөлбөр бүхий үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах эрх зүйн орчин бүрдүүлэх


5. Хотын татварыг төрөлжүүлэн, архи, согтууруулах ундаа, тамхины болон авто машины, агаарын бохирдлын онцгой татвар бий болгох

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 9.4.1. Хотын бие даан хөгжих хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, хотын багц дүрэмтэй болж, бүс нутгийн хөгжлийн бодлоготой уялдсан салбаруудын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулна.
- 9.4.2. Хотын засаглалын оновчтой тогтолцоог бүрдүүлэн бүх шатны төлөвлөлт, төлөвлөгөөг боловсруулах, батлах, шийдвэр гаргахад иргэд, олон нийтийн оролцоог хангаж, иргэдийн мэдээлэл олж авах сувгийг нээлттэй, хүртээмжтэй, ил тод болгоно.
- 9.4.3. Хотын засаглалд төр, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага, олон нийтийн оролцоо, түншлэлийг бэхжүүлэх, хувийн хэвшлийн байгууллагуудын нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийг үр ашигтай байлгахад чиглүүлнэ.
- 9.4.4. Хэрэгжүүлэгч агентлагуудын менежментийг сайжруулан, хүний нөөцийг чадавхжуулна.
- 9.4.5. Хотын нэгдсэн стандартыг боловсруулж, хэрэгжүүлэх, хяналт-мониторингийн судалгаа шинжилгээний цогц үйлчилгээ үзүүлэх тогтолцоо бий болгоно.
- 9.4.6. Иргэд, ААН байгууллагад хог хаягдлыг ангилан ялгах стандарт тогтоож, хэрэгжүүлнэ.
- 9.4.7. Мэдээллийг цахимжуулж, иргэдэд төрийн үйлчилгээг цахимаар цогц байдлаар хүргэх тогтолцоог бий болгож хэрэгжүүлнэ.
- 9.4.8. Гадаадын бизнес төлөөлөгч, жуулчдад ээлтэй, аюулгүй байдлыг хангасан, ухаалаг үйлчилгээний тогтолцоо бүрдүүлнэ.
- 9.4.9. Хотын бүсчлэл, авто замын бүсчлэл бий болгон бүсийн зэрэглэл тогтоож, төвийн бүсэд үйл ажиллагаа явуулж буй ААН байгууллагад бүсийн татвар ногдуулах, төвийн бүсэд зорчих тээврийн хэрэгслийг тодорхой нөхцөл, шаардлага тавьж зорчуулна.
- 9.4.10. Хотын татварыг төрөлжүүлэн архи, согтууруулах ундаа, тамхины болон авто машины, агаарын бохирдлын онцгой татвар бий болгоно.

Зураг 9.7. Олон төвт хот

ОЛОН ТӨВТ ХОТ



ХӨГЖЛИЙН ТӨСӨӨЛӨЛ

Хотын төв



Хотын шинэ төв



Хотын дэд төв



Хотын дэд төв




Хотын олон нийтийн төв



Хотын төрөлжсөн төв



Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилгоор соёл боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн дэд бүтцийн хангамж бүхий хотын төв, дэд төв, төрөлжсөн төв, олон нийтийн төвүүдийг шинээр байгуулж олон төвт хотын тогтолцоог бүрдүүлнэ.




Зураг 9.8. Зүүн хойд Азийн ачаа тээврийн зангилаа төв

ЗҮҮН ХОЙД АЗИЙН АЧАА ТЭЭВРИЙН ЗАНГИЛАА ТӨВ

- **ЛОГИСТИК**
 - Баян өртөө
 - Аргалант-эмээлт
 - Аэросити
- **ТҮГЭЭЛТИЙН ТӨВ**
 - Улаанбаатар хотын 9 байршилд
- **ТӨРӨЛЖСӨН АГУУЛАХЫН АЖ АХУЙ /МЕГА/**
 - Аргалант-Эмээлт
 - Багахангай
 - Налайх

Олон улсын нисэх онгоцны шинэ буудал болон шинээр төлөвлөж байгаа Алтанбулагаас Замын-Үүд чиглэлийн Богдхан төмөр зам, АН-3 хурдны авто зам, эрчим хүчний сүлжээний томоохон төслүүдэд тулгуурлан Хөшигийн хөндий дэх Аэросити хотод Зүүн хойд Азийн ачаа тээврийн нэгдсэн зангилаа төвийг байгуулна.



ДАГУУЛ ХОТ

ЗОРИЛТ 9.5 Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээг бий болгосон, Зүүн хойд Азийн тээвэр, логистикийн болон олон улсын харилцааны зангилаа төв хот болсон ДАГУУЛ ХОТУУД-ыг хөгжүүлнэ.

ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛ

I үе шат (2020–2030)	II үе шат (2031–2040)	III үе шат (2041–2050)
ҮЙЛДВЭРЛЭГЧ ХОТУУД	ТӨРӨЛЖСӨН ХӨГЖИЛТЭЙ ХОТУУД	ӨРСӨЛДӨГЧ ХОТУУД
Хөрөнгө оруулалтын шинэ боломж бүрдүүлж, үйлдвэрлэлийн бүс нутгийг тэлэх үе	Нутагшилт суурьшлын зөв тогтолцоотой, эдийн засгийн төрөлжилтийг эрчимжүүлэх үе	Олон улсад өрсөлдөхүйц эрчимтэй хөгжлийн үе
<ol style="list-style-type: none"> Олон төвт хотын тогтолцоо хэрэгжүүлж, дагуул хотуудыг барьж байгуулах буюу “Аэро сити”, “Майдар” сити шинэ хотын бүтээн байгуулалт эхлүүлж инженерийн шугам сүлжээнд бүрэн холбох, орон сууцжуулах ажлыг эрчимжүүлэх УБ хотын Олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг ашиглалтад бүрэн оруулж, Хойд Азийн зорчигч, ачаа тээвэрлэлтийн зангилаа нэгдсэн логистик төв болгон хөгжүүлэх Хот толгодыг холбосон хурдны тойрог зам барьж байгуулах, тойрог зам дагуу аялал жуулчлалын цогцолборуудыг байгуулах төлөвлөлт хийж, бизнес эрхлэгчдийг дэмжих, түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлаж, аялал жуулчлалын эргэлтэд оруулах, Монгол брэндийн худалдааны төв нээж ажиллуулах Өндөр технологи, мэдлэгт суурилсан үйлдвэрлэлийг хөгжүүлэх 	<ol style="list-style-type: none"> Улаанбаатар бүсийн хэмжээнд эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулах замаар өндөр технологийн үйлдвэрүүдийг нутагшуулж, ажлын байр нэмэгдүүлж дэлхийн зах зээлд өрсөлдөх боломжтой тул хууль эрх зүйн орчинг бүрдүүлж, чөлөөт бүсийг байгуулах Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд аялал жуулчлалын томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх Үндэстэн дамнасан корпорац болон олон улсын байгууллагуудын салбаруудыг бий болгох Найрамдалт хотуудтай эдийн засгийн интеграцад нэгдэх замаар гадаад худалдааны шинэ боломжуудыг нээж, худалдааны шинэ сүлжээ бий болгох Хөдөө, орон нутгаас нийлүүлдэг органик хүнсний сүлжээгэр дамжуулан Монгол брэндийн худалдааны сүлжээг өргөтгөх 	<ol style="list-style-type: none"> Шинэ техник технологи, инноваци шингэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг дагуул хаяа хот тосгодоод нэмэгдүүлэх УБ хотын Олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг ашиглалтад бүрэн оруулж нисэх онгоцны буудлын стандарт нэвтрүүлэн хангаж, Зүүн хойд Азийн зорчигч, ачаа тээвэрлэлтийн зангилаа нэгдсэн логистик төв болгон хөгжүүлэх Дэлхийн хэмжээний соёл, урлагийн фестиваль (хөгжим, кино, хувцас, загвар, хүнс...) наадмыг зохион байгуулах Зүүн хойд Азид хүлээн зөвшөөрөгдсөн соёл, шинжлэх ухааны төв болгон хөгжүүлэх Газар зүйн байршлын давуу талаа ашиглаж олон улсын “Мэдээллийн дата төв”-ийг байгуулах


ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Олон төвт хотын тогтолцоог хэрэгжүүлж, дагуул хотуудыг барьж байгуулах буюу “Аэро сити”, “Майдар” сити шинэ хотын бүтээн байгуулалт эхлүүлж, инженерийн дэд бүтцийн эх үүсвэр, дамжуулах түгээх шугам сүлжээг барьж ашиглалтад оруулах, орон сууцжуулах ажлыг эрчимжүүлэх, биеийн тамир спортын барилга байгууламж барина
- УБ хотын Олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг ашиглалтад бүрэн оруулж, нисэх онгоцны буудлын стандарт нэвтрүүлэн хангаж, Зүүн хойд Азийн зорчигч, ачаа тээвэрлэлтийн зангилаа нэгдсэн логистик төв болгон хөгжүүлнэ.
- Хөшигийн хөндийд байрлах олон улсын нисэх онгоцны буудлыг даган байгуулагдах “Аэро сити” шинэ хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлнэ.
- Шинэ нисэх онгоцны буудлаас хурдны замаар холбогдсон олон улсын дээд түвшний уулзалт, чуулга хийх боломжит цогцолбор байгуулах, үйлчилгээний менежмент, аюулгүй байдлыг хангах тогтолцоог бий болгоно.
- Хотын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг эдийн засаг, нийгмийн үр ашгаар эрэмбэлэн, санхүүжүүлэх, санхүүгийн хувьд бие даан, асуудлуудаа шийдвэрлэх боломжит суурь орчинг бий болгож, нөөц бүрдүүлнэ.
- Аж үйлдвэрийн бүсүүдийг салбар чиглэл бүрд төлөвлөн, кластер байдлаар дагуул хотуудыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг татахын тулд үйлдвэр технологийн паркуудын газрыг худалдах, түрээслэх замаар эзэмшүүлнэ.
- Улаанбаатар бүсийн хэмжээнд эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулах замаар өндөр технологийн үйлдвэрүүдийг нутагшуулж, ажлын байрыг нэмэгдүүлж дэлхийн зах зээлд өрсөлдөх боломжтой тул хууль эрх зүйн орчинг бүрдүүлж чөлөөт бүсийг байгуулна.
- Хот тосгодыг холбосон хурдны тойрог зам барьж байгуулах, тойрог зам дагуу аялал жуулчлалын цогцолборуудыг байгуулах төлөвлөлт хийж бизнес эрхлэгчдийг дэмжих, түүх соёлын дурсгалыг сэргээн засварлаж аялал жуулчлалын эргэлтэд оруулах, Монгол брэндийн худалдааны төв нээж ажиллуулна.
- Соёлын аялал жуулчлал, бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, соёл, урлагийн зах зээлийг өргөжүүлэхэд салбар хоорондын уялдаа холбоог сайжруулна.
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд аялал жуулчлалын томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
- Орон нутгийн хамгаалалттай газруудад ойн аялал жуулчлалыг хөгжүүлэх, олон нийтэд нээлттэй паркуудыг байгуулах, иргэдийн байгаль орчны боловсролыг дээшлүүлнэ.

- 9.5.12 Соёлын өв, урлагийн бүтээлийн оюуны өмчийн эрхийг баталгаажуулж хамгаалах, бүртгэлжүүлнэ.
- 9.5.13 Хотын түүх, соёлын үл хөдлөх өвийг хадгалж, хамгаалах, сэргээн засварлах бодлогыг боловсруулан хэрэгжүүлнэ.
- 9.5.14 Олон улс, тив, дэлхийн томоохон наадмуудыг хүлээн авч зохион байгуулах шаардлага хангасан спортын барилга байгууламжуудыг барьж байгуулна.
- 9.5.15 Тив дэлхийн аварга шалгаруулах тэмцээнүүд, томоохон спортын наадмуудыг зохион байгуулах шаардлага хангасан 30000-40000 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэнг барьж байгуулна.
- 9.5.16 Монгол хүний оюуны бүтээлийг дэлхийн зах зээлд сурталчлах төсөл хэрэгжүүлж, үндэсний уламжлалт соёлын өвийг харилцаат хотуудын хамтын ажиллагааны хүрээн сурталчилна.
- 9.5.17 Жуулчдад зориулсан үндэсний онцлог бүхий урлаг соёлын хөтөлбөрүүд бий болгож тогтмолжуулна.
- 9.5.18 Өндөр технологи, мэдлэгт суурилсан үйлдвэрлэлийг дэмжиж хөгжүүлнэ.
- 9.5.19 Монголын уламжлалт спорт (сурын харваа, шагайн харваа гэх мэт), морин спортын төв (морин поло, тэмээн поло) байгуулж үндэсний багтай болох, гадаад, дотоодын багийг урьж тоглуулах тогтолцоог дэмжинэ.
- 9.5.20 Газар зүйн байршлын давуу талаа ашиглаж олон улсын “Мэдээллийн дата төв”-ийг байгуулна.

Зураг 9.9. Төрөлжсөн хөгжилтэй хотууд


ТӨРӨЛЖСӨН ХӨГЖИЛТЭЙ ХОТУУД




Зураг 9.10. Орон сууцны бодлого

ОРОН СУУЦ

УЛААНБААТАР ХОТ



ДАГУУЛ ХАЯА ХОТ, ТОСГОД



Улаанбаатар хотын хэмжээнд бүтээн байгуулалтыг өрнүүлж гэр хорооллыг дахин төлөвлөн орон сууцны болон, тохилог амины орон сууцны хороолол болгон хөгжүүлж, орон сууцны хангамжийг төвлөрсөн шугам сүлжээнд 70%, инженерийн бие даасан эх үүсвэрт 30%-ийг холбон хөгжүүлнэ.

ЭХНИЙ ҮЕ ШАТ

ГЭР ХОРООЛЛЫН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТ

45,000 айл

АШИГЛАЛТЫН ШААРДЛАГА ХАНГАХГҮЙ
БАРИЛГЫГ БУУЛГАН ДАХИН БАРИЛГАЖУУЛАХ
ТӨСӨЛ

3,746 айл

ГАЗАР ШИНЭЧЛЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨСӨЛ
/дэд бүтцийн төв/

13,500 айл

ОРЛОГОД НИЙЦСЭН ОРОН СУУЦ

38,826 айл

ДАГУУЛ ХАЯА ХОТ, ТОСГОД

16,512 айл



ОРОН СУУЦНЫ ХАНГАМЖ



2050


Зураг 9.11. Үйлдвэрлэлийн технологийн парк

ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК

Шинжлэх ухаан, инновацыг үйлдвэрлэлд нэвтрүүлж импортыг орлох бүтээгдэхүүнийг дэмжин, гадаад зах зээлд өрсөлдөх экспортын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх замаар ажлын байр бий болгож иргэдийн зохистой шилжилт хөдөлгөөн, нутаг дэвсгэрийн тэнцвэртэй хөгжлийг бий болгоно.

ЧӨЛӨӨТ БҮС

Дэлхийн эдийн засгийн тогтолцоонд олон улсын барааны эргэлт, интеграцын идэвхжилт, хөгжлийн түвшинг хурдасгах чөлөөт бүсийг байгуулах замаар өндөр технологийн үйлдвэрлэл, шинэ төрлийн үйлчилгээг нутагшуулан ажлын байрыг нэмэгдүүлж дагуул хаяа хот тосгодод хүн амын суурьшлыг дэмжинэ.



2050

УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ ЗОРИЛГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

Хүснэгт 9.2. Улаанбаатар ба дагуул хот зорилгын хэрэгжилтийн хяналт, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин

Тайлбар: * тэмдэглэгээ бүхий шалгуур үзүүлэлтийг шинээр тооцдог болно.

#	Шалгуур үзүүлэлт (indicator)	Хэмжих нэгж	Суурь түвшин	2030	2040	2050	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Хаанаас авах эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах аргазүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
9	УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ										
1	Хотын хөгжлийн индекс /CDI/	Индекс	0.68	0.75	0.81	0.88	Азийн хөгжлийн банкнаас гаргасан City development index-ийг тодорхойлдог аргачлалын дагуу 1. Боловсрол, 2. Эрүүл мэнд, 3. Дэд бүтэц, 4. Хог хаягдал, 5. Бүтээмжийн индексүүд	Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба, Нийслэлийн статистикийн газар, НХБХГ	Статистик үзүүлэлт цуглуулах	Жилд 1 удаа	Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба
2	Хотын индекс	Индекс	0.5	0.63	0.76	0.93	Улаанбаатар хотын индекс" тооцдог аргачлалын дагуу 1. Хүрээлэн буй орчин, 2. Дэд бүтэц, 3. Амьжиргааны зохистой түвшин, 4. Боловсрол, 5. Эрүүл мэнд, 6. Соёл, урлагийн үйлчилгээ, 7. Хувь хүний аюулгүй байдал, 8. Засаглалын индексүүд	Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба, Нийслэлийн статистикийн газар	Статистик үзүүлэлт цуглуулах	Жилд 1 удаа	Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба

Алсын хараа 2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх төсөл

Алсын хараа 2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод туссан зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн урьдчилсан тооцоог гаргахдаа төсөвт байгууллагын урсгал зардлын хүрээнд хэрэгжих арга хэмжээнүүдийн санхүүжилтийг оруулж тооцоогүй болно.

Монгол Улсын төрийн болон албаны нууцын тухай хуулийн гуравдугаар бүлгийн 13 дугаар зүйлд заасан төрийн нууцад хамааруулах төрийн бодлого, эдийн засаг, шинжлэх ухаан, техник технологийн, батлан хамгаалах, мэдээллийн аюулгүй байдлы болон бусад хүрээний нууцалбал зохих мэдээлэл бүхий төсөл, арга хэмжээ, тэдгээрийн төсөвт өртгийг энэ бодлогод тусгаагүй болно.

Улсын төсвийн урсгал зардлаас гадуур төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламж, гадаад, дотоодын хувийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрээр хэрэгжих зорилго, зорилтуудын урьдчилсан санхүүжилтийн тооцоог гаргахад "Алсын хараа 2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-ыг хэрэгжүүлэх 30 жилийн хугацаанд өнөөгийн өртгөөр 145.1 их наяд төгрөгийн санхүүжилт шаардагдах юм.

Монгол Улсын бодит эдийн засаг нь 2018 онд 18.1 их наяд төгрөг байсан бөгөөд уг бодлогод туссанаар эдийн засгийн бодит өсөлт жилд 6 хувь байхаар төсөөлж байна. Ингэснээр "Алсын хараа 2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого" хэрэгжиж дуусах 2050 онд өнөөгийн бодит өртгөөр 100 гаруй их наяд төгрөгийн эдийн засагтай болох юм. Уг хөтөлбөрт туссан арга хэмжээнүүдийг 30 жилийн хугацаанд бүрэн хэрэгжүүлэх боломжтой эдийн засгийн суурь бий болно.

Хүснэгт 4. Төслийн санхүүжилтийн тооцоо, зорилгоор

№	Зорилго	Төсөвт өртөг, тэр бум төгрөгөөр
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	708.3
2	Хүний хөгжил	16,356.8
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	1,685.5
4	Эдийн засаг	54,501.5
5	Сайн засаглал	70.9
6	Ногоон хөгжил	13,659.1
7	Амар тайван, аюулгүй нийгэм	2,121.2
8	Бүсчилсэн хөгжил	48,166.8
9	Улаанбаатар ба дагуул хот	7,832.5
НИЙТ		145,102.6

Уул уурхайн салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөж буй томоохон төслүүд нь эдийн засгийн зорилгод багтсантай холбоотойгоор уг төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн 37.6 хувь нь энэхүү зорилгод туссан байна. Тухайлбал, Тавантолгой ордын баруун, зүүн Цанхийг ашиглах төслүүд нь 17.7 их наяд төгрөгийн санхүүжилт шаардахаар байгаа юм.

Бүсчилсэн хөгжил зорилгын хүрээнд эдийн засгийн өсөлт, бүс нутгийн хөгжлийг дэмжих автозам, төмөр зам, эрчим хүч болон дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөж буйтай холбоотойгоор улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламж, хувийн хөрөнгө оруулалт зэрэг эх үүсвэрийн 48.2 их наяд төгрөгийн санхүүжилт шаардагдахаар байна.

Хүний хөгжил зорилгын хүрээнд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, шинжлэх ухаан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд урьдчилсан тооцоогоор 16.4 их наяд төгрөгийн санхүүжилт шаардагдахаар байна.

Ногоон хөгжил зорилгыг хэрэгжүүлэхэд 13.7 их наяд төгрөгийн санхүүжилт шаардагдах юм. Ховд, Баян-Өлгий, Булган, Хөвсгөл, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Өвөрхангай, Дорнод аймгийн нутаг дэвсгэр дэх Ховд, Орхон, Туул, Эг, Хэрлэн, Онон зэрэг томоохон голууд болон бусад голын татмууд, 21 аймгийн байгалийн тогтоцуудыг хамгаалахтай холбоотой томоохон төслүүдийг хэрэгжүүлнэ.

Энэхүү бодлогод нийт 187 төсөл хэрэгжүүлэхээр тусгаснаас 135 нь төслийн техник эдийн засгийн үндэслэл, урьдчилсан судалгаа, бодлогын судалгаа эсхүл зураг төсөл гэх мэт ямар нэг түвшний судалгаа хийгдсэн байгаа ба 52 төслийн хувьд судалгаа, тооцооллыг шинээр хийх шаардлагатай байна.

Хүснэгт 5. Хэрэгжүүлэх төслийн жагсаалт

№	Төслийн нэр	Хэрэгжих байршил	Хэрэгжих салбар	Хариуцах яам, агентлаг	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг, сая.төг	ТЭЗҮ, судалгаа хийгдсэн эсэх
ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ							
ДЭЛХИЙН МОНГОЛ							
1	Дэлхийн Монголчууд II хөтөлбөр	Дэлхий дахинд	Монгол Улсын бүх салбарт	ГХЯ	2020-2025	46,300.0	ТЭЗҮ-гүй, судалгаагүй
2	Монгол үндэстний үнэлэмж хөтөлбөр	Дэлхий дахинд	Монгол Улсын бүх салбарт	ГХЯ	2020-2025	177,300.0	ТЭЗҮ-гүй, судалгаагүй
НҮҮДЛИЙН СОЁЛ ИРГЭНШИЛТ МОНГОЛ							
1	Түүхийн дурсгалт газрууд түүнд түшиглэн олон нийтэд байгаль хамгаалал, уламжлалт ёс заншил мэдлэг төлөвшүүлэх "Нүүдлийн соёл иргэншлийн үндэсний хүрээлэн" -г 5 бүсэд байгуулах	Баруун, Хангай, Төв, Зүүн, Улаанбаатарын бүс	Соёл	БСШУСЯ	2021-2035	30,000.0	Мэдээлэлгүй
2	Палеонтологийн музейн барилга байгууламжийг барих	Дундговь аймаг Сайнцагаан сум	Соёл	БСШУСЯ	2024-2026	60,000.0	ТЭЗҮ-гүй, судалгаагүй
3	Үндэсний Археологийн музей байгуулах	Төв аймаг Зуунмод хот	Соёл	БСШУСЯ	2022-2024	70,000.0	ТЭЗҮ-гүй. Судалгаа хийгдэж байгаа.
МОНГОЛ ХЭЛ БИЧИГ							
1	Хүүхдийн Төв номын сангийн техник тоног төхөөрөмжийн шинэчлэл	Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг	Боловсрол	БСШУСЯ	2022-2023	1,500.0	ТЭЗҮ, судалгаатай
ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ЭВ НЭГДЭЛ							
1	Монгол туургатны хэл, соёл, уламжлалыг хадгалж хөгжүүлэх хөтөлбөр	Дэлхий дахинд	Соёл	БСШУСЯ	2021-2050	26,200.0	Мэдээлэлгүй
2	Хархорум хотын туурийг бэхжүүлэх, сэргээх	Өвөрхангай, Хархорин сум	Соёл	БСШУСЯ	2020-2036	30,000.0	ТЭЗҮ-гүй, судалгаагүй
3	Үндэсний урлагийн их театрын шинэ барилга барих	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг	Соёл	БСШУСЯ	2020-2022	200,000.0	Зураг төсөл хийгдээгүй
ЭРДЭМ СУДЛАЛ- НИЙГМИЙН СОЁН ГЭГЭЭРЭЛ							
1	Монгол угсаатны үндэсний музейн цогцолбор байгуулах төсөл	Ховд аймаг, Жаргалант сум	Соёл	БСШУСЯ	2026-2028	55,000.0	ТЭЗҮ-гүй, судалгаагүй
2	Монгол Улсын Үндэсний номын сангийн салбар, номын сангийн шинэ барилга	Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг	Соёл	БСШУСЯ	2020-2023	12,000.0	Зураг төсөл хийгдээгүй

№	Төслийн нэр	Хэрэгжих байршил	Хэрэгжих салбар	Хариуцах яам, агентлаг	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг, сая.төг	ТЭЗҮ, судалгаа хийгдсэн эсэх
ХҮНИЙ ХӨГЖИЛ							
БОЛОВСРОЛ							
1	Бага дунд боловсролын орчин нөхцөл тоног төхөөрөмжийг сайжруулах	Зорилтот аймаг сум дүүрэг баг хороонд	Боловсрол	БСШУСЯ	2020-2025	207,500.0	Мэдээлэлгүй
2	Багануур дахь шинжлэх ухаан, үйлдвэрлэл технологийн цогцолбор / Их сургуулиудын хотхон/	Улаанбаатар хот, Багануур дүүрэг	Боловсрол	БСШУСЯ	2010-2030	11,700,000.0	ТЭЗҮ-тэй
ЭРҮҮЛ МЭНД							
1	Зүрх судасны үндэсний төв байгуулах	Улаанбаатар, Баянгол дүүрэг	Эрүүл мэнд	ЭМЯ	2020-2025	134,731.6	ТЭЗҮ-тэй
2	Эрхтэн шилжүүлэн суулгах-Мэс заслын төв байгуулах төсөл	Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг	Эрүүл мэнд	ЭМЯ	2021-2024	97,015.0	ТЭЗҮ-тэй
3	Яаралтай тусламжийн үндэсний тогтолцоо бүрдүүлэх	Улаанбаатар хот, 21 аймаг	Эрүүл мэнд	ЭМЯ	2020-2030	446,913.7	ТЭЗҮ-тэй
4	Эмийн аюулгүй байдлын лаборатори	Улаанбаатар хот	Эрүүл мэнд	ЭМЯ	2020-2024	54,665.0	ТЭЗҮ-гүй, судалгаатай
ГЭР БҮЛ							
1	Асрамжийн газраас 18 нас хүрсэн залуучуудыг бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх төсөл	Улсын хэмжээнд	Нийгмийн хамгаалал	ХНХЯ	2020-2035	100,000.0	Мэдээлэлгүй
2	Ахмад настны тусламж, үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх	Улсын хэмжээнд	Нийгмийн хамгаалал	ХНХЯ	2020-2025	72,000.0	ТЭЗҮ-гүй, суурь судалгаатай
3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийн хөгжлийн төв	Улсын хэмжээнд	Нийгмийн хамгаалал	ХНХЯ	2023-2040	70,000.0	Мэдээлэлгүй
4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бие даан амьдрах үйлчилгээг дэмжих төсөл	Улсын хэмжээнд	Нийгмийн хамгаалал	ХНХЯ	2022-2040	300,000.0	Мэдээлэлгүй
ШИНЖЛЭХ УХААН, ИННОВАЦИ							
1	Шинжлэх ухааны парк байгуулах	Төв аймаг Сэргэлэн сум	Шинжлэх ухаан	БСШУСЯ	2021-2025	1,081,000.0	ТЭЗҮ-гүй, судалгаагүй
2	Шинжлэх ухаан, технологи, инноваци, үйлдвэрлэлийн төвүүд байгуулах	Дархан, Эрдэнэт, Ховд, Дорнод	Шинжлэх ухаан	БСШУСЯ	2020-2025		ТЭЗҮ-гүй, судалгаагүй
ХҮНД ЭЭЛТЭЙ АМЬДРАХ ОРЧИН							
1	Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламж	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг	Инженерийн дэд бүтэц	БХБЯ	2019-2022	740,644.8	ТЭЗҮ-тэй
2	Ашиглалтын шаардлага хангахгүй байгаа нийтийн зориулалттай орон сууцны 58 барилгыг буулган шинээр барих	Нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд	Барилга, хот байгуулалт	НЗДТГ	2019-2022	110,950.0	Судалгаатай

№	Төслийн нэр	Хэрэгжих байршил	Хэрэгжих салбар	Хариуцах яам, агентлаг	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг, сая.төг	ТЭЗҮ, судалгаа хийгдсэн эсэх
3	Гэр хорооллын дундын бүсэд хэсэгчилсэн инженерийн хангамжийг нэвтрүүлэх "Дэд бүтцийн төв" төсөл	Улаанбаатар	Инженерийн дэд бүтэц	НЗДТГ	2020-2025	460,000.0	Ажлыг зураг төсөлтэй
4	Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл /гадна шугам сүлжээ/	Улаанбаатар	Инженерийн дэд бүтэц	НЗДТГ	2020-2025	297,700.0	Мэдээлэлгүй
5	Алслагдсан орон нутагт сүүн бүтээгдэхүүнийг кластерийн зарчмаар үйлдвэрлэж, импортыг орлож, экспортыг нэмэгдүүлэх	Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Булган, Завхан, Баянхонгор, Төв, Сэлэнгэ, Дорнод, Хэнтий аймгийн 108 сум	Хүнсний үйлдвэр	ХХААХҮЯ	2019-2022	117,000.0	ТЭЗҮ-тэй
6	Хүүхдийн сүүний үйлдвэр байгуулах	Улаанбаатар хот	Хүнсний үйлдвэр	ХХААХҮЯ	2020-2024	7,881.00	ТЭЗҮ-тэй
7	Цэвэр өсгөврийн хөрөнгө үйлдвэрлэх үйлдвэр байгуулах	Улаанбаатар хот	Хүнсний үйлдвэр	ХХААХҮЯ	2020-2025	6,828.3	ТЭЗҮ-тэй
8	Хотын зүүн, баруун бүсэд малын зах, мах боловсруулах үйлдвэр байгуулах	Улаанбаатар хот, Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг	Хүнсний үйлдвэр	ХХААХҮЯ	2020-2025	33,000.0	Мэдээлэлгүй
9	Улаанбаатар хотод төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, махны хадгалалт, борлуулалтын цогцолбор төв.	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг	Логистик	ХХААХҮЯ	2020-2025	69,000.0	ТЭЗҮ-тэй
ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ							
1	Ахмадуудыг дахин мэргэшүүлэх төсөл	Улсын хэмжээнд	Хөдөлмөр эрхлэлт	ХНХЯ	2020-2025	50,000.0	Мэдээлэлгүй
2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах төсөл	Улсын хэмжээнд	Хөдөлмөр эрхлэлт	ХНХЯ	2022-2045	200,000.0	Мэдээлэлгүй
АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА							
НИЙГМИЙН ХАМГААЛАЛ БА ДААТГАЛЫН ТОГТОЛЦОО							
1	Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэд сургалтын төв байгуулах	Улаанбаатар, Төв, Ховд, Орхон, Дорнод	Нийгмийн хамгаалал	ХНХЯ	2021-2026	4,000.0	Мэдээлэлгүй
ОРЛОГОД НИЙЦСЭН ОРОН БАЙР							
1	Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл	Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд	Барилга, хот байгуулалт	НЗДТГ	2018-2027	1,482,000.0	ТЭЗҮ-тэй
2	Буянт-ухаа орон сууцны төсөл	Улаанбаатар, Хан-уул дүүрэг	Барилга, хот байгуулалт	НЗДТГ	2020-2025	46,000.0	Мэдээлэлгүй
3	Ханын материал орон сууцны төсөл	Улаанбаатар, Сонгинхайрхан дүүрэг	Барилга, хот байгуулалт	НЗДТГ	2020-2025	67,000.0	Мэдээлэлгүй

№	Төслийн нэр	Хэрэгжих байршил	Хэрэгжих салбар	Хариуцах яам, агентлаг	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг, сая.төг	ТЭЗҮ, судалгаа хийгдсэн эсэх
ЭРҮҮЛ, ИДЭВХТЭЙ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ							
1	Спортын ордонг шинэчлэх	Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг	Спорт	БСШУСЯ	2021-2023	65,000.0	Схем зурагтай
2	Сумдад усан бассейн бүхий спорт цогцолбор барих	Дундговь Сайнцагаан, Говьсүмбэр Сүмбэр, Сүхбаатар Баруун-Урт	Спорт	БСШУСЯ	2020-2022	21,480.0	Зураг төсөвтэй
ЭДИЙН ЗАСАГ							
ЭДИЙН ЗАСГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД							
1	Алтан Цагаан Овоогийн алт-холимог металлын үндсэн ордыг ашиглах төсөл	Дорнод, Цагаан-Овоо	Уул уурхай	УУХҮЯ	2020-2030	204,400.0	ТЭЗҮ-тэй
2	Гацууртын алтны үндсэн ордыг ашиглах төсөл	Сэлэнгэ, Мандал	Уул уурхай	УУХҮЯ	2020-2030	752,000.0	ТЭЗҮ-тэй
3	Дулаан уул, Зөөвч Овоо ураны ордыг ашиглах төсөл	Дорнод, Улаанбадрах	Уул уурхай	УУХҮЯ	2020-2042	3,006,575.0	ТЭЗҮ-тэй
4	Овоотын нүүрсний ордыг ашиглах төсөл	Хөвсгөл, Цэцэрлэг	Уул уурхай	УУХҮЯ	2020-2048	7,188,447.5	ТЭЗҮ-тэй
5	Оюутолгойн зэс-алтны бүлэг ордыг ашиглах	Өмнөговь, Ханбогд	Уул уурхай	УУХҮЯ	2012-2106		ТЭЗҮ-тэй
6	Тавантолгойн нүүрсний ордын Цанхийн баруун хэсгийг ашиглах төсөл	Өмнөговь аймаг, Цогтцэций сум	Уул уурхай	УУХҮЯ	2020-2050	3,900,131,003.3	ТЭЗҮ-тэй
7	Тавантолгойн нүүрсний ордын Цанхийн зүүн хэсгийг ашиглах төсөл	Өмнөговь аймаг, Цогтцэций сум	Уул уурхай	УУХҮЯ	2020-2050	4,400,722,679.5	ТЭЗҮ-тэй
8	Хармагтайн алт-зэсийн ордыг ашиглах төсөл	Өмнөговь, Цогтцэций	Уул уурхай	УУХҮЯ	2020-2045	934,402.0	ТЭЗҮ-тэй
9	Цагаан суваргын зэс-молибдений төсөл	Дорноговь, Мандах	Уул уурхай	УУХҮЯ	2017-2031	1,725,840.0	ТЭЗҮ-тэй
10	Багануур үйлдвэрлэл, технологийн парк /дэд бүтэц/	Улаанбаатар, Багануур дүүрэг	Хүнд үйлдвэр	УУХҮЯ	2020-2026	161,158.2	ТЭЗҮ-тэй
11	Газрын тос боловсруулах үйлдвэр	Дорноговь аймаг, Алтанширээ сум	Хүнд үйлдвэр	УУХҮЯ	2017-2023	2,983,250.0	ТЭЗҮ-тэй
12	Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах төсөл	Дархан-Уул аймаг, Дархан хот	Хүнд үйлдвэр	УУХҮЯ	2020-2025	4,039,600.0	ТЭЗҮ-тэй
13	Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр	Өмнөговь аймаг, Ханбогд сум	Хүнд үйлдвэр	УУХҮЯ	2020-2024	5,739,825.0	ТЭЗҮ-тэй
14	Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн төсөл	Улаанбаатар, Багануур дүүрэг	Хүнд үйлдвэр	УУХҮЯ	2020-2050	6,833,125.0	ТЭЗҮ-тэй

№	Төслийн нэр	Хэрэгжих байршил	Хэрэгжих салбар	Хариуцах яам, агентлаг	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг, сая.төг	ТЭЗҮ, судалгаа хийгдсэн эсэх
15	Үнэт металл цэвэршүүлэх, боловсруулах үйлдвэрийн төсөл	Улаанбаатар, Сонгинхайрхан дүүрэг	Хүнд үйлдвэр	УУХҮЯ	Мэдээлэлгүй	265,000.0	Судалгаатай
16	Эрдэнэс стийл ХХК-ийн Чойрын ган ба металлургийн коксын үйлдвэрийн төсөл	Говьсүмбэр, Баянтал	Хүнд үйлдвэр	УУХҮЯ	2020-2024	839,600.0	ТЭЗҮ-тэй
17	Мал эмнэлгийн лабораторийн шинэ бүтээн байгуулалт хийж, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг дэмжих	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг	Хөдөө аж ахуй	ХХААХҮЯ	2020-2025	103,600.0	ТЭЗҮ-тэй
18	Малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах	Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум	Хөдөө аж ахуй	ХХААХҮЯ	2020-2022	1,783.0	ТЭЗҮ-тэй
19	Багахангай хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк	Улаанбаатар хот, Багахангай дүүрэг	Аж үйлдвэр	ХХААХҮЯ	2019-2025	36,532.0	ТЭЗҮ-тэй
20	Баруун бүсэд цементийн үйлдвэр байгуулах	Ховд, Баян-Өлгий аймаг	Аж үйлдвэр	БХБЯ	2020-2023	61,300.0	ТЭЗҮ-тэй
21	Биокомбинат үйлдвэрийн өргөтгөл	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг	Аж үйлдвэр	ХХААХҮЯ	2019-2022	148,200.0	ТЭЗҮ-тэй
22	Дархан арьс ширний цогцолбор	Дархан хот	Аж үйлдвэр	ХХААХҮЯ	2019-2034	586,944.9	ТЭЗҮ-тэй
23	Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк	Улаанбаатар хот, Налайх дүүрэг	Аж үйлдвэр	ХХААХҮЯ	2015-2030	94,349.0	ТЭЗҮ-тэй
24	Шилний үйлдвэр байгуулах	Улаанбаатар хот, Багахангай дүүрэг	Аж үйлдвэр	БХБЯ	2020-2025	23,000.0	ТЭЗҮ-тэй
25	Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг	Аж үйлдвэр	ХХААХҮЯ	2020-2027	479,180.0	ТЭЗҮ-тэй
26	Ээрэх үйлдвэрийн хөрөнгө оруулалтын төсөл	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг	Аж үйлдвэр	ХХААХҮЯ	2020-2024	200,971.0	ТЭЗҮ, судалгаатай
27	Аялал жуулчлалын hub-sporke тогтолцоог бүрдүүлэх, hub-уудыг байгуулах	Улсын хэмжээнд	Аялал жуулчлал	БОАЖЯ, ҮХГ	2020-2030	60,000.0	Мэдээлэлгүй
28	Аялал жуулчлалын голлох чиглэлийн авто зам дагуу түр буудаллах үйлчилгээний цогцолбор	Хэвтээ, босоо тэнхлэгийн гол чиглэлийн авто зам дагуу сонгогдсон 39 байршилд	Аялал жуулчлал	БОАЖЯ	2020-2030	106,000.0	ТЭЗҮ-тэй
29	Аялал жуулчлалын мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв байгуулах төсөл	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг	Аялал жуулчлал	БОАЖЯ	2020-2022	13,000.0	Мэдээлэлгүй
30	Зүүн бүсэд үзэсгэлэнт онгон байгаль, тусгай хамгаалалттай газар нутаг, ан амьтан, "Чингис хаан"-ны түүхэн дурсгал, түүх соёлын үл хөдлөх дурсгалд тулгуурлан аялал жуулчлалыг хөгжүүлж "Чингис Хаан" аялал жуулчлалын цогцолбор байгуулах	Хэнтий аймаг Жаргалтхаан, Өмнөдэлгэр, Биндэр, Баян-Адарга, Дадал	Аялал жуулчлал	БОАЖЯ	2020-2030	67,500.0	Зарим төслүүд дээр ТЭЗҮ, судалгаа хийгдсэн.

№	Төслийн нэр	Хэрэгжих байршил	Хэрэгжих салбар	Хариуцах яам, агентлаг	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг, сая.төг	ТЭЗҮ, судалгаа хийгдсэн эсэх
31	Тогтвортой аялал жуулчлалыг дэмжих төсөл	Хөвсгөл, Хэнтий аймаг	Аялал жуулчлал	БОАЖЯ	2020-2024	100,016.0	Судалгаатай
32	Хархорин сум-Шанхын хийд-Бат-Өлзий сум-Улаан цутгалан хүрхрээ-Төвхөн хийд чиглэлийн 91 км авто зам	Өвөрхангай аймаг, Хужирт, Бат-Өлзий сум	Аялал жуулчлал	БОАЖЯ, ЗТХЯ	2020-2030	86,450.0	Мэдээлэлгүй
БҮС НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА							
1	Чөлөөт бүсүүдийг дэмжин хөгжүүлэх	Замын-Үүд, Хөшгийн хөндий, Алтанбулаг, Цагааннуур	Чөлөөт бүс	Шадар сайд	2020-2030		ТЭЗҮ, судалгаатай
САЙН ЗАСАГЛАЛ							
УХААЛАГ БҮТЭЦ							
1	МУ-ын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг нийгэм, эдийн засаг, хүн амын өсөлт, байгалийн нөхцөл, нөөцийн чадавхад нийцүүлэн оновчтой зохион байгуулах, хуваарилах	Улсын хэмжээнд /бүх аймаг, хот, сум, дүүрэг/	Газар зохион байгуулалт, геодези зураг зүй	БХБЯ	2020-2025	1,620.0	ТЭЗҮ-гүй, судалгаагүй
2	Газрын биржийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх төрийн өмчийн оролцоотой байгууллага байгуулан газрын сан бүрдүүлж, газар хөгжүүлэлт хийх, газрын цахим биржээр дамжуулан үйлчилгээ үзүүлж, кадастрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	Улсын хэмжээнд /бүх аймаг, хот, сум, дүүрэг/	Газар зохион байгуулалт, геодези зураг зүй	БХБЯ	2020-2025	3,150.0	ТЭЗҮ-гүй, судалгаагүй
3	Бүс нутаг, хот төлөвлөлтийн институт байгуулах	Улсын хэмжээнд	Барилга, хот байгуулалт	БХБЯ	2020	1,500.0	ТЭЗҮ-гүй, судалгаагүй
4	Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал, бүртгэл, импорт, түгээлт, цахим хяналтын механизм бүхий эмийн зохицуулалтын нэгдсэн агентлаг байгуулах	Улаанбаатар хот	Эрүүл мэнд	ЭМЯ	2021-2024	1,500.0	ТЭЗҮ-гүй, судалгаатай
ЦАХИМ МОНГОЛ (ИРГЭН, ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ)							
1	Монгол Улсын радио өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх	Улсын хэмжээнд	Харилцаа холбоо	ХХМТГ	2020-2022	43,005.7	ТЭЗҮ-тэй
2	Хилийн боомт, алслагдсан сумыг шилэн кабелийн сүлжээнд холбох	16 боомт, 10 сум	Харилцаа холбоо	ХХМТГ	2020-2021	20,143.1	Мэдээлэл байхгүй

№	Төслийн нэр	Хэрэгжих байршил	Хэрэгжих салбар	Хариуцах яам, агентлаг	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг, сая.төг	ТЭЗҮ, судалгаа хийгдсэн эсэх
НОГООН ХӨГЖИЛ							
ЭХ БАЙГАЛЬ АНХДАГЧ ЭКОСИСТЕМ							
1	Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийн судалгаа хийж бүртгэлжүүлэх, нөөц тогтоох, бүртгэл мэдээллийн цахим сан бүрдүүлэх	Улаанбаатар, 21 аймаг	Байгаль орчин	БОАЖЯ	2020-2030	8,500.0	Судалгаатай
2	Генетик нөөцийн үндэсний сан байгуулах /ургамал, амьтан, бичил биетэн/	Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг	Байгаль орчин	БОАЖЯ	2020-2030	14,000.0	ТЭЗҮ-тэй
3	Генетик нөөцөд суурилсан биотехнологийн судалгаа, үйлдвэрлэлийг дэмжих төсөл	Байршил тодорхойгүй	Байгаль орчин	БОАЖЯ	2020-2040	8,000.0	Төслийн танилцуулгатай
4	Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаанд болон байгаль хамгаалагчдын байр	Дорнод Дашбалбар, Говь-Алтай Цогт, Баянхонгор, Хөвсгөл Цагаан Уул, Хөвсгөл Улаан Уул, Увс Ховд, Дорноговь Хатанбулаг	Байгаль орчин	БОАЖЯ	2020-2028	7,840.0	Мэдээлэлгүй
5	Ус, цаг уурын ажиглалтын сүлжээг өргөжүүлж, автоматжуулах	21 аймаг	Байгаль орчин	БОАЖЯ	2021-2025	8,500.0	Судалгаатай
6	Цаг агаарын аюулт үзэгдлийг илрүүлэх Доплерийн радарын станц байгуулах	Улаанбаатар, Хөвсгөл, Өмнөговь, Өвөрхангай, Увс, Говь-Алтай	Байгаль орчин	БОАЖЯ	2021-2040	30,000.0	Судалгаатай
№	Төслийн нэр	Хэрэгжих байршил	Хэрэгжих салбар	Хариуцах яам, агентлаг	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг, сая.төг	ТЭЗҮ, судалгаа хийгдсэн эсэх
БАЙГАЛИЙН БАЯЛГИЙН ҮР ӨГӨӨЖ							
1	Байгаль орчны хяналт-шинжилгээний төв лабораторийг шинээр барих, чадавхыг бэхжүүлэх	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг	Байгаль орчин	БОАЖЯ	2020-2025	42,000.0	ТЭЗҮ, зураг төсөвтэй
2	Агаарын чанарын хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлэх	Улаанбаатар хот, 21 аймгийн төв	Байгаль орчин	БОАЖЯ	2020-2024	10,000.0	Мэдээлэлгүй
3	НОГООН ХҮРЭМ төсөл /Газрын доройтлыг бууруулах, цөлжилтийг сааруулах, ойжуулах, ойг нөхөн сэргээх/	Улаанбаатар хот Баянзүрх хайрхан, 21 аймаг	Байгаль орчин	БОАЖЯ	2020-2040	188,600.0	Баянзүрх хайрхан ТЭЗҮ-тэй
4	Ойн аж ахуйн цогцолбор төв байгуулах	Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Төв, Хэнтий	Байгаль орчин	БОАЖЯ	2021-2025	15,000.0	Мэдээлэлгүй

№	Төслийн нэр	Хэрэгжих байршил	Хэрэгжих салбар	Хариуцах яам, агентлаг	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг, сая.төг	ТЭЗҮ, судалгаа хийгдсэн эсэх
ҮНЭТ БАЯЛАГ УС							
1	Гидрогеологийн 1:200000 дунд масштабын зураглал, хот суурин газрын ус хангамжийн эх үүсвэрийн усны нөөцийн хайгуул судалгаа	Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Увс, Завхан, Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр, Сүхбаатар, Дорнод	Байгаль орчин	БОАЖЯ	2021-2040	15,000.0	Судалгаатай
2	Усны нөөцийг хуримтлуулах Хөх морь төсөл /урсацын тохируулгатай усан сангууд/, Хөх сувд төсөл /хөв цөөрмүүд/	Ховд, Баян-Өлгий, Булган, Хөвсгөл, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Өвөрхангай, Дорнод аймгийн нутаг дэвсгэр дэх Ховд, Орхон, Туул, Эг, Хэрлэн, Онон зэрэг томоохон голууд болон бусад голын татмууд, 21 аймгийн байгалийн тогтоцууд	Байгаль орчин	БОАЖЯ, ЭХЯ, АЗДТГ	2020-2050	11,374,419.9	ТЭЗҮ-гүй, судалгаатай
3	Говийн бүсийн уул уурхайн төслүүдэд үйлдвэрийн технологийн ус нийлүүлэх төсөл	Улаанбаатар, Төв, Дундговь, Өмнөговь аймаг	Байгаль орчин	БОАЖЯ, УУХҮЯ, БХБЯ	2020-2027	1,392,113.4	ТЭЗҮ-тэй
ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ БАГАТАЙ, БҮТЭЭМЖТЭЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ НОГООН ХӨГЖИЛ							
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны ногоон барилга /жишиг ногоон оффис/	Улаанбаатар хот	Байгаль орчин	БОАЖЯ	2021-2024	9,200.0	Зураг төсөвтэй
2	Хог хаягдлаас эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэр	Улаанбаатар хот	Байгаль орчин	БОАЖЯ, ЭХЯ, НЗДТГ	2020-2023	472,450.0	ТЭЗҮ-тэй
3	Аюултай хог хаягдлын зориулалтын төвлөрсөн байгууламж байгуулах	Улаанбаатар хот, Багануур дүүрэг, Төв аймаг, Сэргэлэн сум	Байгаль орчин	БОАЖЯ	2020-2024	63,443.5	ТЭЗҮ-тэй
4	Хог хаягдлын зориулалтын ландшафлийн байгууламж, аюултай хог хаягдлыг түр хадгалах байгууламж	Бүсийн төвүүд, 10 аймгийн төв	Байгаль орчин	БОАЖЯ, АЗДТГ	2020-2030		Мэдээлэлгүй

№	Төслийн нэр	Хэрэгжих байршил	Хэрэгжих салбар	Хариуцах яам, агентлаг	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг, сая.төг	ТЭЗҮ, судалгаа хийгдсэн эсэх
АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ							
ДАРХАН ХИЛ							
1	Улсын хил хамгаалалтын холбоо, мэдээллийн сүлжээний шинэчлэл хөтөлбөр	Баян-Өлгий Өлгий, Ховд Үенч, Говь-Алтай Алтай, Өмнөговь Овоот, Даланзадгад, Дорноговь Хатанбулаг, Улаан-Уул, Замын-Үүд, Сүхбаатар Онгон, Эрдэнэцагаан, Дорнод Халхгол, Мэнэн, Чойбалсан, Баян-Уул, Баян-Өлгий Цагааннуур, Увс Баруунтуруун, Улаангом, Завхан Тэс, Хөвсгөл Ханх, Булган Тэшиг, Сэлэнгэ Сүхбаатар, Хэнтий Дадал, Төвийн бүсийн бүх анги, салбар, ерөнхий газар	Хууль зүй	ХЗДХЯ	2020-2045	572,264.0	Судалгаатай
2	Монгол улсын хил хамгаалалтын удирдлага төв	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг	Хууль зүй	ХЗДХЯ	2020-2021	5,100.0	Судалгаатай
3	Бүсчилсэн хил хамгаалалт II хөтөлбөр	Улсын хэмжээнд	Хууль зүй	ХЗДХЯ	2025-2045	12,000.0	Судалгаатай
4	Улсын хил хамгаалалтын болон тусгай зориулалтын авто техникийг шинэчлэх хөтөлбөр	Улсын хэмжээнд	Хууль зүй	ХЗДХЯ	2020-2045	150,731.0	Судалгаатай
5	Улсын хил хамгаалалтын зориулалттай инженерийн байгууламж хөтөлбөр	Улсын хэмжээнд	Хууль зүй	ХЗДХЯ	2020-2045	138,319.2	ТЭЗҮ-тэй
6	Хилийн отряд, засвар, харуул, боомтын барилга байгууламж, дэд бүтцийн шинэчлэл хөтөлбөр	Улсын хэмжээнд	Хууль зүй	ХЗДХЯ	2020-2045	256,941.0	ТЭЗҮ-тэй
7	Хилчдийн нийгмийн хамгаалал II хөтөлбөр	Улсын хэмжээнд	Хууль зүй	ХЗДХЯ	2025-2045	5,500.0	Судалгаатай

№	Төслийн нэр	Хэрэгжих байршил	Хэрэгжих салбар	Хариуцах яам, агентлаг	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг, сая.төг	ТЭЗҮ, судалгаа хийгдсэн эсэх
ХҮН БА НИЙГМИЙН АМАР ТАЙВАН БАЙДАЛ							
1	Улаанбаатар хот, аймгийн төвийн гудамж талбайг камержуулах	Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн төв	Хууль зүй	ХЗДХЯ	2020-2022	79,700.0	ТЭЗҮ-тэй
2	Бүсүүдэд нэгдсэн хорих анги, эмнэлэг шинээр барих	Орхон, Хэнтий, Говьсүмбэр, Ховд, Өвөрхангай	Хууль зүй	ХЗДХЯ	2025-2045	60,785.5	Мэдээлэлгүй
3	Мансууруулах бодис хэрэглэгч, донтогч нарт эрүүл мэнд, сэтгэл зүйн засал, нийгмийн тусламж үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах төв байгуулах	Улаанбаатар хот	Хууль зүй	ХЗДХЯ	2020-2030	18,700.0	ТЭЗҮ-гүй, судалгаагүй
ХУУЛЬ САХИУЛАХ САЛБАРЫН ХӨГЖИЛ							
1	Монгол Улсын Шүүхийн шинжилгээний байгууллагын хүчин чадал, чадамжийг сайжруулах	Улаанбаатар хот, Сүхбаатар, Хан-Уул дүүрэг	Хууль зүй	ХЗДХЯ	2020-2022	54,530.0	ТЭЗҮ, судалгаатай
2	Цахим хяналт удирдлагын төв барих / шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт/	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг	Хууль зүй	ХЗДХЯ	2020-2023	36,715.0	ТЭЗҮ-тэй
3	Цагдаагийн байгууллагын автопарк шинэчлэх	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг	Хууль зүй	ХЗДХЯ	2020-2024	30,900.0	Судалгаатай
4	Цагдаагийн байгууллагын хэт богино долгионы радио холбооны шинэчлэл хийх	Улсын хэмжээнд /бүх аймаг, хот, сум, дүүрэг/	Хууль зүй	ХЗДХЯ	2020-2021	64,700.0	Судалгаатай
5	Архивын ерөнхий газрын цогцолбор барилгын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг	Хууль зүй	ХЗДХЯ	2019-2022	50,008.0	Судалгаатай
6	Улсын бүртгэлийн байгууллагын оффисс, архив, үйлчилгээний цогцолбор барих	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг	Хууль зүй	ХЗДХЯ	2020-2020	20,000.0	Зураг төсөлтэй
МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ							
1	Харилцаа холбооны хиймэл дагуул	Улаанбаатар хот	Харилцаа холбоо	ХХМТГ	2020-2038	526,084.0	ТЭЗҮ-тэй
2	3D 4D /хэмжээст/ Кадастрын мэдээллийн нэгдсэн систем	Улсын хэмжээнд /бүх аймаг, хот, сум, дүүрэг/	Газар зохион байгуулалт, геодези зураг зүй	БХБЯ	2020-2025	26,711.0	ТЭЗҮ-гүй, судалгаагүй
3	Төрийн өмчийн газрыг зурагжуулж бүртгэн газрын кадастрын мэдээллийн санд оруулж, баталгаажуулах	Улсын хэмжээнд /бүх аймаг, хот, сум, дүүрэг/	Газар зохион байгуулалт, геодези зураг зүй	БХБЯ	2020-2021	2,317.0	ТЭЗҮ-ТЭЙ
4	Улсын хэмжээнд газар, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний нэгдсэн систем байгуулах	Улсын хэмжээнд /бүх аймаг, хот, сум, дүүрэг/	Газар зохион байгуулалт, геодези зураг зүй	БХБЯ	2020-2025	1,200.0	ТЭЗҮ-гүй, суурь судалгаатай

№	Төслийн нэр	Хэрэгжих байршил	Хэрэгжих салбар	Хариуцах яам, агентлаг	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг, сая.төг	ТЭЗҮ, судалгаа хийгдсэн эсэх
5	Иргэний үнэмлэхийн үйлдвэрийг өргөтгөн үндэсний гадаад паспортын бичилт хийх бүтцийг бий болгох	Улаанбаатар хот	Хууль зүй	ХЗДХЯ	2020-2021	8,000.0	ТЭЗҮ-гүй, Судалгаагүй
6	Иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспортын бэлдэц үйлдвэрлэх, дотоодын үйлдвэр байгуулах	Улаанбаатар хот	Хууль зүй	ХЗДХЯ	2041-2042		ТЭЗҮ-гүй, Судалгаагүй
БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ							
БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ДАГУУ ХЭРЭГЖИХ ТӨСЛҮҮД							
1	Баруун-Урт-Бичигт чиглэлийн 272 км цемент бетон хучилттай их даацын авто зам	Сүхбаатар, Баруун-Урт, Бичигт боомт	Авто зам	ЗТХЯ	2020-2030	220,000.0	ТЭЗҮ-тэй
2	Жаргалтхаан сум-Өмнөдэлгэр сум-Рашаан хад-Өглөгчийн хэрэм-Биндэр сум-Баян-Адарга сум-Дадал сумыг холбосон 290 км авто зам	Хэнтий аймаг Жаргалтхаан, Өмнөдэлгэр, Биндэр, Баян-Адарга, Дадал	Авто зам	ЗТХЯ	2020-2022	275,500.0	Мэдээлэлгүй
3	Чойбалсан хотоос Ульхан боомт чиглэлийн 223.48 км хатуу хучилттай авто зам	Дорнод аймаг, Хэрлэн, Цагаан овоо, Баян-Уул	Авто зам	ЗТХЯ	2020-2030	221,350.0	ТЭЗҮ-тэй
4	Чойбалсан хотоос Хавиргын боомт чиглэлийн 124.5 км хатуу хучилттай авто зам	Дорнод аймаг, Хэрлэн сум, Чойбалсан сум	Авто зам	ЗТХЯ	2020-2030	118,750.0	ТЭЗҮ-тэй
5	Чойбалсан-Эрэнцав чиглэлийн 242 км авто зам	Дорнод аймаг, Чойбалсан, Эрэнцав	Авто зам	ЗТХЯ	2020-2030	231,800.0	Мэдээлэлгүй
6	Өндөрхаан - Норовлин чиглэлийн 200 км хатуу хучилттай авто зам	Хэнтий аймгийн Хэрлэн, Батноров, Норовлин сум	Авто зам	ЗТХЯ	2020-2023	190,000.0	ТЭЗҮ-гүй, судалгаатай, зураг төсөлтэй
7	Багануур - Өндөрхаан - Чойбалсан чиглэлийн 220кВ-ын ЦДАШ барих, 220 кВ-ын дэд станцыг өргөтгөх	Багануур, Хэнтий, Дорнод	Эрчим хүч	ЭХЯ	2020-2023	302,895.0	Судалгаатай
8	Чойбалсангийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөх	Дорнод аймаг, Чойбалсан (Хэрлэн сум)	Эрчим хүч	ЭХЯ	2020-2022	245,992.5	ТЭЗҮ-гүй
9	Богдхан төмөр замын төсөл	Улаанбаатар төмөр замын Багахангай өртөөнөөс Төв аймгийн Батсүмбэр сум	Төмөр зам	ЗТХЯ	2020-2023	1,929,200.0	ТЭЗҮ-тэй

№	Төслийн нэр	Хэрэгжих байршил	Хэрэгжих салбар	Хариуцах яам, агентлаг	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг, сая.төг	ТЭЗҮ, судалгаа хийгдсэн эсэх
10	Дархан – Сэлэнгийн авто замаас Шаамар – Зүүнбүрэн – Цагааннуур – Түшиг - Зэлтэрийн боомт чиглэлийн 120,85 км хатуу хучилттай авто зам	Сэлэнгэ аймгийн Шаамар, Зүүнбүрэн, Цагааннуур сумдын нутаг дэвсгэрт	Авто зам	ЗТХЯ	2020-2022	214,745.0	ТЭЗҮ-тэй
11	Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км автозамын шинэчлэлийн төсөл	Улаанбаатар хот, Төв аймгийн Баянчандмань, Борнуур, Жаргалант, Сэлэнгэ аймгийн Баянгол, Дархан-Уул аймгийн Хонгор сум	Авто зам	ЗТХЯ	2019-2021	455,000.0	ТЭЗҮ-тэй, зураг төсөлтэй
12	Бага болон дунд чадлын байнгын ажиллагаатай усан цахилгаан станцын төслийн судалгаа хийх, оновчтой байршлыг тогтоож, хэрэгжүүлэх	Төвийн бүсд	Эрчим хүч	ЭХЯ	2020-2025	133,300.0	Мэдээлэлгүй
13	Даланзадгад-Баяндалай -Гурвантэс чиглэлийн 220 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг үргэлжлүүлэн дуусгах	Өмнөговь аймаг	Авто зам	ЗТХЯ	2020-2021	209,000.0	ТЭЗҮ-тэй
14	Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам	Дорноговь аймгийн Сайншанд, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг сумд	Төмөр зам	ЗТХЯ	2020-2030	2,860,000.0	ТЭЗҮ-тэй
15	Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 45.3 км төмөр замын төсөл	Өмнөговь Гурвантэс сум	Төмөр зам	ЗТХЯ	2015-2045	392,374.8	ТЭЗҮ-тэй
16	Сайншанд-Хамрын хийд чиглэлийн авто замаас Зүүнбаян уул чиглэлийн 16 км хатуу хучилттай авто зам	Дорноговь аймаг, Сайншанд сум	Авто зам	ЗТХЯ	2020-2021	15,200.0	ТЭЗҮ-тэй
17	Тавантолгой - Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто зам төсөл	Өмнөговь аймаг, Цогтэций сум	Авто зам	ЗТХЯ	2020-2030	1,085,847.9	ТЭЗҮ-тэй
18	Тавантолгой- Манлай-Ханги чиглэлийн авто зам төсөл, 435 км	Өмнөговь аймгийн Цогтэций, Манлай, Дорноговь аймгийн Мандах, Сайхандулаан сумд	Авто зам	ЗТХЯ	2019-2049	360,000.0	ТЭЗҮ-тэй

№	Төслийн нэр	Хэрэгжих байршил	Хэрэгжих салбар	Хариуцах яам, агентлаг	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг, сая.төг	ТЭЗҮ, судалгаа хийгдсэн эсэх
19	Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км замын төгсгөлөөс "Цагаан дэл" уул хилийн боомт хүртэлх 270 км авто зам	Өмнөговь аймаг Ханхонгор сум	Авто зам	ЗТХЯ	2018-2040	710,100.0	Концессын гэрээтэй (DBOT)
20	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 267 км төмөр зам төсөл	Өмнөговь аймаг, Цогтцэций сум	Төмөр зам	ЗТХЯ	2020-2022	950,688.3	ТЭЗҮ-тэй
21	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414.6 км төмөр замын төсөл	Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Дорноговь аймаг, Зүүнбаян	Төмөр зам	ЗТХЯ	2019-2023	3,008,276.6	ТЭЗҮ-тэй, зураг төсөлтэй
22	Багануур-Чойрын 220 кВ-ын 2 хэлхээт 178 км цахилгаан дамжуулах агаарын шугам барих, дэд станцуудыг өргөтгөх төсөл	Улаанбаатар, Багануур дүүрэг, Говьсүмбэр	Эрчим хүч	ЭХЯ	2020-2022	106,000.0	Судалгаатай
23	Бөөрөлжүүтийн 300 МВт-ын хүчин чадал бүхий дулааны цахилгаан станц төсөл	Дорноговь аймаг	Эрчим хүч	ЭХЯ	2020-2025	1,119,700.0	ТЭЗҮ, судалгаатай
24	Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станц	Өмнөговь аймаг, Цогтцэций сум	Эрчим хүч	ЭХЯ	2020-2023	2,733,250.0	ТЭЗҮ-тэй
25	Чойр - Сайншанд - Замын -Үүдийн 220кВ-ын ЦДАШ-ыг барих	Дорноговь, Говьсүмбэр	Эрчим хүч	ЭХЯ	2020-2023	237,440.0	ТЭЗҮ-тэй
26	Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний ордыг түшиглэн уурхайн өргөтгөл хийх, 5280 МВт-ын чадал бүхий цахилгаан станц, 660 кВ-ын тогтмол гүйдлийн ЦДАШ барьж эрчим хүч экспортлох гэрээ байгуулах, төслийг эхлүүлэх	Говьсүмбэр	Эрчим хүч	ЭХЯ	2020-2025	17,500,000.0	ТЭЗҮ-гүй, судалгаатай
27	Мандалговь-Арвайхээр 220 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц	Дундговь аймаг, Мандалговь сум, Өвөрхангай аймаг, Арвайхээр сум	Эрчим хүч	ЭХЯ	2020-2025	155,000.0	Судалгаатай
28	Булган Хишиг Өндөр Гурван булаг чиглэлийн 133.7 км хатуу хучилттай авто замын барилгын ажил	Булган аймгийн Хишиг-Өндөр, Гурван булаг сумдын нутаг дэвсгэрт	Авто зам	ЗТХЯ	2020-2021	126,350.0	ТЭЗҮ-тэй
29	Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн авто замын авто замаас Өлзийт сум Мөрөн-Тариалан чиглэлийн авто замын төгсгөлийг холбох 120 км хатуу хучилттай авто зам	Архангай Өлзийт сум	Авто зам	ЗТХЯ	2017-2026	106,950.0	ТЭЗҮ-тэй
30	Хатгал-Жанхай-Тойлогт чиглэлийн 32.4 км хатуу хучилттай авто зам	Хөвсгөл аймгийн Хатгал сумын нутаг дэвсгэрт	Авто зам	ЗТХЯ	2020-2021	30,400.0	ТЭЗҮ, судалгаатай

№	Төслийн нэр	Хэрэгжих байршил	Хэрэгжих салбар	Хариуцах яам, агентлаг	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг, сая.төг	ТЭЗҮ, судалгаа хийгдсэн эсэх
31	Хялганат-Хангал-Эрдэнэт чиглэлийн 52.57 км хатуу хучилттай авто зам	Орхон аймгийн нутаг дэвсгэр	Авто зам	ЗТХЯ	2021-2022	30,400.0	ТЭЗҮ, судалгаатай
32	Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын төсөл	Хөвсгөл, Булган, Орхон аймаг	Төмөр зам	ЗТХЯ	2020-2030	5,720,000.0	ТЭЗҮ-тэй
33	Багануур зүүн өмнөд бүс, Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээний алдагдал бууруулах төсөл	Багануур, Эрдэнэт, Булган	Эрчим хүч	ЭХЯ	2020-2022	145,030.0	ТЭЗҮ, судалгаатай
34	Эгийн голын 315 МВт-ын хүчин чадал бүхий усан цахилгаан станц төсөл	Булган аймаг, Хутаг-Өндөр сум	Эрчим хүч	ЭХЯ	2020-2025	2,262,037.7	ТЭЗҮ-тэй
35	Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын шинэчлэл төсөл	Орхон аймаг, Эрдэнэт хот (Баян-Өндөр сум)	Эрчим хүч	ЭХЯ	2020-2021	136,389.8	ТЭЗҮ-тэй
36	Өлгий (БӨ)-Улаанхус сум-Алтай таван богд уул чиглэлийн 118 км авто зам	Баян-Өлгий Өлгий, Улаанхус	Авто зам	ЗТХЯ		112,100.0	Мэдээлэлгүй
37	Улиастай-Алтай чиглэлийн 194 км хатуу хучилттай авто замын барилгын ажил	Завхан, Говь-Алтай, Алдархаан, Цагаанхайрхан, Тайшир, Алтай сум	Авто зам	ЗТХЯ	2020-2022	150,000.0	ТЭЗҮ-гүй, судалгаатай, зураг төсөлтэй
38	Ховд -Улаангом чиглэлийн 163 км хатуу хучилттай авто зам	Ховд, Увс аймаг Өлгий, Өмнөговь, Тариалан сумдын нутагт	Авто зам	ЗТХЯ	2020-2025	154,850.0	ТЭЗҮ, судалгаатай
39	Баруун бүсэд сэргээгдэх эрчим хүчийг дэлгэрүүлэх төсөл	Увс, Ховд, Баян-Өлгий	Эрчим хүч	ЭХЯ	2019-2023	105,280.0	Мэдээлэл байхгүй
40	Улиастай-Дөргөн-Мянгадын 220 кВ-ын 2 хэлхээт 380 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих ажлын судалгааг хийх, ажлыг эхлүүлэх	Ховд аймаг, Говь-Алтай сум	Эрчим хүч	ЭХЯ	2020-2022	212,000.0	Мэдээлэл байхгүй
41	Ховд аймгийн Эрдэнэбүрэн суманд усан цахилгаан станц барих төсөл, 64 МВт-100МВт	Ховд аймаг, Эрдэнэбүрэн сум	Эрчим хүч	ЭХЯ	2015-2022	759,332.0	ТЭЗҮ-гүй, судалгаатай, зураг төсөлтэй
42	Тэлмэний 100МВт-ын ДЦС барих төсөл	Завхан аймаг Тэлмэн сум	Эрчим хүч	ЭХЯ	2020-2030	491,985.0	ТЭЗҮ-тэй
БҮХ БҮС, АЙМАГ, СУМДУУДАД ХЭРЭГЖИХ ТӨСЛҮҮД							
1	Авто замын дагуу үйлчилгээний төв байгуулах төсөл	21 аймгийн 51-н цэгт	Авто тээвэр	ЗТХЯ	2020-2030	106,000.0	ТЭЗҮ-тэй
2	Алтанбулаг, Сайншанд, Хөшгийн хөндий, Цагааннуур тээвэр логистикийн төв байгуулж, хуурай боомтын статустай болгох	Сэлэнгэ, Дорноговь, Төв, Баян-Өлгий	Логистик	ЗТХЯ	2022-2027	200,000.0	ТЭЗҮ-гүй
3	Зургаан бүсийн нисэх буудлыг олон улсын нисэх буудал болгон өргөжүүлж, хүчин чадлыг нэмэгдүүлэх	Дорнод, Увс, Баянхонгор, Ховд, Өмнөговь, Хөвсгөл	Агаарын тээвэр	ЗТХЯ, БОАЖЯ	2020-2040	580,000.0	Зарим байршилд ТЭЗҮ-тэй

№	Төслийн нэр	Хэрэгжих байршил	Хэрэгжих салбар	Хариуцах яам, агентлаг	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг, сая.төг	ТЭЗҮ, судалгаа хийгдсэн эсэх
4	Сумдын төвийг хатуу хучилттай авто замаар холбох - 20 сум	Увс аймаг Өлгий сум, Завхан аймаг Цагаанчулуут сум, Говь-алтай аймаг Тайшир сум, Сүхбаатар аймаг Асгат сум, Сүхбаатар аймаг Эрдэнэцагаан сум, Хэнтий аймаг, Батноров сум, Хэнтий аймаг Норовлин сум, Дорнод аймаг Баян-Уул сум, Дорнод аймаг Цагаан-Овоо, Дорнод аймаг Чойбалсан, Сэлэнгэ аймаг Зүүнбүрэн сум, Сэлэнгэ аймаг Цагааннуур сум, Сэлэнгэ аймаг Түшиг сум, Архангай аймаг Өлзийт сум, Архангай аймаг Хайрхан сум, Говь-алтай аймаг Шарга сум, Хэнтий аймаг Дадал сум, Дорноговь аймаг Зүүнбаян сум, Булган аймаг, Гурванбулаг сум, Булган аймаг Хишиг-Өндөр сум	Авто зам	ЗТХЯ	2020-2022	95,000.0	Мэдээлэлгүй
5	Тээвэр логистикийн төвүүд байгуулах	Өмнөговь аймаг, Завхан аймаг, Дорнод, Дархан-Уул, Бичигт боомт, Замын үүд, Овоот, Орхон, Өвөрхангай, Өлгий хот, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл	Логистик	ЗТХЯ	2025-2030	21,000.0	Мэдээлэлгүй

№	Төслийн нэр	Хэрэгжих байршил	Хэрэгжих салбар	Хариуцах яам, агентлаг	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг, сая.төг	ТЭЗҮ, судалгаа хийгдсэн эсэх
6	Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах	Улсын хэмжээнд /21 аймаг, нийслэлийн нийт нутаг дэвсгэр/	Газар зохион байгуулалт, геодези зураг зүй	БХБЯ	2020-2045	17,160.0	ТЭЗҮ-тэй
7	Газар зүйн нэрийн хээрийн тодруулалтыг улсын хэмжээнд хийх	Улсын хэмжээнд	Газар зохион байгуулалт, геодези зураг зүй	БХБЯ	2020-2022	5,100.0	ТЭЗҮ-тэй
8	Монгол орны нутаг дэвсгэрийн 55%-ийг 1:25000 масштабтай байр зүйн тоон зургаар зурагжуулах	Улсын хэмжээнд	Газар зохион байгуулалт, геодези зураг зүй	БХБЯ	2020-2025	87,700.0	ТЭЗҮ-тэй
9	Монгол улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл	Улсын хэмжээнд	Барилга, хот байгуулалт	БХБЯ	2021-2040	5,600.0	ТЭЗҮ-гүй, судалгаагүй
10	Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах	Улсын хэмжээнд /21 аймгийн 330 сум/	Газар зохион байгуулалт, геодези зураг зүй	БХБЯ	2020-2045	69,795.0	ТЭЗҮ-тэй
11	Сумын төвүүдийн инженерийн шугам сүлжээний зураглал хийх	309 сум, 21 томоохон суурин	Газар зохион байгуулалт, геодези зураг зүй	БХБЯ	2020-2022	5,362.0	ТЭЗҮ-тэй
12	Сумын хөгжил төсөл	21 аймгийн 108 сум	Инженерийн дэд бүтэц	БХБЯ	2020-2030	54,000.0	ТЭЗҮ-гүй, суурь судалгаатай
13	10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл	Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говь Сүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Төв, Сүхбаатар	Эрчим хүч	ЭХЯ	2019-2022	391,378.4	Судалгаатай
14	Бүсийн хөгжлийн төсөл боловсруулах	Улсын хэмжээнд	Барилга, хот байгуулалт	БХБЯ, ҮХГ	2022-2042	4,200.0	ТЭЗҮ-гүй, судалгаагүй
УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ							
ДАГУУЛ ХОТ							
1	Улаанбаатар хотын шинэ суурьшлын бүсүүдийг хөгжүүлэх төсөл	Улиастай ам, Авто худалдааны цогцолбор, Морингийн даваа, Био-Сонгино	Барилга, хот байгуулалт	НЗДТГ	2020-2033	554,050.1	ТЭЗҮ-тэй
ТӨЛӨВЛӨЛТ ТӨВТЭЙ ХӨГЖИЛ							
1	Багануур дэд станцыг Улаанбаатар дэд станцтай холбох 220 кВ-ын 2 хэлхээт 118 км цахилгаан дамжуулах агаарын шугам барих, дэд станцуудыг өргөтгөх ажлыг эхлүүлэх	Улаанбаатар хот, Багануур дүүрэг	Эрчим хүч	ЭХЯ	2020-2022	84,800.0	Судалгаатай

№	Төслийн нэр	Хэрэгжих байршил	Хэрэгжих салбар	Хариуцах яам, агентлаг	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг, сая.төг	ТЭЗҮ, судалгаа хийгдсэн эсэх
2	Багануурын цахилгаан станц төсөл	Багануур дүүрэг	Эрчим хүч	ЭХЯ	2020-2041	2,623,920.0	ТЭЗҮ-тэй
3	Дулааны гуравдугаар цахилгаан станцыг 250 МВт-аар өргөтгөх, шинэчлэх	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг	Эрчим хүч	ЭХЯ	2020-2023	956,637.5	ТЭЗҮ-гүй, судалгаатай
4	Дулааны гуравдугаар цахилгаан станцын өндөр даралтын хэсгийн хүчин чадлыг 75 МВт-аар өргөтгөх	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг	Эрчим хүч	ЭХЯ	2020-2021	338,923.0	Судалгаатай
5	Дулааны дөрөвдүгээр цахилгаан станцын №1-4 турбогенераторын хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинэчлэх	Улаанбаатар, Баянгол дүүрэг	Эрчим хүч	ЭХЯ	2020-2025	234,921.4	ТЭЗҮ-тэй
6	Тохируулгын горимд ажиллах том чадлын цэнэг хураагуур барих төсөл	Улаанбаатар хот	Эрчим хүч	ЭХЯ	2020-2025	259,700.0	Судалгаатай
7	Улаанбаатар хотын Амгалангийн дулааны станцыг 50 МВт-ын дулаан, цахилгаан хослон үйлдвэрлэх станц болгон өргөтгөх	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг	Эрчим хүч	ЭХЯ	2020-2022	207,453.7	ТЭЗҮ-гүй, судалгаатай
8	Улаанбаатар хотын дулааны 2 дугаар цахилгаан станцын хүчин чадлыг 300 МВт (1 агрегат нь тохируулгын горимд ажиллах хийн генератор бүхий)- аар өргөтгөх	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг	Эрчим хүч	ЭХЯ	2020-2023	1,040,275.0	ТЭЗҮ-тэй
9	Агаарын замын автобус байгуулах төсөл	Улаанбаатар	Тээвэр	НЗДТГ	2020-2025	751,643.8	Мэдээлэлгүй
10	Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр	Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд	Тээвэр	НЗДТГ	2017-2023	214,286.8	Судалгаатай
11	Нийтийн тээврийн үйлчилгээний парк шинэчлэлт хийх	Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд	Тээвэр	НЗДТГ	2020-2021	528,200.0	Судалгаатай
12	Улаанбаатар нэгдсэн терминал төсөл	Улаанбаатар	Логистик	НЗДТГ	2020-2025	37,718.9	Мэдээлэлгүй

АЛСЫН ХАРАА 2050, МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД УЧИРЧ БОЛОХ ЭРСДЭЛҮҮД

Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд учирч болох дараах эрсдэлүүд байгааг анхаарч, түүнээс гарах сөрөг үр дагавраас сэргийлэх арга замуудыг тухай бүр авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Үүнд:

- 1. Ядуурал, орлогын тэгш бус байдал.** Ядуурлыг эрчимтэй бууруулах, орлогын зөрүүг багасгах арга хэмжээ авахгүй бол энэ нь нийгэмд тогтворгүй байдлыг үүсгэж, улмаар нийтийг хамарсан хямралын нөхцөлийг бий болгож болзошгүй юм. Иймээс эдийн засгийн өсөлтийг нийгмийн бүх давхарга, салбар, бүс нутагт хүртээмжтэй болгох нь дунд болон урт хугацааны хамгийн том сорилт болж байна.
- 2. Ажилгүйдэл.** Хүний амьдрах орчин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин, цалин орлогын түвшин доогуур байгаа нь залуу үе гадаадад дүрвэх хөдөлгөөн цаашид нэмэгдэж, ажиллах хүчин хомстолд орох эрсдэл өндөр байна. Чанартай ажлын байрыг эрс нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 3. Өр.** Манай улсын өрхийн сектор, хувийн сектор, улсын сектор бүгд өрийн дарамттай болоод байна. Ойрын жилүүдэд дорвитой алхам хийхгүй, гадаадын зээлээр үр ашиггүй төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, өрийг өрөөр дарах замаар явбал дефолт болох эрсдэл өндөр байна. Улс орны өмнө тулгарч байгаа асуудлуудыг эрэмбэлэн дотоодын нөөцийг бүрэн ашиглаж, эдийн засгийг тэлэх замаар орлогоо нэмэгдүүлэн эрсдэлээс сэргийлнэ.
- 4. Авлига.** Авлига, өмчийн томоохон хэргүүд шударгаар шийдвэрлэгдэхгүй байвал төрд итгэх иргэдийн итгэл суларч иргэний хөдөлгөөн идэвхжиж, улс төрийн гүн хямрал руу орох эрсдэл өндөр байна. Шүүхийн тогтолцоог бүрэн шинэчлэн шударга ёсыг тогтоох,

төрийн албыг чадавхжуулж, шинэчилснээр авлигаас сэргийлнэ.

- 5. Засаглалын тогтворгүй байдал.** Засаглал тогтворгүй, бодлогын залгамж халаагүй байдал гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын итгэлийг алдах эрсдэл байсаар байна. Улс төр-эдийн засгийн бодлогыг парламентад суудалтай намууд зөвшилцөн тодорхойлох, хөгжлийн бодлого, төлөвлөлтийг тогтвортой байлгах институцийн тогтолцоог бий болгон эрсдэлээс сэргийлнэ.
- 6. Төр, хувийн хэвшлийн түншлэл.** Зөвхөн мөнгө хөрөнгөөр хэмжсэн сонгуулийн тогтолцоо нь хувийн хэвшлийн төлөөлөл төрд орж өөрийнхөө бизнесийн асуудлыг шийдвэрлээд явдаг зарчим үргэлжилбэл тогтворгүй байдал илүү гүнзгийрч, гадаадаас хараат байдал улам бүр нэмэгдэнэ. Улс төрийн намуудын санхүүжилтийг төсвөөс шийдэж байж төр бизнесийг зааглана.
- 7. Эдийн засгийн тогтворгүй байдал.** Засгийн газар, компаниуд нь хөрөнгө оруулалтыг шингээх улсын чадавхаас давсан хэмжээний хөрөнгө оруулалтыг хийж үйлдвэрлэлийг өргөтгөх аюултай. Энэ тохиолдолд зах зээлд нийлүүлэгдэх бололцоотой хангамжаас давсан эрэлт үүсэж эдийн засаг "халалтын" байдалд орж үнэ, цалин хурдацтай өснө. Иймээс хэт халсан эдийн засагтай болохгүйн тулд эртнээс эрэлт, мөнгөний нийлүүлэлтийг зохимжтой хэмжээнд хязгаарлах бодлого хэрэгжүүлнэ.
- 8. "Хөөсөн" эдийн засгийн дараах өрийн дарамт.** Гадаад, дотоодоос авах Засгийн газар, хувийн хэвшил, компаниудын зээлийн хэмжээ, үнэт цаасны хөрөнгө оруулалтын хэмжээг ДНБ-д эзлэх өрийн хэмжээтэй тулгаж байнга хянах учиртай. Энэ асуудлыг өрийн менежментийг оновчтой хийх замаар зохицуулна.
- 9. Дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнийн хэлбэлзэл.** Олон улсын хэмжээнд бүс нутгуудын улс төр, эдийн засгийн тогтворгүй байдал удаан үргэлжлэх нь манай улсад дараах эрсдэлүүдийг дагуулж болзошгүй юм.
 - I. Экспортын барааны үнийн уналт.** Манай орны гол экспортын бараа болох нүүрс, зэсийн баяжмал, алт, ноолуурын үнэ дэлхийн зах зээлд унаж болзошгүй юм. Урт хугацаанд үнийн уналт үргэлжлэх тохиолдолд үйлдвэрлэл, экспортоо түр зогсоох, хэмжээг багасгах аль эсвэл татварын орлогыг бууруулахгүй байх үүднээс экспортын хэмжээ, цар хүрээг эрс нэмэгдүүлэх замаар орлогыг нөхөх аргуудыг хэрэглэнэ.
 - II. Импортын барааны гол хэсэг болох газрын тос, шатахууны үнийн өсөлт.** Дэлхийн зах зээл дэх газрын тосны үнийг өсгөх эрсдэл байгаа нь манай улсад шатах, тослох материалын үнийг өсгөх эрсдэлийг дагуулж болзошгүй юм. Уг эрсдэлийг багасгахын

тулд газрын тос, шатахууны стратегийн нөөцийг нэмэгдүүлэх, хангамжийн эх үүсвэр, сувгийг олшруулах, шинэ томоохон агуулах барих, дотоодод газрын тосыг боловсруулж тодорхой хэмжээний шатах, тослох материалын хэрэгцээг хангадаг болох нь чухал.

III. Хүнсний бүтээгдэхүүний үнэ. Байгалийн гамшиг, дэлхийн зах зээлийн байдал зэргээс шалтгаалан хүнсний үнийн тогтворгүй байдалтай тулгарч болзошгүй юм. Иймд мах, сүү, будаа, буудай, гурил, ургамлын тос зэрэг хүнсний гол бүтээгдэхүүнийг нөөцлөх үйл ажиллагааг эрчимжүүлэн, нөөцийн төрөл, хэмжээг нэмэгдүүлэх нь чухал байна. Үүний тулд хүнсний зоорь агуулах байгууламжийн тоо, хүчин чадлыг байнга өргөтгөх, хүнсний хэрэгцээгээ 100% дотоодоос хангадаг болох нь чухал болно.

10. Гадаад зах зээлээс босгох хөрөнгө оруулалтын өртөг нэмэгдэх.

Европын орнуудын өрийн хямралаас үүдсэн хөрөнгө оруулалтын урсгал Азийн хөгжиж буй улсууд руу чиглэх хандлага ажиглагдаж байгаа хэдий ч хөрөнгө оруулагчид нь бонд, хувьцаанд хөрөнгө оруулахаас зайлс хийж, алт болон бусад хөрөнгийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулах сонирхол нь нэмэгдэж болзошгүй юм. Манай улс шиг түүхий эдийн үнийн хэлбэлзлээс хэт их хамааралтай орнуудын бонд, үнэт цаасны эрэлт хэрэгцээ буурах эрсдэлтэй юм. Тиймээс олон улсын зах зээл дээр гаргах Засгийн газрын болон бусад байгууллагуудын бондын худалдаа буурах, улмаар хүү, зардал өсөж цаашлаад дэд бүтэц болон хөгжлийн томоохон төслүүдийн хэрэгжилт удаашрах эрсдэл бий болж болзошгүй юм.

11. Гадаадын хөрөнгийн дотогшлох урсгалтай холбоотой эрсдэл.

Манай улс эрчимтэй хөгжлийн эхэн үе шатад гадаадаас ихээхэн хэмжээний богино хугацааны хөрөнгө эдийн засагт орж, үл хөдлөх хөрөнгө, хувьцаа, үнэт цаас, түүний ногдол ашиг, банкны хадгаламж хэлбэрт шилжин, үнийн хөөрөгдлийг бий болгох, манай эдийн засгийн байдлыг тогтворгүй болсон үед хөрөнгийн урсгал гадагшлах үйл явц маш хурдацтай явагдах эрсдэлтэй. Үүнээс болж үндэсний валютын ханш огцом унах, хувьцааны ханш буурах, банк санхүүгийн системд хямрал үүсэх аюултай. Үүнээс болгоомжлохын тулд манай улсын банк, үнэт цаасанд байгаа гадаадын богино хугацаатай хөрөнгийг Төв банкны зүгээс хянах, богино хугацаанд гаргахгүй байх, богино хугацаанд гаргах тохиолдолд торгуультай байх хууль дүрэм журмыг хэрэгжүүлнэ.

12. Хөдөлмөрийн нөөцийн дутагдал. Монгол Улс дунд болон урт хугацаанд эдийн засаг эрчимтэй тэлэх хэрээр манай хөдөлмөрийн насны хүн амын хувийн жин харьцангуйгаар буурах, ажиллах хүчин хүрэлцэхгүй байж болзошгүй юм. Мэргэжилтэй ажиллах хүч дутагдсан тохиолдолд гадны ажиллах хүчийг ихээр оруулж ирэх шаардлага гарах бөгөөд энэ нь нийгэмд тогтворгүй байдал үүсэх аюултай юм.

I. Хөдөлмөрийн нөөцийг аль болох бүрэн ашиглах хүрээнд: МСҮТ-ийн өнөөгийн тогтолцоог өргөжүүлэн, цэргийн албан хаагч, оюутан сурагчид, ахимаг насны ажилгүй, мэргэжилгүй хүмүүст мэргэжил олгох богино хугацааны эрчимжүүлсэн сургалт,

дамжааг бий болгох, зохион байгуулахад төрөөс дэмжинэ.

II. Гаднаас ажиллах хүч оруулах тохиолдолд нэн тэргүүнд Монгол туургатан мэргэжилтэн, ажилчдыг тэргүүний ээлжид урих нь зөв гэж үзэж байна. Энэ чиглэлээр нарийн журам гаргаж мөрдөх нь чухал юм.

13. Дулаан, эрчим хүчний хямрал. Манайд цахилгаан станц, дамжуулах шугам, дэд станц, түгээх шугамд гарах байгалийн гамшиг болон хүний алдаанаас гарах осол, эвдрэл, тасалдал, хангамжийн тогтворгүй байдал үүсэх аюултай. Томоохон ДЦС-ууд, аймгийн төвийн дулааны станцууд зэрэгт томоохон эвдрэл гарсан тохиолдолд Нийслэл хот, аймгийн төвүүд тэр чигээр хөлдөх аюултай байгааг анхаарах нь зүйтэй. Иймээс цахилгаан станцуудыг нэмж барьж байгуулах, нийслэлд дулааны төвлөрсөн бус эх үүсвэрүүдийг бий болгох, хийн цахилгаан, дулааны станцыг барих, эрчим хүчний нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх нь чухал болно.

14. Байгаль, экологийн эрсдэл. Байгаль орчны бохирдол, уул уурхайн бөгөөд үйлдвэрлэлийн осол гэмтэл, цөлжилт, үер, газар хөдлөлт, ган, зуд, малын өвчин зэрэг байгалийн гамшигтай тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулж, стратегийн нөөцийг байнга нэмэгдүүлж байх нь чухал. Үүнээс сүүлийн үед хамгийн их анхаарал татаж байгаа эрсдэл нь усны хангамжийн асуудал бөгөөд цаашид усны хайгуулыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

15. Геополитикийн эрсдэл. Хөрш орнуудын үйлдвэрлэл, ашиглалт, манай үндэсний үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж болзошгүй. Геополитикийн хүрээнд хөрш болон түнш орнуудтай хамтран ажиллахад хараат байдалд орохоос сэргийлэх, үндэсний эрх ашгийг хамгаалж ажиллах нь зүйтэй.

16. Нийгмийн халамж үйлчилгээний тэлэлт. Нийгмийн халамжийн тогтолцоо нь ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад нөлөөлөхгүй байна. Иймд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх замаар үйлчилгээний менежментийг сайжруулах, тэргүүн туршлагыг нэвтрүүлэх тогтолцоог бий болгох шаардлагатай байна.



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР